

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД
АУДИТЫН ХЭЛТЭС**



**ДОТООД АУДИТЫН
ТАЙЛАНГИЙН ЭМХТГЭЛ**

**Улаанбаатар хот
2020 он**

Хянасан:

ЦЕГ-ын Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Эмхтгэсэн:

ЦЕГ-ын Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх

Эхийг бэлтгэсэн:

ЦЕГ-ын СААА-ны Хангалт үйлчилгээний төвийн Хэвлэх хэсгийн эх бэлтгэгч, цагдаагийн ахлах дэслэгч Х.Бат-Энэрэлт

Формат: 60x90 1/16

Хэвлэлийн хуудас: 22 х/х

Хэвлэсэн тоо: 100 ш

ЦЕГ-ын Хэвлэх хэсэгт хэвлэв.

ГАРЧИГ

д/д	Тайлангийн нэр	Хуудас
1.	Цагдаагийн байгууллагын мөрдөгчийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан	6-19
2.	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас бусад байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр байгуулсан санамж бичиг, гэрээний хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын тайлан	20-33
3.	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сахилгын мэдээ гаргах үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан	34-38
4.	Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан	39-52
5.	Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан	53-65
6.	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас төрийн бусад байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангах үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан	66-83
7.	Гэрч, хохирогчийг хамгаалах цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан	84-97
8.	Гэрээт харуул хамгаалалт, хувийн хамгаалалтын үйл ажиллагаанд цагдаагийн байгууллагаас хяналт тавих үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан	98-107
9.	“Эрүүл цагдаа” хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын тайлан	108-117
10.	Аймаг дахь цагдаагийн газар, хэлтсээс архивын баримтыг цахимжуулах үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан	118-121
11.	Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн дүрэмт хувцасны хангалт, хүрэлцээ, эдэлгээ, хугацаа, тооцоо хийж буй байдалд хийсэн дотоод аудитын тайлан	122-135
12.	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын автомашины шатахуун зарцуулалттай холбоотой үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан	136-144
13.	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын туслах аж ахуйн бүртгэл, тооцоо, даатгалын үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан	145-154
14.	Цагдаа, дотоодын цэргийн байгууллага дахь шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын тайлан	155-162
15.	Цагдаагийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2018 онд хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын тайлан	163-170
16.	Дипломат байгууллага, улсын онц чухал объектыг хамгаалах цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан	171-178

17. Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан 179-186
18. Цагдаагийн ерөнхий газрын Төв архивын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан 187-191
19. Цагдаагийн ерөнхий газрын удирдлага, албадын дарга нараас өгсөн үүрэг, ажлын чиглэлд хийсэн дотоод аудитын тайлан 192-201
20. Цагдаагийн байгууллагын зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан 202-208
21. Цагдаагийн байгууллагын санхүүгийн анхан шатны баримт бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан 209-217
22. Эрүүгийн цагдаагийн албаны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан 218-225
23. Увс аймаг дахь цагдаагийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан 226-234
24. Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан 235-241
25. Улсын нэгдсэн санд бүртгэлтэй эрх зүйн актын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний тайлан 242-263
26. Цагдаагийн байгууллагын албаны сургалтын үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээний тайлан 264-275
27. "Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг"-ийн хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын тайлан 276-281
28. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан 282-289
29. Цагдаагийн байгууллагын мэдээллийн сан дахь яллагдагчийн сангийн баяжилт, гэмт хэргийн илрүүлэлтийн статистикийн нөхцөл байдалд хийсэн дотоод аудитын тайлан 290-293
30. Хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан 294-308
31. Хэвлэл мэдээллийн төвийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээний тайлан 309-314
32. Цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээний тайлан 315-326
33. Телехяналтын камерын хангамж, ашиглалтын байдалд хийсэн хяналт шинжилгээний тайлан 327-331
34. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг шинээр боловсруулан батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан 332-335
35. Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдалд хийсэн эрсдэлийн үнэлгээний тайлан 336-350

ӨМНӨТГӨЛ

Улсын салбарт дотоод аудитыг нэвтрүүлж хөгжүүлэх төрийн бодлогын хүрээнд 2014 онд Цагдаагийн ерөнхий газрын бүтцэд дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлэх нэгжийг шинээр байгуулж, алба хаагчдыг шаардлагатай сургалтад хамруулан мэргэшүүлсэн.

Өнгөрсөн хугацаанд тус нэгжээс гүйцэтгэлийн, нийцлийн, үйл ажиллагааны болон санхүүгийн олон тооны дотоод аудитыг амжилттай хэрэгжүүлж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангахын зэрэгцээ аудитын хүрээнд илэрсэн эрсдэл бүхий асуудал, зөрчил, дутагдлыг арилгах, үйл ажиллагааг сайжруулах санал, зөвлөмжийг тухай бүр холбогдох нэгжид хүргүүлж, биелэлт, үр дүнг тооцон ажиллаж ирсэн.

Аудит нь тодорхой цаг хугацаанд хэрэгжээд дуусдаг ч аудитаар илрүүлсэн асуудал, гаргасан дүгнэлт, санал, зөвлөмжийн ач холбогдол, үнэ цэнэ нь урт хугацаанд үргэлжлэх шинжтэй байдаг.

Иймд Цагдаагийн ерөнхий газрын Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсээс урьд онуудад хэрэгжүүлсэн дотоод аудит, хяналт шинжилгээ, эрсдэлийн үнэлгээний тайлангуудаас түүвэрлэн энэхүү эмхтгэлийг гаргалаа.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах албан тушаалтан, алба хаагч бүр албан хэрэгцээнд зориулсан энэхүү эмхтгэлийг уншиж судлан мэдээлэл, сургамж авах, аудитын мөрөөр өгсөн санал, зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Та бүхэнд ажлын амжилт хүсье.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Ж.БОЛД

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2020 оны 05 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаагийн байгууллагын мөрдөгчийн үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудитын төрөл, код: Үйл ажиллагааны аудит, ЦЕГ-ХШДАХ/ҮА-2020/04

Аудитын хугацаа: 2020.03.16- 2020.05.08

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа В.Отгонбаяр /аудитын явцад өөр байгууллагад сэлгэн томилогдсон/, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх, Эрүүгийн цагдаагийн албаны Гүйцэтгэх ажлын дүн шинжилгээний хэлтсийн чиглэлийн ахлах мөрдөгч, цагдаагийн дэд хурандаа С.Тайван, Мөрдөн байцаах албаны Захиргаа, хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Б.Энх-Амгалан

1. ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлаас шинэчлэн баталсан Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн, хуулийн өөрчлөлтийг дагаж холбогдох эрх зүйн актууд шинэчлэгдсэнээр цагдаагийн байгууллага, алба хаагчид мөрдөн шалгах ажиллагааг эрх зүйн шинэ орчинд явуулах болсон.

2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт нь мөрдөн шалгах ажиллагааны шуурхай байдлыг хангах, мөрдөгчийн үйл ажиллагаанд тулгамдаж байсан зарим асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн чухал алхам болжээ.

Тухайлбал, мөрдөгч зарим төрлийн нууцад хамаарахаас бусад мэдээллийг прокурорын зөвшөөрөлгүй авах, гэмт хэргийн тухай гомдол, мэдээлэл шалгах хугацааг албаны даргын шийдвэрээр (14 хоног) сунгах, мөрдөгчийн даалгаврыг прокурорын байгууллагаар дамжуулалгүй шууд хүргүүлэх боломжтой болсон ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой зарим хугацааг тодорхой болгосныг энд дурдаж болно.

2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар цагдаагийн байгууллагын хэмжээнд 250 офицер орон тоо дутуу байгаагаас 118 нь

мөрдөгч албан тушаал байна. Түүнчлэн нийт алба хаагчдын 13.5, үүнээс офицер бүрэлдэхүүний 16.1, ахлагч бүрэлдэхүүний 10.5 хувь нь эмэгтэй алба хаагч байна.

Аудитын хүрээнд аймаг, дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтэст ажиллаж буй мөрдөгчийн орон тоо, нөхөн хангалт, хүний нөөцийн шилжилт хөдөлгөөний талаарх судалгааг авч нэгтгэсэн /Хүснэгт 1, 2/ дүнгээс үзвэл мөрдөгчийн орон тооны дүүргэлт 93.0 хувь, эмэгтэй мөрдөгч нийслэлд 11.0, орон нутагт 4.0 хувийг эзэлж байна.

2019 онд нийслэлд нийт мөрдөгч бүрэлдэхүүний 1/3 буюу 34.0 хувь, 2020 оны эхний улирлын байдлаар 16.0 хувь нь ямар нэг байдлаар шилжилт, хөдөлгөөнд оржээ. Харин орон нутагт мөрдөгчид харьцангуй тогтвортой ажиллаж 2019 онд 11.0 хувь нь шилжилт, хөдөлгөөнд орсон бол 2020 он гарснаар шилжилт, хөдөлгөөн хийгдэх байдал идэвхжиж эхэлсэн байна.

Дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсийн мөрдөгчдийн 50.0 хувь нь 2 жил хүртэл, 80.0 хувь нь 5 жил хүртэл хугацаанд мөрдөгчөөр ажилласан туршлагатай байхад орон нутагт мөрдөгчдийн 37.0 хувь нь 2 жил хүртэл, 65.0 хувь нь 5 жил хүртэл хугацаанд мөрдөгчөөр ажиллаж байна.

Хүснэгт 1. Дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсийн мөрдөгчдийн талаарх судалгаа

Батлагдсан орон тоо	Үүнээс бэлэн байгаа орон тоо	Үүнээс		Мөрдөгчөөр ажилласан туршлага /жилээр/						Нэгжээс шилжсэн, хөдөлгөөнд орсон алба хаагчдын тоо	
		эр	эм	1 жил хүртэл	1-2	2-3	3-4	4-5	5-аас дээш	2019 онд	2020 оны 1 улиралд
532	494	442	52	136	112	63	48	37	98	170	79
Хувь	93	89	11	27	23	13	10	7	20	34	16

Хүснэгт 2. Аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн мөрдөгчдийн талаарх судалгаа

Батлагдсан орон тоо	Үүнээс бэлэн байгаа орон тоо	Үүнээс		Мөрдөгчөөр ажилласан туршлага /жилээр/						Нэгжээс шилжсэн, хөдөлгөөнд орсон алба хаагчдын тоо	
		эр	эм	1 жил хүртэл	1-2	2-3	3-4	4-5	5-аас дээш	2019 онд	2020 оны 1 улиралд
741	687	659	28	165	87	72	52	75	238	78	98
Хувь	93	96	4	24	13	10	7	11	35	11	14

Мөрдөн байцаах албанаас мөрдөгчийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, мөрдөн шалгах ажиллагааг хялбаршуулах зорилгоор “хэргийн түүвэр, шалгах төлөвлөгөө”, “алба хаагчдын 7 хоног, өдөр тутмын ажлын төлөвлөгөө”-г цахимжуулж, Улсын бүртгэлийн ерөнхий газраас авдаг

зарим төрлийн лавлагаа, мэдээллийг цахим гарын үсгээр баталгаажуулан шууд авч ашиглахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Мэдээллийн технологи, холбооны төвийн энэ онд хийсэн судалгааны дүнгээс үзвэл 2019 онд цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь төрийн болон төрийн бус 117 байгууллагаас 472.065 лавлагаа, мэдээллийг 1.280.379 хуудас цаасаар авчээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийг шалгаж шийдвэрлэхийн тулд мөрдөгчид олон тооны лавлагаа, мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах шаардлага үүсч, тухайн байгууллагаас хариу ирэхгүй байх, эсхүл хугацаа алдаж ирдэг зэргээс мөрдөн шалгах ажиллагааны шуурхай байдал алдагдаж, ажлын ачаалал, зардал өсч байна.

2017 оноос хойш мөрдөн шалгах ажиллагааны зардалд төсөв батлагдах болсон бөгөөд 2020 онд батлагдсан 882.9 сая төгрөгөөс аймаг дахь цагдаагийн газар, хэлтэст 10.0, дүүрэг дэх цагдаагийн газарт хэлтсийн тоог харгалзан 23.5-38.0, Нийслэлийн цагдаагийн удирдах газарт 105 сая, бусад мөрдөн шалгах чиг үүрэгтэй нэгжүүдэд тодорхой хувь хэмжээгээр хуваарилан олгожээ /Хүснэгт 3/.

Хүснэгт 3. Мөрдөн шалгах ажиллагааны зардлын төсөв, түүний гүйцэтгэл

Мөрдөн шалгах ажиллагааны зардал төсөвт /сая төгрөгөөр/	2017	2018	2019	2020
Батлагдсан	202,5	527,1	1.027,1	882,9
Гүйцэтгэл	200	525,9	754,8	-

Мөрдөгчдийн ажлын ачааллын талаар урьд хийгдсэн судалгаа, дүн шинжилгээний ажлын дүгнэлт, статистик мэдээлэл нь мөрдөгчид, түүний дотор нийслэлийн төвийн дүүргүүд дэх цагдаагийн хэлтсийн мөрдөгч нар өндөр ачаалалтай ажиллаж байгааг харуулдаг.

Түүнчлэн Мөрдөн байцаах албанаас зохион байгуулсан хэд хэдэн удаагийн сэтгэл зүйн сорилд мөрдөгчдийн зүгээс өндөр ачаалалтай ажиллаж байгаа нь тэдний хувьд хамгийн тулгамдсан асуудал гэдгээ илэрхийлжээ.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2020 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.7-д заасны дагуу цагдаагийн байгууллагын мөрдөгчийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, удирдлагыг мэдээллээр хангах, мөрдөгчийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж хялбаршуулах,

ажлын ачааллыг бууруулах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хүргүүлж, үр дүнг тооцох.

2.2 Аудитын цар хүрээ

Аудитад эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх зорилгоор мөрдөн шалгах чиг үүргийг хэрэгжүүлж буй цагдаагийн байгууллагын мөрдөгч албан тушаал /эрүүгийн мөрдөгч, мөрдөгч, хэсгийн төлөөлөгч г.м/-д ажилладаг алба хаагчдаас явуулж буй мөрдөн шалгах ажиллагаа, түүнтэй холбогдуулан мөрдөгчдөөс хэрэгжүүлж буй бусад үйл ажиллагааг хамруулсан.

Мөрдөн шалгах нууц ажиллагаа, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон мөрдөгчөөс цагдаагийн алба хаагчийн нийтлэг чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлж буй бусад чиг үүрэг, үйл ажиллагааг аудитын объектод хамруулаагүй болно.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх чиглэлээр цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд холбогдох баримт бичиг, эрх зүйн актуудыг судалсан.

Мөрдөгчийн үйл ажиллагаанд тулгарч буй хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх асуудлаар нэгжийн удирдлага, алба хаагчдын санал, хүсэлтийг сонсох, аудитад шаардлагатай мэдээлэл цуглуулах зорилгоор Сүхбаатар, Хэнтий аймаг, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн газар, Налайх, Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн удирдлага, Эрүүгийн цагдаа, Мөрдөн байцаах, Хэрэг бүртгэх тасгийн дарга, алба хаагчидтай уулзалт, ярилцлага зохион байгуулсан.

Түүнчлэн мөрдөн шалгах чиг үүрэгтэй нэгжүүдээс хүний нөөцийн нөхөн хангалт, шилжилт хөдөлгөөн, мөрдөгчдийн ажлын туршлага, ачааллын талаарх мэдээлэл, мөрдөн шалгах ажиллагаа, мөрдөгчдийн үйл ажиллагаанд тулгарч буй хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх боломжийн талаар саналыг авч нэгтгэсэн.

Аудитын явцад цугларсан мэдээллийг харьцуулах, нягтлах, баталгаажуулах зорилгоор Эрүүгийн цагдаа, Мөрдөн байцаах, Санхүү, аж ахуй, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Хүний нөөц, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс, Интерполын үндэсний төв товчооны Ажлын албаны холбогдох алба хаагчидтай уулзалт, ярилцлага зохион байгуулсан.

Аудитын явцад цугларсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан “Урьдчилсан тайлан”-г бичиж, холбогдох нэгжүүдэд хүргүүлэн “Удирдлагын тайлбар”-ыг авч энэхүү тайланд тусгасан.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

Энэ хэсэгт аудитын явцад шууд илэрсэн асуудлуудаас гадна цуглуулсан мэдээлэлд аудиторын зүгээс хийсэн оюун дүгнэлтийн үр дүнд тодорхойлсон “асуудал”-уудыг ач холбогдлоор нь эрэмбэлэн орууллаа. Үүнд:

3.1 Шүүх, прокурор, цагдаа, мөрдөн шалгах ажиллагаанд оролцдог бусад төрийн байгууллагыг төсвөөс санхүүжүүлж, ажиллуулахын үндсэн зорилго бол “гэмтнийг олж тогтоон, зохих ял зэмийг хүртээх, хохирсон эрхийг сэргээх, улмаар нийгэмд шударга ёсыг тогтоож, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах, хүний эрхийг хангах” гэж энгийнээр томъёолж болно.

Гэвч дээрх субъектүүдээс тус тусын байгууллагын явцуу болон харьцангуй бага түвшний зорилгод автаж, “үндсэн зорилго”-оо хойш тавьдаг байдал нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцооны нэгдмэл, харилцан уялдаа, хамааралтай байх, хамтын ажиллагааны нягт байдлыг сулруулж байна.

Дээрх байгууллага, алба хаагчдын бодлого, үйл ажиллагаанд харилцан ойлгомжтой, хялбар байж, хатуу, хаалттай байр сууринаас аль болох зайлсхийн, асуудлаа ил тод, нээлттэй зөвшилцөх, гаргаж буй шийдвэр, түүний үр дагаврыг чөлөөтэй хэлэлцэх, бие биенээ дэмжих байдал үгүйлэгдэж байна.

3.2 Мөрдөн шалгах ажиллагаатай холбогдуулан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд хоорондын харилцаа, тэдгээрийн харилцан мэдээлэл солилцох боломж, хурд, хүсэл сонирхол сул байна.

Тухайлбал, үүрэн холбооны оператор компаниуд, банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа, мэдээлэл авахад учирч буй хүндрэл бэрхшээлийг тоочихоос өмнө төрийн байгууллага хооронд лавлагаа, мэдээлэл дамжуулахад зарцуулж буй цаг хугацаа, бичиг цаас, явдал чирэгдлийг ярих нь чухал байна.

Мөрдөн шалгах ажиллагааны чиглэлээр төрийн байгууллагуудаас харилцан дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах хурд өнөөгийн нийгмийн харилцаа, гэмт этгээдүүдийн хурдаас хоцорч, хохирсон эрхийг сэргээх хугацааг сунгасаар байна.

3.3 Бусад этгээдээс үл хамаарч цагдаагийн байгууллага дотооддоо шийдэх ёстой асуудал олон байна. Цахимаар, утсаар, эсхүл сангаас хялбар авчих боломжтой лавлагаа, мэдээллийг заавал албан бичгээр хандаж байгаа нь харилцан ачаалал нэмж байна.

Албад, төвийн хэлтэс, чиглэл хариуцсан нэгжүүдээс мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд анхан шатны нэгж, алба хаагчиддаа ойлгомжтой байх, асуудлыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх чиглэлээр тэдэнд мэдээлэл өгөх, дэмжлэгээ өсгөх нь зүйтэй.

3.4 Мөрдөн шалгах ажиллагааны явцад цагдаагийн байгууллага, мөрдөгч нь прокурор, шүүхийн байгууллагатай өргөн хүрээнд харилцдаг. Тиймээс ч мөрдөн шалгах ажиллагааг “ухаалаг” болгох ажил нь эдгээр байгууллагын идэвхи санаачлага, оролцоо, дэмжлэггүйгээр хэрэгжих боломжгүй юм.

Тухайлбал, мөрдөн шалгах ажиллагааны явцад прокурор, шүүхийн байгууллагатай харилцах ажиллагаа /хэргийн хугацаа сунгах, зөвшөөрөл авах, шийдвэр гаргуулах, зарим лавлагаа, мэдээллийг нотлох баримтын хэмжээнд үнэлдэг болох гэх мэт/-г цахимжуулах, хялбаршуулах, нэгдсэн ойлголтод хүрэхэд хамтын ажиллагаа зайлшгүй билээ.

Харамсалтай нь шүүх, прокурор, цагдаагийн байгууллага, тэдгээрийн харьяа нэгж, алба хаагчид нь асуудлыг өөр өөрийнхөөрөө ялгаатай тайлбарлаж, хэрэгжүүлэх, хувь хүний мэдлэг, туршлага, харилцааны ур чадвар, хувийн сонирхлоос үүдэлтэй тэдний хооронд үл ойлголцол үүсэх, бие биедээ үл итгэх байдал оршоор байна.

Онолын хувьд хяналт нь эрсдэлд суурилж хэрэгжих учиртай бөгөөд хэтэрсэн хяналтын механизм нь хэвийн үйл ажиллагааг алдагдуулах эрсдэлтэй юм. Гэвч цагдаа нь цагдаагаа, прокурор нь прокуророо, прокурор нь мөрдөгчөө, шүүхээс бүгдийг нь шат шатандаа хянах гэсэн оролдлого нь үндсэн зорилгоосоо холдон, тогтолцооны ажиллагааг удаашруулж, зарим тохиолдолд гацаах хүртэл хэмжээнд хүрчээ.

3.5 Цагдаагийн байгууллагад шинэ зүйлийг санаачлах, дэмжих, турших, нэвтрүүлэх, болохгүй бол өөрчлөх, сайжруулах, бүр зогсоох хурд удаан байна. Үүнд шат шатны удирдлага, алба хаагчдын “алдахаас айх” хандлага нөлөөлж байна гэж үзлээ.

Тухайлбал, мөрдөгчийг зэрэгтэй болгох, мөрдөгчийн стандарт ажлын ачааллыг тодорхойлох, цалингийн шатлал, зэрэглэлийг ялгамжтай тогтоох, зарим үйл ажиллагааг эхлүүлэх, өөрчлөх, эсхүл зогсоох зэрэг алба хаагчдаас гаргаж буй санал, санаачлага бүрийг туршиж, алдаж, онох замаар хамгийн зөв, оновчтой хувилбар, стандарт, шийдлээ олдог байх нь зүйтэй.

3.6 Зөвхөн дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн мөрдөгчид ч биш, ажил, ачаалал ихтэй, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад зайлшгүй шаардлагатай хүний нөөц, төсөв, санхүү, техник хэрэгслээр бүрэн хангагдаагүй нэгжийн удирдлага, алба хаагчдын хичээл зүтгэлийг жижүүрт хоносон ч маргааш нь ажлаа бодоод амарч чаддаггүй мөрдөгч, албаны унаагүй алслагдсан сумын хэсгийн төлөөлөгчөөр жишээлж болно.

Цаашид цагдаагийн байгууллага, алба хаагчид нь дутуу ч гэлээ болгож бүтээх, аргалж аргацаах гэсэн бодлого, хандлагаа өөрчилж, тулгарч буй асуудал, бэрхшээлээ эрх бүхий албан тушаалтанд санаа зовж, ичиж нэрэлхэлгүй илэрхийлэн, зоригтой шаардаж шийдвэрлүүлэх ёстой.

3.7 Аливаа байгууллагын удирдлагын тогтолцооны зөв хэлбэрийг пирамидтай зүйрлүүлдэг. Пирамидын орой данхайж, өргөжихийн хирээр эрх мэдлийн төвлөрөл үүсч, дээрээс доош чиглэсэн дарамт шахалт, бичиг цаасны эргэлт өсч, ажлын ачаалал нэмэгдэх, дээд, доод шатны харилцааны суваг нарийсч, аажмаар харилцан үл зөвшөөрөх байдал үүсдэг байна.

Иймд цагдаагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтын бүтэц, орон тооны зохистой байдлыг ямагт хянаж, албад, төвийн хэлтэс, нэгжүүдээс анхан шатны нэгжийн үйл ажиллагаанд оролцох хэлбэр, хир хэмжээ, мөрдөн шалгах чиг үүрэгтэй нэгжүүдийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох нь зүйтэй юм.

3.8 Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсээс өгсөн мэдээллээс үзвэл сүүлийн 3 жилийн дунджаар жил бүр 630 офицер, 512 ахлагч цагдаагийн байгууллагаас гарч, 316 офицер, 638 ахлагч шинээр томилогджээ /Хүснэгт 4/.

Хүснэгт 4. Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн шилжилт, хөдөлгөөн /2017-2019/

	Халагдсан		Чөлөөлөгдсөн		Тэтгэвэрт		Хүүхэд асрах чөлөөтэй		Нас барсан		Шинээр томилогдсон	
	оф	ах	оф	ах	оф	ах	оф	ах	оф	ах	оф	ах
2017	44	95	117	163	253	154	56	28	6	6	82	*
2018	110	97	295	185	329	150	92	25	10	7	579	854
2019	67	107	220	377	200	84	55	53	5	4	288	1061
Нийт	221	299	632	725	812	388	203	106	21	17	949	1915
Дундаж	64	100	211	242	271	129	68	35	7	6	316	638

*Аудитын явцад Хүний нөөцийн хэлтсээс тухайн үзүүлэлтэд харгалзах мэдээллийг гаргаж өгөөгүй болно.

Дээрх мэдээллийг өмнөх 3 жил /2014-2016/-ийнхтэй харьцуулбал жилд дунджаар цагдаагийн байгууллагаас гарсан офицерын тоо 1.8 дахин, ахлагчийн тоо 1.2 дахин өссөн дүнтэй байгаа нь цагдаагийн байгууллагаас гарах алба хаагчдын тоо өссөнийг харуулж байна.

Түүнчлэн Цагдаагийн ерөнхий газраас хүний нөөцийн чиглэлээр нэг жилд гарсан тушаалын тоо 1000-аас давсан нь 5-8 жилийн өмнөхтэй харьцуулбал бараг 2 дахин өссөн дүнтэй байна.

Дээрх мэдээллүүдийг нэгтгэн дүгнэвэл цагдаагийн байгууллагын хүний нөөцийн оролт нь гаралтаа гүйцэхгүй, улмаар байнгын дутуу орон тоотой ажиллаж байгаа нь алба хаагчдын ачааллыг нэмэгдүүлэх нэг шалтгаан болж байна. Нөгөө талаас хүний нөөц тогтворгүй, шилжилт

хөдөлгөөн их байдлаас шалтгаалан үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй байдал, залгамж чанар алдагдах, эзэнгүйдэж саатах эрсдэл үүсч байна.

3.9 Дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсийн мөрдөгчдийн 50.0 хувь нь 2 жил хүртэл, 80.0 хувь нь 5 жил хүртэл хугацаанд мөрдөгчөөр ажилласан туршлагатай байхад орон нутагт мөрдөгчдийн 37.0 хувь нь 2 жил хүртэл, 65.0 хувь нь 5 жил хүртэл хугацаанд мөрдөгчөөр ажиллаж байна.

Харьцангуй туршлагатай алба хаагчдыг албад, төвийн нэгжүүдэд томилж ажиллуулах нь зүйн хэрэг боловч анхан шатны нэгжийн мөрдөгчдийн ажил, амьдралын туршлагын зохист харьцааг анхаарах цаг болжээ.

Олон жил ажилласан туршлагатай мөрдөгчдийн өгүүлж буй “харж суралцах үе” буюу зааж чиглүүлэх дээд үегүй байх нь шинэ залуу алба хаагчдын ажлын байран дээрээ сурч дадлагажих боломжийг хумиж, алдаа дутагдал гаргах эрсдэлийг өсгөж байна.

Хэдийгээр Дотоод хэргийн их сургуулийн сонсогчдын мөрдөн шалгах ажиллагааны дадлагыг үр дүнтэй байлгах талаар чиглэлийн алба, нэгжүүд хичээж байгаа ч энэ нь дөнгөж төгсөөд мөрдөгчөөр томилогдож буй алба хаагчдын хувьд хангалтгүй юм. Нөгөө талаас ахлагч бүрэлдэхүүн, бусад нөөцөөс мөрдөгчөөр томилогдмогц тухайн алба хаагчдад чиглэсэн мэргэшүүлэх сургалт явагдахгүй байгаа нь ноцтой үр дагавар үүсгэх эрсдэлтэй юм.

3.10 Цагдаагийн байгууллагын төсөвт мөрдөн шалгах ажиллагааны зардалд зориулагдсан төсөв батлагддаг болсноор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай байдал, оролцогчдын эрх ашгийг хамгаалах ажилд дэвшил гарсан.

Засгийн газрын 2018 оны 161 дүгээр тогтоолоор “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох, санхүүжүүлэх журам”-ыг баталж мөрдүүлсэн хэдий ч мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой зарим зардлыг тооцож олгох талаар нэг мөр ойлголтгүй, зарим цагдаагийн байгууллага, нэгжээс энэ чиглэлээр олгогдсон төсвөө огт зарцуулаагүй, 2019 оны төсвөөс 272.2 сая төгрөг зарцуулагдалгүй үлдсэн байна.

3.11 Аливаа зүйл олон талтай байдаг шиг мөрдөгчийн үйл ажиллагаатай холбоотой дээр дурдсан асуудал нь маш олон хүчин зүйлсийн харилцан хамаарлаас шалтгаалж байгаа ч алба хаагчийн мэдлэг, туршлага, сэтгэл зүй, харилцааны ур чадвар, идэвх санаачлага, хувийн зохион байгуулалт голлох нөлөөтэйг аудитын багаас онцолж байна.

Мөрдөгчийн ажлын ачаалал, сэтгэл зүйн талаар олон тооны судалгаа, санал асуулгууд явагддаг ч үр дүн нь эргэж мэдээлэгддэггүй, өөрчлөгдөж шинэчлэгдсэн зүйл төдийлөн ажиглагддаггүй талаар алба хаагчид үзэл бодлоо илэрхийлсэн.

Мөрдөн байцаах албанаас энэ онд “Жи Си Ай” төрийн бус байгууллагаар хийлгэсэн сэтгэл зүйн сорилын урьдчилсан дүгнэлтэд “Судалгаанд оролцсон мөрдөгчдийн 70.0 хувь нь боломж олдсон тохиолдолд ажлын байраа орхих сэдэлтэй байна” гэсэн нь цагдаагийн байгууллагаас мөрдөгч, тэдний үйл ажиллагааны талаар яаралтай арга хэмжээ авах цаг болсныг анхааруулж байна.

4. ДҮГНЭЛТ

Урьд хийгдсэн олон тооны судалгаа, дүн шинжилгээний ажлын тайлан, сэтгэл зүйн сорилын дүгнэлт, алба хаагчидтай хийсэн уулзалт, ярилцлагын үр дүнгээс үзвэл цагдаагийн байгууллагын мөрдөн шалгах чиг үүрэгтэй нэгж, алба хаагчдын хувьд хамгийн тулгамдсан асуудалд ажлын ачаалал орж байна.

Алба хаагчдын амрах, нөхөн сэргэлт авах, сурч хөгжих, ар гэртээ зарцуулах цаг буурах, стресс, ядаргаанд орж, биеийн эсэргүүцэл суларч, эрүүл мэнд доройтох, улмаар ажлын бүтээмж буурч, алдаа гаргах, ажилдаа сэтгэл ханамжгүй болох зэрэг нь ажлын ачааллаас үүдэлтэй олон сөрөг үр дагаврын зарим нь юм.¹

Хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, орон тоог нэмэх замаар мөрдөгчийн ажлын ачааллыг бууруулах оролдлого нь дан ганц цагдаагийн байгууллагын хүсэл сонирхлоор шийдэгддэггүй, нөгөө талаас байгууллагын хүний нөөц, санхүүгийн боломжоор хязгаарлагдсан амаргүй ажил байдаг.

Нөгөө талаар хэрэг шалгах харьяаллыг өөрчлөх, гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгуулахаар, зарим хороо, нутаг дэвсгэрийг нэгээс / мөрдөгч, тасаг, хэлтэс/ нөгөөд шилжүүлэх зэргээр ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор хийгдэж ирсэн алхамууд нь мөрдөгчийн ачааллыг бодитой бууруулахгүй, түр аргацаасан, үр дүн багатай арга нь харагдаж байна.

Тиймээс энэхүү аудитын гол зорилго нь мөрдөгчийн ачааллыг бууруулахын тулд хууль тогтоомжийг өөрчлөх, төсөв, санхүү, орон тоог нэмэгдүүлэх санал, санаачлага гаргах бус, одоо байгаа эрх зүйн орчин, нөхцөл байдал, боломжийн хүрээнд мөрдөгчийн үйл ажиллагааг “ухаалаг” болгох буюу одоо байгаа түвшнээс илүү шуурхай, хялбар, оновчтой, явдал чирэгдэл, шат дамжлага, дарамт шахалт, бичиг цаас, үргүй зардал багатай болгох чиглэлээр санал, зөвлөмж гаргах явдал байсан.

Гэвч аудитын явцад цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийхийн хирээр цагдаагийн байгууллага, нэгжийн мөрдөн шалгах ажиллагаа, мөрдөгчийн үйл ажиллагаанд тулгамдсан асуудлын суурь шалтгаан нь дан ганц тэдний асуудлаас хальсан, илүү ерөнхий шинжтэй, өргөн хүрээтэй асуудал болох нь ажиглагдсан.

Өөрөөр хэлбэл эдгээр суурь шалтгааныг анхаарч үзэхгүй

¹ Цагдаагийн алба хаагчийн аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлангаас, 2019 он

өнгөрөх, цаашид гүнзгийрүүлэн судалж, шат шатандаа хэлэлцэж, шийдвэрлэхгүйгээр аливаа өөрчлөлт, сайжруулалт хийх нь бат бөх хөрсөнд суугаагүй хэврэг, өнгөцхөн буюу “косметик” шинжтэй ажил болох эрсдэлтэй байна.

Аудит нь аливаа зөв ажлыг үгүйсгэж харлуулах өчүүхэн ч зорилго агуулаагүй бөгөөд мөрдөгчийн үйл ажиллагааг хялбаршуулах, боловсронгуй болгох чиглэлээр албад, нэгжүүдээс санаачлан хэрэгжүүлсэн ажил, сайн туршлагыг бас энд дурдах нь зүйтэй.

Тухайлбал, үйл ажиллагааг цахимжуулж, хялбаршуулах чиглэлээр Мөрдөн байцаах алба, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ /хэргийн түүвэр, шалгах төлөвлөгөөний програм, 102 дугаарын утсанд ирсэн гэмт хэргийн талаарх дуудлага, мэдээллийг тухайн нутаг дэвсгэр хариуцсан нэгжийн удирдлагуудын гар утсанд мессэжээр мэдэгдэх, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвөөс камерын бичлэг авах ажиллагааг цахимжуулах гэх мэт/, мөрдөгчийн үйл ажиллагааг хялбаршуулах чиглэлээр зарим дүүрэг дэх цагдаагийн газраас хэрэгжүүлсэн сайн туршлага /жижүүр прокурор томилуулж ажиллуулах, яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй, хийгдвэл зохих бүх ажиллагаа нь хийгдсэн хэргүүдийг нэг мөрдөгчид хариуцуулж, бусдынх нь ажлын ачааллыг бууруулах гэх мэт/-ыг онцолж байна.

Хуулийг хэрэгжүүлэхэд гарч буй техник ажиллагаатай холбоотой хүндрэлүүдийг “хууль буруу” гэж тайлбарлах нь өрөөсгөл юм. Харин нэгэнт батлагдсан хуулийг хэрэгжүүлэх дэд бүтцийг илүү оновчтой, шуурхай, хялбар, товчхон хэлбэл “ухаалаг”-аар бий болгоход бүх талууд /төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд/-ын оролцоо, хамтын ажиллагаа чухал байна.

Иймд цагдаагийн байгууллагаас санаачлан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудал, хүндрэл бэрхшээл, гарц шийдлээ тус тусдаа биш хамтарч хэлэлцэх, бүх талуудын оролцоог хангасан өргөн хүрээтэй ажил хэргийн яриа, уулзалт, нэгдсэн хэлэлцүүлгийг зохион байгуулж, үр дүнтэй гарц, шийдлийг дэвшүүлж, хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

5. ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, илэрсэн асуудал, аудитын дүгнэлтийг үндэслэж, холбогдох нэгжүүдээс ирүүлсэн “Удирдлагын тайлбар”-ыг харгалзан, мөрдөгчийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, илэрсэн асуудлуудыг шийдвэрлэх чиглэлээр дараах саналуудыг илтгэн танилцуулж байна. Үүнд:

5.1 Удирдлагын босоо тогтолцоотой цагдаагийн байгууллагад аливаа асуудлыг эцэслэн шийдвэрлэх гол эрх мэдэл нь Цагдаагийн

ерөнхий газрын дарга, түүний зөвлөлийн гишүүдэд байдаг. Иймд мөрдөгчийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр удирдлагаас дараах бодлого, чиглэлийг баримтлан ажиллахыг зөвлөж байна. Үүнд:

- Мөрдөгчийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, ачааллыг бууруулах чиглэлээр хэрэгжих ач холбогдол бүхий ажил, арга хэмжээг зөвөөр ойлгож, бүх талаар дэмжих

- Цагдаагийн байгууллагын мөрдөн шалгах ажиллагааг “ухаалаг” болгох, тулгамдаж буй асуудлаа хамтран шийдвэрлэх чиглэлээр дээд шатны байгууллага, албан тушаалтан, шүүх, прокурор, бусад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй ил тод, нээлттэй байр сууринаас идэвхитэй харилцаж, хамтран ажиллах

- Байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох алба, нэгжийн удирдлага, алба хаагчдаас гаргасан аливаа санал, санаачлагыг аль болох хэрэгжүүлж нэвтрүүлэх байдлыг эрхэм болгон дэмжин урамшуулах,

- Аймаг, дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсийн удирдлагад хариуцсан нутаг дэвсгэрийн хүрээнд үйл ажиллагаагаа оновчтой удирдан, зохион байгуулахад шаардлагатай хүний нөөц, төсөв, санхүү, бусад эрх мэдлийг нэмэгдүүлэн олгох асуудлыг шийдвэрлэх

5.2 Аудитаар илэрсэн асуудлыг шийдвэрлэх зорилгоор холбогдох нэгжүүдэд дараах зөвлөмжийг хүргүүлэх. Үүнд:

Захиргааны удирдлагын газарт:

- Орон тоог нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлагаас өмнө батлагдсан орон тоондоо хүний нөөцийг нь бүрэн бүрдүүлж ажиллах нь мөрдөн шалгах чиг үүрэгтэй нэгж, цаашилбал цагдаагийн байгууллагын хүний нөөцийн тулгамдсан асуудал болж байна. Иймд хүний нөөцийн нөхөн хангалт, томилгоог одоо байгаа түвшнээс илүү шуурхай, хялбар зохион байгуулах, үүний тулд шаардлагатай дүрэм, журам, үйл ажиллагааны өөрчлөлтийг санаачлан хэрэгжүүлэх

- Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, алба хаагчийг анх томилогдсон албан тушаалд тогтвортой ажиллуулах шаардлагыг хэрэгжүүлэх үр дүнтэй бодлого боловсруулж мөрдөх

- Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн нөхөн хангалт, шилжилт хөдөлгөөн, тогтвортой байдлын талаарх тоон мэдээлэл, судалгааг тогтмол гаргаж, дүн шинжилгээ хийх, тэдгээрийн шалтгаан, нөхцлийг нарийвчлан судалж, цаашид хүний нөөцийн чиглэлээр баримтлах бодлого, чиглэлийг оновчтой тодорхойлох

- Мөрдөгчийн албан тушаалд шинээр томилогдсон Дотоод хэргийн их сургуулийн төгсөгч, ялангуяа ахлагч бүрэлдэхүүн, энгийн

их, дээд сургууль төгссөн алба хаагчдын зайлшгүй хамрагдвал зохих сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсруулж, тухайн албан тушаалд томилогдонмогц мэргэшүүлэх сургалтад хамруулж байх

- Дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн Эрүүгийн цагдаа, Мөрдөн байцаах, Хэрэг бүртгэх тасгийн орон тоог бууруулалгүйгээр Нийслэлийн төвийн дүүргүүд дэх цагдаагийн газрын хэлтсүүдэд жижүүрийн мөрдөгчийн орон тоо бий болгох асуудлыг холбогдох албадтай хамтран судалж шийдвэрлэх

- Гүйцэтгэж буй чиг үүргийн онцлог, хариуцлага, ажлын өндөр ачаалалтай байдлыг харгалзан Нийслэлийн төвийн 6 дүүрэг дэх цагдаагийн газрын мөрдөгчдийн албан тушаалын цалингийн зэрэглэлийг ахиулах асуудлыг судалж шийдвэрлэх

Мөрдөн байцаах, Эрүүгийн цагдаа, Хэрэг бүртгэх албанд:

- Цагдаагийн байгууллагын мөрдөн шалгах ажиллагаа, мөрдөгчийн үйл ажиллагааг “ухаалаг” болгох, тулгамдаж буй асуудлыг хамтран шийдвэрлэх чиглэлээр шүүх, прокурорын байгууллагатай идэвхитэй харилцаж, хамтран ажиллах, уулзалт, хэлэлцүүлгийг өргөжүүлсэн хэлбэрээр зохион байгуулж, бодитой үр дүн гаргах

- Мөрдөн шалгах ажиллагааны явцад төрийн байгууллага, аж ахуйн нэгжээс авах шаардлагатай аливаа лавлагаа, мэдээллийг шуурхай, хялбар, цахимаар авах боломж, шийдлийн талаар холбогдох байгууллагуудтай хамтарсан уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, бодитой үр дүн гаргах

- Мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд хийгдэх бүх төрлийн шинжилгээ, үнэлгээ, аудитын дүгнэлт, орчуулга, үгийн тайлбар зэргээр жагсаалт, сан үүсгэх, тэдгээрийг олон дахин ашиглах боломжийг судалж, шийдвэрлэх

- Дуу, дүрсний бичлэг хийх болон бусад шаардлагатай техник, хэрэгслээр тоноглогдсон мөрдөгчийн өрөөний стандартыг боловсруулж, мөрдүүлэх

- Нэг мөрдөгчийн сард гүйцэтгэвэл зохих ажлын бүтээмж, стандарт ачааллыг бодитой судалж, тодорхойлох

- Гэмт хэргийн төрлөөс хамаарч түүнийг шалгахад хийгдвэл зохих ажиллагааг тус бүрт нь гарган, тодорхой хэмжүүрээр илэрхийлж, нэгж, алба хаагчдын ажлын ачааллыг тодорхойлох, ажлын үр дүнг хэмжихэд ашиглах

- Алба хаагчдыг сэлгэн ажиллуулах нь нэгж, алба хаагчдын хооронд ажлын туршлага, мэдлэгийг дамжуулах, алба хаагчдыг сурган дадлагуулах, ажил сайжруулах үр дүнтэй арга тул цаашид ажлын ачаалал багатай нэгжээс ачаалал ихтэй нэгжид алба хаагчдыг аль болох боломжит урт хугацаагаар сэлгэн томилж ажиллуулах

- Мөн аудитын явцад алба хаагчдаас гаргасан дараах саналуудыг

судалж шийдвэрлэх нь зүйтэй. Үүнд:

- ШШГЕГ-ын 461 дүгээр ангид хүн цагдан хорихтой холбогдуулан шүүхийн тогтоолыг биетээр хүргэж өгдөг ажиллагааг цахимжуулах
- Бусад нэгжээс эрүүгийн хэргийг нэгтгүүлэхээр шилжүүлэн ирүүлэхээс зайлхийж, яллагдагчаар таталгүй, хэрэг шалгах ажиллагааг удаашруулдаг байдлыг таслан зогсоох
- Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангаас гардаг лавлагаа, мэдээллийг нотлох баримтын хэмжээнд үнэлүүлэх асуудлыг судалж шийдвэрлүүлэх
- Нийтийн хэв журам хамгаалах тасгийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр зарим ажлын үзүүлэлтийг тусгах замаар тэднээс мөрдөгчийн үйл ажиллагаанд үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх
- Ажил дүгнэх үзүүлэлт, сарын ажлын мэдээ таслах хугацаа, хэргийн хугацааг цахимаар сунгах болон бусад асуудлыг прокурорын байгууллагатай зөвшилцөн уялдуулах
- Прокурорын шаардлагын мөрөөр алба хаагчдад арга хэмжээ авахыг урьтал болгохгүй, ажлын үр дүн, бодит нөхцөл байдлыг харгалзан үзэх
- Зайлшгүй ажлын шаардлагатайгаас бусад тохиолдолд мөрдөгчдийг бусад мөрдөн шалгах байгууллага, нэгж дээр “Ажлын хэсэг”-т татан оролцуулахгүй байх, түүнд ажил, ачаалал багатай нэгжээс алба хаагчдыг татан оролцуулахад анхаарах.

Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанд:

- Мөрдөгчийн үйл ажиллагааг цахимжуулах, ялангуяа бусад төрийн байгууллага, аж ахуйн нэгжээс лавлагаа, мэдээллийг цахимаар авч байх талаар холбогдох албадыг дэмжиж хамтран ажиллах
- Анхан шатны нэгжийн мөрдөгчдөөс албад, төвийн хэлтсийн мөрдөгчдийн нэгэн адил мэдээллийн санд хандах, мэдээлэл, лавлагаа авах эрхийг нэмэгдүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх
- Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангуудаас гарч буй лавлагаа, мэдээллийн хэлбэр, загварыг сайжруулж, өөрчлөх замаар прокурор, шүүхийн байгууллагад нотлох баримтын хэмжээнд үнэлүүлэх боломжийг судалж, хэрэгжүүлэх

Санхүү, аж ахуйн албанд:

- Засгийн газрын 2018 оны 161 дүгээр тогтоолоор батлагдсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох, санхүүжүүлэх журам”, “Цогцост үзлэг хийх, зөөвөрлөх, задлан шинжлэх ажиллагаанд оролцсон алба хаагчид нэмэгдэл олгох /Код 810/ журам”-д заасны дагуу нэмэгдлийг зохих зардлаас олгуулах

- Мөрдөн шалгах чиг үүрэгтэй нэгжийн алба хаагчдад олгох харилцаа холбооны зардлыг шийдвэрлэж, бичиг хэргийн зардлыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах

- Суманд ажиллаж буй хэсгийн төлөөлөгч нарын албаны тээврийн хэрэгслийн судалгааг гаргаж, тэднийг албаны унаагаар хангах асуудлыг судалж, үе шаттайгаар шийдвэрлэх

Аймаг, дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтэст:

- Зарим дүүрэг дэх цагдаагийн газраас мөрдөн шалгах ажиллагаанд хэрэгжүүлж буй оновчтой ажил, арга хэмжээг судалж нэвтрүүлэх /прокурорын байгууллагатайгаа зөвшилцөн жижүүр прокурор ажиллуулах, яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй хэргүүдийг нэг буюу хэд хэдэн мөрдөгчид төвлөрүүлж, бусад мөрдөгчдийн ачааллыг бууруулах, хэсгийн байцаагчдыг ээлжээр жижүүрт гаргаж, зөрчил шалгуулах гэх мэт/

- Зарим аймаг, дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсээс 2019 онд олгогдсон мөрдөн шалгах ажиллагааны зардлыг огт зарцуулаагүй, эсхүл дутуу зарцуулсан зэргээс үзвэл тухайн нэгжийн удирдлага, алба хаагчид энэ талаарх мэдээлэл дутуу байна гэж дүгнэхээр байна. Иймд нэгэнт олгогдсон төсөв зардлыг зориулалтын дагуу зарцуулж, үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах

- Шинэ томилогдсон мөрдөгчдийг сурган дадлагажуулах, тэднээс прокурор, шүүхийн байгууллагын төлөөлөл, иргэдтэй харилцах ур чадвар, сэтгэл зүйн бэлтгэлийг дээшлүүлэх чиглэлээр илүү туршлагатай алба хаагчдыг дагалдуулах, үр дүнг тооцох

- Аймаг, сумын нутгийн өөрөө удирдах байгууллагын дэмжлэгийг авч, сум дахь хэсгийн төлөөлөгчдийг албаны унаагаар хангах асуудлыг шийдвэрлүүлэх

Зөвлөмж хүлээн авсан нийт байгууллага, нэгжид:

- Аудитын мөрөөр өгөх санал, зөвлөмжид аудитаар илэрсэн асуудал бүрийг хэрхэн шийдвэрлэхийг нэг бүрчлэн зааж тусгах боломжгүй тул аудитаар илэрсэн асуудал, аудитын дүгнэлт, хөндөгдсөн бүхий л асуудлаар байгууллага, нэгжүүд хамтран байр суурь, гарц шийдлээ боловсруулж, хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

- Зөвлөмж хүлээн авсан байгууллага, нэгж нь түүний хэрэгжилтийг хангаж, биелэлт, үр дүнг тооцон, энэ оны 11 дүгээр сарын 15-ны дотор Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын нэр дээр ирүүлнэ.

6. УДИРДЛАГЫН ТАЙЛБАР

Аудитын урьдчилсан тайланг холбогдох нэгжүүдэд хүргүүлсний дагуу ирүүлсэн “Удирдлагын тайлбар”-уудыг энэхүү тайланд хавсаргав.

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас бусад байгууллагатай хамтран ажиллах зорилгоор байгуулсан санамж бичиг, гэрээний хэрэгжилтэд хийх дотоод аудит

Аудитын төрөл, код: Гүйцэтгэлийн аудит, ЦЕГ-ХШДАХ/ГА-2020/01

Аудитын хугацаа: 2020.01.23- 2020.02.19

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх

1. ТАНИЛЦУУЛГА

“Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах / Код 240/ журам”-д “санамж бичиг”-ийг гэрээний нэгэн адил эрх зүйн үр дагаваргүй бөгөөд зөвхөн талуудын харилцан итгэлцэл дээр тулгуурлан хэрэгжих хэлцлийн нөхцлийг агуулсан баримт бичиг гэж тодорхойлоод цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас бусад байгууллагатай хамтран ажиллах зорилгоор санамж бичиг, гэрээг хэрхэн байгуулах, бүртгэх, хяналт тавих, хэрэгжилтийг хангаж, тайлагнах асуудлыг зохицуулжээ.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ бусад байгууллагатай хамтран ажиллах, харилцан дэмжлэг үзүүлэх зорилгоор хамтран ажиллах гэрээ, санамж бичгийг харилцан тохиролцсон нөхцлөөр байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аудитын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст хадгалагдаж байсан 25 санамж бичиг, хамтран ажиллах гэрээний судалгаа /Хавсралт 1/-г гаргаж, холбогдох нэгжүүдээс тэдгээрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг авч нэгтгэсэн.

Түүнчлэн аудитын явцад холбогдох нэгжүүдээс ирүүлсэн мэдээллийн дагуу Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст бүртгэгдэж, хяналтад авагдаагүй 13 санамж бичиг, гэрээ /Хавсралт 2/-ний судалгааг нэмж гаргалаа.

Санамж бичиг, гэрээний хэрэгжилтийг хариуцаж буй нэгж	ЭЦА	МБА	НХЖХ ОНАБХА	ТЦА	МДШУА	НЦУГ	ДЦШ	ХТТГ	БХТ	ТЗБХ	СГАСХ	АБХ	УСХ	ГХХХ	ИУТГАА
Санамж бичиг, гэрээний тоо	5	6	3	1	8	1	2	3	1	1	1	1	5	3	1

Санамж бичиг, гэрээг зорилгоор нь ангилбал; гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 10, гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр 4, эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны чиглэлээр 7, мэдээллийн технологи, сангийн чиглэлээр 9, бусад чиглэлээр 8 санамж бичиг, гэрээ байгуулагджээ.

Санамж бичиг, гэрээг хоёр болон түүнээс дээш талтайгаар Зэвсэгт хүчний жанжин штаб, Үндэсний аудитын газар, Авлигатай тэмцэх газар, Онцгой байдлын ерөнхий газар зэрэг 25 төрийн байгууллага, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Монголын оюутны холбоо, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Нийслэлийн сэтгүүлчдийн нэгдсэн холбоо зэрэг 9 төрийн бус байгууллага, Оюутолгой, Монгол шуудан, үүрэн холбооны оператор компаниуд, банкууд зэрэг 14 аж ахуйн нэгж, бусад 6 этгээдтэй байгуулсан байна.

Санамжбичиг,гэрээнийхэрэгжилтийнталаархмэдээллийгхариуцсан нэгжүүдээс авч үнэлэхэд; гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн технологи, сангийн чиглэлээр байгуулсан санамж бичиг, гэрээнүүд илүү бодитой хэрэгжиж, тодорхой үр дүнд хүрчээ. Тухайлбал, Мобиком корпораци, Оюутолгой ХХК-тай хамтран хэрэгжүүлсэн “Яараад яахав дээ”, “Дураараа биш ээ дүрмээрээ”, “Жи Си Ай Монгол” ТББ-тай хамтран хэрэгжүүлсэн “Нэг хором” аянууд, Үндэсний дата төв УТҮГ, Мал эмнэлгийн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монгол шуудан ХК, үүрэн холбооны оператор компаниуд, банкуудтай байгуулсан санамж бичиг, гэрээний хүрээнд цагдаагийн байгууллага, алба хаагчийг шаардлагатай мэдээллийн сангаар хангах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг хялбаршуулах чиглэлээр хийгдсэн ажлуудыг энд дурдаж болно.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2020 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.2-т заасны дагуу цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас бусад байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр байгуулсан санамж бичиг, гэрээний хэрэгжилтэд дотоод аудит хийж, удирдлагыг мэдээллээр хангах, аудитын объектыг боловсронгуй болгох, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хүргүүлж, үр дүнг тооцох нь дотоод аудитын зорилго юм.

2.1 Аудитын цар хүрээ

Аудитад Цагдаагийн албаны тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсэгт заасны дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон хууль тогтоомжийн дагуу хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас бусад байгууллагатай байгуулсан хамтран ажиллах гэрээ, санамж бичгийн хэрэгжилтийг хамруулна.

Дээрх зорилгоор байгуулагдсан нууцын зэрэглэлтэй болон Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст бүртгэгдээгүй аудитын явцад ил болсон санамж бичиг, гэрээний хэрэгжилтийг аудитын объектод хамруулаагүй болно.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас бусад байгууллагатай хамтран ажиллах талаарх эрх зүйн зохицуулалт, Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст хадгалагдаж буй санамж бичиг, гэрээг нэг бүрчлэн судалсан.

Дээрх санамж бичиг, гэрээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг холбогдох алба, нэгжүүдээс авч дүн шинжилгээ хийсэн. Мөн санамж бичиг, гэрээний нөгөө тал болох төрийн болон төрийн бус зарим байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзалт, ярилцлага зохион байгуулсан.

Түүнчлэн санамж бичиг, гэрээний талууд, хугацаа, зорилго, биелэлтийн талаарх нэгдсэн судалгаа гаргаж, аудитад ашиглан, энэхүү тайланд хавсаргасан.

Аудитын явцад цугларсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан “Урьдчилсан тайлан”-г бичиж, холбогдох нэгжүүдэд хүргүүлэн “Удирдлагын тайлбар”-ыг авч энэхүү тайланд тусгасан.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 “Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах / Код 240/ журам”-д цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгж нь бусад байгууллагатай хамтран ажиллах тухай санал, хүсэлтээ Захиргааны удирдлагын газрын даргаар уламжлуулан Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулж, шийдвэрлүүлэх, шаардлагатай бол санамж бичиг, гэрээний төслөө Хуулийн хэлтсээр хянуулах, байгуулсан санамж бичиг, гэрээг Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст хүргүүлж, бүртгүүлэх, хамтран ажилласан явц байдал, үр дүнгийн талаарх танилцуулгыг мөн хэлтэст улирал бүр хүргүүлэхээр тус тус зохицуулсан.

Журмын энэхүү зохицуулалт нь цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас бусад байгууллагатай хамтран ажиллах үйл ажиллагааг нэгдсэн бодлого, бүртгэл, хяналттай байлгах, санамж бичиг, гэрээний ач холбогдол, үр дүнг тооцож үнэлэх зүй ёсны шаардлагыг хангахад чиглэгдсэн.

Гэвч Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст санамж бичиг, гэрээний нэгдсэн бүртгэл хөтлөгдөөгүй, санамж бичиг, гэрээг бүртгүүлэх, тэдгээрийн хэрэгжилт, үр дүнг тооцож ирүүлэх талаар ажил хариуцсан алба хаагч холбогдох нэгжүүдэд хяналт тавьж ажиллаагүй байна.

3.2 “Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах / Код 240/ журам”-ын 240.5.2-т хамтран ажиллах гэрээ, санамж бичгийг Төлөвлөлт, зохион байгуулалт хариуцсан нэгжид ажлын 3 хоногийн дотор хүргүүлж, бүртгүүлэхээр заасан боловч аудитын явцад цуглуулсан мэдээллээр бүртгэлгүй 13 санамж бичиг, гэрээ /Хавсралт 2/ байна. Аймаг дахь цагдаагийн газар, хэлтсээс тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгжтэй байгуулсан санамж бичиг, гэрээг нэмбэл дээрх тоо өсөх хандлагатай.

Мөн журмын 240.5.7-д санамж бичиг, гэрээний хэрэгжилтийг хариуцсан нэгж нь тухайн байгууллагатай хамтран ажилласан явц байдал, үр дүнгийн талаарх танилцуулгыг Төлөвлөлт, зохион байгуулалт хариуцсан нэгжид улирал бүр хүргүүлэхээр зохицуулсан боловч уг заалтыг хэрэгжүүлээгүй нь санамж бичиг, гэрээ байгуулах, бүртгэх, ач холбогдол, үр дүнг нь тооцож үнэлэх ажил орхигдоход нөлөөлсөн байна.

3.3 Аудитын явцад нэг байгууллагын бүтцийн нэгжтэй давхардаж санамж бичиг, гэрээ байгуулсан, тэдгээрийн хэрэгжилтийг хариуцах нэгжийг оновчгүй тодорхойлсон, хэрэгжих боломжгүй болон хэрэгжихэд хүндрэлтэй асуудлаар санамж бичиг, гэрээ байгуулагдсан зэрэг асуудлууд тогтоогдож байна.

Энэ нь санамж бичиг, гэрээ байгуулах эрх хэмжээ, хамрах хүрээ ямар байх, тухайн нэгж, орон нутгийн цагдаагийн байгууллагын хариуцсан нутаг дэвсгэр, үйл ажиллагааны хүрээнд байгуулагдсан санамж бичиг, гэрээг хэрхэн бүртгэж, хяналт тавих, энэ тохиолдолд санамж бичиг, гэрээг ямар субъект байгуулж, баталгаажуулах, санамж бичиг, гэрээнээс салбарлаж дахин санамж бичиг, гэрээ байгуулж болох эсэх зэрэг асуудлаар эрх зүйн зохицуулалтыг илүү нарийвчлах шаардлагатайг харуулж байна.

3.4 Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас бусад байгууллагатай байгуулсан санамж бичиг, гэрээ нь агуулга, хэлбэрийн хувьд нэгдсэн стандартгүй, төслийг боловсруулсан нэгж, алба хаагчаас хамаарч өөр өөр хэлбэр, дизайнтай, зохицуулах зүйл, нөхцөл нь харилцан адилгүй байна.

Тухайлбал, санамж бичиг, гэрээний зорилго, хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ, хэрэгжилтийг хариуцах нэгж, талуудын эрх, үүрэг, хүчин төгөлдөр байх хугацаа, түүний сунгалт, биелэлт, үр дүнг тооцох, тайлагнахтай холбоотой зохицуулалт орхигдох, оновчгүй тодорхойлогдох, ойлгомжгүй байдал үүсэх эрсдэлтэй.

Иймд эрх зүйн зохицуулалт, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааны онцлог, хэрэгцээ шаардлага, үүсч болзошгүй эрсдэл, албан хэрэг хөтлөлтийн шаардлагад нийцүүлсэн санамж бичиг, гэрээний үлгэрчилсэн загварыг бий болгож, тэдгээрийн хэлбэр, дизайн, агуулга, бүрэлдэхүүн хэсэг буюу нөхцлийг нэгдсэн стандартад оруулах нь зүйтэй байна.

4. ДҮГНЭЛТ

Цагдаагийн байгууллага нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн дэмжлэгийг авч, хамтарч ажиллах нь зайлшгүй бөгөөд энэ зорилгоор бусад байгууллагатай хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулж, хэрэгжүүлсээр иржээ.

Аудитын хүрээнд цугларсан мэдээллийн дагуу цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, нийт 54 этгээдтэй, 38 хамтран ажиллах гэрээ, санамж бичгийг байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Санамж бичиг, гэрээ нь цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас гадагш чиглэсэн, тухайн байгууллагатай хамтарч ажил, арга хэмжээ хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрэхээр харилцан эрх, үүрэг хүлээсэн баримт бичиг болохын хувьд түүнийг байгуулах, бүртгэх, хэрэгжилтийг хангаж, хяналт тавих, биелэлт, үр дүнг тооцох үйл ажиллагааг чанартай гүйцэтгэх ёстой юм.

Аудитын хүрээнд цуглуулсан нотлох баримт, мэдээлэлд үндэслэн, санамж бичиг, гэрээний биелэлт нийтлэг байдлаар хангалттай, хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ нь ач холбогдол, үр дүнтэй, харин тэдгээрийг бүртгэх, хэрэгжилтийг тайлагнах, биелэлт, үр дүнг тооцох үйл ажиллагаа дутагдалтай, зохих журмын дагуу хэрэгжээгүй байна гэж аудитын багаас дүгнэлээ.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас бусад байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр байгуулсан санамж бичиг, гэрээний бодит судалгааг анх удаа гаргаж, тэдгээрийн хэрэгжилтийг нэгтгэн тооцсон, санамж бичиг, гэрээг байгуулах, бүртгэх, хэрэгжилтийг тайлагнан, хяналт тавих үйл ажиллагаан дахь алдаа дутагдлыг илрүүлж, тэдгээрийг залруулах, үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр санал, зөвлөмж гаргаж, удирдлагыг мэдээллээр хангасан нь энэхүү аудитын ач холбогдлыг илэрхийлж байна.

Цаашид цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд иргэд, олон нийт, бусад байгууллагын дэмжлэгийг авч, хамтран ажиллах хэрэгцээ шаардлага улам бүр өсөх зөв, зүй ёсны хандлагатай байх тул санамж бичиг, гэрээтэй холбоотой үйл ажиллагаа, зохицуулалтыг боловсронгуй болгож, нэгдсэн ойлголт, стандарттай болох шаардлагатай байна.

5. ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, аудитын үр дүнд үндэслэж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас бусад байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр санамж бичиг, гэрээ байгуулах, бүртгэх, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах, биелэлт, үр дүнг тооцох үйл

ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор дараах зөвлөмжийг холбогдох нэгжүүдэд хүргүүлэх саналтай байна. Үүнд:

Захиргааны удирдлагын газарт:

- “Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах /Код 240/ журам”-д заасны дагуу санамж бичиг, гэрээний нэгдсэн бүртгэлийг хөтөлж, хэрэгжилтийн талаарх мэдээллийг холбогдох нэгжүүдээс хугацаанд нь авч, үр дүнг тооцон, Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж ажиллах /ТЗБХ/,

- Санамж бичиг, гэрээ байгуулах эрх хэмжээ, хамрах хүрээ, түүнийг байгуулж, баталгаажуулах эрх бүхий албан тушаалтан, санамж бичиг, гэрээг бүртгэх, хэрэгжилтийг тайлагнах хугацаа, санамж бичиг, гэрээнээс салбарлаж дахин санамж бичиг, гэрээ байгуулах болон энэхүү тайланд дурдсан бусад асуудлаар журмын зохицуулалтыг нарийвчлан боловсруулах /ТЗБХ, ХуХ/,

- Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааны онцлог, хэрэгцээ шаардлага, албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн бүрдлийн шаардлагад нийцсэн хэлбэр, агуулга бүхий санамж бичиг, гэрээний үлгэрчилсэн загварыг бий болгож, журмын хавсралт болгон батлуулж, мөрдүүлэх /ТЗБХ, ХуХ/.

Цагдаа, дотоодын цэргийн нийт байгууллага, нэгжид:

- Аудитын тайланд дурдагдсан бүртгэлгүй санамж бичиг, гэрээг Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст хүргүүлж бүртгүүлэх, цаашид бусад байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр санамж бичиг, гэрээ байгуулах тухай саналаа танилцуулах, санамж бичиг, гэрээний төслийг боловсруулах, хянуулах, бүртгүүлэх, хэрэгжүүлэх, биелэлт, үр дүнг тайлагнахдаа “Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах /Код 240/ журам”-ыг баримтлах,

- Аудитын явцад зарим санамж бичиг, гэрээний хугацаа дуусч байгаа, хүчин төгөлдөр байх хугацаа нь тодорхойгүй, хэрэгжилт нь хангалтгүй, хэрэгжиж дууссан, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил, арга хэмжээ, түүнийг хариуцах нэгжийг оновчгүй тодорхойлсон, бүтцийн зохион байгуулалт, нэршил өөрчлөгдсөн зэрэг байдлууд тогтоогдсон. Иймд өөрийн байгууллага, нэгжийн хариуцаж буй санамж бичиг, гэрээнд дүн шинжилгээ хийж, тэдгээрт шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, эсхүл шинээр байгуулах талаарх саналаа холбогдох нэгжид гаргаж шийдвэрлүүлэх.

Зөвлөмж хүлээн авсан байгууллага, нэгж нь түүний хэрэгжилтийг хангаж, биелэлт, үр дүнг энэ оны **05** дугаар сарын **15**-ны дотор Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын нэр дээр ирүүлнэ.

6. УДИРДЛАГЫН ТАЙЛБАР

Аудитын урьдчилсан тайланг холбогдох нэгжүүдэд хүргүүлсний дагуу ирүүлсэн “Удирдлагын тайлбар”-уудыг энэхүү тайланд хавсаргав.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

Хавсралт 1

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ
ЧИГЛЭЛЭЭР БАЙГУУЛСАН САНАМЖ БИЧИГ, ГЭРЭЭ, ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТ**

2020.02.11

Улаанбаатар хот

д/д	Санамж бичиг, гэрээ байгуулсан			Санамж бичиг, гэрээний			Хэрэгжилтийг хариуцсан нэгж
	Байгууллага	Албан тушаалтан	Огноо, дугаар	Хугацаа	Зорилго	Хэрэгжилт	
1	Нийслэлийн сэтгүүлчдийн нэгдсэн холбоо	УСХ-ийн дарга, д/х Н.Мөнх-Итгэл, НСНХ-ны тэргүүн Б.Ганзориг	2019.12.20, 2019/08	3 жил	НСНХ нь хамтран ажилладаг хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сурталчлах.		УСХ
2	Хүүхдийн эрх хамгааллын төв ТББ	ЦЕГ-ын ТДД, х/а Р.Отгонжаргал, ХЭХТөв ТББ-ын захирал С.Буянхшиг	2019.11.14, 2019/07				
3	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ	ЦЕГ-ын ТДД, х/а Р.Отгонжаргал, ХЭХТөв ТББ-ын захирал Н.Арвинтариа	2019.11.14, 2019/06	2+1 жил	Гэрч, хохиронч, тэдгээрийн хамаарал бүхий иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэдэнд туслалцаа, дэмжлэг үзүүлэхтэй холбоотой хамтын ажиллагааг зохицуулах.		ГХХХ
4	Нийслэлийн ХУД-ийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс	ЦЕГ-ын ТДД, х/а Р.Отгонжаргал, ХУД-ийн ГБХЗХХ-ийн дарга О.Мягмарсүрэн	2019.11.14, 2019/05				
5	Мал эмнэлгийн ерөнхий газар	ЦЕГ-ын ТДД, х/а Р.Отгонжаргал, МЭБЕГ-ын дарга Д.Түмэндэмбэрэл	2019.11.11, 2019/04	2+1 жил	Мал эмнэлгийн гэрчлэлийн системийг хамтран ашиглах.		МДШША
6	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	ЦЕГ-ын дарга, х/а С.Баатаржав, ХБХХЕГ-ын дарга Ц.Ганчимэг	2019.10.10, 2019/03	3+1 жил	Сонстог, хэл ярианы бэрхшээлтэй иргэд эмнэлэг, цагдаа, онцгой байдал зэрэг яаралтай түргэн тусламжийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх үүднээс 101, 102, 103, 105 тусгай дугаарын утсаар болон цахим зурвасар дуудлага өгөх, мэдээлэл хүлээн авах үйлчилгээг зохион байгуулах, нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлэх зорилгоор хамтран ажиллах.		МДШША

Албан хэрэгцээнд

7	"Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төсөл	ЦЕГ-ын дэд бөгөөд НЦГ-ын дарга, х/а Д.Ядамдорж, УБХ-ын ГХХХОДХ-ийг хэрэгжүүлэгч төслийн зохицуулагч Д.Авирмэд	2019.08.28, 2019/02	Төсөл хэрэгжүүлж дуусах хүртэл	МУЗГ, АХБанк хооронд байгуулсан "ГХХХОДХ"-ийн хүрээнд БЗД-ийн 10-р хорооны нутаг дэвсгэрт "Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах бамр"-ыг барьж, ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах	НЦУГ
8	Мобиком корпораци ХХК, Оюу толгой ХХК	ЦЕГ-ын ТДД, х/а Р.Отгонжаргал, Мобиком корпораци ХХК-ийн ерөнхий захирал Тацула Хамеда, Оюу толгой ХХК-ийн гүйцэтгэх захирал Армандо Торрес	2019.06.14	2 жил	Зам тээврийн ослыг бууруулах, үүнд чиглэсэн нөлөөллийн ажлуудыг үр дүнтэй зохион байгуулах чиглэлээр ЗХАБ-ын төслийг хамтран хэрэгжүүлэх, замын хөдөлгөөнд оролцохтой холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, холбогдох хуулийг сурталчлах, иргэдийн жолоо барих зан хандлагад эерэг нөлөө үзүүлэх, Талууд хоорондоо мэдээ, мэдээлэл солилцох, шаардлагатай сургалтыг зохион байгуулах, сайн туршлагыг хуваацлах үйл ажиллагааг дэмжих чиглэлээр хамтран ажиллах.	УСХ
9	Онцгой байдлын ерөнхий газар	ЦЕГ-ын дарга, х/а С.Баатаржав, ОБЕГ-ын дарга, х/г Т.Бадрал	2018.09.14, 2018/07	3+1 жил	Холбогдох хуулиуд, хамтарсан Тушаалаар батлагдсан журмуудыг хэрэгжүүлэх, жаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх.	НХЖХ ОНАБХА
10	ХААИС-ын Эдийн засаг, бизнесийн сургууль	МДШУА-ны дарга, х/а О.Зоригт, ХААИС-ын ЭЗБС-ийн захирал, доктор, дэд профессор Б.Баасансүх	2018.09.26, 2018/06	3+1 жил	Цагдаагийн байгууллагын мэдээлэл судалгаа, дүн шинжилгээний чиглэлээр ажиллаж байгаа алба хаагчдад статистикийн мэдлэг олгох, мэргэжил дээшлүүлэх, давтан сургах, статистик, математик загварчлалын мэргэжлийн ангийн оюутнуудыг сургалт, үйлдвэрлэлийн дадлага хийхэд хамтран ажиллах.	МДШУА
11	Төрийн банк ХХК	ЦЕГ-ын ТДД, х/а Р.Отгонжаргал, Төрийн банк ХХК-ий гүйцэтгэх захирал Г.Дэлгээн	2018.06.26, 2018/05	2 жил	ГХУСТХууль, бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан, нөхцлийг тооцоо, арилгах сургалт, сурталчилгааг явуулах, банкны салбар, нэгжийг цагдаагийн эрүүлийн чиглэлд оруулах, мэдээлэл солилцон, харилцан дэмжлэг, туслалцаа үзүүлж хамтран ажиллах.	НХЖХ ОНАБХА

12	Хил хамгаалах ерөнхий газар	ИГТТАА-ны дарга, д/х Н.Баясгалан, ХХЕГ-ын ХМТХ-ийн дарга, х/а Н.Урдийнбиш	2018.04.23, 2018/04	Хугацаагүй	Интерполын мэдээллийн сүлжээнд боловсруулагдсан мэдээлэлтэй ХХЕГ-аас шууд хандат хийх нөхцөлтэй тогтоох.	ИГТТАА
13	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	ЦЕГ-ын ТДД, х/а Р.Отгонжаргал, ТБХХЗГ-ын дарга О.Алтансүх	2018.03.14, 2018/04	1+1 жил	Хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах, харилцан дэмжлэг үзүүлэх, мэдээ, мэдээлэл солилцох, сургалт зохион байгуулах, иргэд олон нийтэд хуулийг сурталчлах үйл ажиллагааг дэмжих.	УСХ
14	Жи Си Ай Монгол ТББ	УСХ-ийн дарга, х/а Г.Арсгалхуяг, Жи Си Ай Монгол ТББ-ын 2018 оны үндэсний ерөнхийлөгч М.Батбаяр	2018.02.01, 2018/03	2 жил	Хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах, харилцан дэмжлэг үзүүлэх, мэдээ, мэдээлэл солилцох, сургалт зохион байгуулах, иргэд олон нийтэд хуулийг сурталчлах үйл ажиллагааг дэмжих.	УСХ
15	Хүний эрхийн үндэсний комисс	ЦЕГ-ын дарга, х/а С.Баатаржав, ХЗҮК-ын дарга Ж.Бямбадорж	2017.12.19, 2018/01	3+ жил	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон харилцаанд оролцогчдын эрхийг хамгаалах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, сахилга хармуцлагыг сайжруулах, цагдаагийн алба хаагчдад хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх, байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх.	ТЗБХ
16	Монголын Оюутны Холбоо	УСХ-ийн дарга, х/а Д.Батчулуун, МОХ-ны Ерөнхийлөгч Н.Удаанжаргал	2017.10.12, 05/04	2+1 жил	ЦАТХ-ийн 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсэгт заасны дагуу Цагдаагийн байгууллага болон МОХ-ны ажлын уялдаа холбоог хангах, харилцан дэмжлэг үзүүлэх, бодит үр дүнд хүрэх.	УСХ
17	Монголын Өмгөөлөгчдийн Холбоо	ЦЕГ-ын дарга, х/а Ө.Энхтөр, МБХ-ны Ерөнхийлөгч Б.Ганбаатар	2017.04.13, 2017/04	3+1 жил	ЦАТХ-ийн 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсэгт заасны дагуу Цагдаагийн байгууллага болон МБХ-ны ажлын уялдаа холбоог хангах, харилцан дэмжлэг үзүүлэх, бодит үр дүнд хүрэх.	МБА
18	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар / хуучнаар/	ЦЕГ-ын МТХТ-ийн дарга, х/а Ц.Отгонбат, ОБУБЕГ-ын МТТ-ын дарга С.Чинбат	2017.06.06, 2017/03	2+2 жил	Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангаас ЦЕГ, түүний харьяа алба, нэгж, нутаг албан хариуцсан цагдаагийн байгууллагын албан хэрэгцээнд лавлагаа, мэдээллийг цахим хэлбэрээр солилцох, хамтран ажиллах	МДШУА

Албан хэрэгцээнд

19	Монголбанк	ЦЕГ-ын дарга, т/к Ө.Энхтөр, Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баярсайхан	2017.02.22, №03	2+1 жил	Олон улсын төлбөрийн карт ашиглан үйлдэж болзошгүй хууль бус гүйлгээг урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэл солилцох "Дундын мэдээллийн сан" үүсгэж, хамтран ажиллах.	ЭЦА
20	Зэвсэгт хүчний жанжин штаб	ЗЦА-ны дарга, х/а Б.Даваазул, ЭХЖШ-ын 1-р орлогч дарга, х/г Р.Сүхбат	2017.02.15	3 жил	Зэвсэгт хүчний Автотехникийн хяналтын албаны үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой талуудын харилцааг зохицуулах.	ТЦА
21	Гаалийн ерөнхий газар	ЦЕГ-ын дарга, т/к Р.Чингис, ГЕГ-ын дарга Б.Цэнгэл	2015.06.30, №6	Хугацаагүй +1	Тарифын болон тарифын бус хязгаарлалттай бараа, түүний дотор хар тамхи, мансууруулах болон сэтгэлэд нөлөөлөх бодисыг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, түүнтэй холбоотой мэдээлэл солилцох, сургалт, судалгаа зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллах.	ГХТА /хуучнаар/ буюу ЭЦА, МБА, ХТТТ
22	Авлигатай тэмцэх газар	ЦЕГ-ын дарга, т/к Р.Чингис, АТГ-ын дарга, т/к Н.Ганболд	2015.04.15, №1	Хугацаагүй	Хууль тогтоомжор тогтоосон чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах, харилцан дэмжлэг үзүүлэх, мэдээ, мэдээлэл солилцоход шуурхай хандах, иж бүрэн, тасралтгүй ажиллагааг дэмжих.	АБХ, ЗБГХТГ / хуучнаар/ буюу ЭЦА, МБА
23	Хууль сахиулахын их сургууль / хуучнаар/	ЦЕГ-ын дарга, б/г Б.Билэгт, ХСИС-ийн захирал, х/а Р.Чингис	2013.11.06	4+4 жил	Талуудын хамтын ажиллагааны чиглэл, хүрээ, зарчмыг Тодорхойлох, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны болон бусад чиглэлээр хамтран ажиллах.	СГАСХ
24	Үндэсний статистикийн хороо	ЦЕГ-ын дарга, б/г Б.Билэгт, УСХ-ны дарга С.Мэндсайхан	2013.05.09	Хугацаагүй +1	Талууд хамтран гэмт хэргийн статистикийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, мэдээ, судалгааны үнэн бодит байдал, ажлын уялдаа холбоог хангах, цуглуулсан мэдээллийг боловсруулах, гэмт хэргийн статистикийг олон улсын жишигт нийцүүлэх, гэмт хэргийн гаралт, нийгэмд үзүүлэх сөрөг үр дагаврыг багасгах чиглэлээр хамтран судалгаа, шинжилгээ хийж, эрх бүхий байгууллагыг мэдээ, мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах.	МДШША
25	Үндэсний аудитын газар	ЦЕГ-ын дарга, б/г Б.Билэгт, УАГ-ын дарга, ерөнхий аудитор А.Зангад	2013.04.08	Хугацаагүй +1	Талууд, түүний харьяа нэгж хамтран санхүү, эдий засгийн болон мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, түүнтэй холбоотой мэдээлэл, дүгнэлт, зөвлөмжийг харилцан солилцох, судалгаа явуулах, сургалт зохион байгуулах.	ЭЦА

Хавсралт 2

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ
ЧИГЛЭЛЭЭР БАЙГУУЛСАН САНАМЖ БИЧИГ, ГЭРЭЭНИЙ ЖАГСААЛТ***

2020.02.11

Улаанбаатар хот

Д/д	Санамж бичиг, гэрээ байгуулсан			Санамж бичиг, гэрээний		Хүчинтэй эсэх	
	Байгууллага	Албан тушаалтан	Огноо, дугаар	Хугацаа	Зорилто	Хэрэгжилтийг хариулсан нэгж	Тийм Үгүй
1	"Монгол малчин" мэдээллийн агентлаг	ЭЦА-ны ХГТХ-ийн дарга, д/х Н.Мэндбаяр, МММА-ийн захирал О.Өлзийбадрах	2019.01.09	Тодорхойгүй	Талууд тус тусын үйл ажиллагааны чиглэлийн дагуу иргэдийн алдсан болон олдсон малын талаарх мэдээллийг солилцож, эзэн хохиролчийг олж тогтоох, зарлан мэдээллийг шуурхай явуулах зорилгоор "Малчин-33" телевиз, "mongolmalchin.mn" сайт, "Малчин лавлах-109" мэдээллийн төв, гэжж, фэйсбүүк хуудсанд байршуулах, "Малчин лавлах-109" дугаарын Утсанд ирсэн гэмт хэргийн талаарх мэдээллийг шалгах чиглэлээр хамтран ажиллах	ЭЦА	+
2	ХСИС-ийн Цагдаагийн сургууль	МБА-ны дарга, х/а Д.Отгонжаргал, ХСИС-ийн ЦС-ийн захирал, х/а Б.Болдбаатар	2018.04.05	Тодорхойгүй	"ЦЕГ-ын МБА, ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн хамтын ажиллагааны удирдамж" гэх уг баримт бичгийг талууд эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын чиглэлээр хамтран ажиллах зорилгоор байгуулсан.	МБА	+
3	ЭМЯ, БШУСЯ, НЗДТГ, Нийслэлийн боловсролын газар, Монголиан контент дэвелопмент фактори ХХК, Жи Си Ай Монгол ТББ	МБА-ны ЗХШУХ-ийн дарга, х/а Ц.Энхбаяр болон бусад байгууллагын төлөөлөл	2019.11.25	Тодорхойгүй	"Хор баяраг" аяныг зохион байгуулж, ЕБС-ын сурагч, өсөөр үеийнхний насны онцлог тохирсон медиа контент, бодит кейсээр дамжуулан тамхины хор хөнөөлийн талаар мэдлэг, мэдээлэл олгох, нийгэмд тахианаас татгалзах урмаллыг хэрэгжүүлэх, өдөрлөг зохион байгуулах.	МБА	+

Албан хэрэгцээнд

4	Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар	МБА-ны ХЕОЭГХМШХ-ийн дарга, х/а Ц.Баатар, ДБХСМДХГ-ын Байгал хамгааллын асуудал хариуцсан захирал Б. Чимэддорж	2020.01.08	Хугацаагүй	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэраг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, ойлголт, хандлагыг өөрчлөх, хууль сахиулах байгууллын алба хаачдын байгаль хамгаалах хууль тогтоомжийн мэдлэг, гэмт хэрэгтэй тэмцэх мэрэгжлийн үр чадварыг дээшлүүлэх, чадавхижуулах, мэдээллээр хангах, харилцан хамтран ажиллах.	МБА	+
5	ХИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхим	НХХХОНАБХА-ны дарга, х/а Ж.Амгалан, ХСИС-ийн ЦС-ийн захирал, х/а Б.Болдбаатар	2019.04.09	4+4 жил	НХХХОНАБХ чиглэлийн хичээл, сургалтын чанар, үр нөлөөг дээшлүүлэх, мэдлэг, чадвартай цагдаагийн ажилтан бэлтгэн гаргах шаардлагыг хангах, багш, алба хаагчдаа чадавхижуулах чиглэлээр сургалт, зөвлөгөөн, хурлыг хамтран зохион байгуулах эрх зүйн баримт бичиг боловсруулахад хамтран ажиллах, харилцан дэмжлэг туслалцаа үзүүлэх.	НХХХ ОНАБХА	+
6	"Үндэсний дата төв" УТҮГ	ЦЕГ-ын дарга, МТХТ-ийн дарга нар, "Үндэсний дата төв" УТҮГ-ын захирал	2014.07.17 2015.12.22 2017.01.17	Хугацаагүй, 1+1 жил	Тус байгууллагатай 2014, 2015, 2017 онуудад 3 удаа "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулж, талуудын хооронд цахим мэдээлэл солилцох, бэлэн бус торгуулийн системийн хэвийн ажиллагааг хангах, ТҮЦ машины ашиглалттай холбоотой хамтран ажиллаж ирсэн байна.	МДШУА	+
7	Улаанбаатар хотын банк, Богд банк, Төрийн банк, Хаан банк ХХК	ЦЕГ-ын ТДД, х/а РОТгонжаргал, Тухайн банкны дахирал, дэд захирал	2017.11.20 2018.03.06 2018.03.20 2018.06.29	1+1 жил	Тус банкуудтай "Хамтран ажиллах гэрээ" байгуулж, жолоочид ногдуулсан бэлэн бус торгуулийн төлбөрийг банкны бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан төлөх боломжийг бүрдүүлж хялбаршуулсан байна.	МДШУА	+
8	Жи мобайл, Скайтел, Юнител ХХК	МТХТ-ийн дарга, х/а Ц.Огтонбат	2017.05.01	4 жил	Тус "Хамтран ажиллах гэрээ" нь гэмт хэрэг зөрчлөөс аюулгүй орчин ажиллах амьдрах нөхцлийг бий болгоход хөдөлгөөнт төхөөрөмжид суурилсан шинэ техник, технологийг, програм хангамж, төхөөрөмж нэвтрүүлэх ажилд хамтарч ажиллах зорилгоор байгуулагдсан. Үр дүнд нь "ЗГ" сүлжээ ашиглан цагдаагийн байгууллагын сүлжээнд холболт Үүсч, бэлэн бус торгуулийн системийг нэвтрүүлсэн байна.	МДШУА	+

9	МУ-ын ЕТГ, БШУСЯ, БХЯ, ГХЯ, МХЕГ, ТЕГ, ХХЕГ, ХЭУК, СЭМҮТ, НЭМХ, Монголын медиа корпораци, Зууны мэдээ сонин, Ньос агентлаг, Минисего нийгэмлэг ТББ	ЦЕГ-ын ХТТГ-ын дарга, х/а Х.Доржжаран болон бусад байгууллагын төлөөлөл	2018.03.07	3 жил	Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төрийн бодлого, үйл ажиллагааг сурталчлах, энэ зорилгоор төрийн, төрийн бус болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагааг нэгтгэж, идэвхжүүлэх.	ХТТГ	+
10	Монгол Улсын их сургууль	ХТТГ-ын дарга х/а Ж.Эрдэнэболд, МУИС-ын дэд захирал Б.Очирхуяг	2019.05.19	1+1 жил	"Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах, хууль тогтоомжийг тайлбарлан тануулах, гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг судлах, урьдчилан сэргийлэх, мэдээлэл солилцох, соён гэгээрүүлэхэд хамтран ажиллах.	ХТТГ	+
11	ДХИС-ын Цагдаагийн сургууль	ДЦШ-ын дарга, х/а С.Ганбат, ДХИС-ийн ЦС-ийн захирал, х/а Б.Болдбаатар	2019.05.24	5+5 жил	Талуудын хамтын ажиллагааны зарчмыг тодорхойлж, үйл ажиллагааг нь уялдуулан, хамтран ажиллах.	ДЦШ	+
12	Менежер карьерийн институт ТББ	ДЦ-ийн 05 дугаар ангийн Штабын дарга, д/х Ж.Мөнхсолонго, МКИ-ын захирал Н.Гэрэлтуяа	2019.05.06	1 жил	Талуудын хооронд харилцан ашигтай хамтран ажиллах нөхцлийг хангах, алба хаагч, суралцагчдын сургалт, дадлагын чиглэлээр хамтран ажиллах.	ДЦШ	+
13	Монгол шуудан ХК	Бүртгэл хяналтын төвийн дарга, д/х Ч.Батболд, Бизнес хөгжлийн газрын захирал А.Эрхэмбаяр	2019.05.17 2019/96	3 жил	Хамтран ажиллах гэрээний зорилго нь тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхийг шуудангийн хягаар хүргүүлэх ажлыг зохион байгуулахтай холбоотой талуудын харилцааг зохицуулах юм.	БХТ	+

*Энэхүү жагсаалтад орсон санамж бичиг, гэрээ нь дотоод аудитын хүрээнд холбогдох нэржүүдээс ирүүлсэн мэдээллийн дагуу Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст бүртгэлгүй байсан баримт бичгүүд юм. Иймд дээрх санамж бичиг, гэрээний хэрэгжилт, үр дүнг аудитын хүрээнд хамруулаагүй болно.

Түүнчлэн орон нутгийн цагдаагийн газар, хэлтсээс тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагатай байгуулсан санамж бичиг, хамтран ажиллах гэрээ нь уг жагсаалтад ороогүй болно.

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2020 оны 03 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сахилгын мэдээ гаргах үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудитын объект: Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсээс сахилгын мэдээ гаргах үйл ажиллагаа

Аудитын төрөл, код: Үйл ажиллагааны аудит, ЦЕГ-ХШДАХ/ҮА-2020/02

Аудитын хугацаа: 2020.01.28- 2020.02.24

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа В.Отгонбаяр

1. ТАНИЛЦУУЛГА

Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэс нь Цагдаагийн албаны тухай хуулийн 14.1.3-д “цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, алба хаагч, ажилтан гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилгын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж, шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авах, цагдаагийн албаны дотоод хяналт-аюулгүй байдлыг хангах”, Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрмийн 4.4-т “Аюулгүй байдал хариуцсан нэгж нь сахилгын зөрчлийн талаарх өргөдөл, гомдол түүний шийдвэрлэлтийн талаар мэдээллийн сан үүсгэж, хөтөлнө” гэж заасны дагуу цагдаа, дотоодын цэргийн 63 нэгж, байгууллагын сахилгын мэдээг улирал, хагас, бүтэн жилээр загвар хүснэгтийн дагуу дэлгэрэнгүй, хураангуй хэлбэрээр авч, нэгж тус бүрт үнэлэлт, дүгнэлт өгч, дүн шинжилгээ хийж, байгууллагын удирдлагыг мэдээллээр хангаж байна.

Тус хэлтэс нь байгууллага, алба хаагчийн аюулгүй байдалтай холбоотой нийт 8 төрлийн мэдээг авч, нэгтгэж байна. Үүнд:

д/д	Мэдээний төрөл	Асуултын тоо	Давтамж	Эрх зүйн зохицуулалт
1.	Сахилгын мэдээ	90	Улирал бүр	ЦБҮАЖ /код-914.52/
2.	Албаны шалгалтын мэдээ	89	Сар бүр	ЦБҮАЖ /код-112/
3.	Алба хаагчтай холбоотой өргөдөл, гомдлын мэдээ	34	Сар бүр	ЦБҮАЖ /код-121.7.1/

4.	Эрүүгийн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан алба хаагчийн мэдээ	58	Сар бүр	ЦБУАЖ /код-912/
5.	Зөрчил гаргасан алба хаагчийн мэдээ	47	Сар бүр	
6.	Гэмт хэрэгт өртөж хохирсон алба хаагчийн мэдээ	65	Сар бүр	
7.	Зөрчилд өртөж хохирсон алба хаагчийн мэдээ	58	Сар бүр	
8.	Албан үүргээ гүйцэтгэж байгаад амь насаа алдсан мэдээ	18	Сар бүр	

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд 2019 онд 1589 өргөдөл, гомдол хүлээн авч, 1587 албаны шалгалт явуулж, 1590 алба хаагчид сахилгын шийтгэл оногдуулж, эрүүгийн гэмт хэрэгт 39, зөрчилд 64 алба хаагч холбогдож, гэмт хэрэгт 31, зөрчилд 169 алба хаагч өртөж хохирсон, 1 алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа амь насаа алдсан байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд сахилгын мэдээ гаргах үйл ажиллагаанд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, дээрх үйл ажиллагааг боловсронгуй болгох, илэрсэн асуудлыг арилгах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хүргүүлж, үр дүнг тооцоход чиглэгдэнэ.

2.2 Аудитын цар хүрээ

Аудитын зорилгыг хангах хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсийн 2018, 2019 оны сахилгын болон байгууллага, алба хаагчийн аюулгүй байдалтай холбоотой мэдээ гаргах үйл ажиллагааг аудитын объектод хамруулсан.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, дотоодын цэргийн анги, салбараас сахилгын мэдээ гаргах үйл ажиллагааны талаарх эрх зүйн зохицуулалтыг судалж, аудит хийгдэх нэгжийн удирдлага, алба хаагчтай уулзалт, ярилцлага хийлээ.

Аудитын нотлох баримтыг цуглуулах, сахилгын мэдээ гаргах үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор МДШШУА-ны Мэдээллийн технологи, холбооны төвийн Технологийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Б.Сансартуяатай хамтран шинээр боловсруулж буй “eICS” програмын талаар Нийслэлийн цагдаагийн удирдах газар, нийслэлийн 6 дүүрэг дэх цагдаагийн газрын төлөвлөлт, зохион байгуулалт, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн нарт мэдээлэл хийж, харилцан санал солилцсон.

Дотоодын цэргийн штаб, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газрын ажил хариуцсан алба хаагчидтай батлагдсан удирдамжийн дагуу ярилцлага хийж, Захиргааны удирдлагын газар, Баянгол дүүрэг дэх цагдаагийн газрын нягтлан бодогч нартай утсаар холбогдон тэднээс сахилгын мэдээ гаргах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, санал хүсэлтийг авсан.

Аудитын явцад цугларсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан “Урьдчилсан тайлан”-г бичиж, Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлэн “Удирдлагын тайлбар”-ыг авч, тайланд хавсаргасан болно.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд сахилгын мэдээ гаргах үйл ажиллагааг ЦБҮАЖ-ын /код-914/, мэдээ гаргах аргачлал, загвар хүснэгтийг ЦБҮАЖ-ын /код-914.52/-аар зохицуулж, цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрмийн 11.1 дэх хэсэгт зааснаар дүнг дараа улирлын эхний сарын 10-ны дотор, жилийн эцсийн мэдээг 12 дугаар сарын 20-ны дотор ирүүлэхээр журамласан байна.

Дээрх журмын хавсралт хүснэгтэд ахлах төлөөлөгч, ахлах хэрэг бүртгэгч гэж албан тушаалын ангилал хуучин нэршлээр байгаа, гэмт хэрэгт холбогдсон дотоодын цэргийн алба хаагчийн мэдээлэл орхигдсон, асуумжийн агуулга давхардсан зэрэг нь шинээр боловсруулагдаж буй “eICS” програмыг ашиглах үед өгөдлүүд нийцэхгүй байдал үүсч байна.

Мөн сахилгын болон бусад мэдээг харьяа 63 нэгж, байгууллагаас цаасаар авч, нэгтгэж байгаа нь шуудангаар ирэхдээ хугацаа алдах, нэгтгэхэд техник ажиллагаа ихтэй, ажиллагааны явцад алдаа гарах, түүнийг дахин хянах байдлаар, ялангуяа нэгтгэж буй алба хаагчийн ажлын бүтээмжид багагүй ачаалал бий болгосоор байна.

3.2 Сахилгын мэдээ гаргаж буй загвар хүснэгтэд сахилгын зөрчлийн хэлбэр, түүнд нөлөөлсөн шалтгаан нөхцлийг ерөнхий томьёолсон /тухайлбал архидан согтуурсан зөрчлийг архидан согтуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, ажлын байр эсхүл амарч байх үедээ архидан согтуурсан гэх зэргээр дотор нь ангилаагүй/ нь дүн шинжилгээ хийхэд хүндрэл үүсгэж байна.

Иймд сахилгын зөрчлийн төрөл, ангилал, түүнд нөлөөлсөн шалтгаан нөхцлийг шинээр тодорхойлох, өөрөөр хэлбэл сахилгын болон албаны

шалгалтын мэдээний зөрчлийн хэлбэр, шалтгаан нөхцлийг харьцуулан өөрчлөх, “хувь хүний буруутай үйл ажиллагаа”, “ёс зүй төлөвшөөгүй” гэх мэт “тодорхой бус” хүчин зүйлсийг дурьдах бус аль болох оновчтой болгох байдлаар “eICS” програмд нийцүүлэх байдлаар холбогдох журамд өөрчлөлт оруулан, эрх зүйн зохицуулалтыг илүү нарийвчлах нь зүйтэй байна.

3.3 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлыг харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн тохиолдолд анх хүлээн авсан болон шалгаж шийдвэрлэсэн байгууллагад давхардуулан бүртгэснээр тоон мэдээ нэг дахин өсч, бодитой бус гарсан байгаа нь өмнөх оны сахилгын болон бусад мэдээний тоон үзүүлэлтээс тодорхой хувиар өссөн дүнтэй танилцуулагдаж ирсэн байна.

3.4 Аудитын явцад Мэдээлэл, технологийн төвөөс “eICS” програмд нэвтрэх эрх авч, зөрчлийн хэлбэр, түүний шалтгаан нөхцлийг тодорхойлсон байдал, өгөгдөлтэй танилцаад хээл хахууль, шан харамж авсан, өмч хөрөнгө үрэгдүүлсэн, төсвийн хөрөнгийг ашигласан зэрэг зөрчлүүдийг эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдсан, хэргийн хугацаа хэтэрсэн, хэрэг материал дутуу шалгасан, эргүүл, харуул хамгаалалтын болон эрүүлжүүлэх баривчлах байрны журам зөрчсөн үйлдлийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль, дүрэм, журам зөрчсөн, хувцасны болон бусад хангамж дутуу олгосон, торгуулийн мөнгийг мөнгийг хувьдаа ашигласан, торгуулийн тасалбар үрэгдүүлсэн, хүчингүй болсон торгуулийн тасалбарыг хувьдаа ашигласан зэрэг цөөн тохиолдох зөрчлийг бусад зөрчилд хамааруулан ангилж оруулах нь үнэлэлт дүгнэлт өгч, дүн шинжилгээ хийх, түүнд чиглэсэн урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээнд эерэг нөлөө үзүүлэхээр байна гэж үзлээ.

4. ДҮГНЭЛТ

Цагдаагийн төв байгууллагаас Цагдаагийн албаны хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт заасан байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ нийт 8 төрлийн мэдээг холбогдох журмын дагуу баталсан хүснэгт, аргачлалын дагуу нэгтгэн, дүн шинжилгээ хийж, байгууллагын удирдлагыг мэдээллээр хангаж ирсэн байна.

Энэ ажлын хүрээнд тус хэлтсээс “ICS” /Internal Control System/ програмыг санаачлан нэвтрүүлж, мэдээллийн бүтэц, өгөгдлийг сайжруулах талаар холбогдох саналыг Мэдээллийн технологийн төвд хүргүүлсэн боловч хэрэгжээгүй, харин аудитын явцад уг програмын шинэчилсэн загвар, ашиглах талаар тухайн чиг үүргийг хэрэгжүүлдэг алба хаагчдад мэдээлэл хийж, дээрх 8 төрлийн бүртгэлээс гадна цагдаагийн алба хаагчийн галт зэвсэг хэрэглэсэн тухай бүртгэлийг нэмж хөтлөхөөр болсон.

Цаашид цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас алба хаагчдын ёс зүй, сахилгын зөрчил нэг бүрийг илрүүлэх, бүртгэх, түүний хэлбэр, шалтгаан нөхцлийг оновчтой томъёолох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, арилгах арга хэмжээ авах ажлыг боловсронгуй болгон мэдээлэх, тайлагнах үйл ажиллагааг цахимжуулах нь Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын энэ оны зорилт, бодлого, үйл ажиллагаатай нийцэхээр байна гэж аудитын багаас дүгнэлээ.

5. ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, аудитын үр дүнд үндэслэн байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, гаргаж буй сахилгын болон бусад мэдээ гаргах үйл ажиллагааг боловсронгуй болгох асуудлаар дараах зөвлөмжийг хүргүүлэх саналтай байна. Үүнд:

Аюулгүй байдлын хэлтэст:

- “Сахилгын шийтгэл оногдуулах /Код-914/ журам”, аргачлал, загвар хүснэгт /Код-914.53/-ийг шинээр нэвтрүүлэх “eICS” програмд нийцүүлж шинэчлэн боловсруулж, сахилгын болон албаны шалгалтын мэдээний зөрчлийн хэлбэр, шалтгаан нөхцлийг дахин судалж өөрчлөх, ажлын байрны дарамт, эрүүдэн шүүхтэй холбоотой зэрэг сахилгын зөрчлийн хэлбэрийг нэмж оруулах.

Хуулийн хэлтэст:

- “Сахилгын шийтгэл оногдуулах /Код-914/ журам”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/129 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”-д сахилгын мэдээ тайлагнах, үр дүнг тооцохтой холбоотой зүйл, заалтыг “eICS” програмд нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах.

Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанд:

-“eICS” програмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Аюулгүй байдлын хэлтсээс хүргүүлэх саналын дагуу /”хариуцсан ажилтан” хэсгээс шилжин томилогдсон, цэргийн байнгын тэтгэвэрт гарсан алба хаагчдын нэрсийг хасах, сахилгын зөрчлийн хэлбэр, шалтгаан нөхцлийг шинэчлэх... зэрэг/ холбогдох өөрчлөлтийг хийж, энэ оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах.

Зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, нэгжээс түүний хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, дүнг энэ оны **05** дугаар сарын **10**-ны дотор Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын нэр дээр ирүүлнэ.

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2019 оны 10 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Аудитад цагдаа, дотоодын цэргийн нийт анги, байгууллагаас мэдээлэл цуглуулж, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтэс, Хүний нөөцийн хэлтэс, Аюулгүй байдлын хэлтэс, Санхүү, аж ахуйн албаны зарим үйл ажиллагааг хамруулсан.

Аудитын объект: Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаа

Аудитын төрөл, код: Үйл ажиллагааны аудит, ЦЕГ-ХШДАХ/ҮА-2019/06

Аудитын хугацаа: 2019.08.22- 2019.09.20

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх

1. ТАНИЛЦУУЛГА

Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, 21 дүгээр зүйлийн 21.1.9 дэх хэсэгт тус тус заасны дагуу цагдаагийн байгууллага, түүний удирдлага нь алба хаагч, ажилтны аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүрэгтэй.

Алба хаагчийн аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаа нь Хөдөлмөрийн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн, Төрийн албаны, Цагдаагийн албаны, Дотоодын цэргийн, Цэргийн албаны, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиуд, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 100, 113, 511, 620, 801, 803, 804, 808, 810, 912, 915, 920, 922, 924, 926-935, 937-939, 947 дугаар код, холбогдох бусад эрх зүйн акт, баримт бичгээр зохицуулагдаж байна.

1.1 Алба хаагчийн аюулгүй байдлын талаар:

Аудитын хүрээнд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас мэдээлэл авч нэгтгэхэд албан үүргээ гүйцэтгэж яваад амь эрсэдсэн 99 /

Хавсралт 1/, сүүлийн 5 жилийн байдлаар эрүүл мэндээр хохирсон 271 /Хавсралт 2/, эд хөрөнгөөр хохирсон 76 /Хавсралт 3/ алба хаагч байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор батлагдсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-д заасны дагуу цагдаагийн төв байгууллага, харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгааныг судлан бүртгэсэн акт, дүгнэлт гаргах эрх, үүрэг бүхий орон тооны бус байнгын комиссыг томилон ажиллуулах үүрэгтэй. Энэ талаар Санхүү, аж ахуйн албанаас ажлын чиглэл хүргүүлж, цагдаа, дотоодын цэргийн нийт 64 байгууллага, нэгжид уг комиссыг байгуулсан байна.

Мөн Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тав дахь хөтөлбөр /2017-2020/”-г үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/91 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр /2018-2020/”-ийг хэрэгжүүлэх, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 тушаалыг мөрдүүлэх зорилгоор цагдаа, дотоодын цэргийн 62 байгууллага, нэгжид “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөл”-ийг байгуулжээ.

Төсөвт холбогдох зардлыг тусгаагүй ч Санхүү, аж ахуйн албанаас энэ оны 05 дугаар сарын 20-ноос 07 дугаар сарын 05-ны өдрийн хооронд “Эрүүл-зүрх”, “Элэг бүтэн Монгол”, “Эрүүл-Улаанбаатар” төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч “Оном” сангийн эмч, мэргэжилтнүүдээр баг бүрдүүлэн, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, Улаанбаатар цагдаагийн хүрээний 42 анги, байгууллагын 3458 алба хаагч, ажилтныг хамруулсан нь үр дүнтэй ажил болжээ.

Санхүү, аж ахуйн алба, Нийслэлийн цагдаагийн удирдах газраас Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлд “Төсвийн байгууллага нь тухай жилийн батлагдсан төсвийн 0,5 хувиас ... доошгүй хэмжээний хөрөнгийг ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах” гэж заасны дагуу 2014 оноос хойш жил бүр даатгалын компанитай гэрээ байгуулж, алба хаагчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулж байгаа нь эрсдэлийг бууруулж, хохирлыг арилгахад чухал алхам болсон байна. 2019 онд Санхүү, аж ахуйн албанаас 6723, Нийслэлийн цагдаагийн удирдах газраас 2995, нийт 9718 алба хаагчийг уг даатгалд хамруулж, 2019 оны эхний 9 сард давхардсан тоогоор 128 алба хаагч 91.4 сая гаруй төгрөгийн нөхөн төлбөрийг даатгалаас авчээ /Хавсралт 5/.

Алба хаагчийн аюулгүй байдлыг хангахад тусгай хэрэгсэл чухал ач холбогдолтой бөгөөд Санхүү, аж ахуйн албанаас ирүүлсэн мэдээллээс үзвэл 2018 оны төсөвт 1,384 сая, 2019 оны төсөвт 2,871 сая төгрөгийн хөрөнгө оруулалт тусгагджээ. 2016 онд цагдаагийн байгууллагын гэмт

хэрэгтэй тэмцэх шууд чиг үүрэгтэй алба хаагчдын тоог 7314 гэж тооцон, тусгай хэрэгслийн хангалтыг хийж байгаа бөгөөд 2019 оны байдлаар дээрх алба хаагчдыг бугуйн гаваар 95.3, нэг удаагийн гаваар 100, резинэн бороохойгоор 87.6, цахилгаан бороохойгоор 96,7, хутганаас хамгаалах бээлийгээр 98.3, нулимс асгаруулагч шүршигчээр 92.5, иж бүрэн бүсээр 100, хамгаалалтын иж бүрэн хувцсаар 63.5, дуулга малгайгаар 61.5, хутганаас хамгаалах хантаазаар 48.6, хамгаалалтын бамбайгаар 63.1, энгэрийн камераар 83.4 хувийг тус тус хангасан байна.

1.2 Алба хаагчдад хууль тогтоомжоор олгогдсон баталгааны талаар:

Аудитын хүрээнд Цагдаагийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасан алба хаагчийн нийгэм, эдийн засгийн баталгааны хэрэгжилттэй танилцахад төсөв, санхүүгийн боломж хүрэлцээнээс шалтгаалан хэрэгжилт нь жигд бус байна.

Тухайлбал, алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, төрсөн нутагтаа ирэх, очих замын зардлыг олгох, гэр бүлийн хүнийг ажлын байраар хангаагүй нөхцөлд нийгмийн даатгалын шимтгэлийг нь төлөх, алба хаагч шилжин томилогдоход уналга, ачаа тээшийн зардлыг олгох, ээлжийн амралтаа биеэр эдлээгүй нөхцөлд цалин хөлсийг нэмэгдүүлэн олгох, цэрэг, цагдаагийн сургуульд суралцсан хугацааг ажилласан жилд оруулж, цалин, ээлжийн нэмэгдэл амралтыг тооцох зэрэг баталгааг эдлүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр төсөвт тусгагддаггүй, энэ талаар хийгдсэн бүртгэл, судалгаа байхгүй байна.

Түүнчлэн Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоолоор батлагдсан “Цагдаагийн алба хаагчид төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын дагуу үндсэн цалингийн 45 хүртэлх хувийн нэмэгдэл нь Цагдаагийн ерөнхий газрын Төв байрны нэгжүүд болон нэр бүхий 14 нэгжээс бусад байгууллага, нэгжийн алба хаагчдад олгогдохгүй байна.

1.3 Алба хаагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах талаар:

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2010 оны 691 дүгээр тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажиллагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр” батлагдаж, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор 2012 онд Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтэст Алба хаагчийн эрх ашгийг хамгаалах тасгийг 4 орон тоотой байгуулан ажиллуулж, 2014 онд татан буулгаснаас хойш алба хаагчийн эрх ашгийг хамгаалах дагнасан чиг үүрэгтэй нэгж, алба хаагчгүй болсон.

Улмаар энэ оны 03 дугаар сард Хуулийн хэлтэст алба хаагчийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий 2 орон тоог бий болгосноор тус хэлтсээс алба хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлж буй хүчин зүйлсийн шалтгааныг тогтоох, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тодорхойлох зорилгоор зарим нэгжид сургалт зохион байгуулах, санал

асуулга авах, байгууллагын www.info.police.gov цахим хуудсанд “Helpline” буюу “Танд туслая” цэсийг нээх, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, түүнд өртөж хохирсон 14 алба хаагчид хууль зүйн зөвлөгөө өгөх, алба, газар, хэлтэс, тасаг, хэсгийн дарга нарын албан тушаалын тодорхойлолтод алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргийг тусгуулах зэрэг ажлыг хэрэгжүүлжээ.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2019 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.5-д заасны дагуу цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаанд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, аудитын объектыг боловсронгуй болгох, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, эрсдэлийг бууруулах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хүргүүлж, үр дүнг тооцох нь дотоод аудитын зорилго юм.

2.2 Аудитын цар хүрээ

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн аюулгүй байдал, баталгаа, хууль ёсны эрх ашиг нь алба хаагчдын амь нас, эрүүл мэндээс цалин хөлс, нөхөн олговор хүртэл, хувцас, тусгай хэрэгслээс байгууллага, алба хаагчийн нэр хүнд хүртэл өргөн цар хүрээг хамарсан ойлголт тул аудитын хамрах хүрээг хязгаарлахад бэрхшээлтэй байсан.

Иймд аудитыг тухайн чиг үүргийг хариуцан ажилладаг цагдаагийн төв байгууллагын алба, нэгжүүдээс хэрэгжүүлсэн /хэрэгжүүлбэл зохих/ үйл ажиллагаа, түүнд холбогдох мэдээлэл, судалгаанд суурилан хэрэгжүүллээ.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ 4 төрлийн маягт боловсруулж, цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгжид хүргүүлэн, албан үүргээ гүйцэтгэж яваад амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирсон алба хаагчдын судалгаа, алба хаагчийн аюулгүй байдал, баталгаа, хууль ёсны эрх ашигт тулгамдаж буй эрсдэл, шийдвэрлэх боломжийн талаарх санал /Хавсралт 4/-ыг авч нэгтгэн, аудитад ашигласан.

Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтэс, Хүний нөөцийн хэлтэс, Аюулгүй байдлын хэлтэс, Санхүү, аж ахуйн албаны удирдлага, чиглэл хариуцсан алба хаагчид, Цагдаагийн алба хаагчдын эрх ашгийг хамгаалах холбооны төлөөлөлтэй уулзалт ярилцлага зохион байгуулж, аудитад шаардлагатай мэдээлэл, баримт материалыг цуглуулсан.

Аудитын явцад цугларсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан “Урьдчилсан тайлан”-г бичиж, дээр дурдсан нэгжүүдэд хүргүүлэн “Удирдлагын тайлбар”-ыг авч энэхүү тайланд хавсаргав.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 “Алба хаагч, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, өртөж хохирсон талаар мэдэгдэх, сан бүрдүүлэх, ашиглах /Код-912/ журам”-д аюулгүй байдал хариуцсан нэгж нь гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, өртөж хохирсон алба хаагчийн санг бүрдүүлж, урьдчилан сэргийлэх чиглэлийг тодорхойлох, шалтгаан нөхцлийг нь арилгах зорилгоор ашиглах, “Албан үүргээ гүйцэтгэж байхдаа гэмтэж бэртсэн, осолд өртсөн алба хаагчийг бүртгэх /Код-929/ журам”-д байгууллагын дарга нь алба хаагч гэмтэж бэртсэн талаарх мэдээг улирал тутам цагдаагийн төв байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлэхээр тус тус зохицуулсан. Журмын дээрх зохицуулалт нь албан үүргээ гүйцэтгэж байгаад амь нас, эрүүл мэндээр хохирсон алба хаагчдын бүртгэл хөтлөх нэгжийг давхардуулсан шинжтэй байна.

Түүнчлэн мэдээллийн сангийн програм хэвийн ажилладаггүй, хариуцсан алба хаагч шилжин томилогдсон, нэгжүүдээс холбогдох мэдээллээ ирүүлдэггүй зэрэг шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон алба хаагчийн мэдээллийн сан үүсээгүй, холбогдох нэгжүүдээс өгч буй тоон мэдээлэл нь зөрүүтэй байна. Аудитын явцад зарим нэгж /СХДЦХ-2, ХУДЦХ-2, ЧДЦХ-1, ЧДЦХ-2/-ээс сүүлийн 5 жилийн байдлаар албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэндээр хохирсон алба хаагч байхгүй талаар мэдээлэл ирүүлж байгаа нь бодит байдалд нийцэхгүй, нэгжийн удирдлагаас асуудалд ач холбогдол өгөөгүй, бүртгэл судалгааны ажил хэвшээгүй байгааг харуулж байна.

3.2 “Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг тодорхойлох /Код-100/ журам”-д Аюулгүй байдлын хэлтсийн чиг үүргийг “Цагдаагийн байгууллага, алба хаагч, ажилтан гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилгын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, судалгаа хийх, шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авч байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах” гэж тодорхойлсон байдаг. Тус хэлтсээс 2018-2019 онд алба хаагчийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаар мэдээлэл хүсэхэд тодорхой мэдээлэл ирүүлээгүй, энэ талаар хариуцсан алба хаагчтай ярилцлага хийхэд бодитой, үр дүнд хүрсэн ажил, арга хэмжээ хэрэгжүүлээгүй тухай илэрхийлсэн болно.

3.3 Аудитын явцад цугларсан мэдээллээс үзвэл албан үүргээ гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, эсэргүүцэх, доромжлох, хүч хэрэглэн бие, эрх

чөлөөнд нь халдах, улмаар амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд нь хохирол учруулах явдал бүтээмэл байна.

Энэ нь алба хаагч өөрөө буруутаж шалгуулахаас эмээж зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхээс зайлсхийх, биеийн хүч, тусгай мэх хэрэглэх, харилцааны ур чадвар сул, дуудлага, мэдээллийн дагуу очихдоо эрсдэлээ буруу тооцох, гэмт этгээд, зөрчил гаргагчийг зайнаас аюулгүй болгох тусгай хэрэгсэл дутмаг болон бусад олон хүчин зүйлээс шалтгаалж байна.

Мөн архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн, албан тушаал, эрх мэдэл, танил тал, хөрөнгө мөнгө, хүч бяраар далайлгасан зарим иргэд цагдаагийн алба хаагчийн шаардлага, үйл ажиллагааг эсэргүүцэж, эрх чөлөөнд нь халдахаас буцахгүй хандлагатай, энэхүү үйлдлийнхээ үр дагаврыг мэддэггүй, мэдсэн ч давуу байдлаа ашиглан ял шийтгэлгүй үлдэнэ гэсэн сөрөг итгэл үнэмшилтэй байгаа нь алба хаагчийн аюулгүй байдалд учрах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

3.4 2017 онд батлагдан одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Цагдаагийн албаны тухай хуулиар алба хаагчид улс төр, хууль зүй, нийгэм, эдийн засгийн олон чухал баталгааг эдлүүлэхээр зохицуулсан. Улс орны эдийн засаг, төсөв, санхүүгийн боломжоос шалтгаалан зарим нийгэм, эдийн засгийн баталгааг алба хаагч бүрт жигд эдлүүлэх боломжгүй байгаа ч цаашид улс орны төсөв, санхүүгийн байдалтай уялдан хэрэгжих ирээдүйг харсан зохицуулалт гэж холбогдох албан тушаалтнууд тайлбарлаж байна.

Алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, төрсөн нутагтаа ирэх, очих замын зардлыг олгох, гэр бүлийн хүнийг ажлын байраар хангаагүй нөхцөлд нийгмийн даатгалын шимтгэлийг нь төлөх, алба хаагч шилжин томилогдоход уналга, ачаа тээшийн зардлыг олгох, ээлжийн амралтаа биеэр эдлээгүй нөхцөлд цалин хөлсийг нэмэгдүүлэн олгох, цэрэг, цагдаагийн сургуульд суралцсан хугацааг ажилласан жилд оруулж, цалин, ээлжийн нэмэгдэл амралтыг тооцох зэрэг баталгааг эдлүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр төсөвт тусгагддаггүй, энэ талаар хийгдсэн бүртгэл, судалгаа байхгүй байна.

Түүнчлэн Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоолоор батлагдсан “Цагдаагийн алба хаагчид төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын дагуу үндсэн цалингийн 45 хүртэлх хувийн нэмэгдэл нь Цагдаагийн ерөнхий газрын Төв байрны нэгжүүд болон нэр бүхий 14 нэгжээс бусад байгууллага, нэгжийн алба хаагчдад олгогдохгүй байгаа нь учир дутагдалтай, журам бүрэн хэрэгжихгүй байна.

3.5 Хуулийн хэлтсээс энэ оны 06 дугаар сард цагдаагийн алба хаагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаар төв, орон нутгийн цагдаагийн байгууллага, нэгжийн 392 алба хаагчаас авсан санал асуулгын дүнгээс үзвэл удирдах албан тушаалтнаас алба хаагчийг хамгаалах талаар хайхрамжгүй хандлагатай, алба хаагчид өөрсдийгөө эрсдэлтэй

нөхцөлд ажилладаг, эрх ашиг нь зөрчигдсөн нөхцөлд хөөцөлдөөд ч үр дүн гарахгүй, эрх ашгаа хэрхэн хамгаалах талаар ойлголт муутай гэж үнэлсэн нь алба хаагчдын нийтлэг төсөөллийг илтгэж байна.

Дунд шатны удирдах албан тушаалтнуудын манлайлал, харилцааны үр чадвар дутмаг, захирах захирагдах зарчмаар далайлган алба хаагчдын эрх ашгийг зөрчих, тэдэнтэй дээрэнгүй, зүй бус харьцах, тэдний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалдаггүй талаар алба хаагчдаас гомдол, мэдээлэл ихээр ирдэг тухай Цагдаагийн алба хаагчдын эрх ашгийг хамгаалах холбооноос илэрхийлсэн.

3.6 Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас энэ оны 08 дугаар сард нийслэлийн дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн мөрдөн шалгах чиг үүрэг бүхий алба хаагчдын үйл ажиллагаанд судалгаа хийж, ажлын ачаалал их, цаашид ачаалал буурахгүй, улам бүр өсөх хандлагатай гэж дүгнэжээ. Алба хаагчид ч өөрсдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад нэн тэргүүнд авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ бол ажлын ачааллыг бууруулах гэж тодорхойлж байна.

Алба хаагчдын амрах, нөхөн сэргэлт авах, сурч хөгжих, ар гэртээ зарцуулах цаг буурах, стресс, ядаргаанд орж, биеийн эсэргүүцэл суларч, эрүүл мэнд доройтох, улмаар ажлын бүтээмж буурч, алдаа гаргах, ажилдаа сэтгэл ханамжгүй болох зэрэг нь ажлын ачааллаас үүдэлтэй олон сөрөг үр дагаврын нэг л хэсэг болж байна.

3.7 Эмэгтэй алба хаагчид хүүхэд төрүүлж, хүүхэд асрах чөлөөтэй байх үед нийгмийн даатгалын шимтгэл нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр төлөгддөг. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, Засгийн газрын 2011 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн алба хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох журам”-ын 3-т тус тус заасны дагуу алба хаагчид олгох тэтгэвэр, тэтгэвэрт гарахдаа авах нэг удаагийн тэтгэмжийг түүний сүүлийн 5 жилийн цалин хөлсний дунджаас тооцож олгодог тул тэтгэвэрт гарах /20 жил/-аас өмнө хүүхэд төрүүлсэн эмэгтэй алба хаагчдын тэтгэвэр, тэтгэмж нь бага хэмжээгээр тогтоогдож, эрх ашиг нь зөрчигдөж байна.

4. ДҮГНЭЛТ

Аливаа байгууллагыг дотор нь ажиллаж буй хүмүүсээс салгаж ойлгох аргагүй бөгөөд бүхий л ололт амжилт, алдаа дутагдал нь ажиллагсадаас шууд хамаарч байдаг. Энхийн цагт албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлага, гамшиг осолд өртөх, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирох явдал гагцхүү онцгой байдал, цагдаагийн албанд л тохиолддог, хамгийн түгээмэл байдаг нь бодитой билээ.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад албан үүргээ гүйцэтгэж яваад амь эрсэдсэн 99, сүүлийн 5 жилд эрүүл мэндээр хохирсон 271 /нэгж

бүрт бүртгэл, судалгаа бодитой хийгдвэл энэ тоо эрс өсөх магадлалтай/ алба хаагч байгаа, хуульд заасан нийгэм, эдийн засгийн баталгаа жигд, бүрэн олгогддоггүй, ажлын ачааллын талаар урьд хийгдсэн судалгаа, алба хаагчдаас авсан санал асуулгын дүн болон аудитын явцад цугларсан бусад мэдээлэлд үндэслэн тэдний аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаанд онцгойлон анхаарч, бодитой ахиц дэвшил гаргах шаардлагатай гэж аудитын багаас дүгнэлээ.

Албан үүргээ гүйцэтгэж буй цагдаа, дотоодын цэргийн алба хаагч халдашгүй байх үзлийг нийгэмд төлөвшүүлэхийн тулд нөлөөллийн арга хэмжээг олон чиглэлээр авч хэрэгжүүлэх, байгууллага, алба хаагчийн хууль ёсны үйл ажиллагааг мушгин гуйвуулсан, нэр хүнд, алба хаагчийн эрх чөлөөнд халдсан хэнтэй ч эвлэршгүй байж, нийгмийн байдлыг нь үл харгалзан хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож хэвших нь зүйтэй байна.

Гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон алба хаагчдын талаарх бүртгэл судалгаа хангалтгүй, тоон мэдээллүүд зөрүүтэй, хариуцсан нэгжүүд нь үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хуульд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нь алба хаагч, ажилтны аюулгүй байдлыг хангах, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүрэгтэй гэж заасан ч энэхүү үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, нийт байгууллага, алба хаагчдын аюулгүй байдал, эрх ашигт хамааралтай эрсдэл, тулгамдсан асуудлыг тодорхойлж шийдвэрлүүлэх ажил эзэнгүйдсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэс нь холбогдох журмын дагуу байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн сан бүрдүүлж, алба хаагчид гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлийг тодорхойлж, шалтгаан нөхцлийг арилгах, энэ талаар цагдаагийн төв байгууллагын удирдлагыг мэдээллээр хангаж, өгсөн чиглэлийн дагуу ажил зохиох зэрэг чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүй, хяналт шалгалтын чиг үүрэг давамгайлсан шинжтэй үйл ажиллагаа явуулж байна.

“Дотоод аюулгүй байдлыг хангах /Код/-113 журам”-д цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хүний нөөц, мэдээлэл, төсөв, санхүү, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, барилга байгууламж, алба хаагчийн аюулгүй байдал гэсэн төрөлтэй байхаар зохицуулсан. Аюулгүй байдлыг дээрх төрөл, чиглэл бүрээр хангах үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах нь тусгай мэдлэг, мэргэшил шаардсан ажил тул хариуцах нэгжийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эмч, өмгөөлөл, инженер техник, мэдээллийн технологи, барилга, зэвсэг тусгай хэрэгсэл, эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн алба хаагчдаар бүрдүүлэн шинээр бий болгох шаардлагатай байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага бүрт “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комисс”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл”-ийг байгуулсан, нийт алба хаагчдыг гэнэтийн ослын даатгалд даатгуулж хэвшсэн, Хуулийн хэлтэст алба хаагчдын эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий 2 орон тоог бий болгож, алба хаагчдыг томилсон зэрэг нь үр дүнтэй хэрэгжсэн нөхцөлд алба хаагчдын эрүүл мэнд, эрх ашгийг хамгаалахад чиглэсэн чухал алхамууд болжээ.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд тулгамдаж буй аливаа эрсдэлийн суурь шалтгаан нь эрх зүйн зохицуулалт, төсөв, санхүүгийн боломж хүрэлцээ, ажлын ачааллаас үүдэлтэй байдаг. Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомжоор алба хаагчид эдлүүлэхээр зохицуулсан баталгааг жигд, бүрэн эдлүүлэхэд шаардлагатай төсөв, санхүүгийн боломжгүй гэх нийтлэг тайлбар байгаа ч тухайн баталгааг эдлэх эрх үүссэн алба хаагч, тохиолдлын бүртгэл судалгааг хийж, түүнд шаардагдах зардлыг тооцооноор шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг хэмнэсэн, эсхүл хэмнэх боломжтой төсвийн бусад зардлаас зохих журмын дагуу шилжүүлэн шийдвэрлэх боломжтой юм.

Жилээс жилд өсөн нэмэгдэх хандлагатай байгаа цагдаагийн байгууллага, алба хаагчийн ажлын ачааллыг зөвхөн орон тоог нэмэгдүүлэх замаар шийдвэрлэх боломжгүй, түүнд шаардагдах төсөв, санхүүгийн эх үүсвэр байхгүй нь бодит үнэн учраас олон улсад туршигдсан, Монгол Улсын төрийн зарим байгууллагад ч амжилттай хэрэгжүүлж буй “Байгууллагын үйл ажиллагааны дахин инженерчлэл”, “Автоматжуулалт”, “Үүлэн /Cloud/ технологи” болон бусад арга хэмжээг мэргэшсэн зөвлөх багийн дэмжлэгийг авч, цагдаагийн байгууллагад хэрэгжүүлснээр ажлын ачааллыг бодитой бууруулах боломжтой гэж үзэж байна.

5. ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, аудитын дүгнэлт, аудитад хамаарах нэгжүүдээс ирүүлсэн “Удирдлагын тайлбар”-ыг үндэслэн, цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг боловсронгуй болгох, эрсдэлийг бууруулах чиглэлээр дараах саналыг танилцуулж байна. Үүнд:

5.1 Алба хаагчийн аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, цаашилбал цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг чиглэл бүрээр нь хангах үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах нэгжийг Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын харьяанд шинээр байгуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эмч, өмгөөлөл, инженер техник, мэдээллийн технологи, барилга, зэвсэг тусгай хэрэгсэл,

эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн алба хаагчдаар хүний нөөцийг бүрдүүлэх,

5.2 Дээр дурдсан саналын дагуу шинээр нэгж байгуулах боломжгүй нөхцөлд байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиглэлээрх Аюулгүй байдлын хэлтсийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэхэд шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг хийж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эрсдэлийн удирдлага, мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшсэн алба хаагчдаар хүний нөөцийг бэхжүүлэх,

5.3 Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагчтай холбоотой хэвлэл, мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй эерэг, сөрөг бүхий л мэдээллийг бүртгэн, дүн шинжилгээ хийж, зохих арга хэмжээг авах, байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг санаатай мушгин гуйвуулж, нэр хүндэд нь халдаж буй этгээдэд хариуцлага тооцох, шаардлагатай залруулга, мэдээллийг түгээх ажлыг эрчимжүүлэх,

5.4 Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэгт заасны дагуу алба хаагчдын ажилласан жилийг нэмэгдүүлэн тооцох зохицуулалтад нийт бие бүрэлдэхүүний 26.2 хувийг бүрдүүлж буй захиргааны чиг үүрэгтэй алба хаагчдыг хамруулж, төрийн бусад тусгай байгууллага дахь жишигт нийцүүлэх,

5.5 Санхүү, аж ахуйн албаны хөдөлмөрийн аюулгүй байдлын байцаагч, хүний их эмч нь цагдаагийн төв байгууллагын алба хаагчдад эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, “Сүүж-Уул” сувиллын эрхийн бичгийг олгох, “Эрүүл цагдаа” хөтөлбөрийн хэрэгжилт, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагууд дахь “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комисс”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл”-ийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааны тайлан мэдээллийг нэгтгэн үнэлэх, бусад чиг үүргийг хэрэгжүүлэх зэргээр өндөр ачаалалтай /Хавсралт 6/ ажиллаж байна. Иймд нийт алба хаагчдын аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, Төв байрны алба хаагчдад үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор Хангамжийн хэлтэст 1 сувилагчийн орон тоог нэмэгдүүлэх,

5.6 Хууль тогтоомжид заасан баталгааг эдлэх эрх үүссэн алба хаагч, тохиолдлын нэгдсэн бүртгэл судалгаатай болж, түүнд шаардагдах зардлыг тооцон, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг хэмнэсэн, эсхүл хэмнэх боломжтой төсвийн бусад зардлаас зохих журмын дагуу шилжүүлэн шийдвэрлэх бодлого баримталж ажиллах,

5.7 Алба хаагчдын орлогыг нэмэгдүүлэх, өрхийн амьжиргааг бодитой дэмжих зорилгоор Цагдаагийн албаны тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.7 дахь хэсэгт заасны дагуу суралцсан хугацааг ажилласан жилд оруулан тооцох, Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоолоор батлагдсан “Цагдаагийн алба хаагчид төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-д заасны дагуу үндсэн цалингийн 45 хүртэлх хувийн нэмэгдлийг нийт алба хаагчдад олгох,

5.8 Байгууллага, алба хаагчдын ажлын ачааллыг бууруулах зорилгоор “Байгууллагын үйл ажиллагааны дахин инженерчлэл”, “Автоматжуулалт”, “Үүлэн /Cloud/ технологи” болон бусад арга хэмжээг мэргэшсэн зөвлөх багийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх,

5.9 Аудитаар илэрсэн асуудал, дээр дурдсан саналуудыг шийдвэрлэх зорилгоор дараах зөвлөмжийг холбогдох нэгжүүдэд хүргүүлэх саналтайг тус тус илтгэн танилцуулж байна. Үүнд:

Захиргааны удирдлагын газарт:

- Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдал, ялангуяа алба хаагчдын аюулгүй байдлыг хамгаалах үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажиллах нэгжийг мэргэшсэн алба хаагчдаар бүрдүүлэн шинээр бий болгох /ХНХ/,

- Аюулгүй байдлын хэлтсийн хүний нөөцийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эрсдэлийн удирдлага, мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшсэн алба хаагчдаар бэхжүүлэх /ХНХ/,

- Санхүү, аж ахуйн албаны Хангамжийн хэлтэст 1 сувилагчийн орон тоог шинээр бий болгож нэмэгдүүлэх /ХНХ/,

- Дунд түвшний удирдах ажилтнуудын манлайлал, удирдахуйн арга барилын талаар гарч буй шүүмжлэлтэй холбогдуулан тэднийг сонгон шалгаруулж, томилохдоо ажлын туршлага, мэргэжлийн ур чадвараас гадна манлайлал, харилцааны ур чадварыг нь гол шалгуур болгох бодлого баримтлах /ХНХ/,

- Тайлангийн 4 дүгээр хавсралтын 2 дугаар хэсгийн 3, 4, 5, 6-д заасан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрсдэлийг арилгах талаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагыг нарийвчлан судалж, дээд шатны байгууллагад санал хүргүүлэн шийдвэрлүүлэх /ХуХ/,

- Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэгт заасны дагуу ажилласан жилийг нэмэгдүүлэн тооцох зохицуулалт нь нийт алба хаагчдад жигд үйлчлэх талаар хуульд оруулах өөрчлөлтийн саналыг боловсруулж, дээд шатны байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх /ХуХ/,

- Эмэгтэй алба хаагчдын тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой энэхүү тайлангийн 3.7-д заасан асуудлыг алба хаагчдад ашигтайгаар шийдвэрлэх зорилгоор хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг боловсруулж, дээд шатны байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх /ХУХ/,

Санхүү, аж ахуйн албанд:

- Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагууд дахь “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комисс”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл”-ийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагааны тайлан, мэдээллийг нэгтгэн үнэлэх, гишүүдийг мэргэшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах,

- Алба хаагчдыг гэнэтийн ослын даатгалд даатгуулсан гэрээний төлбөр, даатгалын байгууллагаас буцаан олгосон нөхөн олговрын зөрүү өндөр байгаад анхаарч, даатгалын тохиолдлын хамрах хүрээ, нөхөн олговрын хэмжээг нэмэгдүүлэх зэргээр гэрээний нөхцлийг цагдаагийн байгууллагад илүү ашигтайгаар шинэчлэх,

- Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан баталгааг эдлэх эрх үүссэн нийт алба хаагчдын судалгааг гаргах, шаардлагатай хөрөнгийг төсвийн хэмнэсэн зардлаас гарган олгох тухай чиглэлийг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавих,

- Мөн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.7 дахь хэсэгт заасны дагуу алба хаагчдын суралцсан хугацааг ажилласан хугацаанд оруулан тооцож, цалин хөлсийг нэмэгдүүлэн олгох ажлыг Хүний нөөцийн хэлтэстэй хамтран хэрэгжүүлэх,

- Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоолоор батлагдсан “Цагдаагийн алба хаагчид төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-д заасны дагуу үндсэн цалингийн 45 хүртэлх хувийн нэмэгдлийг нийт алба хаагчдад олгох асуудлыг шийдвэрлүүлэх,

- Гэмт этгээдийг зайнаас аюулгүй болгох аминд үл хүрэх зэвсэг, тусгай хэрэгслээр алба хаагчдыг хангах зорилгоор 2020 онд худалдан авалт хийхэд энэ чиглэлд түлхүү анхаарах,

- Тайлангийн 4 дүгээр хавсралтад дурдсан Хэрэг бүртгэх алба, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, Тусгай ажиллагааны газар, Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэст холбогдох асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах.

Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанд:

- Гэмт хэрэг, зөрчлийг шалгах ажиллагааны зардал, мөрдөн шалгах чиг үүрэгтэй алба хаагчдын бичиг хэрэг, харилцаа холбоо, шатахууны нэг сарын дундаж зардлын судалгааг гаргах,

- Байгууллага, алба хаагчдын ажлын ачааллыг бууруулах чиглэлээр орон тоо, төсөв хөрөнгө нэмэгдүүлэх, хууль тогтоомжийг өөрчлөхөөс бусад шинэлэг санал, санаачлагыг гаргаж, шийдвэрлүүлэх,

Аюулгүй байдлын хэлтэст:

- Холбогдох журмын дагуу байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, алба хаагчид гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлийг тодорхойлж, шалтгаан нөхцлийг арилгах, энэ талаар цагдаагийн төв байгууллагын удирдлагыг мэдээллээр хангаж, өгсөн чиглэлийн дагуу ажил зохиох чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх,

- Алба хаагчийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай бүхий л төрлийн мэдээллийн сан, бүртгэл, судалгааг бий болгож, үйл ажиллагаандаа ашиглах, энэ чиглэлээр нэгжүүдээс хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, дүн мэдээг нэгтгэх,

- Байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хариуцах бие даасан нэгж байгуулагдаагүй нөхцөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эрсдэлийн удирдлага, мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшсэн алба хаагчдаар хэлтсийн хүний нөөцийг бэхжүүлэх,

Хэвлэл мэдээллийн төвд:

- Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр цагдаагийн байгууллага, алба хаагчтай холбоотой цацагдсан мэдээллийн бүртгэл, архив үүсгэж, тэдгээрт дүн шинжилгээ хийн, шаардлагатай залруулга, мэдээллийг түгээх, худал мэдээлэл тарааж байгууллага, алба хаагчийн нэр хүндэд халдсан, хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан этгээдэд хариуцлага тооцуулах талаар холбогдох нэгжүүдтэй хамтран ажиллаж, хяналт тавих,

Урьдчилан сэргийлэх хэлтэст:

- Хууль тогтоомжийн дагуу албан үүргээ гүйцэтгэж буй цагдаа, дотоодын цэргийн алба хаагч халдашгүй байх үзлийг нийгэмд төлөвшүүлэх чиглэлээр ухуулга, нөлөөллийн арга хэмжээг холбогдох нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлэх,

Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд:

- Дуудлага, мэдээллийн дагуу очиж ажилладаг алба хаагчдад аюулын зэргийн үнэлгээ хийх, биеийн хүч, тусгай мэх, хэрэгсэл хэрэглэх ур чадвар эзэмшүүлэх сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсруулж, сургалтыг зохион байгуулах,

Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст:

- Байгууллага, алба хаагчдын ажлын ачааллыг бууруулах зорилгоор “Байгууллагын үйл ажиллагааны дахин инженерчлэл”, “Автоматжуулалт”, “Үүлэн/Cloud/ технологи”-ийн талаар мэргэшсэн мэргэжилтэн, судлаачдыг урьж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах,

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад:

- Албан үүргээ хууль тогтоомжийн дагуу, шударгаар биелүүлсэнтэй холбогдуулан эрх мэдэл, албан тушаалтан, бусад этгээдээс ирж болзошгүй аливаа дарамт шахалтаас алба хаагчдыг хамгаалах, энэ тухай бүртгэл хөтөлж, Цагдаагийн ерөнхий газрын удирдлага, Аюулгүй байдлын хэлтсийг мэдээллээр хангах,

- Тус тусын нэгж дээрх “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комисс”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл”-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу идэвхитэй ажиллуулах,

- Албан үүргээ гүйцэтгэж яваад амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирсон алба хаагчдын бүртгэл судалгааг тогтмол хөтөлж, хуульд заасан тэтгэмж, нөхөн олговрыг олгох ажлыг зохион байгуулж, алба хаагчдын эрх ашгийг хамгаалах,

- Гэнэтийн ослын даатгалын тохиолдол, нөхөн олговор авах эрхийн талаар алба хаагчдад байнга мэдээлэл түгээж, даатгалын компанитай хамтран ажиллах.

- Зөвлөмж хүлээн авсан байгууллага, нэгж нь зөвлөмжийн хэрэгжилтийн явцын талаарх танилцуулгыг **2020** оны **01** дүгээр сарын **15**-ны дотор, эцсийн биелэлт, үр дүнг мөн оны **06** дугаар сарын **15**-ны дотор тус тус Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст ирүүлнэ.

6. УДИРДЛАГЫН ТАЙЛБАР

Аудитын урьдчилсан тайлантай холбогдуулан Санхүү, аж ахуйн алба, Хүний нөөцийн хэлтэс, Хуулийн хэлтэс, Аюулгүй байдлын хэлтсээс тус тус ирүүлсэн “Удирдлагын тайлбар”-ыг тайланд хавсаргав.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

---oOo---

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: НХЖХОНАБХА-ны Эргүүл хамгаалалтын газрын Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтэс, Дотоодын цэргийн штабын 05, 805 дугаар анги

Аудитын объект: Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа

Аудитын төрөл, код: Үйл ажиллагааны аудит, ЦЕГ-ХШҮДАХ/ҮА-2019/01

Аудитын хугацаа: 2019.05.01- 2019.05.31

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх

1. ТАНИЛЦУУЛГА

Шүүхийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9, 12 дугаар зүйлийн 12.1.8 дахь хэсэгт тус тус заасны дагуу цагдаагийн байгууллага нь шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, шүүх хуралдааны журам сахиулах, яллагдагчийг хуяглан хүргэх, шүүхийн дуудсанаар ирэхгүй байгаа яллагдагч, гэрч, зохигч, хэргийн оролцогчдыг албадан ирүүлэх үүргийг дараах чиглэлээр гүйцэтгэж байна.

Нэг.Шүүх, шүүхийн барилга, байгууламжийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 281 дүгээр тогтоолоор “Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад авах улсын онц чухал объектын жагсаалт”-д аймаг, нийслэл, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн байр нь цагдаагийн байгууллагын төсөвт хамгаалалтад байхаар тогтоосны дагуу дараах 9 объектыг цагдаагийн байгууллагаас хамгаалж байна /Хавсралт 1/. Үүнд:

1. Нийслэлийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх
2. Захиргааны хэргийн нэгдсэн шүүх

3. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
4. Сонгинохайрхан, Хан-Уул, Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
5. Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх
6. Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх
7. Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх
8. Шүүхийн төрөлжсөн архив
9. Хан-Уул, Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын байр

Түүнчлэн Дотоодын цэргийн командлагчийн 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/13 дугаар тушаалын дагуу Дотоодын цэргийн 05, 805 дугаар ангиас дараах 3 объектыг түр хамгаалж байна. Үүнд:

10. Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх
11. Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх
12. Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Гэр бүлийн хэрэг, маргаан шийдвэрлэх байр /3 дугаар байр/

Аймаг, сум буюу сум дундын шүүхийн байрны хамгаалалтыг тухай орон нутгийн цагдаагийн газар, хэлтсээс хариуцан хэрэгжүүлж байна.

Хоёр.Шүүх хуралдааны журам сахиулах, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй Улсын дээд шүүх, эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны 10 шүүх, ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461, хорих 409 дүгээр анги дахь онлайн шүүх хуралдааны танхимд 2018 онд 47807 шүүх хуралдаан явагдсанаас 29783, 2019 оны эхний 4 сарын байдлаар 18667 шүүх хуралдаан явагдсанаас 10675 шүүх хуралдааны журмыг цагдаагийн байгууллагаас тус тус сахиулж, оролцогчдын аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.

Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсээс 2014 оноос хойш нийт 12 шүүгчийг албан үүрэгтэй нь холбогдуулан дунджаар 1 сарын хугацаанд биечилсэн хамгаалалтад авч ажилласан байна.

Он	2014	2015	2016	2017	2018	2019	Нийт
Хамгаалалтад авсан шүүгчийн тоо	3	2	3	3	1	0	12

Гурав.Хуяглан хүргэх, албадан ирүүлэх үйл ажиллагааны чиглэлээр:

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтэс нь цагдан хорих байрнаас шүүх хуралдаанд, шүүх хуралдаанаас цагдан хорих байранд 2018 онд 5317, 2019 оны эхний 4 сарын байдлаар 2683 /давхардсан тоогоор/ яллагдагч, шүүгдэгч, ялтны аюулгүй байдлыг ханган хуяглан хүргэжээ.

Мөн эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдээс шүүх хуралдааны оролцогчийг албадан ирүүлэх шүүгчийн захирамж 2018 онд 2390-ийг хүлээн авснаас 2280, 2019 оны эхний 4 сарын байдлаар 694-ийг хүлээн авснаас 687 захирамжийн биелэлтийг тус тус хангаж ажиллажээ.

Дээрх үйл ажиллагааг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2016 оны А/40, 113 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам”, “Яллагдагчийг хуяглан хүргэх, албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаа явуулах журам” болон бусад эрх зүйн акт, баримт бичгийн хүрээнд явуулж байна.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтсээс санаачлан зураг төслийг боловсруулж, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 3 сая гаруй төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлснээр Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Сонгинохайрхан, Хан-Уул, Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх тус бүрт 1 хуралдааны танхимд шүүгдэгчийн тусгаарлах хаалт хийлгэж суурилуулсан нь шүүгч, шүүгдэгч, бусад оролцогчдын аюулгүй байдлыг хангахад шинэлэг, үр дүнтэй ажил болжээ.

Мөн хамгаалуулагч байгууллагатай хамгаалалтын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр ойр хамтран ажиллаж, хамгаалалтын үйл ажиллагаанд шаардлагатай техник хэрэгсэл, бусад асуудлыг шийдвэрлүүлж, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа нь аудитын явцад ажиглагдлаа.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2019 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.3-т заасны дагуу шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, Цагдаагийн ерөнхий газрын удирдлагыг мэдээллээр хангах, аудитын объектыг боловсронгуй болгох, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, эрсдэлийг бууруулах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хүргүүлж, үр дүнг тооцох нь дотоод аудитын зорилго юм.

2.2 Аудитын цар хүрээ

Аудитад Шүүхийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9, 12 дугаар зүйлийн 12.1.8 дахь хэсэгт тус тус заасны дагуу цагдаагийн байгууллагаас шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, шүүх хуралдааны журам сахиулах, яллагдагчийг хуяглан хүргэх, шүүхийн дуудсанаар ирэхгүй байгаа яллагдагч, гэрч, зохигч, хэргийн оролцогчдыг албадан ирүүлэх үйл ажиллагааг хамрууллаа.

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, иргэний хэргийн хариуцагчийг цагдаагийн байгууллагаас эрэн сурвалжлах ажиллагаа болон аудитад хамрагдсан нэгжийн бусад үйл ажиллагааг аудитын объектод хамруулаагүй болно.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлж буй НХЖХОНАБХА-ны Эргүүл хамгаалалтын газрын Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтсийн удирдлага, алба хаагчид, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч, шүүхийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн, Улаанбаатар хот дахь шүүхүүдийн Тамгийн газрын дарга нартай уулзалт ярилцлага зохион байгуулж, аудитад шаардлагатай мэдээлэл, баримт материалыг цуглуулсан.

Мөн Улаанбаатар хотод байршиж буй шүүх, шүүхийн бусад байгууллага нийт 13 объект, ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр ангид биечлэн ажиллаж, холбогдох журмын хэрэгжилт, хамгаалалтын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тооцож үнэлсэн.

Аудитын явцад цугларсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан “Урьдчилсан тайлан”-г бичиж, НХЖХОНАБХА-ны Эргүүл хамгаалалтын газарт хүргүүлэн “Удирдлагын тайлбар”-ыг авч энэхүү тайланд тусгасан.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтэс нь батлагдсан 99 орон тоотойгоос 1 офицер, 6 цагдаагийн орон тоо дутуу байна. Тус хэлтсийн Шүүхийн аюулгүй байдлыг хангах тасаг нь тасгийн дарга 1, эргүүл хамгаалалтын офицер 1, харуулын цагдаа 28, нийт 30 орон тоотойгоор шүүхийн 9 байгууллагыг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Алба хаагчид батлагдсан орон тооны дагуу 3 ээлжээр 24/48 цагаар үүрэг гүйцэтгэж байгаа нь Хөдөлмөрийн хуульд заасан хэмжээнээс сард дунджаар 64 цаг илүү ажиллаж, нэгдсэн, хэсэгчилсэн болон бусад арга хэмжээнд татагдан оролцсоноор илүү цагийн хэмжээ бүр нэмэгдэх, улмаар алба хаагчдын ажлын сэтгэл ханамжийг бууруулах, харуул, хамгаалалтын хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

3.2 Шүүгч, шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах тасаг нь тасгийн дарга 1, эргүүл хамгаалалтын офицер 8, хамгаалалтын цагдаа 25, нийт 34 орон тоотойгоор нийслэлийн хэмжээнд 63 шүүх хуралдааны танхимд журам сахиулах, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж байна. Онцлох шүүх хуралдааны талаарх мэдээллийг Шүүхийн тамгын газраас урьдчилан авч хүч нэмэгдүүлсэн хамгаалалтыг зохион байгуулдаг. Орон тооны хүрэлцээгүйгээс иргэний болон захиргааны хэргийн шүүх хуралдааны танхим бүрт цагдаагийн алба хаагч биечлэн хяналт тавих боломжгүй, телекамераар хяналт тавьж байна. Гэвч Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдэд шүүх хуралдааны танхим дахь телекамерыг цагдаагийн алба хаагч хянах нөхцлийг бүрдүүлээгүй нь шүүх хуралдааны журам сахиулах үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна.

Түүнчлэн ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр анги, хорих 409 дүгээр анги дахь онлайн шүүх хуралдааны танхимд хурал явагдах үед цагдаагийн алба хаагч журам сахиулж байна. Хорих ангийн хамгаалалтын бүс, объект дотор явагдаж буй дээрх онлайн шүүх хуралд цагдаагийн алба хаагч үүрэг гүйцэтгэж байгаа нь ач холбогдол багатай, хүний нөөцийн оновчгүй зарцуулалт байх тул тухайн үйл ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлэх нь зүйтэй байна.

3.3 “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам”-аар шүүх хуралдааны танхимд тавигдах шаардлага, шүүхийн байрыг хамгаалахад шаардлагатай техник хэрэгслийг нарийвчлан зохицуулсан ч бодит байдал дээр хэрэгжилт нь хангалтгүй байна. /Хавсралт 2/ Тухайлбал;

3.1.1 Хаалган болон гар метал илрүүлэгч, ачаа, тээш шалгах рентген төхөөрөмж, ачаа тээш түр хадгалах хайрцаг, согтуурал хэмжигч багаж /драгер/, утасны сүлжээ сарниулагч, яаралтай тусламжийн дохиоллын систем зэрэг техник хэрэгсэл хүрэлцээгүй, давхар болон 1-ээс дээш орж гарах хаалга, шүүх бүрэлдэхүүн болон шүүгдэгчийг тусгаарласан хаалттай байх шалгуурыг хэсэгчлэн хангасан шүүх хуралдааны танхимын тоо нийт танхимын 30 хувиас бага байна.

3.1.2 Эрүүгийн хэргийн анхан шатны 2 шүүхээс бусад шүүхэд Түр саатуулах өрөө байдаггүй нь давтамж багатай ч захиргааны, иргэний хэргийн шүүх, Нийслэлийн давж заалдах шатны болон Улсын дээд шүүхээс хорих ял авсан, эсвэл шүүгдэгч нь хорих, цагдан хорих байрнаас ирж шүүх хуралдаанд оролцох үед тэдгээрийг түр саатуулах үйл ажиллагаанд эрсдэл үүсгэж байна.

“Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам”-д яллагдагч, шүүгдэгч, ялтныг Түр саатуулах өрөөнд хэрхэн тусгаарлах талаар нарийвчлан зохицуулсан. Энэ журмаар Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй

дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх дэх 2 Түр саатуулах өрөө нь хүрэлцээгүй, тухайн шүүхийн архив, сервер, бялдаржуулах өрөөнд уг өрөөний үүдээр дамжин ордогос шүүхийн ажиллагсад гадаа хаалганы нууц кодыг мэддэг, шүүгдэгч нарыг Түр саатуулах өрөөнөөс шүүх хуралдааны танхимд хүргэхдээ гадуур авч явдаг, цагдаагийн алба хаагчийн хяналтын цэгийг харсан телекамер байдаггүй зэрэг нь аюулгүй байдлын түвшинг сулруулж байна.

3.4 Аудитын явцад шүүхүүдийн Тамгын газрын дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн холбогдох ажилтан нартай уулзалт ярилцлага зохион байгуулахад шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай техник, тусгай хэрэгслээр шүүхийн байр, шүүгч, цагдаагийн алба хаагчдыг хангахад шаардлагатай зардлыг өөрийн төсөвт суулгаж, тодорхой ажлуудыг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаагаа илэрхийлсэн. Нөгөө талаас тухайн шүүх дээр үүрэг гүйцэтгэх цагдаагийн алба хаагчдыг аль болох тогтвортой ажиллуулах, ингэснээр алба хаагч, шүүхийн ажилтнуудын хооронд үүсдэг харилцааны зөрчилдөөнөөс сэргийлэх боломжтой талаар санал гаргасан болно.

3.5 Хуяглан хүргэх ажиллагаа буюу яллагдагч, шүүгчдэгчийг нэг объектоос нөгөө объектод харуул хамгаалалтын хяналт дор явганаар болон тээврийн хэрэгсэл ашиглан хүргэх ажиллагааг ЭХГ-ын ШШАБХХ-ийн Хуяглан хүргэх, албадан ирүүлэх тасгаас хэрэгжүүлж байна. Хуяглан хүргэх ажиллагааг хэрэгжүүлж буй цагдаагийн алба хаагчдын мэдээлэл /нэр, хувийн дугаар, цол, нүүр царай г.м/-ийг нууцлах арга хэмжээ байхгүйгээс алба хаагчид яллагдагч, шүүгдэгч, ялтанд нүдлэгдэх, албан үүргээ гүйцэтгэсний төлөө доромжлол, заналхийлэлд өртөх, эсхүл хувийн харьцаа үүсгэснээс болж тавих шаардлага сулрах зэрэг эрсдэл байгааг аудитын явцад алба хаагчид илэрхийлсэн. Иймд гадаад орнуудын жишигт нийцүүлэн хуяглан хүргэх ажиллагааг хэрэгжүүлж буй алба хаагчдыг нүүрний маск, тусгай хувцас, хэрэгслээр хангаж, аюулгүй байдлыг хангах нь зүйтэй байна.

3.6 Хуяглан хүргэх ажиллагаанд ашиглагддаг [REDACTED] маркийн [REDACTED] улсын дугаартай тээврийн хэрэгсэл нь 2012 онд БНХАУ-д үйлдвэрлэгдсэн, 2014-2016 онд Тахарын албанд ашиглагдах хугацаанд моторт нь 2 удаа гэмтэл гарч засварт орсон байна. Өнөөдрийн байдлаар уг автомашин нь мотор муудсан тул алс замд явах боломжгүй, суудлын тоо бага, кабинд тусгаарлах зориулалтын тоноглолгүй, халаалтын систем нь ажилладаггүйгээс өвлийн улиралд урд болон хажуу талын салхины шил цантаж үзэгдэх орчин хязгаарлагдах, зорчигчид даарах зэрэг хүндрэл гарч байна.

4. ДҮГНЭЛТ

Тахарын алба татан буугдаж, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг цагдаагийн байгууллагад шилжин ирснээс хойш анх удаа тус үйл ажиллагаанд Цагдаагийн төв байгууллагаас дотоод аудитыг хэрэгжүүлж, хамгаалуулж буй объект бүрт аудитын баг биечлэн очиж, нөхцөл байдалтай танилцан дотоод аудитыг хэрэгжүүлсэн нь энэхүү аудитын ач холбогдлыг илтгэнэ.

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг “Хангалттай”, уг үйл ажиллагаанд тулгамдсан ноцтой эрсдэлгүй байна гэж дүгнэлээ. Хамгаалалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй гол асуудал нь шүүх, шүүхийн байгууллагын барилга, байгууламжийн зохион байгуулалт, цагдаагийн алба хаагчдын орон тооны хангалт хүрэлцээнээс үүдэлтэй байна.

Тухайлбал, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хамтран баталсан журамд заасан шүүх хуралдааны танхим, түр саатуулах өрөөний стандартын хэрэгжилт хангалтгүй, шүүгч, шүүхийн байрыг хамгаалах, шүүх хуралдааны журам сахиулах ажиллагаанд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалт, хүрэлцээ дутмаг байна. Мөн шүүхийн байрыг хамгаалах цагдаагийн алба хаагчийн орон тоог 3 ээлж байхаар тулган баталсан, шүүх хуралдааны журам сахиулж ажиллах алба хаагчдын тоо хүрэлцээгүй байгаа нь ажлын ачааллыг нэмэгдүүлж, хамгаалалтын үйл ажиллагаанд эрсдэл учруулахаар байх тул хүний нөөцийн бодлого, төлөвлөлтөд анхаарч үзэхийг аудитын багаас онцолж байна.

Хамгаалуулагч байгууллага болох шүүхүүдийн Тамгын газар, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах талаар тодорхой төлөвлөлт хийн, санаачлага гарган ажиллаж байгаа нь аудитын явцад ажиглагдлаа.

Цаашид шүүхийн байгууллага улам бүр өргөжин тэлэх, шинэ барилга, байгууламж ашиглалтад орохын хирээр одоо нэг дор үйл ажиллагаа явуулж байгаа шүүхүүд тусдаа гарч, цагдаагийн байгууллагаас хамгаалбал зохих объектын тоо өсөх, шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэг маргаан, шүүх хуралдааны танхимын тоо жилээс жилд өсөх хандлагатай байх тул цагдаагийн байгууллагын орон тоо, техник хэрэгслийг нэмэгдүүлэх талаар Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн ерөнхий зөвлөл, Цагдаагийн байгууллага хамтран ажиллах, харилцан ойлголцох зайлшгүй шаардлагатай байна.

5. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, аудитын үр дүн, аудитад хамрагдсан нэгжээс ирүүлсэн “Удирдлагын тайлбар”-ыг үндэслэн, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, эрсдэлийг бууруулах чиглэлээр дараах саналыг танилцуулж байна. Үүнд:

5.1 Ижил албан тушаалын тодорхойлолттой хэд хэдэн орон тоотой цагдаагийн байгууллага, нэгжид алба хаагч хүндэтгэн үзэх шалтгааны / орон тоо дутуу, ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй г.м/ улмаас албан үүргээ гүйцэтгэхгүй болсон нөхцөлд түүний ажил, үүргийг бусад алба хаагчдад хуваарилан гүйцэтгүүлэх боломжтой юм.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтсийн шүүхийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй ажлын байрны орон тоог 3 ээлж, 24/48 цагаар үүрэг гүйцэтгэхээр тулгаж баталснаас алба хаагчид байнга илүү цагаар ажиллах, улмаар тэдний сэтгэл ханамж, эрүүл мэнд, хамгаалуулж буй объектын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Иймд цагдаагийн байгууллагын хэмжээнд 24 цагаар тасралтгүй үүрэг гүйцэтгэх харуул, жижүүрийн ажлын байрны орон тоог 4 ээлж байхаар тооцож орон тоог нэмэгдүүлэх,

5.2 ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр анги, хорих 409 дүгээр анги дахь онлайн шүүх хуралдааны танхимд хурал явагдах үед цагдаагийн алба хаагч журам сахиулж байна. Хорих ангийн хамгаалалтын бүс, объект дотор явагдаж буй дээрх онлайн шүүх хуралд цагдаагийн алба хаагч үүрэг гүйцэтгэж байгаа нь ач холбогдол багатай, хүний нөөцийн оновчгүй зарцуулалт байх тул тухайн үйл ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлэх,

5.3 ЭХГ-ын ШШАБХХ-ийн Хуяглан хүргэх, албадан ирүүлэх тасгийн алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг бууруулах зорилгоор гадаад орнуудын жишигт нийцүүлэн алба хаагчдыг нүүрний маск, тусгай хувцас, хэрэгслээр хангах арга хэмжээ авах,

5.4 Хуяглан хүргэх ажиллагааг хэвийн, аюулгүй хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай тусгай тоноглогсон, техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан 1 ширхэг тээврийн хэрэгслээр холбогдох нэгжийг хангах,

5.5 Хамгаалуулагч байгууллагаас шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах талаар авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ, аудитын үр дүнгийн талаарх мэдээллийг бэлтгэж, Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх,

5.6 Аудитаар илэрсэн асуудал, дээр дурьдсан саналуудыг шийдвэрлэх зорилгоор дараах зөвлөмжийг холбогдох нэгжүүдэд хүргүүлэх саналтайг тус тус илтгэн танилцуулж байна. Үүнд:

Хүний нөөцийн хэлтэст:

- Цагдаагийн байгууллагын хэмжээнд батлагдсан орон тооны дагуу 3 ээлж, 24/48 цагаар үүрэг гүйцэтгэж буй харуул, жижүүрийн ажлын байрны судалгааг гаргаж, тэдгээрийн орон тоог 4 ээлж байхаар тооцож нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттай авах,

Санхүү, аж ахуйн албанд:

- Яллагдагч, шүүгдэгч, ялтныг хуяглан хүргэх үйл ажиллагаанд шаардлагатай тусгай тоноглогдсон тээврийн хэрэгслийн санхүүжилтийг шийдвэрлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулах,

- Хуяглан хүргэх чиг үүрэгтэй алба хаагчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр нүүрний маск, тусгай хувцас, хэрэгслээр хангах асуудлыг судалж шийдвэрлэх,

Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст:

- Аудитын хүрээнд шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах талаар хамгаалуулагч байгууллагаас авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ, аудитын үр дүнгийн талаарх мэдээллийг бэлтгэж, Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх,

Эргүүл, хамгаалалтын газарт:

- ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр анги, хорих 409 дүгээр анги дахь онлайн шүүх хуралдааны танхимд шүүх хурал явагдах үеийн хамгаалалтыг тухайн байгууллагад шилжүүлэх асуудлыг холбогдох нэгжтэй хамтран шийдвэрлэх,

- Аудитаар илэрсэн бусад асуудал, аудитын үр дүнд суурилан гаргасан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр шүүх, цагдаагийн холбогдох байгууллага, нэгжтэй хамтран ажиллах.

Зөвлөмж хүлээн авсан алба, нэгж нь түүний хэрэгжилт, үр дүнгийн талаарх танилцуулгыг 2019 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст ирүүлнэ.

Хавсралт 1

**ШҮҮХИЙН БАЙР, ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТАНХИМ, ТЭДГЭЭРИЙН
ХАМГААЛАЛТАД АЖИЛЛАЖ БУЙ АЛБА ХААГЧДЫН СУДАЛГАА**

2019.05.06

Улаанбаатар хот

д/д	Шүүхийн байр	Хаяг	Танхимын тоо	Объектын хамгаалалт			Шүүх хуралдааны хамгаалалт	
				Хариуцсан байгууллага	Харуулын цагдаа/ харуулчин	Ээлж	Офицер	Цагдаа
1.	Улсын дээд шүүх	ЧД-ийн 1 дүгээр хороо, НЦГ-ын замын урд талд	3	ТТХГ	-	-	-	2
2.	Нийслэлийн давж заалдах шатны шүүх	ЧД-ийн 1 дүгээр хороо, Барилгачдын талбайн баруун талд	2	ЭХГ-ын ШШАБХХ	3	3 ээлж, 24/48	1	2
3.	Захиргааны хэргийн нэгдсэн шүүх	СБД-ийн 8 дугаар хороо, Их тойруу, Содномын гудамж, Дашчойлон хийдийн хойд талд	7	ЭХГ-ын ШШАБХХ	3	3 ээлж, 24/48	1	2
4.	БЗД, СБД, ЧД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	БЗД-ийн 2 дугаар хороо, КТМС-ийн ард талд	8	ЭХГ-ын ШШАБХХ	3	3 ээлж, 24/48	1	6
5.	СХД, ХУД, БГД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	СХД-ийн 17 дугаар хороо, 1 дүгээр хороолол, 34-р байрны урд талд	6	ЭХГ-ын ШШАБХХ	3	3 ээлж, 24/48	1	5
6.	БЗД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	БЗД-ийн 5 дугаар хороо, Монгол кино үйлдвэрийн байрны ард талд	5	ДЦ-ийн 805 дугаар анги	4	4 ээлж, 8/16	1	1
7.	СБД, ЧД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	СБД-ийн 4 дүгээр хороо, 1.1-р байр, СБДЦХ-1-ийн урд талд	9	ЭХГ-ын ШШАБХХ	3	3 ээлж, 24/48	1	2

8.	СБД, ЧД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Гэр бүлийн хэрэг маргаан шийдвэрлэх байр	СБД-ийн 4 дүгээр хороо, СБД, ЧД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн урд талд	3	ДЦ-ийн 805 дугаар анги	4	4 ээлж, 8/16	-	1
9.	БГД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	БГД-ийн 3 дугаар хороо, Темер зам дахь цагдаагийн хэлтсийн хойд талд	5	ЭХГ-ын ШШАБХХ	3	3 ээлж, 24/48	1	1
10.	СХД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	СХД-ийн 29 дүгээр хороо, АМГТХЭГ-ын зүүн талд	6	ДЦ-ийн 05 дугаар анги	4	4 ээлж, 8/16	-	1
11.	ХУД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	ХУД-ийн 3 дугаар хороо, ХУДЦХ-1-ийн урд талд	5	ЭХГ-ын ШШАБХХ	3	3 ээлж, 24/48	1	1
12.	ХУД, БГД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын байр	ХУД-ийн 3 дугаар хороо, Дүүргийн захиргааны зүүн урд талд	2	ЭХГ-ын ШШАБХХ	3	3 ээлж, 24/48	-	-
13.	Шүүхийн төрөлжсөн архив	СБД-ийн 8 дугаар хороо, Түшээ дээд сургуулийн 4-р давхарт	-	ЭХГ-ын ШШАБХХ	3	3 ээлж, 24/48	-	-
14.	Цагдан хорих 461 дүгээр ангийн онлайн хурлын танхим	БГД-ийн 20 дугаар хороо, ДЦС-IV-ийн урд талд	1	ШШГЕГ	-	-	-	1
15.	Хорих 409 дүгээр ангийн онлайн хурлын танхим	БЗД-ийн 11 дүгээр хороо, Ногоон зоорийн баруун талд	1	ШШГЕГ	-	-	-	1
Нийт			63	-	39	-	8	32

Хавсралт 2

**“ШҮҮХ, ШҮҮГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЖУРАМ”-Д ЗААСНЫ ДАГУУ
НИЙСЛЭЛ ДЭХ ШҮҮХ, ШҮҮХИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ**

2019.06.10

Улаанбаатар хот

Шүүхийн байр	Объектын хамгаалалтад ашиглагдах техник хэрэгсэл										ЦАХ-ийн тусгай хэрэгсэл										Шүүх хуралдааны танхим, өрөөний хамгаалалт											
	Телекамерын хяналт	Метал илрүүлэгч /канал/	Метал илрүүлэгч /гар/	Ачаа тээш шалгах рентген	Дээр	Тандагч	Үтэсн сүлжээ сарниулагч	Ачаа тээш түр халгах хайрцал	Цахим бүртгэгч /скайнер/	Энэрийн зүүлт	Хийн бүү	Бороохой	Гав	Станц	Дотуур холбоо	Хамгаалах хэрэгсэл	Энэрийн камер	Танхимын тоо	Хуралдааны танхимд	Шүүгчдийн өрөөнд	Түр саатуулах өрөөнд	Шүүгчдийн өрөөтэй давхарт чинтэй хаалга	Давхар хаалгатай танхим	Тусдаа хаалгатай танхим	Объектын нөөц хаалга	Шүүх бүрэлдэхүүнийн хаалт	Шүүгчдийн хаалт	Галын хор	Цонхны хаалт	Түр саатуулах өрөө	ЦАХ-ийн өрөө	
Улсын дээд шүүх											1	1	-	-	-	-	3	-	-	-	-	3	3	-	-	-	+	+	-	-		
Нийслэлийн давж заалдах шатны шүүх	19	1	1	-	-	-	-	24	1	-	1	1	1	+	+	1	2	-	-	-	-	1	2	-	-	+	+	-	-	1		
Захираганы хэргийн шүүхийн нэгдсэн байр	16	1	2	-	-	-	-	24	1	-	1	1	1	+	+	1	7	-	-	-	+	-	-	-	1	1	+	+	-	-	1	
БЗД, СБД, ЧД-ийн Эрүүгийн хэргийн АШШүүх	16	-	1	-	1	1	-	12	1	-	1	1	1	+	+	1	8	1	-	-	+	2	1	-	1	+	+	-	-	-	-	2
СХД, ХУД, БГД-ийн Эрүүгийн хэргийн АШШүүх	11	1	1	-	1	-	-	24	1	-	1	1	1	+	+	1	6	-	-	-	+	-	1	1	-	1	+	+	3	1	1	
БЗД-ийн Иргэний хэргийн АШШүүх	18	-	1	-	-	-	-	-	-	-	1	1	-	+	+	-	5	-	-	-	-	-	-	-	-	-	+	+	-	-	-	1

СБД, ЧД-ийн Иргэний хэргийн АШШүүх	9	-	-	-	-	-	-	-	-	12	1	-	1	1	1	1	+	+	1	-	+	+	-	-	-	-	-
БГД-ийн Иргэний хэргийн АШШүүх	4	-	-	-	-	-	-	1	1	1	1	-	1	1	1	+	+	+	-	1	-	+	-	-	-	-	-
СХД-ийн Иргэний хэргийн АШШүүх	31	-	-	-	-	-	-	-	1	1	-	-	1	1	+	-	+	+	-	1	-	+	-	-	-	-	1
ХУД-ийн Иргэний хэргийн АШШүүх	9	-	-	-	-	-	-	12	1	-	1	-	1	1	+	+	+	-	-	1	-	+	-	-	-	-	-
ХУД, БГД-ийн Иргэний хэргийн АШШ-ийн Тамгын байр	9	-	-	-	-	-	-	-	1	1	-	-	1	1	+	+	+	-	-	1	-	+	-	-	-	-	1
Шүүхийн төрөлжсөн архив	6	-	-	-	-	-	-	-	1	1	-	-	1	1	+	-	+	+	-	-	-	-	-	-	-	-	-

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас төрийн бусад байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангах үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудитын объект: Аудитад цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас төрийн бусад байгууллага, албан тушаалтанд хүргүүлж буй мэдээлэл

Аудитын төрөл, код: Үйл ажиллагааны аудит, ЦЕГ-ХШҮДАХ/ҮА-2019/08

Аудитын хугацаа: 2019.08.22- 2019.09.20

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх

1. ТАНИЛЦУУЛГА

Аудитын хүрээнд цуглуулсан мэдээллээс үзвэл цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгжээс хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг, даалгавар, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, биелэлт, тайлан, эрүү, хэв журмын нөхцөл байдал, гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ, эрүүгийн хэрэг, албаны шалгалтын танилцуулга зэрэг нийт 69 төрлийн мэдээ, мэдээлэл /Хавсралт 1/-ийг 38 төрийн болон бусад байгууллага, албан тушаалтанд /Хавсралт 2/ өдөр, 7 хоног, 14 хоног, сар, улирал, хагас, бүтэн жилийн давтамжтайгаар хүргүүлж байна.

Дээрх үйл ажиллагаа нь Цагдаагийн албаны, Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Аудитын, Шилэн дансны, Төсвийн, Нийгмийн даатгалын, Татварын, Авлигын эсрэг, Захиргааны ерөнхий, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулиуд, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар батлагдсан “Монгол Улсын ҮАБЗ-ийг мэдээллээр хангах журам”, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, ХЗДХС-ын 2017 оны А/189 дүгээр тушаалаар батлагдсан “ХЗДХС-ын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”, ЦЕГ-ын даргын 2017 оны А/100

дугаар тушаалаар батлагдсан “Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээ, Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад шалгагдсан эрүүгийн хэргийн хөдөлгөөн, шийдвэрлэлтийн мэдээг хүргүүлж танилцуулах байгууллага, албан тушаалтны жагсаалт” болон бусад байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн албан бичиг, үүрэг, албан даалгавар, зөвлөмж, шийдвэр, дээд шатны байгууллагын баталсан хөтөлбөр, төлөвлөгөө, тухайн байгууллагатай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 131, 134, 701, 702 дугаар код, холбогдох бусад эрх зүйн акт, баримт бичгээр зохицуулагдаж байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2019 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.7-д заасны дагуу цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас төрийн бусад байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангах үйл ажиллагаанд дотоод аудит хийж, удирдлагыг мэдээллээр хангах, аудитын объектыг боловсронгуй болгох, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хүргүүлж, үр дүнг тооцох нь дотоод аудитын зорилго юм.

2.2 Аудитын цар хүрээ

Аудитад холбогдох хууль тогтоомж, баримт бичигт заасны дагуу цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгжээс төрийн бусад байгууллага, албан тушаалтанд тогтмол хүргүүлж буй мэдээллийг хамруулсан болно.

Ингэхдээ тухайн мэдээллийг хүргүүлэх хууль зүйн үндэслэл, давтамж, мэдээллийн агуулга, хэлбэр, нууцлал, найдвартай, иж бүрэн байдал, хэрэгцээ шаардлагад дүн шинжилгээ хийнэ.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ маягт боловсруулж, цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгжээс төрийн бусад байгууллага, албан тушаалтанд хүргүүлж буй мэдээллийн нэр, агуулга, давтамж, эрх зүйн үндэслэлийн талаарх мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийсэн.

Дээрх мэдээллийг боловсруулж, хүргүүлдэг цагдаагийн нэгж, алба хаагчид, түүнийг хүлээн авч ашигладаг, нэгтгэн, үнэлдэг төрийн бусад байгууллагын холбогдох ажилтнуудтай биечилсэн байдлаар болон утсаар ярилцлага хийж, аудитын зорилгод нийцүүлэн мэдээлэл авч ашигласан.

Аудитын явцад цугларсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан “Урьдчилсан тайлан”-г бичиж, холбогдох нэгжүүдэд хүргүүлэн “Удирдлагын тайлбар”-ыг авч энэхүү тайланд тусгасан.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгжээс хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг, даалгавар, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, биелэлт, тайлан, эрүү, хэв журмын нөхцөл байдал, гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ, эрүүгийн хэрэг, албаны шалгалтын танилцуулга зэрэг нийт 69 төрлийн мэдээ, мэдээллийг 38 төрийн болон бусад байгууллага, албан тушаалтанд тодорхой давтамжтайгаар хүргүүлж байна.

Хэдийгээр дээрх мэдээллүүд нь цаасан суурьтай архивын нэгж болж, тодорхой хугацааны дараа Төв архивт татагдан хадгалагдаж байгаа ч тухайн нэгж дээрээ цахим архив, сан үүсгэж, дээрх мэдээллүүдийг дүн шинжилгээ, хяналт шалгалт, дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх болон бусад зорилгоор дахин ашиглахад шуурхай, хялбар байлгахад анхаарах шаардлагатай байна.

3.2 Аудитын явцад цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгжээс мэдээлэл хүлээн авч ашигладаг зарим төрийн байгууллага, ажилтнуудаас тусгайлан гаргасан дараах санал, хүсэлтийг аудитын тайланд тусгаж, үйл ажиллагаандаа анхаарах нь зүйтэй гэж үзлээ. Тухайлбал;

- **Хууль зүй, дотоод хэргийн яам:** Цагдаагийн байгууллагаас хүргүүлж буй мэдээлэлтэй холбогдуулан тус яам нь дотоод нэгжүүдээсээ санал авах ажлыг зохион байгуулж, дараах зөвлөмжийг ирүүлсэн:

1. Алба хаагчтай холбоотой, эсхүл ноцтой гэмт хэргийн шийдвэрлэлтэд анхаарч, прокурор, шүүхийн байгууллагаас уг хэргийг хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдээлэл авч, ирүүлж байх,
2. Засгийн газрын тогтоол, Сайдын тушаал гаргаж шийдвэрлүүлэхээр ирүүлж буй асуудлын хууль зүй, техник, эдийн засгийн судалгааг бүрэн хийж, шийдвэр гаргах боломж, процессын хугацааг тооцоолох,
3. Төрийн албаны хууль тогтоомжийн шинэчлэл, төрийн байгууллагын ажлын үр дүн, чанарыг сайжруулахын тулд байгууллагын зорилго, зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг хэрэгжихүйц, хэмжигдэхүйц, бодитой, үр дүнд чиглэсэн байдлаар тодорхойлоход анхаарч, тайлан, биелэлтийг үр дүнг дүгнэж болохуйц байдлаар ирүүлэх.

- **Хүний эрхийн үндэсний комиссын Ажлын албаны дарга**

██████████: “Цагдаагийн байгууллагатай хамтын ажиллагаа маань үр дүнтэй байгаа. Цаашид хамтын ажиллагааныхаа агуулга, хэлбэр, үр дүнг зөвхөн оны эцэст биш явцын дунд уулзаж хэлэлцдэг байх хүсэлтэй байна. Мөн ЦДЦСНТ-тэй хамтран 2017 онд бэлтгэсэн хүний эрхийн 56 сургагч багшийг нэгж дээрх хүний эрхийн сургалтдаа идэвхитэй ашиглана уу”.

- Улсын онцгой комиссын Ажлын албаны ахлах мэргэжилтэн

██████████: “Улсын онцгой комиссын 2018 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг танай байгууллагаас хугацаанд нь, дэлгэрэнгүй гаргаж өгдөг. Харин голомтын бүсэд ажилласан цагдаагийн алба хаагчдын талаарх мэдээлэл, баримтыг тухайн орон нутгийн Онцгой байдлын албанд гаргаж өгөх ажил жигд бус байгаагаас Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсэгт заасан томилолтын зардлыг танай алба хаагчид авч чадахгүй байна. Бусад төрийн байгууллагад энэ ажил нь жигдэрчихсэн, алба хаагчид нь орон нутгийн төсвөөс холбогдох нэмэгдэл, урамшууллаа тогтмол авдаг”.

- Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөлийн Нарийн бичгийн дарга

██████████: “Терроризмийн эрсдэлийн үнэлгээг гаргахад цагдаагийн байгууллагаас өгч буй мэдээлэл нь гол эх сурвалж болдог бөгөөд тус Зөвлөлтэй хамгийн идэвхитэй хамтран ажилладаг байгууллага юм. Саяхан Терроризмтой тэмцэх тухай хууль /хуучин нэршлээр/ шинэчлэн батлагдсантай холбогдуулан тус Зөвлөлийн чиг үүрэг, эрх хэмжээ, татан авах мэдээллийн цар хүрээ өргөжсөнийг судалж, үйл ажиллагаандаа тусгахыг зөвлөж байна”.

- Үндэсний статистикийн хорооны ажилтан

██████████: “Цагдаагийн байгууллагатай хамтран баталсан маягтын дагуу мэдээллээ авдаг тул асуудал хүндрэл багатай. НҮБ-аас гаргадаг гэмт хэргийн чиг хандлагын судалгаа, хар тамхи, мансууруулах бодистой холбоотой судалгаа гэсэн 2 чухал судалгаа байдаг. Эдгээр судалгааны дийлэнх мэдээлэл нь цагдаагийн байгууллагаас гардаг тул энэ чиглэлээрх статистик мэдээлэл, бүртгэл, судалгааны ажлаа идэвхижүүлэхийг зөвлөж байна”.

- Архивын ерөнхий газрын ажилтан ██████████: “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийн биелэлтийг танай байгууллагаас сар бүр өссөн дүнгээр хүлээн авч байгаа. Тухайн сард зарим чиглэлээр ажил гүйцэтгээгүй байсан ч хэрэгжилтийг 4 маягтын дагуу сар бүр гаргаж ирүүлэхэд анхаарч ажиллахыг зөвлөж байна”.

3.3 Монгол Улсад суугаа гадаад орны Элчин сайдын яамдуудаас зарим иргэний гэмт хэрэг, зөрчилд холбогдсон эсэх лавлагаа, жолооны үнэмлэхний зурагтай лавлагааг Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэст албан бичгээр хандан авч байна. Дээрх хүсэлтийг тус хэлтсээс МДШШУА-ны Статистик мэдээллийн хэлтсийн Лавлагааны сан, Бүртгэл хяналтын төвд албан бичгээр хүргүүлэн, хариуг авч, холбогдох Элчин сайдын яамдад хүргүүлж байгаа нь үйл ажиллагааны олон шат дамжлагыг бий болгон, ачаалал үүсгэж байна.

3.4 Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл

ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу 2017 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас "Ухаалаг засаглал" ТББ-аар "Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим сан"-г бүтээлгэн, яамд, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ашиглаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/40 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгээс уг санг цагдаагийн байгууллагад бий болгох асуудлыг судалж, 28.8 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай тухай танилцуулжээ.

Байгууллагын үйл ажиллагаанд олон эерэг үр дүн авчрах уг програмыг санхүүжилт шийдэгдэх эсэхийг хүлээлгүйгээр Мэдээллийн технологи, холбооны төвөөс хөгжүүлэх нөөц боломж бий эсэхийг судалж үзэх нь зүйтэй байна.

4. ДҮГНЭЛТ

Цагдаагийн байгууллага нь хууль тогтоомжийн дагуу нийгмийн өргөн цар хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг байгууллага болохын хувьд бүх шатны төрийн байгууллага, албан тушаалтан, иргэд, олон нийтийг үйл ажиллагааныхаа явцад үүссэн мэдээллээр ханган ажиллаж байна.

Энэхүү аудитад тодорхой цаг хугацаанд, давтамжтай хүргүүлж буй мэдээллийг хамруулсан бөгөөд нийт 69 төрлийн мэдээллийг 38 төрийн болон бусад байгууллага, албан тушаалтанд хүргүүлж байгаагаас Хууль зүй дотоод хэргийн яаманд 31, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд 5, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 4 төрлийн мэдээлэл хүргүүлж байгаа нь хамгийн өндөр давтамжтай байлаа.

Цагдаагийн байгууллагаас гадагш урсгалтай мэдээллийг анх удаа нэгтгэн дүн шинжилгээ хийх, тэдгээрийг хэрэглэгч байгууллагуудын санал, шүүмж, байр суурийг тандан судлах оролдлого хийж, цаг хугацааны хувьд оны эцсийн тайлан, биелэлт гаргах ажлын өмнө хийгдсэн нь энэхүү аудитын ач холбогдлыг илэрхийлж байна.

Цагдаагийн байгууллагаас мэдээлэл хүлээн авагч байгууллага, холбогдох ажилтнууд нь тухайн мэдээллийн агуулга, хэлбэр, ач холбогдолд нийтлэг сэтгэл хангалуун байдаг нь аудитын явцад ажиглагдсан.

Цаашид төрийн бусад байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангаж буй цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгж бүр боловсруулж буй мэдээллийн агуулга, хэлбэр, давтамж, ач холбогдлын талаар хүлээн авагч байгууллага, холбогдох ажилтантай байнга, нээлттэй харилцаж, холбогдох хууль тогтоомж, баримт бичгийн хүрээнд тогтмол өөрчлөлт, сайжруулалт хийж, үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай нь харагдаж байна.

5. ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, аудитын үр дүн, холбогдох нэгжүүдээс ирүүлсэн “Удирдлагын тайлбар”-г үндэслэн цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгжээс төрийн бусад байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангах, түүнд холбогдох бусад үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор дараах саналыг танилцуулж байна. Үүнд:

5.1 Төрийн байгууллагын үйл ажиллагааг цахимжуулж, ухаалаг болгох төрийн бодлогод нийцүүлэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг шуурхай, хялбар болгож, зардлыг бууруулах зорилгоор “Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим сан”-г нэвтрүүлэхэд шаардлагатай 28.8 сая төгрөгийг ирэх оны төсвийн санхүүжилтээр шийдвэрлэх,

5.2 Аудитаар илэрсэн асуудал болон дээр дурдсан саналыг шийдвэрлэх зорилгоор дараах зөвлөмжийг холбогдох нэгжүүдэд хүргүүлэх саналтай байгааг тус тус илтгэн танилцуулж байна. Үүнд:

Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст:

- “Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим сан”-г цагдаагийн байгууллагад нэвтрүүлэх ажлыг Санхүү, аж ахуйн албатай хамтран зохион байгуулах,

Цагдаа, дотоодын цэргийн нийт байгууллага, нэгжид:

- Төрийн бусад байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангаж буй цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгж бүр боловсруулж буй мэдээллийн агуулга, хэлбэр, давтамж, ач холбогдлын талаар хүлээн авагч байгууллага, холбогдох ажилтантай байнга, нээлттэй харилцаж, холбогдох хууль тогтоомж, баримт бичгийн хүрээнд тогтмол өөрчлөлт, сайжруулалт хийж хэвших,

- Хэдийгээр цаасан суурьтай баримт нь архивлагдан хадгалагдаж байгаа ч цахим мэдээллийн сан нь тухайн мэдээллийг хялбар, шуурхай байдлаар дахин ашиглах боломжийг бүрдүүлж байдаг.

- Гэвч тодорхой алба хаагчийн шилжилт хөдөлгөөн, техник хэрэгслийн саатлаас шалтгаалан байгууллага, нэгжийн цахим мэдээлэл устах эрсдэлтэй байна. Иймд нэгж бүр өөрийн үйл ажиллагааны явцад үүссэн шаардлагатай мэдээллээр нэгдсэн цахим санг зохих нууцлал, эмх цэгцтэй, найдвартай, иж бүрэн байх шалгуурыг хангахуйц байдлаар бий болгож, үйл ажиллагаандаа ашиглах,

- Гамшгийн бүсэд ажилласан цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдад Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу зохих нэмэгдлийг олгуулахад шаардлагатай мэдээлэл, баримтыг тухай бүр холбогдох байгууллагад гарган өгч, хамтран ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг тухайн нэгжид хэрэгжүүлж буй эсэхийг Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсээс хяналт шалгалт, дотоод аудит, сургалт, уулзалт ярилцлага, албан томилолтын хүрээнд газар дээр нь танилцах байдлаар үр дүнг тооцож үнэлнэ.

6. УДИРДЛАГЫН ТАЙЛБАР

Аудитын урьдчилсан тайлантай холбогдуулан Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсээс 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн ТЗБХ/174, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 8/2145 дугаарын албан бичгээр тус тус “Удирдлагын тайлбар” ирүүлснийг энэхүү тайланд хавсаргав. Дээрх нэгжүүдээс ирүүлсэн тайлбарт:

- Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 2017 онд “Ухаалаг засаглал” төрийн бус байгууллагад захиалж хийлгэн, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн “Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим сан”-г цагдаагийн байгууллагад нэвтрүүлэх нь илүү үр дүнтэй, түүнийг худалдан авахад шаардлагатай 28.8 сая төгрөгийг шийдвэрлэх нь байгууллагын төсөвт ачаалал үүсгэхгүй тухай,

- “Гадаадын байгууллага, иргэнтэй харилцах /Код 131/ журам”-ын 131.5.8-д “Цагдаагийн албаны тухай хуулийн 61.4-т заасны дагуу цагдаагийн байгууллагын тоо бүртгэл, мэдээллийн сангаас гадаадын байгууллагад мэдээлэл өгөх тохиолдолд цагдаагийн төв байгууллагын Гадаад харилцааны ажил хариуцсан нэгжээр дамжуулан хүсэлт тавьсан олон улсын болон гадаад улсын цагдаагийн байгууллага, дипломат төлөөлөгчийн газарт хүргүүлнэ” гэж заасан тул дээрх мэдээлэл /лавлагаа/-ийг тухайн нэгжээс шууд олгох боломжгүй тухай тус тус дурджээ.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

Хавсралт 1

**ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН АНГИ, БАЙГУУЛЛАГААС ТӨРИЙН БУСАД
БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХҮРГҮҮЛЖ БУЙ МЭДЭЭЛЭЛ**

2019.10.25

Улаанбаатар хот

д/д	Харуцсан ж/ж	Мэдээллийн		Ерөнхий агуулга	Хүрүүлэх давтамж	Хүрүүлэх эрх зүйн үндэслэл	Хүлээн авагч байгууллага, албан тушаалтан
		Нэр	Мэдээллийг				
1	Харуцсан ж/ж Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс	Засгийн газрын тогтоол /34/, түүгээр батлагдсан төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөний /16/ хэрэгжилт	Нэр	Ерөнхий агуулга	Хүрүүлэх давтамж	Хүрүүлэх эрх зүйн үндэслэл	Хүлээн авагч байгууллага, албан тушаалтан
2		МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн Өмнөлт					
3		ҮАБЗ-ийн зөвлөмжийн хэрэгжилт /3/					
4		УИХ, байнгын хорооны тогтоолын хэрэгжилт /6/					
5		ЗГ-ын албан даалгавар /3/, хуралдааны тэмдэглэл /13/, Ерөнхий сайдын захирамжийн /2/ хэрэгжилт					
6		Ерөнхийлөгчийн зарлигийн хэрэгжилт /2/					
7		МХЕГ-ын даргын 2019 оны 01/37 дугаар удирдамж					
8		Улсын онцгой комиссын 2018 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилт					
9		НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийн хэрэгжилт					
10		ЦЕГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө, ЦДБ-ын үйл ажиллагааны тайлан					
11		ЦБ-ын тухайн онд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан					
12		Хэргийн танилцуулга					
13		Дээд байгууллагаас шилжүүлж ирүүлсэн өргөдөл гомдол, санал, хүсэлтийн мэдээ					
14		Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн мэдээ					
15		ХЭУК, ЦЕГ-ын хооронд байгуулсан хамтран ажиллах Санамж бичгийн хэрэгжилт					
				Баримт бичгийн хүрээнд цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, тэдгээрийн үр дүн	Тухайн баримт бичгийн төрлөөс хамаарч улирал, хагас, бүтэн жилээр хүргүүлдэг	Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журам, ХЗДХС-ын 2017 оны А/189 дүгээр тушаалаар батлагдсан аргачлал, ХЗДХЯ, МУГХУСАЗЗ, ХХМТГ, УХГ-аас ирүүлсэн албан бичиг, ЗГХЭГ-аас өгсөн үүрэг	Хүлээн авагч байгууллага, албан тушаалтан
			Хяналтанд авсан баримт бичгийн хэрэгжилт, үр дүн	Тухай бүр			ХЗДХЯ
			Мөрдөн шалгах ажиллагааны явцын мэдээлэл	Улирал бүр			ХЗДХЯ
			Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн мэдээ	Жил бүр			ХЗҮК

Албан хэрэгцээнд

16	Хүний нөөцийн хэлтэс	Хүний нөөцийн хөдөлгөөний тайлан	ЦАХ-ийн ажилласан жил, хөдөлгөөний мэдээлэл	Хагас, бүтэн жил	Төрийн албаны зөвлөл
17		Төрийн албаны салбар зөвлөлийн тайлан	ЦЕГ-ын дэргэдэх ТАСЗ-ийн ажлын тайлан	Хагас, бүтэн жил	
18	Хүний нөөцийн хэлтэс	Хөгжлийн баршээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	ХЭДХА-ны төлөвлөгөө 2019.05.27	Улирал бүр	ХЭДХА
19		ХЭДХС-ын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын жөндөрийн нэгдсэн бодлогын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	ЦДЦБ-ын жөндөрийн нэгдсэн бодлогын төлөвлөгөөний биелэлт	Жил бүр	
20	Хүх	Захирагааны хэм хэмжээний актыг хэрэгжилт	ЦЕГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээнд үйлчилж байгаа эхх-ний актыг хэрэгжилт	Жил бүр	Захирагааны ерөнхий хуулийн 69.1 хэсэг
21	СГАСХ	ОХУ-ын ДХЯ-ны харьяа академи, их, дээд сургууль, БНТУ-ын Цагдаагийн академид элсэн суралцагчдын материал		Жил бүр	ХЭДХС-ын 2018 оны А/77 дугаар тушаалаар батлагдсан "Гадаадын их, дээд сургуульд суралцагчдыг сонгон шалгаруулах, суралцуулах журам"
22		Эрх зүйн сургалт, сурталчилгааны төлөвлөгөөний биелэлт		Хагас, бүтэн жилд	ХЭДХЯ-ны эрх зүйн сургалт сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөө
23	ГХАХ	МУ-ын иргэд болон гадаадын иргэд тус улсад амьдарч байх хугацаанд эрүүгийн хэрэг, захирагааны зөрчилд холбогдож байсан эсэх лавлагаа /95/			ГХЯ, ЭСЯ
24		ЦАХ-чид гадаад улсад зорчихор виз мэдүүлэх үед ЭСЯ-дад тодорхойлолт гаргах /178/		Тухай бүр	
25		ЦАХ-чид гадаадад албан ажил, томилолт, сургалт, уралдаан тэмцээнд оролцох үед холбогдох материалыг хүрүүлэх			
26		Дипломат болон албан паспорт			ХЭДХЯ-аар дамжуулан ГХЯ-нд
27	ХШДХА	ЦАХ-тай холбоотой ирсэн өргөдөл, гомдлыг шалгасан тухай албаны шалгалтын танилцуулга		Тухай бүр	ХЭДХА
28		ЦДЦБ-ын дотоод аудитын жилийн төлөвлөгөө, түүний биелэлт		Хагас, бүтэн жилд	
29		ЦДЦБ-ын эрсдэлийн үнэлгээний тайлан		Жил бүр	

30	ХШДХА	Шилэн данс, ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын тайлан	Улирал бүр	ШДТХууль	ХЗДХА
31		УАГ-аас өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын тайлан	Хагас, бүтэн жилд	ЗГ-ын тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрэм	ХЗДХА, УАГ
32	Аюулгүй байдлын хэлтэс	Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Хагас, бүтэн жилд	ХЗДХА-ны 2019.09.20-ны өдрийн 1-1/4211 албан бичиг	ХЗДХА
33		Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн биелэлт	Жил бүр	ЗГ-ын 2017 оны 114 дүгээр тогтоолын 3 дахь заалт	АТГ
34		ЦАХ-ийн хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг	Жил бүр	АЭХ-ийн 11.3, АТГ-ын 91 дүгээр тушаал	
35		Захирааны хяналтын мэдээ	Сар бүр	ГХУСТХ-ийн 15 зүйл, Хорих ял эдлээд суллагдсан зарим хүнд захиргааны хяналт тогтоох /Код 601/ журам	УЕПГ-ын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтэс
36	НХХЖОНАБХА	Агаарын чанарын бүсэд хяналт шалгалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын мэдээ	Сар бүр	БОАЖС, НЭД-ын хамтарсан 2019.08.14-ний А/433, А/820 тушаал, захирамж	Орчны Бохирдлыг бууруулах үндэсний хороо
37		Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажлын тайлан, мэдээ	Хагас, бүтэн жилд	ХЗДХС, ШЕЗ-ийн даргын хамтарсан А/40, А/113 тушаал	Шүүхийн ерөнхий зөвлөл
38		Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажлын тайлан, мэдээ	Сар бүр	Яллагдлагчийг хуяглан хүргэх, албадан ирүүлэх... жуурын 4.20	Шүүхийн 9 байрны Тамгын газрын дарга нар
39		УАБ-ыг хангах тусгайлан чиг үүрэгтэй байгууллагын хамтран ажиллах төлөвлөгөөний биелэлт	Хагас, бүтэн жилд	Төлөвлөгөө	УАБ3АА
40		Цагдаагийн байгууллагын 2019 оны терроризмоос сэргийлэх ажлын төлөвлөгөөний биелэлт	Хагас, бүтэн жилд	ЗГ-ын 2010 оны 40 тогтоолын 2, ЦЕГ-ын 2019 оны г/төл-ний 2.1.9 дэх заалт	ТТА33

Албан хэрэгцээнд

41	Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн 7 хоногийн тойм мэдээ	7 хоног тутам	МУ-ын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлиг, УАБЗ-ийг мэдээлгээр хангах / Код 134/ журам	ЕТГ, ХЗДХС, УАБЗ-ийн нбд, Е/сайд
42	Инфографик мэдээ	Сар бүр	ЦБ-аас хэрэгжүүлсэн ажил, үйлчилгээний тухай	ХЗДХЯ-ны ТЗУГ
43	Танилцуулах мэдээ	Сар бүр	МУ-ын дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлээр ЦБ-аас хийсэн ажлын тайлан	УАБЗ-ийн нбд
44	УАБЗ-өөс боловсруулсан програмын дагуу хоногийн эрүү, хэв журмын хоногийн нөхцөл байдлын мэдээлэл	Өдөр бүр	УАБЗ-өөс боловсруулсан програмын дагуу хоногийн эрүү, хэв журмын хоногийн нөхцөл байдлын мэдээлэл	УАБЗ
45	Улсын хэмжээнд, хонотт үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, төрөл, хүн амины санаагай болон, онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэргийн тухай	Өдөр бүр	Улсын хэмжээнд, хонотт үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, төрөл, хүн амины санаагай болон, онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэргийн тухай	УАБЗ, УИХ-ын ТТ, ЕТГ, ЗТХЭГ, ХЗДХЯ-нд цаасаар, УЕПГ, ТЕГ, ТТХГ-г цахимаар
46	Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ	Сар бүр	Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ	ҮСХ болон төрийн байгууллагуудад цахимаар болон батлагдсан маягтын дагуу
47	ЦДЦАБ-ын худалдан авах ажиллагааны ерөнхий тайлан	Хагас, бүтэн жилд	Хөрөнгө оруулалт, урсгал төсөв, орон нутгийн төсөв, сан, бусад санхүүжилтээр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл	ХЗДХЯ
48	Эх оронч худалдан авалтын жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	Хагас, бүтэн жилд	Дотоодын зах зээлээс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл	ХЗДХЯ, Үндэсний аж үйлдвэрийн бодлогын зөвлөл
49	Төсвийн хязгаарт хүргүүлэх санал	6 сарын 10-ны дотор	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан жилийн төсвийн хязгаарын санал	Төсвийн тухай хуулийн 8.3.1
50	Төсвийн төсөл	8 сарын 01-ний дотор	2020 оны төсвийн төсөл, 2021-2022 оны төсвийн төсөвлөл	Төсвийн тухай хуулийн 8.4.2
51	ЦЕГ-ын нэгтгэсэн санхүүгийн тайлан	Хагас, бүтэн жилд	Хөрөнгө, авлага, өр төлбөр, зэний өмчийн талаарх мэдээлэл	Төсвийн тухай хуулийн 8.9.2

МАШУА

Санхүү, аж ахуйн алба

52	Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн зөрчлийн мэдээ		7 хоног тутам	Тээврийн Прокурорын газар, Дүүргийн ПГ УБТЗ, ИНЭГ.	Тээврийн Прокурорын газар, Дүүргийн ПГ УБТЗ, ИНЭГ.
53	Ажлын тайлан мэдээ /Гэрээг цагдаагийн газар, тасаг/		Сар, улиралд	Хамтран ажиллах гэрээ	Эрдэнэс Монгол ХХК, Гашуун сухайт авто зам ХХК
54	Хариуцсан нутаг дэвсгэрт гарсан зам тээврийн ослын нөхцөл байдлын танилцуулга		14 хоног тутам		Дүүргийн ЭДТГ
55	Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах ялаар шийтгэгдсэн ялгнүүдын судалгаа		Сар бүр		Нийслэлийн ШШТГ
56	ТЦА-ны хоногийн нөхцөл байдлын мэдээ, үйлдэгдсэн зам тээврийн ослын шалтгаан нөхцөл, сэрэмжлүүлэг мэдээ		Өдөр бүр	Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний салбар төлөвлөгөө	Нийслэлийн ЭДТГ, иргэд, олон нийт
57	Үүргийн биелэлт	НЭД-ын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг, даалгавар	14 хоног тутам	ЦАТХ 16.2, МУЗЭНДНТУТХ 29.1.6	НЭДТГ
58	Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын танилцуулга	НЭД-ын шуурхай зөвлөгөөн дээрх ЦБ-д холбогдох заалтуудын биелэлт	Улирал бүр	ЦАТХ 15.2	
59	НИТХ, ЭД-ын захирамж, тогтоол, албан даалгаврын биелэлт		Хагас, бүтэн жилд		Иргэний зөвлөл
60	Байгууллагын үйл ажиллагааны тайлан	ЦБ-ын ү/а-ны тайлан	14 хоног тутам		Дүүргийн ЭДТГ
61	Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын мэдээ	Хариуцсан нутаг дэвсгэрт үйлдэгдсэн	Сар бүр	ГХУСТХ 16.3.5	
62		Хоногийн хугацаанд үйлдэгдсэн	Өдөр бүр		
63					
64	Захираганы хяналтад байгаа этгээдийн хүснэгтэн мэдээ		Сар бүр	Эрүүгийн хууль 6.12, 6.13, ГХУСТХ 15.зүйл	Дүүргийн Прокурорын газар
65	"Төрийн архив, албан хэрэг хөтөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилт	Цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлж байгаа ажлын дүн мэдээ	Сар бүр	3Г-ын 2006 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан хөтөлбөр	Архивын ерөнхий газар
66	Төрийн архивын болон хөмрөг үүсгэгч байгууллагуудын баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалтын мэдээ		Жил бүр	АЕГ-ын даргын 2018 оны А/97 тушаал "Архивын баримтад улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх журам"	

67	Эрүү, хэв журмын нөхцөл байдлын мэдээ	Сар бүр	ЦАТХ 16.2	Аймгийн ИТХ, ЗДТГ
68	Хоногийн нөхцөл байдлын мэдээ	Өдөр бүр		УАГ, Татвар, нийгмийн даатгал, санхүүгийн хэлтэс
69	Аудит, татвар, нийгмийн даатгалын тайлан, төсвийн гүйцэтгэл	Сар бүр		

---000---

Хавсралт 2

**ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН АНГИ, БАЙГУУЛЛАГААС
ТӨРИЙН БУСАД БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД
ХҮРГҮҮЛЖ БУЙ МЭДЭЭЛЭЛ**

2019.10.25

Улаанбаатар хот

1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл:

- Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт / хагас, бүтэн жил/

- Гэмт хэрэг, зөрчлийн 7 хоногийн мэдээ

- Сар бүрийн танилцуулах мэдээ

- Эрүү, хэв журмын нөхцөл байдлын хоногийн мэдээ /програм/

- Улсын хэмжээнд хоногт үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, төрөл, хүн амины санаатай болон онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэргийн тухай /өдөр бүр/

2. Ерөнхийлөгчийн тамгын газар:

- Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн 7 хоногийн тойм мэдээ

- Улсын хэмжээнд хоногт үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, төрөл, хүн амины санаатай болон, онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэргийн тухай

3. Улсын их хурлын Тамгын газар:

- Улсын хэмжээнд хоногт үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, төрөл, хүн амины санаатай болон, онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэргийн тухай

4. Засгийн газрын хэрэг эрхлэх газар:

- ҮАБЗ-ийн 2014 оны 25/16 дугаар зөвлөмжийн хэрэгжилт

- Засгийн газрын 2019 оны 91 дүгээр тогтоолын хэрэгжилт

- Улсын хэмжээнд хоногт үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, төрөл, хүн амины санаатай болон, онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэргийн тухай

5. Шүүхийн ерөнхий зөвлөл:

- Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажлын тайлан, мэдээ / хагас, бүтэн жил/

6. Улсын ерөнхий прокурорын газар:

- Захиргааны хяналтын мэдээ /сар бүр/

- Улсын хэмжээнд хоногт үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, төрөл, хүн амины санаатай болон, онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэргийн тухай

7. Тээврийн прокурорын газар:

- Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн зөрчлийн мэдээ

8. Дүүргийн прокурорын газар:

- Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн зөрчлийн мэдээ /7 хоног тутам/

- Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын мэдээ / өдөр, сар бүр/

- Захиргааны хяналтад байгаа этгээдийн хүснэгтэн мэдээ /сар бүр материалаар/

9. Хууль зүй, дотоод хэргийн яам:

- Засгийн газрын тогтоол /34/, түүгээр батлагдсан төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөний /16/ хэрэгжилт

- МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт

- ҮАБЗ-ийн зөвлөмжийн хэрэгжилт /3/

- УИХ, байнгын хорооны тогтоолын хэрэгжилт /6/

- ЗГ-ын албан даалгавар /3/, хуралдааны тэмдэглэл /13/, Ерөнхий сайдын захирамжийн /2/ хэрэгжилт

- Ерөнхийлөгчийн зарлигийн хэрэгжилт /2/

- НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийн хэрэгжилт

- ЦЕГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө, ЦДЦБ-ын үйл ажиллагааны тайлан

- ЦБ-ын тухайн онд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан

- Хэргийн танилцуулга

- Дээд байгууллагаас шилжүүлж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн мэдээ

- Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн мэдээ

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх

2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

- ХЗДХС-ын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын жендэрийн нэгдсэн бодлогын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

- Захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилт

- ОХУ-ын ДХЯ-ны харьяа академи, их, дээд сургууль, БНТУ-ын Цагдаагийн академид элсэн суралцагчдын материал

- Эрх зүйн сургалт, сурталчилгааны төлөвлөгөөний биелэлт

- ЦАХ-чид гадаадад албан ажил, томилолт, сургалт, уралдаан тэмцээнд оролцох үед холбогдох материалыг хүргүүлэх

- Дипломат болон албан паспорт

- ЦАХ-тай холбоотой ирсэн өргөдөл, гомдлыг шалгасан тухай албаны шалгалтын танилцуулга

- ЦДЦБ-ын дотоод аудитын жилийн төлөвлөгөө, түүний биелэлт

- ЦДЦБ-ын эрсдэлийн үнэлгээний тайлан

- Шилэн данс, ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын тайлан

- УАГ-аас өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын тайлан
- Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- Инфографик мэдээ /сар бүр/
- ЦДЦАБ-ын худалдан авах ажиллагааны ерөнхий тайлан
- Эх оронч худалдан авалтын жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө
- Төсвийн хязгаарт хүргүүлэх санал
- Төсвийн төсөл
- ЦЕГ-ын нэгтгэсэн санхүүгийн тайлан

10. Эрүүл мэндийн яам:

- Сэтгэцийн эрүүл мэнд үндэсний 2 дахь хөтөлбөрийн хэрэгжилт

11. Байгаль орчин, аялал, жуулчлалын яам:

- Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолын хэрэгжилт

12. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам:

- Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт

13. Гадаад хэргийн яам:

- МУ-ын иргэд болон гадаадын иргэд тус улсад амьдарч байх хугацаанд эрүүгийн хэрэг, захиргааны зөрчилд холбогдож байсан эсэх лавлагаа
- ЦАХ-чид гадаадад албан ажил, томилолт, сургалт, уралдаан тэмцээнд оролцох үед холбогдох материалыг хүргүүлэх

14. Тагнуулын ерөнхий газар:

- Улсын хэмжээнд хоногт үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, төрөл, хүн амины санаатай болон, онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэргийн тухай

15. Төрийн тусгай хамгаалалтын газар:

- Улсын хэмжээнд хоногт үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, төрөл, хүн амины санаатай болон, онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэргийн тухай

16. Онцгой байдлын ерөнхий газар:

- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын хэрэгжилт

17. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар:

- МХЕГ-ын даргын 2019 оны 01/37 дугаар удирдамжийн хэрэгжилт

18. Иргэний нисэхийн ерөнхий газар:

- Засгийн газрын 2010 оны 289 дүгээр тогтоолын хэрэгжилт

19. Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газар:

- “Төрөөс мэдээлэл, харилцаа, холбооны талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хамаарах зорилт, арга хэмжээний тайлан

20. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар:

1. МХЕГ-ын даргын 2019 оны 01/37 дугаар удирдамжийн хэрэгжилт

21. Авилгатай тэмцэх газар:

- Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн биелэлт
- ЦАХ-ийн хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг

22. Үндэсний аудитын газар:

- ҮАГ-аас өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын тайлан
- Аудит, татвар, нийгмийн даатгалын тайлан, төсвийн гүйцэтгэл /сар бүр/

23. Архивын ерөнхий газар:

- “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт /сар бүр/
- Төрийн архивын болон хөмрөг үүсгэгч байгууллагуудын баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалтын мэдээ /жил бүр/

24. МУГХУСАЗЗөвлөл:

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

25. Төрийн албаны зөвлөл:

- Хүний нөөцийн хөдөлгөөний тайлан
- Төрийн албаны салбар зөвлөлийн тайлан

26. Хүний эрхийн үндэсний комисс:

- Хамтран ажиллах санамж бичгийн хэрэгжилт

27. Улсын онцгой комисс:

- УОК-ын 2018 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилт

28. Терроризмтой тэмцэх ажлыг зохицуулах зөвлөл:

- Цагдаагийн байгууллагын 2019 оны терроризмоос сэргийлэх ажлын төлөвлөгөөний биелэлт

29. Үндэсний аж үйлдвэрийн бодлогын зөвлөл:

- Эх оронч худалдан авалтын жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

30. Үндэсний статистикийн хороо:

- Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ /сар бүр/

31. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо:

- Агаарын чанарын бүсэд хяналт шалгалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын мэдээ /сар бүр/

32. Нийслэлийн ШШГГ:

- Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах ялаар шийтгэгдсэн ялтнуудын судалгаа /сар бүр/

33. Нийслэлийн ЗДТГ:

- ТЦА-ны хоногийн нөхцөл байдлын мэдээ, үйлдэгдсэн зам тээврийн ослын шалтгаан нөхцөл, сэрэмжлүүлэг мэдээ

- НЗД-ын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг, даалгаврын биелэлт /14 хоног тутам/

- Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын танилцуулга /14 хоног тутам/

- НИТХ, ЗД-ын захирамж, тогтоол, албан даалгаврын биелэлт / улирал бүр/

34. Дүүргийн ЗДТГ:

- Хариуцсан нутаг дэвсгэрт гарсан зам тээврийн ослын нөхцөл байдлын танилцуулга /14 хоног тутам/

35. Аймгийн ИТХ, ЗДТГ:

- Эрүү, хэв журмын нөхцөл байдлын мэдээ /сар бүр/

- Хоногийн нөхцөл байдлын мэдээ

36. Татвар, нийгмийн даатгал, санхүүгийн хэлтэс:

- Аудит, татвар, нийгмийн даатгалын тайлан, төсвийн гүйцэтгэл /сар бүр/

37. УБТЗ, ИНЕГ, Эрдэнэс Монгол ХХК, Гашуун сухайт авто зам ХХК:

- Гэрээт цагдаагийн газар, тасгийн ажлын тайлан мэдээ /сар, улирал тутам/

38. Монгол Улсад суугаа гадаад орны ЭСЯ:

- МУ-ын иргэд болон гадаадын иргэд тус улсад амьдарч байх хугацаанд эрүүгийн хэрэг, захиргааны зөрчилд холбогдож байсан эсэх лавлагаа

- ЦАХ-чид гадаад улсад зорчихоор виз мэдүүлэх үед ЭСЯ-дад тодорхойлолт гаргах ЦАХ-чид гадаад улсад зорчихоор виз мэдүүлэх үед ЭСЯ-дад тодорхойлолт гаргах

- ЦАХ-чид гадаадад албан ажил, томилолт, сургалт, уралдаан тэмцээнд оролцох үед холбогдох материалыг хүргүүлэх

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2019 оны 05 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаагийн байгууллагын гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс

Аудитын төрөл: Үйл ажиллагааны аудит

Аудитын хугацаа: 2019.05.06- 2019.05.28

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа М.Азжаргал

1. ТАНИЛЦУУЛГА

Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь Цагдаагийн албаны тухай хуулийн 10.1.8-д "...гэрч, хохирогчийг хамгаалах", Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9.1.3-т "...гэрч, хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх...", Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар бүлэг /Гэрч, хохирогчийг хамгаалах/, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 1.1-д "...гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх..." чиг үүргийг хэлтсийн дарга 1, тасгийн дарга 2, эрүүгийн ахлах мөрдөгч 4, эрүүгийн мөрдөгч 13, ахлах мэргэжилтэн 1, мэргэжилтэн 1, бичиг хэргийн эрхлэгч, архивч 1, сэтгэл зүйч 2, мэдээлэл, холбоо сүлжээний инженер 1, цагдаа-жолооч 3, үйлчлэгч 1 /энгийн/ нийт 30 алба хаагчийн орон тоотойгоор, хэлтсийн дарга /удирдлага/, эрүүгийн цагдаагийн болон аюулгүй байдал, хамгаалалтын тасаг гэсэн бүтэцтэйгээр хэрэгжүүлж байна.

Тус хэлтэс нь Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд зааснаар 2014-2019 онд дараах арга хэмжээнүүдийг прокурор, шүүгчийн шийдвэрээр хэрэгжүүлсэн. Үүнд:

№	Хамгаалалтын арга хэмжээний хэлбэр / хуулиар тогтоосон/	2014	2015	2016	2017	2018	2019.05	Нийт
1	Урьдчилан сануулах	9	26	19	4	31	50	139
2	Тодорхой үйлдлийг хязгаарлах				2	3	3	8

3	Биечилсэн хамгаалалт	8	8	5	10	9	8	48
4	Мэдээллийн нууцлалыг хангах					1		1
5	Нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах	5	4	4	3	4	4	24
6	Аюулгүй газарт түр байрлуулах	10	4	5	2	3	5	29
7	Нүүлгэн шилжүүлэх							
8	Баримт бичгийг солих							
9	Гадаад төрхийг өөрчлөх							

Мөн хугацаанд тус хэлтсээс хамгаалалтад авсан гэрч, хохирогчийн тоон мэдээллийг харуулбал:

№	Хамгаалалтад авсан субъект	2014	2015	2016	2017	2018	2019	Нийт
1	Гэрч	1	7	4	6	6	7	33
2	Хохирогч	19	32	23	11	39	58	182
3	Хамаарал бүхий этгээд	11	40	12	11	17	4	95
4	Гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн хүн		2		3			5
5	Шүүгч	3	2	3	3	1		12
6	Прокурор		2		2	2	2	8
Нийт дүн		34	85	42	36	65	71	335

Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа нь дараах урсгал схемын дагуу явагдаж байна. Үүнд:

Нэгдүгээр үе шат. Хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх шийдвэр, хамгаалуулагч иргэнийг хүлээн авах /Прокурорын тогтоол, шүүгчийн захирамж/;

Хоёрдугаар үе шат. Хэлтэс, тасгийн дарга нараас хамгаалалтын арга хэмжээг удирдан зохион байгуулах, хариуцан хэрэгжүүлэх алба хаагчийг томилох;

Гуравдугаар үе шат. Хамгаалалтын арга хэмжээний хяналтын хэрэг нээж, шийдвэрт заагдсан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;

➤ Хамгаалалтын арга хэмжээний хэлбэрээс шалтгаалан хүн хүч, техник хэрэгслийн хуваарилалт хийх, хяналт тавих

➤ Хамгаалалтад ажиллах алба хаагчдын ажил үүргийн хуваарийг батлах, үйл ажиллагаанд нь хяналт тавих

➤ Хамгаалалтад ажиллах автомашин, шатахуун, холбооны зардал, 24 цагаар үүрэг гүйцэтгэх алба хаагчдын хоолны зардлыг шийдвэрлүүлэх

- Хамгаалалтын техник хэрэгслийг суурилуулах, олгох, хяналтыг хэрэгжүүлэх
- Галт зэвсэг, тусгай хэрэгслийг олгох, ашиглалтад хяналт тавих
- Хамгаалуулагч иргэнтэй уулзаж нөхцөл байдлыг тодруулж тайлбар авах, аюулын зэргийн эрсдэлийн үнэлгээ хийх, сэтгэл зүйн сорил авах, сэтгэл зүйн хамгаалалт, сэтгэл зүйн болон бусад шаардлагатай туслалцаа үзүүлэх эсэхийг тодорхойлох
- Хамгаалуулагч болон заналхийлэгч этгээдийн согтуурсан, мансуурсан эсэхийг тогтоох
- Заналхийлэгч этгээд болон хамгаалуулагч хүний нарийвчилсан, дэлгэрэнгүй судалгааг хийх
- Хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн Гүйцэтгэх ажлын арга хэмжээг зохион байгуулах
- Шүүгчийн шийдвэр /захирамж/-ийн дагуу маш нууц зэрэглэлийн аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх;

Дөрөвдүгээр үе шат. Заналхийлэгч этгээдийн талаар гүйцэтгэх ажлын арга хэмжээг зохион байгуулж, баримтжуулан шалгах

- Баримтжуулан шалгах үед тогтоогдсон нөхцөл байдал, үйлдэл нь эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг агуулсан бол харьяалах цагдаагийн байгууллагад шилжүүлэн шалгуулах
- Заналхийлэгч этгээд нь гэмт хэрэг үйлдэн оргон зугтсан тохиолдолд тухайн этгээдийг олж тогтоох, дайчлан баривчлах үйл ажиллагааг зохион байгуулах
- Шаардлагатай үед гүйцэтгэх ажлын арга хэмжээг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх;

Тавдугаар үе шат. Хамгаалалтын арга хэмжээний хэлбэрийг өөрчлөх, цуцлах саналаа эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн, шийдвэр /тогтоол, захирамж/ гаргуулах;

Зургаадугаар үе шат. Хамгаалалтын арга хэмжээний хяналтын хэргийг хааж, архивт шилжүүлэх зэрэг болно.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг баталгаажсан мэдээллээр хангах, аудитын объектыг боловсронгуй болгох, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хүргүүлж, үр дүнг тооцоход чиглэгдэнэ.

2.2 Аудитын цар хүрээ

Аудитын зорилгыг хангах хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн 2017, 2018, 2019 оны эхний 5 сарын үйл ажиллагааг аудитын объектод хамруулсан.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ аудит хийгдэх нэгжийн удирдлага, алба хаагчидтай хийх уулзалт ярилцлагын удирдамж, аудитын хүрээнд шалгах мэдээлэл, түүнийг нотлох аргыг боловсруулан хэлтсийн даргаар батлуулж ашигласан.

Аудитын удирдамж, төлөвлөгөөг Гэрч, хохирогчийг хэлтсийн дарга болон холбогдох алба хаагч нарт танилцуулж, хэлтсийн бүтэц, орон тоо баталсан тушаал, алба хаагчдын ажил үүргийн хуваарь, үйл ажиллагааны дэс дараалал /flowchart/, үйл ажиллагааны удирдлага, эрсдэл, хяналтын талаарх мэдээлэл болон холбогдох баримт бичгүүдийг гаргуулан авч судалсан.

Түүнчлэн аудитын нотлох баримтыг цуглуулах зорилгоор тус хэлтсийн алба хаагчидтай уулзалт ярилцлага зохион байгуулж, алба хаагчдын ажил, үүргийн гүйцэтгэлийг газар дээр нь тулган баталгаажуулах, бодлогын баримт бичгийн биелэлт, үр дүнг хэрхэн тайлагнасан байдалтай танилцсан болно.

Аудитын явцад баталгаажуулсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан тайлангийн төслийг бичиж, Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэст хүргүүлэн “Удирдлагын тайлбар”-ыг авсан.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 10.1, Хууль зүйн сайдын 2014 оны А/204 дүгээр тушаалаар баталсан “Биечилсэн хамгаалалтын журам”-ын 1.6, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны Н/09 дүгээр тушаалаар баталсан “Биечилсэн хамгаалалтын заавар”-т зааснаар “...*биечилсэн хамгаалалтад авагдсан гэрч, хохирогчийн аюулын эрсдэлийн түвшин бага бол 2, дунд бол 3-4, өндөр бол 5 ба түүнээс дээш алба хаагч хамгаалалтад авч ажиллана*” гэж шалгуурыг тогтоосон байна. Гэтэл одоогийн байдлаар тус хэлтэст хэрэгжиж байгаа эрсдэлийн түвшин тогтоосон байдлаар 5 биечилсэн хамгаалалт давхцан хүн хүч хүрэлцэхгүйгээс шалтгаалж эрсдэлийн дунд түвшний биечилсэн хамгаалалтын арга хэмжээнд 4 алба хаагч ажиллахаас 1, өндөр түвшний хамгаалалтын арга хэмжээнд 5 алба хаагч ажиллахаас 2 алба хаагч 24 цагаар үүрэг гүйцэтгэж байгаа нь дээрх журмын шалгуурыг хангахгүй байна. Үүнээс шалтгаалан алба хаагчдын хууль, журамд заасан амралтыг эдлүүлэх боломжгүй байгаа нь хамгаалалтад авсан иргэний эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл үүсгэж болохоор байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсээс 2017 онд 10, 2018 онд 9, 2019 онд 8биечилсэн хамгаалалтын арга хэмжээ, 2017 онд 2, 2018 онд 3, 2019 онд 5 аюулгүй газарт түр байрлуулах хамгаалалтын арга хэмжээ тус тус хэрэгжүүлснээс үзэхэд жил ирэх тутам дээрх тоон үзүүлэлтүүд нэмэгдэх хандлагатай байна. Иймд аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны Н/09 дүгээр тушаалаар баталсан “Биечилсэн хамгаалалтын заавар”-т заасан “... биечилсэн хамгаалалтад авагдсан гэрч, хохирогчийн аюулын эрсдэлийн түвшин бага бол 2, дунд бол 3-4, өндөр бол 5 ба түүнээс дээш алба хаагч хамгаалалтад авч ажиллана” шалгуурт нийцүүлэн хэрэгжүүлэхэд 5 эрүүгийн мөрдөгчийн орон тоог шийдвэрлэх зайлшгүй шаардлага бий болсон байна.

Тус хэлтсээс бүтэц, орон тоог шийдвэрлүүлэх талаар Тэргүүн дэд даргад 1 (2019.01.15-ны 18/39 дугаартай албан бичгээр), Санхүү, аж аюулын албанд 1 (2017.04.13-ны 20/176 дугаартай албан бичгээр), Аюулгүй байдлын хэлтэст 2 (2018.11.02-ны 18/615, 2019.04.08-ны 18/243 дугаар албан бичиг) удаа тус тус санал хүргүүлсэн боловч тодорхой шийдвэр гарахгүй өдий хүрчээ.

Дээрх нөхцөл байдалд хэлтсийн удирдлагаас үйл ажиллагаандаа учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх саналаа дээд шатны удирдлагад тухай бүрт нь мэдээлсэн байна. Дээд шатны удирдлагаас эрх хэмжээний хүрээнд эрсдэлийг бууруулах, шилжүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр удирдлагын менежментийн үүргийн дагуу гаргадаг зохих шийдвэр хүлээгдэж байна.

3.2 Цагдаагийн албаны тухай хуулийн 93.1-т “Цагдаагийн байгууллагын төсвийг улсын төсөвт тусгаж санхүүжүүлэх, ... төсөв нь цагдаагийн байгууллага үйл ажиллагаагаа шуурхай, тасралтгүй, үр дүнтэй явуулах шаардлагыг хангасан байна”, мөн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.2, Хууль зүйн сайдын 2014 оны А/114 дүгээр тушаалаар баталсан “Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”-ын 1.6-д “... хамгаалалтад шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан. Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах болон Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн санхүүжилт нь улсын төсвөөс нэгдсэн дүнгээр хийгддэг бөгөөд 2016 онд батлагдсан төсөв 653,134,000 төгрөг, үүнээс гүйцэтгэл нь 569,610,262 төгрөг, 2017 онд батлагдсан төсөв 808,955,800 төгрөг, үүнээс гүйцэтгэл нь 810,839,761 төгрөг, 2018 онд батлагдсан төсөв 1,023,068,500 төгрөг, үүнээс гүйцэтгэл нь 1,023,068,500 төгрөг байна.

Тус хэлтэст төсөв захиран зарцуулах эрх хэмжээ олгогдоогүй, нягтлан бодогч, няравын орон тоо байхгүйгээс шалтгаалан алба хаагчдын 24 цагаар үүрэг гүйцэтгэсэн хугацааны тээврийн хэрэгслийн шатахуун, холбооны зардал, хоолны мөнгө тухай бүр олгогдохгүй дараа сард

олгогдож байгаа нь алба хаагчдын үүрэг гүйцэтгэлт, эрүүл мэнд, аюулгүй байдал болон байгууллагын үйл ажиллагааны шуурхай, тасралтгүй, үр дүнтэй явагдах нөхцөл байдалд хүндрэл үүсэхээр байгаа талаар Тэргүүн дэд даргад 1, Санхүү, аж ахуй албанд 1, Аюулгүй байдлын хэлтэст 2 удаа мэдээлж, танилцуулга хүргүүлжээ.

Хүний нөөцийн хэлтсийн 2019.02.21-ний өдрийн Б/1024 дугаартай албан бичгээр "...цагдаагийн байгууллага нь 2019 онд батлагдсан төсвийн хязгаарт багтаан ажиллаж байгаа бөгөөд Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолоор цалин олгоход 88 тэрбум төгрөгөөр дутагдах судалгаа гарсан бөгөөд сул орон тооноос хэмнэгдсэн мөнгөөр орон тоо шинээр бий болгох боломжгүй" гэсэн хариу өгсөн байна.

Мөн аюулгүй газарт түр байрлуулах хамгаалалтын арга хэмжээнд авагдсан гэрч, хохирогч, иргэний хоол хүнс, ахуйн хэрэглээний зардлыг дээрх хууль, журмын дагуу 2016-2019 оны улсын төсөвт тусгуулаагүй байна. Үүнээс шалтгаалан уг зардлыг алба хаагчид өөрсдийн цалингаас гаргах, төрийн бус байгууллагуудаас хандив тусламж авах байдлаар зохицуулалт хийн ажиллаж иржээ. Тухайлбал; Монголын Улаан загалмай нийгэмлэгт 2017 онд 1, 2018 онд 2, 2019 онд 2 удаа албан бичгээр хүсэлт тавьж, анхны тусламжийн болон хүнсний зүйлийн багц, аяны хөнжил, насанд хүрээгүй хохирогчийн 1-2 ээлжийн солих хувцас, хичээлийн хэрэглэл зэргийг авч, хамгаалалтад байгаа иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байна.

Хууль зүйн сайдын 2014 оны А/204 дүгээр тушаалаар баталсан "Биечилсэн хамгаалалтын журам"-ын 1.6-д *"Хамгаалалтын арга хэмжээнд шаардлагатай холбоо, тээвэр, орон байр, галт зэвсэг, тусгай хэрэгсэл нэг бүрийг эрх бүхий тухайн байгууллага бүрэн хариуцаж зохион байгуулна"* гэж заасан боловч тус хэлтэст одоогийн байдлаар шуурхай албаны 3 автомашин байгаа нь хүрэлцэхгүй байгаа тул алба хаагчид хувийн автомашинаар хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байна. Хувийн автомашинаар үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад шатахууны зардлыг байгууллагаас үүрэг гүйцэтгэж дууссаны дараа олгож байгаа нь алба хаагчдад хүндрэл учруулж байна.

Цаашид байгууллагын үйл ажиллагааг шуурхай, тасралтгүй, үр дүнтэй явуулах шаардлагыг хангахын тулд хууль болон журмаар тогтоосон төсвөөс санхүүжүүлэх аюулгүй газарт түр байрлуулах хамгаалалтын арга хэмжээнд авагдсан гэрч, хохирогч, иргэний нийгмийн /хоол хүнс, ахуйн хэрэглээний/ үйлчилгээний болон биечилсэн хамгаалалтын арга хэмжээнд шаардагдах зардлуудыг төсвийн төсөөлөлд тусгах асуудлыг Санхүү, аж ахуйн албатай хамтран зохион байгуулах, мөн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18.1.4-т *"нийгмийн болон эдийн засгийн туслалцаа"* гэсэн заалтыг шинээр хуулийн төсөлд нэмж оруулахаар байна.

Алба хаагчдын 24 цагаар үүрэг гүйцэтгэсэн хугацааны хоолны мөнгө, тээврийн хэрэгслийн шатахууны болон холбооны зардлыг дараа нь бус тухай бүр олгуулах асуудлыг Санхүү, аж ахуйн албатай зөвшилцөж, батлагдсан төсвийн хүрээнд тухайн хэлтсийн үйл ажиллагааны онцлог /алба хаагч бүр 24 цагаар үүрэг гүйцэтгэдэг/, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн зардлын тооцоог урьдчилан гарган, санхүүжилтийг авч, гүйцэтгэлийг сарын эцэст тулган баталгаажуулах байдлаар шийдвэрлэх боломжтой бөгөөд нябо, няравын орон тоог шинээр бий болгох шаардлагагүй байна.

Прокурор, шүүгч нь Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 22.1-д заасан нөхцөл байдлыг харгалзан үзэхгүй аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргаж байгаа нь уг арга хэмжээний зардал жил ирэх тусам нэмэгдэх, зарим талаар үр дүн багатай арга хэмжээний тоо өсч, алба хаагчдын ажлын ачаалал нэмэгдэх эрсдэл үүсэхээр байгааг анхаарч Шүүх болон Прокурорын байгууллагатай нягт хамтран, үйл ажиллагааг уялдуулан ажиллах нь зүйтэй.

3.3 Төрийн албаны тухай хуулийн 7.1.2-т “...мэргэшсэн, тогтвортой байх”, Цагдаагийн албаны тухай хуулийн 66.3-т “Цагдаагийн байгууллага цагдаагийн алба хаагч бүрд мэргэжлээрээ суралцах, албан тушаал дэвших тэгш боломж, нөхцөл бүрдүүлнэ”, Хууль зүйн сайдын 2014 оны А/204 дүгээр тушаалаар баталсан “Биечилсэн хамгаалалтын журам”-ын 1.4-т “Хамгаалалтын ажилтан нь гэрч, хохирогч түүнд хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангахаар тусгайлан томилогдсон хамгаалалтын ажлын зохих түвшний мэдлэг, дадлага, туршлагатай, галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл, зэвсэггүй тулалдах мэхийг эзэмшсэн байна”, Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө /ЗГ-ын 2015 оны 346 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт/-ний 2.3-т “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх асуудлаар бусад улсын туршлагыг судлах, сайн туршлага, арга хэмжээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны Н/09 дүгээр тушаалаар батлагдсан “Биечилсэн хамгаалалтын заавар”-т хамгаалалтын ажилтны сургалт дадлагын талаар “Гадаад орны ижил чиг үүрэг бүхий байгууллагын сургалтад хамруулах, сургагч багш урьж сургалт зохион байгуулах”-аар заасан.

Тус хэлтсээс 2019 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 18/49 дугаартай албан бичгээр ирүүлсэн эрсдэлийн үнэлгээгээр дараах эрсдэлүүд өндөр түвшинд үнэлэгдсэн байна. Үүнд;

- энгийн сургууль төгссөн алба хаагчдын ур чадвар дутмаг байгаагаас байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах
- хамгаалалтад ажиллаж байгаа алба хаагчид галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх ур чадвар дутагдалтай байгаагаас алба хаагчийн болон хамгаалуулагчийн аюулгүй байдалд эрсдэл учрах

- алба хаагчдыг томилохдоо тухайн мэргэжлийн хэлтсийн саналыг авахгүйгээр шууд томилж байгаагаас ажлын байрны шалгуур, шаардлага хангаагүй алба хаагч томилогдож, байгууллагын хэвийн үйл ажиллагаа /гэрч, хохирогчийн нууцлал алдагдах, мэргэжлийн алдаа, ёс зүйн зөрчилд холбогдох, албанаас халагдах/ алдагдах, алба хаагчдын болон албаны нэр хүнд унах
- Алба хаагчдыг гадаад орны ижил төстэй байгууллагын үйл ажиллагаатай танилцуулах, туршлага судлуулах, сургалтад хамруулах, гадаад орны байгууллагуудтай харилцаа тогтоож хамтран ажиллах талаар тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулаагүйгээс алба хаагчдын мэргэжлийн ур чадвар дээшлэхгүй байх, байгууллагын болон алба хаагчийн ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үр дүн буурах зэрэг болно.

Эрсдэлийн үнэлгээний мөрөөр тухайн байгууллагын удирдлагаас өөрийн эрх хэмжээний хүрээнд тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулсан боловч бодит үр дүнд хүрээгүй байна. Цаашид эрсдэлийг бууруулах чиглэлээр дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд;

а. Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2-д "... сургалтын хөтөлбөр боловсруулж нэвтрүүлэх", мөн 4.1-д "...гэрч, хохирогчийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх", 4.2-д "...хууль, хяналтын байгууллагын ажилтан, алба хаагчдыг гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр сургаж, мэргэшүүлэх сургалтыг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлэх төсвийг төлөвлөгөөнд тусгасан боловч цагдаагийн байгууллагын төсөвт тусгуулаагүй байна. Уг төлөвлөгөөнд төсөвт зардалтай 14 ажил, арга хэмжээ байгаа боловч нэг ч ажил, арга хэмжээний зардлыг цагдаагийн байгууллагын төсөвт тусгуулаагүй байгааг анхаарч, төсвийн төслийг яаралтай боловсруулан Санхүү, аж ахуйн албанд хүргүүлэх нь зүйтэй. /Хавсралт 1/

б. Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил хийх, олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх, хууль зүйн дээд боловсролын сургалтын хөтөлбөрт хохирогч судлал /виктимологи/, гэрч, хохирогчтой харилцах, туслалцаа үзүүлэх асуудлыг тусгах саналаа Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэст 2019 онд (2019.01.21-ны 18/63 дугаартай албан бичгээр) 1, 2018 онд (2018.05.16-ны 18/280, мөн 2018.09.04-ны 18/471 дугаартай албан бичгээр) 2, Тэргүүн дэд даргад 2017 онд (2017.11.29-ний 20/578 дугаартай албан бичгээр) 1, 2018 онд (2018.05.16-ны 18/280 дугаартай албан бичгээр) 1 нийт 5 удаа хүргүүлсэн боловч тодорхой үр дүнд хүрээгүй байна. Иймд төлөвлөгөөний 1.2-д "...сургалтын хөтөлбөр боловсруулж нэвтрүүлэх"

заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төсвийг шийдвэрлүүлэн эрдэмтэн, судлаач нарыг оролцуулан мэргэжлийн багаар хөтөлбөр боловсруулах ажлыг Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэстэй хамтран зохион байгуулах нь илүү үр дүнтэй болно.

с. 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар тус хэлтэс нь 30 алба хаагч, ажилтны орон тоотойгоос 29 алба хаагч үүрэг гүйцэтгэж байна. 2017 оноос цагдаагийн ахмад Х.Булгантамир нь эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдаж байгаа тул албан үүрэг биелүүлэхийг түдгэлзүүлсэн байна. 2018 онд 4 алба хаагч өөр албанд шилжиж, 3 алба хаагч цэргийн байнгын тэтгэвэрт гарч, 1 алба хаагч өөрийн хүсэлтээр албанаас чөлөөлөгдсөн нь нийт бие бүрэлдэхүүний 24.0 хувьд өөрчлөлт орсон тоон үзүүлэлт гарч байна. 2019 оны эхний 5 сарын байдлаар 2 алба хаагч өөр албанд шилжиж, 3 алба хаагч шинээр томилогдсон байна. Энэ нь хууль, журамд заасны дагуу тус хэлтэст томилогдож байгаа алба хаагчдыг мэргэжлийн хэлтсээр нь судлуулах, тэдний саналыг авах, ажлын байрны шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан тогтвор суурьшилтай ажиллах, сахилга ёс зүй, харилцааны өндөр ур чадвартай алба хаагчийг сонгон шалгаруулж авахад анхаарвал зохистой байна. Үүнээс шалтгаалан албаны болон хамгаалалтын арга хэмжээ тасалдах, гэрч, хохирогчийн нууцлал, аюулгүй байдал алдагдах, алба хаагчийн болон байгууллагын нэр хүндэд эрсдэл үүсэх магадлалтай байгааг Хүний нөөцийн болон Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн дарга нар хяналтдаа авч, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахыг зөвлөж байна.

д. Тус хэлтэс нь БНТУ-ын Ерөнхий сайдын дэргэдэх Хамтын ажиллагааг зохицуулах агентлаг /ТИКА/ Олон улсын байгууллагын Улаанбаатар хот дахь Хөтөлбөр зохицуулах газрын дэмжлэгээр БНТУ-ын цагдаагийн болон гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүргийн байгууллагад алба хаагчдыг туршлага судлуулах, сургалтад хамруулах, сургагч багш урьж, гэрч, хохирогчийг хамгаалах аюулгүй байдал, хамгаалалтын чиглэлээр сургалт зохион байгуулах, техникийн болон бусад чиглэлээр дэмжлэг тусалцаа авах саналаа Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэст 2017 онд (2017.07.03-ны 20/329 дугаартай албан бичиг) 1, 2018 онд (2018.04.03-ны 18/176 дугаартай албан бичиг) 1, 2019 онд (2019.01.22-ны 18/64 дугаартай албан бичиг) 1 нийт 3 удаа хүргүүлсэн боловч шийдвэр гараагүй байна. Цаашид дээрх төлөвлөгөөний 2.2-т “Гэрч, хохирогчийг хамгаалах, тусалцаа үзүүлэх чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, техникийн тусалцаа авах”, 2.3-т “Гэрч, хохирогчийг хамгаалах, тусалцаа үзүүлэх асуудлаар бусад улсын туршлагыг судлах, сайн туршлага, арга хэмжээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх” заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний /үндэслэл, хэрэгцээ шаардлага, үр дүнг оновчтой тодорхойлсон/ саналаа Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлэх нь зүйтэй.

3.4 Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсэн эрхийг нь нөхөн сэргээх, учирсан хохирлыг арилгах, тэдэнд төрөөс нийгмийн халамж, туслалцаа үзүүлэх тогтоолоог бий болгох зорилгоор Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолоор “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг

- улс, орон нутгийн төсөв;
- Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн хөрөнгө;
- хандивлагч орон болон олон улсын байгууллагын тусламж;
- төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн тусламж;
- бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхээр хөтөлбөрт тусгасан байна.

Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд 2016-2018 онд 9340.3 сая төгрөг, 2019-2021 онд 5256.0 сая төгрөг, 2022-2024 онд 6541.3 сая төгрөг нийт 21137.6 сая төгрөг зарцуулахаар тусгагдсан боловч цагдаагийн байгууллагын 2016-2019 оны төсөвт хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал тусгагдаагүй байна.

Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 10.5-д “*Үндэсний хөтөлбөрийн санхүүжилтийг улсын төсөв болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгана*” гэсэн заалтын хэрэгжилт сул байна. Иймд уг хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад шаардагдах зардлын тооцоог хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний мөнгөн дүн тавигдсан заалт бүрээр гаргаж, төсвийн төсөөллийг боловсруулж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан төсвийн цаглабарын дагуу /2019 оны 06 сарын 10-ны дотор/ Санхүү, аж ахуйн албанд хүргүүлэх шаардлагатай байна. /Хавсралт №1-ээс үзнэ үү/

Уг хөтөлбөрийн 8.3-д “*Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагаа тус бүрээр хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална*” гэж заасан ба хөтөлбөрийн 1 дүгээр үе шат дууссан, 2 дугаар үе шат эхэлж байгаа боловч хөтөлбөрийн хэрэгжилтийг /зорилт, үйл ажиллагааны үр дүнг хэмжих/ үнэлэх шалгуур үзүүлэлт батлагдаагүй өнөөдрийг хүрчээ. Энэ нь хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, хяналт шинжилгээ хийх боломжгүй гэсэн үг юм.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/42 дугаар тушаалаар баталсан “Цагдаа, дотоод цэргийн байгууллагаас 2019 онд хяналтад авч, хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт”-аар уг /ГХХТҮҮХ/ хөтөлбөрийн хэрэгжилтийг цагдаагийн байгууллагын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нэгж нь Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс байхаар

тогтоосон байна.

Иймд тус хэлтсээс хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулахын тулд дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд;

➤ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.5-д заасны дагуу хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад шаардагдах зардлын тооцоог хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний мөнгөн дүн тавигдсан /14/ заалт бүрээр гарган, төсвийн төсөөллийг боловсруулж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан төсвийн цаглабарын дагуу /2019 оны 06 сарын 10-ны дотор/ Санхүү, аж ахуйн албанд хүргүүлэх

➤ Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулах

➤ Шалгуур үзүүлэлт батлагдмагц хөтөлбөрийн хэрэгжилтэд явцын хяналт шинжилгээ хийж, үр дүнг Цагдаагийн ерөнхий газрын даргад мэдээлэх зэрэг болно.

4. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг үнэн зөв бодитой тодорхойлох, түүний мөрөөр хариу арга хэмжээг хэрэгжүүлсэн байдал, түүнд тавих удирдлагын дотоод хяналт, байгууллагын засаглалын оновчтой байдлыг харгалзан **“Их хэмжээний сайжруулалт хэрэгтэй”** гэж дүгнэлээ. Үүнд:

4.1 Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 10.1, Хууль зүйн сайдын 2014 оны А/204 дүгээр тушаалаар баталсан “Биечилсэн хамгаалалтын журам”-ын 1.6, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны Н/09 дүгээр тушаалаар баталсан “Биечилсэн хамгаалалтын заавар”-т зааснаар *“...биечилсэн хамгаалалтад авагдсан гэрч, хохирогчийн аюулын эрсдэлийн түвшин бага бол 2, дунд бол 3-4, өндөр бол 5 ба түүнээс дээш алба хаагч хамгаалалтад авч ажиллана”* гэсэн шалгуурыг хангахын тулд аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх 5 эрүүгийн мөрдөгчийн орон тоог батлагдсан бүтэц, орон тоонд нийцүүлэн Хүний нөөцийн хэлтсээр шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

4.2 Цагдаагийн албаны тухай хуулийн 93.1-т *“Цагдаагийн байгууллагын төсвийг улсын төсөвт тусгаж санхүүжүүлэх, ...төсөв нь цагдаагийн байгууллага үйл ажиллагаагаа шуурхай, тасралтгүй, үр дүнтэй явуулах шаардлагыг хангасан байна”*, мөн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.2, Хууль зүйн сайдын 2014 оны А/114 дүгээр тушаалаар баталсан “Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах

аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам"-ын 1.6-д "...хамгаалалтад шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ" гэсэн шалгуурыг хангахын тулд хууль болон журмаар тогтоосон төсвөөс санхүүжүүлэх аюулгүй газарт түр байрлуулах хамгаалалтын арга хэмжээнд авагдсан гэрч, хохирогч, иргэний нийгмийн /хоол хүнс, ахуйн хэрэглээний/ үйлчилгээний болон биечилсэн хамгаалалтын арга хэмжээнд шаардагдах зардлуудыг төсвийн төсөөлөлд бодитой тусгах асуудлыг Санхүү, аж ахуйн албатай хамтран зохион байгуулах, мөн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4-т "нийгмийн болон эдийн засгийн туслалцаа" гэсэн заалтыг шинээр хуулийн төсөлд нэмж оруулах асуудлыг Хуулийн хэлтэстэй хамтран судалж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

4.3 Төрийн албаны тухай хуулийн 7.1.2-т "...мэргэшсэн, тогтвортой байх", Цагдаагийн албаны тухай хуулийн 66.3-т "Цагдаагийн байгууллага цагдаагийн алба хаагч бүрд мэргэжлээрээ суралцах, албан тушаал дэвших тэгш боломж, нөхцөл бүрдүүлнэ", Хууль зүйн сайдын 2014 оны А/204 дүгээр тушаалаар баталсан "Биечилсэн хамгаалалтын журам"-ын 1.4-т "Хамгаалалтын ажилтан нь гэрч, хохирогч түүнд хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангахаар тусгайлан томилогдсон хамгаалалтын ажлын зохих түвшний мэдлэг, дадлага, туршлагатай, галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл, зэвсэггүй тулалдах мэхийг эзэмшсэн байна" гэсэн шалгуурыг хангахын тулд Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2, 4.1, 4.2-т заасан ажил, арга хэмжээний зардлыг цагдаагийн байгууллагын төсөвт тусгуулах, шинээр томилогдож байгаа алба хаагчдыг мэргэжлийн хэлтсээр судлуулж, ажлын байрны шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан эсэх талаар тэдний саналыг авах, дүгнэлт гаргуулах, цаашид тогтвор суурьшилтай ажиллах, сахилга ёс зүй, харилцааны зөрчил, мэргэжлийн алдаа гаргахгүй байх талаар баталгаа гаргуулах байдлаар мэргэшсэн алба хаагчийг томилон, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

4.4 Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.5-д "Үндэсний хөтөлбөрийн санхүүжилтийг улсын төсөв болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгана", мөн /ГХХТҮҮХ/ хөтөлбөрийн 7.2-т "Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ" гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд 2016-2018 онд 9340.3 сая төгрөг, 2019-2021 онд 5256.0 сая төгрөг, 2022-2024 онд 6541.3 сая төгрөг нийт 21137.6 сая төгрөг зарцуулахаар тусгагдсан боловч цагдаагийн байгууллагын 2016-2019 оны төсөвт хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал тусгагдаагүй байна.

Иймд уг хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад шаардагдах зардлын тооцоог хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний мөнгөн дүн тавигдсан заалт бүрээр гарган, төсвийн төсөөллийг боловсруулж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан төсвийн цаглабарын дагуу /2019 оны 06 сарын 10-ны дотор/ Санхүү, аж ахуйн албанд хүргүүлэх шаардлагатай байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/42 дугаар тушаалаар баталсан “Цагдаа, дотоод цэргийн байгууллагаас 2019 онд хяналтад авч, хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт, үр дүнг тооцоо баримт бичгийн жагсаалт”-аар Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь цагдаагийн байгууллагын хэмжээнд /ГХХТҮҮХ/ хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй тул төлөвлөгөөнд тусгагдсан зардлыг шийдвэрлүүлэх, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулах, шалгуур үзүүлэлт батлагдмагц хөтөлбөрийн 8.4-т заасны дагуу хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах нь зүйтэй байна.

5. ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, аудитын үр дүнд суурилан Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр аудитын багаас дараах зөвлөмжийг холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлж байна. Үүнд:

5.1 Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 10.1, Хууль зүйн сайдын 2014 оны А/204 дүгээр тушаалаар баталсан “Биечилсэн хамгаалалтын журам”-ын 1.6, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны Н/09 дүгээр тушаалаар баталсан “Биечилсэн хамгаалалтын заавар”-т зааснаар “...биечилсэн хамгаалалтад авагдсан гэрч, хохирогчийн аюулын эрсдэлийн түвшин бага бол 2, дунд бол 3-4, өндөр бол 5 ба түүнээс дээш алба хаагч хамгаалалтад авч ажиллана” гэсэн шалгуурыг хангахын тулд аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх 5 эрүүгийн мөрдөгчийн орон тоог шийдвэрлүүлэх /ХНХ, ГХХХ/;

5.2 Цагдаагийн албаны тухай хуулийн 93.1, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.2, Хууль зүйн сайдын 2014 оны А/114 дүгээр тушаалаар баталсан “Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”-ын 1.6 дахь заалтын хэрэгжилтийг хангахын тулд төсвөөс санхүүжүүлэхээр хууль болон журмаар тогтоосон аюулгүй газарт түр байрлуулах хамгаалалтын арга хэмжээнд авагдсан гэрч, хохирогч, иргэний хоол хүнс, ахуйн хэрэглээний болон биечилсэн хамгаалалтын арга хэмжээнд шаардагдах зардлуудыг төсвийн төсөөлөлд бодитой тусгаж, шийдвэрлүүлэх /СААА, ГХХХ/;

5.3 Төрийн албаны тухай хуулийн 7.1.2, Цагдаагийн албаны тухай хуулийн 66.3, Хууль зүйн сайдын 2014 оны А/204 дүгээр тушаалаар баталсан “Биечилсэн хамгаалалтын журам”-ын 1.4 дэх заалтын хэрэгжилтийг хангахын тулд Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2, 4.1, 4.2-т заасан ажил, арга хэмжээний зардлыг цагдаагийн байгууллагын төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулах /СААА, ГХХХ/

5.4 Тус хэлтэст шинээр томилогдож байгаа алба хаагчдыг мэргэжлийн хэлтсээр нь судлуулах, тэдний саналыг авах, ажлын байрны шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан эсэх талаар дүгнэлт гаргуулах, цаашид тогтвор суурьшилтай ажиллах, сахилга ёс зүй, харилцааны зөрчил, мэргэжлийн алдаа гаргуулах байх талаар баталгаа гаргуулах зэрэг мэргэшсэн алба хаагч тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнийг багасгах арга хэмжээ авч ажиллах /ХНХ, ГХХХ/;

5.5 Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18.1.4-т “*нийгмийн болон эдийн засгийн туслалцаа*” гэсэн заалтыг шинээр хуулийн төсөлд нэмж оруулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /ХХ, ГХХХ/;

5.6 Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.5, хөтөлбөр /ГХХТҮҮХ/- ийн 7.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зардал /2016-2018 онд 9340.3 сая төгрөг, 2019-2021 онд 5256.0 сая төгрөг, 2022-2024 онд 6541.3 сая төгрөг нийт 21137.6 сая төгрөг/-уудыг цагдаагийн байгууллагын төсөвт тусгуулах ажлыг 2019 оны 06 дугаар сарын 10-ны дотор багтаан зохион байгуулж, дүнг 2019 оны 07 дугаар сарын 01-ний дотор Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст ирүүлэх /СААА, ГХХХ/;

5.7 Хөтөлбөр /ГХХТҮҮХ/-ийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулах, шалгуур үзүүлэлт батлагдмагц хөтөлбөрийн 8.4-т заасны дагуу хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, үр дүнг Дэд даргын нэр дээр ирүүлэх /ГХХХ/;

Зөвлөмжийн биелэлтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг 2019 оны 12 дугаар сарын 10-ны дотор Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст ирүүлэх.

6. УДИРДЛАГЫН ТАЙЛБАР

Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэст 2019 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн З^а/3028 дугаартай албан бичгээр дотоод аудитын урьдчилсан тайланг хүргүүлж, “Удирдлагын тайлбар”-ыг авахад, тайланд тусгах саналгүй гэсэн болно.

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2019 оны 06 дугаар сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Гэрээт харуул хамгаалалт, хувийн хамгаалалтын үйл ажиллагаанд цагдаагийн байгууллагаас хяналт тавих үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: НХЖХОНАБХА-ны Нийтийн хэв журам хамгаалах газар

Аудитын объект: Гэрээт харуул хамгаалалт, хувийн хамгаалалтын үйл ажиллагаанд цагдаагийн байгууллагаас хяналт тавих үйл ажиллагаа

Аудитын төрөл: Үйл ажиллагааны аудит

Аудитын хугацаа: 2019.06.17- 2019.06.24

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа М.Азжаргал

1. ТАНИЛЦУУЛГА

Гэрээт харуул хамгаалалт, хувийн хамгаалалтын үйл ажиллагаанд цагдаагийн байгууллагаас хяналт тавих үйл ажиллагаа нь Цагдаагийн албаны тухай хуулийн 11.1.6-д "...гэрээт харуулын болон хувийн хамгаалалтын үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах", Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 21.1-д "Харуул хамгаалалтын үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд цагдаагийн байгууллага хяналт тавина", Хувийн хамгаалалтын тухай хуулийн 13.1-д "Хувийн хамгаалалтын үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд цагдаагийн байгууллага хяналт тавина", Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/40 дугаар тушаалаар баталсан "Харуул хамгаалалт эрхлэх хуулийн этгээдийг бүртгэх, үйл ажиллагааг явуулах, эрхийг түдгэлзүүлэх, бүртгэлээс хасах үйл ажиллагаанд нь хяналт тавих журам"-ын 4.1-д "Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдийн үйл ажиллагаа, галт зэвсэг, тусгай хэрэгслийн ашиглалт, хадгалалтад хууль тогтоомжид заасны дагуу хяналт тавина", мөн 4.2-д "Цагдаагийн байгууллагаас жил бүр харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд нэгдсэн хяналт шалгалтыг зохион байгуулах...", Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/266 дугаар тушаалаар баталсан

“Гэрээт харуул хамгаалалт, хувийн хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ олгох, хяналт тавих” журам /ЦБҮАЖ код 605/-ын 605.4.4-т “... нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагаа, сургалт, галт зэвсэг, тусгай хэрэгслийн ашиглалт, хадгалалтад хяналт тавина” гэсэн эрх зүйн зохицуулалтын хүрээнд зохих үндэслэл, журмын дагуу явагдаж байна.

Гэрээт харуул хамгаалалт болон хувийн хамгаалалтын үйл ажиллагаанд цагдаагийн байгууллагаас тавих хяналтын үйл ажиллагаа нь дараах хэлбэрээр зохион байгуулагдахаар хууль, журамд тодорхойлсон байна. Үүнд:

№	Гэрээт харуул хамгаалалтын хяналтын хэлбэрүүд	2016	2017	2018
1.Хамгаалалтын үйл ажиллагаанд тавих хяналт				
1.1	Гэрээт харуул хамгаалалт эрхлэх зөвшөөрөл шинээр авсан аж ахуйн нэгжийн тоо	251	263	247
1.2	Үүнээс харуул хамгаалалтын албаны алба хаагчдаас гэмт хэрэгт холбогдсон аж ахуйн нэгжийн тоо	Хяналт байхгүй	Хяналт байхгүй	Хяналт байхгүй
1.3	Үүнээс харуул хамгаалалтын албаны алба хаагчдаас зөрчилд холбогдсон аж ахуйн нэгжийн тоо	Хяналт байхгүй	Хяналт байхгүй	Хяналт байхгүй
1.4	Өөрөө хүсэлт гаргаж, татанбуугдсана ахуйн нэгжийн тоо	0	8	15
1.5	Хуульд заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн аж ахуйн нэгжийн тоо	0	0	0
1.6	Шүүхээр гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагааг зогсоож бүртгэлээс хассан аж ахуйн нэгжийн тоо	0	0	0
1.7	Цагдаагийн байгууллагын иж бүрэн шалгалтаар илрүүлсэн зөрчлийн тоо	8	20	3
1.8	Цагдаагийн байгууллагын хэсэгчилсэн шалгалтаар илрүүлсэн зөрчлийн тоо	Хяналт байхгүй	Хяналт байхгүй	Хяналт байхгүй
2.Сургалтын үйл ажиллагаанд тавих хяналт				
2.1	Гэрээт харуул хамгаалалтын чиглэлээр ажиллаж байгаа нийт хамгаалалтын ажилтнуудын тоо	8240	8250	9509
2.2	Үүнээс сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо	8240	8250	9509
2.3	Давтан сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо	0	0	0
2.4	Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан алба хаагчдын тоо	0	0	0
2.5	Дотоод хэргийн их сургуулиас зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан алба хаагчдын тоо	12/8240	12/8250	16/9509
2.6	Сургалтын чиглэлээр явуулсан шалгалтаар илрүүлсэн зөрчлийн тоо	Хяналт байхгүй	Хяналт байхгүй	Хяналт байхгүй
3.Галт зэвсэг, тусгай хэрэгслийн ашиглалт, хадгалалтад тавих хяналт				
3.1	Харуул хамгаалалт эрхлэх гэрчилгээ нь хүчингүй болсон хуулийн этгээдийн галт зэвсэг, тусгай хэрэгслийг шийдвэрлэсэн тоо /галт зэвсэг, хэдэн тусгай хэрэгсэл тус бүрээр/	Хяналт байхгүй	Хяналт байхгүй	Хяналт байхгүй

3.2	УЕП, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 12/05 тоот хамтарсан тушаалаар баталсан “Харуул хамгаалалтын ажилтан галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл ашиглах заавар”-ыг зөрсөн зөрчлийн тоо	Хяналт байхгүй	Хяналт байхгүй	Хяналт байхгүй
3.3	Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 19.2 дахь заалтыг зөрсөн зөрчлийн тоо	Хяналт байхгүй	Хяналт байхгүй	Хяналт байхгүй
4.Хувийн хамгаалалтын талаар				
4.1	Хувийн хамгаалалт эрхлэх зөвшөөрөл шинээр авсан аж ахуйн нэгжийн тоо		1	2

Улсын хэмжээнд Хувийн хамгаалалт эрхлэх зөвшөөрөлтэй 3, гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж давхардсан тоогоор 761, үүнээс цахим санд баталгаажсан 334 байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

Гэрээт харуул хамгаалалт, хувийн хамгаалалтын үйл ажиллагаанд цагдаагийн байгууллагаас хяналт тавих үйл ажиллагаанд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг баталгаажсан мэдээллээр хангах, аудитын объектыг боловсронгуй болгох, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хүргүүлж, үр дүнг тооцоход чиглэгдэнэ.

2.2 Аудитын цар хүрээ

Аудитын зорилгыг хангах хүрээнд 2016, 2017, 2018 оны байдлаар Гэрээт харуул хамгаалалт, хувийн хамгаалалтын үйл ажиллагаанд цагдаагийн байгууллагаас хяналт тавих үйл ажиллагааг аудитын объектод хамруулсан.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ аудит хийгдэх нэгжийн удирдлага, алба хаагчидтай хийх уулзалт ярилцлагын удирдамж, аудитын хүрээнд шалгах мэдээлэл, түүнийг нотлох аргыг боловсруулан хэлтсийн даргаар батлуулж ашигласан.

Аудитын удирдамж, төлөвлөгөөг холбогдох нэгжийн удирдлага, алба хаагчдад танилцуулж, гэрээт харуул хамгаалалт, хувийн хамгаалалтын үйл ажиллагаанд цагдаагийн байгууллагаас хяналт тавих үйл ажиллагаанд удирдлага болгох эрх зүйн актууд, алба хаагчдын ажил үүргийн хуваарь, үйл ажиллагааны дэс дараалал, үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, түүнд тавих хяналт, удирдлагын талаарх мэдээлэл болон холбогдох баримт бичгүүдийг гаргуулан авч судалсан.

Түүнчлэн аудитын нотлох баримтыг цуглуулах зорилгоор холбогдох нэгжийн алба хаагчидтай уулзалт ярилцлага зохион байгуулж, алба хаагчдын ажил, үүргийн гүйцэтгэлийг газар дээр нь үзэж, SAS цахим системийн ашиглалтын байдалтай танилцсан болно.

Аудитын явцад цуглуулсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан тайлангийн төслийг бичиж, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Нийтийн хэв журам хамгаалах газарт хүргүүлэн “Удирдлагын тайлбар”-ыг авсан.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 6.1-д “Харуул хамгаалалт эрхлэх хуулийн этгээд нь эрх үүргээ хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, боловсон хүчин, зэвсэг техник, тусгай хэрэгсэл, хууль тогтоомжийн лавлагаатай байхаас гадна өөрийгөө санхүүжүүлэх чадвартай байна” гэж заасан.

Гэтэл улсын бүртгэлийн гэрчилгээ авсан боловч тогтмол үйл ажиллагаа явуулах албан өрөө, тасалгаа, оффис байхгүй, байгууллагын захирал гэх хүмүүсийн утас нь холбогддоггүй, оршин суух тодорхой хаяггүй, хамгаалалтын ажилтан байхгүй, тогтмол үйл ажиллагаа явуулдаггүй байгууллага 135 байна.

Үүнээс шалтгаалан хамгаалалтын гэрээ байгуулсан аж ахуйн нэгж /үйлчлүүлэгч/-ийн эрх ашиг хохирох, залилангийн гэмт хэрэг үйлдэгдэх үндсэн шалтгаан болох, уг үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж байгаа цагдаагийн албаны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсэхээр байна.

Иймд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нийтийн хэв журам хамгаалах нэгжийн ахлах байцаагч нар зөвхөн цахим сангаар хяналт тавих бус, хууль, журамд заасан нэгдсэн болон хэсэгчилсэн шалгалтыг өөрийн хариуцсан нутаг дэвсгэртээ гэнэтийн байдлаар тогтмол зохион байгуулж, шалгуур хангаагүй хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх, Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 21.3 *Шүүх мөн хуулийн 21.3.1-21.3.4 заасан үндэслэл тогтоогдвол харуул хамгаалалтын байгууллагын үйл ажиллагааг зогсоож бүртгэлээс хасна*-т заасан үндэслэл тогтоогдвол холбогдох материалыг Шүүхэд хүргүүлж, гэрээт харуул хамгаалалт эрхлэн явуулах үйл ажиллагааг зогсоон, бүртгэлээс хасаж цэгцлэх шаардлагатай байна.

3.2 Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 11.1-д “Харуул хамгаалалтын алба хаагч ижил загварын дүрэмт хувцас, тухайн байгууллагын онцлогийг тусгасан ялгах тэмдэг хэрэглэх ба тэдгээрийн зардлыг харуул хамгаалалтын байгууллага хариуцна”, мөн 11.2-д “Дүрэмт хувцасны загвар болон ялгах тэмдэг, дүрэмт хувцас хэрэглэх журмыг цагдаагийн төв байгууллага тогтооно” гэж заажээ.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2008 оны 126 дугаар тушаалаар “Гэрээт харуул хамгаалалтын байгууллагын алба хаагчдын дүрэмт

хувцасны загвар, өнгө, материалын ялгаа, дүрэмт хувцас өмсөж хэрэглэх журам”-ыг баталсан.

Гэтэл гэрээт харуул хамгаалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдүүдийн зүгээс хувцасны ангилал, нэр төрлийг нэмэгдүүлэх, өнгө үзэмжийг сайжруулах, хувцасны материалыг хүний биед эвтэй байдлаар шинэлэг технологиор шийдэх, үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хувцас хийлгэж, хамгаалалтын ажилтнуудад өмсүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх талаар удаа дараа хүсэлт гаргаж байжээ.

Иймд уг журмын хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ хийж, гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдүүдээс санал авч, журмын төслийг шинэчлэн боловсруулж, Хуулийн хэлтсээр хянуулан Цагдаагийн ерөнхий газрын даргаар батлуулах нь зүйтэй.

3.3 Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 10.1-д “Харуул хамгаалалтын үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх асуудлыг цагдаагийн төв байгууллага хариуцна” гэж заасан. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны Б/586 дугаар тушаалаар “Гэрээт харуул хамгаалалтын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”-г баталсан.

Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс 2016-2018 онд сургалт зохион байгуулаагүй, харин 2019 онд 1 удаа гэрээт харуул хамгаалалтын сургалтыг зохион байгуулж, 105 харуул хамгаалалтын ажилтныг хамруулж, гэрчилгээ олгосон байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын хамтарсан 2011 оны 107/118 дугаар тушаалаар баталсан “Харуул хамгаалалтын үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх боловсон хүчний дамжааны сургалтын хөтөлбөр”-ийн дагуу Дотоод хэргийн Их сургуулийн Ахлагчийн сургуулийн гэрээт харуул хамгаалалтын сургалтад 25999 хүн хамрагдаж төгсжээ. Дээрх хугацаанд давтан болон мэргэжил дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт байхгүй байна.

Цаашид хуулийн хэрэгжилтийг хангахын тулд харуул хамгаалалтын үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах болон мэргэжил дээшлүүлэх сургалтыг Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс хариуцаж зохион байгуулах нь зүйтэй.

3.4 Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/40 дугаар тушаалаар баталсан “Харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсч буй хуулийн этгээд нь бүртгүүлэхдээ цагдаагийн байгууллагын цахим хаяг /www.sas.police.gov.mn/-т байгууллагын холбогдох мэдээллийг оруулсан байна”, мөн 2.3-т “Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан хуулийн этгээдийн энэ журмын 2.2 дахь хэсэгт заасан мэдээллийг шалгаж, шаардлага хангасан тохиолдолд “Харуул хамгаалалтын нэгдсэн бүртгэлийн сан”-д нэвтрэх нууц үгийг бүртгэлтэй цахим хаягаар хуулийн этгээдэд илгээнэ” гэж заасан.

Цахим хаягаар зөвшөөрөл олгох үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгжид шуурхай, хүртээмжтэй хүргэж байгаа нь сайшаалтай хэдий ч сангийн

ашиглалт, хяналт сул байна. Тухайлбал, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл хангалттай бус, /хаяг байршил тодорхойгүй/, тоон мэдээллүүд зөрүүтэй /бүртгэгдээгүй төлөвт байгаа 761, үүнээс нийт баталгаажсан 334, орон нутагт нийт 36, үүнээс баталгаажсан 26 г.м/ байна.

Мөн түүнчлэн харуул хамгаалалтын албаны алба хаагчдаас гэмт хэрэг, зөрчилд холбогдсон аж ахуйн нэгжийн тоо, цагдаагийн байгууллагын хэсэгчилсэн шалгалтаар илрүүлсэн зөрчлийн тоо, давтан сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо, харуул хамгаалалт эрхлэх гэрчилгээ нь хүчингүй болсон хуулийн этгээдийн галт зэвсэг, тусгай хэрэгслийг шийдвэрлэсэн тоо, Улсын Ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 12/05 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Харуул хамгаалалтын ажилтан галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл ашиглах заавар”-ыг зөрчсөн зөрчлийн тоо, Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 19.2 дахь заалт /Хүүхэд болон жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүмүүст энэ хуулийн 19.1-д зааснаас бусад тохиолдолд галт зэвсэг хэрэглэхийг хориглоно/-ыг зөрчсөн зөрчлийн тоо зэрэг хяналтын үр дүн, үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийн тоон мэдээллүүд нь цахим сангаас гарах боломжгүй байна.

Иймд цахим санд оруулж байгаа мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хянах үүрэг бүхий нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нийтийн хэв журам хамгаалах нэгжийн ахлах байцаагч, Бүртгэл хяналтын төвийн уг сангийн ашиглалтыг хариуцсан ахлах мэргэжилтэн, Нийтийн хэв журам хамгаалах газрын гэрээт харуул хамгаалалт хариуцсан ахлах мэргэжилтэн нарыг оролцуулан “Ажлын хэсэг” байгуулж, гэрээт харуул хамгаалалтын байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн хяналт тавих бус, газар дээр нь очиж, нөхцөл байдалтай танилцах, бүрдүүлсэн материалд тулган баталгаажуулалт хийж, тоон мэдээллийн зөрүүг арилгах арга хэмжээг шуурхай зохион байгуулж, үр дүнг Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст 2019 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн дотор тайлагнах шаардлагатай.

Үүнээс шалтгаалан байгууллагын тайлан мэдээ зөрүүтэй гарах, хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн бүртгэл давхардах, цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа хяналтын үр нөлөө буурах эрсдэл үүсэхээр байгааг анхааруулж байна.

4. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн Гэрээт харуул хамгаалалт /хувийн хамгаалалт/-ын үйл ажиллагаанд цагдаагийн байгууллагаас хяналт тавих үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг үнэн зөв бодитой тодорхойлох, түүний мөрөөр хариу арга хэмжээг хэрэгжүүлсэн байдал, түүнд тавих удирдлагын дотоод хяналт, байгууллагын засаглалын оновчтой байдлыг харгалзан Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ, Дотоод аудитын олон улсын стандартын

дагуу “**Сайжруулалт хэрэгтэй**” гэж дүгнэлээ. /Олон улсын стандартын дагуу дотоод аудитад хамрагдсан нэгжийн үйл ажиллагааг үнэлэх шалгуурыг хүснэгтээр харуулав/

Үнэлгээний томъёолол	Үнэлгээний шалгуур	Анхаарах асуудлууд
Хангалттай	Гол чухал эсвэл томоохон гэж үзэх алдаа зөрчил эсвэл асуудал илрээгүй, хяналтын орчин сайн бөгөөд эрсдэлтэй хэсгүүдэд хяналт сайн тавигддаг бол;	Анхаарах гол асуудал байхгүй, гэхдээ хязгаарлагдмал түвшинд авч үзэх асуудал байж болно.
Сайжруулалт хэрэгтэй	Хэдийгээр хяналтын орчин зохистой боловч зарим хяналттай холбоотой алдаа зөрчил, асуудал илэрсэн бол;	Илэрсэн асуудалтай холбоотойгоор хэрхэн сайжруулах талаар авч үзэх
Их хэмжээний сайжруулалт хэрэгтэй	Материаллаг алдаа зөрчил, эрсдэлийг үүсгэх хяналтын сул талууд илэрсэн, эрсдэлийг бууруулах хяналтууд байгаа боловч тэдгээрт их хэмжээний сайжруулалт хэрэгтэй бол;	Илэрсэн асуудлын шалтгааны авч үзэх
Хангалттай бус	Эрсдэлийг бууруулах аливаа хяналт байхгүй эсвэл байгаа хяналт нь хангалттай бус, эрсдэлээс хамгаалах шуурхай арга хэмжээ авах шаардлагатай бол;	Илэрсэн асуудлын шалтгааныг тусгайлан авч үзэх шаардлагатай

Цаашид илэрсэн асуудалтай холбогдуулан дараах сайжруулалтыг хийх шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

Нэг. Улсын хэмжээнд 2016-2018 оны байдлаар гэрээт харуул хамгаалалтын талаар тоон мэдээллийг цуглуулахад, хувийн хамгаалалт эрхлэх зөвшөөрөлтэй 3, гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж давхардсан тоогоор 761, үүнээс цахим санд баталгаажсан 334, нийт 25999 хамгаалалтын ажилтнууд үүрэг гүйцэтгэж байгаа гэсэн статистик тоо гарч байна.

Харин уг үйл ажиллагаанд хяналт тавьж байгаа цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг хэмжих дараах шалгуур үзүүлэлтүүдийн тоон мэдээлэл нь цахим сангаас гарах боломжгүй байна. Үүнд;

- Харуул хамгаалалтын албаны ажилтнуудаас гэмт хэрэг, зөрчилд холбогдсон аж ахуйн нэгжийн тоо
- Цагдаагийн байгууллагын хэсэгчилсэн шалгалтаар илрүүлсэн зөрчлийн болон хүргүүлсэн мэдэгдлийн тоо
- Давтан сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо
- Харуул хамгаалалт эрхлэх гэрчилгээ нь хүчингүй болсон

хуулийн этгээдээс хураан авч, шийдвэрлэсэн галт зэвсэг, тусгай хэрэгслийн тоо,

➤ Улсын Ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 12/05 тоот хамтарсан тушаалаар баталсан “Харуул хамгаалалтын ажилтан галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл ашиглах заавар”-ыг зөрчсөн зөрчлийн тоо

➤ Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 19.2 дахь заалт /Хүүхэд болон жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүмүүст энэ хуулийн 19.1-д зааснаас бусад тохиолдолд галт зэвсэг хэрэглэхийг хориглоно/-ыг зөрчсөн зөрчлийн тоо зэрэг болно.

Иймд цахим сангийн мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангах, ашиглалтыг сайжруулахын тулд гэрээт харуул хамгаалалтын байгууллагуудын тооны зөрүү, давхардлыг арилгах, улсын хэмжээнд тулган баталгаажуулалт хийж, баталгаажсан төлөвөөс бусад төлөвт /хянах, түдгэлзүүлэх, тодорхойгүй/ байгаа байгууллагуудад хэсэгчилсэн шалгалт явуулж, хуулийн шаардлага хангаагүй хуулийн этгээдүүдийн тусгай зөвшөөрлийг Шүүхээр хүчингүй болгуулж цэгцлэх шаардлагатай байна. Шүүхэд шилжүүлж шийдвэрлүүлсэн тохиолдол огт бүртгэгдээгүй болно.

Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2008 оны 126 дугаар тушаалаар баталсан “Гэрээт харуул хамгаалалтын байгууллагын алба хаагчдын дүрэмт хувцасны загвар, өнгө, материалын ялгаа, дүрэмт хувцас өмсөж хэрэглэх журам”-ын зохицуулалт нь одоогийн гэрээт харуул хамгаалалтын байгууллагууд болон тэдгээрийн үйлчлүүлэгч нарын зүгээс тавьж байгаа стандарт шаардлагад нийцэхгүй байгаагаас журмын хэрэгжилт хангалтгүй байна.

Иймд уг журмын хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ хийж, гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдүүдээс санал авч, журмын төслийг шинэчлэн боловсруулж, Хуулийн хэлтсээр хянуулан Цагдаагийн ерөнхий газрын даргаар батлуулах нь зүйтэй.

Гурав. Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулиар харуул хамгаалалтын үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх боловсон хүчнийг бэлтгэх, давтан болон мэргэжил дээшлүүлэх сургалтыг цагдаагийн төв байгууллага хариуцахаар зохицуулсан байна.

Гэтэл цагдаагийн байгууллагаас 2016-2018 онд сургалт зохион байгуулаагүй, харин дээрх хугацаанд Дотоод хэргийн Их сургуулиас 25999 иргэнийг /1 ажилтны сургалтын төлбөр 195000 төгрөг/ гэрээт харуул хамгаалалтын сургалтад хамруулж, 5.069.805.000 төгрөгийг улсын төсөвт оруулсан байна.

Цаашид хуулийн хэрэгжилтийг хангахын тулд харуул хамгаалалтын үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах болон мэргэжил дээшлүүлэх сургалтыг Цагдаа, дотоодын цэргийн

сургалтын нэгдсэн төвөөс хариуцаж зохион байгуулах нь зүйтэй байна.

Дөрөв. Гэрээт харуул хамгаалалтын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэлийн дата өгөгдөл үүсгэх зорилгоор ашиглаж байгаа SAS цахим мэдээллийн сангийн ашиглалт, түүнд тавих хяналт, цуглуулсан өгөгдлийн үнэн зөв, бодит байдалтай нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, цаашид сангийн хөгжүүлэлтийг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Энэ нь нэг талаас гэрээт харуул хамгаалалтын байгууллагуудын ажилтнуудын мэдлэг, ур чадвар дутмаг, нөгөө талаас хяналтыг хэрэгжүүлж байгаа цагдаагийн алба хаагчдын ажлын хариуцлага сул, програмын талаарх мэдлэг шаардлагын түвшинд хүрэхгүй байгаатай шууд холбоотой байна.

Иймд цахим санд оруулж байгаа мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хянах үүрэг бүхий нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нийтийн хэв журам хамгаалах нэгжийн ахлах байцаагч, Бүртгэл хяналтын төвийн уг сангийн ашиглалтыг хариуцсан ахлах мэргэжилтэн, Нийтийн хэв журам хамгаалах газрын гэрээт харуул хамгаалалт хариуцсан ахлах мэргэжилтэн нарыг оролцуулсан “Ажлын хэсэг” байгуулж, гэрээт харуул хамгаалалтын байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн хяналт тавих бус, газар дээр нь очиж, нөхцөл байдалтай танилцах, бүрдүүлсэн материалд тулган баталгаажуулалт хийж, тоон мэдээллийн зөрүүг арилгах арга хэмжээг шуурхай зохион байгуулж, үр дүнг тооцох шаардлагатай байна.

5. ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, аудитын үр дүнд суурилан Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаанд цагдаагийн байгууллагаас хяналт тавих үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр аудитын багаас дараах зөвлөмжийг холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлж байна. Үүнд:

5.1 Цахим сангийн мэдээллийг цэгцэлж, зөвхөн баталгаажсан төлөвт шилжсэн хуулийн этгээдүүдийн мэдээллийг үндэслэн бусад төлөвт байгаа гэрээт харуул хамгаалалтын байгууллагуудын үйл ажиллагаанд хэсэгчилсэн шалгалт зохион байгуулж, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг 2019 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн дотор Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст ирүүлэх /НХЖХГ, БХТ, НЦГ, МТХТ/;

5.2 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2008 оны 126 дугаар тушаалаар баталсан “Гэрээт харуул хамгаалалтын байгууллагын алба хаагчдын дүрэмт хувцасны загвар, өнгө, материалын ялгаа, дүрэмт хувцас өмсөж хэрэглэх журам”-ын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдүүдээс санал авч, журмын төслийг шинэчлэн боловсруулж, Хуулийн хэлтсээр хянуулан Цагдаагийн ерөнхий газрын даргаар батлуулах /ТЗБХ, ХХ,

НХЖХГ, БХТ, НЦГ, Говьсүмбэр, Сэлэнгэ, Баянхонгор, Баян-Өлгий, Орхон, Дархан-Уул, Төв, Дорнод, Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газар/;

5.3 Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 10.1 дэх заалтын хэрэгжилтийг хангахын тулд харуул хамгаалалтын үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах болон мэргэжил дээшлүүлэх сургалтыг Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс хариуцаж зохион байгуулах /СААА, ЦДЦСНТ, НХЖХГ/;

5.4 Цахим санд оруулж байгаа мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хянах үүрэг бүхий нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нийтийн хэв журам хамгаалах нэгжийн ахлах байцаагч, Бүртгэл хяналтын төвийн уг сангийн ашиглалтыг хариуцсан ахлах мэргэжилтэн, Нийтийн хэв журам хамгаалах газрын гэрээт харуул хамгаалалт хариуцсан ахлах мэргэжилтэн нарыг оролцуулсан “Ажлын хэсэг” байгуулж, гэрээт харуул хамгаалалтын байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн хяналт тавих бус, газар дээр нь очиж, нөхцөл байдалтай танилцан, бүрдүүлсэн материалд тулган баталгаажуулалт хийж, тоон мэдээллийн зөрүүг арилгах арга хэмжээг шуурхай зохион байгуулж, үр дүнг 2019 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн дотор Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст ирүүлэх /НХЖХГ, БХТ, НЦГ, МТХТ/;

5.5 Цагдаагийн байгууллагаас гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаанд тавих хяналтын үр дүнг үнэлэх */Дүгнэлтийн 1 дэх хэсэгт дурдсан/* шалгуур үзүүлэлтийн тоон мэдээллийг цахим санд оруулах, бүртгэх асуудлыг шийдвэрлэх /НХЖХГ, БХТ, НЦГ, МТХТ/;

5.6 Зөвлөмжийн биелэлтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг 2019 оны 10 дугаар сарын 10-ны дотор Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст ирүүлэх.

6.УДИРДЛАГЫН ТАЙЛБАР

Аудитын урьдчилсан тайлантай холбогдуулан НХЖХОНАБХА-ны Нийтийн хэв журам хамгаалах газраас “Тайланд тодорхойлон тусгах саналгүй” гэсэн “Удирдлагын тайлбар”-ыг ирүүлсэн.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2019 оны 10 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: “Эрүүл цагдаа” хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Санхүү, аж ахуйн албаны Хангамжийн хэлтэс

Аудитын объект: “Эрүүл цагдаа” хөтөлбөрийн хэрэгжилт

Аудитын төрөл: Гүйцэтгэлийн аудит

Аудитын хугацаа: 2019.09.19- 2019.10.08

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа М.Азжаргал

1. ТАНИЛЦУУЛГА

Цагдаагийн алба хаагчдын эрүүл, мэндийн байдалд үүсч болох эрсдэлийг тодорхойлох, алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээний /2017 он/ дүнд үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/135 дугаар тушаалаар “Эрүүл цагдаа” хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрийн зорилго нь Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрүүл мэндийг дэмжих, эрүүл зөв аж төрөх ёс, зан үйлийг хэвшүүлэх замаар эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл чийрэг бие бялдар, сэтгэл зүйг бэлтгэхэд чиглэгдсэн. Хөтөлбөр нь 2018 оноос 2020 он хүртэл хэрэгжинэ. Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг хүснэгтээр харьцуулалт хийж харуулбал /2017 оны үзүүлэлтийг суурь үзүүлэлтээр тооцсон/;

№	Шалгуур үзүүлэлт	Тоон мэдээлэл	2017	2018	2019.9
1	Урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр нийт бие бүрэлдэхүүний 70-аас доошгүй хувийг хамруулах.	Нийт цагдаагийн байгууллагын алба хаагчдын тоо	9872	9745	9967
		Үүнээс урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамрагдсан алба хаагчдын тоо	5471	7105	6790
		Эрүүл мэндийн мэдээллийн цахим санд шивэгдсэн алба хаагчдын тоо	2017	7052	3445
		Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаагүй алба хаагчдын тоо	3099	2629	3186

2	Ердийн болон МШӨ-нөөр өвчилсөн, хөдөлмөрийн чадвар түр алдсан алба хаагч, ажилтны нөхөн сэргээх эмчилгээнд хамруулж, эрүүл болсон алба хаагч, ажилтны тоо 10 хувиар өссөн байх.	Ердийн болон МШӨ-нөөр өвчилсөн, хөдөлмөрийн чадвар түр алдсан алба хаагч, ажилтны тоо	477	519	354
		Үүнээс нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдсан алба хаагч, ажилтны тоо	225	234	176
		Үүнээс эрүүл болсон, эдгэрсэн алба хаагч, ажилтны тоо	358	375	283
3	Үйлдвэрлэлийн ослоор гэмтсэн, амь насаа алдах тохиолдлыг жил бүр бууруулсан байх.	Үйлдвэрлэлийн ослоор гэмтсэн алба хаагчдын тоо	110	73	27
		Амь насаа алдсан алба хаагчдын тоо	4	5	6
4	Нийт бие бүрэлдэхүүний 70 буюу түүнээс дээш хувийг биеийн тамир, спорт, соён гэгээрүүлэх, сургалтын арга хэмжээнд хамруулсан байх.	Биеийн тамир, спортын арга хэмжээнд хамрагдсан алба хаагчдын тоо	45408	41607	47702
		Соён гэгээрүүлэх, сургалтын арга хэмжээнд хамрагдсан алба хаагчдын тоо	110518	125784	261641
5	Ердийн болон МШӨ-нөөр өвчилсөн, хөдөлмөрийн чадвар түр алдагдсан, гэмтэж бэртсэн алба хаагч, ажилтны рашаан, сувилалд 10 буюу түүнээс дээш хувийн хөнгөлөлттэй үнээр алба хаагчдыг хамруулсан байх.	Ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвчилсөн алба хаагчийн тоо	1023	1210	731
		Хөдөлмөрийн чадвар түр алдагдсан алба хаагчдын тоо	240	205	139
		Гэмтэж бэртсэн алба хаагчдын тоо	115	77	36
		Үүнээс рашаан, сувилалд хамруулсан алба хаагчдын тоо	497	475	347
		Үүнээс 10 буюу түүнээс дээш хувийн хөнгөлөлттэй үнээр хамрагдсан алба хаагчдын тоо	258	198	115

Хөтөлбөр баталж хэрэгжүүлснээр алба хаагч, ажилтны эрүүл мэндийн мэдлэг дээшилж, өвчлөл буурч ажлын бүтээмж нэмэгдсэн байх, урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамрагдаж, мэргэжлээс шалтгаалах өвчлөл буурсан байх, алба хаагч, ажилтны бие бялдрын хөгжил, сэтгэл зүйн чадамж сайжирч, үүрэг гүйцэтгэх чадвар дээшилсэн байх гэсэн 4 зорилтын хүрээнд 22 ажил, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Хөтөлбөрийн хэрэгжилт 2018 онд 78.0, 2019 оны эхний хагас жилийн байдлаар 81.7 хувьтай байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1.Аудитын зорилго

“Эрүүл цагдаа” хөтөлбөрийн хэрэгжилтэд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, аудитын объектыг боловсронгуй болгох, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хүргүүлж, үр дүнг тооцоход чиглэгдэнэ.

2.2 Аудитын цар хүрээ

Аудитын зорилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2018, 2019 оны эхний 9 сарын байдлаар “Эрүүл цагдаа” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний үр дүнг аудитын объектод хамруулсан.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ аудит хийгдэх нэгжийн удирдлага, алба хаагчидтай хийх уулзалт ярилцлагын удирдамж, аудитын хүрээнд шалгах мэдээлэл, түүнийг нотлох аргыг боловсруулан хэлтсийн даргаар батлуулж ашигласан.

Аудитын удирдамж, төлөвлөгөөг холбогдох нэгжийн удирдлага, алба хаагчдад танилцуулж, холбогдох эрх зүйн актуудыг судалж, шалгуур үзүүлэлтийн талаарх тоон мэдээллүүдийг Санхүү, аж ахуйн албанаас гаргуулан авч, хөтөлбөрийн үр дүнг хөтөлбөрийн 7.1-д заасан шалгуур үзүүлэлтээр үнэллээ.

Түүнчлэн аудитын нотлох баримтыг цуглуулах зорилгоор холбогдох нэгжийн алба хаагчидтай уулзалт ярилцлага зохион байгуулж, тусгай чиг үүргийн адил төстэй нэгжүүд болох Дотоод хэргийн Их сургууль, Хил хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газрын Эрүүл мэндийн төвийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаатай танилцсан.

Аудитын явцад цуглуулсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан тайлангийн төслийг бичиж, Санхүү, аж ахуйн албаны Хангамжийн хэлтэст хүргүүлэн “Удирдлагын тайлбар”-ыг авсан.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.8-д “Цагдаагийн алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ”, Эрүүл цагдаа хөтөлбөрийн 7.1-д “... жил бүр нийт бие бүрэлдэхүүний 70-аас доошгүй хувийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчилсөн, хөдөлмөрийн чадвар түр алдсан алба хаагч, ажилтныг

нөхөн сэргээх эмчилгээнд хамруулж, эрүүл болсон алба хаагч, ажилтны тоо 10 хувиар өссөн байх, нийт бие бүрэлдэхүүний 70 буюу түүнээс дээш хувийг биеийн тамир, спорт, соён гэгээрүүлэх, сургалтын арга хэмжээнд хамруулсан байх, ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчилсөн, хөдөлмөрийн чадвар түр алдсан, гэмтэж бэртсэн алба хаагч, ажилтныг рашаан сувилалд 10 буюу түүнээс дээш хувийг хөнгөлттэй үнээр хамруулсан байх” гэсэн шалгуур үзүүлэлтийг тогтоосон.

Гэтэл урьдчилан сэргийлэх үзлэгт 2017 онд нийт алба хаагчдын 55.4, 2018 онд 73.0, 2019 онд 68.1 хувь нь хамрагджээ. Үүнээс үзвэл 2019 онд шалгуур үзүүлэлт /70-аас доошгүй хувь/ хангагдаагүй байна. Алба хаагчдын эрүүл мэндийн мэдээллийг цахим санд оруулах ажлын гүйцэтгэл 2017 онд 37.0, 2018 онд 37.3, 2019 онд 92.4 хувь байгаа нь сайшаалтай байна гэж үзэв.

Цаашид алба хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах, эрүүл мэндийн мэдээллийн санг цахимжуулах, хүний нөөцийн болон нийгмийн даатгалын мэдээллийн сантай холбох асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй. Ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвчилсөн, хөдөлмөрийн чадвар түр алдсан алба хаагч, ажилтан нь 2017 онд нийт бие бүрэлдэхүүний 13.0, 2018 онд 15.0, 2019 онд 9.0 хувь болж буурчээ.

Үйлдвэрлэлийн ослоор гэмтсэн алба хаагчдын тоо 2017 онд 110, 2018 онд 73, 2019 онд 27 болж буурсан, харин амь насаа алдсан алба хаагчдын тоо 2017 онд 4, 2018 онд 5, 2019 онд 6 болж өссөн байгаа нь /амь насаа алдах тохиолдлыг жил бүр бууруулсан байх/ шалгуур үзүүлэлтийг хангаагүй байна.

Хөтөлбөрийн 6.1.3-д “...алба хаагч, ажилтны бие бялдрын хөгжил, сэтгэл зүйн чадамж сайжирна”, 6.1.4-д “...алба хаагч, ажилтны эрүүл мэнд, сэтгэл зүй сэргэж, үүрэг гүйцэтгэх чадвар дээшилнэ” гэж хүрэх үр дүнг тодорхойлсон боловч үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтийг тогтоож өгөөгүй байсан нь хөтөлбөр хэрэгжиж эхлэхээс өмнөх суурь үзүүлэлт ямар байсан, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд ямар эерэг үзүүлэлт гарсан болохыг чанарын болон тоон үзүүлэлтээр илэрхийлэх, үнэлгээ бодитой өгөх боломж хязгаарлагдмал байлаа.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл ажиллагаа, зорилгодоо хүрч байгаа эсэх, түүний үр дүн, үр нөлөөг үнэлэхэд чанарыг баталгаажуулах тоон мэдээлэл нэн чухал байдаг. Цагдаагийн байгууллагад анх орох хүсэлт гаргасан иргэдийг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах үеэс эхлэн алба хаагчийн эрүүл мэндийн талаарх тоон мэдээллийг шивж оруулах, жил бүр үзлэгт хамрагдсаны дараа мэдээллийг нэмж байх, өөрчлөлтийг хянах, дүн шинжилгээ хийх, түүний мөрөөр цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, үр дүнг тооцох, шаардагдах хөрөнгө, санхүүгийн тооцоог бодитой гаргаж, төсөвт тусгуулах зорилгоор үнэн зөв, бодитой боловсруулагдсан алба хаагчийн эрүүл мэндийн мэдээллийн цахим санг үүсгэж, ашиглалтад оруулах шаардлагатай байна.

3.2 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/135 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Эрүүл цагдаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний

биелэлт, үр дүнг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1-д заасан аргачлалаар тооцлоо.

Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн ажил, арга хэмжээний төлөвлөлт, түүний гүйцэтгэл, үр дүнг Санхүү, аж ахуйн албаны 2019 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн 6/1343 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Эрүүл цагдаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 2018, 2019 оны эхний хагас жилийн байдлаар тооцсон баримт бичигт үндэслэн үнэлгээ хийсэн.

Үнэлгээгээр 22 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 14 ажил, арга хэмжээ нь 40.0, 8 ажил арга хэмжээ нь 70.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Цаашид гүйцэтгэлийг сайжруулах шаардлагатай, зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй дараах ажил, арга хэмжээнүүд байна. Үүнд:

№	Холбогдох заалт /ажил, арга хэмжээ/	Тасалдсан заалт	Үнэлгээ /хувиар/
1	1.2.Алба хаагч, ажилтны эрүүл мэндийн мэдээллийн сантай болох	1.2.1, 1.2.2	40.0
2	1.4.Эрүүл, зөв хооллолтын талаарх мэдлэгийг дээшлүүлэх	1.4.1, 1.4.2	40.0
3	1.6.Халдварт болон халдварт бус өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт зохион байгуулах	1.6.1, 1.6.2	40.0
4	2.1.Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг болон тухайн нутаг дэвсгэрийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах	2.1.1	40.0
5	2.4.Монгол Улсад хэрэгжиж буй эрүүл мэндийн төсөл, хөтөлбөрт цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтан, тэдгээрийн ар гэрийг хамруулах талаар холбогдох эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах	2.4.1, 2.4.2	40.0
6	2.5.Ажлын байранд эрүүл ахуйн дүгнэлт гаргуулж, ажиллах орчинг сайжруулах	2.5.1, 2.5.2, 2.5.3	40.0
7	2.8.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс ажиллуулах	2.8.2, 2.8.3	40.0
8	3.1.Алба хаагч, ажилтныг амралт, сувилалд сувилуулах боломжоор хангаж, эрүүл мэндийг сэргээн засах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах	3.1.1	40.0
9	3.2.Алба хаагч, ажилтныг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрны дасгал, хөдөлгөөнийг тогтмол хийж, хэвшүүлэх	3.2.2, 3.2.3	40.0
10	3.3.Алба хаагч, ажилтны бие бялдрыг хөгжүүлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулах	3.3.2, 3.3.3	40.0

11	3.4.Биеийн тамир, спортын мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт, тэмцээн зохион байгуулах	3.4.1, 3.4.2	40.0
12	4.1.Алба хаагч, ажилтны ажил болон хувийн амьдралдаа хандах хандлага, харилцааг эерэгжүүлэх, сэтгэл зүйг засах чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх	4.1.1	40.0
13	4.2 Алба хаагч өөрийн сэтгэл зүйн онцлогийг таних, хөгжүүлэх, чадавхжуулах сургалтыг зохион байгуулах, сэтгэл зүйн төрөл бүрийн хэрэгцээт мэдээллээр хангах	4.2.1, 4.2.3	40.0
14	4.4.Сэтгэл зүйн шалтгаант асуудалтай алба хаагчдад сэтгэл зүйн зөвлөгөө өгөх	4.4.1	40.0

Жич: 40.0 хувь гэсэн үнэлгээ нь зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай гэсэн утгыг илэрхийлнэ.

Дээрх төлөвлөсөн ажил, арга хэмжээний гүйцэтгэл хангалтгүй байгаа нь хөтөлбөрийн зорилгод чиглэсэн ажил, арга хэмжээг судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн бодитой, оновчтой төлөвлөөгүй, гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу тогтмол хянаагүй, цагдаагийн алба хаагчдын эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагаанд тогтмол хяналт шинжилгээ хийж, үр дүнг тооцоогүй, алба хаагчдад зориулсан эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдлыг үнэлээгүй, эрүүл мэндийн нэгдсэн бодлого төлөвлөлт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Мэргэжлийн /Монгол Улсын Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор баталсан “Цэргийн анги, байгууллагын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа” MNS 6655:2017 стандартын хэрэгжүүлэх/ нэгж байхгүй зэргээс шалтгаалсан гэж үзэж болохоор байна.

3.3 Монгол Улсын Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор баталсан “Цэргийн анги, байгууллагын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа” MNS 6655:2017 стандартын 2-д “...цэргийн анги байгууллагад ажиллаж байгаа болон тэтгэвэр, чөлөөнд байгаа алба хаагчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг анхан шатлалд үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаанд хамаарна”, 3.2-д “... тусгайлсан байгууллага нь анхан шатлалд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх бол нэгэн адил дагаж мөрдөнө”, 9.1-д “Цэргийн анги, байгууллагын эрүүл мэндийн төв нь бүтэц, үйл ажиллагааны стандартын хэрэгжилтэд жил бүр дотоодын хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцон, чанарын ахиц гаргаж ажиллана” гэж заажээ.

Монгол Улсын Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор баталсан “Цэргийн анги байгууллагын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа” MNS 6655:2017

стандартыг нэвтрүүлэх, “Эрүүл цагдаа” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, цагдаагийн алба хаагчдын эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, эрүүл мэндийн үйлчилгээг алба хаагчдад хүртээмжтэй хүргэх, эрүүл мэндийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг хийж, гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор Санхүү, аж ахуйн албаны Хангамжийн хэлтсийн бүтцэд Эрүүл мэндийн тасаг /төв/ байгуулах хэрэгцээ шаардлага байна.

Уг тасгийг байгуулахад бүтэц, орон тоог шинээр нэмэгдүүлэх шаардлагагүй бөгөөд батлагдсан орон тоонд нийцүүлэн, Авто баазын их эмчийн 1, Нийслэлийн цагдаагийн газрын Дотоод аюулгүй байдлын хэлтсийн хөдөлмөр, аюулгүй байдал хариуцсан байцаагч, их эмчийн 1, сувилагчийн 1, ахлах сэтгэл зүйчийн 1, сэтгэл зүйчийн 3, Эргүүл хамгаалалтын газрын хөдөлмөр, аюулгүй байдал хариуцсан байцаагч, эмчийн 1, Тусгай ажиллагааны газрын хөдөлмөр, аюулгүй ажиллагааны байцаагч, эмчийн 1, Тээврийн цагдаагийн албаны хөдөлмөр хамгааллын мэргэжилтэн, их эмчийн 1 орон тоог тус тус шилжүүлэн авч, шийдвэрлэх бүрэн боломжтой гэж үзэв.

Үүний үр дүнд алба хаагчдад чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшлэх, эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлэх нэгдсэн бодлого, төлөвлөлттэй болох, гадаад болон дотоодын санхүүжилтээр хэрэгжүүлж буй эрүүл мэндийн төсөл, хөтөлбөрт алба хаагчид болон тэдгээрийн гэр бүлийг хамруулах нөхцөл бүрдэх, алба хаагчдын эрүүл мэндийн мэдээллийн цахим санг бүрдүүлж ашиглалтыг сайжруулах, эмч нарыг /нарийн мэргэжлээр/ мэргэшүүлэн чадавхижуулах, алба хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг өөрсдийн хүчээр зохион байгуулах, алба хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, түүнд тавих дотоод хяналтыг сайжруулах, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх нөхцөл боломж бүрдэх зэрэг давуу талыг бий болгохоор байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг байгууллагуудын эрүүл мэндийн нэгжийн бүтцийг харьцуулбал, Хил хамгаалах ерөнхий газар нь Санхүү, ар талын газрын бүтцэд Эрүүл мэндийн алба /албаны дарга 1, ахлах эмч 1, нарийн мэргэшсэн эмч 2, сувилагч 4/, Дотоод хэргийн Их сургууль нь Санхүү, хангамж үйлчилгээний газрын бүтцэд Эрүүл мэндийн төв /дарга 1, арга зүйч 1, их эмч 3, сувилагч 2/-ийг Монгол Улсын Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор баталсан “Цэргийн анги байгууллагын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа” MNS 6655:2017 стандартын дагуу байгуулж, алба хаагчиддаа эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлж байна. Онцгой байдлын ерөнхий газар нь Санхүү, ар талын газрын бүтцэд эрүүл мэндийн тасгийг /дарга 1, хүний их эмч 1, сэтгэл зүйч 1/ байгуулсан байна.

4. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн “Эрүүл цагдаа” хөтөлбөрийн хэрэгжилтийг 51.0 хувь гэж үнэлэв. Цаашид илэрсэн асуудалтай холбогдуулан дараах сайжруулалтыг хийх шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

4.1 “Эрүүл цагдаа” хөтөлбөрийн 7.1-д заасан шалгуур үзүүлэлтээр хөтөлбөрийн хэрэгжилтийг тооцоход хөтөлбөр хэрэгжиж эхлэсэн үеэс өмнөх суурь үзүүлэлт, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын үнэлгээ, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд бий болсон эерэг өөрчлөлтийг тодорхойлох чанарын болон тоон мэдээлэл, нотлох баримтууд хангалтгүй байсан учир дахин харьяа нэгжүүдээс тоон мэдээллүүдийг цуглуулж, баталгаажуулан авсан болно.

Цагдаагийн байгууллагад анх орох хүсэлт гаргасан иргэдийг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах үеэс эхлэн алба хаагчийн эрүүл мэндийн талаарх тоон мэдээллийг шивж оруулах, жил бүр үзлэгт хамрагдсаны дараа мэдээллийг нэмж байх, өөрчлөлтийг хянаж дүн шинжилгээ хийх, түүний мөрөөр цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг төлөвлөх, үр дүнг тооцох, шаардагдах хөрөнгө, санхүүгийн тооцоог бодитой гаргаж, төсөвт тусгуулах зорилгоор үнэн зөв, бодитой боловсруулагдсан алба хаагчийн эрүүл мэндийн мэдээллийн цахим санг үүсгэж, ашиглалтад оруулах шаардлагатай байна.

4.2 Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг Санхүү, аж ахуйн албаны 2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 6/1343 дугаартай албан бичгээр ирүүлсэн 2018, 2019 оны эхний хагас жилийн байдлаар “Эрүүл цагдаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг тооцсон баримт бичигт үндэслэн Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1-д заасан аргачлалаар тооцож үзэхэд, нийт 22 ажил, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 14 ажил, арга хэмжээ нь 40.0, 8 ажил арга хэмжээ нь 70.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хөтөлбөрийн зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг хангаагүй 14 ажил, арга хэмжээ байгаа нь хөтөлбөрийн зорилгод чиглэсэн ажил, арга хэмжээг судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн бодитой, оновчтой төлөвлөөгүй, гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу тогтмол хянаагүй, цагдаагийн алба хаагчдын эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагаанд тогтмол хяналт шинжилгээ хийж, үр дүнг тооцоогүй, алба хаагчдад зориулсан эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдлыг үнэлээгүй, эрүүл мэндийн нэгдсэн бодлого төлөвлөлт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий мэргэжлийн /Монгол Улсын Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор баталсан “Цэргийн анги байгууллагын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа” MNS 6655:2017 стандартын хэрэгжүүлэх/ нэгж байхгүй зэргээс шалтгаалсан байна.

4.3 Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг байгууллагууд Монгол Улсын Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор баталсан “Цэргийн анги байгууллагын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа” MNS 6655:2017 стандартыг нэвтрүүлж, Хил хамгаалах ерөнхий газар нь Санхүү, ар талын газрын бүтцэд Эрүүл мэндийн алба, Дотоод хэргийн Их сургууль нь Санхүү, хангамж үйлчилгээний газрын бүтцэд Эрүүл мэндийн төв, Онцгой байдлын ерөнхий газар нь Санхүү, ар талын газрын бүтцэд Эрүүл мэндийн тасгийг тус тус байгуулан алба хаагчиддаа эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж, үйл ажиллагааг нь хэвшүүлсэн байна.

Иймд дээрх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны Хангамжийн хэлтсийн бүтцэд Эрүүл мэндийн төв/тасаг/-ийг байгуулахад бүтэц, шинээр орон тоо шаардлагагүй бөгөөд батлагдсан орон тоонд нийцүүлэн Авто баазын их эмчийн 1, Нийслэлийн цагдаагийн газрын Дотоод аюулгүй байдлын хэлтсийн хөдөлмөр, аюулгүй байдал хариуцсан байцаагч, их эмчийн 1, сувилагчийн 1, ахлах сэтгэл зүйчийн 1, сэтгэл зүйчийн 3, Эргүүл хамгаалалтын газрын хөдөлмөр, аюулгүй байдал хариуцсан байцаагч, эмчийн 1, Тусгай ажиллагааны газрын хөдөлмөр, аюулгүй ажиллагааны байцаагч, эмчийн 1, Тээврийн цагдаагийн албаны хөдөлмөр хамгааллын мэргэжилтэн, их эмчийн 1 нийт 10 орон тоог тус тус шилжүүлэн авч, шийдвэрлэх бүрэн боломжтой гэж үзэхээр байна.

Эрүүл мэндийн /төв/ тасаг байгуулагдсанаар алба хаагчдад чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшлэх, эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлэх нэгдсэн бодлого, төлөвлөлттэй болох, гадаад болон дотоодын санхүүжилтээр хэрэгжүүлж буй эрүүл мэндийн төсөл, хөтөлбөрт алба хаагчид болон тэдгээрийн гэр бүлийг хамруулах нөхцөл бүрдэх, алба хаагчдын эрүүл мэндийн мэдээллийн цахим санг бүрдүүлж, ашиглалтыг сайжруулах, эмч нарыг /нарийн мэргэжлээр/ мэргэшүүлэн чадавхижуулах, алба хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг өөрсдийн хүчээр зохион байгуулах, алба хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, дотоод хяналтыг сайжруулах, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх нөхцөл боломж бүрдэх зэрэг ач холбогдолтой юм.

5. ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, аудитын үр дүнд суурилан “Эрүүл цагдаа” хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр холбогдох нэгж, албан тушаалтанд аудитын багаас дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

5.1 Цагдаагийн байгууллагад анх орох хүсэлт гаргасан иргэдийг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах үеэс эхлэн алба хаагчийн эрүүл мэндийн талаарх нэгж, тоон мэдээллийг шивж оруулах, жил бүр үзлэгт хамрагдсаны дараа мэдээллийг нэмж байх, өөрчлөлтийг хянаж

дүн шинжилгээ хийх, түүний мөрөөр цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг төлөвлөх, үр дүнг тооцох, шаардагдах хөрөнгө, санхүүгийн тооцоог бодитой гаргаж, төсөвт тусгуулах зорилгоор үнэн зөв, бодитой боловсруулагдсан алба хаагчийн эрүүл мэндийн мэдээллийн цахим санг үүсгэж, ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулж, дүнг 2019 оны 12 дугаар сарын 25-ны дотор Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж, хэрэгжилтийн тайланг ирүүлэх /CAAA, МДШШУА/;

5.2 Хөтөлбөрийн зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг хангаагүй 14 ажил, арга хэмжээний гүйцэтгэлд улирал бүр явцын хяналт шинжилгээ хийж, дүнг улирал бүрийн эхний сарын 10-ны /хөтөлбөр хэрэгжих хугацаанд/ дотор Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст ирүүлж байх /CAAA/;

5.3 Монгол Улсын Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор баталсан “Цэргийн анги байгууллагын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа” MNS 6655:2017 стандартыг нэвтрүүлэх, “Эрүүл цагдаа” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, цагдаагийн алба хаагчдын эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, эрүүл мэндийн үйлчилгээг алба хаагчдад хүртээмжтэй хүргэх, эрүүл мэндийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг хийж, гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор Санхүү, аж ахуйн албаны Хангамжийн хэлтсийн бүтцэд Эрүүл мэндийн төв/тасаг/ байгуулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /CAAA, ХНХ/;

5.4 Зөвлөмжийн заалт нэг бүрийг хангах талаар зохион байгуулалтын идэвхтэй арга хэмжээ авч, дүнг 2019 оны 12 дугаар сарын 25-ны дотор Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст ирүүлэх /CAAA, МДШШУА, ХНХ/.

6. УДИРДЛАГЫН ТАЙЛБАР

Аудитын тайлантай холбогдуулан холбогдох нэгжүүдээс “Удирдлагын тайлбар”-ыг авахад, зөвлөмжийг бүрэн дэмжсэн болно. /Удирдлагын тайлбаруудыг хавсаргав/

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2019 оны 08 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Аймаг дахь цагдаагийн газар, хэлтсээс архивын баримтыг цахимжуулах үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Аймаг дахь цагдаагийн газар, хэлтэс

Аудитын төрөл, код: Үйл ажиллагааны аудит, төлөвлөгөөт бус

Аудитын хугацаа: 2019.08.10- 2019.08.30

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх

1. ТАНИЛЦУУЛГА

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгтэй холбогдуулан Төв архиваас 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 23/849 дугаарын албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу аймаг дахь цагдаагийн газар, хэлтсээс архивын баримтаа цахимжуулж буй байдалд дотоод аудит хийлээ.

Төв архивын нэгтгэсэн мэдээллээс үзвэл аймаг дахь, цагдаагийн газар хэлтсүүдэд дунджаар 2013 оноос хойшхи архивын баримтууд хадгалагдаж байгаа /Хавсралт 1/ бөгөөд Увс аймаг дахь цагдаагийн газарт 2009 оноос хойшхи архивын баримт нь хадгалагдаж байна.

Аудитын хүрээнд аймаг дахь цагдаагийн газар, хэлтэст эхний ээлжинд цахимжуулсан байвал зохих байгууллагын даргын тушаал, зөвлөлийн хурлын тэмдэглэл, байгууллагын төлөвлөгөө, түүний биелэлт, тайлан, ирсэн, явсан бичгийн бүртгэл зэрэг 7 төрлийн баримтын цахимжуулалтын талаарх мэдээллийг авч нэгтгэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Байгууллагын даргын тушаалыг цахимжуулсан байдал 88 хувь,
- Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийг цахимжуулсан байдал 49 хувь,
- Байгууллагын төлөвлөгөө, түүний биелэлт, тайланг цахимжуулсан байдал 47 хувь,
- Байгууллагын ирсэн, явсан бичгийн бүртгэлийг цахимжуулсан байдал 27 хувь гэсэн дундаж үзүүлэлттэй байна /Хавсралт 2/.

2. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

Аймаг дахь цагдаагийн газар, хэлтсүүд байгууллагын даргын тушаалыг нийтлэг байдлаар цахимжуулсан нь сайшаалтай ч бусад баримт бичгийг цахимжуулах явц хангалтгүй байна. Тухайлбал, Булган, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Хэнтий аймаг дахь цагдаагийн газар, хэлтэс нь байгууллагын даргын тушаалаас бусад баримт бичгийг цахимжуулаагүй, Архангай, Увс аймаг дахь цагдаагийн газруудад уг ажлыг огт эхлүүлээгүй байна.

3. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Цаашид төрийн архивыг цахимжуулах талаарх төрийн бодлогын хүрээнд цагдаагийн байгууллагын архивыг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх, энэ чиглэлээр зохих сургалтыг зохион байгуулж, үүрэг, зааварчлагыг тогтмол хүргүүлж ажиллахыг Төв архивт даалган, энэхүү аудитаар цугларсан мэдээллийг хүргүүлэх саналтай байгааг илтгэн танилцуулья.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

**АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН
АРХИВЫН БАРИМТЫН ТОО ХЭМЖЭЭ**

2019.08.29

Улаанбаатар хот

д/д	Хөмрөгийн нэр	Х№	Төв архивт хадгалагдаж байгаа баримтын оны хязгаар	Тухайн байгууллагад байгаа баримтын оны хязгаар
1	Архангай аймаг дахь цагдаагийн газар	29	1991-2015	2016-2019
2	Баян-Өлгий аймаг дахь цагдаагийн газар	24	1991-2014	2015-2019
3	Баянхонгор аймаг дахь цагдаагийн газар	8	1990-2012	2013-2019
4	Булган аймаг дахь цагдаагийн газар	17	1991-2014	2015-2019
5	Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газар	7	1990-2013	2014-2019
6	Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс	38	1991-2013	2014-2019
7	Дархан-Уул аймаг дахь цагдаагийн газар	41	1990-2012	2013-2019
8	Дорноговь аймаг дахь цагдаагийн газар	42	1990-2012	2013-2019
9	Дорнод аймаг дахь цагдаагийн газар	12	1990-2013	2014-2019
10	Дундговь аймаг дахь цагдаагийн газар	28	1990-2012	2013-2019
11	Завхан аймаг дахь цагдаагийн газар	1	1990-2015	2016-2019
12	Орхон аймаг дахь цагдаагийн газар	51	1990-2015	2016-2019
13	Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газар	9	1990-2015	2016-2019
14	Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар	13	1991-2013	2014-2019
15	Увс аймаг дахь цагдаагийн газар	33	1990-2008	2009-2019
16	Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газар	40	1990-2013	2014-2019
17	Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газар	2	1990-2012	2013-2019
18	Ховд аймаг дахь цагдаагийн газар	37	1990-2014	2015-2019
19	Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газар	22	1991-2012	2013-2019
20	Хэнтий аймаг дахь цагдаагийн газар	35	1991-2013	2014-2019
21	Төв аймаг дахь цагдаагийн газар	32	1990-2015	2016-2019

Хавсралт 2

**АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР, ХЭЛТСИЙН АРХИВЫН ЗАРИМ
БАРИМТЫГ ЦАХИМЖУУЛСАН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

2019.08.29

Улаанбаатар хот

д/д	Бичиг баримтын нэр	Архивын баримтыг цахимжуулсан байдал /хувиар/																							
		Архангай	Баян-Өлгий	Баянхонгор	Булган	Говь-Алтай	Говьсүмбэр	Дархан-Уул	Дорноговь	Дорнод	Дундговь	Завхан	Орхон	Өвөрхангай	Өмнөговь	Увс	Сүхбаатар	Сэлэнгэ	Ховд	Хөвсгөл	Хэнтий	Төв	Дундаж хувь		
1	Байгууллагын даргын тушаал /А/	0	100	100	100	100	100	100	100	27	100	100	100	100	100	0	100	100	100	100	100	100	100	100	87
2	Байгууллагын даргын тушаал /Б/	0	100	100	100	100	100	100	100	43	100	100	100	100	100	0	100	100	100	100	100	100	100	100	88
3	Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл	0	36	100	0	68	0	100	100	0	0	100	100	0	0	0	78	48	100	100	100	0	100	100	49
4	Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө	0	100	0	100	81	0	100	100	0	0	100	100	0	0	0	0	68	100	100	100	0	100	100	50
5	Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	0	100	100	0	79	0	100	100	0	0	100	100	0	0	0	80	68	100	100	100	0	100	100	49
6	Жилийн үйл ажиллагааны тайлан	0	0	0	0	100	0	100	100	0	0	100	100	0	0	0	60	50	100	100	100	0	100	100	43
7	Ирсэн, явсан бичгийн бүртгэл	0	0	0	0	73	0	100	100	0	0	25	100	0	0	0	0	63	100	100	100	0	100	100	27
Дундаж хувь		0	62	57	43	86	28	100	100	10	28	89	100	28	28	0	60	71	100	100	71	28	86	56	

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2020 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцасны хангалт, хүрэлцээ, эдэлгээ, хугацаа, тооцоо хийж буй байдалд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага

Аудитын объект: Дүрэмт хувцасны хангалт, хүрэлцээ, эдэлгээ, хугацаа, тооцоо хийж буй байдал

Аудитын төрөл: Санхүүгийн аудит

Аудитын хугацаа: 2019.05.20-2019.08.16

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа С.Март, цагдаагийн хошууч Ц.Болормаа

1. ТАНИЛЦУУЛГА

Аудитын асуудлын шинжилгээ хийх, нотолгоо цуглуулах зорилгоор Тээврийн цагдаагийн алба, Эргүүл хамгаалалтын газар, Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, Завхан, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар, Сонгинохайрхан, Баянгол дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэс зэрэг нэгжүүдийн алба хаагчдын санал, сэтгэгдлийг тодруулах судалгааг 470 алба хаагчийг хамруулан хийсэн. Судалгаанд социологийн шалгуур үзүүлэлтээр ажиллах нөхцөл, нас хүйс, ажилласан жил зэрэг олон талаас нь харахыг зорилоо.

Цагдаагийн ерөнхий газрын Хангалт, үйлчилгээний төвөөс 2019 оны 6 дугаар сарын 20-ны байдлаар ирүүлсэн мэдээгээр цагдаагийн албанаас халагдсан, чөлөөлөгдсөн алба хаагчийн 342,1 сая, цагдаа, дотоодын цэргийн 72 анги, байгууллагаас ирүүлсэн мэдээллийг нэгтгэхэд 295,0 сая төгрөгийн эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт болон ажлын хувцасны төлбөртэй байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын алба хаагчдыг ажилд томилж, чөлөөлж, өөрчилсөн тушаалыг Хүний нөөцийн хэлтсээс Санхүү, аж ахуйн албанд, Санхүү, аж ахуйн албанаас Хангалт, үйлчилгээний төвд хүргүүлдэг бөгөөд энэ оны 06 дугаар сарын 20-ны байдлаар хүний нөөцийн шилжилт хөдөлгөөний тушаалуудад тулгалт хийхэд Санхүү, аж ахуйн албанаас Хангалт, үйлчилгээний төвд 135 тушаал хүргүүлж, Хангалт, үйлчилгээний төв нь 145 тушаалаар нормт хувцас хангалтын програмд шилжилт хөдөлгөөн хийжээ.

Хангалт, үйлчилгээний төв нь албанаас халагдсан, чөлөөлөгдсөн алба хаагчийн эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт болон ажлын хувцасны төлбөр тооцоог хийхдээ офицер бүрэлдэхүүний тушаалыг Санхүү, аж ахуйн алба, ахлагч бүрэлдэхүүний тушаалыг тухайн нэгжээс мэдээлэл ирүүлсэн тохиолдолд нормт хувцас хангалтын програмд шивж байна.

Хүний нөөцийн хэлтсийн тайлангаас үзэхэд /2019 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар/ цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд бүтцийн өөрчлөлтөөр 472, шилжүүлэн болон зохицуулан томилсон 317, цагдаагаас офицер бүрэлдэхүүнд 134, нөөцөөс офицер, дадлагажих ажилтнаар 9, хүүхэд асрах чөлөө цуцалсан 21, албан тушаал дэвшүүлэн томилсон 167, төрийн өөр байгууллагаас шилжүүлэн буюу сэлгэн томилсон 8, шууд томилсон 2, шүүхийн шийдвэрээр 3, Тусгай ажиллагааны газрын цагдаагаар 166 алба хаагчийг тус тус томилжээ.

Шинээр томилогдсон 188 алба хаагч дүрэмт хувцасны бүрэн хангалт авах, сэлгэн болон өөрчлөгдөн томилогдсон 1299 алба хаагч тодорхой хэмжээний хангалт авахаар байна.

Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсийн сангаас авсан мэдээллээр /энэ оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар/ цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас 391 алба хаагч, ажилтан халагдаж, чөлөөлөгдсөнөөс 345 нь цагдаа, цэргийн цолтой алба хаагч, 46 нь энгийн ажилтан байна.

Албанаас халагдаж, чөлөөлөгдсөн цагдаа, цэргийн цолтой 345 алба хаагчаас 177 нь эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт болон ажлын хувцасны төлбөр төлөхөөр, “Дүрэмт хувцас өмсөж хэрэглэх /код 917/ журам”-ын 917.9.4-д заасны дагуу эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт болон ажлын хувцасны төлбөр төлөхгүй шалтгаанаар 168 алба хаагч халагдаж, чөлөөлөгджээ.

Эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт болон ажлын хувцасны төлбөр төлөхгүй шалтгаанаар нийт алба хаагчдын 49 хувь нь халагдаж, чөлөөлөгдөж байгаа бөгөөд үүнээс тэтгэвэр тогтоолгосон 77, нас барсан 5, хөдөлмөрийн чадвар алдсан 3, төрийн бусад байгууллагад шилжсэн 30, ажил олгогчийн санаачилгаар 2, хүүхэд асрах чөлөө авсан 51 алба хаагч байна.

1.1 Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцасны тооцоо хийж буй байдал:

Хангалт, үйлчилгээний төвөөс эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт болон ажлын хувцасны төлбөр тооцооны мэдээг авч үзэхэд цагдаа, дотоодын цэргийн 55 анги, байгууллагын 703 алба хаагчтай холбоотой 342.0 сая төгрөгийн төлбөр, цагдаа, дотоодын цэргийн 58 анги, байгууллагаас аудитын явцад ирүүлсэн мэдээллийг нэгтгэхэд 614 алба хаагчтай холбоотой 295.0 сая төгрөгийн төлбөрийн үлдэгдэлтэй дүн гарч байна. Бэлтгэж байгаа дүрэмт хувцасны үнэлгээ өссөнөөс шалтгаалан нэг алба хаагчийн эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт хувцасны төлбөрийн хэмжээ өсч, энэ хэмжээгээрээ нийт өр төлбөр нэмэгдсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын Хангалт, үйлчилгээний төвийн үйл ажиллагаанд “Нормт хувцас хангалтын программ”-ыг 2014 оноос ашиглаж эхэлжээ.

“Нормт хувцас хангалтын программ” нь хувцас хангалтын мэргэжилтний ажлын ачааллыг хөнгөвчилж байгаа хэдий ч уг программыг нэвтрүүлснээс хойш хөгжүүлэлт хийгдээгүй, Хүний нөөцийн сангийн мэдээлэлтэй холбогдоогүй, дүрэмт хувцасны эдэлгээний хугацаа нь 50 хувиас хэтэрсэн тохиолдолд болон дараагийн цол олгогдсон байхад өмнөх цолны мөрдэсний төлбөрийг программаар шууд хасах боломжгүй, гар ажиллагаагаар тооцоолол хийдэг, байгууллагын өр төлбөрийн нэгдсэн мэдээллийг программаас авч ашиглах боломжгүй байна. Энэ нь уг программыг зайлшгүй сайжруулах шаардлага байгааг харуулж байна.

1.2 Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцасны хангалт, хүрэлцээ:

Засгийн газрын 2017 оны 155 дугаар тогтоолоор баталсан 47 нэр төрлийн дүрэмт хувцсаар цагдаагийн нэг алба хаагчийг бүрэн хангахад 3,1 сая, нийт бүрэлдэхүүнийг хангахад 32,9 тэрбум, Засгийн газрын 2017 оны 286 дугаар тогтоолоор баталсан 38 нэр төрлийн дүрэмт хувцсаар дотоодын цэргийн нэг алба хаагчийг бүрэн хангахад 2,6 сая, нийт бүрэлдэхүүнийг хангахад 3,4 тэрбум төгрөг шаардагдахаар байна.

Үүнийг жилээр тооцоход цагдаагийн нэг алба хаагчийн дүрэмт хувцасны зардалд дунджаар 1,2 сая, нийт 11.6 тэрбум, дотоодын цэргийн нэг алба хаагчийн дүрэмт хувцасны зардалд дунджаар 0,934 сая, нийт 1,2 тэрбум төгрөг болж байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар халагдаж, чөлөөлөгдсөн цолтой 345 алба хаагчаас 168 /цагдаагийн цолтой 157, цэргийн цолтой 11/ алба хаагч ямар нэгэн төлбөр төлөхгүй шалтгаанаар халагдаж, чөлөөлөгдөж байгааг Засгийн газрын 2017 оны 155 дугаар тогтоолын дагуу цагдаагийн нэг жилд шаардагдах төсвөөр тооцоход /1.091.031*157 алба хаагч=171.291.867/ 171,3 сая, Засгийн газрын 2017 оны 286 дугаар тогтоолын дагуу дотоодын цэргийн нэг алба хаагчид шаардагдах төсвөөр тооцоход /1.009.758* 11 алба хаагч =11.107.338/ 11,1 сая, нийт 182.4 сая төгрөг болж байна. Энэ хэмжээгээр дүрэмт хувцсыг дахин шинээр нэмж бэлтгэх хэрэгцээ бий болж байна.

Цагдаа, цэргийн цолтой төлбөр төлөх шалтгаанаар албанаас халагдаж, чөлөөлөгдөж байгаа 177 /цагдаагийн 168, цэргийн 9/ алба хаагчийн дүрэмт хувцасны тооцоог Засгийн газрын 2017 оны 155 дугаар тогтоолын дагуу цагдаагийн цолтой алба хаагчийн нэг жилд шаардагдах төсвөөр тооцоход /1.091.031*168/ 183.293.208/ 183,3 сая, цэргийн цолтой алба хаагчийн дүрэмт хувцасны тооцоог Засгийн газрын 2017 оны 286 дугаар тогтоолын дагуу дотоодын цэргийн нэг алба хаагчид шаардагдах төсвөөр тооцоход /1.009.758*9 алба хаагч=9.087.822/ 9,1 сая, нийт 192.4 сая төгрөгийн төлбөр үүсэх тооцоо гарч байна.

Дээрх хугацаанд Хангалт, үйлчилгээний төвийн Төрийн сан дахь дансанд 33,5 сая төгрөг тушаагдсан, 40,9 сая төгрөгийн төлбөрийг хувцсаар барагдуулсан, зөрүү 118,8 сая төгрөг нь тайлант хугацааны өр төлбөрөөр тооцогдохоор байна.

1.3 Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцасны эдэлгээ, чанар:

Санхүү, аж ахуйн албаны Хангалт, үйлчилгээний төвийн үйл ажиллагааны талаар 2019 оны 4 дүгээр сард хэрэглэгч 5 байгууллагаас авсан санал, асуулгын дүнг үндэслэн эрсдэлийн үнэлгээ хийж, ач холбогдлоор нь эрэмбэлж үзэхэд албаны хэрэгцээнд олгогдож байгаа хувцасны эдэлгээ, чанар хангалтгүй байх /цэнхэр цамц, хээрийн китель өмд/, одоо мөрдөгдөж байгаа хангалт хоорондын хугацаа, давтамж нь хувцасны эдэлгээ чанарт нийцэхгүй байгаа /парад хувцас, цагаан цамц/, албаны хувцсыг хугацаандаа авч чадахгүй байгаа /парад хувцас, цэнхэр цамц, хээрийн хувцас/ нь хамгийн их баталгаа өгөх эрсдэлтэй асуудал гэж үнэлэгдлээ.

Аудитын хугацаанд хамрах хүрээг өргөтгөн алба хаагчийн дүрэмт хувцасны эдэлгээ, хангалт, хүрэлцээ, чанарын талаар цагдаа, дотоодын цэргийн нийт анги, байгууллагаас санал, асуулга авч, эрсдэлийн үнэлгээ хийж, ач холбогдлоор нь эрэмбэлж үзэхэд албаны хэрэгцээнд олгогдож байгаа хувцасны эдэлгээ, чанар хангалтгүй /цэнхэр цамц, поло цамц, хээрийн китель өмд/, олгосон хувцасны хэмжээ таардаггүй, албаны хувцсыг хугацаандаа авч чаддаггүй, хувцасны материалын чанар муу /цэнхэр цамц, хээрийн китель, өмд, поло цамц/ байгаа нь хамгийн их баталгаа өгөх, хувцасны өнгө амархан ганддаг, сунадаг, бөөсөрдөг, индүүдлэг авдаггүй, хувиасаа мөнгө гаргаж хувцас хийлгэдэг, хангалт бүрэн хийгддэггүй зэрэг нь ердийн баталгаа өгөх эрсдэлтэй асуудлаар үнэлэгдлээ.

1.4 Цагдаагийн алба хаагчдын дүрэмт хувцас, ялгах тэмдэг, материалыг бэлтгэн нийлүүлэх, гүйцэтгэчийг сонгох ажиллагааны зохион байгуулалт:

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/15 дугаар тушаалаар “Улсын төсвийн хөрөнгөөр цагдаагийн алба хаагчдын хэрэгцээт дүрэмт хувцас, ялгах тэмдэг, материалыг шууд гэрээ байгуулж, бэлтгэн нийлүүлэх, гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүн”-ийг, мөн даргын 2019 оны А/16 дугаар тушаалаар “Дотоодын цэргийн алба хаагчдын хэрэгцээт дүрэмт хувцас, ялгах тэмдэг, материалыг шууд гэрээ байгуулж, бэлтгэн нийлүүлэх гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүн”-ийг тус тус байгуулжээ.

Цагдаагийн ерөнхий газрын Дэд дарга цагдаагийн алба хаагчдын хэрэгцээт дүрэмт хувцас, ялгах тэмдэг, материалыг шууд гэрээ байгуулж, бэлтгэн нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах үнэлгээний хорооны даргаар, Дотоодын цэргийн штабын дарга дотоодын цэргийн алба хаагчдын хэрэгцээт дүрэмт хувцас, ялгах тэмдэг, материалыг шууд гэрээ байгуулж, бэлтгэн нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах үнэлгээний хорооны даргаар тус тус ажиллаж байна.

Тэгвэл “Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор баталсан Хууль зүй, дотоод хэрэг, хууль сахиулах салбарын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтын 11-т дотоодын цэргийн алба хаагчдын хэрэгцээт дүрэмт хувцас, ялгах тэмдэг, материалын нөөц, нөхөн хангах, тооцоо төсөв нь нууцад хамаарна...” гэсэн лавлагааг Тагнуулын ерөнхий газраас 2019 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 01/44 дүгээр албан бичгээр ирүүлсэн байхад дотоодын цэргийн алба хаагчдын хэрэгцээт дүрэмт хувцас, ялгах тэмдэг, материалыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-иар шууд гэрээ байгуулах аргаар бэлтгэн нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/223 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааны 2019 оны ерөнхий төлөвлөгөөг баталжээ. Улсын төсвийн хөрөнгөөр бэлтгэх цагдаагийн алба хаагчдын дүрэмт хувцас, ялгах тэмдэг, материалыг бэлтгэн нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгох ажлыг зохион байгуулах үнэлгээний хорооны хурлыг энэ оны эхний хагас жилд 4 удаа зохион байгуулсан байна.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-д босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа ажил, үйлчилгээг худалдан авахад хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээр заажээ.

“Дүрэмт хувцас өмсөж, хэрэглэх /код 917/ журам”-д нөөцөд байх хувцасны хэмжээг зуутын хуваарьт шилжүүлснээр 5-10 хувь байхаар тогтоосон боловч төсөв хүрэлцдэггүйгээс шалтгаалан Хангалт, үйлчилгээний төвийн агуулахад 11 нэр төрлийн, 27,0 сая төгрөгийн өртөг бүхий 520 ширхэг дүрэмт хувцасны нөөцтэй байгаа нь нөөцөд байх хэмжээг хангаж чадахгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 155 дугаар тогтоолоор баталсан “Цагдаагийн алба хаагчийн дүрэмт хувцасны загвар, түүний эдэлгээний хугацаа, цагдаагийн алба хаагчид дүрэмт хувцасны мөнгөн хангамж олгох журам”-аар поло цамцны өнгийг “хар хөх” өнгөтэй байхаар баталсан байхад “цэнхэр” өнгийн поло цамцыг бэлтгэж, цагдаагийн алба хаагчийн хувцас хангалтад олгосон нь дээрх журмыг зөрчсөн гэж үзэхээр байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын төсвийн үр ашиггүй зардалд дотоод аудит хийж, удирдлагыг мэдээллээр хангах, илэрсэн зөрчил, дутагдлыг засч, сайжруулах чиглэлээр зөвлөмж өгч, дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2 Аудитын ажлын цар хүрээ

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцасны хангалт, хүрэлцээ, эдэлгээ, хугацаа, тооцоо хийж буй байдалтай холбоотой мэдээллийг аудитын объектод хамруулсан.

2.3 Аудитын зохион байгуулалт

Дотоод аудитыг хэрэгжүүлэхдээ тухайн аудит хийхэд шаардлагатай хууль, тогтоомж, дүрэм, журам, бусад холбогдох бичиг баримттай танилцан, дүрэмт хувцасны хангалт, хүрэлцээ, эдэлгээ, хугацаа, тооцоо хийж буй байдалтай холбоотой мэдээллийг авч нэгтгэн, цуглуулсан мэдээлэл дээр үндэслэн тулган баталгаажуулах, нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх аргыг ашиглан дүгнэлт хийлээ.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Дүрэмт хувцасны бэлтгэл, төлөвлөлт, сонгон шалгаруулах ажиллагаа

Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга нь ажлын чиг үүргийн хувьд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, аудит хийж, дүгнэлт гаргах эрх бүхий алба хаагчдыг удирддаг бөгөөд худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны даргаар ажиллаж байгаа нь Сангийн сайдын 2014 оны “Журам шинэчлэн батлах тухай” 111 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-д заасан худалдан авах ажиллагааны талаар мэргэшсэн байх шалгуурыг хангасан хэдий ч Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг 10,0 сая төгрөгөөр тогтоосон байхад шууд худалдан авах аргыг ашиглан 4.6 тэрбум төгрөгийн төсөвтэй цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын хэрэгцээт дүрэмт хувцас, ялгах тэмдэг, материалыг худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 3.4 “Хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэсэн заалтыг зөрчиж, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн заалтыг үндэслэн үнэлгээний хороо байгуулан, дотоодын цэргийн алба хаагчдын хэрэгцээт дүрэмт хувцас, ялгах тэмдэг, материалыг шууд гэрээ байгуулж, бэлтгэн нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулсан байна.

Цагдаагийн алба хаагчийн дүрэмт хувцасны загварыг баталсан эрх зүйн баримт бичигт өөрчлөлт ороогүй байхад батлагдсан загвараас өөр цэнхэр өнгөтэй “поло цамц” бэлтгэсэн бөгөөд цагдаагийн алба хаагчийн хувцас хангалтад уг цамцыг тавьж олгосны дараа эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулах материалыг эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна.

3.2 Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцасны төлбөр тооцоо

Хангалт, үйлчилгээний төвөөс авсан эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт болон ажлын хувцасны төлбөр тооцооны мэдээгээр цагдаа, дотоодын цэргийн 55 анги, байгууллагын 703 алба хаагч 342.0 сая төгрөгийн төлбөртэй, харин цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас ирүүлсэн мэдээгээр 614 алба хаагч 295.0 сая төгрөгийн төлбөртэй байгаа нь зөрүүтэй байна.

Хангалт, үйлчилгээний төвөөс ирүүлсэн мэдээлэл нь цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас ирүүлсэн мэдээллээс 47,7 сая төгрөгөөр зөрүүтэй, нас барсан алба хаагчтай холбоотой 1,4 сая төгрөгийн төлбөрийн хасалт хийгээгүй зэрэг нь цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байгаатай холбоотой байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцасны цахим програм ашигладаг талаар авсан асуулгад 53,8% нь “хувцас хангалтын цахим программыг мэдэхгүй” гэжээ.

Хангалт, үйлчилгээний төвийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа “Нормт хувцас хангалтын программ”-ыг 2014 онд ашиглаж эхэлснээс хойш

хөгжүүлэлт, сайжруулалт хийгдээгүйгээс зарим мэдээллийг гар аргаар боловсруулдаг, тооцоо, судалгаа хийхэд шаардлагатай мэдээллийг авах боломжгүй, “Excel” программ дээр хийж байгаа нь учир дутагдалтай байна.

3.3 Алба хаагчийн дүрэмт хувцасны хүрэлцээ, хангамж, чанар, эдэлгээ

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын дүрэмт хувцасны зардалд жилд дунджаар 12,8 тэрбум төгрөг шаардлагатай боловч сүүлийн 5 жилд 4,3-4,6 тэрбум төгрөгийн төсөв батлагдаж байна. Энэ санхүүжилтээр алба хаагчдад олгох нормын дүрэмт хувцасны хэрэгцээний 33,5-33,9 хувийг хангах боломжтой байна.

Төсвийн хүрэлцээ муу байгаагаас шалтгаалан дүрэмт хувцасны хангалт бүрэн хийдэггүй, нөөцөнд байх хувцасны хэмжээг бүрдүүлж чаддаггүй, худалдан авах ажиллагааг зохион байгуулахад хугацаа их шаардагддаг зэргээс дүрэмт хувцасны хангалтыг хугацаанд нь олгож чадахгүй байна.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын батлагдсан дүрэмт хувцсыг бүрэн бэлтгэж чадахгүй, зайлшгүй шаардлагатай цөөн нэр төрлийн хувцас, хэрэглэлээр хангаж байгаагаас өмсөж хэрэглэж байгаа хувцас нь эдэлгээний хугацаа дуусаагүй байхад хуучирч, муудаж байна.

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Хөнгөн үйлдвэрийн хөгжлийн хүрээлэнгийн итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн шинжилгээний сорилын дүнгээс үзэхэд хувцас хангалтад одоо олгож байгаа дүрэмт хувцасны материалын будгийн тогтвор, рН, бүрзийлтийн үзүүлэлтүүд харьцангуй ойролцоо, формальдегидын агууламж 4.6-74.07 мг/кг/ртт-аар, ширхэгийн бүрэлдэхүүн /хөвөн, полиэстр/ 22-35 хувиар зөрүүтэй байна.

Материалын ширхэгийн бүрэлдэхүүн нь дүрэмт хувцасны чанар, эрүүл ахуйн шалгуур хангаж буй эсэхийг харуулах гол үзүүлэлт болдог байна.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын дүрэмт хувцас хийлгэж байгаа материалын ширхэгийн бүрэлдэхүүн зөрүүтэй, чанар хангалтгүй, алба хаагчдын хэрэгцээг хангаж чадахгүй байгаа нь цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын дүрэмт хувцасны төлөвлөлт, бэлтгэл, хангалтын талаар баримтлах бодлогын баримт бичиг байхгүй, хяналт сул байгаатай холбоотой гэж үзэхээр байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцасны чанар, эдэлгээний талаар судалгаанд хамрагдсан алба хаагчийн 48,5% нь “дүрэмт хувцасны чанар, эдэлгээ хангалтгүй, хангалт хоорондын хугацаа, давтамж хангалтгүй”, 37,6 хувь нь “учир дутагдалтай” гэсэн үзүүлэлт гарсан нь материалын сонголт хийхдээ дотоодын нийлүүлэгчдийг өрсөлдүүлдэггүй, харьцуулсан аргаар сонгон шалгаруулалт хийдэггүйгээс шалтгаалсан байна.

Хангалтаар олгогдож байгаа нэг төрлийн хувцасны оёдол, эсгүүр өөр өөр байдгаас алба хаагч өөртөө тааруулж хасуулах, томсгох зэрэг хүндрэл, чирэгдэл үүсдэг байна.

Тухайлбал, цагаан, цэнхэр цамцны бичигдсэн хэмжээс ижил боловч өмсгөл өөр байгаа нь бэлтгэн нийлүүлэгчдийн хувцасны өмсгөлийн стандарт өөр өөр байдаг, жилд бэлтгэн нийлүүлэгчдээ сольдогоос шалтгаалж нэг төрлийн, ижил хэмжээтэй хувцасны өмсгөл харилцан адилгүй байна. Гламор ХХК 2018 онд ноосон цамц нийлүүлэхдээ эхний удаа дан утсаар, чанга нэхээстэй, дараагийн нийлүүлэлтээр давхар утсаар, хирами нэхээс буюу том сул нэхээстэй оёж нийлүүлсэн байгаа нь гүйцэтгэгчийн бүтээгдэхүүнд захиалагчийн тавих чанарын хяналт сул байгааг харуулж байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцасны хүрэлцээ, хангамжийн талаар авсан асуулгад 77,6% нь дүрэмт хувцасны хангалтыг нормоор заасан хугацаандаа авч чаддаггүй, 51,3% нь хувцас размер хэмжээ таараагүй гэсэн байна. Үүнээс үүдэн 73,2% нь хувиасаа мөнгө гарган дүрэмт хувцас оёулж өмсдөг байна. Санал асуулгаар цагаан цамц 282, хээрийн хүрэм, өмд 267, өдөр тутмын хүрэм, өмд 123, малгай 180, хантааз 99, ёслол амралтын хувцас 28, өмд /улаан канттай/ 22, гутал 107, савхин бээлий 80, поло футболка 3-г өөрсдийн мөнгөөрөө оёулж, хамгийн багадаа 15000-250000 орчим төгрөг зарцуулсан, сэтгэл ханамж доогуур төвшинд байгаагаа илэрхийлжээ.

2019 онд өвлийн гутал 7000, богино түрийтэй гутал 7000 ширхэг хэрэгцээтэй гэж захиалга өгсөн байтал төсөв хүрэхгүйгээс 1500 ширхэг хос гутал хийлгэсэн байна.

Энэнь хэдийгээр олон улсын жишигт нийцсэн төрөл, загварын хувцас, хэрэглэлүүд батлагдсан ч санхүүгийн чадавхитайгаа уялдуулахгүйгээр хэтэрхий олон нэр төрөлтэй учир бүрэн бэлтгэж чадахгүй, санхүүгийн хүндрэл үүссэн. Жил бүрийн төсөвт тусгагдсан зардлаар дүрэмт хувцасны хангалт бэлтгэгддэг боловч нийт алба хаагчдын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна.

Ажлын онцлогоос шалтгаалан халуун, хүйтэн нөхцөлд олон цагаар гадаа ажилладаг албадын алба хаагч нарын дүрэмт хувцас хурдан гандах, өнгө үзэмжээ алдах, амархан үжирч урагддагаас хугацаа нормдоо хүрэхгүй болдог байна. Энэ талаар Тээврийн цагдаагийн албанаас жилийн дөрвөн улиралд гудамж, замд үүрэг гүйцэтгэдэг, ажлын хүнд нөхцөлд ажилладаг алба хаагчдын дүрэмт хувцасны нормыг өөрчлөх санал ирүүлсэн. Дүрэмт хувцасны талаар дахин нарийвчлан асуулга авахад 215 алба хаагчийн 68,5% нь хээрийн хүрэм, өмд, 30,1% гутал, 27,7% нь малгай, 30,9% хантааз, 34,0% нь өдөр тутмын хүрэм, өмд, 25,5% нь цамц /цагаан, цэнхэр/, 43,6% нь өвлийн хүрэм, өмдийг өөрсдийн зардлаар худалдан авсан, цаашид эдэлгээний норм хугацааг богиносгох зайлшгүй шаардлагатай 10 нэр төрлийн хувцас хэрэглэлийг жагсаалтаар ирүүлсэн байна.

Гэтэл конторт сууж үүрэг гүйцэтгэдэг алба хаагчид хээрийн хувцас, цэнхэр цамцыг бага хэрэглэдэг тул нормын хугацаандаа хэрэглэж амжаагүй байхад дараагийн хувцас ирдэг. Эндээс зарим алба хаагчдад илүүдэж, зарим алба хаагчдад дутдаг нөхцөл байдал үүсэж байна. Иймд захиргааны чиг үүрэг бүхий алба хаагчид, шууд чиг үүргийн алба хаагчдад чиг үүргээр нь төрөлжүүлэн дүрэмт хувцасны нормыг ялгамжтай олгодог зохицуулалт хийх шаардлагатай байна. Тухайлбал: Нийтийн хэв журам хамгаалах, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэйгээс бусад алба хаагчдад ажиллах хугацаанд нь нэг удаа л агсамжийг олгодог байхаар зохицуулалт хийх шаардлагатай байна.

Аудитын явцад алба хаагчийн дүрэмт хувцасны эдэлгээ, хангалт, хүрэлцээ, чанарын талаар авсан санал асуулгын дүнгээр хувцасны материалын чанар муу, хувцасны өнгө амархан ганддаг, сунадаг, бөөсөрдөг, индүүдлэг авдаггүй гэсэн хамгийн их эрсдэлтэйгээр үнэлэгдсэн цэнхэр цамц, хээрийн китель өмд, поло цамцыг сонгон авч, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Хөнгөн үйлдвэрийн хөгжлийн хүрээлэнгийн итгэмжлэгдсэн лабораторид сорилын шинжилгээ хийлгэсэн.

Лабораториор хийлгэсэн шинжилгээний сорилын дүнгээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 143 дугаар зарлигаар албаны цэнхэр цамцны ширхэгийн бүрэлдэхүүнд хөвөн 85, полиэстр 12, суналт 3 хувь, тендер шалгаруулалтын гэрээний шалгуураар хөвөн 97, полиэстр 0, суналт 3 хувь байхаар заасан байхад ширхэгийн бүрэлдэхүүнд хөвөн 100 хувь, полиэстр 0, суналт 0 үзүүлэлттэй гарсан байна. /Хавсралт№1-ээр цэнхэр цамц, хээрийн китель өмд, поло цамцны Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Хөнгөн үйлдвэрийн хөгжлийн хүрээлэнгийн итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн сорилын шинжилгээний үзүүлэлтийг хавсаргав/.

Ширхэгийн бүрэлдэхүүнд хөвөнлөг шинж чанар давамгайлж, бусад нь бага хувьтай байгаа нь индүүдлэг авдаггүй, үрчийдэг гэх мэт нь алба хаагчид хэрэглэхэд дутагдалтай байдлыг бий болгож байна.

3.4 Хувцас хангалт хариуцсан хүний нөөц

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын хэрэгцээнд улсын төсвийн хөрөнгөөр дүрэмт хувцас, материал бэлтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааны материалаас үзэхэд Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн дүрэмт хувцас бэлтгэх, төлөвлөх, эрх зүйн орчныг сайжруулах, загвар хийц, эдэлгээний хугацааг өөрчлөх, сайжруулах, үнийн болон бусад шаардлагатай судалгааг хийж танилцуулах, хувцасны материалын чанарын хяналт хийх, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллаж, үнэлгээний хорооны шийдвэр, хурлын тэмдэглэл бичих, тендер шалгаруулалтад оролцох, бэлтгэн нийлүүлэгчийг сонгох, шаардлагатай гэрээ хэлэлцээр хийх, бараа татан авах зэрэг худалдан авах ажиллагаатай

холбоотой бүхий л үйл ажиллагаанд 1-2 алба хаагч оролцож байна.

Энэ нь нэг талаас хувцас бэлтгэл, төлөвлөлт, чанар хариуцсан алба хаагчдын ажлын ачаалал их байгаа, нөгөө талаар энэхүү хувцас бэлтгэл, төлөвлөлт, чанар хариуцсан алба хаагчдын үйл ажиллагаанаас цагдаа, дотоодын цэргийн 9551 алба хаагчийн дүрэмт хувцасны чанар, хүртээмж шалтгаалж байгааг харуулж байна.

Хувцасны бэлтгэл, төлөвлөлт, чанар технологи хариуцсан 2 алба хаагч нь албан тушаалын ангилал, зэрэглэл адилхан боловч албан тушаалын тодорхойлолтод хувцасны бэлтгэл, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн нь үйлдвэрлэлийн технологич инженер мэргэжилтэй, туршлагын хувьд цагдаагийн байгууллагад 13-аас дээш жил, үүнээс нэгжийн ахлах, түүнтэй адилтгах албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх шалгууртай, хувцасны чанар технологийн ахлах мэргэжилтэн нь оёмол бүтээгдэхүүний загвар зохион бүтээгч, технологич мэргэжилтэй, туршлагын хувьд хөнгөн, үйлдвэрлэл, хувцасны загвар зохион бүтээгч, технологийн чиглэлээр мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх шалгууртай байхаар тусгажээ.

Аж ахуйн ажилтангүй тул нийслэлийн дүүргүүдийн халагдсан, чөлөөлөгдсөн алба хаагчийн дүрэмт хувцасны төлбөр тооцоо барагдуулалт нь орон нутгаас харьцангуй сул байна.

4. ДҮГНЭЛТ

Хангалт, үйлчилгээний төвд ашиглаж байгаа нормын хувцас хангалтын программаас үзэхэд цагдаа, цэргийн цолтой нийт ■■■ алба хаагчид дүрэмт хувцасны хангалт олгож байгаагаас генерал 1, цагдаагийн ■■■, дотоодын цэргийн ■■■ тусгай ажиллагааны ■■■ алба хаагч байна.

Хүний нөөцийн сангийн мэдээллээс үзэхэд /2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар/ халагдсан, чөлөөлөгдсөн 391 алба хаагч, ажилтнаас цагдаа, цэргийн цолтой 345 алба хаагч байгаа бөгөөд алба хаагчдын 49 хувь нь эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт болон ажлын хувцасны төлбөр төлөхгүй шалтгаанаар халагдаж, чөлөөлөгджээ.

Алба хаагчдын шилжилт хөдөлгөөн харьцангуй нэмэгдэж байгаа нь шинээр болон сэлгэн, шилжүүлэн томилогдсон алба хаагчдын хувцас, хэрэгслийг нэмж бэлтгэх, хувцасны төлбөр тооцоо хийх ажиллагаанд хүндрэл учруулж байна.

Хангалт, үйлчилгээний төвөөс ирүүлсэн дүрэмт хувцасны эдэлгээний хугацааны төлбөрийн нэгдсэн мэдээллийг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас ирүүлсэн мэдээллийн нэгдсэн дүнтэй харьцуулахад 47,7 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Хүний нөөцийн хэлтэс, Санхүү, аж ахуйн алба, Хангалт, үйлчилгээний төвийн ажлын уялдаа холбоо хангалтгүй, хүний нөөцийн шилжилт, хөдөлгөөний мэдээллийг бүрэн хянадаггүй, ахлагч бүрэлдэхүүний шилжилт, хөдөлгөөний тушаалыг цагдаа, дотоодын

цэргийн анги, байгууллагаас Хангалт, үйлчилгээний төвд бүрэн ирүүлдэггүй байдалтай холбоотой байна.

Дүрэмт хувцасны загвар шинэчлэн батлагдсанаас хойш цагдаагийн алба хаагчдад 22, дотоодын цэргийн алба хаагчдад 17 нэр төрлийн цагдаагийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийн хангалт огт хийгээгүй, дүрэмт хувцасны 30-60 хувийг дутуу хангаж байсан, алба хаагчдад хангалтаар олгож байгаа хувцасны хэмжээ таардаггүй, амархан ганддаг, үрчийдэг, угааж арчлах, өмсөж хэрэглэхэд чанарын шаардлага хангадаггүй учраас албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай дүрэмт хувцас, ялгах тэмдгийг өөрсдийн мөнгөөр худалдан авч байна.

Энэ нь сонгон шалгаруулалтыг чөлөөт өрсөлдөөний зарчмаар нээлттэй хийж, дотоодын бэлтгэн нийлүүлэгчдийг өрсөлдүүлж, хамгийн сайн чанар, материалыг шалгаруулах харьцуулалтын аргыг ашиглан хийдэггүй, шинээр хийгдэх хувцас хэрэглэлийг олон алба хаагчдыг хамруулан туршдаггүй, дараа жил хэрэглэх хувцсыг өмнөх жилд нь бэлтгэх, туршилтын хугацаанд чанарын сайжруулалт хийж, үнэ багатай, сайн чанартай материалаар хувцас хийх боломжтой байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 155 дугаар тогтоолоор баталсан “Цагдаагийн алба хаагчийн дүрэмт хувцасны загвар, түүний эдэлгээний хугацаа, цагдаагийн алба хаагчид дүрэмт хувцасны мөнгөн хангамж олгох журам”-аар батлагдсан шалгуур үзүүлэлтээс тендер шалгаруулсан болон бэлтгэсэн дүрэмт хувцасны материалын чанарын үзүүлэлтүүд зөрүүтэй, цагдаагийн дүрэмт хувцас бэлтгэх, дүрэмт хувцас үйлдвэрлэх материал сонгох үйл ажиллагаанд хувцасны чанар, дизайны чиглэлээр мэргэшсэн 1-2 алба хаагчийн цуглуулж, бэлтгэсэн мэдээлэлд үндэслэн үнэлгээний хорооны гишүүд шийдвэр гаргаж байгаа нь хараат бус байдал алдагдах, дүрэмт хувцас бэлтгэх хугацаа сунжрах, бүтээгдэхүүний чанарт тавих хяналт сулрах эрсдэлтэй байна.

Чанар, технологи хариуцсан ахлах мэргэжилтэн нь дүрэмт хувцас бэлтгэх, материал сонгох үйл ажиллагаанд оролцоо багатай, зөвхөн материалын чанар болон үйлдвэрлэлийн явцад хяналт тавьж байна.

Иймд алба хаагчдын хувцасны чанарыг сайжруулах, эдэлгээний хугацааг уртасгах зорилгоор дүрэмт хувцас бэлтгэх, материал сонгох зэрэг бүхий л үйл явцад чанар хариуцсан алба хаагчийн оролцоо, материалын чанар болон үйлдвэрлэлийн явцад тавих хяналтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

5. ЗӨВЛӨМЖ, САНАЛ

5.1 Улсын төсвийн хөрөнгөөр цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын хэрэгцээт дүрэмт хувцас, ялгах тэмдэг, материалыг бэлтгэн нийлүүлэх гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны тушаалыг хууль, дүрэмд нийцүүлэн шинэчлэн гаргах, энэ үйл ажиллагаатай холбоотой гарах тушаал,

шийдвэрийн төслийг Хуулийн хэлтсээр хянуулж байх; /CAAA/

5.2 Цагдаагийн ерөнхий газрын Хангалт, үйлчилгээний төвийн нормт хувцас хангалтын программын гэрээний нөхцөлийг сайжруулж, шинэчлэлт хийх, эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт хувцасны программаас авч ашиглах статистик мэдээллийн тоо хэмжээг нэмэгдүүлж, дүрэмт хувцас бэлтгэх, төлөвлөх, тайлагнах ажиллагаанд ашиглах боломжийг нэмэгдүүлэн, шаардлагатай мэдээллийг бүрэн хэвлэдэг болгох, хүний нөөцийн шилжилт хөдөлгөөний сангийн мэдээлэлтэй уялдуулах, программд хөгжүүлэлт, сайжруулалт хийх замаар гар ажиллагаагаа /CAAA, ХҮТ/

5.3 Санхүү, аж ахуйн алба, Хангалт, үйлчилгээний төв, Хүний нөөцийн хэлтсийн ажлын уялдааг сайжруулах, Мэдээллийн технологи, холбооны ажил хариуцсан нэгж нь нормт хувцас хангалтын программын мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сүлжээний хэвийн үйл ажиллагааг хариуцан ажиллах; /CAAA, ХҮТ, ХНХ, МДШШУА/

5.4 Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын дүрэмт хувцсыг бэлтгэх, төлөвлөх, худалдан авах үйл ажиллагааг хариуцлагатай, хурдан шуурхай, чанартай зохион байгуулах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, хараат бус байдлыг хангах үүднээс хувцасны бэлтгэл, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн болон хувцасны чанар технологи хариуцсан ахлах мэргэжилтний ажлын ачааллыг бууруулах, орон тоог нэмэгдүүлэх боломжийг судалж, шийдвэрлүүлэх; /CAAA/

5.5 Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын дүрэмт хувцасны бодлогын баримт бичиг боловсруулан, дүрэмт хувцасны бэлтгэх, төлөвлөх, хангах, мэдээлэл солилцох үйл ажиллагааг сайжруулах, төсөв хүрэлцээгүй нөхцөлд батлагдсан төсөвт багтаан эхний ээлжид нэн шаардлагатай хувцсыг бэлтгэдэг зохицуулалт хийдэг байх, тухайн жилд бэлтгэн, нийлүүлэх хувцсыг нэн тэргүүнд хангах, нөөц боломжтой үед хангах, эсвэл нэр төрөл, гүйцэтгэх чиг үүргээс нь хамааруулан сонгох зэргээр эрэмбэлэх журам, аргачлалыг тодорхойлж, бодлогын баримт бичигт тусгах; /CAAA/

5.6 Хувцасны загвар хийц, өнгө, эдэлгээний хугацаа, чанар, стандарт, хувцас бэлтгэл, төлөвлөлт, чанар хариуцсан мэргэжилтний ажлын байранд тавигдах шаардлагыг ижил төрлийн ажил үүрэг гүйцэтгэдэг байгууллагын жишигт нийцүүлэн сайжруулж, боловсронгуй болгох, мэргэжлийн баг оролцуулсан ажлын хэсэг зохион байгуулж, дүрэмт хувцасны стандарт, шаардлагыг тодорхойлох бодлогын баримт бичиг боловсруулах; /CAAA/

5.7 Алба хаагчдын хэрэгцээт дүрэмт хувцас, ялгах тэмдэг, материалыг бэлтгэн нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах үнэлгээний хорооны гишүүдийн бүрэлдэхүүнд хувцасны загвар зохион бүтээгч болон чанар, дизайны мэргэжлээр мэргэшсэн гишүүд, бусад төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог

нэмэгдүүлэх, хараат бус байдал алдагдах эрсдэл үүсгэхээс сэргийлэхэд анхаарах; /CAAA/

5.8 Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдад Хангалт, үйлчилгээний төвийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа “Нормт хувцас хангалтын программ”-д дүрэмт хувцасны өмсгөл, хэмжээсийн талаар мэдээлэл оруулах, өөрчлөлт хийх талаар сургалт зохион байгуулах, уг программид хөгжүүлэлт, сайжруулалт хийх, шаардлагатай бол шинэ программ хангамж нэвтрүүлэх; /CAAA, ХҮТ/

5.9 Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангах, тендерийн урилгыг худалдан авах ажиллагааны цахим хуудсанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг өргөнөөр оролцох боломжтой, тендерийн бичиг баримт бүрдүүлэх хангалттай хугацаатай байхаар байршуулах, тендер шалгаруулалтад оролцож байгаа гадаадын аж ахуйн нэгжид давуу эрх олгохгүй байх, гадаад, дотоодын байгууллагын чадавхийг адил шалгуураар үнэлж, тендерийн бичиг баримт ирүүлсэн, шалгуур, шаардлага бүрэн хангасан, байгууллагыг сонгох, Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийг түлхүү оролцуулах, дотоодын үйлдвэрлэгчийг дэмжих бодлогыг баримтлах; /CAAA/

5.10 Дүрэмт хувцасны бэлтгэн нийлүүлэгчийг сонгохдоо Олон улсын стандарт болон Монгол Улсад мөрдөгдөж байгаа хувцасны чанар, эрүүл ахуйн болон бусад шаардлагатай стандартыг хангасан эсэхэд онцгой анхаарах; /CAAA/

5.11 Зарим төрлийн хувцасны хангалт, эдэлгээний хугацаанд зохицуулалт хийж, төрөл албадын чиг үүргээр нь төрөлжүүлэн, ялгамжтай олгодог байх; /CAAA/

5.12 Нийслэлийн дүүргүүдийн цагдаагийн албанаас халагдаж, чөлөөлөгдсөн алба хаагчдын эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт хувцасны төлбөр тооцоо барагдуулах ажлын зохион байгуулалтыг сайжруулах; /CAAA/

5.13 Бэлтгэн нийлүүлэгч бүрээс шалтгаалж хувцасны өмсгөл өөрчлөгддөг асуудлыг шийдвэрлэх; /CAAA/

5.14 Сонгон шалгаруулалт хийгдсэний дараа нийлүүлэлт хийх явцад тавих чанарын хяналтыг сайжруулах. /CAAA/

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын автомашины шатахуун зарцуулалттай холбоотой үйл ажиллаанд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Цагдаагийн ерөнхий газрын Автобааз, Дархан-Уул аймаг, Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газар

Аудитын объект: Глбаны автомашины шатахуун зарцуулалттай холбоотой үйл ажиллагаа

Аудитын төрөл, код: Санхүүгийн аудит, ЦЕГ-ХШДАХ/2019/10/СА-04

Аудитын хугацаа: 2019.11.15-2019.12.25

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа С.Март

1. ТАНИЛЦУУЛГА

Цагдаагийн байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 5.1.5, 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 13.5, 13.6, 13.7 дэх заалт, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам”-ын 4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.1.5 дахь хэсэгт тус тус заасныг баримтлан ажиллах үүрэгтэй. Гэтэл сүүлийн жилүүдэд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын албан хэрэгцээний автомашины шатахуун зарцуулалттай холбоотой анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хүлээн зөвшөөрдөг, автомашины ашиглалт, шатахуун зарцуулалтыг хянадаггүй зэрэг санхүүгийн алдаа, зөрчил нэлээдгүй гарч байна.

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, бэлэн байдалд ажиллах үүргээ биелүүлэхэд албаны автомашин ашиглах үйл ажиллагаа Дэд бүтцийн сайдын 2004 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн 19 дүгээр тушаал, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “код 809”, Цагдаагийн ерөнхий газрын даргын “Автомашины тоо, ажиллах хоног,

хоногийн гүйлт км"-г тогтоосон 2019 оны А/47 дугаар тушаал, Цагдаагийн ерөнхий газрын даргын Санхүү аж ахуйн албаны даргын 2017.12.08-ны өдрийн “Шатахууны нэмэгдэл мөрдөх тухай” тушаал, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4 дүгээр бүлэг “Бараа материалын бүртгэл” хөтлөх арга аргачлал зэрэг бусад эрх зүйн акт, баримт бичгээр зохицуулагдаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын Автобааз нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлэхэд албаны болон тусгай зориулалтын машинуудаар үйлчилж, бэлэн байдлыг хариуцах чиг үүргээ хэрэгжүүлэн цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын газар, албадын харьяанд үйлчилдэг 329 автомашин, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харьяанд үйлчилдэг 266 автомашин, нийт 595 автомашинд шатахуун олгож, засвар, техник үйлчилгээг хариуцан ажиллаж байна.

Дархан-Уул аймаг дахь Цагдаагийн газар албан хэрэгцээндээ 30 тээврийн хэрэгсэл, 2 мотоциклтойгоор үүрэг гүйцэтгэдэг. Тус цагдаагийн газрын даргын 2018 оны Б/210 дугаарын тушаалаар авто машины лимит, тусгай үүрэг болон бүсийн нөхцөлөөр 25 хувийн нэмэгдлийг үндсэн норм дээр нь нэмэгдүүлэн олгож байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудын нийт батлагдсан төсвийн 3.1 орчим хувийг тээвэр, шатахуунтай холбоотой зардал эзэлж байна. Үүнд: Дархан-Уул аймаг дахь Цагдаагийн газар 2019 оны 09 дугаар сарын 31-ний байдлаар төсвийн гүйцэтгэлээр 2.2 хувь, 2019 оны 08 дугаар сарын 31-ний байдлаар Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн 1 дүгээр хэлтэс төсвийн гүйцэтгэлээр 2,7 хувь, Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн 2 дугаар хэлтэс төсвийн гүйцэтгэлээр 3,3 хувь, Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн 3 дугаар хэлтэс төсвийн гүйцэтгэлээр 3,7 хувь, Сонгинохайрхан дүүрэг дэх Цагдаагийн 2 дугаар хэлтэс төсвийн гүйцэтгэлээр 3,5 хувь, Цагдаагийн ерөнхий газрын Автобааз 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төсвийн гүйцэтгэлээр 25.3 хувийг тус тус тээвэр шатахууны зардалд зарцуулжээ.

Аудитын хүрээнд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын удирдлага дотоод хяналтын орчин сул, нягтлан бодогч нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн холбогдох эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, бүртгэлээр тавих хяналтаа хэрэгжүүлээгүй, өдөр тутмын үйл ажиллагааг оновчтой чиглүүлээгүйгээс “Автомашин шатахуун зарцуулалтын үйл ажиллагаа”-ны тооцоо хийж, хяналт тавьж буй байдалтай холбоотой 99.1 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудад шатахуун зарцуулалт хэрхэн явагддаг талаарх мэдээллийг авахаар санал, асуулга авч, эрсдэлийн үнэлгээ хийж, ач холбогдлоор нь эрэмбэлж үнэллээ. Судалгаанд социологийн шалгуур үзүүлэлтийг хангахуйц үйл ажиллагааны чиглэл, дуудлага мэдээлэл, газар зүйн байрлал, ажиллах

нөхцөл зэрэг олон талаас нь харахыг зорилоо. Шатахууны олголт, зарцуулалт, хүрэлцээний талаар түүвэрт хамрагдсан 3 байгууллагын хэрэглэгч, жолооч нараас авсан санал, асуулгын дүнг үзэхэд хамгийн их баталгаа өгөх асуудал бол албаны хэрэгцээнд олгогдож байгаа шатахуун хэрэгцээгээ бүрэн хангадаггүй гэжээ.

Ердийн баталгаа өгөх асуудал бол албанд ашиглагддаг автомашины засвар үйлчилгээг хугацаанд нь хийдэггүйгээс шатахуун зарцуулалт их байдаг гэсэн нь эрсдэлтэй асуудлаар тус тус үнэлэгдлээ.

Эдгээрээс шатахуун зарцуулалтын асуудлаар нэгж дээр бодитой ажил зохион байгуулагддаггүй, ялангуяа хотын дүүргүүд дэх албаны болон тусгай зориулалтын машинуудын бэлэн байдлыг ханган ажиллах чиг үүрэг бүрэн хэрэгждэггүй тул зайлшгүй сайжруулах шаардлага байгааг харуулж байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дотоод аудитын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу санхүүгийн шалгалтын явцад байнга давтан илэрдэг алдаа, зөрчилтэй холбоотой үйл ажиллагаанд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, илэрсэн зөрчил дутагдлыг засаж, сайжруулах чиглэлээр зөвлөмж өгч, дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2 Аудитын ажлын цар хүрээ

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын албаны хэрэгцээний шатахуун зарцуулалттай холбоотой гарч буй алдаа, зөрчлийн талаарх баримт, мэдээллийг аудитын объектод хамруулсан.

2.3 Аудитын зохион байгуулалт

Дотоод аудитыг хэрэгжүүлэхдээ тухайн аудит хийхэд шаардлагатай хууль, тогтоомж, дүрэм, журам, бусад холбогдох бичиг баримттай танилцан, албаны хэрэгцээний шатахуун зарцуулалтын тооцоо хийж буй байдалтай холбоотой мэдээллийг авч нэгтгэн, тулган баталгаажуулах, нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх аргыг ашиглан дүгнэлт хийлээ.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Шатахууны үлдэгдэл бодит байдлаар тайлагнагдахгүй байна.

Түлш, шатах тослох материалын явц байдлыг шалгахад шат шатны дотоод хяналт сул, нягтлан бодогч, ашиглалтын тоо бүртгэгч, техникийн тоо бүртгэгч, нярвуудын ажлын уялдаа холбоо сул, санхүүгийн

холбогдох мэдээ, тайланг зохих түвшинд хийж хэвшээгүйгээс замын хуудас, дагалдах хуудасны тооцоо, шатахууны зарцуулалтын байдал бодит байдлаас зөрүүтэйгээр санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн, түүнд хяналт тавих эрх бүхий алба хаагчид хариуцлагагүй хандсан байна. Үүнд:

Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 1-р хэлтэс: 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх санхүүгийн тайлан тэнцэлд 2 автомашинд 406,6 литр буюу 741.038 төгрөгийн шатахууны үлдэгдэлтэй.

Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 2-р хэлтэс: 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх санхүүгийн тайлан тэнцэлд 256,8 орчим литр буюу 467.500 төгрөгийн шатахууны үлдэгдэлтэй тайлагнасан боловч замын хуудас, дагалдах хуудасны тооцоогоор 4.474 төгрөгийн үлдэгдэлтэй.

Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 3-р хэлтэс: 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх санхүүгийн тайлан тэнцэлд 516,5 орчим литр буюу 940.000 төгрөгийн шатахууны үлдэгдэлтэй тайлагнасан боловч бодит байдлаар шатахууны зарцуулалтын тооцоо хийдэггүй, ЦЕГ-ын Автобаазад замын хуудасны гүйлтийг жагсаалтаар өгдөг. Үлдэгдлийг тооцдоггүй.

Өмнөх шалгалтаар ЦЕГ-ын Автобаазын шатахууны зарцуулалтыг үзэхэд картыг зориулалтын дагуу ашиглаагүй, нэг дор олон удаа уншуулсан, автомашины шатахууны сав /банк/-ны багтаамжийг хэтрүүлэн цэнэглэдэг, 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлан тэнцэлд 138 автомашинд 31-1197 литр буюу 59.082.290 төгрөгийн шатахууны үлдэгдэлтэй байгаагаар тайлагнасан зэрэг нь бодит байдалтай нийцэхгүй байна.

3.2 Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв, бодитой байх зарчмыг хангадаггүй.

Жолооч нарын автомашины замын хуудас болон дагалдах хуудсыг хяналт тавих эрх бүхий шалгах механик, хэсгийн дарга, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын жижүүрүүд спидометрийн заалттай тулгалт хийн шалгаж, ажилд ирсэн, буусан цаг, явсан километрийг үнэн зөв бичиж баталгаажуулаагүйгээс шалтгаалж спидометрийн заалт замын хуудасны гүйлттэй зөрдөг, замын хуудсаар километрээ илүү гүйлгэн бичиж шатахуунаа зарлагаддаг, дүүргийн цагдаагийн албан хэрэгцээнд үйлчилж байгаагаар дагалдах хөтөлсөн хэрнээ хөдөөнөөс шатахуун цэнэглэлт хийдэг зэрэг зөрчлүүд илэрлээ.

Автомашиныг хэрэглэгчид байгууллага, албан тушаалтан очсон цагаас нь эхлэн замын хуудсанд тэмдэглэл хийж, буулгах хүртэлх хугацаанд автомашины ашиглалтын байдлыг бодитойгоор хянаж, дагалдах хуудсыг хөтөлдөггүйгээс жолоочид дээрх боломжийг бүрдүүлсэн байна. Үүнд:

Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 2-р хэлтсийн албанд үүрэг гүйцэтгэдэг 12 автомашинуудын гүйлтийг тулган баталгаажуулахад замын

хуудсаар 235,7 мянган километрээр илүү, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 1-р хэлтсийн албанд үүрэг гүйцэтгэдэг 13 автомашинуудынх 402,5 мянган километрээр илүү, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн газрын албанд үүрэг гүйцэтгэдэг 10 автомашинуудынх 5,9 мянган километрээр тус тус илүү бичигдэж шатахуун зарлагадсан байна. Өмнөх шалгалтаар ЦЕГ-ын Автобаазын автомашинуудын спидометрийн заалтыг замын хуудасны гүйлт километртэй тулган үзэхэд 7,0-53,9 мянган километрээр зөрүүтэй байсан.

Өмнөх хөндлөнгийн шалгалтаар Дархан-Уул аймаг дахь цагдаагийн газрын жолооч нар замын хуудас, дагалдах хуудсыг санхүүдээ өгч тооцоогоо бодуулдаггүй, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн 2-р хэлтэс 580.000 төгрөгийн и-баримтгүй гүйлгээ хийснээс “зөвлөмж”, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн 1-р хэлтэс шатахууны зарцуулалтын баримтын анхан шатны баримтын бүрдэл дутуу 14.410.700 төгрөгийн гүйлгээ хийсэн шалтгаанаар “албан шаардлага” авч байсан.

3.3 Шатахууны картын зарцуулалтыг тухай бүр хянаж чаддаггүй.

Шатахууны карт ашиглалтын байдлыг шалгахад жолооч нар ажил үүргээ гүйцэтгээгүй үедээ зарцуулсан, хувийн автомашиндаа шатахуун хийсэн, шатахууны төрлийг өөрчилж дизель түлш хэрэглэх автомашинд АИ-92 шатахуун авсан, картыг зориулалтын дагуу ашиглаагүй, төрөл, тоо хэмжээ, нэгжийн үнэ тодорхойгүй, засварт байх хугацаандаа шатахуун авсан, орон нутагт ажиллаж байх үедээ карт нь Улаанбаатар хотод уншигдсан, шатахуун авсныг нотлох анхан шатны баримт /НӨАТ-ын баримтыг байгууллагаар сонгон авах/-ыг санхүүд өгч, тооцоо хийж хэвшээгүй төлбөр зөрчил маш их хавтгайрсан байна. Үүнд:

Шатахууны картаас төрөл, тоо хэмжээ, нэгжийн үнэ тодорхойгүй 1.463.000 төгрөгийн гүйлгээг Баянгол дүүрэг дэх цагдаагийн 1-р хэлтэс, 4.489.300 төгрөгийн гүйлгээг Баянгол дүүрэг дэх цагдаагийн 2-р хэлтэс, 4.046.100 мянган төгрөгийн гүйлгээг Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 1-р хэлтэс, 2.749.470 төгрөгийн гүйлгээг Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн 1-р хэлтсүүд тус тус хүлээн зөвшөөрч, зарлага болгон бүртгэлд тусган тайлагнасан.

Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 3-р хэлтэс 4.815.500 төгрөгийн, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 1-р хэлтэс 1.500.000 төгрөгийн, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн 1-р хэлтэс 194.000 мянган төгрөгийн шатахууны хэмжих нэгж, тоо хэмжээ, нэгжийн үнэлгээг 1 төгрөгөөр бүртгэн литрийн хэмжээ, шатахууны талонг литрт шилжүүлээгүй үнийн дүнгээр шууд зардалд бүртгэсэн.

Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 1-р хэлтэс: 170.600 мянган төгрөгийн АИ-95 төрлийн өртөг өндөртэй шатахуун авч зарцуулсан,

бензин зарцуулдаг машинд дизель түлш, дизель түлш зарцуулдаг машинд бензин зарцуулснаар 584.400 мянган төгрөгийн тооцоо бодож тайлагнасан.

Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 3-р хэлтэс: Өртөг өндөртэй 214.100 мянган төгрөгийн АИ-95 төрлийн шатахуун авч хэрэглэж, шатахууны төрлийг өөрчилсөн.

Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн 1-р хэлтэс: АИ-92 шатахуун зарцуулдаг авто машинд өөр төрлийн 409.668 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан.

Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн 2-р хэлтэс: Дизель түлш зарцуулдаг авто машинд 1.538.900 мянган төгрөгийн АИ-92 бензин зарцуулсан.

Сонгино хайрхан дүүрэг дэх цагдаагийн 1-р хэлтэс: Өртөг өндөртэй 641.200 төгрөгийн шатахууныг авч зарцуулж тус тус тайлагнасан асуудалд аудитаар алдаа заагдсаар байна.

3.4 Шатахууны нормыг албаны ачаалал болон нутаг дэвсгэрийн онцлогоос хамааруулан олгодоггүйгээс хүндрэлтэй нөхцөлд ажилладаг гэсэн санал асуулгын дүн гарсан.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын автомашины шатахуун олголт, зарцуулалтын талаар Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын нэг, хоёр, гуравдугаар хэлтсийн дарга, тасгийн дарга, нярав, эргүүлийн цагдаа жолооч нарын нийт 60 гаруй алба хаагчдаас хэсэгчилэн санал асуулга авлаа.

Эргүүлийн цагдаа жолооч нарын хувьд нэмэлтээр шатахуун авсан тохиолдолд тухай бүрд нь шаардах хуудсаар хүсэлтээ бичиж авдаг нь сайшаалтай байна.

Судалгаанд хамрагдсан алба хаагчийн 28,3 хувь нь “24 цагийн хугацаанд үүрэг гүйцэтгэж байгаа автомашинд шатахуун хүрэлцдэггүй”, 18,3 хувь нь “Өвлийн улиралд машинаа унтраалгүй нормалддаг, нэмэгдэл өгдөггүй”, 13,3 хувь нь “Албанд ашиглагддаг автомашины хувьд насжилт хэтэрсэн, моторын ээлж хийгдээгүй, тухай бүрт нь техник үйлчилгээнд орох боломжгүй байдаг учир шатахуун зарцуулалт их байдаг”, 13,3 хувь нь “Батлагдсан лимитээр шатахуун олгоход хүрэлцэхгүй байна гэдэг санал байнга ирдэг”, 11,6 хувь нь “Ажлын ачаалал ихтэй дуудлага мэдээлэл их учир нэмэлтээр автомашин гаргадаг.

Нэмэлтээр гаргасан машинд шатахуун картнаас уншуулахад өөр төрлийн шатахуун уншигддаг гэсэн асуудалд ордог”, 5 хувь нь “Дуудлага мэдээлэл их гарвал шатахуун хүрэлцдэггүй” 3,3 хувь нь “Эргүүлийн цагдаа жолооч нар 24 цагаар үүрэг гүйцэтгэдэг тул өвлийн улиралд машинаа унтраалгүй нормальддаг, гэр хорооллын замаар буюу өгсүүр замаар голдуу явдаг хальтиргаа гулгаа ихтэй газраар явдаг шатахуун хүрэлцэхгүй байдаг тул Цагдаагийн ерөнхий газрын Автобаазад тавигддаг автомашинуудыг хэлтэс дээрээ тавьдаг болгох”, 3,3 хувь нь “Гэр хорооллын замаар буюу өгсүүр замаар голдуу явдаг хальтиргаа

гулгаа ихтэй газраар явдаг тул шатахуун хүрэлцэхгүй байдаг”, 1,6 хувь нь “Машин засвар үйлчилгээнд орсон тохиолдолд шатахуун түгээх станц дээр картаа орхин явсан үед картыг уншуулсан байдаг” гэсэн санал сэтгэгдлүүд ирсэн нь шатахууны нормыг албаны ачаалал болон нутаг дэвсгэрийн онцлогоос хамааруулан олгодоггүй, байнгын ажиллагаатай эргүүлийн машинд мотоцигийн нэмэгдэл олгодоггүйгээс шалтгаалсан байна.

Мөн дүүргүүдийн цагдаагийн газрууд ижил маркын автомашинд өөр өөр норм тогтоодог. “Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын “тугсон” маркын 30-48 УНЧ автомашинд хоногт 14,5 литр олгодгоос шатахуун хүрэлцдэггүй. Гэтэл Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газар ижил маркын машинд 23 литр шатахуун олгож байна”, “БЗД-ийн 8, 9, 17-р хороонд үүрэг гүйцэтгэдэг Шархадны 114-р чиглэлийн автомашинд хариуцсан газар нутаг том, 10000 төгрөгийн шатахуунаар 70 километр явдаг, өдөрт 120-150 километр явдаг өөрөөсөө 20,0 төгрөгөөр өдөр бүр шатахуун хийдэг тул шатахуун хаанаа ч хүрэлцэхгүй байна” гэж сэтгэл ханамж доогуур төвшинд байгаагаа илэрхийлжээ.

4. ДҮГНЭЛТ

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын удирдлагуудын дотоод хяналтын орчин сул, нягтлан бодогч санхүү, нягтлан бодох бүртгэлийн холбогдох эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, бүртгэлээр тавих хяналтаа хэрэгжүүлээгүй, өдөр тутмын үйл ажиллагааг оновчтой чиглүүлээгүйгээс “Автомашин шатахуун зарцуулалтын үйл ажиллагаа”-ны тооцоо хийж, хяналт тавьж буй байдалтай холбоотой 99.037.766 төгрөгийн зөрчил илэрсэн.

Автомашин шатахуун олголт, хүрэлцээ, зарцуулалтын талаар Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын нэг, хоёр, гуравдугаар хэлтсийн алба хаагчдаас авсан санал асуулгын дүнгээс үзвэл шуурхай бэлэн байдлыг хангах чиг үүрэг хүлээдэг жолооч нарт ашиглагдаж байгаа албаны тээврийн хэрэгсэл нь бэлэн бус, шатахуун хүрэлцээгүй, алба хаагчид эрсдэлтэй нөхцөлд ажилладаг, энэ талаар холбогдох алба хаагчид мэддэг ч төсөв хүрэлцэхгүй, лимит нормоос хэтрүүлэн олгох боломжгүй гэсэн шалтгаанаар тодорхой шийдвэр гардаггүй, 24 цагаар үүрэг гүйцэтгэдэг эргүүлийн цагдаа жолооч нар өвлийн улиралд даарч, зуны улиралд халууцаж эрүүл мэндээрээ хохирох эрсдэл ихтэй байна гэж үнэллээ.

Иймд энэ зөрчлийг дахин давтан гаргахгүй байх үүднээс үүсэж болох эрсдэлийг сааруулах чиглэлийн зөвлөмж, практик хэрэглээ талаас нь ашиглах аргачлал², санхүүгийн үйл ажиллагааны заавар журмын

² 2019 онд эмхтгэн гаргасан “Автомашин шатахуун зарцуулалтын үйл ажиллагаанд ашиглагдах анхан шатны баримт хөтлөх заавар, аргачлал” гарын авлага

² 2018 онд ЦЕГ-ын ХШҮДАХ-ээс эмхтгэн гаргасан “Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдах заавар журмын эмхтгэл” гарын авлага

эмхэтгэл² хүргүүлэх шаардлагатай юм. Эдгээрийг нягтлан бодогч санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажилтан, автомашины хэрэглэгч, жолооч нар үйл ажиллагаандаа хэрэгжүүлснээр шатахуунтай холбоотой алдаа, зөрчил бодитойгоор буурах боломжтой гэж үзэж байна.

Аудитын багийн ажлын үр дүнгээр цаашид ч шатахууныг хяналтгүйгээр зарцуулах эрсдэл өндөр байна гэж үзэн **“3 буюу их хэмжээний сайжруулалт хэрэгтэй”** гэж үнэллээ.

5. ЗӨВЛӨМЖ, САНАЛ

Дотоод аудитын дүгнэлт, аудитын явцад цугларсан баримт, өмнөх шалгалтын мэдээллийг үндэслэн дараах саналыг танилцуулж байна. Үүнд:

5.1 Цагдаа, дотоодын цэргийн “Автомашины шатахуун зарцуулалтын үйл ажиллагаа”-г сайжруулах чиглэлээр дотоод аудитын багаас өгсөн зөвлөмжийг цаашдын үйл ажиллагаандаа нэг мөр болгон хэрэгжүүлж ажиллах, удирдлагаас шатахуун зарцуулалттай холбоотой алдаа, зөрчил давтан гаргахгүй байх талаар эрсдэлийн төлөвлөгөөндөө тусгаж, үнэлгээ өгдөг болох;

5.2 Аудитаар илэрсэн асуудал, дурдсан саналуудыг шийдвэрлэх зорилгоор дараах зөвлөмжийг холбогдох нэгжүүдэд хүргүүлэх. Үүнд:

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад:

- Шатахууны зарцуулалтын тайлангаарх үлдэгдэл бодит үлдэгдлээс зөрүүтэй байгааг арилгах.
- Бодитой бус баримт бүрдүүлсэн алба хаагчид хариуцлага тооцож, тооцоо үүсгэн, хохирлыг барагдуулж хэвших
- Албаны автомашины ашиглалтын байдалд хяналт тавих зорилгоор шугам замын эргүүл, шалгалтыг хийж, автомашинуудын гүйлтийг тулган баталгаажуулж спидометрийн заалтыг замын хуудсны гүйлт километртэй тааруулах ажлыг зохион байгуулж, хяналтын тооллого хийх;
- Тус тусын нэгж дээрх орон тооны бус “Техникийн байнгын комисс”-г холбогдох хууль тогтоомжийн дагуу идэвхи, хариуцлагатай ажиллуулах. Жолооч, алба хаагч нар өөрийн мөнгөөрөө шатахуун хийдэг асуудлыг зогсоох.
- Ашиглалтын дүрэм, заавар зөрчсөн нь тогтоогдвол төлбөр, торгууль оногдуулах ажлыг зохион байгуулах;
- Шатахууны лимитийг сар бүр батлуулж, батлагдсан лимитийн дагуу шатахууны зарцуулалтыг спидометрийн заалттай тулган тооцож, тооцоо бодсон акт үйлдэж, тооцооны үлдэгдлийг баталгаажуулсны дараа шатахууны картын цэнэглэлтийг хийж байх;
- Харилцагч байгууллагатай хийх төлбөр тооцоог хөндлөнгийн

хяналттай болгох. Ялангуяа шатахуун түгээх цэгийн түгээгч нар манай байгууллагын жолооч нартай тохирч шатахууны картыг өөр дээрээ барьцаалан авч үлддэг асуудлыг зогсоох, шаардлагатай тохиолдолд эрх бүхий ажилтны шийдвэрээр олгуулдаг болгох;

- Гэрээт шатахуун борлуулагч байгууллагаас ирүүлсэн шатахууны анхан шатны баримтыг тулган шалгах дотоод хяналтаа сайжруулах;
- Санхүү, аж ахуйн ажилтнууд “анхан шатны баримтын бүрдлийн үнэн зөв, бодитой байх зарчмыг хангах” баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч дансны бичилт хийж байх.

Нийслэлийн цагдаагийн удирдах газарт:

Харьяа нэгжүүд дэх нягтлан бодогч, нярав, аж ахуйн ажилтан нарыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, автомашины ашиглалтын тайлан, шатахуун зарцуулалтын тайланг гаргах талаар зааварчлага өгч, хяналт тавих, цаашид алдаа зөрчил гаргахгүй байх талаар анхаарч ажиллах.

Санхүү, аж ахуйн албанд:

- Санхүү бүртгэлийн системд шатахуун зарцуулалтын талаарх дотоод хяналт сул байгаа, хөрөнгө эзэнгүйдэх эрсдэл үүсэж болзошгүй байгаа тул эд хариуцагч, нягтлан бодогч нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах;
- Батлагдсан төсөвт багтаан эхний ээлжид нэн шаардлагатай хэсэгт зохицуулалт хийдэг байх. Төсөв хүрэлцээгүй нөхцөлд илүүдэлтэй байгаа /хөдөө орон нутаг/ нэгжээс ачаалал ихтэй байгаа /дуудлага ихтэй дүүргүүдийн цагдаагийн газарт/ нэгжид төсөв дотроо зохицуулан уян хатан байдлаар хувиарлалт хийдэг байх;
- Нэгжүүдэд нөөцийн шатахууныг хангалттай хэмжээнд нөөцөлж, шаардлагатай үед хэрэглэх боломжтой байдлаар зохион байгуулалт хийх асуудлыг анхаарах.

Аюулгүй байдлын хэлтэст:

Цагдаагийн байгууллагын шуурхай бэлэн байдлыг хангах чиг үүрэг хүлээдэг жолооч нарт ашиглагдаж байгаа албаны тээврийн хэрэгслийн бэлэн бус байдал, шатахууны оновчтой хуваарилалт, хүрэлцээ, хангамжийн талаар эрсдэлтэй нөхцөлийг тодорхойлж, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмж хүлээн авсан байгууллага, нэгж нь зөвлөмжийн хэрэгжилтийг **2020** оны **04** дүгээр сарын **15**-ны дотор Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст ирүүлнэ.

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2019 оны 02 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын туслах аж ахуйн бүртгэл, тооцоо, даатгалын үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага

Аудитын объект: Туслах аж ахуйн бүртгэл, тооцоо, даатгалын үйл ажиллагаа

Аудитын төрөл: Санхүүгийн аудит

Аудитын хугацаа: 2018.12.25- 2019.02.01

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч Ц.Болормаа

1. ТАНИЛЦУУЛГА

Манай аудитын баг нь “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дотоод аудитын төлөвлөгөөнд “Төсвийн үр ашиггүй зардалд дотоод аудит хийх”-ээр заасны дагуу байгууллагын туслах аж ахуйн бүртгэл тооцоо, эд хөрөнгө, автотээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын болон гэнэтийн ослын даатгалын үйл ажиллагааг сонгон дотоод аудит хийлээ.

Аудит хийж эхлэхээс өмнө байгууллагын талаар ерөнхий ойлголт олж авахын тулд аудит хийх зорилго, цар хүрээг танилцуулж, хамтран ажиллах талаарх хүсэлтээ цагдаа, дотоодын цэргийн 59 анги, байгууллагын удирдлагад илгээж, туслах аж ахуйн болон даатгалын талаарх мэдээлэл авч, ажлын төлөвлөгөө гарган, аудитын тодорхой горимуудыг хэрэгжүүлэн ажиллаа.

1.1 Туслах аж ахуйн талаар

Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд төсвийн байгууллагыг төсвийн ерөнхийлөн захирагч урьдчилан бичгээр зөвшөөрсөн, туслах үйл ажиллагаанаас алдагдал учирвал түүнийг нөхөх төсвийн бус эх үүсвэрийг төлөвлөсөн байх, санхүүгийн тайлан болон үр дүнгийн гэрээнд уг үйл ажиллагааны талаар зохих ёсоор тусгасан байх, байгууллагын хөрөнгийг зориулалт бусаар ашиглаагүй, ажилтныг үүрэгт ажлаас нь хөндийрүүлээгүй байх, туслах үйл ажиллагаа эрхлэх нь тухайн төсвийн байгууллагын чиг үүрэг, үндсэн үйл ажиллагаанд харшлахгүй шаардлага хангасан тохиолдолд туслах үйл ажиллагаа явуулж, орлого олохыг зөвшөөрсөн байна.

Мөн “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны /код 813/ журам”-аар цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд туслах үйлдвэрлэл, аж ахуй эрхэлж, үр ашигтай ажиллуулан алба хаагчдын амьжиргааг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулжээ.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас дотоод аудитын хүрээнд ирүүлсэн мэдээллийг нэгтгэж үзэхэд 59 байгууллагаас 29 нь туслах аж ахуй эрхэлж байна. Малын хөдөлгөөний тайланг нэгтгэн үзэхэд 2018 оны эхэнд нийт дүнгээрээ 9182 толгой малтай байсан бөгөөд тайлант хугацаанд 5310-аар нэмэгдэж, 5644-өөр хасагдан, оны эцэст 8848 толгой малтай болжээ. Тухайн онд 1960 төл хүлээн авч, нас дэвшилтээр 3346, худалдаж авсан 4, нийт 5310 толгой мал нэмэгдсэн, тухайн байгууллагын даргын тушаал, шийдвэрээр 1459, малын зүй бусын хорогдлоор 323, малын нас дэвшилтээр 2941, нийт 5644 толгой мал хасагдсан байна.

Нийт мал сүргийн 67,0 хувийг хонь, 26,1 хувийг ямаа, 3,1 хувийг үхэр, 3,8 хувийг адуу эзэлж байна. Ноолуур борлуулснаас 23.764,0, арьс шир худалдсанаас 420.0, ноос борлуулснаас 5.241,1, мал худалдсанаас 8.727,2, нийт 38.152,3 мянган төгрөгийн орлого олсон, туслах аж ахуйн орлогын 74,3 хувь буюу 28.335,2 мянган төгрөгийг улсын төсвийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн, 25,7 хувь буюу 9.817,1 мянган төгрөгийг дансанд тушаахгүйгээр бэлнээр зарцуулсан байна.

Туслах аж ахуйн зардлыг үзэхэд малчны цалин хөлсөнд 70.226,1, шатахуунд 18.281,8, өвс тэжээл бэлтгэхэд 19.674,2, худаг гаргахад 270.0, эм тариа, вакцинжуулалтад 5.241, нийт 111.143,8 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд туслах аж ахуйд зарцуулсан нийт зардлын 86,3 хувь буюу 95.929,6 мянган төгрөгийг урсгал төсвөөс, 13,7 хувь буюу 15.214,2 мянган төгрөгийг туслах аж ахуйн орлогоос зарцуулсан байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын урсгал төсөвт тэтгэмж, тусламжийн зардал байхгүй учраас туслах аж ахуйгаас тодорхой тооны малыг алба хаагч, ажилтан, өндөр настнуудад дэмжлэг үзүүлэх, мөн цагдаагийн баяр болон бусад арга хэмжээний үед байгууллагын дотоод хэрэгцээнд зориулан тухайн байгууллагын даргын тушаалаар зарцуулдаг байна.

1.2 Даатгалын талаар

Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан даатгалын салбарын 2018 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагааны нэгдсэн тайлангаас үзэхэд ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, давхар даатгалын 2, даатгалын зуучлагч 47, даатгалын хохирол үнэлэгч 27 компани даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагууд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа дээрх компаниудаас 6 даатгалын компанийг сонгон гэнэтийн ослын даатгалыг “Монгол даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК-тай, тээврийн хэрэгслийн даатгалыг “Ард даатгал” ХХК,

“Миг даатгал” ХХК-тай, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг “Монгол даатгал” ХХК, “Ард даатгал” ХХК, “Хаан даатгал” ХХК, “Монре даатгал” ХХК-тай, эд хөрөнгийн даатгалыг “Практикал даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК-тай, хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгалыг “Хаан даатгал” ХХК-тай тус тус гэрээ байгуулан, хамтран ажиллажээ.

1.2.1 Эд хөрөнгийн даатгал

Санхүү, аж ахуйн алба: нь 2018.04.18-ны өдөр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн 23 байгууллага, харъяа 14, нийт 37 байгууллагын 75.819.681,5 мянган төгрөгөөр үнэлгээ бүхий 635 барилга, байгууламж, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба болон Захиргааны удирдлагын газрын 1.331.627,0 мянган төгрөгийн үнэлгээ бүхий 21 нэр төрлийн тоног төхөөрөмжийг эд хөрөнгийн даатгалд хамруулж, “Практикал даатгал” ХХК-тай ЭХ 30С 18103960/19 дугаартай гэрээ байгуулсан байна.

Үл хөдлөх хөрөнгийн даатгалын хураамжид 68.237,7 мянган төгрөг, тоног төхөөрөмжийн даатгалын хураамжид 3.994,9 мянган төгрөг, нийт 72.232,6 мянган төгрөг төлөхөөр гэрээнд тусгажээ.

Гал, байгаль, цахилгаан, ус чийгний гэсэн 4 төрлийн эрсдлээс хамгаалж, даатгалын нөхөн төлбөрийг 17 тохиолдолд олгохгүй, 8 тохиолдолд тодорхой хувиар олгохоор харилцан тохиролцож, 2018.04.18-наас 2019.04.18-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаатайгаар даатгалын гэрээг байгуулсан байна.

“Практикал даатгал” ХХК-наас 2018.12.25-ны байдлаар эд хөрөнгийн даатгалтай холбоотой 1 тохиолдолд 17.203,1 мянган төгрөгийн нөхөн олговор олгосон байна.

Нийслэлийн цагдаагийн газар: нь өөрийн болон харъяа дүүргийн 635 төрлийн эд хөрөнгийг “Миг даатгал” ХХК-тай “Эд хөрөнгийн даатгалын гэрээ” байгуулан, 20.786,5 мянган төгрөг хураамж төлж, даатгасан байна.

Уг гэрээнд эд хөрөнгийн даатгалын эрсдэл тохиолдсон нөхцөлд даатгуулагчийн өөрийн хүлээх хариуцлагын хэмжээ 10 хувь байхаар тусгажээ. Нийслэлийн цагдаагийн газар нь өнгөрсөн онд эд хөрөнгийн даатгалын нөхөн төлбөр аваагүй байна.

1.2.2 Тээврийн хэрэгслийн даатгал

Санхүү, аж ахуйн алба: нь 2018.04.18-ны өдөр “Ард даатгал” ХХК-тай нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн 25 байгууллагын 467 автомашин, харъяа 6 нэгжийн 372, нийт 31 байгууллагын 839 тээврийн хэрэгслийг 21.623.187,3 мянган төгрөгөөр үнэлж, автотээврийн хэрэгслийн даатгалын хураамжид 86.492,7 мянган төгрөг төлөхөөр харилцан тохиролцож, D183001109167/20 дугаартай гэрээг байгуулсан байна.

Шинээр нэмэгдэх даатгалын зүйлд зориулан даатгалын гэрээний үлдэх хугацаанд үнэгүй даатгалын үйлчилгээ авах үндсэн гэрээний нөхцлийг үндэслэн 2018.07.27-ны өдөр 5, 2018.09.05-ны өдөр 24, нийт

29 тээврийн хэрэгслийг хураамж төлөхгүйгээр тээврийн хэрэгслийн даатгалд хамруулжээ.

“Ард даатгал” ХХК-аас 2018.12.27-ны байдлаар тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний /дугаар D183001109167, D183001109167-2, D189001109169/ 18 тохиолдлын нөхөн төлбөрт 94.481,2 мянган төгрөг авсан байна.

Нийслэлийн цагдаагийн газар: Тус цагдаагийн газар нь 2018.07.05-ны өдөр “Миг даатгал” ХХК-тай /дугаар /816/57/ гэрээ байгуулж, 19.333,3 мянган төгрөгийн хураамж төлж, 268 тээврийн хэрэгслийг даатгажээ.

“Миг даатгал” ХХК-аас 2018 онд даатгалын 15 тохиолдлын нөхөн төлбөрт 7.748,3 мянган төгрөг авсан байна.

1.3 Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал

Жолооч замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учруулж болзошгүй хохирлыг нөхөн төлөх зорилготойгоор жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг хийсэн байна.

Санхүү, аж ахуйн алба: нь 2018.04.18-ны өдөр “Ард даатгал” ХХК-тай нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн 25 байгууллагын 467, харъяа 6 нэгжийн 363, нийт 31 байгууллагын 835 тээврийн хэрэгслийг суудлын тоо, хөдөлгүүрийн багтаамжаас хамааруулан 4.800.000,0 мянган төгрөгөөр үнэлж, жолоочийн 57.547,0 мянган төгрөгөөр хариуцлагын албан журмын даатгалд, мэргэшсэн болон С, D ангиллын жолоочийн даатгалд 5.029,2 мянган төгрөг, нийт 62.576.2 мянган төгрөгийн хураамж төлөхөөр харилцан тохиролцож, D189001109169 дугаартай гэрээ байгуулсан байна.

Уг гэрээнд 2018.07.27-ны өдөр 5 тээврийн хэрэгслийн даатгалд 930.2 мянган төгрөгийн хураамж төлөхөөр, 2018.09.05-ны өдөр 24 тээврийн хэрэгслийн даатгалд 2.981,9 мянган төгрөгийн хураамж төлөхөөр нэмэлт гэрээ байгуулсан бөгөөд үндсэн гэрээнд нэмэлт гэрээний хураамжийг чөлөөлөхөөр тусгасны дагуу хураамжаас бүрэн чөлөөлжээ.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын багцын урамшуулалд тооцож, 100.000,0 мянган төгрөгийн үнэлгээ бүхий жолоочийн хариуцлагын сайн дурын даатгалыг үнэгүй хийсэн байна.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг 6 төрлийн эрсдлээс хамгаалж хийсэн бөгөөд уг гэрээнд хохирлыг үндэслэн нөхөн төлбөр олгох 7, олгохоос татгалзах 11 тохиолдол байна.

Нийслэлийн цагдаагийн газар: нь “Миг даатгал” ХХК-тай Жолоочийн даатгалын тухай хуульд заасны дагуу тээврийн хэрэгслийн ангиллыг харгалзан 1.422.500,0 мянган төгрөгийн үнэлгээгээр тооцож, 24.709,6 мянган төгрөгийн хураамж төлж, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал хийжээ.

Ховд аймаг дахь цагдаагийн газар: нь “Монре даатгал” ХХК-д урсгал төсвөөс 133,9 мянган төгрөг шилжүүлэн, 2 алба хаагчийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамруулжээ.

Архангай аймаг дахь цагдаагийн газар: нь “Ард даатгал” ХХК-тай гэрээ байгуулан, 7 алба хаагчийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамруулсан бөгөөд 438,9 мянган төгрөгийн хураамжийг алба хаагчид хувиасаа төлж, даатгуулсан байна.

Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газар: нь “Монгол даатгал” ХХК-тай гэрээ байгуулан, 7 алба хаагч 217,0 мянган төгрөгийг хувиасаа төлж, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгуулжээ.

Хэнтий аймаг дахь цагдаагийн газар: нь “Хаан даатгал” ХХК-тай гэрээ байгуулан, 10 алба хаагчийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгуулсан бөгөөд 590,0 мянган төгрөгийг алба хаагчид хувиасаа төлсөн байна.

1.4 Гэнэтийн ослын даатгал

Санхүү, аж ахуйн алба: нь 2018.05.10-ны өдөр нэг жилийн хугацаатай гэнэтийн ослын “Бадмаараг” даатгалын /дугаар 1816/126/43/ гэрээг “Миг даатгал” ХХК- байгуулжээ.

Нэг алба хаагчийн амь нас эрүүл мэндийг 8.000,0 мянган төгрөгөөр үнэлж, нийт 53.784.000,0 мянган төгрөгийн үнэлгээтэйгээр 6723 алба хаагчийг /161.352,0 мянган төгрөгийн даатгалын хураамж төлөхөөс 20 хувийн хөнгөлөлтийг тооцож/ 129.081.6 мянган төгрөгийн хураамж төлөхөөр гэрээ байгуулсан байна.

Гэнэтийн ослын даатгалыг учирч болзошгүй байгалийн бүх төрлийн эрсдэл, үйлдвэрлэл техникийн болон ахуйн холбогдолтой эрсдлүүд, мал, амьтдын нөлөөлөл, бусдад хорлогдох, зодуулах, бууны сум, болон хутга мэс зэрэг хүйтэн зэвсэгтэй дайрлтад өртөх, уурхай нурах дэлбэрэх, цөмрөлт, гулсалт, жүжигчин, тамирчдын бэлтгэл дасгал, сургуулилт хийх, уралдаан тэмцээн, тоглолтын үед бэртэж гэмтэх, цагдаагийн болон авран хамгаалах тусгай ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэж явах үеийн эрсдлүүд, мөн цагдаагийн алба хаагчид нь байгууллагаас албан ёсоор зохиогдож байгаа тэмцээн уралдаанд оролцох, марш тактикийн тэмцээн болон жагсаалын бэлтгэлийн үед цус харвах зэрэг 9 төрлийн эрсдлээс урьдчилан сэргийлж хийсэн бөгөөд уг гэрээнд даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзах 20 тохиолдол байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 9263 алба хаагч гэнэтийн ослын даатгалд урсгал төсвөөс төлбөр төлж хамрагдсан бөгөөд 2 аймгийн 264 алба хаагч хувиасаа хураамж төлж хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгалд хамрагдсан, мөн ипотекийн зээл авсан алба хаагчид Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 210 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан **“Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-д зааснаар** ердийн болон урт хугацааны даатгалд нас барах болон хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар алдах эрсдлийг даатгасан байна.

Ингэснээр байгууллагаас даатгалын төлбөр төлж, гэнэтийн ослын даатгалд 9263 алба хаагч хамрагдсан, мөн гэнэтийн ослын даатгалд

хамрагдсан алба хаагчдаас хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгалд 264 алба хаагч давхар даатгуулсан, ипотекийн зээл авсан алба хаагчид мөн хувиараа төлбөр төлж гэнэтийн ослын даатгалд хамрагдсан бөгөөд нэг алба хаагч гэнэтийн ослын 1-3 даатгалд хамрагдаж байна.

Гэнэтийн ослын даатгалын гэрээнд даатгуулагч буюу даатгагдсан этгээдийн гэнэтийн ослын улмаас эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн болон байнгын амбулаторын хяналтад байсан хуанлийн 90 хүртэл хоногийг хөдөлмөрийн чадварын түр алдалт гэсэн бол хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгалын гэрээнд даатгуулагч 90 хүртэл хоногийн хугацаанд эмнэлэг, амбулатори, гэрээр эмчлүүлэхийг хөдөлмөрийн чадвар түр алдалт гэж тусгажээ.

“Миг даатгал” ХХК-наас 2018 оны 12 дугаар сард ирүүлсэн гэнэтийн ослын даатгалын тайлангаар 56 тохиолдолд 42.767,7 мянган төгрөгийн нөхөн олговор олгосон байна.

Нийслэлийн цагдаагийн газар: нь гэнэтийн ослын даатгалд харьяа дүүргийн цагдаагийн хэлтсийн 2909 алба хаагчийг хамруулан, 34.856,9 мянган төгрөгийн хураамж төлж, “Монгол даатгал” ХХК-тай гэрээ байгуулжээ.

1.5 Хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгал

Сүхбаатар, Хэнтий аймаг дахь цагдаагийн газар: нь тухайн аймгуудад үйл ажиллагаа явуулж байгаа “Хаан даатгал” ХХК-ны салбартай хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгалын гэрээ байгуулжээ.

Гэрээнд заасан даатгалын тохиолдол үүссэн үед 90 хүртэл хоногийн хугацаанд эмнэлэг, амбулатори, гэрээр эмчлүүлсэн нөхцөлд хөдөлмөрийн чадвар алдсан ажлын нэг хоногт 10,0 мянган төгрөгийн нөхөн төлбөр олгохоор тусгажээ.

Дээрх 2 аймгийн цагдаагийн газрын 35 алба хаагч 2018 онд даатгалыг 32 тохиолдолд 3.135,0 мянган төгрөгийн нөхөн олговор авсан байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хувьд даатгалын байгууллагаас хамгийн өндөр нөхөн төлбөр авсан даатгалын төрөл нь гэнэтийн ослын болон хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгал байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын төсвийн үр ашиггүй зардалд дотоод аудит хийж, аудитын явцад илэрсэн зөрчил дутагдал болон тулгарч буй асуудлыг засаж, сайжруулах чиглэлээр дүгнэлт, зөвлөмж өгч, дэмжлэг үзүүлэх зорилготой.

2.2 Аудитын ажлын цар хүрээ

Байгууллагын 2018 оны туслах аж ахуйн үйл ажиллагаа болон цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчийн гэнэтийн осол, эд хөрөнгө, автотээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын даатгалтай холбоотой мэдээллийг аудитын объектод хамрууллаа.

2.3 Аудитын зохион байгуулалт

Дотоод аудитыг хэрэгжүүлэхдээ тухайн аудит хийхэд шаардлагатай хууль, тогтоомж, дүрэм, журам, бусад холбогдох бичиг баримттай танилцан, туслах аж ахуйн болон даатгалын үйлчилгээний талаар хангалттай мэдээлэл олж авахын тулд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын удирдлагаас албан бичгээр болон цахим хэлбэрээр дээрх үйл ажиллагааны талаарх мэдээллийг авч нэгтгэн, цуглуулсан мэдээлэл дээр үндэслэн тулган баталгаажуулах, нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх аргыг ашиглан дүгнэлт хийлээ.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Туслах аж ахуйн орлого

Цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь 2018 онд туслах аж ахуйн үйл ажиллагаанаас нийт 38.152,3 мянган төгрөгийн орлого олсон бөгөөд урсгал төсвийн харилцах дансанд 23.623,5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 4.711,7 мянган төгрөг төвлөрүүлсэн, 9.817,1 мянган төгрөгийг орлогын дансанд төвлөрүүлээгүй байна.

Үндсэн бус үйл ажиллагаанаас олсон 9.817,1 мянган төгрөгийг дансанд төвлөрүүлэхгүйгээр зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-д “Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна” гэсэн заалтыг зөрчжээ.

3.2 Туслах аж ахуйн зарлага

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын туслах аж ахуйд зориулан нийт 110.847,8 мянган төгрөг зарцуулснаас цалин хөлсөнд 70.226,1 мянган төгрөг, тээвэр шатахуунд 18.281,8 мянган төгрөг, өвс тэжээл бэлтгэхэд 19.674,2 мянган төгрөг, худаг гаргахад 270,0 мянган төгрөг, эм, вакцинд 2.395,7 мянган төгрөг зарцуулсан бөгөөд уг зардлын 95.929,6 мянган төгрөгийг урсгал төсвөөс, 14.918,2 мянган төгрөгийг үндсэн бус үйл ажиллагааны орлогоос зарцуулжээ. Цагдаа, дотоодын цэргийн 14 анги, байгууллага нь тухайн байгууллагын батлагдсан цалингийн сангаас 70.226,1 мянган төгрөгийг малчны цалинд олгосон байна.

Байгууллагын урсгал төсвөөс 95.929,6 мянган төгрөгийг үндсэн бус үйл ажиллагаанд зориулан зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-д “Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчжээ.

3.3 Жолоочийн хариуцлагын даатгал

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн алба нь мэргэшсэн болон С, D ангиллын жолоочийн даатгалд 5.029,2 мянган төгрөг, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд 57.547,0 мянган төгрөг, Нийслэлийн цагдаагийн газар 24.709,6 мянган төгрөг, Ховд аймаг дахь цагдаагийн газар 133,9 мянган төгрөгийг урсгал төсвөөс төлсөн байна.

Жолоочийн хариуцлагын даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-д “Замын хөдөлгөөнд оролцдоггүй байлдааны тусгай зориулалттай болон мөрдөх алба, цагдаа, зэвсэгт хүчин, хилийн цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагын тээврийн хэрэгсэлд энэ хууль хамаарахгүй” гэсэн заалтыг үндэслэн цагдаа, дотоодын цэргийн байгууллагын тээврийн хэрэгслийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамруулах шаардлагагүй байхад урсгал төсвөөс 87.419,7 мянган төгрөгийн хураамжийг даатгалын компанид төлж, үргүй зардал гаргажээ. Энэ төрлийн даатгалын нөхөн төлбөрт 3.868,6 мянган төгрөг авсан байна.

3.4 Гэнэтийн ослын болон хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгал

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн алба нь төв, харьяа нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн 41 байгууллагын 6723 алба хаагч, нийслэлийн цагдаагийн газар нь Улаанбаатар хотын болон харьяа дүүргийн 19 газар, хэлтсийн 2909 алба хаагч, нийт 9632 алба хаагчийг урсгал төсвөөс 163.938,4 мянган төгрөг төлж гэнэтийн ослын даатгалд хамруулсан, Хэнтий, Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газрын 264 алба хаагчид хувиасаа 14.256,0 мянган төгрөг төлж, хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгалд хамрагджээ. Дээрх 2 даатгалын төлбөрийн 36 хувийг нөхөн төлбөрт буцаан авсан байна. Нийслэлийн цагдаагийн газар нь даатгалын компанитай хамтран дүүргийн алба хаагчдад даатгалын талаар сургалт зохион байгуулжээ.

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн алба нь Даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.7 дахь хэсэгт “Монгол улсын хуулиар зөвшөөрснөөс бусад нөхцөлд даатгуулагчийн талаархи мэдээ, материалын нууцыг задруулахгүй байх” заалт болон даатгалын байгууллагуудтай байгуулсан гэрээний нууцлалыг хангах заалтыг үндэслэн 4 төрлийн даатгалын гэрээг даатгалд хамрагдсан нэгжүүдэд хүргүүлээгүй байна.

Гэнэтийн ослын болон хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгалын гэрээний аль алинд даатгалын зүйлийг ажилтнуудын амь нас, эрүүл мэнд гэж заасан байгаа бөгөөд хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгалын гэрээгээр зохицуулагдаж байгаа мэргэжлээс шалтгаалах өвчин болон ердийн өвчин, гэнэтийн ослын улмаас даатгуулагч тодорхой хугацаанд хөдөлмөрийн чадвараа түр алдах эрсдэлийг гэнэтийн ослын даатгалын гэрээнд нэмж тусгах боломжийг судалж үзэх шаардлагатай байна.

4. ДҮГНЭЛТ

Цагдаа, дотоодын цэргийн 60 анги байгууллагаас гэнэтийн ослын даатгалд 9632 алба хаагч, тээврийн хэрэгслийн даатгалд 1107 тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын даатгалд 1489 алба хаагч, эд хөрөнгийн даатгалд 635 барилга байгууламж, 21 төрлийн тоног төхөөрөмж, 87 төрлийн эд хогшил, хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгалд 264 алба хаагчийг хамруулсан байна.

Нийт 5 төрлийн даатгалын хураамжид 465.705,1 мянган төгрөг төлснөөс 96,7 хувь буюу 450.203,2 мянган төгрөгийг урсгал төсвөөс, 3,3 хувь буюу 15.501,9 мянган төгрөгийг алба хаагчид хувиасаа төлж даатгал хийлгэжээ. Алба хаагчдын хувиасаа хураамж төлж даатгасан даатгалыг үзэхэд хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгалд 14.256,0 мянган төгрөг, жолоочийн хариуцлагын даатгалд 1.245,9 мянган төгрөг төлжээ.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд цагдаа, дотоодын цэргийн тээврийн хэрэгслийг хамруулах шаардлагагүй байхад урсгал төсвөөс 87.419,7 мянган төгрөгийн хураамж төлж даатгуулсан байна. Мөн цагдаа, дотоодын цэргийн алба хаагчид гэнэтийн ослын болон хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгалд 1-3 даатгалын байгууллагад хувиасаа болон байгууллагаас төлбөр төлж хамрагджээ.

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны даргын 2018 оны 6/687, 6/1215 дугаар албан бичгээр даатгал хийсэн компанийн нэр болон даатгалын гэрээгээр хамгаалагдсан эрсдлээс өөр мэдээлэл байхгүй, нэгдсэн журмаар байгуулсан даатгалын гэрээг “нууц” гэсэн үндэслэлээр даатгалд хамрагдсан нэгжүүдэд хүргүүлээгүй учраас даатгалын талаарх мэдээлэл дутмаг, авах ёстой нөхөн төлбөрийг бүрэн авч чадахгүй байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагаас 29 байгууллага туслах аж ахуй эрхэлж байгаа бөгөөд үндсэн бус үйл ажиллагааны орлогын 9.817,1 мянган төгрөгийг төсвийн дансанд тушаагаагүй, үндсэн бус үйл ажиллагаанд зориулан урсгал төсвөөс 95.929,6 мянган төгрөг зарцуулсан байна.

Төсвийн үр ашиггүй зардалд хийх аудитын хүрээнд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын үндсэн бус үйл ажиллагаатай холбоотой 105.746.7 мянган төгрөг, даатгалтай холбоотой 87.419,7 мянган төгрөг, нийт 193.166,4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

5. ЗӨВЛӨМЖ, САНАЛ

5.1 Даатгалын байгууллагатай хийх гэрээг Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсээр хянуулж байх;

5.2 Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын даатгалын байгууллагуудтай хийсэн гэрээг хянаж, даатгалын байгууллагад төлсөн төсвийн хөрөнгийг үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор даатгалын гэрээний нөхцлийг сайжруулах, даатгалын байгууллагаас урамшуулал болон нөхөн төлбөр авах боломжийг нэмэгдүүлэх асуудлыг нарийвчлан судалж үзэх, шаардлагагүй даатгалыг зогсоох;

5.3 Төв болон харьяа нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад даатгалын гэрээг хүргүүлэх;

5.4 Даатгалын компанитай гэнэтийн ослын болон хөдөлмөрийн чадвар түр алдалтын гэрээ байгуулахдаа хөдөлмөрийн чадвар түр алдалт гэсэн ойлголтыг даатгалын төрлөөсөө хамааран өөр өөрөөр тодорхойлж байгааг нэгдсэн ойлголттой болгох, гэнэтийн ослын даатгал хийхдээ хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгалыг хамтруулан хийх боломжийг судлах, мөн даатгалын гэрээнд нөхөн төлбөр олгох нөхцөл нь нөхөн төлбөр олгохоос татгалзах нөхцлөөр үгүйсгэгдэж байгаа эсэхийг болон даатгалын үр ашгийг нэмэгдүүлэх талаар судалж үзэх;

5.5 Жолоочийн хариуцлагын даатгалыг зарим нэгжүүд байгууллагын урсгал төсвөөс, зарим байгууллагын алба хаагчид хувиасаа хураамж төлж даатгуулж байгааг цэгцэлж, байгууллагаас болон хувиасаа төлөх даатгалын ялгааг тодорхой болгох;

5.6 Гэнэтийн ослын даатгалаас нөхөн төлбөр аваагүй тохиолдолд даатгалын урамшуулалд алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулах асуудлыг даатгалын байгууллагатай тохиролцож, шийдвэрлэх талаар тодорхой ажил зохион байгуулах;

5.7 Цагдаа, дотоодын цэргийн туслах аж ахуй бүхий анги, байгууллагуудад үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахгүй байх зөвлөмжийг хүргүүлэх.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2020 оны 03 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага дахь шилэн дансны тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хийх нийцлийн аудит

Аудит хийгдсэн нэгж: Цагдаа, дотоодын цэргийн 52 анги, байгууллага

Аудитын объект: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл.

Аудитын төрөл, код: Нийцлийн аудит, ЦЕГ-ХШДАХ/НА-2020/03

Аудитын хугацаа: 2020.01.30- 2020.03.09

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн.

Аудитын багийн гишүүн: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч Ц.Болормаа

1. ТАНИЛЦУУЛГА

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.2, 8.5 дахь заалт, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах /код 135/ журам”-ын 135.7.4 дэх хэсэгт тус тус заасны дагуу цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 “...төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ”, “Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах /Код 135/ журам”-ын 135.7.4-т “Энэ журмын хэрэгжилтэд хагас жил тутамд хяналт шинжилгээг Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын ажил хариуцсан нэгж хийж, зөвлөмж, дүгнэлт гаргана” гэж заасны дагуу тус хэлтсээс цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага дахь шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудит хийж, илэрсэн алдаа, дутагдлыг залруулах чиглэлээр үүрэг, зөвлөмжийг хүргүүлэн ажилладаг.

Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.2. ”Дотоод аудитын алба нь улирлын

нэгдсэн тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа сарын 25-ны дотор хүргүүлнэ”, мөн журмын 8.5.” Төсвийн ерөнхийлөн захирагч (дотоод аудитын алба) нь Шилэн дансны тухай хуулийн 8.2-т заасны дагуу шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана” заалтыг тус тус үндэслэн цагдаа, дотоодын цэргийн 52 байгууллагын шилэн дансны аудитын тайланг улирал бүр хүлээн авч нэгтгэн, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хуулийн хугацаанд илгээж байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 20 төрлийн мэдээллийг цагдаа, дотоодын цэргийн 52 байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн байршуулж байгаа бөгөөд Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийх аудитад тухай бүр хамрагдан, “Хангалттай” үнэлгээтэй дүгнэгдэн ажиллаж байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2020 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.14-т заасны дагуу цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас шилэн дансны тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлж буй байдалд аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хүргүүлж, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах нь дотоод аудитын зорилго юм.

2.2 Аудитын цар хүрээ

2019 онд цагдаа, дотоодын цэргийн 52 анги, байгууллагаас шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг аудитын объектод хамруулаа.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг зохицуулсан хууль, тогтоомж, дүрэм, журам, бусад холбогдох бичиг баримттай танилцаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудасны төсөв санхүү, тендер, худалдан авах ажиллагаа, бусад гэсэн 3 цэсэнд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын байршуулсан мэдээлэлд үндэслэн хийлээ.

Засгийн газрын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2019 онд цагдаа, дотоодын цэргийн нэг байгууллагын байршуулсан 21 төрлийн 149 мэдээллийг тулган баталгаажуулж, 52 байгууллагын байршуулсан 21 төрлийн 7190 мэдээллийг нэгтгэн, аудитын тайланд ашиглалаа.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2019 оны жилийн эцсийн байдлаар / хэрэглэгчийн хэсэгт байршуулсан мэдээлэл/ нэгтгэн үнэлэхэд нийт 20 төрлийн 7190 мэдээлэл байршуулахаас байршуулах хугацаа болоогүй 2 төрлийн 104 мэдээлэл байгаа бөгөөд байршуулсан 7086 мэдээллээс 6730-г хугацаанд нь, 356-г хугацаа хоцорч байршуулжээ /Хүснэгт 1/.

Хүснэгт 1

д/д	Байршуулах мэдээллийн төрөл	Нийт мэдээлэх	Мэдээлсэн	Хугацаандаа	Хоцорсон	Байршуулах хугацаа болоогүй	Програмд татагдахгүй байгаа	Байршуулаагүй мэдээлэл	Хэрэгжилтийн хувь
1.Төсөв, гүйцэтгэл									
1.	Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)	52	52	51	1	0	0	0	100
2.	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр,Хагас жилээр,Улирал бүр,Сар бүр)	772	772	729	37	0	6	0	100
3.	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)	576	576	552	24	0	0	0	100
4.	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (Бүтэн жилээр,Хагас жилээр)	98	98	89	3	0	6	0	100
5.	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)	98	98	90	2	0	6	0	100
6.	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)	576	576	540	36	0	0	0	100
7.	Санхүүгийн тайлан (Хагас жилээр)	46	46	43	3	0	0	0	100
8.	Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр)	52	0	0	0	52	0	0	100

Албан хэрэгцээнд

9.	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)	52	0	0	0	52	0	0	100
10.	Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)	52	52	35	11	0	6	0	100
ДҮН		2374	2274	2129	117	104	24	0	100
2. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт:									
1.	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Бүтэн жилээр)	52	52	30	16	0	6	0	100
2.	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр)	628	628	573	49	0	6	0	100
3.	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр)	576	576	556	20	0	0	0	100
4.	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр)	576	576	543	33	0	0	0	100
5.	Худалдан авах ажиллагааны тайлан (Бүтэн жилээр)	52	52	45	1	0	6	0	100
ДҮН		1884	1884	1747	119	0	18	0	100
3. Бусад									
1.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр)	576	576	554	22	0	0	0	100
2.	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр)	576	576	549	27	0	0	0	100
3.	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (Бүтэн жилээр)	52	52	46	0	0	6	0	100

4.	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (Тухай бүр)	576	576	556	20	0	0	0	100
5.	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (Сар бүр)	576	576	519	33	0	24	0	100
6.	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн (Тухай бүр)	576	576	558	18	0	0	0	100
ДҮН		2932	2932	2782	120	0	30	0	100
НИЙТ		7190	7190	6658	356	104	72	0	100

3.2 Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын Засгийн газрын шилэн дансны нэгдсэн цахим хуудасны байгууллагын админ эрхтэй хэрэглэгчийн аудитын тайланд татагдаж байгаа мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэлтэй тулгахад 4 дэд цэсний 4 мэдээлэл бүрэн татагдахгүй, 1 мэдээлэл дутуу, тухайн онд шинээр бүртгүүлсэн 7 байгууллагын 9 төрлийн 72 мэдээлэл нь программын алдаанаас шалтгаалан шилэн дансны аудитын нэгдсэн тайланд татагдахгүй байна. Иймээс шилэн дансны нэгдсэн цахим хуудасны аудитын тайлангаар татагдсан тоон мэдээлэл нь хэрэглэгчийн хэсэгт байршуулсан мэдээллээс зөрүүтэй байна.

3.3 Хугацаа хоцорч байршуулсан 236 мэдээллийн 22 буюу 9.3 хувь нь “Тогтсон хугацаа”-нд 191 буюу 81 хувь нь “Долоо хоног”-ийн дотор, 23 буюу 9.7 хувь нь “Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компанийн мэдээлэл” эзэлж байна. 2019 оны жилийн эцсийн шилэн дансны аудитын тайлангийн мэдээллийг өссөн дүнгээр нэгтгэн үзэхэд батлагдсан төсөв 154.392,2 мянган төгрөг, гүйцэтгэл 154.862,2 мянган төгрөгөөр мэдээлэгдсэн, зөрүү 338,1 мянган төгрөг байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн нэгтгэл /Шилэн дансны аудитын тайлангаар/

Хүснэгт 2

д/д	Тайлангийн төрөл	Нийт мэдээлэх	Хугацаандаа	Хугацаа хоцорсон	Байршуулаагүй	Барйшуулах хугацаа болоогүй
1.	“Долоо хоног”-ийн дотор байршуулах мэдээлэл	4032	3841	191	-	-
2.	“Тогтсон хугацаа”-нд байршуулах мэдээлэл	490	364	22	-	104

3.	Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компаний мэдээлэл	622	599	23	-	-
НИЙТ		5144	4804	236	-	104

3.4 Цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь 7 төрлийн 4032 мэдээллийг “долоо хоногийн дотор” байршуулахаас 3841-ийг хугацаанд нь, 191-ийг хуулийн хугацаа хоцроож байршуулснаар шилэн дансны аудитын тайланд татагдаж байна /Хүснэгт 3/.

“Долоо хоногийн дотор” хэсэгт 25 байгууллага Шилэн дансны тухай хуулинд заасан хугацааг хоцроон мэдээлэл байршуулжээ. Тухайлбал. Баян-Өлгий аймаг дахь цагдаагийн газар 6, Цагдаагийн ерөнхий газрын Гэрээт хамгаалалт, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, Завхан, Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газар, Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын цагдаагийн хэлтэс, Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэс 7, Мөрдөн байцаах алба, Цагдаагийн ерөнхий газрын “Сүлд” чуулга 9, “Сүүж-Уул” амралт, сэргээн засах сувилал, Архангай аймаг дахь цагдаагийн газар, Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэс 14, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар 16 мэдээллийг тус тус хугацаа хоцроон байршуулсан байна.

3.5 Шилэн дансны аудитын 2019 оны жилийн эцсийн тайлангаар цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь “Тогтсон хугацаа”-нд 11 төрлийн 490 мэдээллийг байршуулахаас 364-ийг хугацаанд нь, 22 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож байршуулсан, байршуулах хугацаа болоогүй 104 мэдээлэл байна /Хүснэгт 4/.

2019 оны жилийн эцсийн байдлаар “Тогтсон хугацаа”-нд байршуулах мэдээллээс Шилэн дансны тухай хуулийн 6.1.4, 6.1.5 дахь хэсэгт зааснаар “Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт” /бүтэн жил/ 52, “Санхүүгийн тайлан” /бүтэн жил/ хэсэгт 52, нийт 104 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй, “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө” /бүтэн жил/ хэсэгт 16, “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт” /улирал бүр/ хэсэгт 3, “Санхүүгийн тайлан” /хагас жил/ хэсэгт 3 мэдээллийг хугацаа хоцорч байршуулжээ.

3.6 “Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компаний мэдээлэл” хэсэгт нийт 622 мэдээлэл байршуулахаас хугацаанд нь 599, хугацаа хоцорч 23 мэдээлэл байршуулсан байна.

Шилэн дансны цахим хуудсанд “Худалдан авах ажиллагааны тайлан /бүтэн жил” хэсэгт 3, “Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл” /тухай бүр/ хэсэгт 20, нийт 23 мэдээллийг Шилэн дансны тухай хуульд заасан хугацааг хоцроож мэдээлжээ. /Хүснэгт 5/

4. ДҮГНЭЛТ

Шилэн дансны нэгдсэн программын үйл ажиллагаанд саатал гарснаас шалтгаалан 2019 оны нэгдүгээр улирлын аудитын тайланг байгууллагын админ хэрэглэгчийн эрхээр хянах боломжгүй байсан бөгөөд 3 байгууллага шилэн дансны аудитын тайланг хугацаа хоцорч илгээсэн, сүүлийн 3 улирлын тайланг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагууд тайлант хугацаанд бүрэн илгээсэн байна.

Цагдаа, дотоодын цэргийн 52 анги, байгууллага 2019 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 7190 мэдээлэл байршуулахаас байршуулах хугацаа болоогүй 104 мэдээлэл байгаа бөгөөд байршуулсан 7086 мэдээллээс 6730-г хугацаанд нь, 356-г хугацаа хоцорч байршуулжээ.

Шилэн дансны аудитын тайланд 5144 мэдээлэл байршуулахаас хугацаанд нь 4804, хугацаа хоцорч 236 мэдээлэл байршуулсан, 104 мэдээллийг байршуулах хугацаа болоогүйгээр татагдаж байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар цагдаа, дотоодын цэргийн 52 байгууллагаас 22 нь 1-5, 7 нь 6-10, 8 нь 11-ээс дээш мэдээллийг хугацаа хоцроон шилэн дансны цахим хуудсанд байршуулжээ.

2019 оны оны 1, 3, 4 дүгээр саруудад шилэн дансны цахим хуудасны программд саатал гарснаас зарим мэдээллийг байршуулах боломжгүй, шивсэн мэдээлэл устсанаас мэдээллийг нөхөн байршуулсан, байршуулсан мэдээллийг засварласан, мэдээлэл байршуулах үүрэг бүхий алба хаагч нь мэдээллийг хугацаандаа шивээгүй зэрэг нь мэдээллийг хугацаа хоцорч байршуулах шалтгаан болжээ.

Цаашид цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагууд нь Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол, Сангийн яамнаас сүлжээгээр хүргүүлж байгаа зөвлөмж, заавар болон Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дэд дарга, ХШДАХ-ийн дарга нараас Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр хүргүүлсэн зөвлөмж, үүрэг, ажлын чиглэлийг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

5. ЗӨВЛӨМЖ

5.1 Шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан, ажил гүйлгээ хийсэн, хөндлөнгөөс нөлөөлсөн албан тушаалтан нь шилэн дансны цахим хуудсанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (*Тухай бүр*) хэсэгт захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг байршуулах;

5.2 Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (*тухай бүр*), хэсэгт мэдээллийг бүрэн байршуулж, шийдвэрийн хуулбарыг хавсаргах;

5.3 Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны “29 дүгээр тогтоолд заасны дагуу төсөв санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд тогтоосон хугацаанд иж бүрэн, үнэн зөв байршуулж, баталгаажуулах, “долоо хоногийн дотор” байршуулах мэдээллийг хугацаанд нь байршуулах талаар онцгойлон анхаарах;

5.4 Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны “Бусад” цэсний “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”-ийн хэсэгт тухайн ажил, гүйлгээний мөнгөн дүнг харгалзахгүйгээр мөнгө, хөрөнгө зарцуулсан болон өглөг, авлагатай холбоотой шийдвэрүүдийг жагсаалтаар бүрэн мэдээлж, шийдвэрийг “PDF” форматаар хавсаргах;

5.5 Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д 10 сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн байгууллагууд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн байршуулан ажиллаж байгаа эсэхэд тавих хяналтыг санхүүжилт өгсөн байгууллагын хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтан хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дарга, нягтлан бодогч нарт хүргүүлэх саналтай байгааг илтгэн танилцуулж байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаагийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2018 онд хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага

Аудитын төрөл: Санхүүгийн аудит

Аудитын хугацаа: 2019.06.24-2019.06.28, 2019.09.16-2019.09.25

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа С.Март

1. ТАНИЛЦУУЛГА

Цагдаагийн ерөнхий газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 61 төсөвт байгууллага, 1 төрийн өмчит үйлдвэрийн газар, нийт 62 байгууллагын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Үндэсний аудитын газар болон орон нутгийн аудитын газарт хүргүүлж, 61 байгууллагаас 1 байгууллага нууцын зэрэглэлтэй тул аудит хийгдээгүй, 16 байгууллагыг түүвэрт хамруулж, 7 байгууллагад итгэл үзүүлж, 37 байгууллагад аудит хийжээ.

Хөндлөнгийн аудит буюу төрийн аудитын байгууллагаас Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийж, 1.104.111,1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрүүлж, 535.909,9 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг аудитын явцад залруулан, 568,201,2 мянган төгрөгийн алдаа, зөрчил залруулагдаагүй ба өмнөх оны алдаа, зөрчлөөс 56.1 хувиар буурчээ. Залруулагдаагүй үлдсэн нийт 9 асуудлаар 5.541,3 мянган төгрөгийн алдаанд нөхөн төлүүлэх акт тавигдаж, 36 асуудлаар 179.234,4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 60 асуудлаар 383.425,5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах, хөндлөнгийн аудитын байгууллага, санхүүгийн шалгалтуудаар зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд үнэлэлт өгч, эрсдэлийн дүн шинжилгээ хийж, тулгарч буй асуудлыг засаж, сайжруулах чиглэлээр дүгнэж, дэмжлэг үзүүлж, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор аудит хийж, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг хангууллаа.

Дотоод аудитын явцад “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хөндлөнгийн аудитын тайлан, дүгнэлт, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлага”-ын хэрэгжилтийг 61 байгууллага ирүүлж, 6 асуудлаар 5.541,3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос 4832,01 мянган төгрөг буюу 87,2, 19 асуудлаар 179.234,4 мянган төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага өгснөөс 174036,6 мянган төгрөг буюу 97,1, 33 асуудлаар 383425,5 мянган төгрөгийн зөрчил арилгуулах зөвлөмж өгснөөс 374606,74 мянган төгрөг буюу 97,7 хувийн хэрэгжилттэй байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

Хөндлөнгийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг хангуулснаар Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа сайжирч, дахин давтан алдаа, зөрчил илрэхгүй байх, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

2.2 Аудитын цар хүрээ

Аудитор Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 62 нэгж байгууллагын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газар болон орон нутгийн аудитын газраас хийсэн баталгаажуулах аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг хамруулсан.

Санхүү, аж ахуйн албанаас нэгтгэн ирүүлсэн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хэрэгжилтээс цар хүрээгээ тогтоож, хэрэгжилтээ дутуу ирүүлсэн нэгжийн материалыг түүвэрлэн авч, аудитын объектод хамруулсан. Нэгжүүдээс ирүүлсэн баримт материалаас хэрэгжилт хангалттай ирүүлсэн гэж үнэлэгдсэн нэгжийн материалыг нэг бүрчлэн үзэх нь ажлын давхардал үүсэхээр байх тул аудитын объектод хамруулаагүй болно.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ холбогдох алба хаагчидтай ярилцлага хийх, асуулга, тайлбар, нэмэлт мэдээлэл цуглуулах, нотлох аргыг боловсруулан Санхүү, аж ахуйн албанаас ирүүлсэн материалаас түүвэр хийж, тулган баталгаажуулахад ашиглалаа.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газар: Ажилчдын амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан бодсон, үр дүнгийн урамшуулал, томилолтын мөнгийг илүү, дутуу олгосон асуудалд “2019 оны 06 сарын

01-ний дотор илүү олголтыг орон нутгийн татварын бус орлогын дансанд төвлөрүүлэх, дутуу олгосон цалингийн өглөгийг барагдуулах 3775,0 мянган төгрөгийн” акт тавигдсан байна.

Тус цагдаагийн газар нь 3064,5 мянган төгрөгийг аймгийн Төрийн сангийн орлогын 100050000982 дугаар дансанд шилжүүлж, 710,5 мянган төгрөгийн актыг хэрэгжүүлээгүй байна.

3.2 Говьсүмбэр аймаг дахь Цагдаагийн хэлтэс: Бараа материалын зарцуулалтад НХ маягт хөтлөөгүй олгосон асуудалд “Тусгай зориулалтын материалын зарцуулалт, бүртгэл тайлагналд хэрхэн хяналт тавих талаар Нягтлан бодох бүртгэлийн Бодлогын бичиг баримтад тусгайлан заах санал оруулах” зөвлөмж өгчээ.

Тус цагдаагийн хэлтэс нь “Тусгай зориулалтын материалын данснаас албаны зориулалтаар гарч байгаа хэрэгслийг Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан анхан шатны “НХМаягт БМ-6” маягт, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 235/-ын дагуу баримтуудыг бүрдүүлэн, зарцуулдаг” гэсэн хэрэгжилтийн тайлан гаргаж ирүүлжээ.

Ирүүлсэн биелэлтийг үнэлэхэд хэрэгжилт тодорхойгүй, дэмжих баримтгүй байсан тул нягтлан бодогч, цагдаагийн хошууч Л.Гүнжинлхамаас тодруулахад “Галт зэвсэг, сум олгосон талаар аудитад тайлбарласан, тухай үед хэлтсийн даргын тушаалаар зарлагддаг гэсэн боловч зөвлөмж бичээд өгчихсөн” гэсэн тайлбар өгсөн.

3.3 Ховд аймаг дахь цагдаагийн газар: Аймгийн аудитын газраас хийсэн аудитаар “Цагдаагийн газрын даргын тушаалаар сахилгын арга хэмжээг цалингаас суутгахдаа алба хаагчдын цалингийн суутгалыг нэмэгдэл талд хасах тэмдэгтэй 11,1 сая төгрөгийг суутган цалингийн зардлыг шууд бууруулан хүлээн зөвшөөрсөн байна.” гэсэн зөрчлийг илрүүлж, “Холбогдох стандарт заавар журмыг мөрдөн ажиллах” зөвлөмж өгсөн байна.

Тус цагдаагийн газар нь “Цалингийн арга хэмжээний суутгалыг цалин хөлсний суутгал хэсэгт бүртгэн үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрөх гэсэн зөвлөмж өгснийг цагдаагийн байгууллага улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Монгол Улсад мөрдөж байгаа журам, заавартай нийцэхгүй байна гэж үзэж тайлбар бичин, зөвлөмж авахаар албан бичгийг хүргүүлсэн ба одоогоор хариу ирүүлээгүй байна.” гэсэн хэрэгжилтийн тайлан ирүүлсэн.

Өмнөх 2017 оны Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газар, Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтэс, бусад нэгжүүдэд дээрх зөрчил удаа дараа илэрч, тус нэгжээс 2018 оны 04 дүгээр сарын 28 -ны өдрийн албан бичгээр ажлын чиглэл авах хүсэлтийг ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албаар уламжлан Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газарт

хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй ба 2018 онд тухайн зөрчил дахин давтагдсан байна.

3.4 Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэс: Нийслэлийн аудитын газраас хийсэн аудитаар “Ажилтан албан хаагчдын цалингаас ХХОАТ 135.9 мянган төгрөгийг дутуу суутгаж төсөвт төлөөгүй” алдааг илрүүлж, төлбөрийн акт тавьжээ. Мөн “Бичиг хэргийн зардалд 585.1, халаалтын зардал 800.0, урсгал засварын зардал 44.0, эмийн зардал 266.4 бүгд 1695.4 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн зарцуулж батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулахгүй байгааг талаар” зөвлөмж өгсөн байна.

Өмнөх 2017 онд Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар энэ төрлийн зөрчил илэрч байсан. Бүртгэлээр тавих хяналт сул байгаад хариуцлага тооцон, дүнг материалаар ирүүлэх үүрэг, чиглэлийг ЦЕГ-ын Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсээс ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албанд зөвлөмж өгч байсан боловч 2018 онд мөн зөрчил давтагдан гарч байгаа нь удирдлага, нягтлан бодогч нар ажлаа шуурхай хийж, ажлын хариуцлага сайжруулах шаардлагатайгаас гадна төсвийн сахилга бат сулрах эрсдэл өндөр байгааг харуулж байна.

3.5 Хэнтий аймаг дахь Цагдаагийн газар: Аймгийн аудитын газраас хийсэн аудитаар “Түлш халаалтын зардлаас 1190,0 мянган төгрөгийг нормын хувцас худалдан авах зардалд шилжүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан “төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-ыг ашиглах заавар, “үнэн зөв байдал, санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх” гэсэн санхүүгийн тайлангийн батламж мэдэгдэл”-үүдийг хангахгүй байсан зөрчлийг илрүүлж, “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, зарлагыг эдийн засгийн ангиллын дагуу бүртгэж байх” зөвлөмж өгсөн байна.

Тус цагдаагийн газар нь “Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны даргын “Ажлын чиглэл хүргүүлэх тухай” 2018 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 6/1456 дугаартай албан даалгавар, үүргийн дагуу ерөнжилтийн бэлтгэл хангах чиглэлээр тодорхой зааварчлага өгснийг хэрэгжүүлж, нийт 7 /долоон/ ажилтныг улирлын чанартай ажиллуулж байгаагаас төв конторын барилгын халаалтын зууханд 3 слесарь, 3 галч, Жаргалтхаан сумын Цагдаагийн тасагт 1 галч, үйлчлэгч нарыг ажлын хувцас, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангахад зориулан 7 ш ажлын гутал болон гадуур хувцасны 1190,0 мянган төгрөгийг түлш халаалтын зардлаас олгожээ. Байгууллагын батлагдсан төсөвт нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардалд жилд 1,5 сая төгрөг байдаг ба тухайн

халаалтын зуухны ажиллагсадтай холбоотой зардал жилийн 10 сард гардаг тул хүндрэл учирдаг. Цаашид уг зардлыг Сангийн сайдын зардал хооронд шилжүүлэх журмын дагуу шилжүүлэн зарцуулж ажиллана.” гэсэн хэрэгжилтийн тайлан ирүүлсэн.

3.6 Дорнод аймаг дахь Цагдаагийн газар: Аймгийн аудитын газраас хийсэн аудитаар “Үндсэн хөрөнгийн бүртгэлд анхны өртгөө нөхсөн 266 нэр бүхий хөрөнгө нь үнэлгээ, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалт, УСНББОУС-17 -ийн шаардлагыг тус тус зөрчсөн байна” гэсэн зөрчлийг илрүүлж, “Холбогдох дээд байгууллагад саналаа хүргүүлж, шийдвэр гаргуулах”, УСНББОУС-17 -г хэрэгжүүлэх” зөвлөмж өгчээ.

Тус цагдаагийн газар нь “2019 онд Сангийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 207 дугаар тушаалын 6 дугаар хавсралт “Хөрөнгийн үнэлгээнд баримтлах үл хөдлөх ба хөдлөх хөрөнгийн ашиглалтын норматив хугацаа”-г үндэслэн байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд анхны өртгөө нөхсөн 266 нэр төрлийн хөрөнгөөс 2019 оны 01 дүгээр улиралд 46 нэр төрлийн хөрөнгийг акталж, тус цагдаагийн газрын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын хэсэг 220 нэр төрлийн хөрөнгийг дахин үнэлж цаашид ашиглах хугацааг тогтоож, шийдвэр гаргуулахаар Аймгийн орон нутгийн өмчийн албанд хүргүүлээд байна” гэсэн хэрэгжилтийн тайлан ирүүлсэн.

3.7 Дорноговь аймаг дахь Цагдаагийн газар: Аймгийн аудитын газраас хийсэн аудитаар “Бараа материал бэлтгэх урьдчилгаа дансанд 2017 оны 12 дугаар сарын 31-нд 27.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 2018 оны 12 дугаар сарын 31-нд 29.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй санхүүгийн тайланд тайлагнасан буюу 2.7 сая төгрөгөөр уг дансыг нэмэгдүүлсэн байна.” гэсэн зөрчлийг илрүүлж, “Урьдчилж төлсөн тооцоо дансны 29.8 сая төгрөгийг барагдуулж ажиллах” албан шаардлага өгчээ.

Тус цагдаагийн газар нь “ 2019 оны 09 дугаар сарын 19-ны байдлаар “Петростар ХХК-ний дансанд байгаа 29.8 сая төгрөгийн үлдэгдлээс 27.9 сая төгрөгийн шатахуун авч зарцуулж 1.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.”гэсэн нь албан шаардлага хэрэгжих ёстой хугацаандаа биелэгдээгүй байна. Албан шаардлагын хэрэгжилт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2.2 дахь заалтын дагуу хариуцлага тооцуулах эрсдэлтэй.

3.8 Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газар: Аймгийн аудитын газраас хийсэн аудитаар “Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас шалгахад 2 ширхэг хашаа хайс, 509 ширхэг машин тоног төхөөрөмж, 13 ширхэг авто тээврийн хэрэгсэл, 6 ширхэг программ хангамж, 6 ширхэг бусад үндсэн хөрөнгө, 513 ширхэг тавилга эд хогшил нийт 1049 ширхэг үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан хөрөнгө үлдэх өртөггүй бүртгэлд байгаа нь УСНББОУС 17, НББОУС 16 стандартыг зөрчиж

байна.” гэсэн зөрчилд “Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.39 /элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг ашиглалтаас хасахгүй тохиолдолд тухайн хөрөнгийг хуримтлагдсан элэгдлийнх нь хамт данснаас хасах хүртэл нь бүртгэлд нь хэвээр тусгана/-дэх хэсэг, УСНББОУС-17, НББОУС-16 стандартад заасны дагуу ашиглалтын шаардлага хангахгүй үндсэн хөрөнгийг актлах, цаашид ашиглах үндсэн хөрөнгийг үнэ тогтоох, дахин үнэлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажиллах” зөвлөмжийг өгсөн байна.

Тус цагдаагийн газар нь “1049 хөрөнгөнөөс эхний хагас жилийн тайландаа элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 152 ширхэг хөрөнгийг ашиглалтаас хасахгүй цаашид ашиглах шаардлагатай байгаа тул тухайн хөрөнгийг үнэлгээ тогтоон бүртгэлд тусгах санал, УСНББОУС 17, НББОУС 16 стандартын дагуу ашиглалтын шаардлага хангахгүй 897 ширхэг үндсэн хөрөнгийг актлах саналыг тус тус аймгийн Өмчийн газарт 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 39/1820 дугаар албан тоотоор холбогдох материалын хамт хүргүүлээ.” гэсэн хэрэгжилтийг ирүүлсэн байгаа нь хангалтгүй байна.

Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газар нь жил бүр хөрөнгийг чанар байдлаар ангилан, тооллогыг чанартай хийж, тооллогын комисс хөрөнгийн ашиглалтад үнэлгээ өгч, байгууллагын удирдлагад танилцуулж актлах ба ашиглах хөрөнгүүдийг тодорхойлж, шийдвэр гарган ажиллаагүйгээс энэ зөрчил гарсан гэж үзэж байгаа тул зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар дорвитой ажил зохион байгуулах явдал удаашралтай байна.

4. ДҮГНЭЛТ

Төрийн аудитаас санхүүгийн тайланг баталгаажуулах явцад Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагууд болон Цагдаагийн ерөнхий газрын санхүүгийн 2018 оны нэгтгэсэн тайлан “зөрчилгүй” санал, дүгнэлттэй шалгагдаж, тухайн аудитаар Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дотоод хяналтыг “хангалттай” үнэлсэн нь өмнөх оны алдаа, зөрчлөөс 56.1 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа хэдий ч материаллаг бус алдаа, зөрчил илэрсээр байна.

Мөн цалингийн арга хэмжээний суутгалыг цалингийн хүснэгтийн нэмэгдэл талд хасах тэмдэгтэй суутган цалингийн зардлыг шууд бууруулан хүлээн зөвшөөрсөн бичилтийг зөрчил гэж үзэн, “цалин хөлсний суутгал хэсэгт бүртгэн үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрөх, холбогдох стандарт заавар журмыг мөрдөн ажиллах” гэсэн зөвлөмжийг өгсөөр байна.

Цагдаагийн байгууллага улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Монгол Улсад мөрдөж байгаа журам, заавартай нийцэхгүй байна гэж үзэн тайлбар бичиж, зөвлөмж авахаар Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын дарга, тэргүүлэх

аудитор Ц.Наранчимэгийн нэр дээр албан бичгийг хүргүүлсэн ба одоогоор хариу ирүүлээгүй тул энэ асуудал шийдэгдэхгүй, нягтлан бодогч нарт нэг мөр ойлголт байхгүй байна.

Дотоод аудитын явцад “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хөндлөнгийн аудитын тайлан, дүгнэлт, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлага”-ын хэрэгжилтийг 61 байгууллага ирүүлж, 6 асуудлаар 5.541,3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос 4832,01 мянган төгрөг буюу 87,2, 19 асуудлаар 179.234,4 мянган төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага өгснөөс 174036,6 мянган төгрөг буюу 97,1, 33 асуудлаар 383425,5 мянган төгрөгийн зөрчил арилгуулах зөвлөмж өгснөөс 374606,74 мянган төгрөг буюу 97,7 хувийн хэрэгжилттэй байна.

Иймд хөндлөнгийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангуулах үүрэг, чиглэлийг Санхүү, аж ахуйн албанаас нэгжүүдэд хүргүүлж, тулгарч буй асуудлыг засаж, сайжруулах чиглэлээр дэмжлэг үзүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй байна.

5. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Аудитын эцсийн тайлангийн дүгнэлтийг үндэслэн хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн биелүүлээгүй байгаа нэгжүүдэд шуурхай ажил зохион байгуулах чиглэлээр дараах зөвлөмжийг хүргүүлэх саналтай байгааг илтгэн танилцуулъя. Үүнд:

5.1 Орон нутгийн татварын бус орлогын дансанд төвлөрүүлэх 710,5 мянган төгрөгийн өглөгийг барагдуулах актыг бүрэн хэрэгжүүлэх; */Говь-Алтай/*

5.2 Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.3 дахь хэсгийн “Бараа материалын бүртгэл” хэсэгт “Галт зэвсэг, сум зэрэг байгууллагын онцлогтой тусгай зориулалтын материал”-ын зарцуулалт, бүртгэл тайлагналд хэрхэн хяналт тавих, анхан шатны маягтыг бүрдүүлэх талаар хавсралт оруулж баталгаажуулан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, */Говьсүмбэр/* Аргачилсан зөвлөмж өгч, бусад нэгжүүдэд хэрэгжилтийг хангуулах; */СААА/*

5.3 Цагдаагийн нэгж, байгууллагуудад нийтлэг байдлаар жил дараалан илэрч байгаа цалингийн бичилтийн зөрчлийн асуудлыг нэг ойлголттой болгон, тодорхойлж, үндэслэлтэй ажлын чиглэл хүргүүлэх үүднээс Сангийн яамны Нягтлан бодох, бүртгэлийн бодлогын газраас чиглэл авах нь зүйтэй. */СААА, Ховд, Бусад нэгжүүд/*

5.4 Удирдлага, нягтлан бодогч нарын бүртгэлээр тавих хяналт

хангалтгүй, төсвийн сахилга бат сул байгаас өмнөх онд илэрч байсан зөрчил дахин давтагдан илэрсэн байгаад анхаарч, тодорхой арга хэмжээ авах; */Налайх/*

5.5 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, зарлагыг эдийн засгийн ангиллын дагуу бүртгэж байх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллах; */Хэнтий аймаг дахь цагдаагийн газар/*

5.6 Албан шаардлагыг хэрэгжүүлэх ёстой хугацаандаа хэрэгжүүлээгүй байх тул гүйцэтгэлийг хангаж ажиллах; */Дорноговь/*

5.7 Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянах, тухайн хөрөнгийн нөхцөл байдал, чанар, цаашид ашиглах шалтгааныг тодорхой өгүүлсэн мэдэгдлийг байгууллагын даргад гарган өгч, холбогдох эрх бүхий байгууллагад саналаа хүргүүлж, шийдвэр гаргуулах ажлыг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангах; */Дорнод/*

5.8 Өмнөговь аймгийн Өмчийн газарт 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 39/1820 дугаар албан тоотоор хөрөнгийн шийдвэр гаргуулахаар хандсан хүсэлтийнхээ хэрэгжилтийг нэн даруй хангуулах.

5.9 Жил бүр хөрөнгийг чанар байдлаар ангилан, тооллогыг чанартай хийж, тооллогын комисс хөрөнгийн ашиглалтад үнэлгээ өгч, байгууллагын удирдлагад танилцуулан актлах ба ашиглах хөрөнгүүдийг тодорхойлж, шийдвэр гарган ажиллаагүйгээс зөрчил гарсан байх тул зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар санаачлагатай ажил зохион байгуулах. */Өмнөговь/*

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас дипломат байгууллага, улсын онц чухал объектыг хамгаалах үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Цагдаагийн ерөнхий газрын НХЖХОНАБХА-ны Эргүүл хамгаалалтын газрын Дипломат байгууллага, банк хамгаалах хэлтэс, Дотоодын цэргийн штабын 05, 805 дугаар анги

Аудитын объект: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас дипломат байгууллага, улсын онц чухал объектыг хамгаалах үйл ажиллагаа

Аудитын төрөл, код: Үйл ажиллагааны аудит, ЦЕГ-ХШҮДАХ/ҮА-2018/03

Аудитын хугацаа: 2018.10.09- 2018.11.16

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Д.Батсайхан

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх

1. ТАНИЛЦУУЛГА

Нэгдсэн үндэстний байгууллагаас 1961 онд баталсан Дипломат харилцааны тухай Венийн конвенц, Цагдаагийн албаны тухай хуулийн 12, Дотоодын цэргийн тухай хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага нь дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал объектыг хамгаалах үүргийг гүйцэтгэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 281 дүгээр тогтоолоор “Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад авах улсын онц чухал объектын жагсаалт”-ыг баталсан. Аудитын нөөц, хамрах хүрээг харгалзан уг жагсаалтад орсон дараах объектыг хамгаалах үйл ажиллагаанд аудит хийлээ. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагын төсөвт хамгаалалтад байх объект:

- Гадаадын дипломат төлөөлөгчийн газар /БНТУ, Франц, ОХУ, БНАСАУ, ХБНГУ, БНХАУ, БНЭУ, АНУ, Англи, Лаос, Вьетнам, Чех, Япон, Куба, Солонгос, Эмират, Кувейт, Казакстан зэрэг 18 орны дипломат төлөөлөгчийн газрын 21 пост/
- НҮБ-ын суурин төлөөлөгчийн газар /1 пост/

- Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв /1 пост/
- Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын төв болон үйлчилгээний байрууд, иргэний цахим үнэмлэхийн үйлдвэр /4 пост/

2. Цагдаагийн байгууллагын гэрээт хамгаалалтад байх объект:

- Монголбанкны төв байр, орон нутаг дахь хэлтэс, салбарын байр /8 пост/

3. Дотоодын цэргийн төсөвт хамгаалалтад байх объект:

- Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн төв байр, радио, телевизийн эфирийн студи /6 пост/
- “Изотоп” төв /1 пост/
- Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж /Усан сан, өргөх станцийн-20, хүний худгийн-22, бүсийн эргүүлийн-5, нийт 47 пост/
- “Дулааны III цахилгаан станц”, “Дулааны IV цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компаниуд /23 пост/
- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн төв лаборатори /1 пост/
- Халдварт өвчин судлалын үндэсний төвийн лаборатори /1 пост/
- Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори /2 пост/
- Зоонозын өвчин судлалын үндэсний төв /2 пост/
- “Биокомбинат” төрийн өмчит үйлдвэрийн газар /5 пост/
- Стандарт, хэмжил зүйн газрын төв байр болон Үнэт металлын сорьцын хяналтын газрын байр /4 пост/

Дээрх объектуудын хамгаалалтын үйл ажиллагааг Цагдаагийн албаны тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, Дотоодын цэргийн алба, ажиллагааны дүрэм, Объектын харуулын заавар, Хамгаалуулагч байгууллагатай байгуулсан Хамгаалалтын гэрээ болон бусад эрх зүйн акт, баримт бичгийн хүрээнд явуулж байна.

Дипломат байгууллагын хамгаалалтын цэгт ажиллах орчныг сайжруулах зорилгоор цэг бүрт агаар чийгжүүлэгч, цэвэр ус буцалгагч байршуулж, халаалтыг зохих байдлаар шийдсэн, харуулын цэгт ажиллаж буй алба хаагчдын сонор сэрэмж, албаны бэлэн байдал, хамгаалалтын үйл ажиллагаанд хэлтэс, тасгийн дарга, хяналт шалгалтын офицерын зүгээс тавих хяналт шалгалтыг хэвшүүлсэн нь сайшаалтай байна.

Түүнчлэн Дотоодын цэргийн анги, салбар нь хамгаалуулагч байгууллагатай хамгаалалтын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр ойр хамтран ажиллаж, харуулын цэгийн тохижилт, шалган нэвтрүүлэх тоног төхөөрөмж, телекамерын хяналтын систем болон бусад шаардлагатай

асуудлыг шийдвэрлүүлж, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа нь аудитын явцад ажиглагдлаа.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2018 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.5-д заасны дагуу цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас дипломат байгууллага, улсын онц чухал объектыг хамгаалах үйл ажиллагаанд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, аудитын объектыг боловсронгуй болгох, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, эрсдэлийг бууруулах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хүргүүлж, үр дүнг тооцох нь дотоод аудитын зорилго юм.

2.2 Аудитын цар хүрээ

Аудитад Цагдаагийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 12.1.5 дахь хэсэг, Дотоодын цэргийн тухай хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал объектыг хамгаалах цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын үйл ажиллагааг хамрууллаа.

Ачаа тээшийг тээврийн замд түр хугацаагаар хамгаалах, шүүхийн байрыг хамгаалах болон аудитад хамрагдсан нэгжийн бусад үйл ажиллагааг аудитын объектод хамруулаагүй болно.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ аудит хийгдэх үйл ажиллагааг хэрэгжүүлж буй НХЖХОНАБХА-ны Эргүүл хамгаалалтын газрын Дипломат байгууллага, банк хамгаалах хэлтэс, Дотоодын цэргийн штабын Хамгаалалтын хэлтэс, мөн штабын 05, 805 дугаар ангийн удирдлага, алба хаагчидтай уулзалт ярилцлага зохион байгуулж, аудитад шаардлагатай мэдээлэл, баримт материалыг цуглуулсан.

Мөн Улаанбаатар хотод байршиж буй дипломат төлөөлөгчийн нийт 19 байгууллагын 22 харуулын цэг, ус хангамжийн эх үүсвэр, дулааны цахилгаан станц, Монгол банк, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн байр болон улсын онц чухал объектод хамаарах бусад, нийт 14 байгууллагын 40 гаруй харуулын цэгт биечлэн ажиллаж, хамгаалалтын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл /Хавсралт 1/-ийг тооцож үнэлсэн.

Аудитын явцад цугларсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан тайлангийн төслийг бичиж, НХЖХОНАБХА-ны Эргүүл хамгаалалтын газар, Дотоодын цэргийн штабт тус тус хүргүүлэн “Удирдлагын тайлбар”-ыг авч энэхүү тайланд тусгасан.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Дипломат байгууллага, банк хамгаалах хэлтэс нь батлагдсан 166 орон тоотойгоос харуулын цэгт үүрэг гүйцэтгэх 139 алба хаагч байна. Үүнээс орон тоо дутуу, ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй болон бусад хүндэтгэх шалтгаантай алба хаагчдыг хасч, жилийн ихэнх хугацаанд 100 гаран алба хаагч байнгын бэлэн байдалд байж, 3 ээлжээр харуулын үүрэг гүйцэтгэж байна. Алба хаагчид 3 ээлжээр 24/48 цагаар үүрэг гүйцэтгэх үед Хөдөлмөрийн хуульд заасан хэмжээнээс сард дунджаар 80 цаг илүү ажиллаж, нэгдсэн, хэсэгчилсэн болон бусад арга хэмжээний үеэр эргүүл, хамгаалалтад татагдан оролцсоноор илүү цагийн хэмжээ бүр нэмэгдэж байна. Энэ нь алба хаагчдын ажлын сэтгэл ханамжийг бууруулж, шилжилт хөдөлгөөний гол шалтгаан болж, улмаар харуул, хамгаалалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

3.2 Аудитын явцад Улаанбаатар хотод байршиж буй дипломат төлөөлөгчийн нийт 19 байгууллагын 22 харуулын цэг, ус хангамжийн эх үүсвэр, дулааны цахилгаан станц, Монгол банк, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн байр болон улсын онц чухал объектод хамаарах бусад, нийт 14 байгууллагын 40 гаруй харуулын цэгт биечлэн ажиллаж, хамгаалалтын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдлийг тооцож үнэлсэн. Эдгээр объект, харуулын цэгийн дийлэнхид хамгаалалтын үйл ажиллагаанд тулгамдсан ноцтой эрсдэлгүй боловч зарим цэгийн шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа, телекамерын хяналтын систем, тусгай хэрэгсэл, ажлын орчинтой холбоотой эрсдэл байна. Тухайлбал;

1. БНХАУ-ын ЭСЯ-ны харуулын 1 дүгээр цэгт виз олголтын ачаалалтай холбогдуулан хэв журмын нөхцөл хүндэрч болзошгүй байдлаас шалтгаалан 1-2 хяналтын камер шаардлагатай.

2. БНХАУ-ын ЭСЯ-ны харуулын 2 дугаар цэг, түүний ойр орчимд ариун цэврийн өрөөгүй, гэрэлтүүлэг муу, орчны онцлогоос шалтгаалан 2-4 ширхэг хяналтын камер суурилуулах шаардлагатай.

3. БНЭУ-ын ЭСЯ-ны харуулын цэгт ажиллаж буй алба хаагч нь тус яамруу иргэдийг шууд нэвтрүүлэх эрх мэдэлтэй ч нэвтрэх эрхтэй холбоотой мэдээлэл, иргэдийг шалган нэвтрүүлэхэд шаардлагатай тусгай хэрэгсэл хангалтгүй байгаа нь хамгаалалт сулрах, болзошгүй нөхцөлд цагдаагийн байгууллага, алба хаагч буруутах эрсдэлтэй байна.

4. Вьетнам Улсын ЭСЯ-ны харуулын цэгийн орчимд шөнийн цагаар хөдөлгөөн ихтэй, алба хаагч иргэдийг бүртгэж нэвтрүүлдэг гэх боловч, энэ нь жигд бус хэрэгждэг, иргэдийг шалган нэвтрүүлэхэд шаардлагатай тусгай хэрэгсэл хангалтгүй байна.

5. Япон Улсын ЭСЯ-ны харуулын цэг, түүний ойр орчимд ариун цэврийн өрөөгүй байгаа нь хамгаалалтын үйл ажиллагаанд эрсдэл учруулахаар байна.

3.3 Засгийн газрын 2017 оны 281 дүгээр тогтоолоор батлагдсан жагсаалтын дагуу Монгол банкны төв байр, орон нутаг дахь салбар, хэлтсийн байрыг цагдаагийн байгууллага гэрээний дагуу хамгаалж байна. Монгол банкны төв байрны хамгаалалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа ч тус банкнаас орон нутагруу зузаатгал хийхээр явах үеийн хамгаалалтад ажиллах тусгай орон тоо байхгүйгээс ээлжээс буусан харуулын цагдаа нарын хүчээр уг ажлыг хэрэгжүүлж байна. Мөн Банк хамгаалах гэрээт тасагт 2017, 2018 онуудад 26 алба хаагч шинээр томилогдсон нь тус тасагт шилжилт, хөдөлгөөн их, алба хаагчид тогтворгүй байгааг илтгэж байна.

3.4 Засгийн газрын 2017 оны 281 дүгээр тогтоолоор батлагдсан жагсаалтын дагуу Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын төв болон үйлчилгээний байрууд нь цагдаагийн байгууллагын төсөвт хамгаалалтад байна. Аудитын явцад эдгээр объектуудад очиж ажиллахад үйлчлүүлэгч иргэдийн хөдөлгөөн ихтэй, цагдаагийн алба хаагчид улсын онц чухал объектыг хамгаалж байна гэхээс илүүтэй төрийн аль нэг үйлчилгээний байгууллагын угтах үйлчилгээ, үүдний жижүүрийн үүргийг гүйцэтгэж байгаа мэт байдалтай байв.

3.5 Дотоодын цэргийн 805 дугаар ангийн хамгаалж буй Улаанбаатар хотын цэвэр усны Төвийн эх үүсвэр, усан сан, гүний худгуудад 2012 онд ЦЕГ-ын 200 сая гаруй төгрөгийн хөрөнгө оруулалтаар 66 хяналтын камер суурилуулж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн ч гүйцэтгэгч компанитай байгуулсан гэрээний хугацаа /3 жил/ дуусгавар болсноос хойш тэдгээрийн үйл ажиллагаа доголдож, одоо 2 ширхэг камер л ажиллаж байна. Дээрх телекамерын хяналтын системд 2018 онд МШУТ-өөс үзлэг шалгалт хийж, 10 сая төгрөгийн зардлыг шийдвэрлэж, тоног, төхөөрөмжийг засварлаж, сольсноор хэвийн үйл ажиллагааг хангах боломжтой гэж дүгнэжээ.

4. ДҮГНЭЛТ

Дотоодын цэргийн тухай хуулийг 2017 оны 09 дүгээр сарын 01-нээс мөрдөж эхэлснээс хойш болон дипломат байгууллага, банк хамгаалах цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд сүүлийн 3 жилийн хугацаанд хөндлөнгийн, удирдах дээд байгууллагын зүгээс хяналт шалгалт хийгдээгүй, хамгаалуулж буй объект, харуулын цэг бүрт аудитын баг биечлэн очиж, нөхцөл байдалтай танилцан дотоод аудитыг хэрэгжүүлсэн нь энэхүү аудитын ач холбогдлыг илтгэнэ.

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас дипломат байгууллага, улсын онц чухал объектыг хамгаалах үйл ажиллагааг “Хангалттай”, уг үйл ажиллагаанд тулгамдсан ноцтой эрсдэлгүй байна гэж дүгнэлээ. Дотоодын цэргийн 05, 805 дугаар ангиуд, Эргүүл хамгаалалтын газрын

Дипломат байгууллага, банк хамгаалах хэлтсээс харуул, хамгаалалтын үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлж, анги, салбар, хэлтэс, тасаг, харуулын дарга, эргүүл, хяналт шалгалтын офицерын хяналтаар дамжуулан эрсдэлийг хянаж байна.

Гэвч зарим объектын шалган нэвтрүүлэх ажиллагаа, телекамерын хяналт, техник хэрэгсэл, постын нөхцөл байдалд эрсдэл байна. Тухайлбал, БНХАУ-ын ЭСЯ-ны харуулын 1, 2 дугаар цэгт хяналтын камер, 2 дугаар цэг, Японы ЭСЯ-ны харуулын цэгт ариун цэврийн өрөөг шийдвэрлэх, БНЭУ, Вьетнамын ЭСЯ-ны харуулын цэгт цагдаагийн алба хаагч иргэдийг тус яамруу шууд нэвтрүүлэх эрх хэмжээтэй ч шалган нэвтрүүлэхэд шаардлагатай наад захын мэдээлэл, камерын хяналт, техник хэрэгсэлгүй байгаагаас үүсч болзошгүй эрсдэлийг арилгах нь зүйтэй.

Цагдаагийн байгууллагаас харуулын цэгт ажиллах алба хаагчдыг 4 ээлжтэй, 8/16 цагаар үүрэг гүйцэтгэхээр тооцож, бүтэц, орон тоог баталдаг ч бодит байдал дээр орон тоо дутуу, ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй болон бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас цөөнгүй алба хаагчид албан үүргээ гүйцэтгэдэггүй. Улмаар бэлэн байгаа алба хаагчдын тоо буурснаас алба хаагчид жилийн 2/3-т нь 3 ээлж, 24/48 цагаар харуулын үүрэг гүйцэтгэж, зарим тохиолдолд эргүүл, хамгаалалтад нэмэгдлээр татагдан ажиллаж байгаа нь ажлын ачааллыг нэмэгдүүлж, алба хаагчдын сэтгэл ханамж, эрүүл мэнд, хамгаалалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Цаашид харуулын ажлын байрны орон тоог тулгаж батлах нь хүндэтгэн үзэх шалтгаанаар бүрэн бүрэлдэхүүнээр ажиллах бололцоогүй үед тухайн нэгж, хамгаалалтын үйл ажиллагаа доголдох, хамгаалалтад эрсдэл учрахаар байх тул хүний нөөцийн бодлого, төлөвлөлтөд анхаарч үзэхийг аудитын багаас онцолж байна.

Хэдийгээр Засгийн газрын 2017 оны 281 дүгээр тогтоолын дагуу Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын төв байр, үйлчилгээний байрууд нь цагдаагийн байгууллагын төсөвт хамгаалалтад байгаа ч бодит байдал дээр цагдаагийн алба хаагч нь ямар нэг албан газрын үүдний жижүүр, угтах үйлчилгээний ажилтан шиг үүрэг гүйцэтгэж байна. Иймд дээрх объектыг зайлшгүй Цагдаагийн байгууллагын хамгаалалтад байлгах хэрэгцээ, шаардлагыг нягтлан судалж, хамгаалалтыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллага, Дотоодын цэрэг, эсхүл энгийн байгууллагад шилжүүлэх асуудлыг судалж, саналаа гарган шийдвэрлүүлэх шаардлагатай. Ингэснээр цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах орон тоог /20 гаруй/ нэмэгдүүлэх бололцоотой байна.

Дотоодын цэргийн 805 дугаар ангийн хамгаалж буй Улаанбаатар хотын цэвэр усны Төвийн эх үүсвэр, усан сан, гүний худгуудад 2012 онд ЦЕГ-ын 200 сая гаруй төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 66 хяналтын камер суурилуулж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн ч гүйцэтгэгч компанитай байгуулсан гэрээний хугацаа /3 жил/ дуусгавар болсноос хойш

тэдгээрийн үйл ажиллагаа доголдож, одоо 2 ширхэг камер л ажиллаж байна. Дээрх телекамерын хяналтын системд 2018 онд МШУТ-өөс үзлэг шалгалт хийж, 10 сая төгрөгийн зардлыг шийдвэрлэж, тоног, төхөөрөмжийг засварлаж, сольсноор хэвийн үйл ажиллагааг хангах боломжтой гэж дүгнэжээ. Бага бус хөрөнгө зарцуулж хэрэгжүүлсэн, хамгаалалтын үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой дээрх телекамерын хяналтын системийг засварлахад шаардлагатай зардлыг шийдвэрлэх нь зүйтэй.

5. ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, аудитын үр дүнд суурилж, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас дипломат байгууллага, улсын онц чухал объектыг хамгаалах үйл ажиллагааг боловсронгуй болгох, эрсдэлийг бууруулах чиглэлээр дараах зөвлөмжийг холбогдох нэгжид хүргүүлэх саналтай байна. Үүнд:

Хүний нөөцийн хэлтэст:

1. Ижил ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолт бүхий хэд хэдэн орон тоотой цагдаагийн байгууллага, нэгжид алба хаагч хүндэтгэн үзэх шалтгаан /орон тоо дутуу, ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй г.м/-ы улмаас албан үүргээ гүйцэтгэхгүй болсон нөхцөлд түүний ажил, үүргийг бусад алба хаагчдад хуваарилан гүйцэтгүүлэх боломжтой юм.

Харин 24 цагаар тасралтгүй үүрэг гүйцэтгэх харуул, жижүүрийн ажлын байранд дутуу орон тоо гарах нь ээлжийн тоог бууруулж, алба хаагчдын ажлын цагийн ачааллыг эрс нэмэгдүүлэх, улмаар тэдний сэтгэл ханамж, эрүүл мэнд, хамгаалуулж буй объектын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Аудитын явцад цуглуулсан мэдээллээс үзвэл объектын харуулд ажиллах алба хаагчдын байнгын бэлэн орон тоо нь батлагдсан орон тооны 75 орчим хувьд хэлбэлзэж, жилийн 2/3-оос багагүй хугацаанд 3 ээлж, 24/48 цагаар үүрэг гүйцэтгэж байна.

Иймд Дотоодын цэргийн штаб, Эргүүл хамгаалалтын газар болон харуул, жижүүрийн чиг үүрэг гүйцэтгэдэг бусад нэгж, ажлын байр /албан тушаал/-ны сул орон тооны нөхөн хангалтыг шуурхай зохион байгуулах, боломжтой нөхцөлд орон тоог 4 ээлжинд тулгах бус илүү гарган батлах хүний нөөцийн бодлого баримтлах.

Санхүү, аж ахуйн албанд:

1. Аудитын явцад илэрсэн улсын онц чухал объектын хамгаалалтад учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, ажлын орчин нөхцлийг сайжруулах, техник хэрэгслээр хангах зорилгоор дараах ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг үе шаттай шийдвэрлэх. Үүнд:

- БНХАУ, Япон Улсын ЭСЯ-ны харуулын цэг /2 пост/-ийг дотроо ариун цэврийн өрөөтэй постоор шинэчлэх
- БНХАУ-ын ЭСЯ-ны 1, 2 дугаар цэг, Вьетнам Улсын ЭСЯ-ны харуулын цэгт телекамерын хяналтын систем суурилуулах
- БНЭУ, Вьетнам болон бусад шаардлагатай объектуудын харуулын цэгийг метал илрүүлэгч багаж, үнэмлэхний скайнераар хангах
- Улаанбаатар хотын цэвэр усны Төвийн эх үүсвэр, усан сан, гүний худгуудад суурилуулсан телекамерын хяналтын системийн хэвийн ажиллагааг хангахад шаардлагатай зардлыг шийдвэрлэх.

Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанд:

1. Энэхүү тайланд тусгагдсан дипломат байгууллагын хамгаалалтын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг бууруулахад нэн шаардлагатай харуулын цэгийг шинэчлэх, техник хэрэгслээр хангахтай холбоотой асуудлыг Санхүү, аж ахуйн алба, Мэдээллийн технологи, холбооны төвтэй хамтран шийдвэрлэх

2. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын төв, үйлчилгээний байруудыг зайлшгүй Цагдаагийн байгууллагын хамгаалалтад байлгах хэрэгцээ, шаардлагыг нягтлан судалж, хамгаалалтыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллага, Дотоодын цэрэг, эсхүл энгийн байгууллагад шилжүүлэх талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх

3. Энэтхэг, Вьетнам Улсын Элчин сайдын яамдад иргэдийг нэвтрүүлж буй цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, бүртгэл, хяналтын механизмыг сайжруулах арга хэмжээ авах

Дотоодын цэргийн штабт:

1. Улаанбаатар хотын цэвэр усны Төвийн эх үүсвэр, усан сан, гүний худгуудад суурилуулсан телекамерын хяналтын системийг засварлаж, хэвийн ажиллагаанд оруулах асуудлыг холбогдох нэгжүүдтэй хамтран зохион байгуулах.

Зөвлөмж хүлээн авсан байгууллага, нэгжүүд түүний хэрэгжилтийн талаарх танилцуулгыг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст ирүүлнэ.

6. УДИРДЛАГЫН ТАЙЛБАР

Аудитын урьдчилсан тайлантай холбогдуулан Дотоодын цэргийн штаб, Эргүүл хамгаалалтын газраас ирүүлсэн “Удирдлагын тайлбар”-ыг энэхүү тайланд хавсаргав.

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Мэдээлэл нэгтгэн боловсруулах газар, Мэдээллийн технологи, холбооны төв болон хязгаарлагдмал хүрээнд зарим алба, нэгж, төв

Аудитын объект: Дээр дурдсан нэгжүүдийн мэдээллийн сангийн удирдлага, зохион байгуулалт, хяналт, баяжилт, ашиглалтад хамаарах үйл ажиллагаа

Аудитын төрөл: Үйл ажиллагааны аудит

Аудитын хугацаа: 2018.03.12- 2018.04.09

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх, М.Азжаргал

1. ТАНИЛЦУУЛГА

Цагдаагийн байгууллага нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд, өөрийн дотоод хэрэгцээнд ашиглах зорилгоор мэдээллийн санд холбогдох техникийн болон програм хангамжийн орчныг бүрдүүлж, өгөгдлийн сан үүсгэн ашигладаг.

Дээрх зорилгоор Мэдээллийн технологи, холбооны төвөөс цагдаагийн байгууллага, нэгжүүдээс ирүүлсэн хүсэлт /захиалга/-ийн дагуу 2010, 2014-2017 онуудад 24 төрлийн мэдээллийн сан, цахим хуудсанд хамаарах 46 програм хангамж /Хавсралт 1/-ийг боловсруулан нэвтрүүлсэн байна.

Програм хангамжууд нь мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээ, мэдээлэлтэй танилцах, хайлт лавлагаа хийх /22 веб/ болон тайлан, судалгаа боловсруулах, хяналт тавих /24 аппликейшн/ гэсэн үндсэн 2 зориулалттай.

Дээрх програм хангамжийн ашиглалтыг Эрүүгийн цагдаагийн алба, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Мэдээлэл нэгтгэн боловсруулах газар, Мэдээллийн технологи, холбооны төв, Бүртгэл хяналтын төв зэрэг 11 нэгж хариуцаж, нийт цагдаагийн байгууллагын хэмжээнд ашиглаж байна.

Мэдээллийн технологи, холбооны төв нь цагдаагийн байгууллагын хэмжээнд мэдээллийн систем, өгөгдлийн сан, програм хангамжийн хөгжүүлэлт /бүтээх/, өргөтгөл /засвар, өөрчлөлт оруулах/, бэлэн байдлыг харууцаж, програмд нэвтрэх хэрэглэгчийн эрхийн удирдлага болон бусад чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Мэдээлэл нэгтгэн боловсруулах газар нь цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд хяналт тавих, гарсан алдаа, зөрчлийг засуулах, сангийн мэдээлэлд дүн шинжилгээ, судалгаа хийх, сангийн мэдээлэл /статистик/-ийг удирдлагад танилцуулах, эрх бүхий албан тушаалтан ашиглах бололцоогоор хангах, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, захиргааны зөрчлийн тоо бүртгэгч нарыг мэргэжлийн удирдлагаар хангах болон бусад чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Цагдаагийн байгууллагын “Мэдээллийн технологи, харилцаа холбооны бодлогын зөвлөл”-ийн 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хуралдаанаас цагдаагийн байгууллагын мэдээллийн системийн шинэчлэлийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсний дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/216 дугаар тушаалаар цагдаагийн байгууллагад ашиглагдаж буй програм хангамж, мэдээллийн сангийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, төрийн байгууллагын мэдээллийн санг холбож ашиглах талаар судалгаа хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан.

Ажлын хэсгээс “Өргөдөл, гомдол”, “Гэмт хэрэг”, “Захиргааны тоо бүртгэл”-ийн мэдээллийн сангаас бусад мэдээллийн сангуудын баяжилт, хөдөлгөөн, түүнд тавих шат шатны дарга нарын хяналт хангалтгүй, алба хаагчид шаардлагатай мэдээллийг 43 програм руу тус тусад нь нэвтрэн цуглуулж буй одоогийн техникийн боломж нь цаг хугацаа шаардсан, хүндрэлтэй байдаг гэж дүгнээд цагдаагийн байгууллагад ашиглагдаж буй мэдээллийн сангуудыг ашиглах журам, бүртгэх маягтуудыг өөрчлөх, зарим мэдээллийн санг нэгтгэх, шинэчлэх, төрийн зарим байгууллагын мэдээллийн санг цагдаагийн байгууллагын нэгдсэн сантай холбож ашиглах ажлуудыг судалж, шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсгийг нэн яаралтай байгуулах санал гаргаж, Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд даргад 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдөр танилцуулжээ.

Улмаар Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 03 дугаар тушаалаар цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн шалгах процессын мэдээллийн нэгдсэн сан, тайлан мэдээний програм хангамжид шинэчлэл хийх, Монгол Улсад ашиглагдаж буй мэдээллийн сангийн лавлах гаргах, иргэний мэдээллийг нэгдсэн стандартад оруулж, бүртгэлжүүлэн сан үүсгэх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж, дүнг танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн Мэдээллийн технологи, холбооны төвийн дарга, цагдаагийн хурандаа [REDACTED] ахлуулан байгуулж, ажлын хэсгийн ажил үргэлжилж байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2018 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.3-т заасны дагуу цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон бусад үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдээллийн сангийн удирдлага, зохион байгуулалт, хяналт, ашиглалтын байдалд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, аудитын объектыг боловсронгуй болгох, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хүргүүлж, үр дүнг тооцох нь дотоод аудитын зорилго юм.

2.2 Аудитын цар хүрээ

Аудитад Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт заасан болон цагдаагийн байгууллагын дотоод хэрэгцээнд ашиглах зорилгоор бүрдүүлсэн тоо бүртгэл, мэдээллийн сан, түүнд холбогдох програм хангамжийг хамруулсан.

Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.19-т заасан буюу цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажлын тоо бүртгэл нь аудитын объектод хамаарахгүй.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ аудитын удирдамж, төлөвлөгөө, асуудлын шинжилгээний хүснэгт, ярилцлагын удирдамж, түүврийн сорил, илэрсэн асуудлын бүртгэл зэрэг нийт 12 төрлийн ажлын баримтыг батлагдсан загварын дагуу боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дэд дарга болон хэлтсийн даргаар батлуулж ашигласан.

Аудитын хүрээнд цагдаагийн байгууллагын мэдээллийн сан, холбогдох програм хангамжийн удирдлага, зохион байгуулалт, хяналт, баяжилт, ашиглалтын талаарх мэдээллийг Мэдээллийн технологи, холбооны төв, Мэдээлэл нэгтгэн боловсруулах газраас тус тус гаргуулан авч судалсан.

Түүнчлэн аудитын нотлох баримт цуглуулах зорилгоор дээрх нэгжүүдийн удирдлага, алба хаагчидтай уулзалт ярилцлага зохион байгуулж, аудитын объектын талаар албад, аймаг, нийслэл, дүүргийн цагдаагийн газар, хэлтсээс 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн За/2053 дугаарын албан бичгээр санал авч нэгтгэн дүгнэлээ.

Мөн аудитаар илэрсэн асуудлыг нотлох, тулган баталгаажуулалт хийх зорилгоор 2 төрлийн түүврийн судалгааг хийж ашигласан.

Аудитын явцад цугласан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан “Урьдчилсан тайлан”-г бичиж, Мэдээлэл нэгтгэн боловсруулах газар, Мэдээллийн технологи, холбооны төвд хүргүүлэн “Удирдлагын тайлбар”-ыг авч тайланд тусгасан.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

Аудитын хүрээнд цугларсан баримт материал, цагдаагийн байгууллага, нэгжүүдээс мэдээлэлд үндэслэн энэхүү тайланд тусгаж удирдлагад танилцуулан, шийдвэрлэвэл зохих дараах асуудлууд байна. Үүнд:

3.1 Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрын Статистикийн хэлтэс, төв, орон нутгийн цагдаагийн байгууллагад мэдээлэл судалгаа, захиргааны зөрчлийн тоо бүртгэл хариуцсан алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтод мэргэжлийн шаардлагыг эрх зүйч /Чухал шаардлагатай/, статистикч /шаардлагатай/ байхаар тусгасан. Цагдаагийн байгууллагын хэмжээнд дээрх ажлын байранд ажиллаж буй нийт 94 алба хаагчийн судалгааг авч нэгтгэхэд ердөө 2 алба хаагч статистикч мэргэжилтэй, бусад нь эрх зүйч болон бусад мэргэжилтэй байна.

Статистик мэдээллийг нэгтгэн боловсруулах, түүнд дүн шинжилгээ хийхэд статистик, математикийн шинжлэх ухааны мэдлэгтэй, судалгаа, дүн шинжилгээний арга барилыг сайтар эзэмшсэн, туршлагатай алба хаагч хэрэгцээтэй ч зарим тохиолдолд хангалттай мэдлэг, ур чадваргүй алба хаагчдыг тохиолдлын байдлаар томилох, хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн их байдаг зэрэг нь мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээний ажлын чанарт сөргөөр нөлөөлж байгааг аудитад оролцогчид илэрхийлж байлаа.

3.2 Цагдаагийн алба хаагчдын дунд цагдаагийн байгууллагын мэдээллийн санд цугларсан мэдээллийг үйл ажиллагаандаа үр дүнтэй ашиглах мэдлэг, ур чадвар харилцан адилгүй, мэдээллийн санг ашиглах, судалгаа, дүн шинжилгээ хийх нь гагцхүү мэдээлэл судалгаа хариуцсан алба хаагчийн хийх ёстой ажил мэтээр ойлгох хандлага түгээмэл байна. Энэ нь мэдээллийн сангийн ашиглалтыг бууруулах, нэгэнт бий болсон сангийн баяжилт, хөдөлгөөнийг аажмаар идэвхигүйжүүлэх эрсдэлтэй байна. Түүнчлэн цагдаагийн байгууллага, нэгж нь бие даан мэдээллийн сангаас гарган авч ашиглах боломжтой мэдээллийг заавал Статистикийн хэлтэст хандан цаасан суурьтай гаргуулсаар байгаа нь мэдээллийн сангийн үндсэн зориулалтад нийцээгүй, тус нэгжийн ачааллыг нэмэгдүүлсэн ажил болж байна.

3.3 Мэдээллийн сан, програм хангамж нь бүхэлдээ цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг хялбаршуулан дэмжих, албаны шуурхай, мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангах үндсэн зорилготой, статистик мэдээлэл нь цагдаагийн байгууллагаас гэмт

хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ нөөцийг оновчтой хуваарилан зарцуулахад баримтлах гол шалгуур байх учиртай. Нөгөө талаас аливаа мэдээллийн санг бүрдүүлж, ашиглах нь хэрэглэгчдэд хамгийн хялбар, энгийн байж, өгч буй ачаалал нь ач холбогдол, үр дүнтэй байх ёстой.

Мэдээлэл нэгтгэн боловсруулах газраас сар, улирал, хагас, бүтэн жилээр бэлтгэн гаргаж буй Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээлэл нь гэмт хэрэг, зөрчлийн өсөлт, бууралт, үйлдэгдсэн газар, цаг хугацаа, холбогдогчийн нас, хүйс, нийгмийн байдал, хохирол, захиргааны шийтгэлийн талаар маш дэлгэрэнгүй харьцуулсан мэдээлэл өгдгөөрөө чухал ач холбогдолтой. Гэвч гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг нарийвчлан тодорхойлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөхөд шууд авч ашиглах хангалттай мэдээлэл агуулахгүй байна.

3.4 Мэдээлэл нэгтгэн боловсруулах газраас статистик мэдээлэлд улирал, хагас, бүтэн жилээр дүн шинжилгээ хийж, төв, орон нутгийн цагдаагийн байгууллагад зөвлөмж хүргүүлж байгаа нь сайшаалтай ч тэдгээрийн хэрэгжилтийг тооцож, үнэлдэггүйгээс үр дүнг хэмжих боломжгүй байна. Мөн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүргүүлсэн зөвлөмж нь статистик мэдээллээс илүүтэй бусад эх сурвалжаас авсан мэдээлэлд үндэслэсэн, хэт ерөнхий, өргөн хүрээтэй байна гэж үзлээ.

3.5 Цагдаагийн байгууллагын зарим нэгжийн удирдлага, алба хаагчдын мэдээллийн сангийн баяжилт, ашиглалт, хяналт тавих асуудалд хариуцлагагүй, хэнэггүй ханддаг, холбогдох хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлдэггүй байдлаас шалтгаалан санд оруулбал зохих мэдээллийг оруулахгүй байх, хугацаа хоцроох, алдаатай буюу буруу мэдээлэл оруулах зөрчил тасрахгүй, статистик мэдээ бодитой бус гарах эрсдэлтэй байна. Уг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 2/98 дугаартай албан бичгээр алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад үүрэг хүргүүлжээ.

3.6 Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд цугларсан өгөгдөл, мэдээлэлд засвар, өөрчлөлт оруулах асуудлыг цагдаагийн байгууллага, нэгжээс ирүүлсэн албан бичгийг үндэслэн Мэдээллийн технологи, холбооны төв хариуцаж байна. Зарчмын хувьд мэдээллийн сан, түүнд холбогдох програм хангамжийг шинээр бүтээх, засвар, өөрчлөлт оруулах нь тус төвийн, харин нэгэнт цугларсан өгөгдөл, мэдээлэлд засвар, өөрчлөлт хийх нь тухайн мэдээллийн сангийн ашиглалтыг хариуцаж буй нэгжийн чиг үүрэг байх нь зохистой байна.

3.7 Цагдаагийн ерөнхий газрын 2014 оны 881 дүгээр тушаалаар “Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд нэвтрэх эрхийг тодорхойлсон жагсаалт”-ыг баталсан. Түүнээс хойш цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсон, зарим нэгж,

албан тушаалын нэршил өөрчлөгдсөн, шинээр бий болсон мэдээллийн сангуудад хандах эрхийг тодорхойлох шаардлага гарсан зэргээс шалтгаалан уг жагсаалтыг шинэчлэн батлах шаардлагатай байна.

4. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт материалд үндэслэн цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн удирдлага, хяналт, баяжилт, ашиглалтын үйл ажиллагааг “Хангалттай” гэж үнэлэв. Ингэхдээ цагдаагийн байгууллагаас өнгөрсөн хугацаанд албаны хэрэгцээнд зориулж мэдээллийн сан, програм хангамжуудыг шинээр бий болгон, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн, тэдгээртэй холбоотой дүрэм, журмыг баталж мөрдүүлсэн, мэдээллийн сангийн ашиглалттай холбоотой алба хаагчдыг тодорхой хүрээнд сурган дадлагажуулж, цугларсан өгөгдөл, мэдээллийг нэгтгэн боловсруулах, эргэлтэд оруулах ажил тогтмолжсон байдлыг харгалзсан болно.

Аудитын явцад илэрсэн асуудал нь Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын 2018 оны 03 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн үйл ажиллагаа, аудитын мөрөөр хүргэх зөвлөмжид тусгагдан шийдвэрлэгдэх боломжтой байна.

Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн үйл ажиллагааг эрх зүйн, техникийн, хүний нөөцийн гэсэн 3 орчинд авч үзлээ.

Мэдээллийн технологи, холбооны төвөөс “Цагдаагийн байгууллагын мэдээллийн технологи, харилцаа холбооны бодлого, үйл ажиллагааны журам”-ыг бүхэлд нь шинэчлэн боловсруулсан, батлуулахаар ажиллаж байна.

Мөн гэмт хэрэг, зөрчлийн санд холбогдох 43 маягтыг шинэчлэн боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын “Маягт, заавар батлуулах тухай” 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/68 тушаалаар батлуулан мөрдөж байна.

Цагдаагийн байгууллагын Мэдээллийн технологи, харилцаа холбооны бодлогын зөвлөлөөс цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, шинэчлэн зохион байгуулах цаашдын бодлого, чиглэлийг тодорхойлж, уг ажлыг хэрэгжүүлэх Ажлын хэсгийг байгуулсан нь цаг үеэ олсон ажил болжээ.

Уг ажлын хүрээнд мэдээллийн сангуудыг нэгтгэх, бусад төрийн байгууллагын мэдээллийн санг хамтран ашиглах, нэгдсэн хайлтын систем бий болгох ажил хийгдэхээр төлөвлөсөн байна.

Түүнчлэн 2018 онд “Бэлэн бус торгуулийн систем” худалдаж авах улсын төсвийн 5 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалтын хүрээнд цагдаагийн байгууллагад ашиглагдаж буй сервер, тоног төхөөрөмжийг шинэчлэхээр шийдвэрлэсэн нь сүлжээний хурд, серверийн багтаамж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чухал алхам болжээ.

Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн үйл ажиллагаатай холбоотой хамгийн эрсдэлтэй орчин нь хүний нөөцийн асуудал байна. Мэдээллийн технологийн хөгжлийн нөлөөгөөр цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологи цаашид улам гүнзгий нэвтэрч, алба хаагчдад тавигдах энэ талын мэдлэг, ур чадварын шаардлага өсөн нэмэгдэх төлөвтэй байна. Алба хаагчдын сургалт, хөгжлийн асуудлыг орхигдуулсан нөхцөлд мэдээллийн сантай холбоотой өндөр өртөг бүхий дэд бүтэц нь үр ашиггүй хөрөнгө оруулалт болж хувирах эрсдэлтэй.

Иймд мэдээлэл нэгтгэн боловсруулах, судалгаа, дүн шинжилгээний чиг үүрэгтэй ажлын байранд энэ талын мэдлэг, ур чадвар, дадлага туршлагатай алба хаагчдыг судлан томилох, цагдаагийн нийт алба хаагчдын компьютер, мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварын суурь түвшинг тогтоож, энэ чиглэлийн сургалт, хөгжлийн хэрэгцээг тодорхойлох, цагдаагийн албанд шинээр томилогдох хүмүүст компьютер, сүлжээний орчинд ажиллах мэдлэг, ур чадварыг чухал шалгуур болгон тавих нь зүйтэй байна.

5. ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, аудитын үр дүнд суурилан цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр аудитын багаас дараах зөвлөмжийг холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх саналтай. Үүнд:

Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын 2018 оны 03 дугаар тушаалаар байгуулагдсан цагдаагийн байгууллагын мэдээллийн санг шинэчлэх үүрэг бүхий Ажлын хэсэг /Мэдээллийн технологи, холбооны төвийн дарга, цагдаагийн хурандаа [REDACTED]-т:

1. Аудитын явцад цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн үйл ажиллагаатай холбогдуулан албад, нутаг дэвсгэр хариуцсан болон дүүргийн цагдаагийн газар, хэлтсээс ирүүлж нэгтгэсэн нийт 27 төрлийн мэдээллийн сан, програмд хамаарах хүндрэл бэрхшээл, санал /Хавсралт 1/-ыг Ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд судалж шийдвэрлэх

2. Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд цугларсан өгөгдөл, мэдээлэлд засвар, өөрчлөлт оруулах асуудлыг тухайн мэдээллийн сангийн ашиглалтыг хариуцаж буй нэгж гүйцэтгэж байх асуудлыг судалж, техникийн нөхцөл, эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж шийдвэрлэх

3. Холбогдох нэгжүүдтэй хамтран “Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд нэвтрэх эрхийг тодорхойлсон жагсаалт”-ыг одоогийн нөхцөл, шаардлагад нийцүүлэн шинэчлэн батлуулах ажлыг зохион байгуулах

Мэдээлэл нэгтгэн боловсруулах газарт:

1. Гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийж, төв, орон нутгийн цагдаагийн байгууллагад хүргүүлж буй зөвлөмжийн давтамжаас илүү чанарт анхаарч, биелэлт, үр дүнг бодитой тооцож ажиллах

2. Статистик мэдээний бүртгэлийн маягт, статистик мэдээнд суурилсан дүн шинжилгээг гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцлийг тодорхойлоход ач холбогдолтой байдлаар боловсруулан, гүйцэтгэхэд анхаарч ажиллах

Хүний нөөц, сургалтын хэлтэст:

1. Цагдаагийн байгууллагын мэдээлэл судалгаа, дүн шинжилгээ хариуцсан ажлын байрны томилгоонд тухайн цагдаагийн алба хаагч, иргэний мэдээлэл судалгаа, дүн шинжилгээний чиглэлээр мэргэшсэн байдлыг гол шалгуур болгож, тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого баримтлах

2. Цагдаагийн албанд анх томилогдох иргэний сонгон шалгаруулалтад компьютер, мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварын шалгуур, түвшин тогтоох шалгалтыг оруулах

Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд:

1. Цагдаагийн алба хаагчдын компьютер, мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварын суурь түвшинг тогтоож, энэ чиглэлийн албаны сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, үе шаттай сургалт зохион байгуулах

Албад, нутаг дэвсгэр хариуцсан болон дүүргийн цагдаагийн газар, хэлтэст:

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн сангийн ашиглалтыг нэмэгдүүлэх, энэ зорилгоор алба хаагчдын мэдлэг, ур чадвар, хандлагыг дээшлүүлэх шинэлэг ажил зохиох

2. Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн баяжилт, ашиглалт, хяналттай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 2/98 дугаартай албан бичгээр хүргүүлсэн үүргийг хэрэгжүүлж ажиллах

6. УДИРДЛАГЫН ТАЙЛБАР

Аудитын урьдчилсан тайланг холбогдох нэгжүүдэд хүргүүлсний дагуу ирүүлсэн “Удирдлагын тайлбар”-ыг энэхүү тайланд хавсаргав.

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

2018 оны 06 дугаар сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаагийн ерөнхий газрын Төв архивын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Цагдаагийн ерөнхий газрын Төв архив

Аудит хийгдсэн объект: Цагдаагийн ерөнхий газрын Төв архивын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэр шилжүүлэх үйл ажиллагаа

Аудитын төрөл: Үйл ажиллагааны аудит

Аудитын хугацаа: 2018.06.02- 2018.06.27

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Д.Батсайхан

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх

1. ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолоор “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталж, 3 үе шаттайгаар хэрэгжүүлсэн. Засгийн газрын 2017 оны 04 дүгээр тогтоолоор хөтөлбөрийн 4 дүгээр үе шатыг 2017-2020 онд хэрэгжүүлж, “Үндэсний төв архив, төрийн архивуудад хадгалагдаж байгаа цаасан суурьтай баримт, кино, гэрэл зураг, дуу авианы баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим архив үүсгэх ажлыг зохион байгуулах”-аар баталсан.

Дээрх ажлыг хэрэгжүүлэхээр 2012-2016 онуудад Архивын ерөнхий газраас 4 гэрээт архивчийн орон тоо, цалингийн асуудлыг шийдвэрлэж, Цагдаагийн ерөнхий газрын Төв архивт ажиллуулан, энэ хугацаанд ял шийтгэл, лавлагааны сан, хувийн хэргийн санг цахим хэлбэрт шилжүүлэхэд гол анхаарлаа хандуулан ажиллажээ.

Дээрх гэрээт архивчдыг ажиллуулах гэрээний хугацаа 2016 оны 12 дугаар сарын 31-нд дуусч, Архивын ерөнхий газарт дахин санал хүргүүлсний дагуу 2017 оны 02 дугаар сараас 2 гэрээт архивчтай гэрээ байгуулан ажиллуулж байна.

Цагдаагийн ерөнхий газрын Төв архивын хадгаламжийн санд 2018 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар хөмрөг үүсгэгч 64, бүтцийн өөрчлөлтөд орж татан буугдсан 17, нийт хөмрөг үүсгэгч 81 байгууллагын байнга хадгалах 13259, түр хадгалах 24738, 70 жил хадгалах 16446, нийт

54443 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна.

Захирамжлалын баримт бичиг буюу цагдаагийн төв байгууллага, нэгжийн даргын тушаал нь эрх зүйн үр дагавар үүсгэдэг, архив, лавлагааны зорилгоор хамгийн түгээмэл ашиглагддаг баримт бичиг тул тэдгээрийг нэн тэргүүнд цахим хэлбэрт шилжүүлэх бодлогыг Төв архиваас баримталж байна.

Гэрээт архивч нь цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх зорилгоор хадгаламжийн нэгжийг задлах, буцааж үдэх, баримт бичгийг скайнердах, скайнердсан баримтыг Photoshop програмд засварлах, баримтын онцлох мэдээллийг /хүн, газар, нэгжийн нэр г.м/ лавлагааны санд шивж цахим холболт хийх ажлуудыг шат дараалан гүйцэтгэдэг байна.

Байнга хадгалах баримтын 12.7 хувь буюу 1692 хадгаламжийн нэгж нь захирамжлалын баримт бичиг байх бөгөөд гэрээт архивч нар 2018 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар тэдгээрийн 71.6 хувь буюу 1212 хадгаламжийн нэгжийг цахим хэлбэрт оруулаад байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

Цагдаагийн ерөнхий газрын Төв архивын 2018 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 23/1016 дугаарын албан бичигт холбогдох удирдлагын шийдвэр, "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2018 оны дотоод аудитын төлөвлөгөө"-ний 2.13-т заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын Төв архивт хадгалагдаж буй цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаанд дотоод аудит хийж, түүнийг боловсронгуй болгох чиглэлээр санал, зөвлөмж боловсруулахад дотоод аудитын зорилго оршино.

2.2 Аудитын цар хүрээ

Аудитын зорилгыг хангах хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Төв архивт хадгалагдаж буй цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг гүйцэтгэж буй гэрээт архивчдын 2017-2018 оны үйл ажиллагаа, үр дүнг аудитад хамруулсан.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг Төв архивын удирдлага, алба хаагчидтай уулзалт ярилцлага зохион байгуулах, цаасан суурьтай баримтыг цахим хэлбэр шилжүүлэх үйл ажиллагаатай биечлэн танилцах, түүнд холбогдох тайлан, мэдээлэл, судалгааг гаргуулан авч дүн шинжилгээ хийх зэрэг аргуудыг ашиглан хийж гүйцэтгэлээ.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 5.4.11-т “Архивын баримт бичгийн 30 хувийг цахим хэлбэрт шилжүүлнэ” гэж заасан.

Нийт хөмрөг үүсгэгч 64 байгууллагын дийлэнх нь 2011-2013 он хүртэлх архивын баримтаа Төв архивт төвлөрүүлээд байгаа бөгөөд цаашид тус архивт шилжүүлбэл зохих их хэмжээний баримт тухайн байгууллагуудад түр хадгалагдаж байна.

Архивын ерөнхий газрын даргын 2013 онд баталсан “Архивын баримтыг тоон хэлбэрт шилжүүлэх норм”-оор ажлын 8 цагт гэрээт архивчийн хийж гүйцэтгэх ажлын хэмжээг тогтоосон.

Уг нормын дагуу Төв архивт бэлэн байгаа байнга хадгалах баримтын цахим хэлбэрт шилжээгүй үлдэгдэл 12047 хадгаламжийн нэгжийг цахим хэлбэрт шилжүүлэхэд 2 гэрээт архивч 3.9 жил зарцуулахаар байна.

Хэрэв Төв архивт хадгалагдаж байгаа нийт баримтын 30 хувь буюу 16332 хадгаламжийн нэгжийг цахим хэлбэрт шилжүүлэх, энэ хугацаанд хөмрөг үүсгэгч байгууллагуудаас нэмэгдэж ирэх архивын баримтыг тооцвол дээрх хугацаа илүү уртсах, улмаар архивын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, архивын үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх зорилтын хэрэгжилт удаашрах эрсдэлтэй байна.

3.2 Төв архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаанд ашиглагдаж буй 2 компьютер, 2 тог баригч нь техникийн шаардлага хангахгүй, гэрээт архивчдын өдөр тутмын үйл ажиллагаанд ашигладаг “CANON FORMULA DR 6050C” маркийн скайнер тодорхой бус шалтгааны улмаас ашиглах бололцоогүй болсноос архивын баримтыг цахим хэлбэрт оруулах үйл ажиллагаа доголдож байна.

Дээр дурдсан компьютер, тог баригч нь эдэлгээний шаардлага хангахгүй болсон тул Цагдаагийн ерөнхий газрын Мэдээллийн технологи, холбооны төвийн Техникийн комиссын 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 18-172, 18-173, 18-174, 18-175 дугаар дүгнэлтээр үндсэн хөрөнгөөс хасахаар шийдвэрлэсэн байна.

3.3 Гэрээт архивчдын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалт, хяналтаар бүрэн хангаагүйгээс архивын баримтыг цахим хэлбэрт оруулах зорилгоор хийгдэж буй баримтын мэдээллийг санд шивэх, скайнердах, скайнердсан баримтыг засварлах, цахим холболт хийх үйл ажиллагаа жигд явагдаагүй байна.

Түүнчлэн цахим сангийн өгөгдөл, мэдээллийг нэгдсэн загвар, стандартаар хийж гүйцэтгэх, мэдээллийн агуулга, хэлбэрийн зөрүүтэй байдлыг арилгах шаардлагатай байгаа нь аудитын явцад ажиглагдсан.

4. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан баримт, мэдээлэлд үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын Төв архивын цаасан суурьтай баримтыг

цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг “Хангалттай” гэж үнэллээ. Үүнд архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх чиглэлээр тус байгууллагын удирдлагаас гаргаж буй идэвхи санаачлага, гэрээт архивчдын ажлын гүйцэтгэл, 2016 онд Архивын ерөнхий газраас тус архивт улсын үзлэг явуулаад гаргасан дүгнэлт /99.5 хувь буюу “маш сайн”/-ийг тус тус харгалзан үзсэн.

Гэвч архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаа хүний нөөцийн хүрэлцээ, техник хэрэгслийн хангамж, хэвийн бус ажиллагаа, чанарын хяналт сул байдлаас шалтгаалан Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн зорилт, хүрэх түвшин, цагдаагийн байгууллагын хэрэгцээ шаардлагатай харьцуулахад удаашралтай, цаашид саатаж доголдох эрсдэлтэй байна гэж дүгнэлээ.

5. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, аудитын үр дүнд суурилан Цагдаагийн ерөнхий газрын Төв архивын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, илэрсэн асуудлыг шийдвэрлүүлэх чиглэлээр аудитын багаас дараах саналыг Танд танилцуулж байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 5.4.11-т “Архивын баримт бичгийн 30 хувийг цахим хэлбэрт шилжүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэх, Төв архивын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 4 гэрээт архивчийг зохих зардлыг шийдвэрлэн нэмж ажиллуулах

- Архивын ерөнхий газрын “Цагдаагийн ерөнхий газрын Төв архивын газарт улсын үзлэг явуулсан дүнгийн тухай” Улсын байцаагчийн дүгнэлтэд зөвлөсний дагуу Төв архивт архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, үндэсний хөтөлбөрийн хүрээнд баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим архивын сан хөмрөгийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйгээр хангах мэдээллийн технологи хариуцсан ажилтны орон тоог шинээр бий болгох

- Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаанд өдөр тутам ашиглагдаж буй компьютер, дагалдах хэрэгсэл, скайнерыг шинэчлэхэд шаардлагатай зардлыг шийдвэрлэх зэрэг болно.

Мөн аудитаар илэрсэн асуудалтай холбогдуулан дараах зөвлөмжийг Төв архивт хүргүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

- Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаа нь ажлын шат дамжлага, он дараалал, хамрах хүрээний хувьд жигд, зүй тогтолтой явагдах нь оновчтой. Иймд цахимжуулах үйл ажиллагааг цааш үргэлжүүлэхээс өмнө урьд онуудад хэрэгжсэн үйл ажиллагааг

үнэлэх, дутуу, хоцрогдолтой гүйцэтгэсэн байж болзошгүй ажлуудыг нөхөж хэрэгжүүлэх

- Цахим архивын сан бүрдүүлж ашиглахын нэг гол зорилго нь лавлагаа, мэдээллийг шуурхай гарган ашиглах явдал юм. Үүнд “мэдээлэл нь иж бүрэн байх” зарчим чухал ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл сангаас тухайн хайлт /хүн, байгууллага, он, газар, агуулга г.м/-д хамаарах бүхий л мэдээлэл бүрэн илэрч байх ёстой ч мэдээллийг цахим санд анх оруулах үед гаргасан жижиг алдаа, нэгдсэн загвар, стандартгүй байдал нь үүнд сөргөөр нөлөөлдөг. Иймд одоо бүрдсэн цахим сангийн мэдээллийн бодитой, иж бүрэн байдлыг түүврийн аргаар шалгаж үнэлэх үйл ажиллагааг дотооддоо зохион байгуулах.

6. УДИРДЛАГЫН ТАЙЛБАР

Аудитын тайлангийн төслийг Төв архивт хүргүүлсний дагуу дараах Удирдлагын тайлбарыг ирүүлсэн болно.

“Аудитын дүгнэлт, зөвлөмжийг дэмжиж байна. Цаашид архивын баримтын мэдээллийг санд шивэх, скайнердах, скайнердсан баримтыг засварлах, цахим холболт хийх үйл ажиллагааг жигд явуулах, цахим сангийн өгөгдөл мэдээллийг нэгдсэн загвар, стандартаар хийж гүйцэтгэх, урьд онуудад цахимжуулсан үйл ажиллагааг үнэлэх, дутуу, хоцрогдолтой гүйцэтгэсэн байж болзошгүй ажлуудыг нөхөн хийхэд онцгой анхаарч, удирдлагын хяналтыг төвлөрүүлж ажиллана.”

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2018 оны 05 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаагийн ерөнхий газрын удирдлага болон албадаас өгсөн үүрэг, ажлын чиглэлд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс, албад

Аудитын объект: Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, албадын дарга нараас харьяа нэгжүүдэд хүргүүлсэн үүрэг, ажлын чиглэл, түүний биелэлт үр дүнг тооцох үйл ажиллагаа

Аудитын төрөл: Үйл ажиллагааны аудит

Аудитын хугацаа: 2018.03.22- 2018.05.16

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа М.Азжаргал, Я.Баттулга нар

1. ТАНИЛЦУУЛГА

Удирдлагын үйл ажиллагааг баримтжуулж аливаа асуудлыг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид нийцүүлэн, бичгээр тэмдэглэх баримт бичгийн стандарт шаардлагад нийцүүлэн зөв зохион бүрдүүлэх, бодитой шийдвэрлэх нь байгууллагын бүх шатны бичиг баримтыг боловсруулж байгаа албан тушаалтнуудын үүрэг байдаг. Иймд удирдлагын гаргаж байгаа шийдвэрийн үр дүн нь баримт бичгийн боловсруулалттай шууд холбоотой.

Монгол улсын Стандартчилал хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2011 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт” /MNS 5140-1:2011/-д зааснаар захирамжлалын, зохион байгуулалтын, мэдээлэл лавлагааны баримт бичиг гэсэн 3 бүлэгт ангилсан 29 төрлийн баримт бичиг байхаар заасан байдаг.

Бүлэг	Төрөл	Тодорхойлолт
Захирамжлалын	Зарлиг, тогтоол, захирамж, тушаал, шийдвэр, албан даалгавар, албан шаардлага	Байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд удирдлагын шийдвэрийг баталгаажуулж гаргасан баримт бичиг /дагаж, мөрдөх, заавал биелүүлэх/

Зохион байгуулалтын	Илгээлт, акт, албан бичиг, зөвлөмж, гэрээ, дүгнэлт, журам, заавар, тайлан, төсөл, тэмдэглэл, удирдамж, хөтөлбөр, төлөвлөгөө	Байгууллагын үүрэг зорилт, зохион байгуулалтын бүтэц, эрх зүйн байдлыг тодорхойлсон баримт бичиг /үйл ажиллагааны хэм хэмжээг тогтоох, зохицуулах, журамлах/
Мэдээлэл лавлагааны	Илтгэл, илтгэх хуудас, мэдэгдэл, тодорхойлолт, мэдээлэл, санал, танилцуулга	Мэдээлэх, танилцуулах зорилгоор бэлтгэсэн байгууллагын олон талт үйл ажиллагааны тухай тодорхой мэдээ, мэдээлэл агуулсан баримт бичиг /удирдлагын үйл ажиллагааг үнэн зөв баримтжуулж, байгууллага, иргэдэд мэдээллийг шуурхай хүргэх/

Цагдаагийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих зорилгоор цагдаагийн төв байгууллагын удирдлагаас үүрэг, ажлын чиглэлийг цагдаагийн төв, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад өөрсдийн эрхлэх асуудлын хүрээнд дараах чиглэлээр хүргүүлж байна. Үүнд:

а/Цагдаагийн төв байгууллагын дарга нь хууль тогтоомжоор эрх олгосон болон цагдаагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг хангах бүх чиглэлээр үүрэг, ажлын чиглэлийг;

б/Цагдаагийн төв байгууллагын тэргүүн дэд дарга нь гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл дүн шинжилгээ хийх, мэдээллийн технологи, харилцаа холбооны чиглэлээр;

в/Цагдаагийн төв байгууллагын дэд бөгөөд НЦГ-ын дарга нь нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, бүртгэл, хяналтын болон нийслэлийн цагдаагийн байгууллагыг удирдах чиглэлээр;

г/Цагдаагийн төв байгууллагын дэд /захиргааны удирдлага, дотоод хяналт, аюулгүй байдал/ дарга нь захиргааны удирдлага, албаны аюулгүй байдал, дотоод хяналт, сахилга хариуцлага, бэлэн байдлыг хангах, сургалтын чиглэлээр;

д/Цагдаагийн төв байгууллагын Захиргааны удирдлагын газрын дарга нь хууль тогтоомж, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, үр дүнг тооцох, тайлагнах, захиргааны удирдлага, зохион байгуулалтаар хангах, хүний нөөц, гадаад харилцааг сайжруулах чиглэлээр тус тус үүрэг, ажлын чиглэлийг хүргүүлж байна.

Цагдаагийн ерөнхий газрын удирдлага, албадын дарга нараас 2017.01.01-нээс 2017.12.30-ны хооронд харьяа нэгжүүдэд нийт 2633 заалттай, 1000 орчим хуудас бүхий 534 үүрэг, ажлын чиглэлийг харьяа нэгжүүдэд хүргүүлжээ.

Өгсөн үүрэг, ажлын чиглэлийн биелэлт, үр дүнг тооцож ирүүлэх талаар хугацаа заасан 341, биелэлт, үр дүнг тооцох хугацааг тодорхойлоогүй 193 үүрэг, ажлын чиглэл байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2018 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.4-т заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, албадын дарга нараас харьяа нэгжүүдэд хүргүүлсэн үүрэг, ажлын чиглэл, түүний биелэлт үр дүнг тооцох үйл ажиллагаанд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, аудитын объектыг боловсронгуй болгох, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хүргүүлж, үр дүнг тооцох нь дотоод аудитын зорилго юм.

2.2 Аудитын цар хүрээ

Аудитыг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг тодорхойлох” журмын 100.3.10-д заасан хүрээнд хийх байсан боловч үүрэг, ажлын чиглэлийн давхардлыг тодорхойлох зорилгоор албадын дарга нараас харьяа нэгжүүдэд хүргүүлсэн ажлын чиглэл, үүргийг нэг бүрчлэн тулган үзэх шаардлагын улмаас аудитын цар хүрээг нэмэгдүүлсэн болно.

Уг аудитын объектод гүйцэтгэх ажлын чиглэлээр цагдаагийн байгууллагын удирдлага, Эрүүгийн цагдаагийн албаны даргаас өгсөн үүрэг, ажлын чиглэлийг хамруулаагүй.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ аудитын удирдамж, төлөвлөгөө, асуудлын шинжилгээний хүснэгт, ярилцлагын удирдамж, түүврийн сорил, илэрсэн асуудлын бүртгэл зэрэг нийт 14 төрлийн ажлын баримтыг батлагдсан загварын дагуу боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, хэлтсийн даргаар батлуулж ашигласан.

Аудитын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын удирдлага, албадын дарга нараас 2017.01.01-нээс 2017.12.30-ны хооронд харьяа нэгжүүдэд хүргүүлсэн үүрэг, ажлын чиглэл, түүний бүртгэл, холбогдох архивын материалыг албад, Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсээс гаргуулан авч судалсан.

Мөн аудитаар илэрсэн асуудлыг нотлох, тулган баталгаажуулалт хийх зорилгоор 14 төрлийн түүврийн судалгааг хийж ашигласан.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

Аудитын хүрээнд цугларсан баримт материал, ажлын баримтаар баталгаажсан мэдээлэлд үндэслэн энэхүү тайланд тусган удирдлагад танилцуулж шийдвэрлэвэл зохих дараах асуудлууд байна. Үүнд:

3.1 Монгол Улсын Стандартчилал хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2011 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт”/MNS 5140-1:2011/-д зааснаар захирамжлалын, зохион байгуулалтын, мэдээлэл лавлагааны баримт бичиг гэсэн 3 бүлэгт ангилсан 29 төрлийн баримт бичиг байна. Уг стандартад зааснаар дээд газраас харьяа байгууллага, албан тушаалтанд тодорхой асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлүүлэхээр хугацаатай үүрэг, ажлын чиглэл өгөх үед “Албан даалгавар”-ыг гаргана. Албан даалгавар нь эрх бүхий албан тушаалтнаас дээд газрын шийдвэрийг хэрэгжүүлэх, цаг үеийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор баталж гаргасан баримт бичиг ба үүрэг, ажлын чиглэл гэсэн төрөл байхгүй байна.

Иймд Цагдаагийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих зорилгоор цагдаагийн төв байгууллагын удирдлагаас гаргаж байгаа үүрэг, ажлын чиглэлийг “Албан даалгавар” хэлбэрээр хугацаатай гаргаж, биелэлт, үр дүнг тооцдог байх, харин албадын дарга нар нь зөвлөмж /дээд шатны байгууллага нь харьяа газартаа, эсвэл хяналт шалгалтын эрх бүхий байгууллагаас илрүүлсэн зөрчил дутагдлыг арилгуулах, үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу хэвийн явуулахад зөвлөн туслах зорилгоор гаргадаг баримт бичиг/, алба бичгийн хэлбэрээр /тодорхой асуудлаар байгууллагууд болон нэгжүүд, байгууллага иргэд хоорондоо харилцсан баримт бичиг/ харьяа нэгжүүдэд хүргүүлэх үүрэг, ажлын чиглэлийг боловсруулж байх нь зохистой байна.

Харин Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс нь цагдаагийн төв байгууллагын дарга, Тэргүүн дэд дарга, дэд дарга, Захиргааны удирдлагын газрын даргаас харьяа нэгжүүдэд хүргүүлэх “Албан даалгавар”-ын төслийг боловсруулахдаа Үндэсний архивын ерөнхий газрын дарга нар нь 2009 оны 68 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, Стандартчилал Хэмжил зүйн Үндэсний зөвлөлийн 2011 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан стандарт, “Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг тодорхойлох” журам /ЦБҮАЖ-ын код 100/-д тусгагдсан шаардлагад нийцүүлэн харьяа албадаас албан бичгээр саналыг авч тусгадаг байх нь зүйтэй юм.

3.2 Үндэсний архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-т заасан огноо зөв бичигдсэн байх, хянасан, боловсруулсан албан тушаалтны мэдээлэл бүрэн байх, логик дэс дараалалтай байх, үг, үсгийн болон хэл, найруулгын алдаагүй байх гэсэн 4 шалгуур үзүүлэлтээр Цагдаагийн ерөнхий газрын удирдлага, албадын дарга нараас 2017.01.01-нээс 2017.12.30-ны хооронд харьяа нэгжүүдэд хүргүүлсэн 534 үүрэг, ажлын чиглэлийг боловсруулсан байдалд үнэлгээ хийхэд огноо буруу бичигдсэн 1, хянасан, боловсруулсан албан тушаалтны мэдээлэл байхгүй 46, үг, үсгийн болон хэл, найруулгын алдаатай 16 байна. /Хавсралт №1-ээс үзнэ үү/

Нийт 534 үүрэг, ажлын чиглэлээс 63 буюу 11.7 хувь нь сорил 1-ын шаардлагыг хангахгүй байгаа нь тухайн үүрэг, ажлын чиглэлийг боловсруулж байгаа болон хянасан албан тушаалтны хариуцлагагүй, зөв бичгийн дүрэм, хэл найруулга, баримт бичгийн бүрдлийн талаарх мэдлэг дутмагаас шалтгаалсан байна.

3.3 Стандартчилал Хэмжилзүйн Үндэсний зөвлөлийн 2011 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт”/MNS 5140-1:2011/-д заасан хэвлэмэл хуудас MNS стандартад нийцсэн байх, үсгийн фонд стандартад нийцсэн байх гэсэн 2 шалгуур үзүүлэлтээр 534 үүрэг, ажлын чиглэлийг стандартад нийцсэн байдалтай харьцуулахад 1 дүгээр шалгуур үзүүлэлтийг хангаагүй 3, 2 дугаар шалгуур үзүүлэлтийг хангаагүй 10 байна. /Хавсралт №1-ээс үзнэ үү/

3.4 “Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг тодорхойлох журам”-ын 100.3.12, 100.3.13-д заасан “ЦТБ-ын удирдлагаас өгсөн үүрэг, ажлын чиглэлийг давхардуулан өгөхийг хориглоно”, “Үүрэг, ажлын чиглэлийн нэгдсэн бүртгэлийг хөтөлсөн байх”, “...үүрэг, ажлын чиглэлийн биелэлт, үр дүнг тооцсон байх” гэсэн 3 шалгуур үзүүлэлтээр сорил хийхэд, 534 үүрэг, ажлын чиглэлээс 178-ын биелэлт, үр дүнг тооцоогүй байна. /Хавсралт 1/

Цагдаагийн төв байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг, ажлын чиглэлийг давхардуулан өгөхийг хориглоно гэсэн шалгуур үзүүлэлтийн хувьд 15 чиглэлээр 2633 заалттай 534 үүрэг, ажлын чиглэл нэгжүүдэд хүргэгдсэн байна. Хүргэгдсэн үүрэг, ажлын чиглэлүүдийг эрхлэх асуудлын хүрээгээр хязгаарлаж давхардлыг судлахад, ЦЕГ-ын дарга, дэд дарга /дотоод хяналт/, захиргааны удирдлагын газрын дарга нарын хувьд давхардсан тоо байхгүй, харин тэргүүн дэд /7/, дэд бөгөөд НЦГ-ын дарга /10/ нарын хувьд давхардал байна. /Хавсралт №2-оос үзнэ үү/

Харин Цагдаагийн төв байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг, ажлын чиглэлийг албад, түүний хэлтсийн дарга нар эрхлэх асуудлын хүрээгээр болон агуулга, найруулгыг хувьд давхардуулан үүрэг, ажлын чиглэл өгсөн тохиолдлууд нилээд байна. Иймд ЦТБ-ын удирдлагаас өгсөн үүрэг, ажлын чиглэлийг албад, түүний хэлтсийн дарга нар харьяа нэгжүүдээ дахин үүрэг, ажлын чиглэл болгож хүргүүлэх бус, алба хаагч нартаа танилцуулж судлуулах, биелэлт, үр дүнг тогтоосон хугацаанд бодитой, үнэн зөв тайлагнах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Цаашид албад, түүний хэлтсийн дарга нар Үндэсний архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, Стандартчилал Хэмжилзүйн Үндэсний зөвлөлийн 2011 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан стандарт, “Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг тодорхойлох” журам /ЦБҮАЖ-ын код 100/-д тусгагдсан шаардлагад нийцээгүй үүрэг, ажлын чиглэл хүргүүлэхээс татгалзаж,

зөвлөмж, алба бичгийн хэлбэрээр боловсруулалт хийж, харьяа нэгжүүдэд хүргүүлж байх нь зүйтэй.

Үүрэг, ажлын чиглэлийн биелэлт, үр дүнг тооцсон байх гэсэн шалгуур үзүүлэлтийн хувьд нийт өгсөн үүрэг, ажлын чиглэлийн биелэлт, үр дүнг тооцож ирүүлэх хугацааг заасан 341, биелэлт, үр дүнг тооцох хугацаа заагаагүй 193 үүрэг, ажлын чиглэл хүргүүлсэн байна.

Биелэлт, үр дүнг тооцох хугацааг тодорхойлоогүй нь биелэлтийг хэрхэн тооцсон талаарх мэдээллийг цуглуулахад хүндрэл үүсгэж, дээрх стандартын албан даалгавар /үүрэг, ажлын чиглэл/-ыг хугацаатай өгнө гэсэн заалтыг зөрчсөн байна.

Нэгжүүдэд хүргүүлсэн 534 үүрэг, ажлын чиглэлээс 178 /33.3 хувь/ үүрэг, ажлын чиглэлийн биелэлт, үр дүнг тооцоогүй нь гүйцэтгэлийн удирдлага хангалтгүй, үр дүнг тооцохгүй бол үүрэг, ажлын чиглэл хүргүүлэх шаардлагагүй ба нөгөө талаар нэгжүүдийн албан бичгийн урсгалыг 33.3 хувиар бууруулах боломж байгааг харуулж байна.

4. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт материалд үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, албадын дарга нараас харьяа нэгжүүдэд хүргүүлсэн үүрэг, ажлын чиглэл, түүний биелэлт үр дүнг тооцох үйл ажиллагааг “Сайжруулалт шаардлагатай” гэж дүгнэв. Үүнд:

Нэг. Монгол Улсын Стандартчилал хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2011 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт”/MNS 5140-1:2011/-д “Дээд газраас харьяа байгууллага, албан тушаалтанд тодорхой асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлүүлэхээр хугацаатай үүрэг, ажлын чиглэл өгөх үед “Албан даалгавар”-ыг гаргана. Албан даалгавар нь эрх бүхий албан тушаалтнаас дээд газрын шийдвэрийг хэрэгжүүлэх, цаг үеийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор баталж гаргасан баримт бичиг” гэж тодорхойлсон.

Иймд цагдаагийн төв байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, захиргааны удирдлагын газрын даргаас харьяа нэгжүүдэд хүргүүлж байгаа үүрэг, ажлын чиглэлийг дээрх стандартад нийцүүлэн “Албан даалгавар”-ын төслөөр Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсээс боловсруулж, баримт бичиг нь үг үсгийн алдаагүй, хэл найруулгын хувьд утга санааг бүрэн илэрхийлсэн байх, давхардал, хийдэлгүй байхад анхаарч хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Цагдаагийн байгууллага нь удирдлагын хувьд нэгдмэл төвлөрсөн байх зарчмын хүрээнд цагдаагийн төв байгууллагын удирдлагуудаас баримт бичгийн хувьд албан даалгавар, албадын дарга нараас албан даалгаврын хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлийг тооцох зорилгоор

баримт бичгийн хувьд зөвлөмж, албан бичиг гэсэн 2 төрлөөр баримт бичгийг стандартын дагуу зохион бүрдүүлж нэгжүүдэд хүргүүлж байх талаар ажлын байрны тодорхойлолт, хариуцсан ажлын чиглэлийн дагуу боловсруулалт хийж буй алба тушаалтнууд анхаарах нь зүйтэй.

Хоёр. Үндэсний архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, Стандартчилал Хэмжилзүйн Үндэсний зөвлөлийн 2011 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт” /MNS 5140-1:2011/, “Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг тодорхойлох” журам /ЦБҮАЖ-ын код 100/-д тусгагдсан 9 шалгуур үзүүлэлтээр 534 үүрэг, ажлын чиглэлд үнэлгээ хийхэд, 459 нь шалгуур үзүүлэлт хангасан, 75 нь шалгуур үзүүлэлт хангаагүй, 29 нь үүрэг, ажлын чиглэл бус албан бичгийн хэлбэрээр хүргүүлэх боломжтой мэдээлэл байна. /Хавсралт №1-ээс үзнэ үү/

Үүрэг, ажлын чиглэлийг боловсруулсан албан тушаалтан, түүнийг хянан баталгаажуулдаг удирдах ажилтнуудын баримт бичгийг зохион бүрдүүлэх мэдлэг чадвар сул, дотоод зохион байгуулалт хангалтгүй байгаагаас шалтгаалан нийт үүрэг, ажлын чиглэлийн 14 хувь нь шалгуур үзүүлэлт хангаагүй байна.

Иймд төв байгууллагын хэлтсийн болон албадын дарга нар нь баримт бичиг зохион бүрдүүлэх талаарх мэдлэг эзэмшсэн байх, энэ талаар албан тушаалтнуудын боловсруулсан баримт бичгийг хянах, тэднийг зааварлах чадвартай байх, баримт бичгийн үнэ цэнэ, ач холбогдлыг үнэлж, түүнийг байгууллагын болон өөрийн үйл ажиллагаандаа үр дүнтэй ашиглаж чаддаг болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Мөн төв байгууллагад ажиллаж байгаа алба хаагчдыг ажлын байрны тодорхойлолтын шаардлага хангасан албан баримт бичиг бүрдүүлэх мэдлэг, боловсруулалтын чадвартай алба хаагчдыг сонгож, томилон ажиллуулахад анхаарах шаардлагатай байна. Өнөөгийн түвшинд Цагдаагийн төв байгууллагын албан хэрэг боловсруулалтын байдал зохих түвшинд хүрэхгүй байна гэж үзэхээр байна.

Гурав. Цагдаагийн ерөнхий газрын удирдлага, албадын дарга нараас 2017 онд харьяа нэгжүүдэд нийт 15 чиглэлээр 2633 заалттай, 1000 орчим хуудас бүхий 534 үүрэг, /давхардсан тоогоор 572, зөрүү 38/ ажлын чиглэлийг харьяа нэгжүүдэд хүргүүлжээ.

Хүргэгдсэн үүрэг, ажлын чиглэлүүдийг эрхлэх асуудлын хүрээгээр хязгаарлаж давхардлыг судлахад, ЦЕГ-ын дарга, дэд дарга /дотоод хяналт/, захиргааны удирдлагын газрын дарга нарын хувьд давхардсан тоо байхгүй, харин тэргүүн дэд /7/, дэд бөгөөд НЦГ-ын дарга /10/ нарын хувьд давхардал байна. /Хавсралт №2-оос үзнэ үү/

Харин Цагдаагийн төв байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг, ажлын чиглэлийг албад, түүний хэлтсийн дарга нар эрхлэх асуудлын хүрээгээр

болон агуулга, найруулгыг хувьд давхардуулан үүрэг, ажлын чиглэл өгсөн тохиолдлууд нилээд байна.

Иймд Цагдаагийн төв байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг, ажлын чиглэлийг албад, түүний хэлтсийн дарга нар харьяа нэгжүүддээ дахин үүрэг, ажлын чиглэл болгож хүргүүлэх бус, алба хаагч нартаа танилцуулж судлуулах, биелэлт, үр дүнг тогтоосон хугацаанд бодитой, үнэн зөв тайлагнах талаар зөвлөх, мэдээлэх зорилгоор зөвлөмж, албан бичгийн хэлбэрээр хүргүүлэх нь илүү ач холбогдолтой, давхардал багатай, нэгжүүдэд ачаалал үүсгэхгүй байх боломжит хувилбар болно.

Дөрөв. Цагдаагийн ерөнхий газрын удирдлага, албадын дарга нараас өгсөн үүрэг, ажлын чиглэлийн биелэлт, үр дүнг тооцож ирүүлэх хугацааг заасан 341, биелэлт, үр дүнг тооцох хугацааг заагаагүй 193 үүрэг, ажлын чиглэл хүргүүлжээ.

Биелэлт, үр дүнг тооцох хугацааг тодорхойлоогүй нь биелэлтийг хэрхэн тооцсон талаарх мэдээллийг цуглуулахад хүндрэл үүсгэж, дээрх стандартын албан даалгавар /үүрэг, ажлын чиглэл/-ыг хугацаатай өгнө гэсэн заалтыг зөрчсөн байна.

Нэгжүүдэд хүргүүлсэн 534 үүрэг, ажлын чиглэлээс 178 /33.3 хувь/ үүрэг, ажлын чиглэлийн биелэлт, үр дүнг тооцоогүй нь гүйцэтгэлийн удирдлага хангалтгүй, заавал биелэлт, үр дүнг тооцох хугацааг тодорхой зааж өгч байхыг дээрх баримт бичгийг боловсруулсан албан тушаалтнууд, хянаж баталгаажуулж байгаа удирдлагууд анхаарвал зохино. Зөвхөн цагдаагийн ерөнхий газрын даргын өгсөн 10 үүрэг, ажлын чиглэлийн биелэлт, үр дүнг Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсээс 2017 оны хагас, бүтэн жилээр тооцжээ.

Цагдаагийн төв байгууллагын тэргүүн дэд даргын 38 үүрэг, ажлын чиглэлээс 12, дэд даргын /дотоод хяналт/ 174 үүрэг, ажлын чиглэлээс 46, дэд даргын /НЦГ/ 72 үүрэг, ажлын чиглэлээс 37, захиргааны удирдлагын газрын даргын 18 үүрэг, ажлын чиглэлээс 13 үүрэг, ажлын чиглэлийн биелэлт, үр дүнг тооцоогүй байна. /Хавсралт №2-оос үзнэ үү/

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг тодорхойлох” журмын 100.3.13-д “Албан даалгавар, үүрэг, ажлын чиглэлийн нэгдсэн бүртгэлийг хөтлөх, бүртгэлд авагдсан албан даалгавар, үүрэг, ажлын чиглэлийн биелэлт, тайланг нэгтгэх үүргийг цагдаагийн төв байгууллагын Төлөвлөлт, зохион байгуулалт хариуцсан нэгж хүлээнэ” гэж заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын удирдлагаас хүргүүлж байгаа албан даалгаврын биелэлт, үр дүнг Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс хариуцан тайлагнаж, дотоод хяналтыг хэрэгжүүлэхээр байна.

Монгол Улсын Стандартчилал хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2011 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт”/MNS 5140-1:2011/-д нийцүүлэн Цагдаагийн

ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг тодорхойлох” журам /ЦБҮАЖ код100/-ын 100.3.10, 100.3.11, 100.3.12, 100.3.13-д заасан “Албан даалгавар, үүрэг, ажлын чиглэл” гэснийг “Албан даалгавар” гэж өөрчлөх саналыг Хуулийн хэлтэст хүргүүлэх нь зүйтэй байна.

5. ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, аудитын үр дүнд суурилан Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, албадын дарга нараас харьяа нэгжүүдэд хүргүүлсэн үүрэг, ажлын чиглэл, түүний биелэлт үр дүнг тооцох үйл ажиллагааг эрчимжүүлэх, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр аудитын багаас дараах зөвлөмжийг холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх саналтай байна. Үүнд:

Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст:

1. Монгол Улсын Стандартчилал хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2011 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт”/MNS 5140-1:2011/-ын шаардлагад нийцүүлэн цагдаагийн байгууллагын удирдлагаас тодорхой асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлүүлэхээр хугацаатай үүрэг, ажлын чиглэл өгөхдөө “Албан даалгавар” хэлбэрээр нэгжүүдэд хүргүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэх;

2. Цагдаагийн төв байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, захиргааны удирдлагын газрын даргаас харьяа нэгжүүдэд хүргүүлэх албан даалгаварын төслийг Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсээс боловсруулж, баримт бичиг нь үг үсгийн алдаагүй, хэл найруулгын хувьд утга санааг бүрэн илэрхийлсэн байх, давхардал, хийдэлгүй байх шаардлагад нийцэж байгаа эсэх талаар дотоод хяналтыг хэрэгжүүлэх;

3. Цагдаагийн байгууллага нь удирдлагын хувьд нэгдмэл төвлөрсөн байх зарчмын хүрээнд цагдаагийн төв байгууллагын удирдлагуудаас баримт бичгийн хувьд албан даалгавар, албадын дарга нараас албан даалгаварын хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлийг тооцох зорилгоор баримт бичгийн хувьд зөвлөмж, албан бичиг гэсэн 2 төрлөөр баримт бичгийг стандартын дагуу зохион бүрдүүлж нэгжүүдэд хүргүүлэх ажлыг хэвшүүлэх;

4. Цагдаагийн төв байгууллагын хэлтсийн болон албадын дарга нар нь баримт бичиг зохион бүрдүүлэх мэдлэг эзэмшсэн, энэ талаар албан тушаалтнуудын боловсруулсан баримт бичгийг хянах, тэднийг зааварлах чадвартай байх, баримт бичгийн үнэ цэнэ, ач холбогдлыг үнэлж, түүнийг байгууллагын болон өөрийн үйл ажиллагаандаа үр дүнтэй ашиглаж чаддаг болгоход чиглэсэн зохион байгуулалтын ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

5. Цагдаагийн төв байранд албан бичиг хэргийн мэдлэг, ур чадвар, туршлага, боловсруулалтын шаардлага хангасан алба хаагчдыг томилон ажиллуулахад анхаарах;

6. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг тодорхойлох” журмын 100.3.13-д “Албан даалгавар, үүрэг, ажлын чиглэлийн нэгдсэн бүртгэлийг хөтлөх, бүртгэлд авагдсан албан даалгавар, үүрэг, ажлын чиглэлийн биелэлт, тайланг нэгтгэх үүргийг цагдаагийн төв байгууллагын Төлөвлөлт, зохион байгуулалт хариуцсан нэгж хүлээнэ” гэсэн заалтын хэрэгжилтийг хангах.

Хуулийн хэлтэст:

1. Монгол Улсын Стандартчилал хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2011 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт”/MNS 5140-1:2011/-д нийцүүлэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг тодорхойлох” журам /ЦБҮАЖ код 100/-ын 100.3.10, 100.3.11, 100.3.12, 100.3.13-д заасан “Албан даалгавар, үүрэг, ажлын чиглэл” гэснийг “Албан даалгавар” гэж өөрчлөх.

Албадын дарга нарт:

1. Цагдаагийн төв байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг, ажлын чиглэлийг албад, түүний хэлтсийн дарга нар харьяа нэгжүүддээ дахин үүрэг, ажлын чиглэл болгож хүргүүлэх бус, алба хаагч нартаа танилцуулж судлуулах, биелэлт, үр дүнг тогтоосон хугацаанд бодитой, үнэн зөв тайлагнах талаар зөвлөх, мэдээлэх зорилгоор зөвлөмж, албан бичгийн хэлбрээр хүргүүлж байх.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2018 оны 06 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаагийн байгууллагын зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд хийх нийцлийн аудит

Аудит хийгдсэн нэгж: НХЖХОНАБХА-ны Зөрчил шалгах мэргэжил, арга зүйн хэлтэс

Аудитын объект: 2017 оны 07 дугаар сарын 01-нээс 2018 оны 06 сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаа

Аудитын төрөл: Нийцлийн аудит

Аудитын хугацаа: 2018.05.01- 2018.06.01

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Д.Батсайхан

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа М.Азжаргал

1. ТАНИЛЦУУЛГА

Цагдаагийн байгууллагын зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаа нь Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2017 оны 196 дугаар тогтоолоор баталсан “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардал тооцох журам”, Улсын Ерөнхий прокурорын 2017 оны А/56 дугаар тушаалаар баталсан “Зөрчлийн хэрэгт олгох дугаарын хуваарилалт, бүртгэлийн мэдээний маягт”, мөн прокурорын 2017 оны А/54 дүгээр тушаалаар баталсан “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрийн жагсаалт, загвар”, мөн прокурорын 2018 оны А/01 дүгээр тушаалаар баталсан “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын аргачилсан заавар”-т заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8-д заасан харьяаллын дагуу явуулж байна. Зөрчлийн шийдвэрлэлтийг сүүлийн 5 жилийн байдлаар харуулбал;

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018.05
Зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн тоо	116.542	115.236	103.160	78.722	53.888
Нийт зөрчлийн тоо	681.222	1.423.088	1.038.050	1.327.017	641.679
Шийдвэрлэсэн зөрчлийн тоо	681.222	1.423.088	1.038.050	1.327.017	636.207
Зөрчил шийдвэрлэлтийн хувь	100	100	100	100	99.1
Зөрчил шалгах эрх бүхий алба хаагчийн тоо	1814	1814	1814	1814	2367
Учирсан хохирол /мян.төг/	3.479.250.5	2.640.990.0	2.009.253.5	4.329.761.4	6.043.889.0
Нөхөн төлүүлсэн хохирол /мян.төг/	3.086.043.6	2.190.840.4	1.757.324.6	3.879.580.5	5.354.680.2
Хохирол нөхөн төлүүлэлтийн хувь	88.7	83	87.5	89.6	88.6
Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой иргэдээс ирүүлсэн гомдлын тоо	-	-	-	-	-
Шийдвэрлэсэн гомдлын тоо/хувь	-	-	-	-	-
Прокурорын шаардлага	10	14	9	12	19

Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2017 оны жилийн эцсийн байдлаар эрх бүхий байгууллагууд зөрчлийн талаар нийт 533341-ийг гомдол, мэдээлэл хүлээн авсны 21275 буюу 3.9 хувийг нь хүлээн авахаас татгалзаж, 12656 буюу 2.3 хувьд нь зөрчлийн хэрэг нээж, 497912 буюу 93.3 хувийг нь хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн байна.

Улсын хэмжээнд нийт 11877 хэрэгт зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулснаас 1695 буюу 14.2 хувийг нь хэрэгсэхгүй болгож, 7668 буюу 64.5 хувьд нь эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулжээ.

Мөн 2767 хэрэгт албадлагын арга хэмжээ хэрэгжүүлсний 240 хэрэгт эрх бүхий албан тушаалтан өөрөө албадлагын арга хэмжээ авч, 2527 хэрэгт албадлагын арга хэмжээ авахуулахаар шүүхэд шилжүүлсэн байна.

Нийт хүлээн авсан гомдол, мэдээллийн 95.5 хувь /511373/-ийг Цагдаагийн байгууллага, 0.5 хувь /2657/-ийг Мэргэжлийн хяналтын байгууллага, 0.2 хувь /1034/-ийг Гааль, 0.3 хувь /1779/-ийг Татвар, 0.3

хувь /1699/-ийг Гадаадын иргэн харьяатын газар, 2.8 хувь/14799/-ийг бусад байгууллагууд хүлээн авч шалгажээ.

Хялбаршуулсан журмаар шалгаж шийдвэрлэсэн зөрчлийн талаарх гомдол, мэдээллээс 477786 буюу 96.0 хувийг Цагдаагийн байгууллага, 1697 буюу 0.3 хувийг Мэргэжлийн хяналтын байгууллага, 1010 буюу 0.2 хувийг Гааль, 1576 буюу 0.3 хувийг Татвар, 1636 буюу 0.3 хувийг Гадаадын иргэн харьяатын газар, 14207 буюу 2.9 хувийг бусад байгууллагууд шалгаж шийдвэрлэсэн байна.

Хэрэг бүртгэлт явуулсан нийт зөрчлийн хэргийн 11417 буюу 96.2 хувийг Цагдаагийн байгууллага, 304 буюу 2.6 хувийг Мэргэжлийн хяналтын байгууллага, 17 буюу 0.1 хувийг Гааль, 14 буюу 0.1 хувийг Татвар, 29 буюу 0.2 хувийг Гадаадын иргэн харьяатын газар, 96 буюу 0.8 хувийг бусад байгууллагууд шалгажээ.

Түүнчлэн зөрчлийн хэргийн улмаас нийт 5.018.240.818 төгрөгийн /иргэнд 2.429.192.938, хуулийн этгээдэд 2.407.427.006, төрд 181.620.874 төгрөгийн/ хохирол учирснаас иргэдэд учирсан хохирлын 59.8 хувь буюу 1.454.167.713 төгрөг, хуулийн этгээдэд учирсан хохирлын 2.7 хувь буюу 65.610.727, төрд учирсан хохирлын 40.3 хувь буюу 73.270.700 төгрөгийг нөхөн төлүүлсэн байна.

Прокурорын байгууллагаас зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих явцад нийт 97 дүгнэлт бичсэний 67 буюу 69.0 хувьд эрх бүхий албан тушаалтны шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах, 30 буюу 31.0 хувьд эрх бүхий албан тушаалтны шийтгэлийн хуудсанд өөрчлөлт оруулах санал бүхий дүгнэлт бичиж, шүүхээр шийдвэрлүүлжээ.

Прокурорын хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд эрх бүхий байгууллагад 180 удаа шалгалт хийн, 2383 зөрчил илрүүлж, шалгалтын мөрөөр зөрчлийг арилгуулах тухай 113 шаардлага бичиж, 190 хүний зөрчигдсөн эрхийг сэргээсэн байна.

Цагдаагийн байгууллагад 2017 онд 12 шаардлага ирүүлсэн нь прокурорын бичсэн нийт шаардлагын 10.6 хувийг эзэлж байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2018 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.2-т заасны дагуу цагдаагийн байгууллагын зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд нийцлийн аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, аудитын объектыг боловсронгуй болгох, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан холбогдох алба, нэгжид хүргүүлж, үр дүнг тооцоход оршино.

2.2 Аудитын цар хүрээ

Аудит нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8-д зааснаар цагдаагийн байгууллагад харьяалуулсан зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд эрх зүйн зохицуулалтын хийдэл, давхардал байгаа эсэхийг тогтоох, алба хаагчдын хууль хэрэгжүүлэх үе шатанд ямар хүндрэл бэрхшээл учирч байгааг тогтоох хүрээнд явагдана.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ аудитын хүрээнд шалгах мэдээлэл, түүнийг нотлох аргуудыг ашиглан, аудит хийгдэх нэгжийн удирдлага, алба хаагчидтай хийх уулзалт ярилцлагын удирдамжийг боловсруулан хэлтсийн даргаар батлуулж, биелэлт үр дүнг тооцож ажилласан.

Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааны явцад системтэй, оновчтой арга хандлагаар олон улсын стандартын дагуу эрсдэлийн үнэлгээ хийж, дотоод хяналтын орчныг үнэлж, цаашид сайжруулах шаардлагатай аудитаар илэрсэн асуудлуудад зөвлөмжийг боловсруулсан болно.

Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэх шатанд цагдаагийн байгууллагын алба хаагчдын үйл ажиллагаанд учирч байгаа эрсдэлийг тодорхойлж үнэлэх, Цагдаагийн төв байгууллагаас Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/243 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэгт хүргүүлсэн 4 удаагийн танилцуулга, мөн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 1-4/48 дугаартай албан бичгээр ирүүлсэн зөвлөмж зэрэг холбогдох баримт бичгүүдтэй танилцаж, дүн шинжилгээ хийлээ.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/132 дугаар тушаалаар цагдаагийн байгууллагын хэмжээнд зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий Зөрчил шалгах, мэргэжил арга зүйн хэлтсийг Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны зохион байгуулалтын бүтцэд байгуулсан.

Энэ нь дотоод хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий алба хаагчдыг сургаж дадлагажуулах, мэргэшүүлэх, тэднийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангахад чиглэсэн ач холбогдолтой, оновчтой шийдэл болсон байна.

3.2 Цагдаагийн байгууллагын зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд учирч болзошгүй 24 эрсдэлийг тодорхойлж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны

эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх /ЦБҮАЖ-ын код 137/ журам"-д заасан аргачлалаар эрсдэлийн үнэлгээ хийлээ.

Эрсдэлийн үнэлгээгээр 36 оноотой 3, 30 оноотой 7, 25 оноотой 14, эрсдэлийн төрлөөр нь авч үзвэл үйл ажиллагааны 8, нийцлийн 16 байна. Эрсдэлийн үнэлгээний мөрөөр хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний саналыг боловсруулж Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанд хүргүүлж биелэлт, үр дүнг тооцно. /Хавсралт №2-оос үзнэ үү/

3.3 Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааны явцад байгууллага болон алба хаагч нарт учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, түүний мөрөөр хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг төлөвлөх, биелэлт үр дүнг тооцох, удирдлагыг шийдвэр гаргах түвшинд боловсруулагдсан мэдээллээр хангах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх үйл явц нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх /ЦБҮАЖ-ын код 137/ журам”-ын 137.4.4-т заасан шаардлагын түвшинд хүрэхгүй байна.

Олон улсын загварчлалаар дотоод хяналтыг хэрэгжүүлэх бүтцэд эрсдэлийн удирдлага, хяналт шалгалт, аюулгүй байдал, мэдээлэл, харилцаа холбоо, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиг үүргүүд нь ордог. Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд дараах албан тушаалтнууд дотоод хяналтыг хэрэгжүүлж байна. Үүнд:

Албаны дарга	Зөрчил шалгах, мэргэжил, арга зүйн хэлтэс	Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга	Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга	Ахлах байцаагч
--------------	---	---	---	----------------

Дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа албан тушаалтнуудын зан үйл, ёс суртахуун, хариуцлага хүлээх чадвар, манлайлал, ажлын туршлагаас хамааран хяналтын үр дүн, үр нөлөө харилцан адилгүй байна.

Дотоод хяналт сул байгаагаас шалтгаалан Прокурорын шаардлагын /Гадны хяналтаар илрүүлсэн зөрчлийг арилгуулахаар бичсэн/ тоо 2017 онд 12 байсан бол 2018 оны эхний 05 сарын байдлаар 19 болж өссөн дүнтэй байна.

3.4 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8-д зааснаар цагдаагийн байгууллагад харьяалуулсан зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд эрх зүйн зохицуулалтын хувьд Зөрчлийн тухай хуулийн заалтын хүрээнд 20 хийдэл, 1 давхардал, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн заалтын хүрээнд 28 хийдэл, 3 давхардал байна /Хавсралт 1/.

Дээрх хуулиудын заалтын давхардал, хийдлийг арилгуулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг нэгтгэж, Хуулийн хэлтсээр хянуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/243 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэгт хүргүүлэхээр бэлтгэсэн.

4. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт материалд үндэслэн цагдаагийн байгууллагын зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг “Хангалттай” гэж үнэлэв. Ингэхдээ сүүлийн 5 жилийн зөрчил шийдвэрлэлтийн хувь /99.8/, хохирол нөхөн төлүүлэлтийн хувь /87.4/ гэсэн шалгуур үзүүлэлтийг харгалзан үзлээ.

Иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг хэмжих гол үзүүлэлт болох “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой иргэдээс ирүүлсэн гомдлын тоо”, “Шийдвэрлэсэн гомдлын тоо/хувь” гэсэн үзүүлэлтийн статистик тоон мэдээлэл байхгүй байна.

НХЖХОНАБХА-ны зохион байгуулалтын бүтцэд Зөрчил шалгах, мэргэжил арга зүйн хэлтсийг байгуулсан нь цагдаагийн байгууллагын зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий алба хаагчдыг сургаж дадлагажуулах, мэргэшүүлэх, тэднийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангахад чиглэсэн ач холбогдолтой, оновчтой шийдэл болсон гэж дүгнэхээр байна.

Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааны явцад байгууллага болон алба хаагчдад учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, түүний мөрөөр хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг төлөвлөх, биелэлт үр дүнг тооцох, удирдлагыг шийдвэр гаргах түвшинд боловсруулагдсан мэдээллээр хангах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх үйл явц нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх /ЦБҮАЖ-ын код 137/ журам”-ын 137.4.4-т заасан шаардлагын түвшинд хүрэхгүй байна.

Цагдаагийн байгууллагын зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд учирч болзошгүй 24 эрсдэлийг тодорхойлж, үнэлгээ хийхэд 36 оноотой 3, 30 оноотой 7, 25 оноотой 14, эрсдэлийн төрлөөр нь авч үзвэл үйл ажиллагааны 8, нийцлийн 16 байна.

Иймд эрсдэлийн үнэлгээний мөрөөр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний үр дүнг зөвлөмжид заасан хугацаанд Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст ирүүлэх нь зүйтэй.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8-д зааснаар цагдаагийн байгууллагад харьяалуулсан зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд эрх зүйн зохицуулалтын хувьд Зөрчлийн тухай хуулийн заалтын хүрээнд 20 хийдэл, 1 давхардал, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн заалтын хүрээнд 28 хийдэл, 3 давхардал байгаа нь тогтоогдож байна. /Хавсралт №1-ээс үзнэ үү/

Дотоод аудитын явцад илэрсэн эрх зүйн зохицуулалтын 4 давхардал, 48 хийдлийг арилгуулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Хуулийн хэлтсээр хянуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/243 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсэгт хүргүүлж шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэв.

5. ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, аудитын үр дүнд суурилан “Цагдаагийн байгууллагын зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаа”-г эрчимжүүлэх, илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах чиглэлээр аудитын багаас дараах зөвлөмжийг холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх саналтай байна. Үүнд:

5.1 Иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг хэмжих гол үзүүлэлт болох “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой иргэдээс ирүүлсэн гомдлын тоо”, “Шийдвэрлэсэн гомдлын тоо/хувь” гэсэн статистик тоон мэдээллийг улирал бүрээр гаргаж, дүн шинжилгээ хийж байхад анхаарах /Зөрчил шалгах, мэргэжил, арга зүйн хэлтэс, Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга/;

5.2 Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааны явцад байгууллага болон алба хаагчдад учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, түүний мөрөөр хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг төлөвлөх, биелэлт үр дүнг тооцох, удирдлагыг шийдвэр гаргах түвшинд боловсруулагдсан мэдээллээр хангах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх үйл явцыг тогтмолжуулах, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх /ЦБҮАЖ-ын код 137/ журам”-ын 137.4.4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хагас, бүтэн жилээр хяналт шинжилгээ хийх /Зөрчил шалгах, мэргэжил, арга зүйн хэлтэс, Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга/;

5.3 Эрсдэлийн үнэлгээний мөрөөр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний үр дүнг 2018 оны 11 дүгээр сарын 22-ны дотор Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст ирүүлэх /Зөрчил шалгах, мэргэжил, арга зүйн хэлтэс/;

5.4 Дотоод аудитын явцад илэрсэн эрх зүйн зохицуулалтын 4 давхардал, 48 хийдлийг арилгуулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Хуулийн хэлтсээр хянуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/243 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсэгт хүргүүлэх /Хуулийн хэлтэс, Зөрчил шалгах, мэргэжил, арга зүйн хэлтэс/

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 12 дугаар сарын 12-ны дотор Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст ирүүлэх.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2018 оны 08 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаагийн байгууллагын санхүүгийн анхан шатны баримт бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Цагдаагийн байгууллага, нэгж

Аудитын объект: Санхүүгийн анхан шатны баримт бүрдүүлэлт

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Д.Батсайхан

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа С.Март

1. ТАНИЛЦУУЛГА

Цагдаагийн ерөнхий газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 59 байгууллагын 2015-2018 оны дотоод аудит болон Үндэсний аудитын газар, орон нутгийн аудитын албанаас хийгдсэн шалгалтуудаар анхан шатны баримттай холбоотой ажил гүйлгээний алдаа, зөрчил дахин давтан илэрч байгаа талаар аудит хийлээ.

Аудитаар 2015 онд 398,0 мянган төгрөгийн алдаа, 23.559,0 мянган төгрөгийн зөрчил, 2016 онд 1.843,6 мянган төгрөгийн алдаа, 881.902,2 мянган төгрөгийн зөрчил, 2017 онд 1.951,8 мянган төгрөгийн алдаа, 80.086,8 мянган төгрөгийн анхан шатны баримттай холбоотой зөрчил илэрчээ. Нийт 29 төрлийн 989.343,4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж, албан шаардлага, заавар өгч байгаач хэрэгжүүлж буй санхүүгийн алба хаагчид өдөр тутмынхаа ажилд мөрдлөг болгохгүй байна.

Дотоод аудитын явцад өмнөх шалгалтуудын мэдээлэл, баримт бичигт үндэслэн, шинжилгээний горимууд ашиглан илэрсэн алдаа, зөрчлийн нөхцөл байдлыг тодорхойлох, шалтгаан, үзүүлж буй нөлөөлөл, цаашид үүсэж болох эрсдэлийг бууруулах асуудлыг практик хэрэглээ талаас нь ашиглах аргачлал болгох зорилгоор судалгаа хийлээ.

Аудитын цар хүрээнд хамаарах хугацааны 17 байгууллагын мэдээллийг судалгааны хэсэгт ашигласан бөгөөд нийт анхан шатны баримттай холбоотой илэрсэн алдаа, зөрчлийн 2 хувь нь 2015 онд³, 35 хувь нь 2016 онд, 63 хувь нь 2017 онд байна. Үүний 51 хувь нь хөдөө орон нутгийн цагдаагийн байгууллагууд, 49 хувь нь Нийслэлийн цагдаагийн газрын харьяаны байгууллагад гарчээ.

³ ЦЕГ-н Дотоод аудитын нэгж 2015 онд шинээр байгуулагдаж, 05 сараас үйл ажиллагаагаа эхлүүлсэн тул 2015 оны 5 сарын 25 наас хойших мэдээллийг авсан болно.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

Санхүүгийн аудитын явцад “санхүүгийн анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ хийх” алдаа, зөрчил тогтмол илэрч байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, цаашид бууруулах, давтан гаргахгүй байх талаар шийдэл гаргаснаар цагдаагийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа сайжирч, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

2.2 Аудитын цар хүрээ

Аудитор цагдаагийн 59 нэгж байгууллагын 2015-2018 оныг хамаарах хугацаанд байнга давтагдан илэрч буй “санхүүгийн анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ хийх” алдаа, зөрчилтэй холбоотой үйл ажиллагааг хамааруулна.

Санхүүгийн аудитаар илэрсэн “санхүүгийн анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ хийх”-тэй холбогдолтой хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилт хэрхэн явагдаж байгаа талаар үнэлэлт өгч, эрсдэлийн дүн шинжилгээ хийж, тулгарч буй асуудлыг засаж, сайжруулах чиглэлээр дүгнэж, дэмжлэг үзүүлнэ.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ аудитаар шалгагдсан холбогдох материалаас аудитын цар хүрээнд хамаарах хэсгийг түүвэрлэн судалгаа, харьцуулалтын шинжилгээний аргуудаар мэдээлэл цуглуулж, түүнийг нотлох аргыг боловсруулан баталгаажуулахад ашигласан.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Булган аймаг дахь Цагдаагийн газарт: Булган аймгийн аудитын газраас 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Э.Энх-Амьдралд олгосон 136.0 мянган төгрөгийн 3 удаагийн томилолтын хуудасны он сар давхацсан, 36.0 мянган төгрөгийн томилолт илүү олгосон, Б.Энхтүвшинд 1184.0 мянган төгрөгийн томилолт олгох тушаал гаргасан боловч томилолтын хуудас байхгүй, анхан шатны баримт дутуу бүрдүүлсэн.

3.2 Орхон аймаг дахь цагдаагийн газарт: Орхон аймгийн аудитын газраас хийсэн аудитаар Үндсэн хөрөнгө хүлээн авч бүртгэлд тусгахдаа шийдвэр гаргаагүй байхад ажил гүйлгээ хийсэн, /ҮХ-1/ анхан шатны баримт, маягтыг хөтлөөгүй байна.

3.3 Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын цагдаагийн хэлтэст: Дорноговь аймгийн аудитын газраас хийсэн аудитаар байгууллагын гадна засварын ажлыг гүйцэтгүүлэхээр гүйцэтгэгч

байгууллагад 5.2 сая төгрөгийг шилжүүлсэн бөгөөд засвар хийгдэх ажлын төсөв байхгүй, ажил гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулаагүй, мөн албан хаагчдад 2.2 сая төгрөгийн хоолны мөнгө тушаал шийдвэргүйгээр олгосон байна. 2017 онд хийсэн ЦЕГ-ын дотоод аудитаар шатахууныг нормын дагуу тооцдоггүйгээс шатахуун хэтэрч 968,0, шатахуун хэмнэсэн нь анхан шатны баримтаар нотлогдохгүй, үндэслэл муутай 3.469,0, өссөн дүнгээрээ 9.848,2 мянган төгрөгийн зөрчил, анхан шатны бүрдэлгүй баримтаар ажил гүйлгээ хийсэн 43.274,8, нярвын тайлангаар ашиглагдаж байгаа тусгай зориулалтын материалыг данснаас хассан 1.523,7, нотлох баримтыг үндэслэлгүй албан томилолтын зардал илүү олгосон 438,6, зарцуулалтын тайлангүй, хоолны зардлаас барилгын засвар хийж байгаа ажилчдын хоолны зардал төлсөн 3.380,0, шаардах хуудас, зарлагын баримтын тоо хэмжээ зөрүүтэй, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй баримтаар аж ахуйн материал 28,7, бичиг хэргийн материал зарлага болгосон 1.077,8 мянган төгрөгийн зөрчилтэй гүйлгээ хийсэн.

3.4 Ховд аймаг дахь цагдаагийн газар: Ховд аймгийн аудитын газраас хийсэн аудитаар их хэмжээгээр нийлүүлж байгаа шатахуун, бараа материалыг сонгон шалгаруулалтаар аваагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, сэлбэг хэрэгсэл авахдаа акт дүгнэлт гаргаагүй, Шим-Ус ОНӨҮГ-аас 1,8 сая төгрөгийн бэлэн мөнгө аваад анхан шатны баримтгүй зарцуулсан.

3.5 Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтэс: Нийслэлийн аудитын газраас хийсэн аудитаар замын хуудсанд автомашины спидометрийн заалтыг бичээгүй анхан шатны баримт бүрдүүлээгүйгээс шатахуун зарцуулалтын тооцоог тулгах боломжгүй.

3.6 Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтэс: Тээвэр шатахууны зардлыг түүвэрлэн шалгахад 862.2 мянган төгрөгийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийгдсэн.

3.7 Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 3 дугаар хэлтэс: Цалингийн зардлыг анхан шатны үнэн зөв баримтыг үндэслэн тайлагнаагүйгээс зөрүүтэй тооцоолсон, НДШ-ийн авлагын эхний үлдэгдлийг тайлант хугацаанд зардлын дансанд бичилт хийж хаасан, “Алба хаагчдын цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийг тайланд тусгаагүйгээс 1505.1 мянган төгрөг”-ийн төлбөрийн акт тавьж, ХХОАТ-ын тооцоогоор гарсан дутуу төлөлтийг өглөгөөр бүртгэж тайлагнаагүй, өмнөх оны өглөгт тайлагнаагүй өглөгийг тайлант хугацааны төсвөөс төлсөн урьдчилж төлсөн, шатахууны төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

3.8 Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтэс: Халаалтын зууханд зарцуулах нүүрсний норм норматив байхгүйгээс 13 773.6 мянган төгрөгийн нүүрсний зарцуулалтын тайлан гаргаагүй, Дугуй сервис заг ХХК-д 147 удаагийн 2940 тн бохир ус соруулсны төлбөрт 10,290.0 мянган төгрөг хэдний өдөр хэдэн удаа үйлчилгээ үзүүлсэн нь нотлох баримтгүй

зарцуулсан.

3.9 Сонгино хайрхан дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтэс: Анхан шатны баримтын бүрдэл дутуу, мөнгөн дүн бичигдээгүй байсан нэхэмжлэх, бусад анхан шатны баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан. ЦЕГ-ын дотоод аудитаар санхүүгээс тушаал шийдвэргүй 12 алба хаагчид 1.569,6 мянган төгрөгийн цалин нэмсэн, 1 алба хаагчид 256.5 мянган төгрөг хассан, цалингийн шатлал, нэмэгдэл өөрчлөгдсөн тушаал шийдвэрийг хэрэгжүүлээгүй буруу цалинжуулан 3 алба хаагчдад 567.0 мянган төгрөгийн цалин илүү олгосон, 11 алба хаагчдад 3.642,6 мянган төгрөгийн цалин дутуу олгосон, 1.624,0 мянган төгрөгийн албан томилолтын тооцоог дэмжих баримтгүй олгосон, 4.590,1 мянган төгрөгийн хөрөнгийг урсгал засварын төсөв, гүйцэтгэл хийдэггүй, зарцуулалтын тайлангүй шууд зарлагаддаг, 127.451,7 мянган төгрөгийг хяналт тавих эрх бүхий хүн дэмжих баримтыг баталгаажуулж цохолт хийгээгүй байхад мөнгөн шилжүүлэг хийсэн, 45.417,6 мянган төгрөгийн харилцах дансны бүртгэл анхан шатны баримтгүй, 2.295,4 мянган төгрөгийн автомашины шатахуун зарцуулалтын тооцоо, замын хуудас бичээгүй, 2.546,2 мянган төгрөгийн нүүрс анхан шатны баримтгүйгээр зарлага болгосон, 160.032,9 мянган төгрөгийн бараа материалыг бүрдэл дутуу анхан шатны баримтаар зарлага болгосон.

3.10 Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн 2, 3 дугаар хэлтэс: Тусгай зориулалтын материалын шаардах хуудас /шилжүүлгийн баримт/ олгосон, хүлээн авсан хүний гарын үсэг байхгүй.

3.11 Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтэс: Эргүүлийн автомашин засвартай үед замын хуудас бичиж шатахуун олгосон.

3.12 Багахангай дүүрэг дэх цагдаагийн тасаг: Шатахууны бодит зарцуулалтаар зарлагад бүртгэхгүй, жолоочийн цэнэглэсэн картын дүнгээр зарлагдсан. Томилолтоор явсан замын зардлын баримтгүйгээр 63.0 мянга, томилолтын нэг өдрийн тооцоог зөрүүтэй хийсэн 88.5 мянга, нийт 151.5 мянган төгрөгийг илүү олгосон зөрчил илэрсэн.

3.13 Сэлэнгэ аймгийн цагдаагийн газар: ЦЕГ-ын дотоод аудитаар анхан шатны бүрдэлгүй баримтаар 339.390,0 мянган төгрөгийн ажил гүйлгээ хийсэн.

3.14 Завхан аймгийн цагдаагийн газар: ЦЕГ-ын дотоод аудитаар канондсын төлбөрийн хүсэлтээр 73.455,5, гарын үсэггүй төлбөрийн хүсэлтээр мөнгөн шилжүүлэг хийсэн 96.929,6, эрх бүхий албан тушаалтан зөвшөөрөөгүй байхад шилжүүлсэн 201,8, албан томилолтын тооцоог дэмжих баримтгүй олгосон 357,0, үнэт цаасыг анхан шатны баримтын бүрдэл хангаагүй цохолт зөвшөөрөлгүй баримтаар олголт хийсэн 260,0, алба хаагчдад олгосон үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэл байхгүй, Тосонцэнгэл дэх Цагдаагийн хэлтсийн үнэт цаас хариуцан олгодог алба хаагчтай Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ хийгээгүй, хяналтгүй хөрөнгө зарцуулдаг, барилга засварын төсөв, гүйцэтгэл хийхгүй 3.671,1,

анхан шатны бүрдэлгүй баримтаар зарцуулалт хийсэн 6.678,6, бараа материал орлогод авсан 1.521,8 мянган төгрөгийн гүйлгээ. Үнэт цаасны тооцоо хийхдээ тасалбарын санхүүтэй тооцоо хийх хувийг өгөөгүй байхад ня-бо данснаас анхан шатны баримтгүй шууд хассан 20,0, тооцоогоо хийсэн алба хаагчдийн 300,0 мянган төгрөгийг бүртгэлээр зарлага болгоогүй, 6ш шийтгэвэрийг алба хаагч 6 дугаар сард тушааж тооцоо хийсэн байхад санхүүгийн бүртгэлээс 8 дугаар сард хассан.

3.15 Архангай аймаг дахь цагдаагийн газар: ЦЕГ-ын дотоод аудитаар бараа материал, урсгал засвар, сэлбэгийг зарцуулсан гүйцэтгэлийн тайлан гаргаагүй, данс бүртгэлд байгууллагаас авах авлагаар бүртгээгүй, тооцоо нийлсэн акт үйлдээгүй 5.207,2, кассаас бэлэн мөнгө зарцуулахдаа мөнгө хүлээн авсан хүнээр гарын үсэг зуруулаагүй, олгосон баримт байхгүй, хэнд өгсөн нь тодорхойгүй, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал, ахмадад хүндэтгэл үзүүлэх буцалтгүй тусламжид олгосон мөнгөнөөс татвар тооцсон, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаагүй 1.351,0 мянган төгрөгийн, томилолтын мөнгө илүү олгосон 398,0, тамга зөрсөн, буудлын баримт, томилолтоор ажилласан тухай илтгэх хуудас бичигдээгүй 390,0, шатахууныг замын хуудас, спидометрийн заалт зөрүүтэй, автомашины хувийн хэргийн хөтлөлт бүрэн бус байхад 15.372,8 мянган төгрөг илүү тооцож олгосон.

3.16 Төв аймгийн цагдаагийн газар: ЦЕГ-ын дотоод аудитаар үнэт цаасыг анхан шатны баримтын бүрдэл хангаагүй баримтаар олгосон, агуулахын бүртгэл хөтлөөгүй, алба хаагчдад олгосон үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэл 2015 оны 11 сараас хойш байхгүй, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ хийгээгүй 840,0 мянган төгрөгийн ажил гүйлгээ тус тус хийсэн алдаа, зөрчлүүд гарч байсан.

Хүснэгт 1. АШБ-тай холбоотой гарсан зөрчил /мян.төг/

Үзүүлэлт	Харьяалал			Нийт
	Хөдөө орон нутаг	НЦГ-ийн харьяа	Төв	
2015 он	22719,1	0	0	22719.1
2016 он	184235,0	565970,0	0	750205.6
2017 он	398313,0	25077,3	0	423391.1

Тайлбар: 2015-2018 онд дотоод аудит болон бусад хөндлөнгийн аудитаар шалгагдсан цагдаагийн 17 байгууллагын илэрсэн зөрчлийг судалгаанд хамруулсан болно. Нийт анхан шатны баримттай холбоотой илэрсэн алдаа, зөрчлийн 2 хувь нь 2015 онд, 35 хувь нь 2016 онд, 63 хувь нь 2017 онд байна. Үүний 51 хувь нь хөдөө орон нутгийн цагдаагийн байгууллагууд, 49 хувь нь Нийслэлийн цагдаагийн газрын харьяаны байгууллагад гарчээ.

**Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан байгууллагын
АШБ-ийн алдаа, зөрчлийн төрлөөр /мян.төг/**

Илэрсэн зөрчлийн төрлөөр		Он			Нийт
		2015	2016	2017	
Алдаа	Цалин тушаал шийдвэргүй нэмж, хассан	0	1569.7	0	1569.7
	Цалингийн шатлал, нэмэгдэл өөрчилсөн тушаал шийдвэрийг хэрэгжүүлээгүй		567		567
	Албан томилолтын тооцоог дэмжих баримтгүй олгосон	398	0	151.5	549.5
	Харилцагчаас АШБ-гүй бэлэн мөнгө авч зарцуулсан		0	1800	1800
	Үнэт цаасны тооцоо хийхдээ тасалбарын санхүүтэй тооцоо хийх хувийг өгөөгүй байхад ня-бо данснаас анхан шатны баримтгүй шууд хассан		20		20
Зөрчил	Цалин тушаал шийдвэргүй нэмж, хассан		256.6		256.6
	Цалингийн шатлал, нэмэгдэл өөрчилсөн тушаал шийдвэрийг хэрэгжүүлээгүй		3642.6		3642.6
	албан томилолтын тооцоог дэмжих баримтгүй олгосон	390	1981.0		2371
	Хяналтгүй хөрөнгө зарцуулдаг, урсгал засварын төсөв, гүйцэтгэл хийдэггүй, зарцуулалтын тайлангүй шууд зарлагаддаг	5207.2	8261.2	5200	18668.4
	Хяналт тавих эрх бүхий хүн дэмжих баримтыг баталгаажуулж цохолт хийгээгүй байхад мөнгөн шилжүүлэг хийсэн		127451.7		127451.7
	Анхан шатны баримтгүй ажил гүйлгээ хийсэн		391970.7	43274.8	435245.5
	Автомашин шатахуун зарцуулалтыг тооцдог АШБ Замын хуудас бичээгүй	15372.8	12777.3	862.2	29012.3
	Анхан шатны баримтгүйгээр нүүрс зарлага болгосон		2546.3		2546.3
	Бүрдэл дутуу анхан шатны баримтаар Бараа материал, хөрөнгө зарлага болгосон.		161554.7		161554.7
	АШБ-Зарцуулалтын тайлангүй, хоолны зардлаас барилгын засвар хийж байгаа ажилчдын хоолны зардал төлсөн.			3380	3380
	Ажахуйн материал, Шаардахуудас, зарлагын баримтын тоо хэмжээ зөрүүтэй, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй баримтаар аж ахуйн материал зарлага болгосон			1106.5	1106.5
	Канондсон төлбөрийн хүсэлтээр мөнгөн шилжүүлэг хийсэн		73455.6		73455.6
	Гарын үсэггүй төлбөрийн хүсэлтээр мөнгөн шилжүүлэг хийсэн		96929.6		96929.6
Эрх бүхий албан тушаалтан зөвшөөрөөгүй байхад мөнгө шилжүүлсэн		201.8		201.8	

Зөрчил	Үнэт цаасыг анхан шатны баримтын бүрдэл хангаагүй цохолт зөвшөөрөлгүй баримтаар олгосон, Алба хаагчдад олгосон үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэл байхгүй, Тосонцэнгэл дэх Цагдаагийн хэлтсийн үнэт цаас хариуцан олгодог алба хаагчтай Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ хийгээгүй	840	260		1100
	Үнэт цаасны тооцоо хийхдээ тасалбарын санхүүтэй тооцоо хийх хувийг өгөөгүй байхад ня-бо данснаас анхан шатны баримтгүй шууд хассан		300		300
	Кассаас бэлэн мөнгө зарцуулахдаа анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаагүй	1351			1351
	Алба хаагчдад хоолны мөнгө тушаал, шийдвэргүй олгосон			2200	2200
	Халаалтын зууханд зарцуулах нүүрсний норм норматив байхгүй, нүүрсний зарцуулалтын тайлан гаргаагүй			13773.6	13773.6
	Дугуй сервис заг ХХК-д 147 удаагийн 2940 тн бохир ус соруулсны төлбөрт зарцуулсан нь хэдний өдөр хэдэн удаа үйлчилгээ үзүүлсэн нь нотлох баримтгүй.			10290	10290
	Үндсэн хөрөнгө хүлээн авч бүртгэлд тусгахдаа бүртгэл тусгах талаар шийдвэр гаргаагүй, /ҮХ-1/ анхан шатны баримт, маягыг хөтлөөгүй байна.				0
	Урьдчилж төлсөн шатахууны төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй				0
	Шатахууны тооцоог хийхдээ шатахууны бодит зарцуулалтаар зарлагад бүртгэхгүй, жолоочийн цэнэглэсэн картын дүнгээр зарлагдсан байна.				0
	Үндсэн хөрөнгө хүлээн авч бүртгэлд тусгахдаа бүртгэл тусгах талаар шийдвэр гаргаагүй, /ҮХ-1/ анхан шатны баримт, маягыг хөтлөөгүй байна.				0
Нийт	23559	883745.8	82038.6	989343.4	

Аудитаар 17 байгууллагад 2015 онд 398,0 мянган төгрөгийн алдаа, 23.559,0 мянган төгрөгийн зөрчил, 2016 онд 1.843,6 мянган төгрөгийн алдаа, 881.902,2 мянган төгрөгийн зөрчил, 2017 онд 1.951,8 мянган төгрөгийн алдаа, 80.086,8 мянган төгрөгийн анхан шатны баримттай холбоотой зөрчил илэрчээ. Нийт 29 төрлийн 989.343,4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж, албан шаардлага, заавар өгчээ.

4. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн “Цагдаагийн байгууллагын санхүүгийн аудитаар байнга илэрдэг анхан шатны баримттай холбоотой алдаа, зөрчил”-ийн 44.0 хувь “анхан шатны баримтгүй ажил гүйлгээ хийсэн” зөрчил байгаа нь нярав, аж ахуйн ажилтан нарт хариуцуулах ажлыг хариуцуулахгүйгээр нягтлан бодогч өөртөө хэт ачаалал үүсгэдэгээс цаг хугацаандаа амждаггүй, 30,1 хувь “хяналт тавих эрх бүхий хүн дэмжих баримтыг баталгаажуулж цохолт хийгээгүй байхад, канондсон төлбөрийн хүсэлтээр, гарын үсэггүй төлбөрийн хүсэлтээр тус тус мөнгөн шилжүүлэг хийсэн” нь орон нутагт ихэвчлэн тохиолдож байгаа бөгөөд дарга эзгүй, цаг тухайд нь ажлаа хийхгүй байгаагаас, 16.3 хувь “бүрдэл дутуу анхан шатны баримтаар бараа материал, зарлага болгосон” нь няравтаа тавих хяналт муу, ажил үүргийн ялгамжгүй байдал үүссэн, 3,0 хувь нь “автомашини шатахуун зарцуулалтыг тооцдог замын хуудас бичээгүй” зөрчил байгаа нь шатахууны лимитийг сар бүр батлуулж, батлагдсан лимитийн дагуу шатахууны зарцуулалтыг спидометрийн заалттай тулган тооцохгүйгээр цэнэглэлтийг хийснээс жолооч замын хуудас түүний дагалдах хуудсыг хөтлөхгүй байна. 2,7 хувь нь “халаалтын зууханд зарцуулах нүүрс, бохир ус соруулах төлбөрт зарцуулсан нотлох баримтгүй” норм норматив байхгүйгээс, 1.9 хувь нь “урсгал засварын төсөв, гүйцэтгэл хийдэггүй, зарцуулалтын тайлангүй шууд зарлагдаж хяналтгүй хөрөнгө зарцуулдаг”, төсвийн эрх хэзээ нээгдэж, хуваарилалт яаж хийгдэх нь тодорхойгүй байдгаас болж цаг хугацаа давчуу /оны сүүлээр юмуу, тайлант хугацааны эцсээр/ байдгаас, 1.1 хувь нь “албан томилолтын тооцоог дэмжих баримтгүй олгосон, үнэт цаасны тооцоо хийхдээ анхан шатны баримтгүй шууд хассан, алба хаагчдад хоолны мөнгө тушаал, шийдвэргүй олгосон”, 0,6 хувь “цалин тушаал шийдвэргүй нэмж, хассан, тушаал шийдвэрийг хэрэгжүүлээгүй” тушаал гаргах эрх бүхий албан тушаалтан цаг хугацаандаа тушаалаа гаргаагүй ам шийдвэр хэрэгжүүлж нягтлан бодогч албандаа хайнга хандсан байдлаас, 0.3 хувь нь “харилцагчаас АШБ-гүй бэлэн мөнгө авч зарцуулсан” нь дотоод хяналтгүй байдлаас тус тус шалтгаалсан байна.

Иймд энэ зөрчил хөндлөнгийн аудит, бусад хяналтаар дахин давтан гаргахгүй байх үүднээс үүсэж болох эрсдэлийг сааруулах чиглэлийн зөвлөмж, практик хэрэглээ талаас нь ашиглах аргачлал хүргүүлэх шаардлагатай юм.

5. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Аудитын эцсийн тайлангийн дүгнэлтийг үндэслэн ажлын хариуцлагыг сайжруулах талаар дараах ажлын чиглэлийг хүргүүлэх саналтай байна. Үүнд:

- Нярав, аж ахуйн ажилтан нарт үүрэгт ажлыг хариуцуулахгүйгээр

нягтлан бодогч өөртөө хэт ачаалал үүсгэж “анхан шатны баримтгүй хийсэн” ажил гүйлгээний зардлыг хүлээн зөвшөөрч дансны бичилт хийхгүй, тооцоо үүсгэн, хариуцлага тооцож байх

- Дарга эзгүй, цаг тухайд нь ажлаа хийхгүй байгаагаас гарч байгаа зөрчилд дотоод хяналтаа сайжруулах

- Нярвын ажил гүйлгээг зориулагдсан санхүүгийн программаар хийлгэх, нягтлан бодогч нярвын эрхээр нэвтэрч ажил гүйлгээ хийж, шат шатандаа тавих хяналтгүй, ажил үүргийн ялгамжгүй байдал үүсгэхгүй байх

- Норм, нормативын дагуу журам боловсруулж, халаалтын зууханд зарцуулах нүүрс, бохир ус соруулах зэрэг үйл ажиллагаандаа мөрдөх

- Шатахууны лимитийг сар бүр батлуулж, батлагдсан лимитийн дагуу шатахууны зарцуулалтыг спидометрийн заалттай тулган тооцож, тооцоо бодсон акт үйлдэж, тооцооны үлдэгдлийг баталгаажуулсны дараа шатахууны картын цэнэглэлтийг хийж байх

- Байгууллагын зардлын ил тод байдлыг хангаж, байгууллагын дотоод ажил үйлчилгээний хэрэгцээг тодорхойлон, зардлын зүйл бүрээр өртгийг тооцож, зардлаа, эдийн засгийн үр ашигтай байдалд хуваарилан урьдчилсан байдлаар хэлэлцэж, төсвийн төслөө бэлтгэн төсвийн эрх нээгдэхэд бэлэн байхаар их ба урсгал засварын хяналтын төсөв зохиох, хөрөнгө худалдан авах харьцуулсан үнийн судалгааг хийж бэлтгэлээ хангаж байх

- Бодлогын арга хэмжээг илүү зорилтот болгохын тулд нягтлан бодогч, санхүүгийн ажилтны өдөр тутмын ажлын ачааллыг тооцож, ажлын байрны тодорхойлолтын дагуу ажил үүргийн хуваарьт нь өөрчлөлт оруулах зэрэг чиглэл, зөвлөмжийг хүргүүлэх саналтай байгааг илтгэн танилцуулья.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2018 оны 08 дугаар сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Эрүүгийн цагдаагийн албаны санхүүгийн үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Д.Батсайхан

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа С.Март, цагдаагийн хошууч Ц.Болормаа

1. ТАНИЛЦУУЛГА

Манай аудитын баг нь 2018 оны төлөвлөгөөний дагуу Эрүүгийн цагдаагийн албаны 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлээ.

Эрүүгийн цагдаагийн албаны санхүүгийн баримтад нэгдүгээр гарын үсгийг албаны дарга, цагдаагийн хурандаа [REDACTED] /2017 оны 01 дүгээр сараас 03 сар/, [REDACTED] /2017 оны 03 дугаар сараас 10 сар/, [REDACTED] /2017 оны 11 дүгээр сараас 12 сар хүртэл хугацаанд/, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч, цагдаагийн ахмад [REDACTED] нар зурж, хөрөнгө, мөнгийг захиран зарцуулжээ.

2017 онд 2.635,3 сая төгрөгийн улсын төсвийн урсгал, 8,8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, 1,2 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого оруулж төсөвт төвлөрүүлсэн байна. 2017 оны 4 улирлын төсвийн гүйцэтгэлээр 2.402,4 сая төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 58,9 сая төгрөгийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл, 31,8 сая төгрөгийн ашиглалтын зардал, 54,5 сая төгрөгийн хангамжийн материалын зардал, 9,5 сая төгрөгийн нормативт зардал, 10,3 сая төгрөгийн урсгал зардал, 11,9 сая төгрөгийн томилолтын зардлуудыг тус тус зарцуулсан байна.

2017 оны 4 улиралд тус цагдаагийн газрын үндсэн хөрөнгө нь оны эхэнд 1.740,9 сая төгрөг байсан нь 371,2 сая төгрөгөөр өсөж, 43,5 сая төгрөгөөр хасагдаж, тайлант хугацаанд 1.125,4 сая төгрөгийн хөрөнгийн элэгдэл хорогдлыг тооцсон байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

Аудитын удирдамжийн хүрээнд төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээ зэрэгт холбогдолтой хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд үнэлэлт өгч, эрсдэлийн дүн шинжилгээ хийж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, аудитын

явцад илэрсэн зөрчил дутагдлыг засаж, сайжруулах чиглэлээр дүгнэлт, зөвлөмж өгч дэмжлэг үзүүлнэ.

2.2 Аудитын ажлын цар хүрээ

Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой үндэслэл, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, төсвийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, алба хаагчдын орон тоо, нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоолт, удирдлагын гаргасан санхүүтэй холбоотой тушаал, шийдвэрийн хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, анхан шатны баримтын бүрдүүлэлт, ерөнхий журнал, ерөнхий дэвтэр хөтлөлт, татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан бэлтгэсэн байдал, төрийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хөрөнгө худалдан авах ажиллагаа, эд хөрөнгийн тооллого, тооцоо бодолт гэсэн хүрээнд 2017 оны санхүүгийн үйл ажиллагааг хамруулсан.

Албаны нууцтай холбоотой зарим үйл ажиллагааг аудитын объектод хамруулаагүй болно.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ аудит хийгдэх нэгжийн удирдлага, алба хаагчидтай хийх уулзалт ярилцлага, асуулга, тайлбар, аудитын хүрээнд шалгах мэдээлэл, түүнийг нотлох аргыг боловсруулан хэлтсийн даргаар батлуулж ашигласан.

Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагааны урсгалын схем /ажлын дэс дараалал/-ийг бэлтгэн тухайлсан аудитын төлөвлөгөө гарган, аудит хийх объектоо судалсан.

Түүнчлэн аудитын нотлох баримт цуглуулах зорилгоор 6 төрлийн түүвэр хийж, тулган баталгаажуулахад ашигласан. Аудитын явцад цугласан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан урьдчилсан тайлангийн төслийг бичиж, залруулах зөвлөмжийн хамт багийн ахлагчид санал боловсруулан танилцуулж, аудитаар илэрсэн асуудлын шийдлийг авч, урьдчилсан тайланг Эрүүгийн цагдаагийн албанд хүргүүлэн “Удирдлагын тайлбар”-ыг авч, аудитын мөрөөр өгсөн зөвлөмжийн биелэлтийг тооцож үнэлгээ, дүгнэлт өгсөн.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Мөнгөн хөрөнгө: Төсвийн хөрөнгийг эдийн засгийн ангилалын дагуу зарцуулаагүй, зарим зардлыг хяналтгүй зориулалт бусаар зарцуулсан.

Мөнгөн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, үйл ажиллагааг шалгахад дотоод

хяналт сул, хяналт тавих эрх бүхий албан тушаалтан мөнгө зарцуулах зөвшөөрөл олгохдоо төсвийн хуваарийг тулгадаггүй, мөн удирдах албан тушаалтан тогтворгүй байснаас шалтгаалж доорх алдаа, зөрчил гарсан.

Нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв, бодитой байх зарчмыг хангадаг анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг хийдэггүй [REDACTED] төгрөгийн, төсвийн хөрөнгийг эдийн засгийн ангилалын дагуу зарцуулдаггүй БҮТЭЗ-ийг бичиг хэргийн, биет бус хөрөнгийг хичээл сургалтын зардлаас тус тус гаргаж төсвийн хуваарийг зөрчин [REDACTED] төгрөгийн, мөнгөн шилжүүлэг хийхдээ дэмжих баримтын үнэн бодит байдлыг хянахгүй [REDACTED] төгрөгийн, торгуулийн орлогыг тухай бүрд нь төсвийн орлогод төвлөрүүлэхгүй харилцах дансандаа байршуулж [REDACTED] төгрөгийн, урсгал засварыг гүйцэтгэлийн хяналт тавилгүй зарцуулсан, аж ахуйн нэгж, байгууллагаас худалдан авалт хийхдээ гэрээ байгуулаагүй, хөндлөнгийн хяналтгүй, үнийн судалгаа хийгээгүй зэрэг нийт [REDACTED] төгрөгийн зөрчил илэрсэн.

Бидний зүгээс 2 төрлийн зөвлөмж хүргүүлж, алдаа, зөрчлийг залруулан арилгуулсны дүнд цаашид эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй мөнгө олгох, анхан шатны баримтын бодитой байх зарчим алдагдах, даамжирвал дотоод хяналтгүй болж ашиглал, шамшигдал үүсэх, нэг харилцах данснаас өөр харилцах дансанд /алба хаагчийн дансанд/ мөнгө хийх буюу китинг хийх, бэлтгэн нийлүүлэгчийн нэхэмжлэлийн дүнг илүү илэрхийлэх, хуурамч нэхэмжлэхэд төлбөр хийх зэрэг ашиглах, залилах үйлдэл гарах эрсдэлийг сааруулсан гэж үзэж байна.

3.2 Бараа материал: Бараа материалын ажил гүйлгээнд бүртгэлээр тавих хяналтгүй байдал үүссэн.

Аж ахуйн ажилтан худалдан авалт хийсэн материалаа няравтаа хүлээлгэж өгдөггүй, зарцуулсан материалаа тухай бүрд тайлагнадаггүй, нягтлан бодогч нь нярвынхаа тайланг бодитойгоор шалгаж, данс бүртгэлд тусгаагүй, нярав тайлангаа өөрөө гаргадаггүй, санхүүгийн программаа ашиглаж чаддаггүй зэрэг байдлаас шалтгаалж нярвын тайлангаар гүйцэтгэл, зарцуулалтыг хянаагүйгээр [REDACTED] төгрөгийн материалыг данснаас хассан, бодитойгоор байхгүй засварын зориулалтаар зарцуулагдсан [REDACTED] төгрөгийн материалыг дансанд үлдэгдэлээр бүртгэсэн, [REDACTED] төгрөгийн 6 нэр төрлийн бичиг хэргийн материал, 59 нэр төрлийн аж ахуйн материалыг агуулахын бүртгэлд хөтлөөгүй, Номин тав трейд ХХК-аас 7.522.162 төгрөгийн худалдан авалт хийсэн ажил гүйлгээнээс төсвийн мөнгөөр хийсэн худалдан авалтад хувийн урамшуулалын карт ашиглан үнийн дүнгийн 6%-ийн хөнгөлөлт буюу 78.693 төгрөгийн бонус эдэлсэн зэрэг нийт [REDACTED] төгрөгийн зөрчил илэрсэн.

Бидний зүгээс 2 төрлийн зөвлөмж хүргүүлснээр [REDACTED] төгрөгийн алдаа, зөрчлийг залруулан арилгуулсан. Цаашид материалын

зарцуулалтыг бүрэн хянаж амжихгүй, нярав тайлангаа өөрөө гаргахгүй, санхүүгийн программаа ашиглаж чадахгүй, цаг хугацаандаа бүртгэл хийгдэхгүй, бүртгэлээр тавих хяналтгүй байдгаас шалтгаалан анхан шатны баримтыг үндэслэдэггүй, гүйцэтгэл тооцдог нь ашиглал үүсэх эрсдэлтэй.

3.3 Алба хаагчдийн дотоод томилолтыг буруу тооцож олгосон.

Нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв, бодитой байх зарчмыг хангадаг анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг хийдэггүй. дарга, нягтлан бодогч нар шат, шатандаа тавих хяналт сул, цаг үед нь хянахгүй байгаагаас шалтгаалж дотоод томилолтын мөнгийг олгохдоо 15 алба хаагчид томилолтоор ажилласан талаар ирсэн буцсан хоног бичигдээгүй, ажлын гүйцэтгэл тодорхойлоогүй, баримт хуурамчаар бүрдүүлсэн, байрны баримт байхгүй байхад мөнгө олгосон зэрэг 3.006.500 төгрөгийн зөрчил илэрсэн.

Бидний зүгээс 2 төрлийн зөвлөмж хүргүүлж зөрчлийг залруулан арилгуулсан. Цаашид анхан шатны баримтгүй зардалд бичиж байгаа нь олгосон мөнгө эзэндээ очихгүй байх, дотоод хяналтгүй болж ашиглал, шамшигдал үүсэх эрсдэл гарч болзошгүй.

3.4 Данс бүртгэл: Мөнгө шилжүүлэн худалдан авсан хөрөнгө, материалыг орлогод авахгүй дансны бичилт ашиглан шууд зардалд бичиж данснаас хассан.

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт болон хөрөнгийн зарцуулалт, хадгалалт, хамгаалалт, санхүүгийн үйл ажиллагаа бүртгэлийн ажилтны чадвар, мэргэжлийн шийдлийн хүрээнд явагдаж төсвийн хөрөнгөөр урсгал засвар, шууд олголт хийдэг бараа материалын нийлүүлэлт хийхдээ хяналтгүй, зарцуулалт, гүйцэтгэлийн тайлангүй шууд зардлын дансанд бичсэн. Харилцагчийн нэр сольж өглөг, авлагын тооцоог тохируулан хааснаас 429.900 төгрөгийн, тохируулан бичилт данснаас шууд зардалд 4.430.000 төгрөгийн, цалингийн тооцооны журналын бичилт нь зохих журмын дагуу хийгдээгүй шууд тохируулах бичилтээр тааруулсан 155.000 төгрөгийн зөрчлүүд илэрсэн. Бидний зүгээс 1 төрлийн зөвлөмж хүргүүлж зөрчлийг залруулан арилгуулсан.

Бүртгэлийн хяналт сул байдгаас албан тушаалтан дансны бичилт ашиглан мөнгө, хөрөнгө завших, балансын хөрөнгийн эх үүсвэрийн дүнгүүд буруу илэрхийлэгдэж санхүүгийн тайлангаар хэрэглэгчдэд буруу мэдээлэл хүрэх, төсвийн мэдээ, тайлан буруу гарах, хяналтгүй хөрөнгө данснаас хасагдах, хөрөнгө хариуцан бэлтгэдэг алба хаагчид бүртгэлээр тавих хяналтгүй байдлыг ашиглаж шамшигдал үүсэх эрсдэлтэй. Цаашид үүсч болох эрсдэлийг сааруулах чиглэлийн аргачилсан зөвлөмж өгч ажилласан.

3.5 Туслах аж ахуйн бүртгэл: “Туслах аж ахуй эрхлэх” /Код 813/ журам”-ыг үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, бүрдэл хангаагүй анхан шатны баримтаар зарцуулалт хийсэн.

Тус албаны даргын тушаалаар ахмад настанд 3, Тусгай ажиллагааны газарт 11 хонь өгсөн боловч анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаагүй, олгосон алба хаагчаар гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэг “Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно” заалтуудыг үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, өнгөрсөн онд улсын төсвөөс [REDACTED] төгрөгийг малчны цалин, урамшилд олгожээ.

3.6 Нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоолт: Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1.4, 1.5 дахь заалт, тус албаны даргын тушаалыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Эрүүгийн цагдаагийн албаны алба хаагчдын нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоолтыг үзэхэд нийт [REDACTED] төгрөгийн алдаа, [REDACTED] төгрөгийн зөрчил илэрсэн.

Тус албаны даргын 2017.07.19-ны өдрийн Б/52 тушаалаар үйлчлэгч [REDACTED] г олгох 30 хувийн нэмэгдэл [REDACTED] төгрөгийг олгоогүй, мөн даргын 2017.05.29-ний өдрийн Б/41 дүгээр тушаалаар цагдаагийн ахмад Д.Нямрагчаад албан тушаалын цалинг 3 сар 20 хувь хасач сахилгын шийтгэл ногдуулснаас 6 дугаар сарын цалингаас 20 хувь хасч, 7 дугаар сарын цалингаас 40 хувь суутгах байсныг нэмж олгосон тул 2 сарын сахилгын шийтгэлийн 470.290 төгрөгийг буцаан суутгахаар зөрчил болголоо.

Алба хаагчдын цалин, амралтын тооцооллыг үзэхэд нийт 25 алба хаагчид давхар олгосон [REDACTED] төгрөгийг буцаан суутгахаар зөрчил болгов.

Эрүүгийн цагдаагийн албаны даргын 2017 оны жилийн эцсийн ажлын үр дүнгээр урамшуулал олгосон тушаалд даргын гарын үсэг зуруулж, тамга, тэмдгээр баталгаажуулаагүй, тухайн албаны тасаг, албадаас жилийн эцсийн ажлын үр дүнгээр цалингийн 25 хувийн нэмэгдэл олгохоор санал ирүүлсэн байхад нийт 88 алба хаагчид 30 хувиар нэмэгдүүлэн [REDACTED] төгрөгийг илүү тооцож олгосон байна.

“Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1.4 төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах буюу царцаах, цалин хөлсийг цаашид нэмэгдүүлэх асуудлыг 2019 оноос төсвийн боломжтой уялдуулан шийдвэрлэх, 1.5 төрийн алба хаагчдын албан тушаалын зэрэглэл,

цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоож, энэ талаар шийдвэр гаргахгүй байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасан заалтыг зөрчиж, 33 алба хаагчийн цалингийн шатлал, зэрэглэлийг ахиулж, ██████████ төгрөгөөр цалинг нэмэгдүүлэн олгосон бөгөөд цалин нэмэгдүүлсэн олгосонтой холбоотойгоор нийгмийн даатгалын шимтгэл болон хүн амын орлогын албан татварт ██████████ төгрөгийн зардал гарсан байна.

3.7 Үндсэн хөрөнгийн бүртгэл: Хөрөнгийг дансанд бүртгэхгүйгээр шууд зардалд бичсэн, бараа материалын дансанд бүртгэх хөрөнгийг үндсэн хөрөнгөөр бүртгэсэн байна.

Мэдүүлэг, байцаалт авах 4 өрөөг засварлахад зарцуулсан 18.785.948 төгрөгийн засварын зардлыг барилгын хувийн хэрэгт тэмдэглээгүй, тусгай хэрэгсэл дансанд бүртгэх 313.562 төгрөгийн хийн ба резинэн сумаар бууддаг бууг бусад үндсэн хөрөнгийн дансанд, аж ахуйн материалын дансанд бүртгэх 575.000 төгрөгийн цахилгааны утсыг бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн, Санхүүгийн тооцоолох компаниас авсан 275.000 төгрөгийн няравын програмыг биет бус хөрөнгийн дансанд орлого авахгүйгээр шууд зардалд бичсэн байна.

Албаны хэрэгцээнд ашиглах хөрөнгийг тухайн байгууллагын урсгал төсвөөс бус харъяа дээд байгууллага болон бусад албад, газар, хэлтсээс шилжүүлж авдагас тайлан хугацааны эцэст хөрөнгийн хөдөлгөөн ихээр хийгдэж байна. Үндсэн хөрөнгийн 99 хувийг гадны эх үүсвэрээр бэлтгэсэн, хөрөнгө орлого авах шийдвэрийн 86 хувь, хөрөнгийн зарлагын 44 хувийг оны сүүлийн сард гаргасан байна.

3.8 Мэдээллийн ил тод байдлын талаар: Санхүүгийн дотоод аудит хийгдэх үед зарим мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байсан бөгөөд эргэн хянах аудитаар шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг үзэхэд эд хөрөнгийн эхний хагас жилийн тооллого хийх тушаал шийдвэрийг байршуулаагүй, эхний 5 сарын санхүүжилтийн хэмжээг мэдээлсэн боловч 6 дугаар сарын санхүүжилтийг мэдээлээгүй, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт хэсэгт байр ашиглалттай холбоотой 29.8 мянган төгрөгийн зардлыг мэдээлээгүй. 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын дүгнэлтийг өмнөх оны цахим хуудсанд нөхөн байшуулаагүй, бусад мэдээллийг байршуулсан байна.

4. ДҮГНЭЛТ

Эрүүгийн цагдаагийн албаны удирдлага нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн холбогдох эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйгээс урьдчилсан дүгнэлтээр ██████████ мянган төгрөгийн алдаа, ██████████ мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Манай аудитын багийн зүгээс дотоод аудит хийх явцад илэрсэн алдаа зөрчилтэй 8 асуудалд нотлох баримтыг үндэслэн одоогийн илэрсэн эрсдэлийг тодорхойлж түүнийг бууруулах, засаж залруулах үйл ажиллагаанд чиглэсэн дотоод зохион байгуулалт, ажлын хариуцлагаа сайжруулах 17 төрлийн зөвлөмжийг 2 сарын хугацаатай хүргүүлсэн.

Эрүүгийн цагдаагийн албаны удирдлагын зүгээс илэрсэн алдаа, зөрчилтэй асуудалд санал нийлсэн тайлбараа өгөн, зөвлөмжийн мөрөөр үр нөлөөтэй хариу арга хэмжээ авч, ажил зохион байгуулах төлөвлөгөө боловсруулж, аудитын багт [REDACTED] мянган төгрөгийн алдаа, [REDACTED] мянган төгрөгийн зөрчлийг залруулсан.

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн аудитын багийн зүгээс эргэн хянах аудитыг хийж, нийт илэрсэн алдаа, зөрчлийн [REDACTED] мянган төгрөг буюу 96.7 хувь нь залруулагдсан тул аудитын багийн ажлын үр дүнгээр материаллаг нөлөөлөлгүй гэж үзэн “1 буюу хангалттай” гэж үнэллээ.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2017 оны 11 дүгээр сард Цагдаагийн ерөнхий газарт хийсэн хяналт шинжилгээ, дотоод аудитын тайланд ч эдгээр зөрчил дутагдал илэрсэн талаар дурьдагдсан байгаа нь ашиглан хийх эрсдэл байгааг харуулж байна.

5. ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, эцсийн тайлангийн дүгнэлтийг үндэслэн Эрүүгийн цагдаагийн албаны удирдлага, санхүүгийн алба хаагч нарт цаашид үүсэж болзошгүй эрсдэлийг сааруулах чиглэлээр аудитын багаас дотоод зохион байгуулалт, ажлын хариуцлага, хяналтаа сайжруулах үйл ажиллагаанд чиглэсэн дараах зөвлөмжийг холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх саналтай. Үүнд:

- Дотоод аудитын багаас өмнө нь хүрүүлсэн ажлын баримт “Аудитаар илэрсэн асуудлын бүртгэл”-маягт /Ажлын баримт 2003b/ЦЕГ-ХШҮДАХ/2018/06/СА-1/-ын дагуу өгсөн 8 төрлийн зөвлөмжийг цаашдын үйл ажиллагаандаа нэг мөр болгон хэрэгжүүлж ажиллах, удирдлагаас алдаа, зөрчил давтан гаргахгүй байх талаар эрсдэлийн төлөвлөгөөндөө тусгаж, үнэлгээ өгдөг болох;

- Бараа материал худалдан авахад зах зээлийн үнийн харьцуулсан судалгаа хийх, зарлагын болон дагалдах баримтын бүрдэл хэсгийг нягтлаж байх, хүчингүй баримт байвал тооцоо үүсгэн өглөг, авлагын бүртгэлээр эргэн хянах, ашиглалтад байгаа бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийг ашиглалтын хугацаа дуустал эзэмшигчийн эд хөрөнгө ашиглалтын картанд бүртгэх;

- Хөрөнгийн хяналтын тооллого хийж, илүүдэж, дутагдсан эд хөрөнгийг журмын дагуу шийдвэрлэж, актлах хөрөнгийг зохих журмын дагуу устгах ажлыг тухай бүр шийдвэрлэх.

6. УДИРДЛАГЫН ТАЙЛБАР

Эрүүгийн цагдаагийн албаны удирдлагын зүгээс илэрсэн алдаа, зөрчилтэй асуудалд санал нийлсэн тайлбараа өгч, зөвлөмжийн мөрөөр үр нөлөөтэй хариу арга хэмжээ авч, 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 10/3737 дугаар албан бичгээр [REDACTED] мянган төгрөгийн алдаа, [REDACTED] мянган төгрөгийн зөрчлийг залруулсан тухай баримт материал, “Удирдлагын тайлбар”-ыг ирүүлсэн.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Увс аймаг дахь цагдаагийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудитын төрөл: Санхүүгийн аудит

Аудитын хугацаа: 2018.10.24-2019.01.28

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Д.Батсайхан

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа С.Март, цагдаагийн хошууч Ц.Болормаа

1. ТАНИЛЦУУЛГА

Манай аудитын баг нь “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2018 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний дагуу Увс аймаг дахь цагдаагийн газрын 2017, 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийлээ.

Увс аймаг дахь цагдаагийн газрын санхүүгийн баримтад нэгдүгээр гарын үсгийг тус цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Ч.Лхагвадорж, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч, цагдаагийн ахмад Б.Дуламсүрэн нар зурж, хөрөнгө, мөнгийг захиран зарцуулжээ.

2017 онд 2.061,6 сая төгрөгийн улсын төсвийн урсгал, 47,1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 47,6 сая, туслах үйл ажиллагаанаас 17,8 сая төгрөгийн орлого оруулж, төсөвт төвлөрүүлсэн байна. 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлээр 1.750,1 сая төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 37,2 сая төгрөгийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл, 96,0 сая төгрөгийн ашиглалтын зардал, 111,9 сая төгрөгийн хангамжийн материалын зардал, 17,2 сая төгрөгийн нормативт зардал, 41,2 сая төгрөгийн эд хогшил, урсгал зардал, 39,9 сая төгрөгийн томилолтын зардал, 3,8 сая төгрөгийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 43,5 сая төгрөг, улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэгт 9,3 сая төгрөг, бараа, үйлчилгээний бусад зардалд 3,9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тус цагдаагийн газрын үндсэн хөрөнгө нь 2017 оны эхэнд 3.726,7 сая төгрөг байсан нь 53,9 сая төгрөгөөр нэмэгдэж, 82,8 сая төгрөгөөр хасагдан, тайлант хугацаанд 205,7 сая төгрөгийн хөрөнгийн элэгдэл хорогдлыг тооцсон байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2018 оны дотоод аудитын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу удирдамжаар заасан цар хүрээнд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, аудитын явцад илэрсэн зөрчил дутагдал болон тулгарч буй асуудлыг засаж, сайжруулах чиглэлээр дүгнэлт, зөвлөмж өгч, дэмжлэг үзүүлэх зорилготой.

2.2 Аудитын ажлын цар хүрээ

Байгууллагын үйл ажиллагаатай, холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийн байдалтай танилцах, санхүүтэй холбоотой үйл ажиллагаа болон төлөвлөгөөний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, төсвийн хэрэгжилт түүний дотор байгууллагын төсөв хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, төсвийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, алба хаагчдын орон тоо, нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоолт, нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, анхан шатны баримтын бүрдүүлэлт, ерөнхий журнал, ерөнхий дэвтэр хөтлөлт, татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан бэлтгэсэн байдал, төрийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хөрөнгө худалдан авах ажиллагаа, эд хөрөнгийн тооллого, тооцоо бодолт, цагдаагийн байгууллага болон бусад мэргэжлийн байгууллагаас хийсэн шалгалтын акт, зөвлөмжийн биелэлт зэрэгтэй холбоотой мэдээллийг хамруулан, 2017, 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд түүвэр хийн, аудитын объектод хамруулан ажиллалаа.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ аудит хийгдэх нэгжийн удирдлага, алба хаагчидтай хийх уулзалт ярилцлага, асуулга, тайлбар, аудитын хүрээнд шалгах мэдээлэл, түүнийг нотлох аргыг боловсруулан ашигласан.

Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагааны урсгалын схем /ажлын дэс дараалал/-ийг бэлтгэн, тухайлсан аудитын төлөвлөгөө гарган, аудит хийх объектоо судалсан.

Түүнчлэн аудитын нотлох баримт цуглуулах зорилгоор түүвэр хийж, тулган баталгаажуулахад ашигласан. Аудитын явцад цугласан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан аудитаар илэрсэн асуудлын шийдлийг авч, “Удирдлагын тайлбар”-ыг авч, аудитын мөрөөр өгсөн зөвлөмжийн биелэлтийг тооцож үнэлгээ, дүгнэлт өгсөн.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Мөнгөн хөрөнгө: Нягтлан бодох бүртгэлийн жинхэнэ хэрэгжилтийн зарчим болон мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой эрх зүйн актуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйгээс алдаа гарсан байна.

Тус цагдаагийн газрын мөнгөн хөрөнгийн 2017 оны 6-12 сар, 2018 оны эхний хагас жилийн аж ахуй, бичиг хэрэг, урсгал засварын материалын бүртгэлийг үзэхэд бичиг хэргийн материал худалдан авах төсөв хүрэлцдэггүйн улмаас зээлээр борлуулалт хийдэг байгууллагаас [REDACTED] төгрөгийн материалыг үнийн судалгаа хийхгүйгээр худалдаж авчээ.

Увс аймгийн Тэс, Өлгий, сумын өмнөх оны газрын төлбөр, Сагил, Өмнөговь, Өлгий сумын цагдаагийн хэсгийн халаалтын төлбөр [REDACTED] төгрөг, 2018 оны эхний хагас жилийн газрын төлбөр [REDACTED] төгрөг, нийт [REDACTED] төгрөгийн зардлыг төсөвт тусгаагүй, тус аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс үнэ тариф тогтоосон шийдвэр гараагүй шалтгаанаар хугацаанд нь төлөөгүй, тайлан тэнцэлд өглөгөөр тусгаагүй зөрчил илэрсэн. Аудитын багаас 3 төрлийн зөвлөмж хүргүүлж, алдаа, зөрчлийг зарилгуулсан.

3.2 Нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоолт: Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1.4, 1.5 дахь заалт, тус газрын даргын нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоохтой холбоотой гаргасан тушаалын хэрэгжилтийг бүрэн хангаагүй байна.

Увс аймаг дахь цагдаагийн газрын алба хаагчдын нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоолтыг үзэхэд нийт [REDACTED] төгрөгийн алдаа, [REDACTED] төгрөгийн зөрчил илэрсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн “Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэл батлах тухай” А/135 дугаар тушаалаар тус албанд офицер 76, ахлагч 78, энгийн 3, гэрээт ахлагч 4, нийт 161 орон тоотой ажиллахаар бүтэц, орон тоо батлагджээ.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн “Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад Шуурхай удирдлагын тасаг байгуулан, албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэл батлах тухай” А/212 дугаар тушаалыг үндэслэн офицер 7, ахлагч 6 нийт 13 орон тоог бусад тасгаас шилжүүлэн тус цагдаагийн газрын шуурхай удирдлагын тасгийг шинээр байгуулсан байна.

Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1.4 төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах буюу царцаах, цалин хөлсийг цаашид нэмэгдүүлэх асуудлыг 2019 оноос

төсвийн боломжтой уялдуулан шийдвэрлэх, 1.5 төрийн алба хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоож, энэ талаар шийдвэр гаргахгүй байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасан заалтыг зөрчиж, 19 алба хаагчийн цалингийн шатлал, зэрэглэлийг ахиулж, [REDACTED] төгрөгөөр цалинг нэмэгдүүлэн олгосон зөрчил гаргасан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын “Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг тогтоосон хугацаанд хэрэгжүүлсэн, тайлант хугацаанд бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт ороогүй, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий /ахлах/ нягтлан бодогч тогтвор суурьшилтай ажилласан, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт сайн зэрэг нь Монгол Улсын ерөнхий аудиторовын 2015 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэхэд баримтлах журам”-ын шаардлагыг хангаж байгаа тул Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-т заасны дагуу Увс аймаг дахь цагдаагийн газрын 2017 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлж байна” гэсэн “Итгэмжлэл” авсан тул цалингийн шатлал, зэрэглэлийг ахиулсан зөрчил бүртгэгдээгүй байна.

Увс аймаг дахь цагдаагийн газрын даргын ажлын үр дүнгээр цалин нэмэх болон хасах тушаалыг бүрэн хэрэгжүүлээгүй, удаан жилийн нэмэгдлийг бүрэн олгоогүй зөрчил илэрсэн бөгөөд залруулах боломжтой [REDACTED] төгрөгийн зөрчлийг 2018 оны 11 сард бүрэн арилгасан, залруулагдах боломжгүй [REDACTED] төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

3.3 Үндсэн хөрөнгийн бүртгэл: Увс аймаг дахь цагдаагийн газрын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй конторын барилга, 2 орон сууц, аймгийн төвд байрлах 8 төрлийн барилга, сумдын 20 цагдаагийн хэсгийн байрны бүртгэлийг үзэхэд албан конторын барилгын халаалтын шугам болон хаалга, цонх, дээврийг засварлах, цахилгааны холболтыг шинэчлэх талаар 2015, 2018 онуудад Онцгой байдлын ерөнхий газрын болон Гамшгаас хамгаалах улсын байцаагчийн дүгнэлт гарсан, аж ахуйн аргаар баригдсан Улаангом сумын цагдаагийн хэсгийн нэг барилгыг албаны хэрэгцээнд ашиглах боломжгүй байна. Сумдын цагдаагийн хэсгийн байрнаас Тэс сумын цагдаагийн хэсгийн байрныг актлах саналыг холбогдох байгууллагад хүргүүлсэн, Бөхмөрөн сумын цагдаагийн хэсгийн байрны чанарын талаар 2014, 2017 онд Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлт гарсан, Өмнөговь сумын цагдаагийн хэсгийн байр нь барилгын зураггүй байна.

Тус цагдаагийн газрын эзэмшил, ашиглалтад байгаа аймгийн төвийн 4, сумдын цагдаагийн хэсгийн 19, нийт 23 газрын талбайн хэмжээг нэг бүрчлэн баталгаажуулсан, кадастрын зураг дахь нэгж талбарын

дугаартай, газар эзэмших/ашиглах гэрээ байгуулсан, улсын бүртгэлийн гэрчилгээ авч, баталгаажуулсан байна.

Үндсэн хөрөнгөтэй холбоотой 2 төрлийн зөвлөмж хүргүүлж, алдаа зөрчлийг залруулан арилгуулсны үр дүнд дотод хяналт сулрах эрсдлийг бууруулсан гэж үзэж байна.

3.4 Үнэт цаасны төлбөр тооцоо: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/247 дугаар тушаалаар баталсан “Шийтгэлийн хуудас болон тооцоот маягтаар хангах, хадгалах, олгох, зарцуулах, тооцох, бүртгэх журам”-ыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйгээс [REDACTED] төгрөгийн алдаа, зөрчил гаргасан байна.

Цагдаагийн байгууллагын санд шивсэн мэдээллийг санхүүтэй тооцоо хийсэн шийтгэлийн хуудасны баримттай тулгаж үзэхэд 2017 оны сүүлийн хагас жилд [REDACTED] төгрөгийн, 2018 оны эхний хагас жилд [REDACTED] төгрөгийн орлогыг мэдээллийн санд дутуу шивсэн, [REDACTED] төгрөгийн орлогыг давхар шивсэн, [REDACTED] төгрөгийн шийтгэлийн хуудасны дугаарыг “0” гэж шивсэн, 10.000 төгрөгийг торгуулийн орлогын дансанд дутуу төвлөрүүлсэн байна.

2018 оны эхний хагас жилд 1 шийтгэлийн хуудас хүчингүй болгож, шүүхийн тогтоол, тогтоол гүйцэтгэгчийн мэдэгдлээр 6 шийтгэлийн хуудсыг зарлага болгосон байна. Шийтгэлийн хуудсаар торгох шийтгэл оногдуулсан [REDACTED] төгрөгийг хүү, торгуулийн дансанд төвлөрүүлээгүй байна.

Шийтгэлийн хуудасны төлбөр тооцоотой холбоотой илэрсэн [REDACTED] төгрөгийн зөрчил болон цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн зөрүүг залруулах 3 төрлийн зөвлөмж хүргүүлж, зөрчлийг бүрэн арилгуулсан.

3.5 Мэдээллийн ил тод байдлын талаар: Увс аймаг дахь цагдаагийн газар нь 2018 оны эхний 10 сарын байдлаар шилэн дансны нэгдсэн цахим хуудасны Төсөв гүйцэтгэл, Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, Бусад дэд цэсэнд нийт 121 мэдээлэл байршуулахаас Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд 111, хугацаа хоцорч 11 мэдээлэл байршуулсан байна. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаар анхаарч ажиллах 3 төрлийн зөвлөмж хүргүүллээ.

3.6 Данс бүртгэл: Санхүүгийн тайлангийн бараа материал хэсэг үнэн зөв илэрхийлэгдээгүй, материалын зарлага бодитой бус байна.

Алба хаагч албандаа хайнга хандсан, тайлангаа нэгтгүүлэхэд өглөгтэй тайлан баланс авахгүй гэж засуулдагаас санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдсэн. Ашиглаж байгаа материалыг хасах, эсвэл байхгүй байхад нь бүртгэж байгаа нь санхүүгийн тайлан үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэн гардаг байх үндсэн зарчмыг

алдагдуулж, няравын үлдэгдэлд нөлөөлж байна. 2018 оны эхний хагас жилийн балансын бараа материалын үлдэгдэл 166.229.578,30 төгрөг байхад бараа материалын үлдэгдлийн журналын дансны бичилтээр 165.743.678,30 төгрөгөөр бүртгэсэн байгаа нь дансны бодит үлдэгдлээс 485.900 төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн нь түлш шатах тослох материалын дансны үлдэгдэл 295.900 төгрөгөөр, сэлбэг хэрэгслийн дансны үлдэгдэл 190.000 төгрөгөөр зөрүүтэй байна.

Нярав [REDACTED] цаг тухайд нь ажлаа хийдэггүйгээс аж ахуйн материалын зарцуулалтын байдлыг шалгахад 7 нэр төрлийн засварт хэрэглэсэн материалын зарцуулалтыг тооцохгүй [REDACTED] төгрөгийн биетээр байхгүй материалыг дансанд үлдэгдлээр бүртгэсэн. Худалдан авсан ашиглалтад байгаа материалыг ашиглаж байгаа эзэнд нь хариуцуулаагүй шууд зардалд бичиж, үлдэгдлээр байх ёстой 3 нэр төрлийн [REDACTED] төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийг аж ахуйн материалын данснаас хассан зэрэг нийт [REDACTED] төгрөгийн зөрчил илэрсэн.

Балансаарх эргэлтийн хөрөнгийн дүнгүүд буруу илэрхийлэгдэж, бүртгэлийн хяналт сул байдгаас албан тушаалтан дансны бичилт ашиглан мөнгө, хөрөнгө завших, санхүүгийн тайлангаар хэрэглэгчдэд буруу мэдээлэл хүрэх, төсвийн мэдээ, тайлан буруу гарах, хяналтгүй хөрөнгө данснаас хасагдах, ашиглан шамшигдал үүсэх эрсдэлтэй. Цаашид үүсч болох эрсдэлийг сааруулах чиглэлийн аргачилсан 1 төрлийн зөвлөмж өгч ажилласан.

3.7 Авто машины ашиглалт: Авто машины ашиглалтыг норм, нормативээр тооцоогүй, бүртгэлээр тавих хяналт сул байсан.

Автомашинь замын хуудас, хэрэглэгчийн дагалдах, автомашинь хувийн хэргийг хөтлөхдөө анхан шатны баримтын хэмжээнд бодитой, үнэн зөв хөтөлдөггүй, нөхөн бүрдүүлдгээс ашиглалтын бүртгэлээр тавих хяналт сул байна. Нэгжийн саналыг үндэслэн төсөвт тусгахгүй, дараа оны төсвийг батлахдаа үнэ ханшийн өсөлт зэргийг харгалзалгүй өмнөх оныхоо төсөвтэй адилхан баталдгаас төсвийн хүрэлцээгүй байдал үүсч улирлын эцэст өглөгтэй баланс гардаг, ЦЕГ-т балансаа нэгтгүүлэхэд “өглөгтэй тайлан авахгүй” гэсэн шаардлага тавьж засуулдгаас няравын тайлан бодит үлдэгдлээс зөрүүтэй илэрхийлэгдэж байна. ЗЦА-нд ашиглаж байсан хуучин 2 автомашиныг балансаас балансад шилжүүлэн авч хөдөлгөөнт эргүүлд ашиглаж байгаа нь эдэлгээний хугацаа дуусаж, ашиглалтын шаардлага хангахгүй болсон тул эдгээр машины шатахуун, сэлбэгийн норм хэтрэхэд нөлөөлсөн байна.

Шатахуун, шатах тослох материал олгохдоо норм нормативээр тооцохгүй, бүртгэлээр тавих хяналт сул байгаагаас аудитаар түүвэрлэн шалгасан хэсэгт хамаарах 14 жолоочийн тооцоог бодоход [REDACTED] төгрөгийн шатахууны бодит бус хэмнэлт гарсан, автомашинь хувийн хэрэгт сэлбэг, шатахуун тос материал олгосон талаар бүртгээгүй, өмнөх

оны 9 дүгээр сард олгосон шатах, тослох материалыг 2018 оны 1 дүгээр сард хассан зэрэг [REDACTED] төгрөгийн, норм нормчлоого хэрхэн тооцдог нь тодорхойгүй, техникийн комисс хэлбэрийн төдий ажилласан [REDACTED] төгрөгийн, нягтлан бодогч тайланг шалгаж авахдаа жолоочийн шатахууны үлдэгдлийг нярваас хасч, нярвын тайланг [REDACTED] төгрөгөөр зөрүүлсэн, нягтлан бодогч [REDACTED] хянаагүй гарын үсэг зурснаас шатахуун олгох зөвшөөрлийн хуудсаар авсан шатахуун нь шаардах хуудас болон нярвын зарлага болгосон шатахуунтай зөрсөн, нярвын тайлангаар зарлагадсан шатахууныг нягтлан бодогч хасч дутуу зарлагадсан, нярвын тайлангаар шатахуун олгосон жагсаалт нь тухай бүрдээ хийгдэхгүй нөхөж хийгддэг, колонкоос зөвшөөрөл хяналтгүй шатахуун олгосон байхад зарцуулалтыг хүлээн зөвшөөрдөг зэрэг [REDACTED] төгрөгийн зөрчлүүд илэрсэн.

Автомашин гүйлтийг өсгөхийн тулд ланд 200 маркын /01-02 дугаарын/ машины спидометрийн заалтыг [REDACTED] км-ээр илүү бичсэн, аксент маркын /65-42 дугаарын/ машины спидометрийн заалт 225399 км байсныг засварлаж [REDACTED] км болгож зассан байна. 7 сард мөнгөн гүйлгээний журналаар шатахуунд [REDACTED] төгрөг гарсан байхад бараа материалын орлого авсан дансны бичилтээр [REDACTED] төгрөг орлогодож [REDACTED] төгрөгийн тооцоо зөрсөн. Нийт [REDACTED] төгрөгийн зөрчил илэрсэн.

Дээрх зөрчил нь жолооч болон хэрэглэгчид шатахуун, сэлбэгийг завших, автомашины ашиглалтын талаас хайнга хандах, автомашиныг хугацаанаас нь өмнө /хойно/ ашиглалтаас гаргах зэрэг хөрөнгө эзэнгүйдэх, нярвын тайлангаар зарлагадсан шатахууныг нягтлан бодогч өөрчилдөг, шатахуун олгосон жагсаалт нь тухай бүрдээ хийгдэхгүй нөхөж хийгддэг, колонкоос зөвшөөрөл хяналтгүй шатахуун олгож байгаа нь ашиглал гаргах эрсдэлтэй байна.

Иймд тээврийн хэрэгслийн ашиглалт, засвар үйлчилгээ, хяналт эдэлгээнд байсан автомашин орлогод авах журам, зааврын дагуу жолоочийн авсан шатахууны тооцоог бодож акт үйлдэж байх, шатахууны тооцооны үлдэгдэл хэвийн хэмжээнээс их үүссэн тохиолдолд техникийн комиссын дүгнэлтийг үндэслэн төлбөр болгох, автомашины хувийн хэргийг үнэн, зөв цаг хугацаанд нь хөтөлж, авто машинд хийх засвар, үйлчилгээ, сэлбэг олголт хийхдээ техникийн комиссын актыг 2 хувь үйлдэн санхүүгийн баримт, автомашины хувийн хэрэгт хавсаргаж байх, техникт үзлэг шалгалт хийж спидиометр, тоноглол, бүрэн бүтэн байдлыг шалгаж сонор сэрэмжтэй ажиллах талаар анхааруулга өгөх зэрэг аргачилсан 5 төрлийн зөвлөмжийг өгсөн.

4. ДҮГНЭЛТ

Увс аймаг дахь цагдаагийн газрын удирдлага нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актуудыг үйл

ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйгээс урьдчилсан дүгнэлтээр [REDACTED] мянган төгрөгийн алдаа, [REDACTED] мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Манай аудитын багийн зүгээс дотоод аудит хийх явцад илэрсэн алдаа зөрчилтэй 9 асуудалд нотлох баримтыг үндэслэн одоогийн илэрсэн эрсдэлийг тодорхойлж, түүнийг бууруулах, засаж залруулах үйл ажиллагаанд чиглэсэн дотоод зохион байгуулалт, ажлын хариуцлагаа сайжруулах 24 төрлийн зөвлөмжийг хүргүүлсэн.

Увс аймаг дахь цагдаагийн газрын удирдлагын зүгээс илэрсэн алдаа, зөрчилтэй асуудалд санал нийлсэн тайлбараа өгөн, зөвлөмжийн мөрөөр үр нөлөөтэй хариу арга хэмжээ авч, тодорхой ажил зохион байгуулж, [REDACTED] мянган төгрөгийн алдаа, [REDACTED] мянган төгрөгийн зөрчлийг залруулсан.

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн аудитын багийн зүгээс зөвлөмж өгснөөр, нийт илэрсэн алдаа, зөрчлийн [REDACTED] мянган төгрөг буюу 78,6 хувь нь залруулагдсан, [REDACTED] мянган төгрөг буюу 21,4 хувь нь залруулах боломжгүй зөрчил байгаа тул зарим хяналттай холбоотой асуудал байна гэж үзэн “2 буюу сайжруулалт хэрэгтэй” гэж үнэллээ.

5. ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, эцсийн тайлангийн дүгнэлтийг үндэслэн Увс аймаг дахь цагдаагийн газрын удирдлага, санхүүгийн алба хаагч нарт цаашид үүсэж болзошгүй эрсдэлийг сааруулах чиглэлээр аудитын багаас дотоод зохион байгуулалт, ажлын хариуцлага, хяналтаа сайжруулах үйл ажиллагаанд чиглэсэн дараах зөвлөмжийг холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх саналтай. Үүнд:

- Дотоод аудитын багаас хүргүүлсэн ажлын баримт “Аудитаар илэрсэн асуудлын бүртгэл”-маягтын дагуу өгсөн 24 төрлийн зөвлөмжийг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах
- Удирдлагаас алдаа, зөрчил давтан гаргахгүй байх талаар эрсдэлийн төлөвлөгөөндөө тусгаж, үнэлгээ өгдөг болох
- Сүүлийн 2 жилд төсвийн төлөвлөлтийг нэгжийн саналыг үндэслэн хийгээгүйгээс Увс аймаг дахь цагдаагийн газарт тавилга эд хогшил, техник хэрэгсэл авах зардал төсөвлөгдөөгүйн улмаас хурлын танхимд рапорт хийхэд 20-30 алба хаагч суух сандал, ширээгүй байна. Иймд эд хогшил, техник хэрэгсэл худалдан авах зардлыг суулгах талаарх саналыг уламжлах.

6. УДИРДЛАГЫН ТАЙЛБАР

Увс аймаг дахь цагдаагийн газрын удирдлагын зүгээс илэрсэн алдаа, зөрчилтэй асуудалд санал нийлж, ярилцлага хийн тайлбараа өгч, залруулах боломжтой зөрчлийг арилган, холбогдох баримтыг 2019 оны

01 дүгээр сарын 15-нд аудитын багт ирүүлсэн.

Тус цагдаагийн газар нь 2017 оны төсвийн төсөл боловсруулахдаа өмнөх оны бодит гүйцэтгэл, зах зээлийн үнэ, хэрэгцээ, шаардлагад үндэслэн бичиг хэрэг, урсгал засвар, эд хогшил, техник хэрэгсэл худалдан авах, зардлыг тооцон санал явуулсан боловч ЦЕГ-ын СААА-гаас 25-30% хасагдаж батлагдаж байгаа нь өр үүсэх нөхцөл болдог. Өглөгтэй тайлан нэгтгэхгүй гэдэг шаардлага тавигдаж, материалын орлого, зарлагын гүйлгээг устгаж тайлан нэгтгүүлсэн нь нярвын тайлан санхүүгийн тайлангийн зөрүү үүсэж аудитаар илэрсэн алдаа зөрчил гарахад нөлөөлсөн гэсэн “Удирдлагын тайлбар”-ыг ирүүлсэн.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2018 оны 08 дугаар сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудитын төрөл: Санхүүгийн аудит

Аудитын хугацаа: 2018.05.11-2018.08.15

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Д.Батсайхан

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа С.Март, цагдаагийн хошууч Ц.Болормаа

1. ТАНИЛЦУУЛГА

Манай аудитын баг нь 2018 оны төлөвлөгөөний дагуу Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсийн 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлээ.

Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсийн санхүүгийн баримтад нэгдүгээр гарын үсгийг хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа [REDACTED] /2017.01.01-2017.03.17/, [REDACTED] /2017.03.18-2018.01.12./, [REDACTED] /2018.01.13-наас/, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч, цагдаагийн хошууч [REDACTED] нар зурж, хөрөнгө, мөнгийг захиран зарцуулжээ.

2017 онд 1761.6 сая төгрөгийн улсын төсвийн урсгал, 31,7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, тус дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 5,5 сая төгрөг, цайны газрын түрээсээс 1,1 сая төгрөгийн орлого оруулж, төсөвт төвлөрүүлсэн байна. 2017 оны 4 улирлын төсвийн гүйцэтгэлээр 1.548,6 сая төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 35,7 сая төгрөгийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл, 28,5 сая төгрөгийн ашиглалтын зардал, 93,2 сая төгрөгийн хангамжийн материалын зардал, 7,1 сая төгрөгийн урсгал зардал, 27,2 сая төгрөгийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж, 24,2 сая төгрөгийн нормативт зардлуудыг тус тус зарцуулсан байна.

2017 оны 4 улиралд тус цагдаагийн хэлтсийн үндсэн хөрөнгө нь оны эхэнд 196,7 сая төгрөг байсан нь 1570,0 сая төгрөгөөр өсөж, 26,6 сая төгрөгөөр хасагдаж, тайлант хугацаанд 44,8 сая төгрөгийн хөрөнгийн элэгдэл хорогдлыг тооцсон байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

Аудитын удирдамжийн хүрээнд хамаарах төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээ зэрэгт холбогдолтой хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилт хэрхэн явагдаж байгаа талаар үнэлэлт өгч, эрсдэлийн дүн шинжилгээ хийж, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, аудитын явцад илэрсэн зөрчил дутагдал болон тулгарч буй асуудлыг засаж, сайжруулах чиглэлээр дүгнэлт, зөвлөмж өгч дэмжлэг үзүүлнэ.

2.2 Аудитын ажлын цар хүрээ

Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой үндэслэл, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, төсвийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, алба хаагчдын орон тоо, нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоолт, удирдлагын гаргасан санхүүтэй холбоотой тушаал, шийдвэрийн хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, анхан шатны баримтын бүрдүүлэлт, ерөнхий журнал, ерөнхий дэвтэр хөтлөлт, татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан бэлтгэсэн байдал, төрийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хөрөнгө худалдан авах ажиллагаа, эд хөрөнгийн тооллого, тооцоо бодолт гэсэн хүрээнд 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд түүвэр хийн, аудитын объектод хамруулан ажиллалаа.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ аудит хийгдэх нэгжийн удирдлага, алба хаагчидтай хийх уулзалт ярилцлага, асуулга, тайлбар, аудитын хүрээнд шалгах мэдээлэл, түүнийг нотлох аргыг боловсруулан хэлтсийн даргаар батлуулж ашигласан.

Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагааны урсгалын схем /ажлын дэс дараалал/-ийг бэлтгэн тухайлсан аудитын төлөвлөгөө гарган, аудит хийх объектоо судалсан.

Түүнчлэн аудитын нотлох баримт цуглуулах зорилгоор 6 төрлийн түүвэр хийж, тулган баталгаажуулахад ашигласан. Аудитын явцад цугласан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан урьдчилсан тайланг бичиж, холбогдох нэгжид хүргүүлэн “Удирдлагын тайлбар”-ыг авч, аудитын мөрөөр өгсөн зөвлөмжийн биелэлтийг тооцож үнэлэлт, дүгнэлт өгсөн.

АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Мөнгөн хөрөнгө: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Тус цагдаагийн хэлтэс нь гэрэл цахилгааны төлбөр 1.847.951, хоолны зардал 805.600 төгрөгийг гэрээний хугацаа хэтрүүлэн шилжүүлсэн, гэрэл цахилгааны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүйгээс шалтгаалж, 2017 онд [REDACTED] 2018 оны эхний улиралд [REDACTED] нийт [REDACTED] төгрөгийн алданги төлж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

3.2 Шатахууны тооцоо: Материалын нэр төрлийн тайлан, үнийн дүнгийн тайлан зөрүүтэй автомашины шатахуун зарцуулалтын тооцоо бодоход нэмэлт санхүүжилтээр авсан шатахууныг оруулж тооцоогүй, шатахууныг нэр төрлөөр бус бөөн дүнгээр орлого авч, зарлага болгосон байна.

Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсийн албан ажлын хэрэгцээнд 2017 онд зарцуулах шатахууны төсөв нь 65.6 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд “Автомашины тоо, хоногийн гүйлтийн хэмжээг шинэчлэн батлах тухай” Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016.05.27-ны өдрийн Б/274 дүгээр тушаалаар баталсан нормоор тооцоолоход жилийн дүнгээр 94.1 сая төгрөг, тус хэлтсийн даргын тушаалаар баталсан нормоор тооцоолоход 77.4 сая төгрөгийн төсөв зарцуулах тооцоо гарч байна. Шатахууны төсөв нь батлагдсан нормоос жилийн дүнгээр 12,0-28,0 сая төгрөгөөр дутуу төсөвлөгдөж байна.

2017 оны шатахууны тайланг үзэхэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль болон дахин сонгуулийн хамгаалалтад ажиллах автомашинд олгосон 1.000.000 төгрөг, наадмын хамгаалалтад зориулан олгосон 870.000 төгрөгийг автомашины шатахуун зарцуулалтын тооцоонд оруулаагүй, 799.736 төгрөгийн шатахууныг нэр төрлөөр бус бөөн дүнгээр орлого авч, зарлага болгосон, Айвеко маркийн автомашин болон 2 мотоциклийн замын хуудсыг бичээгүй, 180.000 төгрөгийн шатахууны тооцоог бодоогүй байна.

Түлш шатах тослох материалын нэр төрлийн тайланд тусгасан боловч үнийн дүнгийн тайланд 83.500 төгрөгийн шатахууныг тусгаагүй байна. Шатахуунтай холбоотой нийт [REDACTED] төгрөгийн зөрчил илэрлээ.

Бидний зүгээс 3 төрлийн зөвлөмж хүргүүлж, алдаа, зөрчлийг залруулан арилгуулсны дүнд анхан шатны баримтын бодитой байх зарчим алдагдах, дотоод хяналт сулрах эрсдэлийг бууруулсан гэж үзэж байна.

3.3 Бараа материал: Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар бараа материалыг зарлага болгосон, дансны ангиллыг бууруу бүртгэсэн.

Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсийн бараа материалын бүртгэлийг үзэхэд шаардах хуудасгүйгээр 31.710 төгрөгийн

бичиг хэрэг, аж ахуйн материал зарлага болгосон, хүчин төгөлдөр бус, засвартай баримтаар 193.000 төгрөгийн утасны нэгж олгосон, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх 170.000 төгрөгийн цахилгааны тоолуурыг бараа материалын дансанд бүртгэж, шаардах хуудсаар зарлага болгосон зөрчил илэрсэн. Бидний зүгээс 2 төрлийн зөвлөмж хүргүүлснээр 394.710 төгрөгийн алдаа, зөрчлийг залруулсан.

3.4 Мэдээллийн ил тод байдлын талаар: Зарим мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан, батлагдсан маягтаар мэдээлээгүй байна.

Тус цагдаагийн хэлтсийн шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллээс үзэхэд Төсөв гүйцэтгэл цэсэнд “Байгууллагын батлагдсан төсөв (*Бүтэн жилээр*)” хэсэгт 1 мэдээлэл, “Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт” цэсэнд Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (*Бүтэн жилээр*) 1 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

“Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл”, “Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (*Тухай бүр*)”, “Бонд, зээл, ерийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, “Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт”, “Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт”, “Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн” хэсэгт тоон мэдээлэл ашиглалгүй “мэдээлэл байхгүй” гэж үгэн хэлбэрээр мэдээлжээ.

Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх зарчмын хэрэгжилт бүрэн хангагдахгүй байх, зарим мэдээллүүдийг тоон мэдээлэл ашиглалгүй “мэдээлэл үгүй” гэж үгэн хэлбэрээр мэдээлж байгаа нь шилэн дансны цахим хуудасны хяналтын эрхээр хяналт хийх, тоо мэдээг нэгтгэхэд хүндрэл учруулж байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулах талаар 5 төрлийн зөвлөмж хүргүүлсэн.

3.5 Цалин хөлсний бүртгэл болон цалин тогтоолт: Тушаал шийдвэрийг хэрэгжүүлэхгүй илүү, дутуу тооцож зөрүү үүсгэсэн.

Алба хаагчдын цалингийн тооцоог баримтаар тулган баталгаажуулах, давтан гүйцэтгэх аргыг ашиглан шалгаж тушаал шийдвэрийг хэрэгжүүлэхдээ тооцооллын алдаа гаргаж албандаа хайнга хандсанаас шалтгаалж 5 алба хаагчид 1.180.300 төгрөгийн илүү, 2 алба

хаагчид 2.828.537 төгрөгийг дутуу олгосон байна. Үүнээс удирдлагаас ажлын үр дүнгээр цалин нэмж, хассан тушаалыг хэрэгжүүлэхдээ 2 алба хаагчийн цалинг 83.214 төгрөгөөр илүү, 2 алба хаагчийн 106.821 төгрөгийг дутуу олгосон. Тушаал, шийдвэргүй 2 алба хаагчийн 178.884 төгрөгийн цалинг хасаж, дутуу олгосон алдаа, зөрчлийг илрүүлсэн.

Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1.4-д "...төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах буюу царцаах, цалин хөлсийг цаашид нэмэгдүүлэх асуудлыг 2019 оноос төсвийн боломжтой уялдуулан шийдвэрлэх...", 1.5-д "...төрийн алба хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоож, энэ талаар шийдвэр гаргахгүй байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасан..." заалтыг гарахаас өмнөх цаг хугацааг хамаарах зөрчлүүд байгаа нь ТЗБТасгийн дарга, НЦГ-ын хүний нөөцийн ажилтан нар даргын гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг эргэж хянадаггүй, албад хоорондын уялдаа холбоогүй байдал, алба хаагчид картаар цалингаа авч, банкинд зээл суутгуулдаг болсонтой холбоотойгоор яг хэдэн төгрөгийн цалин авч байгаагаа мэдэхгүй, цалингийн бодолт болон дэлгэрэнгүй мэдээллээ нэг бүрчлэн авч чадахгүй байгаагаас санхүүд хяналт тавьж чадахгүй болсон нь нөлөөлсөн. Цаашид ч энэ алдаа даамжирч болзошгүй байна.

Шат шатандаа тавигдах дотоод хяналтгүй байдлаас алба хаагч цалин хөлсөө дутуу авах, зарим хүн илүү авч завших эрсдэл өндөр байгааг тогтоож бидний зүгээс аргачилсан зөвлөмж хүргүүлснээр дээрх алдаа, зөрчлийг залруулан арилгуулсан.

3.6 Үндсэн хөрөнгийн бүртгэл: Үндсэн хөрөнгийн бүртгэлээр тавих хяналт цаг хугацаандаа, зохих төвшинд хийгдэхгүй, тооллого чанаргүй хийгдэж эзэмшил баталгаажаагүй, дэлгэрэнгүй бүртгэл зохих төвшинд хөтлөгдөөгүй.

Санхүүгийн алба хаагчдын өдөр тутмын ажлын ачаалал их байгаагаас үндсэн чиг үүргийнхээ дагуу бүртгэл хөтлөх, хөрөнгийн зарцуулалт, хадгалалт, хамгаалалтанд хяналт тавих ажил цаг хугацаандаа хийгдэхгүй байна. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг бодитойгоор хөтөлдөггүйгээс шалтгаалж 2018 оны 1 дүгээр улиралын санхүүгийн тайлангийн хөрөнгийн үлдэгдэл [REDACTED] төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн. Уурын зуухны 79.070.886 төгрөгийн өртөгтэй барилга хүлээлцсэн акт, зурагтай хэрнээ үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл болох хувийн хэрэггүй, хэлтсийн конторын 1.300.366.328.00 төгрөгийн өртөгтэй барилга хувийн хэрэгтэй байгаа хэрнээ баяжилтгүй, өртгийг бичихдээ хувийн хэрэг хөтлөгдөхөд байсан үнэ, дуусаагүй барилгаас шингээсэн үнэ, их засварт шингэсэн өртөг зэргийг хөтлөөгүй, эдэлбэр газарт байгаа эд хөрөнгийн тэмдэглэл хийгдээгүй, нийтийн эзэмшлийн талаар оруулаагүй байна.

Тооллогыг чанартай хийхгүй байгаагаас 61 нэр төрлийн 18.406.598 төгрөгийн хөрөнгийг 23 алба хаагчдад эзэмшүүлэхдээ нүдээр үзэж тулган

баталгаажуулахгүй, хөрөнгө ашиглалтын картаар тоолоогүй, хяналтгүй, 2017 оны жилийн эцсийн тооллогоор 1.740.817.199 төгрөгийн хөрөнгийг тоолсон хурлын тэмдэглэлд Өмч хамгаалах байнгын зөвлөл хяналт муу тавьсан, хурлын шийдвэр зохих шаардлагыг хангаагүй, Нийслэлийн Өмчийн харилцааны газраас 2017 оны гэрээг дүгнэхдээ түрээсийн гэрээг хугацаанд нь журмын дагуу байгуулаагүй, гэрээний үүргийг биелүүлээгүйгээс 70 хувьтай гэж үнэлэгдсэн байна.

Сонгинохайрхан дүүргийн 11 хороонд орших “Цагдаагийн пост”-ын 3.876.120 төгрөгийн өртөг бүхий барилга нь 2008 онд баригдаж байгаад ашиглалтад ороогүй, одоогоор балгас шиг болсон талаар удаа дараа санал тавьсан боловч шийдвэрлээгүй хөрөнгө эзэнгүйдсэн байна. Энэ нь тус барилга орчмын газар болон хөрөнгөө алдах нөхцөл байдал үүсэж, өмчлөлийн маргаан үүсэх эрсдэл өндөр байгаа талаар зөвлөмж өгч ажиллалаа.

3.7 Үнэт цаас: Үнэт цаасны орлогыг хугацаа хэтрүүлэн тушаадаг, мөнгөн дүн, тасалсан он сарыг засдаг.

Нягтлан бодогч бүртгэлээр тавих хяналтаа бүрэн хэрэгжүүлэхгүй, ажлын ачаалал, дотоод ажил үүргийн хувиараа зөв зохион байгуулаагүй, дотоод хяналтын орчин хангалтгүй байдлаас шалтгаалж 2 алба хаагч [REDACTED] төгрөгийн 5 шийтгэх хуудсыг таслахдаа зөрчил гаргагчид очих хувийг таслаж санхүүтэй тооцоо хийсэн, 6 алба хаагч [REDACTED] төгрөгийн 7 шийтгэх хуудсыг таслахдаа мөнгөн дүнг зассан, 5 алба хаагч [REDACTED] төгрөгийн 5 шийтгэх хуудсыг хугацаа хэтрүүлэн тушаасан, 4 алба хаагч [REDACTED] төгрөгийн 4 шийтгэх хуудасны анхан шатны баримтын бүрдлийг хангаагүйгээр санхүүтэй тооцоо хийсэн, мөн 1 шийтгэх хуудас хүссэн өргөдөлд авахаар захиалсан тоо бичээгүй байхад олголт хийсэн, 2 алба хаагч [REDACTED] төгрөгийн 2 хүчин төгөлдөр бус шийтгэх хуудсаар зөрчил гаргагчийг торгосон, 6 алба хаагч [REDACTED] төгрөгийн 6 шийтгэх хуудасны он сарыг зассан, нярваас 5 шийтгэх хуудасны “маягт-1”-ийг хүссэн байхад “маягт-2”-ыг олгож үлдэгдлээ зөрүүлсэн зэрэг нийт [REDACTED] төгрөгийн зөрчил илэрсэн. Алба хаагчдын гар дээрх үлдэгдлийн тооцоог цаг хугацаанд нь хянаагүйгээс шалтгаалж дээрх зөрчил гарсан байна.

Бид алдаа, зөрчлийг давтахгүй байх талаар зөвлөмж хүргүүлсэн ба цаашид үнэт цаасны дээрх алдаа, зөрчлөөс хамааран орлого төлөгдөхгүй, төсөвлөсөн орлогын төлөвлөгөө тасалдахад нөлөөлөх, засварласан, хаяж үрэгдүүлсэн үнэт цаасны шалтгааныг тогтоохгүй байгаа нь ашиглал хийх эрсдэл байгааг харуулж байна.

4. ДҮГНЭЛТ

Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсийн удирдлага нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн холбогдох эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйгээс

урьдчилсан дүгнэлтээр [REDACTED] мянган төгрөгийн алдаа, [REDACTED] мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Аудитын багийн зүгээс дотоод аудит хийх явцад илэрсэн алдаа зөрчилтэй 7 асуудалд нотлох баримтыг үндэслэн одоогийн илэрсэн эрсдэлийг тодорхойлж түүнийг бууруулах, засаж залруулах үйл ажиллагаанд чиглэсэн дотоод зохион байгуулалт, ажлын хариуцлагыг сайжруулах 23 төрлийн зөвлөмж өгсөн болно.

Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсийн удирдлагын зүгээс илэрсэн алдаа, зөрчилтэй асуудалд санал нийлсэн тайлбараа өгч, зөвлөмжийн мөрөөр үр дүнтэй хариу арга хэмжээг авснаар санхүүгийн дотоод аудит хийгдэх явцад [REDACTED] мянган төгрөгийн алдаа, [REDACTED] мянган төгрөгийн зөрчил бүрэн залруулагдсан тул аудитын багийн ажлын үр дүнгээр материаллаг нөлөөлөлгүй гэж үзэн “1 буюу хангалттай” гэж үнэлэв.

5. ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, эцсийн тайлангийн дүгнэлтийг үндэслэн Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсийн удирдлага, санхүүгийн алба хаагч нарт цаашид үүсэж болзошгүй эрсдэлийг сааруулах чиглэлээр аудитын багаас дотоод зохион байгуулалт, ажлын хариуцлага, хяналтаа сайжруулах үйл ажиллагаанд чиглэсэн дараах зөвлөмжийг холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх саналтай байна. Үүнд:

- Дотоод аудитын багаас өмнө нь хүрүүлсэн ажлын баримт “Аудитаар илэрсэн асуудлын бүртгэл”-маягт /Ажлын баримт 2003b/ЦЕГ-ХШҮДАХ/2018/06/СА-2/-ын дагуу өгсөн 23 төрлийн зөвлөмжийг цаашдын үйл ажиллагаандаа нэг мөр болгон хэрэгжүүлж ажиллах, удирдлагаас алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар эрсдэлийн төлөвлөгөөндөө тусгаж, үнэлгээ өгдөг болох;
- Холбогдох алба хаагчдад хариуцлага тооцуулах саналтай.

6. УДИРДЛАГЫН ТАЙЛБАР

Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсийн удирдлагын зүгээс илэрсэн алдаа, зөрчилтэй асуудалд санал нийлсэн тайлбараа өгөн, зөвлөмжийн мөрөөр хариу арга хэмжээ авч, санхүүгийн дотоод аудит хийгдэх явцад 1.180,3 мянган төгрөгийн алдаа, 35.121,6 мянган төгрөгийн зөрчлийг залруулсан болно.

**УЛСЫН НЭГДСЭН САНД БҮРТГЭЛТЭЙ
ЭРХ ЗҮЙН АКТЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2017.04.04

Улаанбаатар хот

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын талаар

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаас өгсөн үүрэг, “Цагдаагийн байгууллагын 2017 оны хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөө”, Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 2017 оны 02 дугаар сарын 13-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Н.Батзогсох, мөн хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх бид “Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан улсын нэгдсэн санд бүртгэлтэй эрх зүйн актуудын хэрэгжилт”-эд үнэлэлт, дүгнэлт өгч, тэдгээрийн хэрэгжилтийг сайжруулж, боловсронгуй болгох чиглэлээр зөвлөмж боловсруулах зорилгоор энэхүү хяналт шинжилгээг хийлээ.

Хяналт шинжилгээг 2017 оны 02 дугаар сарын 13-наас 03 дугаар сарын 22-ны хооронд Нийтийн хэв журам хамгаалах алба, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Улаанбаатар хотын цагдаагийн газрын Сургалтын төв, Лицензийн төв, Хамгаалалтын 3 дугаар газар болон Орхон, Булган аймаг дахь цагдаагийн газруудад ажиллан холбогдох алба хаагчидтай уулзалт ярилцлага зохион байгуулах, шаардлагатай баримт бичиг, үйл ажиллагаатай газар дээр нь танилцах хэлбэрээр хийж гүйцэтгэлээ.

Хяналт шинжилгээний хүрээнд дор дурьдсан 7 эрх зүйн актыг хэрэгжүүлэх чиглэлээр цагдаагийн байгууллага, нэгжийн 2016 оны үйл ажиллагааг хамрууллаа. Үүнд:

1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 568 дугаар тушаалаар батлагдсан “Олон нийтийн цагдаагийн ажилтны дүрэм”
2. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 383 дугаар тушаалаар батлагдсан “Олон нийтийн цагдаагийн ажилтны таних тэмдэг, хөдөлмөр аюулгүй байдлын хувцас өмсөж хэрэглэх журам”
3. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/75 дугаар тушаалаар батлагдсан “Галт зэвсгийн гэрчилгээ олгох журам”
4. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/73 дугаар тушаалаар батлагдсан “Борлуулагчийн галт зэвсгийн бүртгэлийн загвар”, “Борлуулагчийн сумны бүртгэлийн загвар” буюу галт зэвсэг, сум борлуулагчдад хяналт тавих цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа
5. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/74 дүгээр тушаалаар батлагдсан “Галт зэвсэг, сумыг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийн загвар”, “Гадаадын иргэн, тамирчид Монгол Улсын хилээр галт зэвсэг нэвтрүүлэх зөвшөөрлийн загвар”, “Галт зэвсэгтэй

адилтгах хэрэгслийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийн загвар” буюу Монгол Улсын хилээр галт зэвсэг, сум, адилтгах хэрэгсэл нэвтрүүлэх зөвшөөрөл олгох цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа

6. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/72 дугаар тушаалаар батлагдсан “Иргэний болон харуул, хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтын заавар”

7. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/32 дугаар тушаалаар батлагдсан “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны журам”

Дээрх эрх зүйн актуудын хэрэгжилт, үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээний дүнг тус бүрт нь танилцуулж байна.

Хоёр.Олон нийтийн цагдаагийн ажилтны дүрэм, холбогдох журмын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний талаар

Олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааг Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйл, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан “Олон нийтийн цагдаагийн ажилтны дүрэм”, “Олон нийтийн цагдаагийн ажилтны таних тэмдэг, хөдөлмөр аюулгүй байдлын хувцас өмсөж хэрэглэх журам”, “Олон нийтийн цагдаагийн ажилтны хөдөлмөрийн гэрээний үлгэрчилсэн загвар”, “Олон нийтийн цагдаагийн ажилтны ажил дүгнэх үзүүлэлт”, “Олон нийтийн цагдаагийн ажилтны үнэмлэхний загвар” болон бусад эрх зүйн актаар зохицуулж байна.

Мөн олон нийтийн цагдааг сургаж бэлтгэх үйл ажиллагаанд Цагдаагийн ерөнхий газрын дарга, дэд дарга нарын баталсан “Олон нийтийн цагдаагийн ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөр”, “Үйлдвэрлэлийн дадлагын сургалтын үлгэрчилсэн удирдамж” зэрэг баримт бичгүүд мөрдөгдөж байна.

“Олон нийтийн цагдаагийн ажилтны дүрэм”-ийн хэрэгжилтэд хийх хяналт шинжилгээний хүрээнд олон нийтийн цагдаа нь дүрэмд заасан шаардлагыг хангаж буй эсэх, олон нийтийн цагдааг бэлтгэх сургалт нь батлагдсан хөтөлбөр, удирдамжид нийцэж буй эсэх, олон нийтийн цагдаагийн үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах болон дүрэмд заасан бусад асуудлыг хамрууллаа.

Цагдаагийн байгууллагад олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүргийг НХЖХА-ны ахлах мэргэжилтэн-1, УБХЦГ-ын ахлах мэргэжилтэн-1 болон аймаг, дүүргийн цагдаагийн газар, хэлтэст нийтийн хэв журам хамгаалах тасгийн ахлах байцаагч, хэсгийн байцаагч, төлөөлөгч нар хэрэгжүүлж байна.

Анх 2013 онд батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулиар тухайн шатны Засаг даргаас холбогдох зардлыг хариуцан олон нийтийг цагдааг ажиллуулахаар хуульчилсан бөгөөд 2016 оны байдлаар Завхан, Сэлэнгэ, Төв, Увс, Хэнтий аймагт олон нийтийн цагдааг ажиллуулаагүй байна.

2016 онд аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 587 олон нийтийн цагдаа ажиллуулахаар орон тоог баталсан боловч орон нутагт ажиллах 188 олон нийтийн цагдаагийн орон тоо дутуу байна. Үүрэг гүйцэтгэж буй 399 олон нийтийн цагдаагаас 224 нь нийслэлд, 175 нь орон нутагт байна.

Олон нийтийн цагдаа нарт олгох урамшууллын хэмжээ нь тухайн орон нутгийн хөрөнгийн боломж, санаачлагаас шалтгаалан харилцан адилгүй байгаа бөгөөд Улаанбаатар хот, Булган, Говьсүмбэр, Дорнод, Орхон, Өмнөговь, Сүхбаатар аймгуудад харьцангуй өндөр буюу 300-450 мянга, Говь-Алтай, Ховд аймагт харьцангуй бага буюу 100 мянга, бусад аймгуудад дундаж буюу 200 мянга орчим төгрөг байна.

Олон нийтийн цагдаагийн урамшууллыг олгуулахаар сар бүр тэдний ажлын тайлан, үнэлгээг Засаг даргад хүргүүлж хэвшсэн. Улаанбаатар хотын хэмжээнд 2016 онд давхардсан тоогоор олон нийтийн цагдаа 80 хүний урамшууллыг 20 хувиар нэмэгдүүлэн олгожээ. Мөн сахилгын зөрчил гаргасан 1 хүний урамшууллыг 20 хувиар бууруулж, 1 хүний Хөдөлмөрийн гэрээг цуцалсан байна.

Олон нийтийн цагдаа нь дүрэмд заасан шаардлагыг хангаж буй эсэхийг тодорхойлох зорилгоор Нийслэлийн цагдаагийн газрын харьяа 4 нэгжийн 19 олон нийтийн цагдаагийн хувийн хэргийг түүвэрлэн авч танилцахад ял шалгах хуудасгүй 4, олон нийтийн цагдаагийн Сургалтын гэрчилгээгүй 12 материал байлаа.

Мөн Орхон, Булган аймаг дахь цагдаагийн газрын нийт 38 олон нийтийн цагдаагийн хувийн хэрэгтэй танилцахад эрүүл мэндийн хуудасгүй 3, ял шалгах хуудасгүй 20, Сургалтын гэрчилгээгүй 14 материал байв.

Хяналт шинжилгээний хүрээнд Улаанбаатар хотод ажиллаж буй олон нийтийн цагдаа нарын нас, хүйсийн судалгаа, Хөдөлмөрийн гэрээ цуцалсан шалтгааны судалгаа, хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцасны тооцооны талаарх судалгааг Нийслэлийн цагдаагийн газар дахь хариуцсан алба хаагчаар хийлгүүлсэн нь чухал ач холбогдолтой боллоо. Дээрх судалгаанаас анхаарал татсан зарим мэдээллийг дурдвал дараах байдалтай байна. Үүнд:

- Олон нийтийн цагдаа нарын нас, хүйсийн харьцаа доорхи байдлаар өөрчлөгджээ.

Огноо	Хүйс		Нас			
	Эр	Эм	20-30	31-40	41-50	51-60
2014.10.15 -ны байдлаар	99 /58%/	73 /42%/	115 /67%/	27 /16%/	18 /10%/	12 /7%/
2015.04.10 -ны байдлаар	119 /53%/	105 /47%/	140 /63%/	45 /20%/	21 /9%/	18 /8%/
2016.02.26 -ны байдлаар	103 /46%/	120 /54%/	138 /62%/	50 /22%/	14 /6%/	22 /10%/
2017.02.21 -ний байдлаар	87 /45%/	104 /55%/	115 /60%/	45 /23%/	13 /7%/	18 /10%/

Дээрх хүснэгтээс үзвэл эрэгтэй олон нийтийн цагдаагийн эзлэх хувь 58-аас 45, 20-30 насны олон нийтийн цагдаагийн эзлэх хувь 67-гоос 60 болж буурсан нь тэдний гүйцэтгэх үүргийн онцлогийг харгалзвал ухарсан статистик байна.

• 2014-2017 оны хооронд нийт 388 олон нийтийн цагдаатай Хөдөлмөрийн гэрээ байгуулснаас 187 гэрээ цуцлагджээ.

Хөдөлмөрийн гэрээ байгуулсан	Хөдөлмөрийн гэрээ цуцалсан	Үүнээс: /Хөдөлмөрийн гэрээ цуцалсан шалтгаан/							
		Сахилга, ёс зүйн зөрчил гаргасан	Удаа дараа ажил тасалсан	Цагдаагийн ахлагчийн дамжаанд элссэн	Цагдаагийн байгууллагад энгийн орон тоонд томилогдсон	Тэтгэвэрт гарсан	Цэргийн албанд татагдсан	Нас барсан / зуурдаар/	Өөрийн хүсэлтээр Хөдөлмөрийн гэрээг цуцалсан
388	187	17 /9%/	6 /3%/	46 /25%/	2 /1%/	2 /1%/	1	1	112 /60%/

Нийт цуцлагдсан Хөдөлмөрийн гэрээний 60 хувийг олон нийтийн цагдаагийн хүсэлтээр цуцалсан байгааг тэдний урамшууллын хэмжээ бага, залуучуудын хувьд цаашид ахиж дэвших боломж хязгаарлагдмал байгаатай холбон тайлбарлаж байна.

• Олон нийтийн цагдаад олгох хөдөлмөрийн аюулгүй байдлын иж бүрэн хувцасны нийт зардал нь 1291350 төгрөг бөгөөд эдэлгээний хугацаа нь 1-5 жил байна. Хөдөлмөрийн гэрээ цуцалсан олон нийтийн цагдаа нараас хувцасны тооцоо, эдэлгээний үнийн зөрүүний төлөлт доорхи байдалтай байна.

Хөдөлмөрийн гэрээ цуцлагдсан	Үүнээс			Үүнээс			
	Хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцасны хангалт аваагүй	Хувцасны тооцоогүй	Хувцасны тооцоотой	Эдэлгээний үнийн зөрүүг төлсөн		Эдэлгээний үнийн зөрүүг төлөөгүй	
				Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
				187	24	4	159

Дээрх мэдээллээс үзвэл Хөдөлмөрийн гэрээ цуцлагдсан олон нийтийн цагдаатай хувцасны эдэлгээний үнийн зөрүүг төлүүлж, тооцоо хийх ажил хангалтгүй хэрэгжиж байна. Үүний шалтгааныг ажил хариуцсан алба хаагчдаас тодруулахад хувцасны тооцоог хэрхэн хийх талаар нарийвчилсан зохицуулалтгүй, олон нийтийн цагдаа нь төлбөрийн чадвар муутай байдагтай холбон тайлбарлаж байна.

Олон нийтийн цагдаагийн ажилтны дүрмийн 5.3-т “Олон нийтийн цагдаа нь хуулиар харьяалуулсан зөрчилд торгууль ногдуулахдаа

тухайн орон нутгийн Засаг даргаас олгосон торгууль, шийтгэврийн хуудсыг ашиглах, ... Засаг дарга нь торгууль, шийтгэврийн хуудсыг олгох, тайлан тооцоо хийх этгээдийг томилон ажиллуулах"-аар заасан. Гэвч Баян-Өлгий, Орхон аймгаас бусад газарт энэ ажил хэрэгжээгүй байх ба шалтгаан нь Засаг дарга нар дүрэмд заасны дагуу торгууль, шийтгэврийн хуудсыг хариуцах этгээдийг томилоогүй, энэ ажилд хойрго хөшүүн хандаж байгаатай холбоотой байна.

2016 онд улсын хэмжээнд олон нийтийн цагдаа нарын ажлын үзүүлэлтийг хүснэгтээр үзүүлбэл:

Нэгжийн нэр	Ажиллаж байгаа ОНЦ	Дутуу орон тоо	Ажлын үзүүлэлт /илрүүлсэн/		
			Гэмт хэрэг	Зөрчил	Торгуулийн арга хэмжээ авсан /мян.төг/
Орон нутаг	175	188	40	1124	690.0
Нийслэл	224	-	247	6240	-
Нийт	399	188	287	7364	690.0
Улсын хэмжээний дүн мэдээнд эзлэх хувь			1.24%	0.86%	2.9%

Цаашид багагүй хөрөнгө, хүч хөдөлмөр зарцуулан хэрэгжиж буй олон нийтийн цагдаа нарын үйл ажиллагааг сайжруулах, ажлын үр дүн, бүтээмжийг нэмэгдүүлэх шаардлага байгаа нь дээрх хүснэгтээс харагдаж байна.

Хяналт шинжилгээний хүрээнд Орхон аймаг дахь цагдаагийн газрын олон нийтийн цагдаа нартай уулзалт ярилцлага хийсэн. Өнгөрсөн хугацаанд тус хамт олноос 8 хүн цагдаагийн байгууллагад томилогдсон, одоо ажиллаж буй залуус нь мөн цагдаа болох хүсэл эрмэлзэлтэй, тэднийг хариуцсан алба хаагчийн ажлын гүйцэтгэл нь сайн байлаа.

2013 онд батлагдсан Цагдаагийн албаны тухай хуульд олон нийтийн цагдаад тусгай хэрэгсэл тавьж олгох тухай тусгасан ч түүнийг хэрэглэх үндэслэл, журмыг зохицуулаагүйгээс олон нийтийн цагдаа нар үүрэг гүйцэтгэхдээ биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх боломжгүй байсан. Тэгвэл 2017 онд батлагдсан тус хуулийн шинэчилсэн найруулгаар энэ асуудлыг зохицуулан шийдвэрлэжээ.

2014-2016 оны хооронд Улаанбаатар хотод Сургалтын төвд нийт 9 удаагийн сургалтаар 388, Дорноговь, Орхон, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газарт 6 удаагийн сургалтаар 76 олон нийтийн цагдааг тус тус сургаж бэлтгэсэн бол бусад аймгийн цагдаагийн газар, хэлтсээс тус сургалтыг зохион байгуулаагүй байна.

Орон нутагт олон нийтийн цагдаагийн сургалт зохион байгуулахад Сургалтын төвөөс сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, шалгалтын тест, бодлого зэрэг материалыг хүргүүлж, сургалтын дараа тухайн нэгжээс ирүүлсэн нэрсийн дагуу Сургалтын гэрчилгээг гаргаж хүргүүлэх зэргээр хамтран ажилладаг байна.

Тухайн шатны Засаг даргаас сургалтын зардлыг шийдвэрлэсний дагуу Сургалтын төвд эхний 3 сургалт л төлбөртэй /нэг хүн 40100 төгрөг/, түүнээс хойшхи сургалтууд үнэ төлбөргүй зохион байгуулагджээ.

Олоннийтийн цагдаагийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө нь дүрэмд заасан агуулгыг бүрэн хамарсан бөгөөд сургалт нь танхимын /5 өдөр 2.5 кр.цаг/ болон дадлагын сургалт /14 хоног/-аас бүрдэж байна. Дадлагын сургалтыг тухайн олон нийтийн цагдааг судалж ирүүлсэн нэгжид хийлгэж, шалгалтыг эрх зүйн мэдлэг /тест/, цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах арга зүй /кейс, бодлого/ болон дадлагын тайлан хамгаалуулах /амаар/ гэсэн 3 хэлбэрээр явуулж байна.

Олон нийтийн цагдаатай холбоотой дүрэм, журмын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний мөрөөр хэрэгжүүлбэл зохих санал, зөвлөмжийг тайлангийн САНАЛ, ЗӨВЛӨМЖ хэсэгт тусгав.

Гурав.Галт зэвсгийн гэрчилгээ олгох журмын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний талаар

Цагдаагийн байгууллагаас галт зэвсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагааг Галт зэвсгийн тухай хууль, Хууль зүйн сайд, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэнд, спортын сайд нарын хамтарсан 2015 оны А/250, А/379, 437 дугаар тушаалаар батлагдсан “Иргэний болон харуул хамгаалалтын ангилалд хамаарах галт зэвсэг, сумны нэр, төрлийн жагсаалт”, Хууль зүйн сайд, Эрүүл мэнд, спортын сайдын хамтарсан 2015 оны А/269, 469 дүгээр тушаалаар батлагдсан “Галт зэвсэг ашиглахад харшлах өвчин, гэмтэл согогийн жагсаалт”, 2015 оны А/268, 468 дугаар тушаалаар батлагдсан “Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг эзэмших, хадгалах журам”, Хууль зүйн сайдын 2015 оны А/219 дүгээр тушаалаар батлагдсан “Хураагдсан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг устгах, худалдах, өмчлөгчид буцаан олгох, шилжүүлэх журам”, А/220 дугаар тушаалаар батлагдсан “Галт зэвсгийн тооллого явуулах журам”, А/249 дүгээр тушаалаар батлагдсан “Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн жагсаалт”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/75 дугаар тушаалаар батлагдсан “Галт зэвсгийн гэрчилгээ олгох журам” болон бусад эрх зүйн актаар зохицуулж байна.

Галт зэвсгийн гэрчилгээ олгох журмын хэрэгжилтэд хийх хяналт шинжилгээний хүрээнд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага /УБХЦГ, Орхон, Булган аймаг дахь цагдаагийн газар/-ын үйл ажиллагаа, галт зэвсэг өмчлөх хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээд нь хуульд заасан шаардлагыг хангаж буй эсэх, бүрдүүлсэн материал нь бүрэн эсэх, Галт зэвсэг болон галт зэвсэг өмчлөгчийн бүртгэл, шилжилт хөдөлгөөн зохих журмын дагуу хийгддэг эсэх, галт зэвсгийн нэгдсэн бүртгэлийн сангийн үйл ажиллагаа, ашиглалтын байдал, галт зэвсгийн тооллого, хураагдсан галт зэвсгийн шийдвэрлэлт зэрэг асуудлуудыг хамрууллаа.

2016 оны 04 дүгээр сараас Галт зэвсгийн мэдээллийн нэгдсэн санг ашиглалтад оруулснаар цагдаагийн байгууллагын галт зэвсгийн гэрчилгээ олгох, бүртгэл, хяналтын үйл ажиллагаанд томоохон ахиц дэвшил гарчээ.

Иргэн, хуулийн этгээд нь галт зэвсгийг бүртгүүлж, гэрчилгээ авахын тулд ГЗТХ-ийн 12 дугаар зүйлд заасны дагуу галт зэвсэг худалдаж авсан, улсын хилээр оруулж ирснээс хойш 10 өдрийн дотор холбогдох баримт бичгийг бүрдүүлэн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хандаж байна.

Улаанбаатар хотын цагдаагийн газарт 2016 онд галт зэвсгийн гэрчилгээ авахаар иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн 990 баримт бичгийн иж бүрдлийг шалгах зорилгоор 20-ыг түүвэрлэн авч танилцахад ямар нэг зөрчилгүй, хуульд заасан баримт бичгийг бүрэн бүрдүүлсэн байлаа.

Харин Орхон аймаг дахь цагдаагийн газарт 2016 онд галт зэвсгийн гэрчилгээ авахаар иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн баримт бичгээс 10-ыг түүвэрлэн авч танилцахад галт зэвсгийн сургалтын гэрчилгээгүй 7 материал байв.

Булган аймаг дахь цагдаагийн газрын тухайд 2016 онд хамаарах 17 баримт бичгийг түүвэрлэн авч танилцахад бүх материал галт зэвсгийн сургалтын гэрчилгээ, ял шалгасан талаарх тэмдэглэл /хуудас/-гүй, 14 материал шүүхийн шинжилгээний байгууллагын тодорхойлолтгүй байлаа.

ГЗТХ-д 2016 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд бүртгэлгүй галт зэвсгийг ямар нэг хариуцлага хүлээлгэхгүй, эх сурвалжийн талаар тайлбар шаардахгүйгээр бүртгэхээр зохицуулсан. Хэдийгээр дээрх хугацаа өнгөрсөн ч иргэдийн гар дээрх бүртгэлгүй галт зэвсгийг аль болох бүртгэлжүүлж цагдаагийн байгууллагын хяналт, мэдээллийн санд оруулах зорилгоор Эрүүгийн цагдаагийн газарт тухайн галт зэвсэг, хүсэлт гаргасан иргэний талаарх мэдээллийг хүргүүлж, ирүүлсэн хариууг үндэслэн галт зэвсгийг бүртгэн гэрчилгээ олгож байна.

Нөгөө талаас зарим хууль, эрх зүйн зохицуулалт, төрийн байгууллагын үйл ажиллагаа нь нуугдмал галт зэвсгийг илрүүлэн бүртгэх үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал:

- 2015 оны 08 дугаар сард батлагдсан Галт зэвсгийн албан татварын тухай хуулиар татварын хэмжээ 30000-60000 төгрөг болж өссөн.
- Иргэд галт зэвсэг өмчлөхийн тулд 150000 төгрөгийн төлбөр төлж галт зэвсгийн аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан байх шаардлага бий болсон. Уг сургалтыг Улаанбаатар хотод Сургалтын төв, орон нутагт Орхон, Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газар л зохион байгуулсан. Бусад аймагт тодорхой шалтгааны улмаас уг сургалтыг зохион байгуулаагүй байна.
- Шүүхийн шинжилгээний байгууллага нь галт зэвсгийн сумны хонгио, хошууны дээжийг авахдаа иргэдээс сумыг гаргуулан үнэ төлбөргүй үйлчилдэг байсан бол Шүүхийн шинжилгээний үндэсний

хүрээлэнгийн захирлын 2016 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн Б/534 дүгээр тушаалаар батлагдсан “Галт зэвсгийн хонгио, хошууг мэдээллийн нэгдсэн санд бүртгэх түр журам” хэрэгжиж эхэлснээр дээж авах хуваарь нь 7 хоногт 2 удаа 2-хон цаг болж буурсан, иргэдээс буудлага үйлдэх сумыг гаргуулахын зэрэгцээ үйлчилгээний төлбөрт 10000-20000 төгрөгийг авдаг болсон.

Дээрх нөхцөл байдал нь иргэдэд эдийн засгийн болон цаг хугацааны хувьд хүндрэл, чирэгдлийг үүсгэж байгаагаас иргэдийн нуугдмал галт зэвсгээ бүртгүүлэх, шилжилт хөдөлгөөнийг зохих журмын дагуу хийлгэх идэвхи, хүсэл сонирхол буурч болзошгүй байна.

Шинэчлэн батлагдсан ГЗТХ-иар галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл /хийн буу/-ийг цагдаагийн байгууллага бүртгэхээр зохицуулсан. Ингэхдээ 2016 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл эх сурвалжийн талаар ямар нэг тайлбар шаардахгүй бүртгэх хуулийн зохицуулалт хийсэн боловч “Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн гэрчилгээ /тодорхойлолт/” нь мөн оны 10 сард батлагдсанаас уг ажил хэрэгжээгүй байна. Цаашид иргэдийн гар дээрх галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг бүртгэлжүүлэхэд нэмэлт зохицуулалт, зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай нь эндээс харагдаж байна.

2016 оны 11 дүгээр сарын 09-нөөс 12 дугаар сарын 20-ны хооронд “Зэвсэг-2016” нэгдсэн арга хэмжээний хүрээнд цагдаагийн байгууллагад бүртгэлтэй 47225 галт зэвсгээс 31798 ширхэг буюу 70.6 хувийг тооллогод хамруулжээ. Тооллогод хамрагдсан галт зэвсгийн хувь хэмжээ бага байгаа ч уг тооллогоор галт зэвсэг нэг бүрийн зураг, холбогдох мэдээллийг мэдээллийн санд шивж оруулсан нь маш бодитой, үр дүнтэй ажил болсон гэж хариуцсан алба хаагчид үнэлж байна. Нөгөө талаас тооллогыг оны эцэст богино хугацаанд явуулах нь орон нутагт цаг агаар, газар зүйн алслагдмал байршлаас шалтгаалан хүндрэл үүсгэх эрсдэлтэй байна.

2016 оны 04 дүгээр сард галт зэвсгийн мэдээллийн нэгдсэн сан ашиглалтанд орсонтой холбогдуулан цагдаагийн байгууллага бүр өөрт бүртгэлтэй галт зэвсгийг уг санд шивж оруулсан. Тухайн үед олон тооны галт зэвсгийг санд давхардуулан бүртгэсэн нь сангийн ашиглалтын явцад илэрч байна. Тухайлбал, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтэст 500 галт зэвсэг давхардаж бүртгэгдсэн, 2017 он гарснаас хойш Улаанбаатар хотын цагдаагийн газарт галт зэвсгийн гэрчилгээтэй холбоотой ирүүлсэн 109 материалыг шүүхэд 5 галт зэвсэг давхардаж бүртгэгдсэн тохиолдол гарчээ.

Галт зэвсгийн шилжилт хөдөлгөөнийг хийхдээ гэрчилгээн дээр хасалт хийсэн тухай тэмдэглэлийг үйлдэж, сангаар шилжин очиж буй нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад шилжүүлж, албан бичгээр мэдэгддэг байна. Энэ үйл ажиллагаа Улаанбаатар хотын хэмжээнд жигдэрсэн ч орон нутагт харьцангуй сул хэрэгжиж байна. 2017 оны 02 дугаар сарын 21-ний байдлаар мэдээллийн санд 585 галт зэвсэг

шилжүүлгийн горимд хүлээгдэж байгаа нь төдий хэмжээний галт зэвсэг цагдаагийн байгууллагын хяналт, татварын зохицуулалтаас гадуур байна гэх тааруухан үзүүлэлт юм.

Галт зэвсгийн мэдээллийн сан нь ГЗТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.9-т заасан агуулгыг бүрэн хамарсан, галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэлтэй холбоотой цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой байна. Тус сан шинээр ашиглалтанд орсонтой холбогдуулан төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын галт зэвсэг хариуцсан алба хаагчдад сургалт зохион байгуулагдсан. Гэвч алба хаагчдын шилжилт хөдөлгөөнтэй холбогдуулан санд ажиллах алба хаагчдыг давтан сургах зайлшгүй хэрэгцээ шаардлага байгаа нь хяналт шинжилгээний явцад ажиглагдлаа.

ГЗТХ-д заасан үндэслэл, журмын дагуу цагдаагийн байгууллагад хураагдсан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг үзлэг шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулах, тэдгээрийг устгах, худалдах, өмчлөгчид буцаан олгох, шилжүүлэх ажлыг Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар томилогдсон Ажлын хэсэг зохион байгуулахаар журамласан.

Хамгийн сүүлд 2015 оны 03 дугаар сард Цагдаагийн ерөнхий газрын даргын А/12 дугаар тушаалаар дээрх Ажлын хэсгийг байгуулж үүрэг гүйцэтгүүлжээ. Уг ажлын хэсгээс тухайн үед хураагдсан байсан 962 галт зэвсгээс 864-ийг устгах, 63-ыг цагдаагийн байгууллагад шилжүүлэх, 14-ийг өмчлөгчид нь буцаан олгох, 21-ийг үргэлжүүлэн шалгахаар шийдвэрлэжээ. Мөн хураагдсан 36223 ширхэг сумнаас 30427 ширхэг сум, 155 ширхэг хоосон сумыг цагдаагийн байгууллагад, 1755 ширхэг сум, 3885 ширхэг сумны хошууг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд шилжүүлэхээр шийдвэрлэжээ.

2016 оны жилийн эцсийн байдлаар цагдаагийн байгууллагад хураагдсан 861 галт зэвсэг, 54122 ширхэг сум байна.

Галт зэвсгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлд "... музейн үзмэр, иргэний болон харуул хамгаалалтын зориулалтаар ашиглах боломжгүй, хөнөөх чадваргүй болсныг цагдаагийн байгууллага тогтоож гэрчилгээ олгосон..." галт зэвсгийг албан татвараас чөлөөлөхөөр зохицуулсан. Түүнчлэн Зэвсэгт хүчнээс тэтгэвэрт гарч буй алба хаагчиддаа байлдааны зориулалттай галт зэвсгийг бэлэглэх явдал цөөнгүй байна. Эдгээр галт зэвсгийг цуглуулгын зориулалтаар л бүртгэх боломжтой, үүний тулд хөнөөх чадваргүй болгох ёстой ч цагдаагийн байгууллагад энэ чиглэлийн мэргэжилтэн, шаардлагатай эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Галт зэвсгийн гэрчилгээ олгох журмын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний мөрөөр хэрэгжүүлбэл зохих санал, зөвлөмжийг тайлангийн САНАЛ, ЗӨВЛӨМЖ хэсэгт тусгав.

Дөрөв. Галт зэвсэг, сум борлуулагчдад хяналт тавих цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээний талаар

Галт зэвсэг, сум борлуулагчдад хяналт тавих цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Галт зэвсгийн тухай хууль, Хууль зүйн сайдын 2015 оны А/245 дугаар тушаалаар батлагдсан “Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, нийтэд худалдах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”, А/249 дүгээр тушаалаар батлагдсан “Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл худалдах төвд эрх олгох, салбар нээх болон төвийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах журам”, Хууль зүйн сайд, Эрүүл мэнд, спортын сайдын хамтарсан “Буудлага үйлдэх байгууламж /тир/-д тавигдах шаардлага батлах тухай” 2015 оны А/248, 433 дугаартай тушаал, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/73 тушаалаар батлагдсан “Борлуулагчийн галт зэвсгийн бүртгэлийн загвар”, “Борлуулагчийн сумны бүртгэлийн загвар” болон бусад эрх зүйн актууд мөрдөгдөж байна.

Энэхүү хяналт шинжилгээний хүрээнд борлуулагчдын талаарх бүртгэл, судалгаа, борлуулагчдаас галт зэвсэг, сумыг хилээр нэвтрүүлэх, тээвэрлэх, худалдах болон хадгалж хамгаалах явцад цагдаагийн байгууллагаас тавих хяналт зэрэг асуудлуудыг хамрууллаа.

Борлуулагчийн үйл ажиллагаанд хяналт тавих цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нь галт зэвсэг, сумыг улсын хилээр нэвтрүүлж тээвэрлэх, худалдан борлуулах болон хадгалж хамгаалах гэсэн 3 үе шатанд хэрэгжиж байна.

4.1 Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг, сум, дагалдах хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, нийтэд худалдах хуулийн этгээд /борлуулагч/-ийн тусгай зөвшөөрөл, галт зэвсэг, сум худалдах төв ажиллуулах эрхийг тус тус Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгодог.

Монгол Улсад тусгай зөвшөөрлийн дагуу галт зэвсэг, сум худалдах 2 төв, борлуулагч 10 /үүнээс 6 нь идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг/, спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд 3 /үүнээс 2 нь идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг/ байна.

Тухайн жилд импортлох галт зэвсэг, сумны төрөл, зориулалт, тоо хэмжээг Хууль зүйн сайд тогтоох бөгөөд борлуулагчаас галт зэвсэг, сумыг улсын хилээр нэвтрүүлэхэд тухай бүр тушаал гаргадаг байна.

ГЗТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэгт “Монгол Улсын хилээр нийтэд худалдах зорилгоор оруулсан иргэний зориулалттай галт зэвсгийг худалдан борлуулахаас өмнө шүүхийн шинжилгээний байгууллагад хүргүүлэн буудлага үйлдүүлж, сумны хонгио, хошууг нь мэдээллийн нэгдсэн санд авч бүртгүүлэх ажлыг цагдаагийн байгууллага зохион

байгуулна” гэсэн нь борлуулагчаас галт зэвсэг, сумыг улсын хилээр нэвтрүүлэхэд тавих хяналтын үндсийг бүрдүүлж байна.

Цагдаагийн байгууллага борлуулагчаас ирүүлсэн албан хүсэлт, улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, нэвтрүүлэх буу, сумны төрөл, загвар, тоог баталсан Хууль зүйн сайдын тушаал, эх сурвалжийн бичиг, нисэх буудлаас агуулах хүртэлх тээвэрлэлтийн замналыг хүлээн авч шүүхийн шинжилгээний байгууллагад хүргүүлж, шинжээчийн дүгнэлтийг авдаг. Уг ажлын үр дүнд улсын хилээр нэвтрүүлсэн галт зэвсэг, сумны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл санд бүртгэгдэж, цаашид хяналт тавих нөхцөл бүрдэж байна.

4.2 Борлуулагчаас иргэн, хуулийн этгээдэд худалдсан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл болон худалдан авагчийн талаарх мэдээллийг тухай бүр мэдээллийн санд бүртгэдэг болсноор худалдан борлуулах үе шатанд тавих цагдаагийн байгууллагын хяналт хялбар, шуурхай хэрэгжих боломжтой болсон.

ГЗТХ-ийн 17 дугаар зүйлд заасны дагуу иргэн, хуулийн этгээд нь борлуулагчаас галт зэвсэг худалдан авахад цагдаагийн байгууллагаас зөвшөөрөл олгож байгаа нь борлуулагчийн худалдах үйл ажиллагаанд тавих хяналтын нэг хэлбэр юм.

Иргэд өргөдөл, иргэний үнэмлэх, оршин суугаа газрын тодорхойлолт, эрүүл мэндийн тодорхойлолт, шүүхийн шинжилгээний байгууллагын тодорхойлолт, борлуулагчийн бүртгэлийн хуулбар, галт зэвсгийн аюулгүй ажиллагааны сургалтын гэрчилгээ зэрэг материалыг бүрдүүлэн хүсэлтээ цахимаар гаргана. Лицензийн төв баримт бичгийн иж бүрдэл, тухайн иргэний ял шийтгэлийн байдлыг шалгасны дараа олгосон зөвшөөрлийг үндэслэн борлуулагч нь галт зэвсгийг худалдаж байна.

Иргэн, хуулийн этгээд борлуулагчаас галт зэвсэг худалдан авахад тавих цагдаагийн байгууллагын хяналт нь үр нөлөөтэй хэрэгжиж байгаа ч иргэд хоорондын галт зэвсэг худалдах үйл явцад харьцангуй сул байгаа нь хяналт шинжилгээний явцад ажиглагдлаа. Өөрөөр хэлбэл худалдан авагчийн хувьд борлуулагчаас галт зэвсэг худалдан авах нь харьцангуй чирэгдэлтэй, цаг хугацаа шаардахаар байгаа нь тэднийг иргэдийн гар дээрээс бүртгэл, хяналтаас гадуур галт зэвсэг худалдан авах нөхцөлрүү түлхэх эрсдэлтэй байна.

4.3 Галт зэвсэг, сум худалдах төв, борлуулагч, спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэгчдийн мэдэлд буй галт зэвсэг, сум, адилтгах хэрэгслийн хадгалалт хамгаалалтын байдалд хяналт тавих үйл ажиллагааг Нийтийн хэв журам хамгаалах алба, Улаанбаатар хотын цагдаагийн газар, Лицензийн төв болон Эрүүгийн цагдаагийн газрын алба хаагчдын хамтарсан Ажлын хэсэг удирдамжийн хүрээнд хэрэгжүүлж байна.

Хамгийн сүүлд НХЖХА-ны даргын 2017 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр баталсан удирдамжийн дагуу дээр дурьдсан тусгай зөвшөөрөлтэй

аж ахуйн нэгж, байгууллагын бичиг баримт, ажлын болон агуулах байр, буудлага үйлдэх байгууламжийн нөхцөл байдал, худалдан борлуулсан галт зэвсэг, сумны бүртгэл судалгаа, үлдэгдэл, тэдгээрийн хадгалалт хамгаалалтанд үзлэг шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр үүрэг чиглэл өгч ажиллажээ.

Галт зэвсэг, сум борлуулагчдад хяналт тавих цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээний мөрөөр хэрэгжүүлбэл зохих санал, зөвлөмжийг тайлангийн САНАЛ, ЗӨВЛӨМЖ хэсэгт тусгав.

Тав. Монгол Улсын хилээр галт зэвсэг, сум, адилтгах хэрэгсэл нэвтрүүлэх зөвшөөрөл олгох цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээний талаар

Монгол Улсын хилээр галт зэвсэг, сум, адилтгах хэрэгсэл нэвтрүүлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд Галт зэвсгийн тухай хууль, Хууль зүйн сайд, Сангийн сайдын хамтарсан 2015 оны А/251, 304 дүгээр тушаалаар батлагдсан “Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл импортлох, худалдах болон спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээд галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх журам”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/74 дүгээр тушаалаар батлагдсан “Галт зэвсэг, сумыг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийн загвар”, “Гадаадын иргэн, тамирчид Монгол Улсын хилээр галт зэвсэг нэвтрүүлэх зөвшөөрлийн загвар”, “Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийн загвар” болон бусад эрх зүйн актыг мөрдөж байна.

Энэхүү хяналт шинжилгээний хүрээнд галт зэвсгийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийн бүртгэл, судалгаа, зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, зөвшөөрөл хүссэн баримт бичгийн иж бүрэн байдал болон хилээр нэвтрүүлсэн галт зэвсэгт хяналт тавих зэрэг асуудлуудыг хамрууллаа.

Галт зэвсгийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхтэй холбогдуулан Лицензийн төвөөс дараах 3 төрлийн зөвшөөрлийг олгож байна. Үүнд:

5.1 Монгол Улсын иргэн улсын хилээр галт зэвсэг нэвтрүүлэх зөвшөөрөл

ГЗТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт “Галт зэвсэг өмчлөх эрхтэй Монгол Улсын иргэн өөрөө өмчлөх зорилгоор энэ хуулиар хориглоогүй нэг галт зэвсгийг жилд нэг удаа улсын хилээр оруулах эрхтэй” гэж заасны дагуу иргэд хүсэлтээ холбогдох баримт бичгийг хавсарган цахим хэлбэрээр Лицензийн төв гаргаж, тус төвөөс хүсэлтийг хянан зөвшөөрөл олгож байна.

2016 онд нийт 222 иргэн хүсэлт гаргаснаас 119-ийг нь зөвшөөрч, 3-ыг нь татгалзан шийдвэрлэжээ. Дээрх баримт бичгүүдээс 25-ыг нь түүвэрлэн авч иж бүрдэл /хүсэлт, ял шалгах хуудас, иргэний үнэмлэх, хорооны тодорхойлолт, эрүүл мэндийн хуудас, галт зэвсгийн техник үзүүлэлт/-ийг нь шалгахад ямар нэг зөрчил дутагдал илрээгүй болно.

5.2 Спорт-уралдааны зорилгоор улсын хилээр галт зэвсэг нэвтрүүлэх зөвшөөрөл

Спорт-уралдааны зорилгоор галт зэвсэг, сумыг улсын хилээр нэвтрүүлэхэд тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд /Буудлагын холбоо/-ийн албан бичиг, гэрчилгээний хуулбарыг үндэслэн Лицензийн төвөөс зөвшөөрөл олгож байна.

2016 онд дээрх зорилгоор нийт 22 зөвшөөрөл олгосон байх бөгөөд тэдгээрт холбогдох баримт бичгийн иж бүрдлийг шалгахад ямар нэг зөрчил, дутагдал илрээгүй болно.

5.3 Гадаад улсын иргэн улсын хилээр галт зэвсэг нэвтрүүлэх зөвшөөрөл

Гадаад улсын иргэн ан агнах зорилгоор Монгол Улсын хилээр галт зэвсэг нэвтрүүлэх зөвшөөрлийг ан агнах тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийн дагуу Лицензийн төвөөс олгож байна.

2016 онд дээрх зорилгоор нийт 118 зөвшөөрөл олгосон байх бөгөөд тэдгээрээс 21-т нь холбогдох баримт бичгийн иж бүрдэл /хуулийн этгээдийн хүсэлт, гэрчилгээний хуулбар, улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт (галт зэвсэг тус бүрт 225000 төгрөг), ан агнах зөвшөөрөл (хүн тус бүрт), гадаадын иргэдийн паспортын хуулбар/-ийг шалгахад ямар нэг зөрчил, дутагдал илрээгүй.

Дээрх зорилгоор Монгол Улсын хилээр нэвтэрсэн галт зэвсгийг буцаж хилээр гарсан эсэхэд гаалийн байгууллагаас улирал тутам мэдээ авч тулгах байдлаар хяналт тавьж байна.

Галт зэвсэг, сум, адилтгах хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээний мөрөөр хэрэгжүүлбэл зохих санал, зөвлөмжийг тайлангийн САНАЛ, ЗӨВЛӨМЖ хэсэгт тусгав.

Зургаа.Иргэний болон харуул, хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтын зааврын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний талаар

Цагдаагийн байгууллагаас иргэний болон харуул, хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалт /цаашид галт зэвсгийн сургалт гэх/-ыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг Галт зэвсгийн тухай хууль, Сангийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан “Сургалтын төлбөрийн хэмжээ,

зардлын норматив батлах тухай” 2016 оны 14, А/10 дугаартай тушаал, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/72 дугаар тушаалаар батлагдсан “Иргэний болон харуул, хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтын заавар”, 2016 оны “Загвар батлах, зааварт нэмэлт оруулах тухай” А/14 дүгээр тушаал, “Зааварт нэмэлт оруулах тухай” А/59 дүгээр тушаал, Б/105 дугаар тушаалаар батлагдсан “Иргэний болон харуул, хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтын төлөвлөгөө” болон бусад эрх зүйн актаар зохицуулж байна.

Энэхүү хяналт шинжилгээний хүрээнд галт зэвсгийн сургалт батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу явагдаж буй эсэх, сургалтын агуулга нь зааварт заасан шаардлагыг хангаж буй эсэх, сургалтад хамрагдсан болон Зааврийн 4.2 дахь хэсэгт заасны дагуу сургалтад хамрагдалгүй гэрчилгээ авсан иргэдийн бүрдүүлсэн баримт бичгийн иж бүрдэл болон бусад асуудлуудыг хамрууллаа.

2015 онд батлагдсан Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар галт зэвсэг өмчлөх иргэн нь галт зэвсгийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх, уг сургалтыг цагдаагийн байгууллагаас зохион байгуулах тухай зохицуулалт шинээр хийгдсэн. Галт зэвсгийн сургалтын гэрчилгээг дараах 2 хэлбэрээр иргэдэд олгож байна. Үүнд:

6.1 Галт зэвсгийн сургалтад хамрагдсан иргэд

Үүний дагуу 2016 онд Сургалтын төвд 14 удаагийн сургалтад 548 иргэн, Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газарт 2 удаагийн сургалтад 29 иргэн, Орхон аймаг дахь цагдаагийн газарт 1 удаагийн сургалтад 49 иргэнийг хамруулан тус тус зохион байгуулжээ. Орон нутагт галт зэвсгийн сургалтыг зохион байгуулахад Сургалтын төвөөс мэргэжилтэн томилж оролцуулах, шаардлагатай сургалтын болон шалгалтын материал, гарын авлага, сургалттай холбогдуулан гарах тушаал шийдвэрийн төслийг хүргүүлж хамтран ажилладаг байна.

2016 онд сургалтад хамрагдсан иргэдийн материалаас 25-ыг түүвэрлэн авч баримт бичгийн иж бүрдэл /өргөдөл, иргэний үнэмлэх, хорооны тодорхойлолт, эрүүл мэндийн хуудас сургалтын төлбөр 150000 төгрөг төлсөн баримт/-ийг шалгахад ямар нэг зөрчил илрээгүй.

Галт зэвсгийн сургалтын зааварт сургалтыг танхимийн 2, дадлагын 1, нийт 3-аас доошгүй хоногийн хугацаатай явуулахаар тусгасан бол Сангийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2016 оны 14, А/10 тушаалаар сургалтыг 2 өдөрт багтаан зохион байгуулахаар зохицуулсан нь хоорондоо зөрчилдөж байна. Сургалтын төвд сургалтыг 2 өдөрт багтаан зохион байгуулж байгаа бөгөөд сургалтын агуулга, сэдэв нь зааварт заасан шаардлагыг хангаж байна.

Түүнчлэн дээрх тушаалаар нэг иргэнд зарцуулах сумны тоог 25 гэж

тогтоосон боловч Санхүү, хангамжийн газраас сургалтад шаардлагатай сумыг бүрэн шийдвэрлэж олгодоггүйгээс нэг суралцагч 8 сумаар буудлага үйлддэг талаар ажил хариуцсан алба хаагчид тайлбарлаж байна.

6.2 Урьд өмнө галт зэвсгийн чиглэлээр сургалтад хамрагдсан иргэд

Цагдаагийн ерөнхий газрын даргын “Зааварт нэмэлт оруулах тухай” 2016 оны А/59 дүгээр тушаалаар галт зэвсгийн сургалтад хамрагдсаныг нотлох дараах бичиг баримттай иргэдэд гэрчилгээний үнэ /5000 төгрөг/-ийг төлүүлэн сургалтын гэрчилгээг олгож болохоор зохицуулсан. Үүнд:

- Буудлага спортын холбооны тодорхойлолт /Буудлага спортын холбооны улсын бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбар/
- Цэрэг, цагдаагийн сургууль /галын бэлтгэлд хамрагдсан/ төгссөн диплом, дипломын хавсралт
- Зэвсэгт хүчин, хил хамгаалах, цагдаа, тагнуул, тахар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тусгай албадын албан байгууллагын тодорхойлолт
- Гэрээт харуул хамгаалалтын сургалтад хамрагдсаныг нотлох гэрчилгээ.

Энэхүү зохицуулалтын дагуу 2016 онд Сургалтын төвөөс 111 иргэн, Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газраас 11 иргэнд тус тус гэрчилгээ олгосон байна. Дээрх иргэдийн бүрдүүлсэн материалаас 25-ыг түүвэрлэн авч танилцахад 2 иргэний галын бэлтгэлийн сургалтад хамрагдаж байсныг гэрчлэх баримт бичиг, тодорхойлолт нь шаардлага хангахааргүй байлаа.

Цаашид зааврын энэхүү зохицуулалтыг илүү тодорхой нарийвчлахгүй бол иргэд ердийн журмаар галт зэвсгийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авахаас зайлсхийх, эсхүл хуульд заасан шаардлагыг хангахгүй иргэд сургалтын гэрчилгээ авах эрсдэл өсөж болзошгүй байна.

Иргэний болон харуул, хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтын зааврын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний мөрөөр хэрэгжүүлбэл зохих санал, зөвлөмжийг тайлангийн САНАЛ, ЗӨВЛӨМЖ хэсэгт тусгав.

Долоо.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны журмын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний талаар

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед хамгаалалт хийх, хяналт тавих цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, “Аюултай ачаа техникийн ерөнхий шаардлага MNS 4978:2003”, “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598:2003”, “Овор ихтэй, урт, хүнд ачааны

тээвэрлэлт, ангилал, ерөнхий шаардлага MNS 5345:2003” стандартууд, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 188 дугаар тушаалаар батлагдсан “Автотээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам”, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга нарын хамтарсан 2015 оны А/32, 231 дүгээр тушаалаар батлагдсан “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны журам” болон бусад эрх зүйн актаар зохицуулж байна.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих хүрээнд цагдаагийн байгууллагаас дараах 3 төрлийн үйл ажиллагааг явуулж байна.

7.1 Санал өгөх

ТДБТХЭХТТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т заасны дагуу тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгахад холбогдох яам нь цагдаагийн байгууллагаас санал авч байна. Аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Лицензын төв нь холбогдох материалыг шалгаж, Эрүүгийн цагдаагийн газраас саналыг авч нэгтгэн, саналаа УУХҮЯ-нд албан бичгээр хүргүүлж байна.

2016 онд тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахаар нийт 60 хүсэлт хүлээж авснаас 32-ыг нь дэмжих, 28-ыг нь татгалзах саналтайгаар хариуг хүргүүлжээ.

7.2 Тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгох

ТДБТХЭХТТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1-т заасны дагуу аюултай ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслийн зөвшөөрлийг цагдаагийн байгууллагаас олгож байна. 2016 онд Лицензийн төв нийт 255 тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл хүссэн материал хүлээж авснаас 195-ыг зөвшөөрч, 60-ыг нь татгалзан шийдвэрлэжээ.

Тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл хүссэн 9 материалыг түүвэрлэн авч иж бүрдэл /ААН-ын албан бичиг, улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, жолоочийн иргэний болон жолооны үнэмлэх, тэсэлгээний болон харьцах эрхийн үнэмлэх, эрүүл мэндийн хуудас, жолоочийн хариуцлагын даатгал, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, татварын гэрчилгээ, оношилгооны хуудас, автотээврийн улсын байцаагчийн дүгнэлт, тээврийн хэрэгслийг шалгасан хүснэгт, тээврийн хэрэгслийн зураг/-тэй танилцахад ямар нэг зөрчил дутагдал илрээгүй.

7.3 Тээвэрлэлтийн үед хамгаалалтын үүрэг гүйцэтгэх

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх үед тээвэрлэх маршрутыг Лицензын төв баталж, хамгаалалтыг ОНАБХА-ны дарга тухайн аж ахуйн нэгжтэй байгуулсан “Хамгаалалтын гэрээ”-ний үндсэн дээр Хамгаалалтын 3 дугаар газраас зохион байгуулж байна.

Хуулийн этгээд нь тээвэрлэлтийн маршрутаа eis.police.gov.mn

хаягаар дамжуулан цахим хэлбэрээр Лицензийн төвд хүргүүлж, батлагдсан маршрутыг биеэр ирж авдаг. 2016 онд нийт 1089 маршрутыг баталсан байна.

ОНАБХА-наас 2016 онд нийт 24 аж ахуйн нэгжтэй Хамгаалалтын гэрээ байгуулан хамтран ажиллажээ. Тус гэрээний загварыг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2009 оны 478 дугаар тушаалаар баталсан. Гэрээний хавсралт “Хамгаалалтын ажил, үйлчилгээний төсөв”-ийг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, хангамжийн газрын дарга, тухайн аж ахуйн нэгжийн удирдлагатай хамтран баталж байна.

Нэг хамгаалалтын төлбөр нь 85000 төгрөг, үүнээс 60000 нь хамгаалалтын үйлчилгээний хөлс /1 алба хаагч/, 20000 нь удирдлагын зардал байна. Мөн хамгаалалтад үүрэг гүйцэтгэж буй алба хаагчийн хоол, холбооны зардлыг хоног тутамд 20000 төгрөгөөр тогтоож, тухайн алба хаагчид бэлнээр өгч байхаар гэрээнд тусгажээ.

Хамгаалалтын гэрээ, батлагдсан маршрут, тухайн аж ахуйн нэгжийн хүсэлтийг үндэслэн Хамгаалалтын 3 дугаар газраас хамгаалалт тус бүрт алба хаагчийг тушаалаар томилон үүрэг гүйцэтгүүлж, хяналт тавин ажиллаж байна. 2016 онд нийт 966 удаагийн тээвэрлэлтэд 1084 алба хаагч үүрэг гүйцэтгэж ажиллажээ.

Хамгаалалтын 3 дугаар газраас үүрэн холбооны ЖиМобайл компанитай хамтран хоорондоо үнэгүй харилцах боломжтой 500 гар утсаар алба хаагчдыг хангасан, тухайн гар утсанд суурилан хамгаалалтын үйл ажиллагаанд ашиглагдах програм хангамжийг нэвтрүүлсэн нь хамгаалалтын үеийн шуурхай удирдлага, хяналтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой болжээ.

Цаг үеийн нөхцөл байдал, тухайн аж ахуйн нэгж, тээврийн хэрэгслийн үйл ажиллагаа, бэлэн байдлыг харгалзан хамгаалалтыг уян хатан зохион байгуулах, нөөц маршруттай байх, хяналт тавих зэргээр хамгаалалтыг гардан зохион байгуулдаг нэгж буюу Хамгаалалтын 3 дугаар газар нь тээвэрлэлтийн маршрутыг баталдаггүй нь учир дутагдалтай байна.

Түүнчлэн хамгаалалтын төлбөрийн хэмжээг тогтоосон албан ёсны шийдвэргүй, гагцхүү гэрээгээр тохиролцон зохицуулж байгаа цаашид шийдвэрлэх шаардлагатай нь харагдаж байна.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед хамгаалалт хийх, хяналт тавих цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээний мөрөөр хэрэгжүүлбэл зохих санал, зөвлөмжийг тайлангийн САНАЛ, ЗӨВЛӨМЖ хэсэгт тусгав.

Найм.Дүгнэлт

Улсын нэгдсэн санд бүртгэлтэй эрх зүйн актын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний хүрээнд олон нийтийн цагдаа, галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй холбоотой цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан нийт 7 төрлийн эрх зүйн акт, үйл ажиллагааг хамрууллаа.

Дээрх эрх зүйн актуудыг хэрэгжүүлэхэд цагдаагийн байгууллагаас шаардлагатай баримт бичгүүдийг боловсруулан баталж мөрдүүлсэн, хариуцсан нэгж, алба хаагчийн эрх хэмжээг тодорхойлсон, хүний нөөцийг сургаж дадлагажуулсан, бүртгэл, судалгаа, мэдээллийн санг бүрдүүлж ашигласан, үйл ажиллагааны урсгал, шат дамжлагыг тодорхойлж хэвшүүлсэн зэргийг харгалзан улсын нэгдсэн санд бүртгэлтэй эрх зүйн актыг хэрэгжүүлэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг “Сайн” гэж үнэллээ.

Дээрх үнэлгээнд үзүүлэх нөлөөлөл харьцангуй бага ч цаашид цагдаагийн байгууллага, нэгжээс зайлшгүй анхаарвал зохих дараах асуудлуудыг хяналт шинжилгээний явцад тодорхойллоо. Үүнд:

8.1 Олон нийтийн цагдаагийн чиглэлээр:

- УБХЦГ-ын хэмжээнд олон нийтийн цагдаатай холбоотой бүртгэл, судалгаа мэдээлэл сайн хийгдсэн ч улсын хэмжээнд дээрх мэдээллийг нэгтгэж, дүн шинжилгээ хийх ажлыг НХЖХА-нд эрчимжүүлэх шаардлагатай.
- Олон нийтийн цагдаа нарын нас, хүйсийн харьцаа цагдаагийн ажил, мэргэжлийн онцлог, шаардлагын үүднээс ухарсан статистик үзүүлэлттэй.
- Нэр бүхий аймгуудад олон нийтийн цагдаатай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй, одоо болтол олон нийтийн цагдааг томилж ажиллуулаагүй байна.
- Олон нийтийн цагдаа нар тогтвор суурьшилгүй ажилладаг, ажлын үр дүн хүссэн хэмжээнд хүрэхгүй байна.
- Хөдөлмөрийн гэрээ цуцалсан олон нийтийн цагдаатай хувцасны тооцоо хийж, эдэлгээний зөрүүг төлүүлэх ажил маш хангалтгүй хэрэгжиж байна.

8.2 Галт зэвсгийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр:

- Зарим аймаг, орон нутагт галт зэвсгийн гэрчилгээ олгохтой холбогдуулан бүртгэл судалгаа хөтлөх, материалыг бүрэн бүрдүүлэх, мэдээллийн санг ашиглан шилжилт хөдөлгөөнийг шуурхай зохион байгуулах ажил дутагдалтай байна.
- Зарим хууль тогтоомжийн зохицуулалт, бусад байгууллагын үйл ажиллагаа нуугдмал галт зэвсгийг илрүүлэн бүртгэл, хяналтанд авах цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.
- Галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл /хийн буу/-ийг бүртгэл, хяналтад авахад нэмэлт зохицуулалт, зохион байгуулалтын арга хэмжээ авах зайлшгүй шаардлага байна.
- Зарим төрийн байгууллагаас байлдааны зориулалттай галт зэвсгийг алба хаагчиддаа бэлэглэх, цагдаагийн байгууллагад галт зэвсгийг хөнөөх чадваргүй болгох мэргэжилтэн байхгүй зэрэг нь холбогдох хууль

тогтоомжийг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна.

- Иргэд борлуулагчаас галт зэвсэг, сум худалдаж авах үйл ажиллагаа нь цагдаагийн байгууллагын бүртгэл, хяналтан дор явагдаж байгаа ч иргэд хоорондын галт зэвсэг, сумны худалдааг хянах боломж, зохицуулалт хязгаарлагдмал байна.

- Галт зэвсгийн аюулгүй ажиллагааны сургалтыг орон нутагт / Өвөрхангай, Орхон аймгаас бусад/ тодорхой шалтгааны улмаас зохион байгуулдаггүй нь иргэдэд хүндрэл бэрхшээл үүсгэх, улмаар цагдаагийн байгууллагаас хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэхэд түвэгтэй байдал үүсгэж байна.

- Галт зэвсгийн сургалтын зааварт сургалтын төлбөрийг гагцхүү сургалтад зарцуулахаар заасан боловч бодит байдал дээр сургалтад шаардлагатай сум, зардлыг шийдвэрлэх асуудалд бэрхшээл учирч байна.

- Галт зэвсгийн чиглэлээр урьд нь сургалтад хамрагдсан болон зарим байгууллагын тодорхойлолтыг үндэслэн галт зэвсгийн сургалтын гэрчилгээг олгох тухай зохицуулалтыг улам нарийвчлахгүй бол иргэд ердийн журмаар галт зэвсгийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авахаас зайлсхийх, эсхүл хуульд заасан шаардлагыг хангахгүй иргэд сургалтын гэрчилгээ авах эрсдэлтэй байна.

8.3 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих чиглэлээр:

1. Тээвэрлэлтийн үеийн хамгаалалтын үйл ажиллагааг гардан хэрэгжүүлдэг нэгж нь хамгаалалтын маршрутыг баталдаггүй байдал нь болзошгүй нөхцөл байдалд хамгаалалтыг шуурхай удирдан зохион байгуулах, хяналт тавих, нууцлал, бэлэн байдлыг хангахад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

2. Хамгаалалтын ажил, үйлчилгээний хөлсийг тээвэрлэлтийн зай, хугацааг харгалзан ялгамжтай байдлаар тогтоож, эрх бүхий байгууллагын шийдвэрээр батлуулах нь зүйтэй.

3. Тээвэрлэлтийн үеийн хамгаалалтад учирч болзошгүй эрсдэл, цаг үеийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг харилцан солилцож хамтарч ажиллах чиглэлээр Хамгаалалтын 3 дугаар газар, Эрүүгийн цагдаагийн газар болон бусад холбогдох нэгжүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх нь зүйтэй.

4. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавихтай холбоотой Лицензийн төвийн архивын баримт бичгийн бүртгэл, хөтлөлтөд зарим зөрчил дутагдал байсан.

Ес.Санал, зөвлөмж

Энэхүү тайланг Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, хяналт шинжилгээний явцад цугларсан мэдээлэл, баримт бичиг, тайлангийн дүгнэлтэд үндэслэн улсын нэгдсэн

санд бүртгэлтэй эрх зүйн актыг хэрэгжүүлэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр дараах зөвлөмжийг холбогдох нэгжүүдэд хүргүүлэх саналтай байна. Үүнд:

Санхүү, аж ахуйн албанд:

- Сангийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан “Сургалтын төлбөрийн хэмжээ, зардлын норматив батлах тухай” 2016 оны 14, А/10 дугаартай тушаал, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/72 дугаар тушаалаар батлагдсан “Иргэний болон харуул, хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтын заавар”-ын 5.2-т заасныг баримтлан сургалтад шаардлагатай зардлыг тухай бүр шуурхай, бүрэн шийдвэрлэж ажиллах
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх үеийн цагдаагийн хамгаалалтын ажил, үйлчилгээний хөлсийг тээвэрлэлтийн зай, хугацааг харгалзан ялгамжтай, мөнгөний ханшийн өсөлттэй уялдуулан боловсруулж, эрх бүхий этгээдийн шийдвэрээр батлуулах арга хэмжээ авах

Эрүүгийн цагдаагийн албанд:

- Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/75 дугаар тушаалаар батлагдсан “Галт зэвсгийн гэрчилгээ олгох журам”-ын 3.8-д заасны дагуу эрэн сурвалжлагдаж байгаа галт зэвсгийн талаарх мэдээллийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад шуурхай хүргэж, эх сурвалж нь тодорхойгүй галт зэвсгийн талаар цагдаагийн байгууллагаас ирүүлсэн лавлагааны хүсэлтийг шуурхай хангаж ажиллах
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх үеийн цагдаагийн хамгаалалтын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээллийг Хамгаалалтын 3 дугаар газартай солилцон хамтарч ажиллах

Нийтийн хэв журам хамгаалах албанд:

- Шинэчлэн боловсруулагдаж буй Олон нийтийн цагдаагийн дүрэм, хувцасны журамд “Улсын нэгдсэн санд бүртгэлтэй эрх зүйн актын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний тайлан”-д дурьдсан асуудлуудыг шийдвэрлэх зохицуулалтыг тодорхой тусгаж оруулах
- Олон нийтийн цагдаад холбогдох бүртгэл, судалгаа, тоон мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэн боловсруулах, түүнд дүн шинжилгээ хийх ажлыг эрчимжүүлэх
- Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын галт зэвсгийн асуудал хариуцсан алба хаагчдыг хамруулан хууль тогтоомжийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, галт зэвсгийн мэдээллийн санг ашиглах чиглэлээр давтан сургалт зохион байгуулах
- Галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл /хийн буу/-ийг бүртгэл, хяналтад авахад шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх,

зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх

- Галт зэвсгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч, хуулийн хэрэгжилтийг хангах

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанд:

- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих цагдаагийн байгууллагын мэдээллийн сан дахь Хамгаалалтын гэрээ, Хамгаалалтад ажилласан алба хаагчдын талаарх бүртгэл мэдээллийн баяжилтыг бүрэн хийх

- Хамгаалалтын гэрээний загварыг тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хамаарах бүх талууд /импортлогч, тээвэрлэгч, хүлээн авагч г.м/-ын оролцоог хангаж, эрх, үүргийг зохицуулсан байхаар шинэчлэн боловсруулж батлуулах

Иргэдэд үйлчлэх төвд:

- Галт зэвсэгтэй холбоотой цагдаагийн байгууллагын бүртгэл, зөвшөөрөл, хяналтын бүхий л үйл ажиллагааны чиглэлээр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, дэмжлэг үзүүлэх, хүний нөөцийг чадавхижуулах арга хэмжээ авах

- Галт зэвсэгтэй холбоотой цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хамаарах тоон мэдээлэл, судалгааг улсын хэмжээнд нэгтгэж тайлагнах, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангаж ажиллахад анхаарах

- Ажахуйн нэгжээс тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй холбоотой тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахаар ирүүлсэн хүсэлтийн хүрээнд саналаа боловсруулахдаа “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих /Код 606/ журам”-ын 606.3.2-т заасны дагуу Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны саналыг авч байх

- Тээвэрлэлтийн маршрутыг батлах үүргийг Олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба /Хамгаалалтын 3 дугаар газар/-нд шилжүүлэх боломж, хэрэгцээ шаардлагыг холбогдох нэгжүүдтэй хамтран судалж шийдвэрлэх

- Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй холбоотой бүртгэл, зөвшөөрөл, хяналтын үйл ажиллагааны явцад цугларсан баримт бичгийг холбогдох заавар, журмын шаардлагад нийцүүлэн архивлах, хяналт шинжилгээний явцад илэрсэн дутагдлыг арилгах

Сургалтын нэгдсэн төвд:

- Орон нутагт олон нийтийн цагдаа бэлтгэх, галт зэвсгийн аюулгүй ажиллагааны сургалтыг зохион байгуулахад тус төвөөс шаардлагатай

бүхий л дэмжлэг туслалцааг үзүүлж, хамтран ажиллах

- Олон нийтийн цагдаагийн давтан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага дахь сургагч багш нараар дамжуулан сургалтыг зохион байгуулах

- Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагуудын хэрэгцээ, саналыг харгалзан олон нийтийн цагдаа бэлтгэх сургалтыг тухайн орон нутагт нь бүсчлэн зохион байгуулах боломжийг судалж явуулах

- Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/72 дугаар тушаалаар батлагдсан “Иргэний болон харуул, хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтын заавар”-ын 4.2 дахь хэсэгт өөрчлөлт оруулах үндэслэл, төслийн саналаа холбогдох нэгжид хүргүүлж шийдвэрлүүлэх

- Орон нутагт зохион байгуулагдаж буй олон нийтийн цагдаа бэлтгэх, галт зэвсгийн аюулгүй ажиллагааны сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, эдгээр сургалттай холбоотой дүн мэдээ, тайланг улсын хэмжээнд нэгтгэн, удирдлагыг мэдээллээр хангах ажлыг сайжруулах

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад:

- Олон нийтийн цагдаагийн үйл ажиллагаа, ач холбогдлыг Нутгийн удирдлагын байгууллагад сурталчилж, дэмжүүлэх, олон нийтийн цагдааг бий болгох, дутуу орон тоог нөхөх талаар идэвхи санаачлагатай ажиллаж, үр дүн гаргах

- Олон нийтийн цагдаа бэлтгэх сургалтыг орон нутагтаа зохион байгуулахад шаардлагатай бэлтгэлийг хангаж, хэрэгцээ шаардлагын хүрээнд сургалтыг зохион байгуулах

- Олон нийтийн цагдаагийн ажлын үр дүн, бүтээмжийг нэмэгдүүлэх, тэдний үйл ажиллагааг цагдаагийн үндсэн бүрэлдэхүүнээс дэмжиж хамтран ажиллах, давтан сургах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах

- Галт зэвсгийн бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг мэдээллийн санд шуурхай хэрэгжүүлж, энэ чиглэлээр мэдээлэл солилцох хамтын ажиллагааг эрчимжүүлэх

- Галт зэвсгийн бүртгэлтэй холбоотой мэдээллийн сангийн алдаа, давхардлыг илрүүлэхэд санаачлагатай хандаж, түүнийг залруулах саналаа тухай бүр Иргэдэд үйлчлэх төвд хүргүүлж шийдвэрлүүлэх

- Галт зэвсэгтэй холбоотой аливаа зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийн иж бүрдлийг бүрэн хангах, тэдгээрийг архивлан хадгалах үйл ажиллагааг холбогдох заавар, журмын шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэх

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБАНЫ
СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2017.10.30

Улаанбаатар хот

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын талаар

“Цагдаагийн байгууллагын 2017 оны хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөө”, Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Н.Батзогсох, мөн хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх бид цагдаагийн байгууллагын албаны сургалтын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн актуудын хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч, тэдгээрийн хэрэгжилтийг сайжруулж, боловсронгуй болгох чиглэлээр зөвлөмж боловсруулах зорилгоор энэхүү хяналт шинжилгээг хийлээ.

Хяналт шинжилгээг 2017 оны 09 дүгээр сарын 06-наас 10 дугаар сарын 09-ний хооронд Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтэс, Гадаад харилцааны хэлтэс, Сургалтын нэгдсэн төв, Мэдээллийн технологи, холбооны төв болон Хууль сахиулахын их сургуульд ажиллан холбогдох алба хаагчидтай уулзалт ярилцлага зохион байгуулах, шаардлагатай баримт бичиг, үйл ажиллагаатай газар дээр нь танилцах хэлбэрээр хийж гүйцэтгэлээ.

Цагдаагийн байгууллагын хүний нөөцийг сургаж бэлтгэх, албаны сургалтын үйл ажиллагааг зохицуулсан дараах эрх зүйн акт, баримт бичгүүдийн зохицуулалтыг хяналт шинжилгээний ажлын шалгуур болгон ашиглалаа. Үүнд:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн мэргэшсэн алба хаагч бэлтгэх, мэргэшлийг дээшлүүлэх хөтөлбөр”, “ХСИС-ийн Цагдаагийн сургуульд суралцагч элсүүлэн суралцуулах журам”, 2017 оны А/45 дугаар тушаалаар батлагдсан “Гадаадын их дээд сургуульд хууль сахиулах байгууллагын алба хаагчийг сонгон шалгаруулах, суралцуулах журам”, ЦЕГ-ын даргын 2015 оны Б/164 дүгээр тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг”, 2017 оны А/179 дүгээр тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагад ажиллах иргэнд тавигдах тусгай шаардлага, шалгуур үзүүлэлт тооцох журам”, 2016 оны Б/257 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын сургалтын хөтөлбөр /2016-2019/” болон “Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх /Код 118/ журам”, “Ажлын байрны сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх /Код 239/ журам”, “Гадаадад суралцагчид санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх /Код 808/ журам”, “Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх /Код 900/

журам”, “Профессор-багш ажиллуулах /Код 943/ журам”, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох /Код 944/ журам”, “Гадаадад суралцагчийг сонгон шалгаруулах /Код 946/ журам”, “Алба хаагчийг мэргэшлийн зэргийн сургалтад хамруулах, шалгалт авах /Код 948/ журам”, “Сургагч-багшийг бэлтгэх, чадавхижуулах, үнэлэх /Код 950/ журам”, “Алба хаагчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах /Код 951/ журам”, ЦЕГ, ХСИС-ийн хооронд 2013 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр байгуулсан “Хамтран ажиллах санамж бичиг” болон бусад.

Хоёр.Цагдаагийн албаны сургалтын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, нөхцөл байдал

Цагдаагийн байгууллагын албаны сургалтын үйл ажиллагааг ЦЕГ-ын Хүний нөөц, сургалтын хэлтэс, Гадаад харилцааны хэлтэс, Сургалтын нэгдсэн төв болон бусад цагдаагийн байгууллага, нэгжүүд хууль, журамд заасны дагуу хариуцан хэрэгжүүлдэг.

Ингэхдээ Хүний нөөц, сургалтын хэлтэс нь албаны сургалтын бодлого, стратегийг боловсруулж хэрэгжүүлэх, сургалтын үйл ажиллагааг цагдаагийн байгууллагын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үнэлгээ шинжилгээ хийх, нэгдсэн бүртгэл судалгаа хөтлөх болон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй байна.

Сургалтын нэгдсэн төв нь цагдаагийн албаны давтан, мэргэшүүлэх, ур чадварын сургалт болон хууль тогтоомжид заасан бусад сургалтыг байгууллагын хэрэгцээ шаардлагад үндэслэн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэрээр зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй.

Гадаад харилцааны хэлтэс нь байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагаанд суурилан богино хугацааны гадаад сургалт, гадаадаас сургагч багш урьж оролцуулан явагдах аливаа сургалтуудыг хариуцан зохион байгуулж байна.

Бусад цагдаагийн байгууллага нь нэгжийн хэмжээнд алба хаагчдын сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, ажлын байран дахь сургалтыг зохион байгуулах, бүртгэл судалгаа хөтлөх зэрэг үүргийг хэрэгжүүлж байна.

Цагдаагийн байгууллагын хүний нөөцийг бэлтгэх болон албаны сургалтын үйл ажиллагааг ерөнхийд нь гадаад болон дотоод сургалт гэж 2 ангилж болно.

2.1 Гадаад сургалт:

Цагдаагийн алба хаагчдыг бакалавр, магистр, докторын түвшний болон удирдлагын сургалтад Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Турк Улсад сурган бэлтгэж байна. ХНСХ-ийн судалгаанаас үзвэл 1998 оноос хойш БНТУ-д нийт 87 иргэнийг сонгон шалгаруулж сургасан бол 2001 оноос хойш ОХУ-ын нэр бүхий сургуулиудад нийт 215 иргэн, алба хаагчийг зохих түвшний сургалтуудад хамруулан бэлтгэжээ.

Түүнчлэн гадаад улс орнуудын ижил чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн сургалт, гадаад арга хэмжээнд 2016 онд давхардсан тоогоор 219 алба хаагчийг, 2017 оны эхний хагас жилд 34 алба хаагчийг тус тус хамруулжээ.

Мөн гадаад орны хамтын ажиллагаатай байгууллагатай хамтран сургагч багш урьж 2016 онд 5, 2017 оны 10 сарын байдлаар 5 богино хугацааны сургалтыг дотооддоо зохион байгуулж, цагдаагийн алба хаагчдыг хамруулсан байна.

2.2 Дотоод сургалт:

2.2.1 Цагдаагийн мэргэжлийн сургалт

Цагдаагийн мэргэжлийн сургалт буюу цагдаагийн байгууллагад анх орж ажиллах ахлагч бүрэлдэхүүний сургалтыг ХСИС-ийн Ахлагчийн сургуульд 3 сарын хугацаатай зохион байгуулж байна.

Дээрх сургалтад хамрагдах иргэдийн сонгон шалгаруулалтыг ЦЕГ-ын ХНСХ-ээс зохион байгуулж, төгсөгчдийг цагдаагийн байгууллагын хүний нөөцөд бүртгэн томилж байна.

2012-2016 оны хичээлийн жилүүдэд ХСИС-ийн Ахлагчийн сургуулийг төгссөн иргэдийн тоон судалгааг харуулбал дараах байдалтай байна.

2012-2013	2013-2014	2014-2015	2015-2015	2016-2017	Нийт
211	238	316	340	406	1511

Түүнчлэн ЦЕГ-ын даргын 2014 оны 706 дугаар тушаалын дагуу Сургалтын нэгдсэн төвд цагдаагийн мэргэжлийн дамжааг 3 сарын хугацаатай зохион байгуулж, 53 иргэнд цагдаагийн мэргэжлийн үнэмлэх олгожээ.

2.2.2 Бакалаврын сургалт

Цагдаагийн байгууллагын офицер бүрэлдэхүүний хүний нөөцийн гол эх сурвалж нь ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн төгсөгчид бөгөөд тэднийг Хууль зүйн сайдын 2016 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/146 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн мэргэшсэн алба хаагч бэлтгэх, мэргэшлийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн дагуу өдөр 2.5+(2)+1.5 жил ба 1+(1)+1 жил, эчнээ 3 жил /их, дээд сургууль төгссөн элсэгчид/ болон 5 жил /бүрэн дунд боловсролтой элсэгчид/-ийн хөтөлбөрөөр бэлтгэж байна.

2017-2018 оны хичээлийн жилд ХСИС-ийн цагдаагийн бакалаврын түвшний сургалтад нийт 1169 сонсогч суралцаж байгаагаас өдрийн ангид 31, эчнээ ангид 39 эмэгтэй сонсогч байна.

Хөтөлбөрийн нэр	Суралцагчдын тоо					
	I дамжаа	II дамжаа	III дамжаа	IV дамжаа	V дамжаа	Нийт
Цагдаа-хууль сахиулах ажил /өдөр/	151	179	188	173		691
Цагдаа-хууль сахиулах ажил /эчнээ 3 жил/	88	75	38			201
Цагдаа-хууль сахиулах ажил /эчнээ 5 жил/	30	69	64	50	64	277
Нийт	269	323	290	223	64	1169

2.2.3 Магистр, доктор болон удирдлагын сургалт

2017 оны байдлаар цагдаагийн алба хаагчдыг ОХУ-ын зарим сургуулиуд, Монгол Улсын ХСИС болон бусад сургуульд магистр, доктор, удирдлагын түвшний сургалтад хамруулан бэлтгэж байна.

ХСИС-ийн магистрантурын сургалтад 2013 оноос хойш нийт 176 цагдаагийн албан хаагч элсэн суралцсанаас 84 нь магистрын зэрэг хамгаалж, үлдсэн алба хаагчдын сургалт үргэлжилж байна.

Харин тус сургуулийн докторантурын сургалтад 2013 оноос хойш нийт 30 цагдаагийн албан хаагч элсэн суралцсанаас одоогоор аль нь ч докторын зэрэг хамгаалаагүй байна. Эдгээр мэдээллийг сүүлийн 5 жилийн байдлаар дэлгэрэнгүй үзүүлбэл:

Хөтөлбөрийн нэр	ХСИС-ийн магистр, докторын сургалтад хамрагдсан цагдаагийн албан хаагчдын тоон судалгаа											
	2013		2014		2015		2016		2017		Нийт	
	Элссэн	Төгссөн	Элссэн	Төгссөн	Элссэн	Төгссөн	Элссэн	Төгссөн	Элссэн	Төгссөн	Элссэн	Төгссөн
Магистр	33		18		32	30	65	25	28	29	176	84
Доктор	7				16		7				30	0

ХСИС-ийн Удирдлагын сургуулийн цагдаагийн стратеги-тактик удирдлагын мэргэжлийн болон хууль сахиулах удирдлагын магистрын хос диплом олгох сургалтанд 2012 оноос хойш нийт 27 цагдаагийн албан хаагч байгууллагын захиалгаар элсэн суралцсанаас 19 нь төгсөж, 8 хүний сургалт үргэлжилж байна.

2012	2013	2014	2015	2016	2017	Нийт
2	8	4	5	4	4	27

2.2.4 Давтан, мэргэшүүлэх болон ур чадварын сургалт

Цагдаагийн алба хаагчийн давтан, мэргэшүүлэх, ур чадварын сургалтыг тухайн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу Сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулж байна. ЦЕГ-ын даргын 2017 оны Б/58 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх 2017 оны сургалтын календарьчилсан төлөвлөгөө”-нд нийт 7 чиглэлийн 88 сургалт төлөвлөгдсөн байна.

Түүнчлэн олон нийтийн цагдаа бэлтгэх сургалт, иргэдэд зориулсан галт зэвсгийн сургалт, офицерийн дамжаа, албаны нохойн сургалтыг төлөвлөгөөний дагуу, бусад төрийн байгууллага, харьяа нэгжүүдээс ирүүлсэн захиалгын дагуу төлөвлөгөөт бус сургалтуудыг зохион байгуулдаг.

Цаашид гэрээт харуул хамгаалалтын албаны ажилтан бэлтгэх сургалт, жолооны эрх сэргээх сургалт болон ЦЕГ-ын Автобааз дээрх жолооны курсыг тус төвд татан сургалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.7-д заасны дагуу ёс зүйн төлбөртэй /51000 төгрөг/ сургалтыг энэ оноос зохион байгуулж эхэлсэн бөгөөд одоогоор 2 удаагийн сургалтад нийслэлийн дүүргийн цагдаагийн хэлтсийн 44 ахлагч, 54 офицер алба хаагч хамрагдаад байна.

2.2.5 Нэгжийн сургалт

“Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх /Код 118/ журам”-ын 118.9.7-д заасны дагуу цагдаагийн байгууллага нь цагдаагийн төв байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, чиглэл, алба хаагчдынхаа сургалтын хэрэгцээ, шаардлагыг үндэслэн ажлын байранд зохион байгуулах /албаны/ жилийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан, байгууллагын даргын тушаалаар баталгаажуулж, хэрэгжүүлэх, төлөвлөгөөний хувь болон түүний биелэлтийг ЦЕГ-ын Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлэх үүрэгтэй.

Түүнчлэн холбогдох журмуудад заасны дагуу цагдаагийн байгууллагад шинээр болон туршилтын хугацаагаар томилогдсон алба хаагчдад чиглэсэн “Ажлын байрны сургалтын хөтөлбөр”, “Дасан зохицох хөтөлбөр”-ийг тус тус хэрэгжүүлэх, тухайн жилд алба хаагчдаас судалбал зохих хууль тогтоомж, ном, гарын авлага, баримт бичгийн жагсаалтыг гаргах, сургалтад ашигласан болон ашиглах материалуудыг нэгтгэн алба хаагчид ашиглах боломжоор хангах зэрэг үүрэгтэй.

Тус хяналт шинжилгээний хүрээнд тухайлсан нэгжийн албаны сургалтын үйл ажиллагааг хамруулаагүй боловч цагдаагийн төв байгууллагаас урьд зохион байгуулсан хяналт шалгалтын дүн мэдээ, сургалт хариуцсан алба хаагчдын тайлбарыг үндэслэн зохих үнэлгээг өгсөн.

Гурав.Цагдаагийн албаны сургалтын үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээний хүрээнд илэрсэн асуудлууд

Тайлангийн 1 дүгээр хэсэгт дурьдсан эрх зүйн акт, баримт бичгүүдийг хяналт шинжилгээний шалгуур болгон ашигласан бөгөөд дараах асуудлууд илэрлээ. Үүнд:

3.1 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн Б/257 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын сургалтын хөтөлбөр /2016-2019/” нь албаны сургалтын талаарх бодлогын шинжтэй баримт бичиг юм. Гэвч Хүний нөөц, сургалтын хэлтэс нь хөтөлбөрт заасны дагуу хэрэгжилтийг нэгтгэн зохион байгуулж, үр дүнг жил бүр тооцох, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр боловсруулан батлуулах үүргээ огт хэрэгжүүлээгүй байна.

3.2 Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн үндсэн эх сурвалж нь ХСИС-ийн шат шатны сургуулийн төгсөгчид бөгөөд Цагдаагийн ерөнхий газар нь тус сургуультай 2013 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр байгуулсан “Санамж бичиг”-ийн хүрээнд хамтран ажиллаж байна. Гэвч захиалагч байгууллагын зүгээс сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсруулахад оролцох, түүнийг сайжруулах санал, санаачлага гаргах, шат шатны сургалтад хамрагдаж буй сонсогч, алба хаагчдын сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хяналт тавих, сургалттай холбоотой аливаа асуудлаар уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах, харилцан мэдээлэл солилцох, дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах ажил орхигдсон, энэ талаарх Хүний нөөц, сургалтын хэлтсийн үйл ажиллагаа хангалтгүй байна.

3.3 “Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх /Код 118/ журам”-ын 118.9.7, 118.12.4-6, “Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх /Код 900/ журам”-ын 900.3.3в-д заасны дагуу Хүний нөөц, сургалтын хэлтэс нь цагдаагийн байгууллага, нэгжийн сургалтын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих ажлын хүрээнд тэдгээрийн жилийн сургалтын төлөвлөгөөний хувийг хүлээн авах, түүний биелэлт, тайланг гаргуулан авч үнэлгээ шинжилгээ хийх үүрэгтэй ч 2016, 2017 онуудад энэ чиглэлээр тодорхой ажил зохион байгуулаагүй, сургалтын талаар цагдаагийн байгууллага, нэгжүүдэд зөвлөмж, ажлын чиглэл хүргүүлээгүй байна.

3.4 “Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх /Код 118/ журам”-ын 118.6.2, 118.6.7, “Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх /Код 900/ журам”-ын 900.3.3в болон ХЗДХС-ын 2017 оны А/45 дугаар тушаалаар

батлагдсан “Гадаадын их, дээд сургуульд хууль сахиулах байгууллагын алба хаагчийг сонгон шалгаруулах, суралцуулах журам”-ын 4.2, 4.3-т заасны дагуу ЦЕГ-ын Хүний нөөц, сургалтын хэлтэс нь гадаад, дотоодын их, дээд сургуулийн бакалавр, магистр, доктор болон удирдлагын сургалтад байгууллагын захиалгаар суралцаж байгаа алба хаагчидтай “Сургалтын гэрээ” байгуулж, түүний биелэлтийг жил бүр дүгнэх үүрэгтэй. Гэвч хяналт шинжилгээний явцад дээрх алба хаагчидтай Сургалтын гэрээг бүрэн байгуулаагүй, гэрээний биелэлтийг дүгнэдэггүй, гэрээний үүргээ биелүүлээгүй алба хаагчтай гэрээнд заасан хариуцлагыг тооцдоггүй зэрэг дутагдал нийтлэг илэрлээ. Тухайлбал ХСИС-ийн Удирдлагын сургуульд цагдаагийн байгууллагын захиалгаар 2016 онд элсэн суралцаж байгаа 4 алба хаагчтай одоог хүртэл Сургалтын гэрээ байгуулаагүй нь талуудын хооронд үүсэх харилцааг тодорхойгүй болгож, эрх ашиг, сонирхолд нь сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн 1998-2016 оны хооронд БНТУ, ОХУ-д цагдаагийн байгууллагын захиалгаар суралцсан иргэн, алба хаагчдаас 38 нь сургуулиа төгсөөгүй, эсхүл төгсөөд цагдаагийн байгууллагад ажиллаагүй судалгаа байх бөгөөд Сургалтын гэрээнд заасны дагуу тэдгээрт суралцах хугацаанд нь олгосон цалин, замын болон бусад зардлыг нөхөн төлүүлэх ажил огт хэрэгжээгүй байна.

3.5 “Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх /Код 118/ журам”-ын 118.9.12, “Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх /Код 900/ журам”-ын 900.3.2ж-д заасны дагуу цагдаагийн байгууллага бүр сургалтад хамрагдсан алба хаагчдын бүртгэл, судалгааг хөтөлж, Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлэх, тус хэлтэс нь судалгааг нэгтгэх, алба хаагчийн хувийн хэрэгт тэмдэглэх ажлыг хариуцдаг. Гэвч нэгж дээрх хүний нөөц, сургалт хариуцсан алба хаагч нь сургалтын бүртгэл, судалгааг жигд хөтөлдөггүй, түүнийг нэгтгэн, дүн шинжилгээ хийх ажил хэрэгждэггүйгээс цагдаагийн албаны сургалтын үйл ажиллагаа нэгдсэн бүртгэл судалгаа, чиг баримжаагүй байна. Хэдийгээр энэ оны 08 дугаар сард МТХТ-өөс “Гадаад болон дотоод сургалтын бүртгэл” програмыг боловсруулсан ч ашиглагдаж эхлээгүй байна.

3.6 “Алба хаагчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах /Код 951/ журам”-д заасны дагуу цагдаагийн алба хаагч бүр жилд 5 кредит цагийн сургалтад хамрагдах, Хүний нөөц, сургалтын хэлтэс нь энэхүү үргэлжилсэн сургалтыг нэгдсэн удирдлагаар хангаж, бүртгэл судалгааг хариуцах үүрэгтэй ч өнөөг хүртэл энэ журам нэгжийн болон цагдаагийн төв байгууллагын түвшинд хэрэгжээгүй байна.

3.7 Үр дүнтэй хэрэгжүүлсэн нөхцөлд цагдаагийн албаны сургалтын үйл ажиллагааг дэмжих, боловсронгуй болгох шинжтэй цөөнгүй арга хэрэгсэл холбогдох эрх зүйн актуудад туссан. Тухайлбал Сургалт арга зүйн зөвлөл байгуулж ажиллуулах, профессор-багш ажиллуулах, ажлын байрны сургалтын болон дасан зохицох хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, кредит цагийг хангах үргэлжилсэн сургалт, сургагч-багшийн

урамшуулал зэргийг нэрлэж болно. Гэвч эдгээр арга хэрэгслийг ашиглах талаар тодорхой ажил хийгдээгүй байна.

3.8 Хяналт шинжилгээний явцад илэрсэн харьцангуй бага түвшний бусад асуудлыг тайланд тусгайлан тусгаагүй бөгөөд тэдгээрийг шийдвэрлэх талаарх санал, зөвлөмжийг тайлангийн САНАЛ, ЗӨВЛӨМЖ хэсэгт тусгав.

Дөрөв.Дүгнэлт

Цагдаагийн байгууллагын албаны сургалтын үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээнд Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтэс, Гадаад харилцааны хэлтэс болон Сургалтын нэгдсэн төвийн сургалтын үйл ажиллагаа, холбогдох эрх зүйн акт, баримт бичгийн хэрэгжилт, энэ хүрээнд Хууль сахиулахын их сургуультай харилцан ажиллаж буй байдлыг хамрууллаа.

Хяналт шинжилгээний хүрээнд илэрсэн асуудлууд, цугласан мэдээлэл, баримт материалд тулгуурлан цагдаагийн албаны сургалтын талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, хяналт, бүртгэл судалгаа, мэргэжил, арга зүйгээр хангах гол чиг үүрэгтэй Хүний нөөц, сургалтын хэлтсийн үйл ажиллагааг “Дутагдалтай”, цагдаагийн албаны давтан, мэргэшүүлэх, ур чадварын сургалтыг зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй Сургалтын нэгдсэн төвийн үйл ажиллагааг “Сайн”, байгууллагын гадаад харилцаанд түшиглэн богино хугацааны гадаад болон гадаадаас сургагч багш оролцуулсан сургалтуудыг зохион байгуулж буй Гадаад харилцааны хэлтсийн үйл ажиллагааг “Сайн” гэж үнэлэн, бусад цагдаагийн байгууллагын албаны сургалтын үйл ажиллагааны түвшин харилцан адилгүй байгаагаас нэгдсэн үнэлгээ өгөх боломжгүй ч нийтлэг давтагддаг дутагдал, анхаарах асуудлууд байна гэж дүгнэлээ.

Нэг талаас байгууллагын өсөн нэмэгдэх сургалтын хэрэгцээг хангах зорилгоор бодлого, стратеги, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтыг хариуцан ажиллаж буй хүний нөөц нь хүрэлцээгүй, нөгөө талаас тухайн албан тушаалд томилогдоод удаагүй алба хаагчдын ажлын дадлага туршлага, хариуцлага, хандлагаас шалтгаалан холбогдох эрх зүйн акт, баримт бичгийн хэрэгжилт суларчээ.

Цагдаагийн албаны сургалтын нэгдмэл байдлыг хангах хүрээнд богино хугацааны гадаад сургалтыг Хүний нөөц, сургалтын хэлтэс хариуцах нь зохимжтой ч энэ нь байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааны шууд үргэлжлэл шинжтэй байх тул Гадаад харилцааны хэлтэс хариуцах нь оновчтой байна. Гэвч 4 орон тоотой тус хэлтсийн нийт ачааллын талаас багагүй хувийг гадаад сургалтыг зохион байгуулах ажил бүрдүүлж байгааг анхаарах цаг болжээ.

Сургалтын нэгдсэн төв нь цагдаагийн албаны давтан, мэргэшүүлэх, ур чадварын сургалтыг зохион байгуулахын зэрэгцээ хууль тогтоомжид

заасан иргэнд галт зэвсгийн мэдлэг олгох, гэрээт харуул хамгаалалтын ажилтны, албаны нохойн, ёс зүйн болон олон нийтийн цагдаагийн сургалтыг зохион байгуулж байна. Түүнчлэн бусад байгууллага, харьяа нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу захиалгат сургалтуудыг явуулдаг. Цаашид жолооны эрх сэргээх сургалт болон ЦЕГ-ын Автобааз дээрх жолооны курсыг тус төвд татан сургалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Мөн цагдаагийн мэргэжлийн анхан шатны дамжаа, офицерийн дамжааг өнгөрсөн хугацаанд цөөн удаа зохион байгуулжээ. Энэхүү олон төрлийн сургалтыг Сургалтын нэгдсэн төвд төвлөрүүлэн зохион байгуулах нь түүнийг цагдаагийн албаны давтан сургалтыг зохион байгуулах үндсэн чиг үүргээс хөндийрүүлэх, сургалтын чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Иймд Сургалтын нэгдсэн төвийн ачааллыг зохист түвшинд байлгах, цагдаагийн албаны шаталсан сургалтын онцлогийг харгалзан цаашид цагдаагийн мэргэжлийн анхан шатны дамжаа, офицерийн дамжааг Хууль сахиулахын их сургуулийн мэргэшсэн сургуульд түшиглэн зохион байгуулах зарчмыг баримтлах нь зүйтэй байна.

Захиалагч байгууллагын хувьд Цагдаагийн байгууллага нь Хууль сахиулахын их сургуулийн цагдаагийн сургуульд элсэгчдийн тоо, тавигдах шалгуур, сонгон шалгаруулалт, сургалт болон төгсөлт зэрэг бүхий л үйл ажиллагаанд “Санамж бичиг”-ийн хүрээнд идэвхитэй санал тавьж оролцох боломжтой билээ. Иймд элсэгчдийн тодорхой хувийг Цагдаагийн ерөнхий газар өөрийн мэдэлд авч албан үүргээ гүйцэтгэж яваад амь нас, эрүүл мэндээр хохирсон, тэтгэвэрт гарсан болон бусад хүндэтгэн үзэх шалтгаантай цагдаагийн алба хаагчийн хүүхэд, хоёроос доошгүй жил үр бүтээлтэй ажилласан, онцгой гавъяа байгуулсан олон нийтийн цагдааг сонгон шалгаруулж сургуульд элсүүлэн суралцуулах боломж байна.

Хууль сахиулахын их сургуульд суралцагч, эсхүл төгсөгчид нь цагдаагийн байгууллагын алба хаагч, хүний нөөцийн гол эх сурвалж болох бодит байдлыг ухамсарлан, сонсогчдод хайхрамжгүй хандах байдлыг таслан зогсоох, сургалтын үйл ажиллагаанд захиалагч байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, тус сургуультай хамтын ажиллагааг шинэ шатанд гаргахыг хяналт шинжилгээний багаас зөвлөж байна.

Тав.Санал, зөвлөмж

Хурдтай хувьсан өөрчлөгдөх нийгэмтэй хөл нийлүүлэн, хуулиар хүлээсэн чиг үүргээ амжилттай биелүүлэхийн тулд аливаа байгууллага тасралтгүй хөгжиж суралцах хэрэгцээ шаардлагатай билээ. Энэ хөгжлийг чиглүүлэн манлайлах хүний нөөцийг бэлтгэх, шинэ шинэ боломжуудыг бий болгох нь тухайн байгууллагын хүний нөөц, сургалт, гадаад харилцааг хариуцсан нэгжүүдийн үйл ажиллагаанаас шууд хамаарч байдаг.

Иймд хяналт шинжилгээний явцад цугласан мэдээлэл, түүний дүгнэлтэд суурилан илэрсэн асуудлуудыг шийдвэрлэх, цагдаагийн албаны сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр дараах саналуудыг Танд танилцуулж байна. Үүнд:

5.1 Цагдаагийн төв байгууллагад албаны сургалтын асуудлыг тасаг, хэлтсийн түвшинд хариуцаж ирсэн уламжлалтай бөгөөд 2014 онд батлагдсан бүтцээр Сургалт, сурталчилгааны хэлтэс /9 орон тоотой/-ийг татан буулгаж, Хүний нөөц, сургалтын хэлтэст сургалт хариуцсан 2 ахлах мэргэжилтний орон тоог бий болгожээ. Одоогийн бүтэц, орон тоо нь цагдаагийн албаны сургалтын хэрэгцээг хангахад хүрэлцэхгүй байх тул Цагдаагийн ерөнхий газрын бүтцэд Сургалтын хэлтсийг шинээр байгуулах

5.2 Байгууллагын төсөв, санхүүгийн байдлаас шалтгаалан тэр бүр алба хаагчийг гадаадад өөрийн зардлаар сургаж бэлтгэх боломж хязгаарлагдмал нөхцөлд гадаад харилцаанд түшиглэн олон улсын тэргүүн туршлага судалж нэвтрүүлэх, хүний нөөцөө чадавхижуулах болон бусад дэмжлэг, туслалцааг авах нь зохистой хувилбар юм. Иймд гадаад сургалтын боломж, чанарыг дээшлүүлэх, Гадаад харилцааны хэлтсийн үйл ажиллагааг байгууллагын гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх үндсэн чиг үүрэгт нь төвлөрүүлэх зорилгоор тус хэлтэст сургалт хариуцсан 2 алба хаагчийн орон тоог нэмж бий болгох

5.3 “Сургалтын бодлого боловсруулж хэрэгжүүлэх /Код 118/ журам”-ын 118.9.3-т заасны дагуу цагдаагийн байгууллагын сургалтын ажлыг арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэгтэй “Сургалт арга зүйн зөвлөл”-ийг байгуулах

5.4 Цагдаагийн ерөнхий газар, Хууль сахиулахын их сургуультай 2013 онд байгуулсан “Санамж бичиг”-ийн хугацаа энэ оны 11 дүгээр сард дуусч байгаатай холбогдуулан түүний хэрэгжилт, үр дүнг тооцож, шинэчлэн байгуулах

5.5 Энэхүү тайланг Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, хяналт шинжилгээний явцад цугласан мэдээлэл, баримт бичиг, тайлангийн дүгнэлтэд үндэслэн цагдаагийн байгууллагын албаны сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр дараах зөвлөмжийг холбогдох нэгжүүдэд хүргүүлэх саналтай байна. Үүнд:

Хүний нөөц, сургалтын хэлтэст:

1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны Б/257 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын сургалтын хөтөлбөр /2016-2019/-ийг 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг нэгжүүдээс санал авч, бодитой, үр нөлөөтэй байдлаар боловсруулж батлуулан хэрэгжүүлэх

2. Цагдаагийн ерөнхий газар, Хууль сахиулахын их сургуультай

байгуулсан “Санамж бичиг”-ийн биелэлт, үр дүнг тооцож, шинэчлэн байгуулах

3. Цагдаагийн байгууллагын сургалтын үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн акт, баримт бичгүүдийн уялдаа холбоо, хэрэгжих боломж, ач холбогдлыг үнэлж, тэдгээрийг шинэчлэн боловсруулах

4. Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын сургалтын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлыг эрчимжүүлж, тэдгээрийн сургалтын жилийн төлөвлөгөө, түүний биелэлтийг хугацаанд нь гаргуулан авч, үнэлэлт дүгнэлт өгч ажиллах

5. Цагдаагийн байгууллагын захиалгаар гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцаж байгаа алба хаагчдын судалгааг сайжруулж, хүн бүртэй Сургалтын гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэх, гэрээний үүргээ биелүүлээгүй алба хаагчтай хариуцлага тооцож ажиллах

6. “Ажлын байрны сургалтын хөтөлбөр” болон “Дасан зохицох хөтөлбөр”-ийн загварыг тус тус боловсруулж, цагдаагийн байгууллага, нэгжид хүргүүлэх

7. Хууль сахиулахын их сургуулийн магистр, доктор, удирдлагын сургуульд суралцаж буй цагдаагийн алба хаагчдаар хийлгэх судалгааны ажлын сэдэв, чиглэлийн саналыг байгууллагын хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг нь харгалзан тодорхойлж хүргүүлэх, тэдгээрт тавих эргэн хяналтыг сайжруулах, судалгааны ажлын хувийг авч Номын санд байршуулах

8. Цагдаагийн албаны сургалтын үйл ажиллагаа бодлого, чиг баримжаатай, тооцоо судалгаатай, байгууллагын хэрэгцээнд нийцсэн байхад сургалт, суралцагчдын нэгдсэн бүртгэл мэдээлэл чухал ач холбогдолтой билээ. Иймд “Гадаад болон дотоод сургалтын бүртгэл” програмын хамрах хүрээ, оруулах мэдээлэл, түүний ашиглалт, програмд хандах эрхийн асуудлыг дахин тодорхойлж, ашиглалтад нэвтрүүлэх

9. Хууль сахиулахын их сургуулийн шат шатны сургалтанд хамрагдаж буй цагдаагийн сонсогч, алба хаагчдын дадлагыг зохион байгуулах журам боловсруулах, журмаар цагдаагийн байгууллага, сонсогч, алба хаагчдын дадлагатай холбоотой эрх зүйн байдал, дадлага удирдах алба хаагчийн үүрэг, тэдэнд олгох урамшууллын асуудлыг зохицуулах

Сургалтын нэгдсэн төвд:

1. Цагдаагийн албаны давтан, мэргэшүүлэх, ур чадварын сургалтыг зохион байгуулах Төвийн үндсэн чиг үүрэгт гол анхаарлаа хандуулж, төвийн болон алба хаагчдын ачааллыг зохист түвшинд байлгах

2. Албаны сургалтын каталогийг боловсруулж, түүнийг цагдаагийн байгууллагын карьерын тогтолцоо, албан тушаалтай холбох боломж шийдлийг судалж хэрэгжүүлэх

3. Хууль сахиулахын их сургууль болон бусад их, дээд сургуульд

нэвтрэн ашиглагдаж буй зайны сургалт, шалгалтыг зохион байгуулах “Moodle” програмыг Төвийн үйл ажиллагаанд нэвтрүүлж ашиглах

4. Сургагч-багшийн судалгааг сургалтын сэдэв, чиглэлийг үндэслэн шинэчлэн бүрдүүлэх, тэдэнд олгохоор журамласан урамшууллын хэлбэрүүдийг бодитой болгох саналаа холбогдох нэгжид тогтмол хүргүүлж шийдвэрлүүлэх

5. Цагдаагийн байгууллагаас тэтгэвэрт гарсан ахмадууд, тэтгэвэрт гарах гэж буй алба хаагчдад чиглэсэн сургалтын хөтөлбөрийг тэдний хэрэгцээ шаардлагад үндэслэн боловсруулж хэрэгжүүлэх

Гадаад харилцааны хэлтэст:

1. Цагдаагийн байгууллагын гадаад харилцаанд түшиглэн олон улсын сургалт, судалгааны төвүүдэд алба хаагчдыг сургаж бэлтгэх, сэлгэн ажиллуулах шинэ боломж, сувгуудыг нээх ажлыг идэвхижүүлэх

2. Гадаад хэлний мэдлэгтэй алба хаагчдын судалгааг тэдний хэлний түвшинг илэрхийлэх албан ёсны баримт бичгийг үндэслэн шинэчлэх

Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад:

1. Нэгжийнхээ жилийн сургалтын үйл ажиллагааг төлөвлөхдөө алба хаагчдын сургалтын хэрэгцээ шаардлагад үндэслэн тоог бус чанар, үр дүнг чухалчилж, төлөвлөгөө, түүний биелэлтийг тогтоосон хугацаанд Хүний нөөц, сургалтын хэлтэс хүргүүлж хэвших

2. Шинээр томилогдсон болон гүйцэтгэх чиг үүрэг өөрчлөгдсөн алба хаагч бүрт чиглэсэн ажлын байрны сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг тооцох

3. Алба хаагчдын Үр дүнгийн гэрээний үнэлгээний 30 хувийг бүрдүүлж буй “Мэдлэг боловсролоо дээшлүүлэх зорилт”-ыг биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, түүний биелэлтийг бодитой тооцож үнэлэх

4. Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар ажлаас түр чөлөөлөгдөн суралцаж буй алба хаагчдыг суралцах нөхцөл бололцоогоор бүрэн хангаж, ээлжийн амралтыг нь өгч сургуульд явуулах, нэмэлт ажил даалгах, буцааж дуудах зэргээр зохисгүй үйлдэл гаргахгүй байх

5. Хууль сахиулахын их сургуулийн сонсогчдын дадлагыг чанар, үр дүнтэй хэрэгжүүлэхэд нэгжийн зүгээс хамаарах үүргийг хангалттай биелүүлж, дадлага удирдаж буй алба хаагчдыг боломжит хэлбэрээр урамшуулах.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2018.02.20

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны Б/164 дүгээр тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийн хэрэгжилтэд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтэс

Аудит хийгдсэн объект: Уг баримт бичгийн 2016, 2017 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн байдал, түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтсийн үйл ажиллагаа

Аудитын төрөл: Үйл ажиллагааны аудит

Аудитын хугацаа: 2017.12.18- 2018.01.31

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх

1. ТАНИЛЦУУЛГА

“Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг” нь /цаашид баримт бичиг гэх/ Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн Б/164 дүгээр тушаалаар батлагдсан бөгөөд энэ чиглэлээр гарсан анхны баримт бичиг гэдгээрээ чухал ач холбогдолтой.

Уг баримт бичгийг өөрчлөлт, хөгжлийн бодлогоор тавигдсан зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд тоо болон чанарын шаардлага хангахуйц хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх, хүний нөөцийг үр ашигтай ашиглах зорилгыг ханган биелүүлэх, нөгөө талаас хувь хүн /алба хаагч/-ий өөрийгөө үнэлэх, карьераа төлөвлөх, түүнд хүрэх арга замаа тодорхойлох үндсэн баримт бичиг гэж тодорхойлсон.

2015 онд баримт бичгийг боловсруулах явцад цагдаагийн байгууллагын хүний нөөцийн давуу болон сул тал, боломж, эрсдэлийг / SWOT шинжилгээ/ тооцож, бэлэн байгаа цагдаагийн алба хаагчдын албан тушаал, мэргэжил, ажилласан жил, нас, боловсролын болон эрдмийн зэргийн тоон судалгааг гаргажээ.

Баримт бичгийн 2.1-т цагдаагийн байгууллагын хүний нөөцийн тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлж, түүнд тулгуурлан бодлогыг тодорхойлох, хүний нөөцийг бүрдүүлэх
- Хүний нөөцийн мэдээллийг удирдлагын шийдвэр гаргах хэрэгсэл болгох
- Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх сургалт, хөгжлийн бодлого боловсруулан хэрэгжүүлж, суралцагч байгууллага болох
- Карьер хөгжлийн болон цалин хөлс, шагнал урамшууллын тогтолцоог ажлын бүтээмжийг дээшлүүлэх хөшүүрэг болгох
- Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх хэрэгсэл болгох.

Дээрх тэргүүлэх чиглэлийн хүрээнд нийт 43 заалт бүхий зарчим, арга хэмжээг хөтөлбөр, төлөвлөгөө, журам боловсруулан хэрэгжүүлэх, хэрэгжилтийг цагдаагийн төв байгууллагын захиргааны удирдлага хариуцсан нэгж удирдан зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнд эрх бүхий нэгж хяналт үнэлгээ хийж, зөвлөмжөөр хангаж ажиллахаар тусгажээ.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

“Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 4.1, “Цагдаагийн байгууллагын дотоод аудитын 2017 оны төлөвлөгөө”-ний 3.3, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн Б/164 дүгээр тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийн 3.1.4-т тус тус заасны дагуу уг баримт бичгийн хэрэгжилтийг тооцож, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр зөвлөмж боловсруулахад дотоод аудитын зорилго оршино.

2.2 Аудитын цар хүрээ

Аудитын зорилгыг хангах хүрээнд “Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийн 2016, 2017 оны эхний хагас жилийн хэрэгжилт, түүнд хамаарах Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтэс, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв, Санхүү, аж ахуйн алба болон бусад нэгжийн үйл ажиллагааг аудитын объектод хамруулсан.

Баримт бичгийн 2.6.1-2.15.5-д заасан нийт 43 ажил, арга хэмжээнд дурьдаагүй хүний нөөцийн үйл ажиллагааг аудитын объектод хамруулаагүй болно.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ аудит хийгдэх нэгжийн удирдлага, алба хаагчидтай хийх уулзалт ярилцлагын удирдамж, аудитын хүрээнд шалгах мэдээлэл, түүнийг нотлох аргыг боловсруулан хэлтсийн даргаар батлуулж ашигласан.

Баримт бичгийн 2016, 2017 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл, цагдаагийн байгууллагад анх орох иргэнийг сонгон шалгаруулах, нөөцөд бүртгэх, цагдаагийн алба хаагчийг томилох, дэвшүүлэх, шилжүүлэн болон сэлгэн ажиллуулах, ажлаас халах, чөлөөлөх, тэтгэвэрт гаргах, шагнал урамшуулал болон бусад тэтгэмж, олговор олгох зэрэг үйл ажиллагааны урсгалын схем /ажлын дэс дараалал/-ийг Хүний нөөц, сургалтын хэлтсээс гаргуулан авч судалсан.

Түүнчлэн аудитын нотлох баримт цуглуулах зорилгоор тус хэлтсийн алба хаагчидтай уулзалт ярилцлага зохион байгуулж, сонгон шалгаруулалт, ахлагч бүрэлдэхүүний боловсролын зэрэг, томилгоо, алба хаагчдыг дэвшүүлэн томилох, шагнаж урамшуулахтай холбоотой 4 төрлийн түүвэр хийж, тулган баталгаажуулахад ашигласан.

Аудитын явцад цугласан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан тайлангийн төслийг бичиж, Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлэн “Удирдлагын тайлбар”-ыг авсан.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Баримт бичгийн 3.1.1-т энэхүү баримт бичигт тусгагдсан зарчмуудыг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө, журам боловсруулж, хэрэгжүүлэхээр заасан боловч 2015 оны 03 дугаар сарын 20-ны өдөр уг баримт бичгийг баталснаас хойш түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр тусгайлан ямар нэг хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлээгүй байна. Улмаар баримт бичигт тусгагдсан зарчим, ажил, арга хэмжээний хэрэгжилт суларч, урсгалаараа явах, эзэнгүйдэх нөхцөл үүссэн байна. Энэ нь аудитын явцад баримт бичгийн хэрэгжилтийг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулахад учирсан хүндрэл бэрхшээл, тухайн зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэсэн тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулаагүйгээс оновчгүй тайлагнах зэрэг байдлаар илэрлээ.

3.2 Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн цахим санг боловсронгуй болгох, програмын алдааг залруулах чиглэлээр Хүний нөөц, сургалтын хэлтсээс зарим санал, санаачлагыг гарган хэрэгжүүлсэн нь үр дүнгээ өгчээ. Цаашид сангийн баяжилтыг сайжруулж, түүний мэдээллийг хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, томилгоонд ашиглах байдлыг нэмэгдүүлэх шаардлага байна. Хүний нөөцийн мэдээллийн санд

алба хаагчдын шилжилт хөдөлгөөнийг шуурхай хийж хэвшсэн ч тэдний, ялангуяа ахлагч бүрэлдэхүүний шагнал, сахилгын шийтгэл, мэргэшлийн бэлтгэл, үр дүнгийн үнэлгээний мэдээллийг оруулах байдал жигдрээгүй байна.

3.3 Баримт бичгийн 2.6.6, 2.7-д цагдаагийн алба хаагчийг дэвшүүлэн томилоход харгалзах шаардлагуудыг тодорхойлсон. Дэвшин томилогдсон алба хаагчдын эрүүл мэнд, бие бялдрын бэлтгэлжилт, үр дүнгийн гэрээний үнэлгээ, уг үнэлгээтэй холбоотой менежерийн санал, гэмт хэрэгт холбогдож шалгагдсан байдал, сахилга, ёс зүйн байдал, харилцааны ур чадвар, манлайллын талаарх мэдээллийг хүний нөөцийн цахим сангаас бүрэн авч ашиглах бололцоогүйгээс зөвхөн тодорхой албан тушаалд ажилласан байх хугацааны шалгуурыг ашигласан.

2016, 2017 онд энгийнээс офицер албан тушаалд томилогдсон 23, ахлагчаас офицер албан тушаалд томилогдсон 34, ахлах албан тушаалд томилогдсон 11, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дэд болон тасаг, хэсэг, дэд хэсгийн даргаар томилогдсон 23, тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргаар томилогдсон 22, төв байгууллагын болон түүний харьяа зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргаар томилогдсон 12, нийт дэвшин томилогдсон 125 алба хаагчийн мэдээллийг түүвэрлэн шалгахад 30 алба хаагч, иргэн буюу 24 хувь нь хүний нөөцийн бодлогын баримт бичигт дурьдсан хугацааны шалгуур /өмнөх шатны албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх/-ыг хангахгүй байлаа.

3.4 Цагдаагийн алба хаагчдад төрийн, дээд шатны болон байгууллагын шагналаар шагнах асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/87 дугаар тушаалаар батлагдсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын шагнал олгох журам”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан “Шагнал, урамшил олгох /Код 925/ журам”-д заасан болзол, шалгуурыг баримтлан олгож байна. Цагдаагийн алба хаагчдад шагналыг зохих шалгуурын дагуу олгож буй эсэхийг шалгах зорилгоор 2016 оны 06 дугаар сард Цагдаагийн ерөнхий газраас төрийн болон яамны шагналаар шагнуулахаар тодорхойлсон 148 алба хаагчийн мэдээллийг түүвэрлэн хүний нөөцийн цахим сантай тулгаж үзэхэд тухайн шагналыг хүртэх болзлыг хангасан 33, хангаагүй 41, тухайн шагналыг авсан эсэх нь тодорхойгүй 23, сангаас мэдээлэл нь илрээгүй /албанаас халагдсан, чөлөөлөгдсөн, тэтгэвэрт гарсан болон бусад шалтгаанаар/ 51 цагдаагийн алба хаагч байлаа. Өөрөөр хэлбэл шагналд тодорхойлогдож түүвэрт орсон алба хаагчдын 33 буюу 22 хувь нь л тухайн шагналыг авах хугацааны шаардлагыг хангасан байна. Харин шагнал урамшил нь шаталсан байх зарчим, зохицуулалтыг түүвэрт орсон алба хаагчдын аль нь ч хангахгүй байв.

3.5 Баримт бичгийн 2.15.3-т соён гэгээрүүлэх ажлын төрөл, хэлбэр, түүнийг дүгнэх журам, аргачлалыг шинэчлэх тухай заасан боловч 2016, 2017 онд төв, орон нутгийн цагдаагийн байгууллагуудын соён гэгээрүүлэх ажлын тайлан, мэдээллийг нэгтгэж, үнэлээгүй, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаагүй, түүнийг дүгнэх журам, аргачлалыг шинэчилж боловсронгуй болгох чиглэлээр тодорхой ажил хийгдээгүй байна.

4. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн “Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийн хэрэгжилтийг **49.1** хувь буюу “хангалтгүй” гэж үнэллээ. Үүнд уг баримт бичгийг хэрэгжүүлэх зорилгоор тусгайлсан хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлээгүйгээс түүнд тусгагдсан зарчим, ажил, арга хэмжээ эзэнгүйдэж, хэрэгжилт урсгалаараа явсан нь нөлөөлсөн байна. Өөрөөр хэлбэл цагдаагийн байгууллагын хүний нөөц, албаны сургалтын үйл ажиллагааны ердийн явцад баримт бичгийн зарим заалт давхцан хэрэгжсэнийг эс тооцвол түүнийг хэрэгжүүлэх ажил орхигдсон байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмаар цагдаагийн алба хаагчийг дэвшүүлэн томилох, шагнаж урамшуулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан ч түүнийг нэг мөр хэрэгжүүлж ажиллаагүй нь дотоод аудитын явцад илэрлээ. Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2017 оны 11 дүгээр сард Цагдаагийн ерөнхий газарт хийсэн хяналт шинжилгээ, дотоод аудитын тайланд ч эдгээр зөрчил дутагдал илэрсэн тухай дурьдагджээ.

Түүнчлэн цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг дэмжих, боловсронгуй болгох чиглэлээр баримт бичигт тусгагдсан, -алба хаагч өөрийн зардлаар гадаадын их, дээд сургуульд боловсролын зэрэг олгох сургалт болон гадаад хэлний сургалтад хамрагдахад дэмжих /2.6.2/, -ажил, чиг үүргийн давхардал, ажлын ачааллын талаар судалгаа хийх /2.8.6/, -албаны сургалтыг онлайн хэлбэрт шилжүүлэх /2.8.7/, -алба хаагчдад хуулиар олгогдсон нийгмийн баталгааг бүрэн эдлүүлэх /2.9.1/, -алба хаагч, ажилтны хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, хөдөлмөрийн нөхцлийн судалгааг хийх /2.10.1/ зэрэг ажлуудын хэрэгжилт сул байв.

5. ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, аудитын үр дүнд суурилан “Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах чиглэлээр аудитын багаас дараах зөвлөмжийг холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх саналтай. Үүнд:

- “Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийн биелэлт, үр дүнг тооцож, цаашид жил бүр баримт бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тусгайлан боловсруулж хэрэгжүүлэх

- Цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг дэмжих, боловсронгуй болгох чиглэлээр баримт бичигт туссан ч хэрэгжилт нь сул байгаа /тайлангийн дүгнэлт хэсэгт дурьдсан заалтууд/ ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг холбогдох нэгж, албадтай хамтран зохион байгуулах
- Баримт бичгийн 2.6.5, 2.6.6, 2.7-д тус тус заасны дагуу алба хаагчдыг офицер, удирдах албан тушаалд дэвшүүлэн томилохдоо холбогдох шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа алба хаагчийг ил тод, нээлттэйгээр албан тушаалд томилоход анхаарч, бодит өөрчлөлт гаргах
- Шагнал, урамшуулал нь цагдаагийн алба хаагчийн ажлын үр дүнг үнэлэх, ажиллах урам зориг, идэвхи санаачлагыг өрнүүлэхэд байгууллагын удирдлагад байдаг үр нөлөөтэй механизмын нэг билээ. Нөгөө талаас шагнал, урамшууллын талаарх журам зохицуулалт нь алба хаагч бүрт тэгш үйлчлээгүй, ил тод бус нөхцөлд эсрэг үр дагавар авчрах эрсдэлтэй юм. Иймд шагнал, урамшууллын талаарх журмыг хэрэгжүүлэхдээ шударга, ил тод, ойлгомжтой байх зарчим, хэрэв алба хаагч тухайн шагналыг хүртэх болзол шалгуурыг хангаж, удирдлага нь шагнуулахаар тодорхойлсон л бол түүнийг дэмжих бодлого баримталж ажиллах
- Баримт бичгийн 2.15.3-т заасны дагуу соён гэгээрүүлэх ажлын төрөл, хэлбэр, түүнийг дүгнэх журам, аргачлалыг шинэчилж, үр дүнг тооцож, үнэлэх
- “Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийн 2.3-т заасан цагдаагийн байгууллагын хүний нөөцийн эрсдэл, сул талын одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, тэдгээрийг арилгах талаар үр дүнтэй ажил төлөвлөж, хэрэгжүүлэх.

6. УДИРДЛАГЫН ТАЙЛБАР

Аудитын тайлангийн төслийг Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлсний дагуу тус хэлтсээс 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн ХНСХ/37 дугаарын албан бичгээр “Удирдлагын тайлбар”-ыг ирүүлсэн нь тайланд дурьдсан болон илэрсэн асуудалтай шууд холбогдолгүй, бодит үндэслэлтэй байх шалгуурыг хангахгүй байсан тул тайланд тусгайлан оруулах шаардлагагүй гэж үзсэн.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2017.01.17

Улаанбаатар хот

Аудитын нэр: Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Цагдаагийн байгууллагын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл /цаашид НХЖХОНАБХГХЗУСА33 гэх/

Аудит хийгдсэн объект: Цагдаагийн байгууллагын НХЖХОНАБХГХЗУСА33, УБХЦГ, ЗЦА, ЭЦГ, МБГ-ын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааны санхүүжилт

Аудитын төрөл: Үйл ажиллагааны аудит

Аудитын хугацаа: 2016.09.14- 2016.11.14

Дотоод аудитын нэгжийн дарга: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Н.Батзоргох

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх, Т.Баттөмөр

1. ТАНИЛЦУУЛГА

1.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын удирдлагын талаар

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын Код-119-т заасны дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг цагдаагийн байгууллагын хэмжээнд үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах чиг үүргийг НХЖХОНАБХГХЗУСА33 гүйцэтгэхээр тусгасан.

Зөвлөл нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хийх ажлын чиглэл тогтоох, санал боловсруулах, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээлэл сонсох, үүрэг чиглэл өгөх, үр дүнг тооцох, иргэдийн дунд санал асуулга явуулж, дүгнэлт хийх, шаардлагатай техник хэрэгслийн судалгаа гаргах, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах, албад, нэгжээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохиосон ажлын тайлан мэдээг гаргуулан авах болон бусад бүрэн эрхийг эдэлж хэрэгжүүлэхээр байна.

Зөвлөлийн бүрэлдэхүүнийг хамгийн сүүлд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн Б/323 дугаарын

тушаалаар шинэчлэн баталж, дарга нь Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, нарийн бичгийн дарга нь НХЖХА-ны МАЗХ-ийн дарга, гишүүд нь ГХТА, НХЖХА, ОНАБХА, УБХЦГ, ТЗБХ, ХуХ, ЭЦГ, МБГ, ЗЦГ, СХГ-ын Санхүүгийн хэлтэс, ХМТ, МТТ болон Холбооны хэлтсийн дарга нар байхаар зохицуулжээ.

Зөвлөл нь сард нэгээс доошгүй удаа хуралдан, гаргасан шийдвэрээ Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулж, холбогдох нэгжид хүргүүлэн хэрэгжилтийг хангуулах журмын зохицуулалттай.

1.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төлөвлөгөөний талаар

Засгийн газрын 2012 оны 252 дугаар тогтоолоор “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г тус тус баталсан. Уг хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2015 онд 35 заалттайгаар гаргаж, биелэлтийг жилийн эцэст 68 хувь гэж үнэлэн тайлагнажээ. Харин 2016 оны төлөвлөгөөг 03 дугаар сард 25 заалттайгаар гаргаж, биелэлтийг эхний хагас жилд 48.2 хувь гэж үнэлсэн боловч Хууль зүйн яамнаас тайлан, биелэлтийг аваагүй байна.

“Цагдаагийн байгууллагаас 2016 онд хэрэгжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 2016 оны 03 дугаар сарын 30-нд гаргаж, 04 дүгээр сарын 05-ны өдрийн 6/1733 дугаарын албан бичгээр цагдаагийн байгууллагуудад хүргүүлжээ.

Хууль зүйн сайдын 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/187 дугаар тушаалаар “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын 2016 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталж, цагдаагийн байгууллагад 6 чиглэлийн 37 заалт бүхий ажил, арга хэмжээг хариуцуулсан. Уг төлөвлөгөөг 2016 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 6/3332 дугаарын албан бичгээр төв, орон нутгийн цагдаагийн байгууллагуудад хүргүүлжээ.

1.3 Цагдаагийн байгууллагын зарим алба, нэгжийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын талаар

Цагдаагийн албаны тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх /Код 227/ журамд заасны дагуу Гэмт хэрэгтэй тэмцэх алба нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг тооцох чиг үүрэгтэй.

Гэвч тус албанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тухайлан хариуцсан алба хаагчийг томилоогүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээлэлгүй байна.

Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг тодорхойлох /Код 100/ журамд заасны дагуу Нийтийн хэв журам хамгаалах алба нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах, бодлого, арга зүйг тодорхойлох болон бусад чиг үүргийг хэрэгжүүлэхээр зохицуулсан.

Тус албаны Мэргэжил, арга зүйн хэлтсийн дарга нь НХЖХОНАБХГХЗУСА33-ийн нарийн бичгийн дарга бөгөөд түүний үүргийг тус хэлтсийн 1 ахлах мэргэжилтэн хариуцан хэрэгжүүлж байна. НХЖХА-наас “Цагдаагийн байгууллагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө”-г холбогдох нэгжүүдээс санал авч нэгтгэн батлуулах, төв, орон нутгийн цагдаагийн байгууллагуудад хүргүүлэх, эдгээр төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж, тайланг Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст хүргүүлэх ажлыг зохион байгуулдаг.

Түүнчлэн тус албанаас улсын хэмжээнд нийтийн хэв журам хамгаалах нэгжээс гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгуулах арга хэмжээ авхуулахаар хуулийн этгээдэд хүргүүлсэн мэдэгдэл, цагдаагийн байгууллагаас хяналт тавьж буй хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан болон хорих ялыг тэнсэж хянан харгалзсан ялтан, эсхүл хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн статистик мэдээллийг тус тус сар бүр нэгтгэн гаргадаг байна.

УБХЦГ-ын Урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах хэлтэс нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулан ажиллахдаа дүүргийн цагдаагийн хэлтсийн НХЖХТ-ийн ахлах байцаагч нараас сар бүр мэдээг авч нэгтгэн дүгнэж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайланг УБХЦГ-ын НХЖХ нэгжид, “Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө”-ний биелэлтийг хагас, бүтэн жилээр, захиргааны хяналтын мэдээг сар бүр НХЖХА-нд тус тус хүргүүлэн ажиллаж байна.

Эрүүгийн цагдаагийн газар, Мөрдөн байцаах газар нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг “Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх жилийн ажлын төлөвлөгөө”-ний хүрээнд хэрэгжүүлж ажилладаг.

Замын цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах хэлтэс нь тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах ажлыг улсын хэмжээнд төлөвлөн, зохион байгуулж, аймаг, нийслэлийн Замын цагдаагийн тасгуудаас сар, улирлаар ажлын мэдээг авч нэгтгэн, тайланг ЗЦА-ны Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст, “Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх жилийн ажлын төлөвлөгөө”-ний дагуу хариуцсан ажлын

биелэлтийг хагас, бүтэн жилээр НХЖХА-нд тус тус хүргүүлэн ажиллаж байна.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага болон Замын цагдаагийн албанаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2015 онд зарцуулсан зардал, түүний зориулалт, санхүүжилтын эх үүсвэрийн талаарх мэдээллийг цуглуулан нэгтгэхэд улс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, байгууллагын төсөв, засаг даргын нөөц хөрөнгө, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын санхүүжилтээр 5 тэрбум орчим төгрөг зарцуулагдсаны талаас илүү хувь нь олон нийтийн цагдаагийн ажилтны урамшуулалд зориулагдсан дүн гарлаа.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

“Цагдаагийн байгууллагын 2016 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 3.7-д заасны дагуу цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дотоод аудит хийж, түүний удирдлага, зохион байгуулалт, төлөвлөлт, хяналтыг боловсронгуй болгох чиглэлээр санал зөвлөмж боловсруулах зорилгоор дотоод аудитыг хийлээ.

2.2 Аудитын цар хүрээ

Аудитын зорилгыг хангах хүрээнд цагдаагийн байгууллагын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэгтгэн удирдах үүрэг бүхий НХЖХОНАБХГХЗУСАЗЗ-ийн үйл ажиллагаа, ГХТА, НХЖХА, ЗЦА, УБХЦГ, ЭЦГ болон МБГ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хяналттай холбоотой үйл ажиллагааг аудитын объектод хамруулсан.

Мөн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудын ЭБШХ, ГХУСТХ-д заасны дагуу гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдэл, тэдгээрийн биелэлтийг тооцсон байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилт, түүний зарцуулалтын байдалд дүн шинжилгээ хийлээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны агуулга, хэлбэр, үр дүнг аудитын объектод хамруулаагүй болно.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын удирдлагын талаар

Зөвлөл нь 2014 онд 5 удаа хуралдахаар “Хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө”-г гаргасан боловч 3 удаа хуралдаж, 2 хурал гишүүдийн ирцээс шалтгаалан хойшилж, уг хурлаар хэлэлцэгдэх байсан асуудлаар үүрэг,

ажлын чиглэл хүргүүлж ажиллажээ. Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн 28 асуудлын 13 буюу 46.4 хувь нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотой байна.

Зөвлөл нь 2015 онд 3 удаа хуралдаж 18 асуудлыг авч хэлэлцжээ. Зөвлөлийн 2015 оны үйл ажиллагаанд хамаарах баримт бичгээр үүсгэсэн архивын нэгжээс үзвэл зөвлөлийн жилийн болон хурал тус бүрт хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг гаргаж, батлуулаагүй, хурлын тэмдэглэл, зөвлөлийн жилийн үйл ажиллагааны нэгдсэн тайлан, төлөвлөгөөний биелэлт гаргаагүй байна. Иймд хурлаар хэлэлцсэн асуудлын хэдэн хувь нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар байсныг тодорхойлох боломжгүй байна.

Зөвлөл нь 2016 онд 23 асуудлыг хэлэлцэхээр төлөвлөгөө гаргаж батлуулсан боловч нэг ч удаа хуралдаагүй байна.

Зохицуулах зөвлөл нь сард 1-ээс доошгүй удаа хуралдахаар журамласан ч 2014 онд 3, 2015 онд 3 удаа хуралдаж, 2016 онд огт хуралдаагүй байгаагаас зөвлөлийн үйл ажиллагаа доголдож тасарсан, хэлэлцэхээр төлөвлөсөн асуудлуудыг бүрэн хэлэлцэж шийдвэрлээгүй гэх дүгнэлтийг хийж болно. Мөн зөвлөлийн нарийн бичгийн даргын үйл ажиллагаа, түүнд шат шатны удирдлагаас тавих хяналт суларснаас зөвлөлийн үйл ажиллагаанд холбогдох баримт бичгийн бүрдэл, хөтлөлт хангалтгүй байна.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдан зохицуулах үүрэгтэй зөвлөлийн үйл ажиллагаа доголдож саатсан нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах болон төлөвлөлт, хяналтын үйл ажиллагаа сулрах эрсдэлийг бий болгожээ.

3.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төлөвлөгөөний талаар

Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэлээр үндсэн 3 төлөвлөгөө байгааг энэхүү тайлангийн 1.2-т дурьдсан. Эдгээрээс цагдаагийн байгууллагаас батлан гаргасан 2 төлөвлөгөө нь энэ оны 2 дугаар улирлын эхэнд, Хууль зүйн яамнаас ирүүлсэн төлөвлөгөө нь эхний хагас жилийн эцэст батлагдан ирсэн нь дээрх төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэхэд хугацаа алдах эрсдэлийг үүсгэжээ.

Түүнчлэн ХЗЯ-наас баталж ирүүлсэн “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын 2016 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний цагдаагийн байгууллагад хамаарах заалт нь цагдаагийн байгууллагаас 2015 буюу өмнөх онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргаж хэрэгжүүлсэн төлөвлөгөөний заалтыг шууд хуулбарласан байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөлт ямар түвшинд байгааг илтгэж байна.

3.3 Цагдаагийн байгууллагын зарим алба, нэгжийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын талаар

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Шүүх, прокурор, хэрэг бүртгэх байгууллага, мөрдөн байцаагч нь холбогдох хуульд заасны дагуу бичсэн энгийн магадлал, мэдэгдлийнхээ биелэлтэд хяналт тавина” гэж заасан. Мөн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх /Код 227/ журам”-ын 227.4.2-т “Эрүүгийн цагдаагийн газар, Мөрдөн байцаах газар нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоон түүнийг арилгуулахаар аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд бичсэн мэдэгдэл, түүний талаар авсан арга хэмжээнд дүн шинжилгээ хийж, Зохицуулах зөвлөлд жил бүр тайлагнах”-аар зохицуулсан. Гэвч дээрх газрууд нь энэ үүргээ хэрэгжүүлээгүй, алба хаагчид нь энэ талаар ямар нэг ойлголтгүй байсан нь аудитын явцад ажиглагдсан.

Аудитын хүрээнд гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгуулахаар цагдаагийн байгууллагуудаас 2015 онд хүргүүлсэн мэдэгдлийн судалгааг гаргуулан авсан нь алба, газрууд дээрх нэгтгэгдсэн мэдээнээс зөрүүтэй байсан нь мэдэгдлийн бүртгэл, судалгааг хийх үйл ажиллагаа бүрэн төлөвшөөгүйг харуулж байна.

Улаанбаатар хотын цагдаагийн газраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажил дутагдалтай, сар бүр маягтын дагуу ажлын мэдээ гаргуулж авдаг нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төдийлөн хамааралгүй агуулгатай байна. Мөн дүүргийн цагдаагийн хэлтсийн нийтийн хэв журам хамгаалах тасгийн ахлах байцаагчдын ажлын байрны тодорхойлолтыг нэгдсэн байдлаар хийснээс урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах чиглэлийг хариуцан ажиллах алба хаагч тодорхойгүй болж эзэнгүйдэх эрсдэл үүсчээ.

Түүнчлэн Улаанбаатар хотын цагдаагийн газар, Замын цагдаагийн албанаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээрх зарим нэг төлөвлөгөөний биелэлтэд ашиглагдахаас өөрөөр эргэлтэд орж ашиглагдахгүй, удирдах дээд шатны байгууллага, албан тушаалтны анхааралд орохгүй байна.

4. ДҮГНЭЛТ

Орчин үеийн судлаачид үр дүнтэй урьдчилан сэргийлэх ажиллагаа нь гэмт хэргийн улмаас үүсч болох хор уршиг, сөрөг үр дагаврыг арилгах, улмаар цаг хугацаа, хүн хүч, хөрөнгийн нөөцийн зарцуулалтыг бууруулах ач холбогдолтой болохыг онцолж байна. Тиймээс ч гадаад орнуудын цагдаагийн байгууллага үйл ажиллагааныхаа урьдчилан сэргийлэх чиглэлийг түлхүү анхаарч, гол хүн хүч, хөрөнгө хэрэгслээ чиглүүлэн ажиллах болжээ.

Аудитын хүрээнд цугларсан баримт материал, алба хаагчидтай хийсэн ярилцлагаас үзвэл өнөөдөр цагдаагийн нэгж, алба хаагчид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тодорхой зорилго, төлөвлөгөөтэй хэрэгжүүлэхээс илүүтэй үндсэн ажлын хажуу дахь дайвар үүрэг мэт харж, энэ ажил урсгалаараа яваа байдалтай байна.

Нэгэнтээ Зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга хэлсэн үгэндээ уг зөвлөл нь цагдаагийн төрөл, мэргэжлийн албадын уялдаа холбоо, хамтын ажиллагааны шуурхай байдлыг хангах гол үндсэн зорилготой байгуулагдсан тухай илэрхийлсэн байдаг. Зөвлөл нь ийм өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулах бол гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах нь түүний үйл ажиллагааны багахан хувийг л эзлэх юм. Үүнийг зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлуудын агуулгаас ч харж болно.

Иймд цагдаагийн байгууллагын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг нэгтгэн удирдах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, энэ чиглэлийн аливаа хөтөлбөр, төлөвлөгөө, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжүүлсэн ажлын үр дүн, үр нөлөөнд дүн шинжилгээ хийж, цаашдын бодлого, чиглэлийг тодорхойлох ажлыг гүйцэтгэх бие даасан бүтцийг бий болгох хэрэгцээ шаардлага байна.

Мөн 2015 онд л гэхэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн байгууллагын хэмжээнд багагүй төсөв хөрөнгө /5 тэрбум орчим төгрөг/ зарцуулагдсан судалгаанаас үзвэл түүний зарцуулалтын байдал, зориулалт, үр дүнд хяналт шалгалт хийх, үнэлэлт дүгнэлт өгөх ач холбогдлыг илтгэж байна.

5. ЗӨВЛӨМЖ

Аудитын үр дүнд суурилан аудитын багаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, төлөвлөлт, хяналтыг боловсронгуй болгох чиглэлээр дараах зөвлөмжийг холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх саналтай. Үүнд:

- НХХЖОНАБХГХЗУСА33-ийн бүрэлдэхүүнийг ХЗДХС-ын 2016 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/48 дугаар тушаалд нийцүүлэн шинэчлэн батлах,

- Зөвлөлийн үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй байдлыг хангах зорилгоор зөвлөлийн ажлын албыг бий болгох, эсхүл зөвлөлийн нарийн бичгийн дарга, түүнийг төлөөлөн зөвлөлийн ажлын албыг хариуцаж байгаа алба хаагчийн ажлын байрны тодорхойлолтод гүйцэтгэх чиг үүргийг тодорхой тусгаж, үр дүнг тооцдог болох,

- Дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах ажил хариуцсан ахлах мэргэжилтний орон тоо, ажлын байрны тодорхойлолтыг тусгайлан боловсруулж батлуулах,

- Цагдаагийн байгууллагын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг нэгтгэн удирдах, мэргэжил, арга зүйн удирдлагаар

хангах, энэ чиглэлийн аливаа хөтөлбөр, төлөвлөгөө, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжүүлсэн ажлын үр дүн, үр нөлөөнд дүн шинжилгээ хийж, цаашдын бодлого, чиглэлийг тодорхойлох ажлыг гүйцэтгэх бие даасан бүтцийг бий болгох,

- Цагдаагийн байгууллагын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 үндсэн төлөвлөгөө байгаа нь давхардсан шинжтэй байх тул 2017 оноос тэдгээрийг нэгтгэн нэг төлөвлөгөө гаргах.

6.УДИРДЛАГЫН ТАЙЛБАР

Аудитын урьдчилсан тайланг ГХТА, НХЖХА, ЗЦА, ЭЦГ, МБГ, УБХЦГ-т хүргүүлж, Удирдлагын тайлбарыг авахад, тайланд тусгасан асуудал, саналыг дэмжсэн хариу ирүүлснийг энэхүү тайланд хавсаргав.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2016.07.20

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаагийн байгууллагын мэдээллийн сан дахь яллагдагчийн сангийн баяжилт, гэмт хэргийн илрүүлэлтийн статистикийн нөхцөл байдалд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: УБХЦГ-ын харьяа 6 дүүргийн / [REDACTED] / цагдаагийн хэлтэс

Аудит хийгдсэн объект: Цагдаагийн байгууллагын мэдээллийн сан дахь ЭБШХ-ийн 205 дугаар зүйлийн 205.1.1-т заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн гэмт хэргийн мэдээлэл, дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн Хэрэг бүртгэх тасаг, Мөрдөн байцаах тасагт буй хэргийн материал

Аудитын төрөл: Нийцлийн аудит

Аудитын хугацаа: 2016.05.16- 2016.05.27

Дотоод аудитын нэгжийн дарга: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Н.Батзогсох

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа В.Отгонбаяр, А.Отгонсүх

1. ТАНИЛЦУУЛГА

2015 онд улсын хэмжээнд бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй гэмт хэрэг нийт 13922 бүртгэгдсэнээс 8644 хэрэгт ял сонсгож илрүүлэлт 62.1 хувь байсан нь өмнөх оныхоос 3.5 хувь өссөн үзүүлэлт байна.

Тэгвэл нийслэлийн хэмжээнд 2015 онд бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй гэмт хэрэг 10130 бүртгэгдсэнээс 5966 хэрэгт ял сонсгож илрүүлэлт 59.8 хувь байсан нь өмнөх оныхоос 3.5 хувь өссөн үзүүлэлт юм.

Дотоод аудитад хамрагдсан дүүргийн 6 цагдаагийн хэлтсийн тухайд 2015 онд бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй гэмт хэрэг 5157 бүртгэгдсэнээс 3078 хэрэгт ял сонсгож илрүүлэлт 59.7 хувь байсан нь өмнөх оныхоос 2.2 хувь өссөн үзүүлэлт байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

“Цагдаагийн байгууллагын 2016 оны дотоод аудитын төлөвлөгөө”-нд цагдаагийн байгууллагын мэдээллийн сан дахь яллагдагчийн сангийн баяжилтад дотоод аудит хийгдэхээр тусгасан.

Мэдээллийн сан дахь яллагдагчийн мэдээлэл нь гэмт хэргийн илрүүлэлтийн хувьтай шууд холбоотой байдаг. Өөрөөр хэлбэл мэдээллийн санд яллагдагчийн маягт шивж оруулснаар тухайн гэмт хэргийг илэрсэнд тооцож байна.

Нөгөө талаас ЭБШХ-ийн 205 дугаар зүйлийн 205.1.1-т заасан “яллагдагчаар татагдвал зохих этгээд тогтоогдоогүй” үндэслэлээр түдгэлзүүлсэн хэрэгт яллагдагчийн маягт шивэх замаар гэмт хэргийн илрүүлэлтийн хувийг зохиомлоор өсгөх эрсдэл байдаг.

Иймд цагдаагийн байгууллагын мэдээллийн сан дахь яллагдагчийн сангийн баяжилтад дотоод аудит хийж, түүнийг боловсронгуй болгох чиглэлээр санал, зөвлөмж боловсруулах нь энэхүү ажлын зорилго юм.

2.2 Аудитын цар хүрээ

Дотоод аудитын цар хүрээг тодорхойлохдоо гэмт хэргийн гаралт, илрүүлэлтийн хувь харьцангуй өндөр байдгийг харгалзан Улаанбаатар хотын дүүргийн цагдаагийн 1 дүгээр хэлтсүүдийг сонгож, 2015 онд бүртгэгдсэн гэмт хэргийн хүрээгээр хязгаарлалаа.

Аудитын хүрээнд дээрх цагдаагийн хэлтсүүдийн Хэрэг бүртгэх тасаг, Мөрдөн байцаах тасагт байгаа 2015 оны дугаартай ЭБШХ-ийн 205 дугаар зүйлийн 205.1.1-т заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн хэргийн материалтай нүд үзэн танилцаж, мэдээллийн сан дахь яллагдагчийн мэдээллийг тулгаж шалгав.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

“Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх /Код 710/ журам”-д заасны дагуу гэмт хэргийн илрүүлэлтийн хувийг тооцохдоо бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй нийт хэргийн тоог дээрх хэргээс яллагдагчаар татаж, ял сонсгосон хэргийн тоонд харьцуулан гаргаж байна. ЭБШХ-ийн 205 дугаар зүйлийн 205.1.1-т заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн хэрэг нь илрээгүй хэрэг бөгөөд тухайн хэргийн мэдээллийн санд яллагдагчийн маягт шивэх ёсгүй юм.

Аудитад хамрагдсан дүүргийн 6 цагдаагийн хэлтсийн Хэрэг бүртгэх тасаг, Мөрдөн байцаах тасагт хадгалагдаж буй 2015 оны дугаартай ЭБШХ-ийн 205 дугаар зүйлийн 205.1.1-т заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн нийт 915 хэргийн материалтай нүд үзэн танилцаж, мэдээллийн сантай тулгахад 18.3 хувь буюу 168 хэрэгт яллагдагчийн маягт шивж оруулснаас 39 хэрэгт “Яллагдагчаар татах тогтоол” үйлдсэн байлаа. Өөрөөр хэлбэл илрээгүй 129 хэрэг цагдаагийн байгууллагын мэдээллийн санд илэрсэн төлөвтэйгээр бүртгэгдсэн байна /Хавсралт 1/.

Мэдээллийн санд яллагдагчийн маягыг буруу шивсэнээс шалтгаалан дээрх цагдаагийн хэлтсүүдийн 2015 оны гэмт хэргийн

илрүүлэлтийн хувь доод тал нь 1-5 хувь, дунджаар ■ хувь зохиомлоор өсөж бүртгэгджээ. Мөн ■ иргэний хувийн байдал цагдаагийн байгууллагын мэдээллийн санд гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон мэтээр бүртгэгдсэн байна /Хавсралт 2/.

Дээрх байдлаас шалтгаалан гэмт хэргийн илрүүлэлтийн талаарх статистик мэдээлэл бодит байдлаас зөрүүтэй гарах, цаашид энэ зөрчил даамжирвал цагдаагийн нэгж, алба хаагчдын ажилдаа хандах хандлагад сөргөөр нөлөөлж, гэмт хэргийн илрүүлэлтийн хувь хуурамчаар өсч, бодит байдал дээр буурах, цагдаагийн байгууллагын мэдээллийн санд гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон байдлаар бүртгэгдсэн иргэдийн хувийн байдал дордож, гомдол гаргасан нөхцөлд цагдаагийн байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

4. ДҮГНЭЛТ

ЭБШХ-ийн 205 дугаар зүйлийн 205.1.1-т заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн хэрэгт холбогдуулан мэдээллийн санд яллагдагчийн маягт хуурамчаар шивж оруулах замаар гэмт хэргийн илрүүлэлтийн хувийг өсгөсөн зөрчил дотоод аудитад хамрагдсан дүүргийн цагдаагийн хэлтсүүдэд байна. Аудитын хүрээнд 2015 оны дугаартай нийт 915 эрүүгийн хэргийн материалыг мэдээллийн сантай тулгахад 129 хэрэгт яллагдагчийн маягт шивсэн нь гэмт хэргийн илрүүлэлтийн хувийг нэгж тус бүрт хамгийн багадаа 1-5 хувь, дунджаар ■ хувь өсгөжээ. Үүнээс үзвэл Улаанбаатар хот болон улсын хэмжээнд 2015 оны гэмт хэргийн илрүүлэлтийн хувь ■ орчим хувийн зохиомол өсөлттэй гэсэн урьдчилсан таамаглалыг дэвшүүлэх боломжтой байна.

Түүнчлэн ■ эрүүгийн хэрэгт ■ /давхардсан тоогоор/ иргэнийг гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, яллагдагчаар татагдсан байдалтайгаар мэдээллийн санд бүртгэсэн нь тухайн иргэдийн хувийн байдлыг дордуулжээ.

5. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Дээрх зөрчил үүсэхэд гэмт хэрэг хамтран үйлдсэн этгээд нь тогтоогдоогүй шалтгаанаар түдгэлзүүлсэн хэрэгт сэжигтэн яллагдагчийн сангийн баяжилт хийх сангийн шийдэл, гэмт хэргийн илрүүлэлтийг тооцох аргачлал, тухайн мэдээллийг санд шивж оруулсан алба хаагч, түүнд хяналт тавих үүрэгтэй хэрэг бүртгэх, мөрдөх байцаах тасгийн дарга нарын ажлын хариуцлага, тухайн нутаг дэвсгэрийг хариуцсан удирдах албан тушаалтан болон бусад алба хаагчдын оролцоо нөлөөлсөн байх боломжтой байна.

Иймд аудитын үр дүнд суурилан зөрчлийг дахин давтуулахгүй байх чиглэлээр дараах зөвлөмжийг холбогдох нэгжүүдэд хүргүүлэх саналтай байна. Үүнд:

- Гэмт хэрэг хамтран үйлдсэн этгээд нь тогтоогдоогүй үндэслэлээр түдгэлзүүлсэн хэрэг цагдаагийн байгууллагын мэдээллийн санд илэрсэн төлөвтэй бүртгэгдэж байгааг залруулж, гэмт хэргийн илрүүлэлтийг тооцох аргачлал, сангийн мэдээллийг боловсронгуй болгох
 - Хэргийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг санд цаг алдалгүй тухай бүр оруулахад онцгой анхаарах
 - Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн дарга нар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчдын шалгаж буй хэргийн материал, сангийн баяжилт хийж буй байдалд хяналт тавих үүргээ хариуцлагатай хэрэгжүүлэх
 - Гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах нэгжээс нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсийн түдгэлзүүлсэн хэргийн материалыг сангийн мэдээлэлтэй тулгаж, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах ажлыг тогтмол зохион байгуулах.

6. УДИРДЛАГЫН ТАЙЛБАР

Аудитад хамрагдсан нэгжүүдээс ирүүлсэн Удирдлагын тайлбарт илэрсэн зөрчлийг арилгасан тухай тайлан, мэдээлэл ирүүлснийг энэхүү тайланд хавсаргав.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2016 оны 05 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Улаанбаатар хотын цагдаагийн газрын Сүхбаатар, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэс, Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэс, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн гуравдугаар хэлтэс, Төв, Дархан-Уул аймаг дахь цагдаагийн газар

Аудитын объект: Хэсгийн байцаагчийн үйл ажиллагаа

Аудитын төрөл, код: Үйл ажиллагааны аудит

Аудитын хугацаа: 2016.03.25- 2016.05.05

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Н.Батзогсох

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа С.Дина, М.Азжаргал

1. ТАНИЛЦУУЛГА

1.1 Хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны талаар:

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2003 оны 229 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ын 1.2-т “Цагдаагийн байгууллагын тухай хуулиар даалгасан гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам хамгаалах урьдчилан сэргийлэх үүргийг хэрэгжүүлэхээр тодорхой нутаг дэвсгэрийн нэгжийг хариуцсан Цагдаагийн төв байгууллагаас томилсон цагдаагийн алба хаагчийг хэсгийн байцаагч” гэж заасан байна. Хэсгийн байцаагч нь Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий цагдаагийн байгууллагын анхан шатны нэгжийн ажилтан бөгөөд иргэдийн дунд ажиллах үндсэн албан тушаал юм.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд хамааралтай дараах журмууд байна. Гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалах /код 205/, Биечилсэн судалгаа хийх /код 212/, Гэмт хэрэг, зөрчлийг шалгах хойшлуулшгүй ажиллагаа /код 213/, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх /код 227/, Эрэн сурвалжлах /код 229/ зэрэг⁵ 30 журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Хэсгийн байцаагч нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2003 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 229 дүгээр тушаалаар баталсан “Хэсгийн

байцаагчийн ажлын заавар”, 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталгаажуулсан “Хэсгийн байцаагчийн ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолт”-ыг үндэслэн ажлаа төлөвлөн, зохион байгуулдаг байна. Уг зааварт хэсгийн байцаагч дараах судалгаатай байна⁶ гэж заасан. Үүнд:

1. Сум, баг, хорооны зураглал,
2. Хүн амын судалгаа, өрхийн дэлгэрэнгүй бүртгэл,
3. Тухайн нутаг дэвсгэрт байрлах албан газар, байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн эдийн засгийн чадавх,
4. Гарсан гэмт хэрэг, зөрчил, түүний нөхцөл, шалтгааны талаарх судалгаа,
5. Тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдээд гэмт этгээд нь тогтоогдоогүй хэргийн судалгаа,
6. Гэмт хэрэг, зөрчилд холбогдогчийн судалгаа,
7. Гэмт хэрэг үйлдээд даалтанд байгаа, гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй сэжигтэй хүмүүсийн бүртгэл,
8. Эрэн сурвалжлагдаж буй оргодол, этгээдүүдийн судалгаа,
9. Хорих ял эдлээд суллагдсан, хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй, ял хойшлогдсон хүмүүсийн судалгаа,
10. Гэр бүл, орчиндоо байнга тааламжгүй байдал гаргадаг хүмүүсийн судалгаа,
11. Тухайн нутаг дэвсгэрт түр оршин суух гадаадын болон харъяалалгүй иргэдийн судалгаа,
12. Автомашин, бууны бүртгэл,
13. Насанд хүрээгүй хүмүүсийг уруу татагчдын судалгаа,
14. Тамга, тэмдэг, олшруулагчийн бүртгэл судалгаа,
15. Туслах хүчний судалгаа зэрэг объект, субъектын судалгаа хийж, баяжуулахаар заасан байна.

Мөн уг зааварт сум, дүүрэг, баг, хорооны Иргэдийн төлөөлөгчдийн болон нийтийн хурал, тухайн шатны Засаг дарга хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх асуудлаар хэсгийн байцаагчийг удирдана гэж заажээ. Иргэдийн төлөөлөгчдийн болон нийтийн хурал, тухайн шатны Засаг дарга нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэсгийн байцаагчтай хамтран ажиллах төлөвлөгөө гаргах, мөн хэв журам хамгаалах чиглэлээр олон нийтийн эргүүл, жижүүр ажиллуулах тухай захирамж гаргах, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгт хяналтын камер суурилуулах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн эрсдэлийн нөхцөл байдлыг тодорхойлох, үнэлгээ гаргах, хөршийн хяналт хөтөлбөр гэх мэт ажлыг хэрэгжүүлж байна. Хэсгийн байцаагч нь иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй өргөдөл, гомдлыг хүлээн авч шалгаж байна.

Захиргааны зөрчлийг хуулийн хугацаа буюу 14 хоногт, шаардлагатай тохиолдолд тасгийн даргаар 14 хоногийн хугацаагаар сунгуулж, нийт 28

хоногийн дотор шалгаж шийдвэрлэнэ. Хангалттай үндэслэл тогтоогдсон тохиолдолд зөрчил гаргасан этгээдийг захиргааны журмаар баривчлуулж, торгуулийн хуудсаар болон шийтгэврээр торгох арга хэмжээ авдаг байна. Захиргааны арга хэмжээ авсан материалыг захиргааны тоо бүртгэгчид хүлээлгэн өгөхдөө захиргааны шийтгэл ногдуулсан, хохирогчийн талаарх болон захиргааны зөрчлийн картуудыг бөглөж, санд шивж оруулах ажиллагааг хийж байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

2.1.1.Хэсгийн байцаагчийн ажлын ачааллыг тооцох, гүйцэтгэх ажлын цар хүрээ, хэмжээ хязгаарыг тодорхойлох;

2.1.2.Хэсгийн байцаагчийн ажлыг ямар шалгуур үзүүлэлтээр дүгнэвэл оновчтой байхыг тодорхойлох;

2.1.3.Хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн орчинг сайжруулах хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор аудит хийгдсэн.

2.2 Аудитын цар хүрээ

Улаанбаатар хотын цагдаагийн газрын Сүхбаатар, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэс, Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэс, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн гуравдугаар хэлтэс, Төв, Дархан-Уул аймгийн цагдаагийн газрын хэсгийн байцаагч нар хамрагдсан.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Засгийн газрын 2011 оны “Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” 153 дугаар тогтоолын хавсралтаар “4000 хүн ам тутамд 1 хэсгийн байцаагч ажиллах”-аар тогтоосон жишиг нормативыг мөрдөж ажиллаагүйгээс хэсгийн байцаагчийн ажлын ачаалал нэмэгдсэн байна.

Шалгуур: Засгийн газрын 2011 оны “Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” 153 дугаар тогтоолын хавсралтаар “4000 хүн ам тутамд 1 хэсгийн байцаагч ажиллуулна” гэж жишиг нормативыг тогтоосон байна.

Бодит нөхцөл байдал: Хүн ам, аж ахуйн нэгжийн нягтаршил ихтэй хороодод 3, бусад хороодод 2, нийт Улаанбаатар хотын хэмжээнд 271, орон нутагт 121, улсын хэмжээнд нийт 392 хэсгийн байцаагч нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэг гүйцэтгэж байсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн “Улаанбаатар хотын цагдаагийн газар, харьяа нэгж, дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн бүтцийн зураглал, орон тоо батлах тухай” Б/284 дүгээр тушаалаар хороонд 1 хэсгийн байцаагч ажиллуулж эхэлсэн бөгөөд нийслэлийн 152 хороонд 154, орон нутагт 122, нийт улсын хэмжээнд 276 хэсгийн байцаагчийн орон тоог баталсан. Өнөөдрийн байдлаар нийслэлд 147, орон нутагт 116, нийт 263 хэсгийн байцаагч ажиллаж байна. Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэст 2, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэс, Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэст тус бүр 1, Төв аймаг дах цагдаагийн газарт 3, Хэнтий аймгийн дахь цагдаагийн газарт 2, Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газарт 1, нийт 13 хэсгийн байцаагчийн орон тоо дутуу байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 284 дүгээр тушаалаар баталсан бүтэц орон тоогоор Улаанбаатар хотын төвийн 14 дүүргийн цагдаагийн хэлтсийн нийтийн хэв журам хамгаалах тасагт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах чиг үүрэг бүхий дараах алба хаагчид үүрэг гүйцэтгэж байна⁴.

Дүүргүүд	БГД-1	БГД-2	БЗД-1	БЗД-2	БЗД-3	СБД-1	СБД-2	СХД-1	СХД-2	СХД-3	ХУД-1	ХУД-2	ЧД-1	ЧД-2	Бүгд
Дэд хэсгийн ахлах байцаагч	2	2	1	2	2	3	3	3			1	1	3	2	25
Хэсгийн байцаагч	13	10	8	11	9	8	12	13	9	10	5	11	9	10	138
Хороо хариуцсан цагдаа	13	10	8	11	9	8	12	13	9	10	5	11	9	10	138
Эргүүлийн офицер	25	25	22	37	22	27	28	42	20	24	8	28	22	34	364
Эргүүлийн цагдаа жолооч	16	20	16	24	16	24	24	27	20	16	8	12	20	30	273
Эргүүлийн цагдаа	21	13	21	14	5	22	1	9	1		1	8	2	2	120
Телекамерын цагдаа	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	56
Нийт дүн	94	84	80	103	67	96	84	111	63	64	28	71	65	88	1110

Нийслэлийн 1 хороонд дундажаар 8648 хүн амьдарч байнга оршин сууж байна. 641-1990 хүртэл хүн амтай 3, 2104-өөс дээш 2, 3354-өөс дээш хүн амтай 4, 4329-өөс дээш хүн амтай 9, 5030-аас дээш хүн амтай 15, 6026-аас дээш хүн амтай 18, 7034-өөс дээш хүн амтай 20, 8065-аас дээш хүн амтай 20, 9011-ээс дээш хүн амтай 11, 10010-аас дээш хүн амтай 8, 11025-аас дээш хүн амтай 13, 12210-аас дээш хүн амтай 8, 13382-оос

⁴ Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны Б/284 дүгээр тушаалаар батлагдсан дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн бүтэц орон тооны жагсаалтаас авсан.

дээш хүн амтай 4, 14043-аас дээш хүн амтай 4, 15647-оос дээш хүн амтай 6, 16669-өөс дээш хүн амтай 1, 17126-аас дээш хүн амтай 4, 18834-өөс дээш хүн амтай 1 хороо байна. Багануур дүүргийн 2 хороо хамгийн бага хүнтэй бөгөөд тэнд 215 өрхийн 641 хүн оршин сууж байна⁵.

Шалтгаан: Улсын хэмжээнд 392 хэсгийн байцаагчийн орон тоо байсныг 276 болгон 116 хэсгийн байцаагчийн орон тоог хасаж, 138 хороо хариуцсан цагдаагийн орон тоог нэмжээ. Гэтэл томилсон цагдаа нарыг тухайн дүүргийн нөхцөл байдлаас шалтгаалан хороон дээр нь ажлуулахгүй, албадан саатуулах, явган болон машинт эргүүл, жижүүрийн албан хаагч өвчтэй, чөлөөтэй, шилжсэн тохиолдолд уг орон тоог нөхөх байдлаар үүрэг гүйцэтгүүлж байна. Энэ нь хороон цагдаа нар хариуцсан хороон дээрээ ажиллахгүй, хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд туслалцаа, дэмжлэг үзүүлж чадахгүй байна.

Үр нөлөө: Цагдаагийн байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн буурах, алба хаагчдын ажлын ачааллыг нэмэгдэх эрсдэл үүсхээр байна.

3.2 Хэсгийн байцаагч нарын ажиллах орчин нөхцөл, баталгаа харилцан адилгүй байна.

Шалгуур: “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т “Цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, тэтгэвэр тэтгэмж авах, ажлын өндөр амжилт гаргасан гавьяа зүтгэлийг нь үнэлж, шагнаж урамшуулна”, 4.3-т “Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцлөөр хангуулна”, 4.5-д “Тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажилласан хэсгийн байцаагч аминдаа орон сууц барих, амьдралын нэн тэргүүний хэрэгцээт зүйлс худалдан авах, өөрийн хүсэлтээр суралцах болон хүүхдээ сургахад нь зориулан байгууллагаас хөнгөлттэй зээл олгох, шаардлагатай бол зээлийн баталгаа гаргаж өгнө”, “Төрийн хөрөнгөөр давтан сургах, мэргэшлээ дээшлүүлэх, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалынхаа цалин хөлсийг авна” гэжээ.

Бодит нөхцөл байдал:

1. Нийт 281 хэсгийн байцаагчийн 2013-2016 онд шагнагдсан байдлын талаар судалгаа авахад Төрийн дээд шагнал одон, медиалаар шагнагдсан алба хаагч байхгүй, Хуулийн зүйн яамны “Хүндэт жуух”, мөнгөн шагналаар 4, Цагдаагийн ерөнхий газрын “Албаны төлөө I медаль”-аар 1, “Албаны төлөө II медаль”-аар 9, “Албаны төлөө III медаль”-аар 10, “Хүндэт жуух”-аар 9, “Баярын бичиг”-ээр 8 алба хаагч тус тус шагнагдсан байна. 281 хэсгийн байцаагчаас 41 хэсгийн байцаагч ажлын үр дүнгээр шагнагдсан нь нийт хэсгийн байцаагч нарын 14.5 хувь байна.

2. Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, иргэдийг чирэгдэл, бухимдалгүй нэг цэгээс үйлчлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор иргэдэд нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн

⁵ Нийслэлийн статистикийн газраас гаргасан 2014 оны хороодын хүн амын тоо

барилгыг үе шаттайгаар барих ажлыг эхлүүлээд байна. Өнөөдрийн байдлаар нийслэлийн 104 хэсгийн байцаагч цогцолбор байранд, 42 хэсгийн байцаагч цогцолбор байрны хонгилд, 4 хэсгийн байцаагч коридорт тусгаарласан өрөөнд, 8 хэсгийн байцаагч орон сууцны 1 дүгээр давхар буюу дэд хэсгийн байранд үйл ажиллагаа явуулж байна. Ажиллах нөхцөл, орчиноо сайжруулахын тулд хэсгийн байцаагч нар өөрсдийн зардлаар албан өрөөгөө зассан байна.

3. Улаанбаатар хотын цагдаагийн газрын даргын 2013 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн “Жишиг хэмжээг тогтоох тухай” 138 дугаар тушаалаар хэсгийн байцаагч нарт сард 125 ширхэг бичгийн цаас, 3000 төгрөгийн ярианы карт олгодог байна. Судалгаа бүртгэлээ шинэчилж, үзэмжтэй хийхийн тулд өнгөт цаас, хавтас, хальсан уут авах, материалжуулах, хариуцсан хорооны нутаг дэвсгэрт байгаа ААНБ бүрт мэдэгдэл, зөвлөмж өгөх иргэдэд хандсан санамж, сэрэмжлүүлэг бэлтгэн орц, дэлгүүр, ААНБ бүрт байрлуулах, тусгай болон нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж материалжуулах, өргөдөл гомдлын материал бүрдүүлэх зэрэг ажлын зардлыг хувиасаа гаргаж байна. Сард олгож байгаа 2500-3000 төгрөгийн нэгж нь 1 өдөр л хэргийн холбогдогч, саатуулах хүний ар гэр лүү яриад л дуусдаг.

4. Албанаас тавьж олгосон хувилагч /принтер/ байдаггүй тул алба хаагчид бүгд өөрсдөө худалдаж авах юм уу гэрээсээ авч ирж албандаа ашигладаг. Санамж сэрэмжлүүлэг тарах материалыг өөрсдөө хувилан олшруулдаг ба принтерийн хор дээд тал нь 1500 хуудас гаргаад дуусдаг. Өөрсдөө хороо цэнэглэнэ 7-8 удаа цэнэглэсэн хор дахин цэнэглээд ч гардаггүй тул 3-4 сар тутамд шинэ хор өөрсдийн мөнгөөр худалдан авч байна.

5. Албаны унаа байхгүй тул саатуулах байрнаас захиргааны зөрчил гаргасан хүнийг авах, баривчлуулах, захиргааны шийтгэл ногдуулах хүнийг эмнэлэгт үзүүлэх, шүүх рүү авч явах, дуудлага мэдээллийг шалгах зэрэг бүхий л үйл ажиллагаанд хувийн машинаа ашиглаж байна.

6. Улаанбаатар хотын цагдаагийн газраас хийсэн дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн хороодын байршил, хоорондох зайн судалгаанаас үзвэл: Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо 14.5 км, 15 дугаар хороо 20 км, 18, 20 дугаар хороо 13.5 км, 21, 23 дүгээр хороо 10.1 км, 28 дугаар хороо 11.1 км, Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хороо 19.6 км, Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороо 14 км, 21 дүгээр хороо 60 км, 27 дугаар хороо 25 км, Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо 16 км, Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо 29 км, 13 дугаар хороо 39 км, 14 дүгээр хороо 18 км зайтай байна. Иймд хэсгийн байцаагчийн аюулгүй байдлыг хангах, тэдний ар гэртээ зарцуулах цагийг нэмэгдүүлэх, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор тухайн хороонд оршин сууж амьдардаг, алба хаагчийг уг хороонд хэсгийн байцаагчаар томилж, ажиллуулвал илүү үр дүн гарахаар байна.

7. Хэсгийн байцаагчийн өдөр тутмын гүйцэтгэж байгаа үндсэн үүргийн нэг бол “Цагдаагийн байгууллагын туслах тоо бүртгэлийн заавар”-ын дагуу холбогдох бүртгэл судалгааг хөтөлж, санд оруулах, баяжилт хөдөлгөөн хийх ажил байдаг. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн камержуулалт, дохиолол хяналтын нэгдсэн систем бүрдүүлэх зорилгоор 2011-2012 онд нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн утасгүй /4.9 гГр/ сүлжээг цагдаагийн байгууллага ашиглаж байна. Өнөөдрийн байдлаар энэ сүлжээнд 75 хорооны хэсгийн байцаагч холбогдсон. Гэтэл суурилагдсан тоног төхөөрөмж нь хулгайд алдагдсан, техникийн болон цахилгааны хэлбэлзлийн улмаас гэмтэж ашиглах боломжгүй болсон шалтгаанаар сүлжээ нь ашиглагдахгүй байгаа 63 хэсгийн байцаагч байна. Багануур, Налайх дүүргийн цагдаагийн хэлтэс, Багахангай дүүргийн цагдаагийн тасгийн нийт 14 хэсгийн байцаагч сүлжээнд огт холбогдоогүй байна. Сүлжээний хурдаас хамаарч мэдээлэл оруулахад гацах, шивэгдсэн мэдээлэл санд ороогүй байх зэрэг хүндрэл байнга гарч байна.

8. Дархан-Уул, Төв аймгийн цагдаагийн газрын хэсгийн байцаагчид мөн сүлжээнд холбогдоогүй. Бусад орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсийн хэсгийн байцаагч нар сүлжээнд холбогдсон эсэх нь тодорхойгүй бөгөөд энэ талаар Нийтийн хэв журам хамгаалах албаны хэсгийн байцаагч хариуцсан ахлах мэргэжилтэнгээс тодруулахад мэдэхгүй байна. Нийтийн хэв журам хамгаалах албанаас Судалгаа, хяналтын мэдээллийн санд шивэгдсэн захиргааны хяналтын мэдээ, шашны байгууллагуудын судалгааны баяжилтийг 2016 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар хянаж үзэхэд мэдээлэл зөрүүтэй, зарим иргэдийн мэдээллийг бүртгээгүй, бүртгэгдсэн гэх боловч алдаатай, дутуу оруулсан байна.

Шалтгаан: Хэсгийн байцаагчийн албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөл, баталгаагаар хангах талаар удирдлага, зохион байгуулалтын тодорхой шинэчлэл хийгдээгүй, нэгэн хэвийн байдлаар хандаж ирсэн байна.

Үр нөлөө: Дээрх шалгуурыг мөрдөж ажиллаагүйгээс хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд доголдол гарах, албаны нэр хүндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх, хэсгийн байцаагчийн ажилдаа хандах хандлага сулрах үр дагавар үүсэхээр байна.

3.3 “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”, “Хэсгийн байцаагчийн ажлын байр”-ны тодорхойлолтын хоорондын уялдаа холбоо хангалтгүй байна.

Шалгуур: Цагдаагийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллага мөн”, “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ын 6 дугаар зүйл “Хэсгийн байцаагчийн үндсэн үүрэг”.

Бодит нөхцөл байдал: Цагдаагийн албаны тухай хууль хэрэгжсэнээр Нийтийн хэв журам хамгаалах албаны үндсэн чиг үүрэг өөрчлөгдсөн, үүнтэй холбогдуулан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд нэмэлт өөрчлөлт орж, 2012 онд хэсгийн байцаагчийн үндсэн үйл ажиллагаанд мөрдөж байсан 17 эрх зүйн акт, өнөөдрийн байдлаар 30 болж өсчээ.

Өнөөдрийн хүчин төгөлдөр үйлчилж буй хэсгийн байцаагчийн ажлын заавар, ажлын байрны тодорхойлолт нь хоорондоо хэрхэн уялдсан эсэхийг авч үзэхэд, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэсгийн байцаагчийн хийж гүйцэтгэх ажлыг тодорхой зааж өгөөгүйгээс энэ чиглэлийн бүх ажил, түүний үр дүн, хүлээх хариуцлага нь хэсгийн байцаагчид ногддог байна. Тухайлбал, 1 мөрдөн байцаагч өөрийнхөө шалгасан хэргийнхээ шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээ авхуулахаар 1 сарын дотор 1 хэсгийн байцаагчид 19 мэдэгдэл, 2 даалгавар өгсөн байна. Мэдэгдэл, албан даалгаварт мөрдөн байцаалтаар уг гэмт хэрэгт ямар шалтгаан нөхцлийг тогтоогдсон нь тодорхойгүй, гүйцэтгүүлэхээр даалгасан ажил нь тухайн гэмт хэргийн нөхцөл байдалтай уялддаггүй, хорооны судалгаа гаргах, маршрутын тогтоох, хяналтад авах, эрэн сурвалжлах зэрэг ажил хийхийг даалгаж, биелэлтийг тогтоосон хугацаанд ирүүлээгүй бол хуулийн дагуу арга хэмжээ авна гэж мэдэгддэг жишиг тогтсон байна.

Ажлын байрны тодорхойлолтод хэсгийн байцаагчийн гүйцэтгэх ажил үүргийг нарийн зааглаагүйгээс олон чиглэлийн ажил руу ордог, эргээд хийгдсэн ажлын гүйцэтгэл нь үнэлэгдэхгүй, хэрхэн яаж үнэлэх, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тодорхой тусгаагүй байна. Улаанбаатар хотын цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах газарт Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах гэсэн мэргэжил арга зүйн 2 хэлтэстэй. Нэгж дээр энэ 2 хэлтсийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч нь 1 хэсгийн байцаагч болж байна. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх дуудлага мэдээллийг шуурхай шалгаж шийдвэрлэн бүртгэл судалгаанд аваагүй бол хариуцлага хүлээнэ. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилах арга хэмжээг хариуцсан хорооныхоо нутаг дэвсгэрт зохион байгуулна. Хөрөнгө санхүүгийн асуудал, цаг хугацаанаас шалтгаалж ажлын үр дүн, чанарын асуудал яригдвал бас л арга хэмжээ тооцогддог байна.

Мөн ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтыг боловсруулахдаа бусад алба хаагчдын тухайлбал хэсгийн төлөөлөгч, эрүүгийн төлөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын гүйцэтгэх чиг үүрэг, ажлын ачааллыг тооцох ажлын байрны шинжилгээ хийгдээгүй байна.

Шалтгаан: Цагдаагийн албаны тухай хуульд нийцүүлэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2003 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 229 тоот тушаалаар баталсан “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ыг

шинэчлэн боловсруулаагүй, “Хэсгийн байцаагчийн ажлын байр”-ны тодорхойлолтыг боловсруулахдаа хууль, зааврын хоорондын уялдаа холбоог хангаагүйгээс шалтгаалан хэсгийн байцаагчийн өдөр тутмын үйл ажиллагаанд ажил үүргийн давхардал үүссэн байна.

Үр нөлөө: Хэсгийн байцаагчийн гүйцэтгэж байгаа ажил үүрэг нь хэсгийн төлөөлөгч, эрүүгийн төлөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, эргүүлийн офицерын гүйцэтгэх ажил үүрэгтэй давхардсанаас хэсгийн байцаагчийн ажлын ачаалал нэмэгдэх, байгууллагын хэвийн үйл ажиллагаанд сөрөг үр дагавар үүсэхээр байна.

3.4 Хэсгийн байцаагчийн ажил дүгнэх үзүүлэлт нь хэсгийн байцаагчийн өдөр тутмын хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай нийцэхгүй байна.

Шалгуур: “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ын 11 дүгээр зүйл “Хэсгийн байцаагч ажлын дүнг тооцох үнэлэмж”, “Алба хаагчийн ажлыг үнэлэх /код 111/ журам”-ын 111.4.18.2 дахь заалт.

Бодит нөхцөл байдал: Алба хаагчийн ажлыг үнэлэх /код 111/ журмын /маягт ЦБУАЖ №111.4182.ж/ хавсралтад зааснаар хэсгийн байцаагчийн ажлыг 23 /44/, хэсгийн байцаагчийн заавраар 9/10/ үзүүлэлтээр дүгнэхээр байна. Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын 268 хэсгийн байцаагчийн 2016 оны нэгдүгээр улирлын ажлын дүн мэдээгээр нэгдүгээр байранд орсон хэсгийн байцаагч Улаанбаатар хотод 2537, орон нутагт 1877, дундаж оноотой хэсгийн байцаагч хотод 979, орон нутагт 600, хамгийн бага оноотой хэсгийн байцаагч нь хотод 124, орон нутагт 123 оноотой дүгнэгдсэн байна.

Аймаг, нийслэл, орон нутгийн онцлог, хүн амын тоо /5000-19000 хүн амтай/, байршил, ажлын ачаалал харилцан адилгүй тул хэсгийн байцаагчдын ажлыг адилтган дүгнэх боломжгүй байна.

Захиргааны зөрчлийг материалжуулан шалгасан тоо, мэдээ Дорнод аймагт 29-118, Хэнтий аймагт 102-189, Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэст 41-144 зөрчлийг материалжуулан шалгасан байна.

Дүүргүүдийн цагдаагийн хэлтсийн хороод цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээнд холбогдсон эсэхээс шалтгаалж Patrol сангийн ашиглалт хангалтгүй байна. Тухайлбал: Сүхбаатар дүүрэг дэхь цагдаагийн 1 дүгээр хэлтсийн хэсгийн байцаагчдын компьютер сүлжээнд холбогдоогүйгээс оройн цагаар хэлтэс дээрээ ирж, орон нутагт мэдээлэл судалгааны байцаагчаар дамжуулж мэдээгээ санд оруулдаг байна. Хөөн хэлэлцэх хугацаа зогсоосон/-5/, хөөн хэлэлцэх хугацаа зогсоосон материалаас шийдвэрлэсэн/2/, захиргааны журмаар түр хураагдсан эд зүйлсийг санд шивсэн бүрт/2/, хохирогчийг хамгаалах байранд хүргэж өгсөн тоо/3/, шүүхэд эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргасан тоо/3/, эрэн сурвалжилж олсон мал, тээврийн хэрэгсэл, галт зэвсэг гэсэн үзүүлэлтүүд ихэвчлэн дүгнэгдэхгүй хоосон байна.

Олон нийтийн цагдаагийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласан тухай бүрт 5 оноо гэж заасан. Улаанбаатар хотод 1 хороонд 2 олон нийтийн цагдаа ажиллаж байгаа бөгөөд 2 онца * 21 аж.хоног*5 оноо = 210 оноо авах ёстой. Орон нутагт 1-2 олон нийтийн цагдаагийн ажилтантай бөгөөд одоогоор 4 аймагт огт байхгүй байна. Олон нийтийн цагдаагийн ажилтан байхгүй, цөөхөн тоогоор ажилладаг, хороон дээр ажилладаггүй бол хэсгийн байцаагч дээрх оноог авч чадахгүй байдал ажиглагдаж байна.

Шинэлэг ажил санаачилсан тухай бүрт 25 оноо өгөхөөр тусгасан бөгөөд ямар ажлыг “шинэлэг ажил” гэдгийг тайлбарлаагүйгээс зарим аймгууд зохион байгуулсан арга хэмжээ бүрийг тооцдог байна.

“Мэдэгдэл, зөвлөмж өгч үр дүнг тооцсон байдал” хэсэгт өгсөн мэдэгдэл үү, мэдэгдлийн хариу авсныг тооцох уу, нэг утгатай олон мэдэгдлийг аж ахуйн нэгж, байгууллагад өгсөн тоогоор эсвэл нэг утгатай мэдэгдлийг нэг гэж тоолох эсэхийг тодорхойлсон аргачлал байхгүй байна. Ямар дуудлагыг гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл гэж бүртгэх талаар нэгдсэн ойлголт байхгүйгээс дуудлага, мэдээлэлд очиж ажилласан тоо харилцан адилгүй байна. Цагдаагийн нэг хэлтсийн хэсгийн байцаагчийн дүн мэдээнд гэр бүлийн хүчирхийллийн 79 дуудлагаар очиж шалгасан боловч хүчирхийлэл үйлдэгчийг саатуулах арга хэмжээ огт аваагүй байна.

Шалтгаан: Хэсгийн байцаагчийн өдөр тутмын үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд баримталж байгаа шалгуур “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”, “Алба хаагчийн ажлыг үнэлэх /код 111/ журам”-ын /маягт ЦБҮАЖ №111.4182.ж/ хавсралт, Монгол улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх /код 701/, Судалгаа, хяналтын тоо бүртгэл хөтлөх /код 703/ журам, “Хэсгийн байцаагчийн ажлын байр”-ны тодорхойлолт зэрэг эрх зүйн актуудын хоорондын уялдаа холбоог хангаагүйгээс хэсгийн байцаагчийн ажил бодитой үнэн зөв дүгнэгдэхгүй, зохиомолоор ажлын ачаалал, ажил үүргийн давхардал үүсч байна.

Тухайлбал, Хэсгийн байцаагчийн ажлын заавраар хэсгийн байцаагч 15 төрлийн судалгаа хийхээр заасан бол Судалгаа, хяналтын тоо бүртгэл хөтлөх /код 703/ журмаар 41 бүртгэлийг хөтөлж мэдээллийн санд оруулахаар, захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй өргөдөл гомдол шалгасан тохиолдолд Монгол улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх /код 701/ журмаар 21 төрлийн маягтыг бөглөж санд оруулахаар байна. Өнөөдөр нэг хэсгийн байцаагч нийт 77 төрлийн бүртгэл, судалгаа хөтлөхөөр харагдаж байна.

Үр нөлөө: Хэсгийн байцаагчийн өдөр тутмын гүйцэтгэж байгаа ажил үүрэгтэй уялдуулан ажлын байрны тодорхойлолт, ажил дүгнэх үзүүлэлт, хэсгийн байцаагчийн ажлын зааврыг шинэчлэн боловсруулж, өөрчлөхгүй бол хэсгийн байцаагчийн өөрийн хариуцсан нутаг дэвсгэртэй урьдчилан сэргийлэх ажлыг бодитой зохион байгуулах, олон нийт, цагдаагийн

байгууллагын хамтын ажиллагааг хангаж идэвжүүлэх, иргэдэд үзүүлэх цагдаагийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд эрсдэл үүсэхээр байна. Хэсгийн байцаагчийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, ажил дүгнэх шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тогтоох, ажлын ачааллыг бууруулах, урамшуулалын шинэлэг / *албан тушаалын зэрэглэлийг 1 шатаар нэмэгдүүлэх*/ арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй бол алба хаагчдын ажилдаа хандах хандлага сулрах, хэсгийн байцаагчаар ажиллах хүсэл сонирхолтой алба хаагчдын тоо цөөрөх үр дагавар үүсхээр байна.

4. ДҮГНЭЛТ

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулахад хэсгийн байцаагч онцгой үүрэгтэй. Хэсгийн байцаагчийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах ажилд удирдлага, зохион байгуулалтын тодорхой шинэчлэл хийгдээгүй, нэгэн хэвийн байдлаар явагдаж ирсэн байна. Аудитын үр дүнд илэрсэн асуудлуудыг дараах байдлаар дүгнэж байна. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор баталсан жишиг нормативын дагуу Улаанбаатар хотод 271, орон нутаг 121, улсын хэмжээнд нийт 392 хэсгийн байцаагч ажиллаж байсан бол өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод 154, орон нутагт 122, нийт 276 болж, 116 хэсгийн байцаагчийн орон тоо хасагдаж, 138 хороо хариуцсан цагдаагийн орон тоо нэмэгдсэн байна.

2. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссоос 2014 онд Цагдаагийн алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийн талаар судалгаа хийж, 4000 хүн ам тутамд 1 хэсгийн байцаагч, хороо бүрт эрүүгийн төлөөлөгч, цагдаа, Нийслэлд 15000 хүн ам тутамд 2-оос доошгүй, аймгийн төвд 5000 хүн ам тутамд нэгээс доошгүй чиглэлд хэв журмын эргүүл үүрэг гүйцэтгэвэл цагдаагийн алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийг хангаж, албаны үйл ажиллагааг хэвийн явуулах боломжийг бүрдүүлэх боломжтой гэсэн дүгнэлт, санал гаргаж Монгол Улсын Их Хуралд хүргүүлсэн байна. Иймд цагдаагийн байгууллагын үйлчилгээг иргэн бүрт хүртээмжтэй хүргэж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгыг хангаж, алба хаагчдын ажлын ачааллыг багасгах, ажиллах нөхцөлийг сайжруулахын тулд дээрх жишиг нормативыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

3. Шинэчлэн батлагдсан Зөрчлийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхдийн хамгааллын тухай хууль 2016 оны 09 дүгээр сараас эхлэн хэрэгжиж эхлэхтэй холбогдон захиргааны хэрэг бүртгэгч, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хариуцсан алба хаагчдын орон тоог бий болгох асуудал тулгарч байна. Цагдаагийн ерөнхий газрын даргын

2015 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталгаажуулсан ажлын байр / албан тушаал/-ны тодорхойлолтод хэв журмын цагдаа гэсэн нийтлэг нэг тодорхойлолт батлагдсан. Бүтэц, орон тооны тушаалаар эргүүлийн цагдаа, хороо хариуцсан цагдаа, жижүүрийн цагдаа гэсэн нэршилтэй ажлын байр батлагдсан байна. Иймд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн бүтэц, орон тооны санал ирүүлж, алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хэрэгтэй байна.

4. Хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажиллах нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд Хан-Уул дүүргийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас хэсгийн байцаагч нарт дэмжлэг үзүүлэх зорилгоор дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хурлын 2013 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн “Журам батлах тухай” 03 дугаар тогтоолоор Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөлийн ажиллах журам”-ыг баталсан байна. Энэ журамд заасны дагуу урьдчилан сэргийлэх ажлын зардал гэж хороо хариуцсан хэсгийн байцаагч нарт сар бүр 98.000 төгрөг олгож байна. Иймд уг туршлагыг Улаанбаатар хотын хэмжээнд нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, ажиллах нь зүйтэй байна.

5. Одоо мөрдөгдөж буй эрх зүйн актуудаар хэсгийн байцаагч нь 77 төрлийн бүртгэл судалгаа хөтөлж, холбогдох мэдээллүүдийг үнэн зөв, хурдан шуурхай туслах тоо бүртгэлийн болон цахим санд оруулахаар заасан байна. Иймд хэсгийн байцаагчийн ажлын байранд ашиглагдаж байгаа техник хэрэгсэл, хангамжийг сайжруулж, цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээнд бүрэн холбуулах, сүлжээний хурдыг нэмэгдүүлэх нэн шаардлагатай байна.

6. Хэсгийн байцаагчийн ажлын заавар батлагдан хэрэгжээд 13 жил өнгөрсөн бөгөөд хууль, эрх зүйн орчин шинэчлэгдсэн, хэсгийн байцаагчийн ажлын чиг үүрэгт өөрчлөлт орсноор зарим заалт нь бодит байдалтай нийцэхгүй байна. Тухайлбал: *Аж ахуйн нэгж, байгууллагад ашиглаж байгаа өнөөт хувиллагч болон тамга тэмдгийг бүртгэж хяналт тавих, мотоцикль болон тээврийн хэрэгслийг улсын техникийн үзлэг тооллогонд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулж хяналт тавих, нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч, туслах ажилтныг өдөр тутам мэргэжлийн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг тооцох* гэх мэт заалтууд байна. Иймд шинэчлэн батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэн “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ыг боловсруулж, батлуулах шаардлагатай байна.

7. Хэсгийн байцаагчийн ажлын байрны тодорхойлолтыг боловсруулахдаа зорилго, зорилтыг нарийвчлан тодорхойлоогүй, гүйцэтгэх ажлын цар хүрээ, хэмжээ хязгаарыг оновчтой тогтоогоогүй, бусад ажлын байртай давхардсан ажил үүргийг арилгаагүй байна.

8. Хэсгийн байцаагч нарын ажлыг тоон үзүүлэлтээр бус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагааны

үнэлэмжийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүнг гол үзүүлэлт болгож, үр дүнг тооцох шалгуур үзүүлэлт, аргачлалыг оновчтой, ойлгомжтой байдлаар боловсруулж, мөрдүүлэхээр байна.

5. ЗӨВЛӨМЖ

Аудитын ажлын хүрээнд Хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль, тогтоомж, журмыг хэрэгжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааг сайжруулах, иргэдэд үзүүлэх цагдаагийн байгууллагын үйлчилгээг хүртээмжтэй болгох чиглэлээр дараах зөвлөмжүүдийг хүргүүлж байна. Үүнд:

Нийтийн хэв журам хамгаалах албанд:

1. Хэсгийн байцаагчийн ажлын зохион байгуулалтыг сайжруулж, албандаа хандах хандлага, албаны үнэлэмжийг дээшлүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2. Хэсгийн байцаагчийн нийгмийн баталгааг хангах зорилгоор хөтөлбөр, төсөл хэрэгжүүлж, цалингийн шатлалыг ТТ-10 болгож, 1 шатлал ахиулах;

3. Хэсгийн байцаагчийн ажлын байрыг цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээнд холбож, сүлжээний хурдыг нэмэгдүүлэх ажлыг Мэдээлэл, технологийн төвтэй хамтран хэрэгжүүлэх;

4. Хэсгийн байцаагчийн гүйцэтгэх ажлын цар хүрээ, хэмжээ хязгаарыг тодорхойлж, ажлын зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;

5. Хэсгийн байцаагчийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтэд түшиглэсэн хамтын ажиллагааны бодит үр дүн, чанарыг ажлын гол үзүүлэлт болгон ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг боловсруулж, батлуулах;

6. Цагдаагийн ерөнхий газрын дарга, Хүүхдийн төлөө үндэсний газрын дарга нарын хамтарсан 2014 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн “Журам батлах тухай” 765/А/119 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллага, хүүхэд асран хамгаалах байгууллагын хамтран ажиллах журам”-ын хэрэгжилтийг хангуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч, үр дүнг танилцуулах;

7. Цагдаагийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор энэ чиглэлийн үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдыг оролцуулсан уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж, урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэрийг өөрчлөх, үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтийг боловсруулж, мөрдүүлэх;

8. Хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч нарыг алба-амины автомашинаар хангах боломжийг судалж, санал боловсруулж танилцуулах;

9. Зөрчлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль 2016 оны 09 дүгээр сараас эхлэн мөрдөж эхлэхтэй холбогдуулан захиргааны хэрэг бүртгэлт, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх алба хаагчдын орон тоог нэмэгдүүлэх талаар тооцоо судалгаа хийж, санал танилцуулах.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэст:

1. Хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн төр, захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлж, хэсгийн байцаагчийн ажиллах нөхцөлийг сайжруулж, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцох;

2. Олон нийтийн цагдаагийн ажилтанг баг, хороон дээр ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх;

3. Дэд хэсгийн ахлахын гүйцэтгэх ажил үүргийг тодорхой болгож, зохион байгуулалтын өөрчлөлт хийж, дэд хэсгийг бие даан хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэх;

4. Дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсээс саатуулах байранд хүргэгдэж саатуулагдсан иргэдийг буцаан авах автомашин, шатахууны зардлыг шийдвэрлэх;

5. Хэсгийн байцаагчийн бичиг хэргийн хангалт, ярианы картын лимитийг нэмэгдүүлэх талаар тооцоо судалгааг гаргаж, Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, хангамжийн газар танилцуулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах.

Хүний нөөц, сургалтын хэлтэст:

1. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан жишиг нормативын дагуу Хэсгийн байцаагч нарын орон тоог нэмэгдүүлэх талаар санал танилцуулж, зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцох.

Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст:

1. Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан бүтэц, орон тооны дагуу ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолт боловсруулж, батлуулах;

2. Хэсгийн байцаагчийн ажлын байрны тодорхойлолтыг боловсруулахдаа зорилго, зорилтыг нарийвчлан тодорхойлох, гүйцэтгэх ажлын цар хүрээ, хэмжээ хязгаарыг оновчтой тогтоох, бусад ажлын байртай давхардсан ажил үүргийг арилгахад анхаарах.

Хуулийн хэлтэст:

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актуудыг хүртээмжтэй хүргэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.

Нийтийн хэв журам хамгаалах алба нь санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2016 оны 06 дугаар сарын 16-ны дотор гаргаж, хэрэгжилтийг 2016 оны 09 дугаар сарын 30-ны дотор ДХАБГ-ын ХШҮДАХ-т тайлагнана.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016.05.19

Улаанбаатар хот

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын талаар

“Цагдаагийн байгууллагын хяналт шинжилгээний 2016 оны төлөвлөгөө”, Таны 2016 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх, В.Отгонбаяр нар Хэвлэл, мэдээллийн төвийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийлээ.

Хяналт шинжилгээний зорилго нь цагдаагийн байгууллагаас хэвлэл, мэдээллийн байгууллага, олон нийттэй харилцах үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, тус төвийн үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Хяналт шинжилгээний хүрээнд Хэвлэл, мэдээллийн төвийн үйл ажиллагааны тайлан, дүрэм, ажлын байрны тодорхойлолт болон бусад шаардлагатай мэдээллийг гаргуулан авч судалсан. Мөн төвийн үйл ажиллагаатай газар дээр нь биечлэн танилцаж, алба хаагчидтай уулзалт ярилцлага зохион байгуулсан.

Хоёр.Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааны ач холбогдол

Хэвлэлийн хүрээлэнгээс 2015 онд хийсэн судалгаагаар Монгол Улсын хэмжээнд нийт 138 телевиз, 72 радио, 111 сонин, 90 сэтгүүл болон 92 мэдээ, мэдээллийн цахим сайт үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь цөөн хүн амтай манай улсын хувьд их тоо юм. Тиймээс ч хэвлэл, мэдээллийн байгууллагуудын өрсөлдөөн ширүүсч, илүү дуулиантай мэдээллийг бүгдээс өрсөж түгээхийн төлөө зорих болжээ.

БНТУ-ын Цагдаагийн академийн багш асан Проф.Док. Өндэр Аятач “Цагдаагийн байгууллага гэдэг хэвлэл, мэдээллийнхний хувьд хамгийн мөлжүүртэй яс байдаг. Тэд сонингоо олон хувь борлуулж, сувгаа олон хүнд үзүүлж, интернэт хуудсандаа олон хандалт авахын тулд цагдаагийн байгууллагыг байнга хараандаа байлгаж, ялангуяа сөрөг мэдээллийн хойноос идэвхитэй хөөцөлддөг” гэж бичсэн нь бий. Үнэхээр ч тус улсын томоохон телевизийн сувгуудын оройн “Үндсэн мэдээ”-ний ½-д нь цагдаа идэвхитэй байдлаар, ¼-д нь идэвхигүй /мэдээний арын фонд харагдах г.м/ байдлаар гардаг юм.

Манай улсад ч цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаа, алдаа оноо, шалгаж байгаа гэмт хэргийн талаарх мэдээлэл нь хэвлэл, мэдээллийнхний сонирхлыг ихээр татаж, тэднээр дамжин олон нийтэд шуурхай, хүртээмжтэй хүрэх болжээ. Ийм нөхцөлд цагдаагийн байгууллага, алба хаагчаас хэвлэл, мэдээллийн байгууллагатай

харилцах харилцаанд онцгой ач холбогдол өгч, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлага байна.

Энэхүү харилцаа, хамтын ажиллагаа эерэг ойр байхын хирээр хоёр тал “хожиж”, холдож муудахын хирээр аль аль тал, тэр тусмаа цагдаагийн байгууллага илүү ихийг “алдах” эрсдэлтэй юм. Нөгөө талаас аль ч улсад байдаг цагдаагийн байгууллагын талаарх уламжлалт сөрөг хандлагыг саармагжуулж, цагдаагийн байгууллагын нэр хүнд, имижийг өргөн, цагдаа-иргэдийн харилцааг хөгжүүлэхэд хэвлэл, мэдээллийн байгууллагын дэмжлэг, нөлөөлөл их билээ.

Гурав.Хэвлэл, мэдээллийн төвийн үйл ажиллагааны нөхцөл байдал

Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл, мэдээллийн төв нь нийт 7 орон тоотой төвийн дүрэмд заасан үйл ажиллагааг явуулж байна. Хяналт шинжилгээний багаас хяналт шинжилгээг эмх цэгц, зохион байгуулалттай хийх зорилгоор Хэвлэл, мэдээллийн төвөөс дүрэмд заасны дагуу хэрэгжүүлж буй үйл ажиллагааны чиглэл /бүтээгдэхүүн/ бүрийг тусгайлан авч үзлээ. Тухайлбал, хэвлэлийн бага хурал зохион байгуулах, хэвлэлийн тойм бэлтгэж цагдаагийн байгууллагын удирдлагад танилцуулах, “Цагдаа” эмхтгэл эрхлэн гаргах, МҮОНТ-ээр гарах нэвтрүүлгийг бэлтгэх, цагдаагийн байгууллагатай холбоотой үйл явдлыг баримтжуулах, Цагдаагийн ерөнхий газрын цахим хуудсанд мэлээлэл оруулах, төвийн фэйсбүүк хуудсыг хөтлөх болон бусад үйл ажиллагааг нэрлэж болно.

3.1 Хэвлэлийн бага хурал зохион байгуулах, мэдээлэл өгөх үйл ажиллагаа

Хэрэв цагдаагийн байгууллагаас үнэн зөв, бодитой мэдээллийг цаг алдалгүй нийгэмд түгээх ажлыг хэрэгжүүлэхгүй бол тэрхүү мэдээллийн эрэлт, хоосон орон зайг худал ташаа, бохир мэдээ, мэдээлэл дүүргэх эрсдэлтэй. Тиймээс ч Хэвлэл, мэдээллийн төвөөс цаг үеийн нөхцөл байдал, тодорхой нэг асуудал болон хоногийн гэмт хэргийн нөхцөл байдлын мэдээг дараах 3 хэлбэрээр хэвлэл, мэдээллийн байгууллагаар дамжуулан олон нийтэд түгээж байна.

А.Хэвлэлийн бага хурал- Олны анхаарал татсан, бусад төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран мэдээлэл өгөх шаардлагатай асуудлаар хэвлэлийн бага хурал зарлана. Хурлын зарыг тус төвийн фэйсбүүк хуудас болон утсаар түгээж, мэдээллийг Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн дэд даргаар хянуулан хүргэдэг байна. Мөн улирал бүрийн эцэст Мэдээлэл, технологийн төв болон Судалгаа, дүн шинжилгээний төвтэй хамтран гэмт хэргийн статистик мэдээллээр хэвлэлийн бага хурал хийж байна.

Б.Хэвлэлийн мэдээлэл- Мөн олны анхаарал татсан гэмт хэргийг шалгаж буй явц байдлын талаар мэдээлэл өгөх зорилготой хэвлэлийн бага хурлаас хамрах хүрээ нь бага мэдээлэл түгээх үйл ажиллагаа юм. Мэдээллийн агуулгыг тухайн хэргийг шалгаж буй газар, хэлтсийн удирдлагатай зөвшилцөж тодорхойлдог.

В.Хоногийн нөхцөл байдлын мэдээг түгээх- Цагдаагийн байгууллагатай ойр хамтран ажилладаг хэвлэл, мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд фэйсбүүк хуудсаар дамжуулан хоногийн мэдээг түгээдэг. Мэдээний агуулгыг тодорхойлохдоо цагдаагийн алба хаагчид түргэн шуурхай ажиллаж илрүүлсэн гэмт хэргийн талаарх мэдээллийг түлхүү өгөхийг зорьдог.

3.2 Телевизийн нэвтрүүлэг бэлтгэх

Тус төвөөс 7 хоног бүр “Цагдаагийн мэдээлэл” 15 минут, “Амрыг эрье” 30 минутын нэвтрүүлгийг бэлтгэн МҮОНТ-ээр гаргаж байна. “Цагдаагийн мэдээлэл” нэвтрүүлэг нь Мэдээ, мэдээлэл, цаг үе, үйл явдал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэл, Ярилцлагын цаг, Танилцуулга /цагдаагийн нөлж, байгууллагын/, Баярлалаа /цагдаагийн байгууллага, алба хаагчтай холбоотой иргэдээс ирүүлсэн талархал/ зэрэг булангуудтай бол “Амрыг эрье” нэвтрүүлгийн бүтэц нь эрүү, хэв журмын нөхцөл байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээ, мэдээллээс бүрдэж байна. Эдгээр нэвтрүүлгийн агуулгыг цаг үеийн нөхцөл байдалд уялдуулан тус төвөөс тодорхойлж, төлөвлөгөөг сар бүр Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга баталж байна.

Мөн цагдаагийн байгууллагын онцлох үйл явдлуудыг фото зураг, дүрс бичлэгээр баримтжуулан мэдээлэх, архивлан хадгалах ажлыг зохион байгуулдаг. Тус төвд цагдаагийн байгууллагын сүүлийн 20 жилийн түүхэнд хамаарах дүрс бичлэг, фото зургийн сан хадгалагдаж байна.

3.3 “Цагдаа” эмхтгэл эрхлэн гаргах

“Цагдаа” сэтгүүл нь улиралд нэг удаа 36 хуудастай, нэг бүр нь 1760 төгрөгийн үнэтэй 1000 ширхэг хэвлэгдэж, орон нутгийн голдуу цагдаагийн байгууллагуудад түгээгдэж байна. Сэтгүүлийн агуулгыг Хэвлэл, мэдээллийн төвөөс танилцуулсан саналыг дагуу Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга тодорхойлж баталгаажуулдаг.

Сэтгүүл нь иргэд олон нийтэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, мэдээ, мэдээлэл түгээх, түүхэн архив болж үлдэх чухал ач холбогдолтой ч хэвлэлтийн тооноос хамааран хүртээмж багатай, улиралд нэг удаа гардаг тул агуулга, мэдээ, мэдээлэл нь хугацаа алдаж уншигчдад хүрдэг сул тал байна.

3.4 Хэвлэлийн тойм бэлтгэх

Төвөөс өдөр тутмын сонин хэвлэл, хандалт ихтэй цахим сайтуудад цагдаагийн байгууллага, алба хаагчтай холбоотой болон гэмт хэргийн талаар нийтлэгдсэн мэдээллийг тойм байдлаар бэлтгэж цагдаагийн

байгууллагын удирдлагуудад танилцуулж байна. Тухайлбал Өнөөдөр, Өдрийн сонин, Зууны мэдээ, Засгийн газрын мэдээ сонин, zaluu.com, news.mn, medee.mn, shuud.mn, 24tsag.mn зэрэг нийт 10 гаруй сайтын мэдээлэлд мониторинг хийж байна.

Дээр дурьдсан 4 сонинтой анх удаа хамтран ажиллах гэрээ байгуулснаар улиралд нэг удаа тодорхой хэмжээний нийтлэлийг үнэгүй хэвлүүлэх, үнийн хөнгөлөлт эдлэх болон цахим сонины эрх авах зэрэг боломжтой болжээ.

Хэвлэлийн тоймыг Эрүүгийн нөхцөл байдал, Хэв журмын нөхцөл байдал, Цагдаагийн байгууллага, алба хаагчтай холбоотой мэдээлэл, Өнөөдөр болох үйл явдлын тойм болон Бусад гэсэн агуулгатайгаар бэлтгэдэг. Бэлтгэсэн хэвлэлийн тоймын цахим архив байгаа ч түүнд дүн шинжилгээ хийж бусад байдлаар ашигласан зүйлгүй. Мөн удирдлагаас хэвлэлийн тоймтой холбогдуулан цагдаагийн нэгж, албан тушаалтанд өгсөн үүрэг, чиглэл, тэдгээрийн биелэлтийн талаар бүртгэл мэдээлэлгүй байна.

3.5 Цагдаагийн ерөнхий газрын цахим хуудсанд мэдээлэл оруулах

Төвөөс Цагдаагийн ерөнхий газрын www.police.gov.mn цахим хуудасны “Цаг үе, үйл явдал” цэсэнд цагдаагийн байгууллагатай холбоотой мэдээлэл бэлтгэн оруулж байна. Аливаа цахим хуудас “амьд”, олон хандагчтай байхын тулд агуулга нь байнга шинэчлэгдэн баяжигдах шаардлагатай байдаг. Харин цагдаагийн байгууллагын цахим хуудсанд бүгдийг бус цар хүрээ, ач холбогдлын хувьд харьцангуй чухал үйл явдлуудын мэдээллийг бэлтгэн оруулах бодлого баримталж байгаа нь тус сайтын мэдээллийн шинэчлэгдэх хурдыг сааруулж, улмаар сайтад хийх хандалтыг бууруулах эрсдэлтэй юм. Нөгөө талаас сайтруу хийгдэж буй хандалтыг тооцох тоолуургүй нь сайтын менежментийг оновчтой зохион байгуулах боломжийг бууруулж байна.

3.6 Төвийн фэйсбүүк хуудас хөтлөх

Хэвлэл, мэдээллийн төв нь өөрийн фэйсбүүк хуудсаар дамжуулан цагдаагийн байгууллагатай холбоотой үйл явдал, мэдээ мэдээллийг түгээж байна. Тус цахим хуудас нь 30.000 дагагчтай.

Мөн төв, орон нутгийн цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээгээ олон нийтэд сурталчлуулахаар ирүүлсэн хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг фэйсбүүк хуудсаар түгээхээс гадна хамтран ажилладаг цахим сайтуудад байршуулах ажлыг зохион байгуулдаг.

Фэйсбүүк хуудсанд иргэдээс олон тооны сэтгэгдэл ирүүлдэг нь цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд холбогдох гомдол, санал, мэдээлэл хүссэн агуулгатай байдаг. Гэвч ажлын ачааллаас шалтгаалан тэдгээр сэтгэгдлийн мөрөөр ямарваа нэг ажил зохиогдоггүй байна.

Дөрөв.Дүгнэлт

Хэвлэл, мэдээллийн төв харьцангуй ачаалалтай ажиллаж, дүрэмд заасан чиг үүргээ “хангалттай” түвшинд хэрэгжүүлэхийн зэрэгцээ цагдаагийн байгууллагыг сурталчлах чиглэлээр телевизийн цуврал нэвтрүүлгүүд, сэтгүүл, ном бүтээл бэлтгэн гаргаж байгаа нь сайшаалтай байна гэж хяналт шинжилгээний багаас дүгнэлээ.

Цагдаагийн ерөнхий газраас 2015 онд төвийн алба хаагчдын цол, цалингийн шатлалыг нэмэгдүүлж, шинэ видеокамер хэрэгслээр хангасан нь үр дүнгээ өгч, цаашид зохих санхүүгийн болон бусад дэмжлэгийг авч илүү ихийг хийж бүтээх хүсэл эрмэлзэлтэй байгаа нь хяналт шинжилгээний явцад ажиглагдсан.

Хэвлэл, мэдээллийн төвийн үйл ажиллагааг зохицуулж буй дүрэм, журам, одоо явуулж буй үйл ажиллагааг бүхэлд нь авч үзвэл цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд “мэдээлэх” л агуулгатай байна.

Тэгвэл олон нийттэй харилцах /PR/ нь мэдээлэл түгээх үйл ажиллагаанаас тусдаа ойлголт бөгөөд түүнийг цагдаагийн байгууллага, алба хаагчаас олон нийттэй сайн харилцаа хөгжүүлэх замаар эерэг имижийг бүрдүүлэх, тэдний санаа бодлыг байгууллагын хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн системтэйгээр удирдан чиглүүлэх, судалгаа, дүн шинжилгээнд суурилсан, төлөвлөгөөтэй цогц үйл ажиллагаа гэж ойлгож болно.

Тиймээс ч цагдаагийн байгууллагын олон нийттэй харилцах чиг үүрэг нь тодорхой нэг нэгж, алба хаагчийнх бус нийт цагдаагийн байгууллага, одоо ажиллаж байгаа, ажиллаж байсан хэн бүхний үйл хэрэг билээ. Нөгөө талаас PR-ийг реклам сурталчилгаанаас зааглан ойлгож, өнгөцхөн, худал ташаа мэдээ, мэдээллээс зайлсхийх нь чухал.

Өнөөдөр цагдаагийн нэгж бүр олон нийттэй харилцах чиглэлээр тодорхой ажлуудыг хэрэгжүүлж байгаа нь эргэлзээгүй. Гэвч нийт байгууллагын хэмжээнд хүчээ нэгтгэн, нэгдмэл удирдлага, зорилго чиглэлтэйгээр олон нийттэй харилцах нь чухал ач холбогдолтой. Иймд мэргэжлийн байгууллага, зөвлөхийн дэмжлэгтэйгээр цагдаагийн байгууллагын олон нийттэй харилцах стратеги, төлөвлөгөөг бий болгох хэрэгцээ байна.

Тав.Санал, зөвлөмж

Хяналт шинжилгээний явц, үйл ажиллагаатай биечлэн танилцсан тэмдэглэл, уулзалт ярилцлагын хүрээнд цугларсан мэдээлэл, баримт материалд түшиглэн Хэвлэл, мэдээллийн төвийн үйл ажиллагааг дэмжих, цагдаагийн байгууллагын олон нийттэй харилцах /PR/ үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр дараах асуудлуудыг шийдвэрлүүлэх саналтай байна. Үүнд:

5.1 Мэргэжлийн байгууллага, зөвлөхийн дэмжлэгтэйгээр цагдаагийн байгууллагын олон нийттэй харилцах стратеги, төлөвлөгөөг боловсруулах

5.2 Цаашид Хэвлэл, мэдээллийн төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэхийн тулд мэргэшсэн сэтгүүлчийг томилуулах, мэдээллийн мониторинг, дүн шинжилгээний чиглэлээр ажиллах алба хаагчийн орон тоо шинээр бий болгох

5.3 Хэвлэл мэдээллийн байгууллагуудаас төрөл бүрийн хөнгөлөлт, урамшуулалт үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын хэвлэл захиалгын эрхийг Хэвлэл, мэдээллийн төвд нэгтгэн төвлөрүүлэх

5.4 Хэвлэл, мэдээллийн төвийн хэвийн үйл ажиллагааг хангаж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчдыг сурталчлахад шаардлагатай зардлыг шийдвэрлүүлэх /Хавсралт 1/

5.5 Мөн хяналт шинжилгээний мөрөөр Хэвлэл мэдээллийн төвд дараах зөвлөмжийг хүргүүлэхээр төлөвлөж байгааг тус тус илтгэн танилцуулья.

- Цагдаагийн байгууллага, алба хаагчтай холбоотой мэдээллээр үүсгэсэн хэвлэлийн тоймын архивыг судалгаа, дүн шинжилгээний зорилгоор ашиглах талаар зохих нэгжүүдтэй хамтран ажиллах

- Тус төвд хадгалагдаж байгаа цагдаагийн байгууллагын түүхийг өгүүлэх дүрс бичлэг, фото зургийн санг каталогжуулж, тэдгээрийн хүртээмж, ашиглалтыг сайжруулах зорилгоор каталогийн мэдээллийг нийт байгууллага, алба хаагчдад түгээх

- Цагдаагийн байгууллагыг сурталчилж, алба хаагчдыг алдаршуулах зорилгоор төв, орон нутгийн цагдаагийн байгууллагаас онцлох, үлгэр жишээ, шилдэг алба хаагчдын талаарх судалгааг жилд нэгээс доошгүй удаа гаргуулан ашиглах

- Цагдаагийн ерөнхий газрын www.police.gov.mn сайтад аливаа мэдээллийг “..... газраас мэдээлж байна” гэх гарчигтайгаар нийтэлж байгаа нь уншигчдын шуурхай мэдээлэл авах боломж, сонирхол, хандалтыг бууруулах эрсдэлтэй байх тул бусад мэдээллийн сайт, төрийн байгууллагуудын цахим хуудасны жишгийг харгалзан аливаа мэдээний гарчгийг мэдээний товч агуулгаар илэрхийлж хэвших. Мөн цахим хуудсанд тавигдах мэдээллийн давтамжийг нэмэгдүүлэх, хандалтыг хэмжих тоолууртай болгох ажлыг зохион байгуулах

- Төвийн үйл ажиллагааны тайлан, ажлын цар хүрээ, алба хаагчдын ачааллыг бодитой, цэгцтэй тодорхойлж илэрхийлэх зорилгоор төвийн үйл ажиллагааг бүрэн хамарсан ажлын дүн мэдээний маягт / хүснэгт/-ыг боловсруулж мөрдөх.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРГҮҮЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2015.10.29

Улаанбаатар хот

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын талаар

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/57 дугаар тушаалын дагуу цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх ажлын хэсэг байгуулагдсан.

Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх, гишүүдэд Нийтийн хэв журам хамгаалах албаны ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа С.Тогтохжаргал, цагдаагийн хошууч Б.Баярцэнгэл, Улаанбаатар хотын цагдаагийн газрын Үйл ажиллагааны хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн Мэргэжил, арга зүйн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Л.Амармөрөн нар ажиллалаа.

Хяналт-шинжилгээг холбогдох эрх зүйн акт, баримт бичгүүдийг судлах, цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагааны чиглэлээр урьд онуудад хэрэгжсэн судалгааны ажлын тайлан, төслийн танилцуулгыг ашиглах, Улаанбаатар хотын төвийн дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдэд хүрэлцэн очиж эргүүлийн үйл ажиллагаатай биечлэн танилцах, ажил хариуцаж буй шат шатны алба хаагчидтай уулзалт, ярилцлага хийх, биечлэн эргүүлийн үүрэг гүйцэтгэх зэрэг аргаар хэрэгжүүлсэн.

Тухайлбал, 2012-2013 онд Хууль зүйн яам, Хууль сахиулахын их сургууль болон Цагдаагийн ерөнхий газрын хамтран хэрэгжүүлсэн “Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, үйл ажиллагааны орчин, түүний шинэтгэл” сэдэвт судалгааны ажлын тайлан, 2013 онд Нийслэлийн цагдаагийн газраас “Максима Консалтинг” судалгааны байгууллагатай хамтран боловсруулсан “Аюулгүй, амгалан хот эргүүлийн хөтөлбөр, төсөл”-ийн танилцуулга, 2014 оны 09 дүгээр сард Гэмт хэрэгтэй тэмцэх газар болон Нийтийн хэв журам хамгаалах газрын хамтран хэрэгжүүлсэн эргүүлийн үйл ажиллагаанд ажлын зураг авалт хийсэн тухай танилцуулга, Нийтийн хэв журам хамгаалах алба болон Улаанбаатар хотын цагдаагийн газраас ирүүлсэн танилцуулга зэрэг болно.

Хоёр.Цагдаагийн эргүүлийн үйл ажиллагааны ач холбогдол

Олон улсад цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг үндсэн 2 хэсэгт хувааж үздэг нь проактив /proactive policing/ болон реактив /reactive policing/ цагдаагийн үйл ажиллагаа юм. Үүнийг дэлгэрүүлбэл, гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө буюу урьдчилан сэргийлэх ажиллагааг проактив, нэгэнт гэмт хэрэг үйлдэгдсэн бол түүнийг таслан зогсоох, илрүүлэх ажиллагааг реактив цагдаагийн үйл ажиллагаа гэдэг байна.

Судлаачид үр дүнтэй урьдчилан сэргийлэх ажиллагаа нь гэмт хэргийн улмаас үүсч болох хор уршиг, сөрөг үр дагаврыг арилгах, улмаар

цаг хугацаа, хүн хүч, хөрөнгийн нөөцийн зарцуулалтыг бууруулах ач холбогдолтой болохыг онцолж байна. Тиймээс ч гадаад орнуудын цагдаагийн байгууллага үйл ажиллагааныхаа урьдчилан сэргийлэх чиглэлийг түлхүү анхаарч, гол хүн хүч, хөрөнгө хэрэгслээ чиглүүлэн ажиллах болжээ.

Цагдаагийн эргүүлийн үйл ажиллагаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн хэлбэрийн нэг бөгөөд дараах ач холбогдолтой. Үүнд:

- Эргүүл нь гудамж талбай, олон нийтийн газрыг хяналтад авч, гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөл, орчныг хумих,
- Гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд хэргийн газар шуурхай очих, улмаар хохирогчид яаралтай тусламж үзүүлэх, хэргийн газрыг хамгаалах, гэмт хэргийг таслан зогсоох, халуун мөрөөр нь илрүүлэх,
- Хариуцсан нутаг дэвсгэрт орших аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй холбоо тогтоож, олон нийт-цагдаагийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх,
- Иргэдийн аюулгүй байдлын мэдрэмжийг нэмэгдүүлж, цагдаагийн байгууллагын нэр хүнд, имижийг өргөх гэх мэт.

Орчин үед цагдаагийн эргүүлийн үйл ажиллагааг техник технологийн ололттой хослуулан хэрэгжүүлэх нь үр дүнтэй байна.

Статистик мэдээнээс үзвэл 2011 оноос 2014 он хүртэлх хугацаанд нийт гэмт хэрэг 42.3 хувь өссөн байхад гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 60.0 хувь, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 59.6 хувь, бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэрэг 78.8 хувь тус тус өсчээ. Өөрөөр хэлбэл дээрх гэмт хэргүүдийн өсөлтийн хувь нь нийт гэмт хэргийн өсөлтийн хувиас давсан үзүүлэлттэй байгааг цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагааны үр дүнтэй холбон тайлбарлаж болох юм.

Гурав.Цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт

Цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой сүүлийн жилүүдэд гарсан шийдвэр, өөрчлөлтийн талаар дурьдвал:

Засгийн газрын 2007 оны 346 дугаарын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” тогтоолоор эргүүлийг 24 цагийн горимд шилжүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2008 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 27 дугаар тушаалаар Нийслэлийн хөдөлгөөнт эргүүлийн газрыг 480 алба хаагчийн орон тоотой байгуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2010 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 114 дүгээр тушаалаар дүүргүүдийн цагдаагийн хэлтэс, Эргүүл хамгаалалтын газрын явган эргүүлийн тасгийн алба хаагчдыг Нийслэлийн

хөдөлгөөнт эргүүлийн газарт шилжүүлснээр 4 хэлтэс, 16 тасаг, 70 машинт эргүүлийн, 94 явган эргүүлийн, нийт 164 чиглэлд, 803 алба хаагчийн орон тоотой болсон.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2012 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 700 дугаар тушаалаар Нийслэлийн хөдөлгөөнт эргүүлийн газрыг татан буулгаж, үйл ажиллагааг нь дүүргийн цагдаагийн хэлтэст шилжүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн тушаалаар төвийн дүүргүүдийн цагдаагийн 14 хэлтэст эргүүлийн офицер 364, эргүүлийн цагдаа жолооч 273, эргүүлийн цагдаа 120, хороо хариуцсан цагдаа 138 байхаар бүтэц, орон тоог баталжээ. Үүнээс үзвэл дүүргийн цагдаагийн нэг хэлтэст дунджаар эргүүлийн офицер 26, эргүүлийн цагдаа жолооч 20, эргүүлийн цагдаа 8, хороо хариуцсан цагдаа 10 ноогдож, эргүүлийн үйл ажиллагаанд ажиллах боломжтой нийт 64 алба хаагч байна.

Мөн дүүргийн цагдаагийн хэлтэс тус бүрт эргүүл хамгаалалт хариуцсан ахлах байцаагч 1, УБХЦГ-ын Үйл ажиллагааны хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн Мэргэжил, арга зүйн тасагт эргүүл хариуцсан ахлах мэргэжилтэн 2, НХЖХА-ны Бодлого, зохицуулалтын хэлтэст эргүүл хариуцсан 1 ахлах мэргэжилтэн тус тус ажиллаж байна.

Дөрөв.Цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагааны нөхцөл байдал

Улаанбаатар хотын цагдаагийн газраас ирүүлсэн танилцуулгаас үзвэл, энэ оны 06 дугаар сарын байдлаар нийслэл хотын хэмжээнд өдөрт явган эргүүлийн 10-15 чиглэлд 20-23 алба хаагч ажиллаж, эргүүлд ажиллах боломжтой 150-200 алба хаагч тодорхой шалтгаанаар /ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй, тамирчин, хүүхэд асрах чөлөөтэй, гадуур ажилтай гэх мэт/ эргүүлийн үйл ажиллагаанд оролцох боломжгүй болж, шөнийн цагаар авто эргүүлийн чиглэлийн 67 автомашиныг эс харгалзвал нийслэл хот эзэнгүйдэж байна.

Энэ байдал гэнэт бий болоогүй, хэдэн жилийн өмнөөс улбаатай болох нь урьд хийгдсэн судалгааны ажлын тайлан, танилцуулгуудаас харагдаж байна. Иймд ажлын хэсгээс эргүүлийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, хяналтын тогтолцоо, хүн хүч, техник, тусгай хэрэгслийн хангалт хүрэлцээ, албаны бэлэн байдлыг нарийвчлан тодорхойлох зорилгоор Улаанбаатар хотын төвийн дүүргүүдийн нийт 14 цагдаагийн хэлтэст ажилласнаар дараах нөхцөл байдал тогтоогдлоо. Үүнд:

Эргүүлийн хүн хүчний талаар:

ЦЕГ-ын даргын 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Б/284 дүгээр тушаалаар дээр дурьдсан цагдаагийн хэлтсүүдэд эргүүлийн

офицер 357, эргүүлийн цагдаа жолооч 273, эргүүлийн цагдаа 88, нийт 718 алба хаагчийн орон тоо батлагджээ. Үүнээс 2015 оны 09 дүгээр сарын 03-наас 11-ний өдрийн байдлаар 1 хувь буюу 7 орон тоо дутуу, 60 хувь буюу 435 алба хаагч хөдөлгөөнт эргүүлд, 5 хувь буюу 35 алба хаагч явган эргүүлд, 19 хувь буюу 134 алба хаагч эргүүлээс бусад ажилд ажиллаж, 15 хувь буюу 109 алба хаагч тодорхой шалтгааны улмаас албан үүргээ гүйцэтгээгүй байна /Хавсралт 1/.

Эргүүлээс бусад ажилд ажиллаж буй алба хаагчдаас дэд хэсэг, пост, иргэдэд үйлчлэх төвд 76, ээлжийн амралттай болон бусад шалтгаанаар эзгүй байгаа алба хаагчийн оронд 13, байнгын болон түр товчоонд 9, хэрэг уншдаг зөвлөхөөр 8, татварын албанд 7, конторын цагдаагаар 6, бусад ажилд 15 алба хаагч ажиллаж байна.

Харин тодорхой шалтгаанаар албан үүргээ гүйцэтгээгүй алба хаагчдаас ээлжийн амралттай 62, өвчтэй 14, тамирчин 9, захиргааны чөлөөтэй 7, тасалсан 5, сургалтанд 4, хүүхэд асрах чөлөөтэй болон энхийг сахиулах ажиллагаанд оролцож байгаа тус бүр 3 алба хаагч байна. Эмэгтэй эргүүлийн офицер, цагдаа нийт 30 байна.

Хөдөлгөөнт эргүүлийн талаар:

Улаанбаатар хотын төвийн дүүргүүдийн цагдаагийн хэлтэст хөдөлгөөнт эргүүлд ажиллавал зохих нийт 67 автомашинтайгаас хөдөлгөөнт эргүүлд 61 автомашин ажиллаж, алба хаагчид нь ээлжийн амралттай 2, засвартай 3, хөдөлгөөнт эргүүлээс бусад ажилд дайчлагддаг 1 автомашин байна /Хавсралт 2/. Үүнээс 7 хэлтсийн 34 автомашин 12 цаг, 7 хэлтсийн 27 автомашин 24 цагийн хуваариар ажиллаж байна.

Хөдөлгөөнт эргүүлийн албаны бэлэн байдал, тусгай хэрэгслийн хангалт хүрэлцээ, хөтлөгдөх дэвтэр, баримт бичгийн иж бүрдлийн талаарх нөхцөл байдлын үнэлгээг 2 дугаар хавсралтад харуулав.

Явган эргүүлийн талаар:

Улаанбаатар хотын төвийн дүүргүүдийн цагдаагийн хэлтсийн эргүүлийн томилгоо, мэдээнээс үзвэл 2015 оны 09 дүгээр сарын 03-наас 11-ний хооронд явган эргүүлийн 71 чиглэлд, офицер 29 /үүнээс 9 нь хөдөлгөөнт эргүүлийн ээлжээс буусан офицер/, цагдаа 79 /үүнээс 67 нь хороо хариуцсан цагдаа/, олон нийтийн цагдаа 34, нийт 142 алба хаагч ажиллажээ /Хавсралт 3/.

Дүүргийн цагдаагийн хэлтсүүдэд явган эргүүлд ажиллуулах хүн хүч дутмаг байдгаас хөдөлгөөнт эргүүлийн ээлжнээс буусан алба хаагчид, хорооны цагдаа, олон нийтийн цагдааг явган эргүүлд татан ажиллуулж байгаа ч энэ нь нэгж бүрт жигд бус, тогтмолжоогүй байна. Зарим дүүргийн цагдаагийн хэлтсээс ачаалал ихтэй онцлог өдрүүдэд нийт алба хаагчдыг явган эргүүлд татан оролцуулснаар бодитой эерэг үр дүн гарч байгаа ч, нөгөө талаас алба хаагчдын ажлын ачааллыг нэмэгдүүлж, сэтгэл ханамжийг бууруулах эрсдэлтэй байна.

Дүүргийн цагдаагийн хэлтсүүдэд явган эргүүлийн хүн хүч хүрэлцээгүй болсон нь дараах хэд хэдэн учир шалтгаантай байна. Үүнд:

- Авто эргүүлийг 4 ээлжтэй болгож зохион байгуулах, нийслэлийн хороодод хороон цагдаагийн орон тоо бий болгоход явган эргүүлийн орон тооноос шилжүүлэн авч шийдвэрлэсэн,
- Эргүүлийн алба хаагчийн орон тоон дээр ажилладаг дунджаар 100 гаруй алба хаагч өөр ажил үүрэг гүйцэтгэдэг, эргүүлд ажиллах боломжтой мөн тооны алба хаагч тодорхой шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэхгүй байгаагаас хүн хүч дутагдах, эргүүлийн чиглэл буурах,
- Аливаа шалтгаанаар үүрэг гүйцэтгээгүй алба хаагчдын нөхөөсөнд эргүүлийн алба хаагчдыг томилж ажиллуулах явдал дүүргийн цагдаагийн хэлтсүүдэд түгээмэл байна.

Тав.Эргүүлийн үйл ажиллагааны төлөвлөлт, хяналтын талаар

УБХЦГ-ын даргын 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/16 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн эргүүлийн нэгдсэн байршилт”-ын дагуу явган эргүүлийн 445 чиглэлд 890 алба хаагч, авто эргүүлд 67 автомашинтайгаар ээлжээр 536 эргүүлийн офицер, эргүүлийн цагдаа жолооч, 24 цагийн үйл ажиллагаатай цагдаагийн 25 хэсэгт 150 цагдаа ээлжээр ажиллахаар байна. Энд дурьдсан явган эргүүлийн чиглэл, хүн хүчний тооцоо нь дүүргийн цагдаагийн хэлтсийн хүн хүчний боломжоор хязгаарлагдан хэрэгжих хэт өөдрөг тооцоо юм.

Дүүргийн цагдаагийн хэлтсээс хүн хүчний боломжид тулгуурлан, хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдал, гэмт хэрэг, зөрчлийн дэлгэрэнгүй судалгаанд үндэслэн эргүүлийн чиглэл, хүн хүчийг төлөвлөж зохион байгуулах үүрэгтэй. Гэвч хяналт шинжилгээний явцад дээрх үйл ажиллагаа нэгж тус бүрт харилцан адилгүй, жигдэрч тогтмолжоогүй, ач холбогдол, үр дүнг нь бүдэгрүүлж хэлбэр төдий хэрэгжүүлдэг, эргүүлийн чиглэлийн үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тооцдоггүй зэрэг нийтлэг дутагдал ажиглагдлаа.

Эргүүлийн үйл ажиллагаанд тавих хяналтын хүрээнд, дүүргийн цагдаагийн хэлтсийн НХЖХТ-ийн дарга сард 1-2 удаа, эргүүл хамгаалалт хариуцсан ахлах байцаагч нар өдөр тутам хяналт тавьж, зааварчлага өгч ажилласан байна. Мөн тухайн хэлтсийн хариуцлагатай эргүүлүүд болон УБХЦГ-ын ахлах байцаагч, ёс журмын эргүүлүүд сард 2-3 удаа хөдөлгөөнт эргүүлийн үйл ажиллагаанд хяналт тавьжээ. Гэвч хяналт шалгалтын болон рапортын дэвтэрт “танилцав” гэж бичиж гарын үсэг зурах төдийхнөөр хэрэгжиж буй эдгээр хяналтын үр нөлөө бага байгаа нь хяналт шинжилгээний явцад ажиглагдсан энгийн зөрчил, дутагдлуудаас харагдаж байлаа.

Зургаа.Эргүүлийн үйл ажиллагаатай холбоотой ажлын сайн туршлагын талаар

Ажлын хэсгийн гишүүд Улаанбаатар хотын төвийн дүүргүүдийн 14 цагдаагийн хэлтэст ажиллаж, эргүүлийн үйл ажиллагааны нөхцөл байдалтай танилцахад шат шатны удирдлага, алба хаагчдын идэвхи санаачлагаас хамааран өөр өөр дүр зурагтай байлаа. Тухайлбал:

1. СБД-2, БГД-1 дүгээр хэлтсээс дүүргийн удирдах байгууллагуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зорилго чиглэл, ач холбогдол, авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ үр дүнг зөв ойлгуулж танилцуулснаар тэднээс санхүүгийн болон бусад дэмжлэг туслалцааг авч чадаж байгаа нь сайшаалтай байна. Тухайлбал СБД-2 хэлтэст урамшилт эргүүлийн зардалд сар бүр 12 сая төгрөг, хөдөлгөөнт посттой болоход 30 сая төгрөгийг тус тус дүүргээс шийдвэрлэсэн. Харин бусад дүүргийн цагдаагийн хэлтсээс дүүргийн удирдлагатай хамтарч ажиллах, үйл ажиллагаагаа сурталчлан төсөв хөрөнгө шийдвэрлүүлж ажиллах чиглэлээр хангалтгүй байлаа.

2. ЧД-1 дүгээр хэлтсийн хөдөлгөөнт эргүүлийн 113 чиглэлийн алба хаагчид хамтран үүрэн холбооны 3 операторын утасны дугаар, гар утасны хамт худалдан авч, тэдгээрийг сар бүр хувиасаа цэнэглэн албан хэрэгцээнд ашиглаж байгаа нь бүтээлч санаачлага болжээ.

3. СБД-2 дугаар хэлтэст 16 төрлийн дуудлага, мэдээлэл дээр хэрхэн ажиллах, дуудлага мэдээллийн хуудсыг хэрхэн бөглөх талаар загвар боловсруулан ламинатордож, хөдөлгөөнт эргүүлийн автомашинуудад тараасан, эргүүлийн алба хаагчдыг гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээ, мэдээлэл олж авах талаар шахан, үр дүнг тооцож, албаны болон зайны сургалтын материал, объектын судалгааг жигдрүүлэн, тухай бүр шинэчилж ажилласан нь бусад дүүрэгт үлгэр жишээ болохуйц байна.

4. БЗД-2 дугаар хэлтэст эргүүлийн алба хаагчид хариуцсан нутаг дэвсгэрээ бүрэн таних, чиглэлүүд бие биенээ нөхөн ажиллахад хүндрэл учруулахгүй байх зорилгоор хөдөлгөөнт эргүүлийн чиглэлийг 14 хоног тутамд сэлгэн ажиллуулж байгаа нь шинэлэг байна.

5. ХУД-1 дүгээр хэлтсийн хөдөлгөөнт эргүүлийн объектын судалгаа нь хэлбэр дизайн, агуулгын хувьд шинэлэг, ойлгомжтой байв. Мөн эргүүлийн чиглэлийг гэмт хэргийн нөхцөл байдлын нарийвчилсан судалгаанд тулгуурлан боловсруулж ажилласан нь үр дүнтэй байна.

6. ХУД-2 дугаар хэлтэс нь хөдөлгөөнт эргүүлийг шөнийн цагаар дуудлагагүй үедээ Яармагийн зам дээр тээврийн хэрэгсэлд шалгалт зохион байгуулж ажиллуулснаар энэ оны эхний 8 сарын байдлаар 7 хэрэг, 40 гаруй согтуу жолоочийг илрүүлж, тухайн зам дээр осолдож нас барсан хүний тоо өнгөрсөн оны мөн үеийнхээс 7 дахин буурчээ.

7. СХД-3 дугаар хэлтэс нь дүүргийн Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран ажиллаж, хөдөлгөөнт эргүүлийн машинуудад нэг бүр нь 40000 төгрөгийн үнэ бүхий иж бүрэн анхны тусламжийн хайрцагийг жигдрүүлэн

олгуулсан. Мөн бүх машинуудад бамбай, каск, хорт утааны баг тавьж олгосон нь болзошгүй онцгой нөхцөлд үүрэг гүйцэтгэхэд алба хаагчийн аюулгүй байдлыг хангах сайн алхам болжээ.

8. БГД-1 дүгээр хэлтсээс хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 11 их, дээд сургуультай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, “Оюутан цагдаа” нэрийн дор оюутнуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилт татан оролцуулах ажлыг эхлүүлээд байгаа нь сайшаалтай байна.

9. Хяналт шинжилгээний явцад хийсэн уулзалт ярилцлагын үеэр алба хаагчдаас хувийн мөнгөөрөө албаны автомашинд сэлбэг хэрэгсэл худалдан авах, засвар үйлчилгээ хийлгэсэн талаарх мэдээлэл түгээмэл байгааг харгалзан дүүргийн цагдаагийн хэлтсүүдээс мэдээлэл цуглуулж нэгтгэхэд сүүлийн 1-2 жилийн хугацаанд хөдөлгөөнт эргүүлийн алба хаагчид нийт 11.5 сая төгрөгийн үнэ бүхий сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээг хувийн мөнгөөр худалдан авч албан хэрэгцээнд ашигласан байна. Уг зардлын дийлэнх нь дугуй, аккумулятор, суудлын бүрээс худалдан авах, автомашины доод эд ангийг хамгаалах хаалт хийлгэхэд зарцуулагджээ.

Долоо.Эргүүлийн үйл ажиллагаатай холбоотой анхаарвал зохих асуудлын талаар

1. Батлагдсан орон тооны дагуу эргүүлийн офицер, цагдаа-жолооч болон цагдаа нийт 718 алба хаагч байх ёстойгоос 1 хувь буюу 7 орон тоо дутуу, 19 хувь буюу 134 алба хаагч эргүүлээс бусад ажилд ажиллаж, 15 хувь буюу 109 алба хаагч тодорхой шалтгааны улмаас албан үүргээ гүйцэтгээгүй байгаа нь хүн хүчний хүрэлцээгүй байдлыг улам дэвэргэж, эргүүлийн үйл ажиллагааг доголдуулж байна.

2. Эргүүлийн чиглэлийг хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдлын судалгаанд үндэслэн төлөвлөж зохион байгуулах ажил жигдэрч хэвшээгүй, үр дүнгээ тооцож, цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэлээ тодорхойлдоггүй дутагдал нийтлэг байна.

3. Хяналт шинжилгээний явцад илэрсэн энгийн зөрчил, дутагдлуудаас үзвэл дүүргийн цагдаагийн хэлтэс, тасгийн дарга нар, УБХЦГ-ын ахлах байцаагчид болон ёс журам сахиулах эргүүлээс эргүүлийн үйл ажиллагаанд тавьж буй хяналт нь үр дүн багатай, хэлбэр төдий хэрэгжиж байна гэж үзэж болохоор байна.

4. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Б/284 дүгээр тушаалаар баталсан бүтцээр дүүргийн цагдаагийн хэлтэс дэх захиргааны зөрчил хариуцсан ахлах байцаагчийн орон тоо байхгүй болсон. Улмаар гомдол, мэдээллийг шалгах чиглэлээр хэсгийн байцаагч нарын ачаалал 2 дахин өсч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах цаг багассан байна. Тухайлбал, энэ оны 04 дүгээр сард Улаанбаатар хотын хэмжээнд хэсгийн байцаагч нар

нийт 960 гомдол, мэдээллийг хүлээн авч, 78 эрүүгийн хэрэг үүсгэж, 402 эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, 46 харъяаллын дагуу шилжүүлж, 433 захиргааны зөрчлийг материалжуулан шалгасан бол 08 дугаар сард нийт 1785 гомдол, мэдээллийг хүлээн авч, 104 эрүүгийн хэрэг үүсгэж, 576 эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, 38 харъяаллын дагуу шилжүүлж, 1053 захиргааны зөрчлийг материалжуулан шалгажээ.

5. Зарим дүүрэгт эргүүлийн алба хаагчдад тусгай хэрэгслийг оновчгүй тавьж олгосноос тусгай хэрэгсэл давхардаж олгогдох, эсхүл дутах зэрэг дутагдал байсан.

6. Хөдөлгөөнт эргүүлийн автомашинд байх эмийн сан, албаны болон зайны сургалтын материал, объектын судалгааны 80-87 хувь нь албаны хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаагүй, нэгдсэн стандартгүй, баяжилт шинэчлэлт хийгдээгүй байна.

7. Зарим дүүргийн цагдаагийн хэлтэс дотоод нөөц бололцоондоо тулгуурлан энэ оны 03 дугаар сар хүртэл хөдөлгөөнт эргүүлийн алба хаагчдад 2000-3000 төгрөгийн холбооны зардал олгож байснаа зогсоосон нь албаны шуурхай байдалд сөргөөр нөлөөлж байна.

8. Автомашины дугуй болон бусад сэлбэг хэрэгслийн эдэлгээний хугацаа, норм, хоногийн гүйлтийн хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээ, онцлогийг харгалзан ялгамжтай тогтоогоогүйгээс автомашины эвдрэл гэмтэл, шатахууны хомсдолоос шалтгаалан албаны бэлэн байдал алдагдахад хүргэж байна.

9. Албаны тусгай хэрэгсэлтэй холбогдуулан цахилгаан бороохой нь тогтоогчноосоо мултартч унадаг, энгэрийн камерийн тогтоогч нь хэврэг, амархан хугардаг, нулимс асгаруулагч нэг удаа хэрэглэснээс хойш хошуугаараа хийгээ алдаж амархан дуусдаг, алсын дуудлагад явахад станцын үйл ажиллагаа доголддог зэрэг хүндрэл бэрхшээл байна.

10. Нийслэлийн Засаг даргын А/609 дүгээр захирамжаар үйлчилгээний газруудын ажиллах хугацааг шөнийн 04 цаг хүртэл сунгаснаар өдрийн цагаар ачаалал багасаж, шөнийн цагаар ачаалал эрс нэмэгдсэн.

11. Зарим дүүргийн цагдаагийн хэлтсийн даргаас НХЖХТ-ийн дарга, эргүүл хамгаалалт хариуцсан ахлах байцаагчийн үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандаж, тэдний цаашилбал хэв журмын чиглэлээр ажиллаж буй нийт алба хаагчдын мэдлэг, ур чадварын түвшинг шалгаж тогтоох нь зүйтэй гэх саналтай байсан нь анхаарал татаж байлаа.

12. Хөдөлгөөнт эргүүлийн автомашин, сэлбэг хэрэгслийг Киa Моторс болон Монгол Хьюндай Киa гэсэн 2 компаниас худалдан авч, засвар үйлчилгээг хийлгэж байна. Гэвч Монгол Хьюндай Киa компаниас тавьж олгосон сэлбэг хэрэгсэл нь чанаргүй, засвар үйлчилгээний явцыг хөндлөнгөөс хянах боломжгүй, ийм боломжоор хангуулах хүсэлт тавьсан ч шийдвэрлэдэггүй зэрэг хүндрэл байгааг алба хаагчдаас илэрхийлсэн.

Найм.Дүгнэлт

Хяналт шинжилгээний явцад цугларсан мэдээлэл, баримт материалд тулгуурлан Цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагаатай холбоотой дараах дүгнэлтэнд хүрлээ.

Статистик мэдээнээс үзвэл 2011 оноос 2014 он хүртэлх хугацаанд нийт гэмт хэрэг **42.3** хувь өссөн байхад гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг **60.0** хувь, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг **59.6** хувь, бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэрэг **78.8** хувь тус тус өсчээ. Өөрөөр хэлбэл дээрх гэмт хэргүүдийн өсөлтийн хувь нь нийт гэмт хэргийн өсөлтийн хувиас давсан үзүүлэлттэй байгааг цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагааны үр дүнтэй холбон тайлбарлаж болох юм.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны Б/284 дүгээр тушаалаар нийт 718 эргүүлийн офицер, цагдаагийн орон тоог баталсан ч тэдний **1/3** нь тодорхой шалтгааны улмаас ажиллахгүй буюу эргүүлийн чиглэлээр ажиллаагүй байна. Эргүүлийн эмэгтэй офицер, цагдаа нийт **30** байна.

Улаанбаатар хотын төвийн дүүргүүдийн цагдаагийн хэлтэст хөдөлгөөнт эргүүлд ажиллавал зохих нийт 67 автомашинтайгаас хөдөлгөөнт эргүүлд 61 автомашин ажиллаж, алба хаагчид нь ээлжийн амралттай 2, засвартай 3, хөдөлгөөнт эргүүлээс бусад ажилд дайчлагддаг 1 автомашин байна. Хөдөлгөөнт эргүүлийн алба хаагчдын ажлын ачаалал, үр дүнг харгалзан 4 ээлж буюу ажлын 12 цагийн хуваарьт оруулсан хэдий ч **7** хэлтсийн **27** автомашин 24 цагийн хуваариар ажиллаж байгаа нь ухарсан алхам болжээ.

Хөдөлгөөнт эргүүлийн автомашинд байх эмийн сан, албаны болон зайны сургалтын материал, объектын судалгааны **80-87** хувь нь албаны хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаагүй, нэгдсэн стандартгүй, баяжилт шинэчлэлт хийгдээгүй байна.

Нөгөө талаас эргүүлийн автомашины дугуй, сэлбэг хэрэгслийн эдэлгээний хугацаа, хоногийн гүйлтийн хэмжээг нэмэгдүүлэх замаар хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээ, онцлогийг харгалзан ялгамжтай тогтоох зайлшгүй шаардлага байна.

Эргүүлийн чиглэлийг хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдлын судалгаанд үндэслэн төлөвлөж зохион байгуулах ажил жигдэрч хэвшээгүй, үр дүнгээ тооцож, цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэлээ тодорхойлдоггүй дутагдал нийтлэг байна.

Хяналт шинжилгээний явцад илэрсэн энгийн зөрчил, дутагдлуудаас үзвэл дүүргийн цагдаагийн хэлтэс, тасгийн дарга нар, УБХЦГ-ын ахлах байцаагчид болон ёс журам сахиулах эргүүлээс эргүүлийн үйл ажиллагаанд тавьж буй хяналт нь үр дүн багатай, хэлбэр төдий хэрэгжиж байна гэж үзэж болохоор байна.

Хүн хүчний хязгаарлагдмал боломжоос шалтгаалан явган эргүүлийн цөөн чиглэл гарч байгаа бөгөөд явган эргүүлийн гол ачааг

хороо хариуцсан цагдаа, олон нийтийн цагдаа болон ээлжнээс буусан хөдөлгөөнт эргүүлийн алба хаагчид үүрч байна.

Нэгтгэн дүгнэвэл эргүүлийн үйл ажиллагааны чанар, үр нөлөөнд байгууллагын төсөв, санхүүгийн боломжоос гадна шат шатны дарга нарын идэвхи санаачлага, ажлын хариуцлага, хичээл зүтгэл голлох нөлөөг үзүүлж байна.

Ес.Зөвлөмж

Хяналт шинжилгээний тайлан, дүгнэлтэд үндэслэн эргүүлийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Нийтийн хэв журам хамгаалах албанд:

1. Эргүүлийн үйл ажиллагааны төлөвлөлт, хяналтыг үр дүнтэй зохион байгуулах чиглэлээр дэлгэрэнгүй аргачилсан зааварыг боловсруулж холбогдох нэгжүүдэд хүргүүлэх.

Улаанбаатар хотын цагдаагийн газарт:

1. Хөдөлгөөнт эргүүлийн автомашины анхны тусламжийн хайрцагт байвал зохих эм, хэрэгслийн жагсаалт, тоо хэмжээг гаргаж мөрдүүлэх,

2. Хөдөлгөөнт эргүүлийн автомашины объектын судалгаа болон зайны сургалтын материалын агуулга, бүрдэл хэсэг, түүнд нэмэлт баяжилт хийх хугацаа, давтамжийг тодорхойлж мөрдүүлэх,

3. Хөдөлгөөнт эргүүлийн 4 ээлж, 12 цагийн ажлын горимыг бүх дүүрэгт нэг мөр хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллах,

4. Нийслэлийн Засаг даргын А/609 дүгээр захирамжид өөрчлөлт оруулах замаар Архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг газруудын ажиллах цагийн хуваарийг богиносгох саналыг уламжилж шийдвэрлүүлэх,

5. Эргүүлийн алба хаагчдыг эргүүлээс бусад чиглэлээр ажиллуулдаг байдлыг таслан зогсоож, хяналт тавьж ажиллах,

6. Эргүүлийн үйл ажиллагааны талаарх энэхүү тайланд тусгагдсан болон бусад ажлын сайн туршлагыг сурталчилж, дүүргийн цагдаагийн хэлтэс бүрт жигд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах,

7. Дүүргийн цагдаагийн хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, эргүүл хариуцсан ахлах байцаагч нарын манлайлал, мэдлэг, ур чадварын түвшин, ажлын үр дүнг үнэлэх ажлыг зохион байгуулж, шаардлагатай бол алба хаагчдын ажлын байрыг өөрчлөх саналыг холбогдох нэгжид гаргаж шийдвэрлүүлэх,

Санхүү, хангамжийн газарт:

1. Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2011 оны 224 дүгээр тушаалаар тогтоосон автомашины дугуй, аккумуляторын эдэлгээний

хугацааны доод хязгаарын жишиг нормыг богиносгох асуудлыг судалж, холбогдох байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх,

2. Хөдөлгөөнт эргүүлийн автомашины хоногийн гүйлтийн хэмжээг одоо байгаа түвшнээс бууруулалгүй, дүүргийн цагдаагийн хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээ, онцлогт тохируулан ялгамжтай тогтоох,

3. Хөдөлгөөнт эргүүлийн автомашины засвар үйлчилгээг шуурхай зохион байгуулах, Монгол Хьюндай Киа компаниас хийж буй засвар үйлчилгээний явцыг хөндлөнгөөс хянах боломжийг хөдөлгөөнт эргүүлийн алба хаагчдад олгоход анхаарч шийдвэрлэх,

4. Хөдөлгөөнт эргүүлийн алба хаагчдын холбооны зардалд шаардлагатай 55.840.000 төгрөгийн зардлыг 2016 оны төсөвт тусгуулж шийдвэрлүүлэх,

5. Цагдаагийн алба хаагчдад тавьж олгосон тусгай хэрэгсэл / энгэрийн камер, цахилгаан бороохой, нулимс асгаруулагч г.м/-тэй холбоотой хүндрэл бэрхшээлийг цаашид хийгдэх тусгай хэрэгслийн сонгон шалгаруулалт, худалдан авах ажиллагаанд анхаарах,

6. Хөдөлгөөнт эргүүлийн машинуудыг цахилгаан /hybrid/ хөдөлгүүртэй автомашинаар сольсноор үүсэх хэмнэлт, үр дагавар, эдийн засгийн үр ашгийн талаар судалгаа хийж Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулах.

Хүний нөөц, сургалтын хэлтэст:

1. Улаанбаатар хотын цагдаагийн газар болон харьяа нэгжүүдэд ажиллаж буй эмэгтэй алба хаагчдын хувь хэмжээг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан жишиг нормативд хүргэж бууруулах, цаашид эргүүлийн алба хаагчийн орон тоонд эмэгтэй алба хаагч томилохгүй байх,

2. Эргүүлийн алба хаагчийн сул орон тоонд өөр алба хаагч томилох асуудлыг шуурхай шийдвэрлэж, цаашид албаны хэвийн үйл ажиллагааны эмзэг байдлыг хүний нөөцийн үйл ажиллагаандаа анхаарч ажиллах.

Дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдэд:

1. Эргүүлийн алба хаагчдыг эргүүлээс бусад ажилд ажиллуулдаг байдлыг таслан зогсоох,

2. Эргүүлийн алба хаагчдад тусгай хэрэгсэл давхардуулан олгох, тусгай хэрэгсэлгүй алба хаагчийг эргүүлд гаргах зэрэг зөрчлийг арилгаж, тусгай хэрэгслийн хангалт, хуваарилалтыг оновчтой зохион байгуулах,

3. Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдал, гэмт хэрэг, зөрчлийн дэлгэрэнгүй судалгаанд үндэслэн эргүүлийн чиглэл,

хүн хүчийг төлөвлөж зохион байгуулахад онцгой анхаарч, үр дүнг тухай бүр тооцож, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж хэвших,

4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны явц, үр дүн, ач холбогдлын талаар нутгийн захиргааны байгууллагыг мэдээллээр хангаж, энэ чиглэлээр хэрэгжүүлэх гэж буй ажил, арга хэмжээг сурталчлан тэдний дэмжлэг туслалцааг авахад санаачлагатай ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг 2015 оны 12 дугаар сарын 20-ны дотор Дотоод хяналт, аюулгүй байдлын газарт ирүүл.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ТЕЛЕХЯНАЛТЫН КАМЕРЫН АШИГЛАЛТАД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2015.06.12

Улаанбаатар хот

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын талаар

Таны 2015 оны А/30 дугаар тушаал, мөн Дотоод хяналт, аюулгүй байдлын газрын даргын 2015 оны 05 дугаар сарын 04-ний өдөр баталсан удирдамжийн дагуу цагдаагийн байгууллагын телехяналтын камерын ашиглалтын байдалд хяналт-шинжилгээ хийх ажлын хэсгээс гүйцэтгэсэн ажлын дүнг танилцуулж байна.

Ажлын хэсгийн ахлагчаар Дотоод хяналт, аюулгүй байдлын газрын Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Н.Батзогсох, нарийн бичгийн даргаар мөн хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх, гишүүнээр мөн хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч Л.Оюунтуяа, Холбооны хэлтсийн ахлах инженер, цагдаагийн хошууч С.Энхбат, мөн хэлтсийн техникч, цагдаагийн дэслэгч Т.Билгүүн нар ажиллалаа.

Ажлын хэсгийн хурлыг нийт 3 удаа зохион байгуулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаал, хяналт-шинжилгээний ажлын удирдамжийн төслийг гарган батлуулж, ажил, үүргийн хуваарь, мэдээлэл цуглуулах маягтыг боловсруулж ашигласан. Мөн ажлын хэсгийн гишүүд Улаанбаатар хотын цагдаагийн хүрээний байгууллагуудад хүрэлцэн очиж ажиллахад шаардлагатай автомашин, шатахууны зардлыг шийдвэрлүүлсэн.

Ажлын хэсгийн зорилго нь цагдаагийн байгууллагын аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд телехяналтын камерын хангамж, ашиглалтын нөхцөл байдлыг тодорхойлж, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийг телехяналтын камерын системээр бүрэн хангахад шаардагдах тоног төхөөрөмж, зардлын судалгааг гаргаж, ашиглалтыг сайжруулах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулах юм.

Иймд хяналт-шинжилгээний дүнгийн танилцуулгыг телехяналтын камерын хангалт, телехяналтын камерын ашиглалтын байдал болон дүгнэлт, санал зөвлөмж гэсэн дэд хэсэгтэйгээр бичлээ.

Хоёр.Телехяналтын камерын хангамжийн талаар

Төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын телехяналтын камерын хангамж хүрэлцээг тодорхойлох зорилгоор судалгааны маягт /Хавсралт 1/-ыг боловсруулж, орон нутгийн цагдаагийн байгууллагуудаас албан бичгээр, Улаанбаатар цагдаагийн хүрээний байгууллагуудад ажлын хэсгийн гишүүд хүрэлцэн очиж мэдээлэл цуглуулсан.

Судалгаагаар Улаанбаатар цагдаагийн хүрээний 38 байгууллагад

байгууллагын аюулгүй байдлыг хангах чиглэлээр гадна талд **91**, дотор орчинд **492**, нийт **583** ширхэг телехяналтын камер суурилуулагдсанаас **75.3** хувь буюу **439** ширхэг нь хэвийн ажиллаж байна /График 1/.



Телехяналтын камерын системийн **15** хувь нь IP /ай пи/, **85** хувь нь аналог систем байна. IP систем нь аналог системээс сүлжээний орчинд ажилладаг тул хаанаас ч хянах боломж олгодог, дүрс бичлэгийн чанар, бичлэг хадгалах багтаамж өндөр, ашиглахад хялбар зэрэг давуу талтай тул цаашид телекамерын аналог системтэй нэгжүүдийг IP системрүү шилжүүлэх нь зүйтэй байна.

Мөн гэрэл багатай болон харанхуй орчинд хийгдсэн камерын бичлэгийн чанарыг сайжруулахын тулд цагдаагийн байгууллагуудын гадна орчны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, зарим камеруудыг илүү нягтрал сайтай, харанхуй орчинд бичлэг хийх боломжтой /инфра туяатай/ камераар солих шаардлагатай байна.

Хууль зүйн сайдын 2014 оны А/73 дугаар тушаалаар батлагдсан “Архидан согтуурахтай тэмцэх сан”-гийн 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Төрийн нарийн бичгийн даргын баталсан “Хамтран ажиллах гэрээ”-ний хэрэгжилтийг хангах хүрээнд “Архидан согтуурахтай тэмцэх сан”-гийн 80865,0 мянган төгрөгийн санхүүжилтээр Нийслэлийн төвийн 6 дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсүүд болон Налайх, Багахангай дүүргийн цагдаагийн хэлтсийн саатуулах байрны телехяналтын камерын системийг шинэчилсэн нь саатуулах байранд хүний эрх, алба хаагчийн эрх ашиг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чухал алхам болжээ.

Телехяналтын камерын системгүй 8 нэгжийн 5 барилга байгууламж /МТТ, ТАГ, МШАДҮТГ, МШАДҮМГ /хуучнаар/, СДТөв, АНСТөв, АССХэлтэс, ИАТЦХ/ байна. Албаны шинэ байранд орохоор төлөвлөж буй нэгжүүдээс бусад телехяналтын камерын системгүй болон ийм системтэй ч байгууллагын аюулгүй байдлыг бүрэн хангах зорилгоор телекамерийн хүчин чадлыг сайжруулах, нэмж суурилуулах Улаанбаатар цагдаагийн хүрээний байгууллагуудад нийт **338** ширхэг телекамер шаардлагатай байна. Шинээр нэмж суурилуулах шаардлагатай телехяналтын камер, дагалдах тоног төхөөрөмжийг худалдан авахад **216.8** сая төгрөгийн зардлыг шийдвэрлэх урьдчилсан тооцоо гарсан.

Аймгуудын цагдаагийн газар, хэлтсийн тухайд, нийт **435** камер

суурилуулагдсанаас **381** буюу **87.5** хувь нь хэвийн ажиллаж байна /График 2/.

Цаашид орон нутгийн цагдаагийн байгууллагын телехяналтын камерын системийг шинэчлэх, барилга байгууламжийг бүрэн хяналтад авахад шаардлагатай **385** камерыг худалдан авахад **231.0** сая төгрөгийн зардлыг шийдвэрлэх урьдчилсан тооцоо гарсан /Хавсралт 3/



Гурав.Телехяналтын камерын ашиглалтын талаар

Аливаа техник технологийн дэвшил нь түүнийг ашиглах хүний мэдлэг, ур чадварын түвшнээр хэмжигдэн хязгаарлагдаж байдаг. Энэ байдлыг ухаалаг утсыг зөвхөн утсаар ярьж, мессеж бичих төдийхнөөр ашиглахтай жишээлэн тайлбарлаж болно. Үүнтэй адил цагдаагийн байгууллагын аюулгүй байдлыг хангах зорилготой телехяналтын камерын системийн ач холбогдол, үр нөлөө нь түүний ашиглалтаас шууд хамаардаг.

Ажлын хэсгээс төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын телехяналтын камерын ашиглалтын байдлыг тодорхойлох зорилгоор судалгааны маягт /Хавсралт 2/-ыг боловсруулж, мэдээлэл цуглуулан нэгтгэсэн.

Улаанбаатар хотын хэмжээнд судалгаанд хамрагдсан **38** цагдаагийн байгууллагын **92.1** хувь нь телехяналтын камер суурилуулсан тухай бүртгэлгүй, **94.7** хувь нь телехяналтын камерын ашиглалтын талаар бүртгэл судалгаагүй, камерын бичлэгийг ашигласан тохиолдол нийслэлд **3**, орон нутагт **4** удаа гарсан нь маш бага үзүүлэлт юм.

Автобааз болон Сүхбаатар дүүргийн цагдаагийн 1 дүгээр хэлтсийн дарга нарын өрөөнд байгаа камерын хяналтын дэлгэцийг жижүүрийн өрөөнд шилжүүлэх шаардлагатай, бусад нэгжүүд дэх камерын хяналтын цэгийн зохион байгуулалт нь оновчтой байлаа.

Улаанбаатар хотын дүүргийн цагдаагийн хэлтсүүд болон Цагдаагийн ерөнхий газрын харъяа зарим нэгжүүдэд холбоо, мэдээллийн технологийн ажилтны орон тоо байхгүйгээс Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, Холбооны хэлтсээс энэ чиглэлийн ажлыг хариуцан ажиллаж байна.

Энэ нь дээрх нэгжүүдийн ачааллыг нэмэгдүүлж, хүн хүчний хүрэлцээгүйгээс холбоо, телехяналтын камер болон дагалдах техник хэрэгслийн засвар үйлчилгээнд хүндрэл учрах, камерын хяналтын цэгт ажиллаж буй алба хаагчийн дээрх техник, програм хангамжтай ажиллах мэдлэг, ур чадвар дутмаг байгаа зэргээс хэвийн үйл ажиллагаа нь тодорхой хугацаагаар саатах эрсдэлтэй байгаа нь хяналт-шинжилгээний явцад ажиглагдлаа. Тухайлбал, Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газрын /хуучнаар/ телехяналтын камер бичлэг хийх горимд шилжээгүй, Автобаазын хяналтын цэгт ажиллаж буй алба хаагчийн мэдлэг, ур чадвар дутмагаас камерын системийн үйл ажиллагаа зогссон байсан зэрэг дутагдал илэрсэн. Нөгөө талаас Баянзүрх дүүргийн цагдаагийн 3 дугаар хэлтэс дотоод нөөц бололцоогоо ашиглан 3 ширхэг камер суурилуулж байгууллагын эмзэг цэгүүдийг хяналтад авсан нь сайшаалтай байлаа.

Дөрөв. Дүгнэлт, санал

Цагдаагийн байгууллагын нэгж бүр телехяналтын камераар тодорхой хэмжээнд хангагдсан боловч ашиглалтын хугацаа дууссан, эвдэрч ажиллагаагүй болсон, дүрсний нягтрал бага, харанхуйд бичлэг хийх боломжгүй зэргээс шалтгаалан нийт **1018** камераас **198** нь ажиллагаагүй гэсэн үзүүлэлттэй байна. Эдгээр камерыг шинэчлэх, телехяналтын камерын системгүй нэгжүүдэд энэ системийг бий болгоход нийт **723** ширхэг камер, дагалдах тоног төхөөрөмжийг худалдан авах, үүний тулд **447.8** сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэх урьдчилсан тооцоо гарлаа. Энэхүү зардлыг тооцохдоо нэгж камерын зах зээлийн дундаж үнэ дээр дагалдах хэрэгслийн /кабель утас, холболтын хэрэгсэл г.м/ зардлыг нэмж, шаардлагатай нийт камерын тоогоор үржүүлэн гаргасан.

Хяналт-шинжилгээний явцад цагдаагийн байгууллагын хөрөнгө ихээр төвлөрсөн Автобааз, Хангалт үйлчилгээний тасгийн телехяналтын камерын систем тун хангалтгүй байсан нь анхаарал татаж байлаа.

Мөн цагдаагийн байгууллагуудад телекамерын систем, техник хэрэгслийг суурилуулсан, засвар үйлчилгээ хийсэн бүртгэл судалгаагүй, камерын бичлэгийг ашигласан тухай бүртгэл хөтөлдөггүй зэрэг нь ашиглалтын байдал хангалтгүй байгааг харуулж байна.

Нийслэлийн дүүргийн цагдаагийн хэлтсүүд болон Цагдаагийн ерөнхий газрын харъяа зарим нэгжүүдэд мэдээллийн технологи хариуцсан ажилтны орон тоо байхгүй, шаардлагатай засвар үйлчилгээг Холбооны хэлтэс, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвөөс хариуцан хэрэгжүүлдэг нь засвар үйлчилгээнд хугацаа алдах, техник хэрэгсэл эзэнгүйдэж ашиглалт нь буурах зэрэг эрсдэлийг үүсгэж байна. Энэ байдал зөвхөн телекамерын системд бус тухайн нэгжийн мэдээллийн сүлжээ, компьютер, станц, холбооны хэрэгслийн хэвийн үйл ажиллагаанд ч сөргөөр нөлөөлж байгаа нь байгууллагын аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй юм.

Хяналт-шинжилгээний үр дүнд үндэслэн цагдаагийн байгууллагын аюулгүй байдлыг хангах зорилготой телехяналтын камерын ашиглалтыг сайжруулах чиглэлээр төв, орон нутгийн цагдаагийн байгууллагад, техник хэрэгслийн засвар үйлчилгээнд учирч буй хүндрэл бэрхшээлийг арилгах чиглэлээр Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, Мэдээлэл, технологийн төв болон Холбооны хэлтэст тус тус ажлын чиглэл хүргүүлээд байна.

Цаашид байгууллагын төсөв, санхүүгийн боломжийг харгалзан эхний ээлжинд өндөр эрсдэл бүхий нэгжүүдэд /Мөрдөн байцаах газрын 1, 2 дугаар байр, Тусгай ажиллагааны газар, Автобааз, Хангалт, үйлчилгээний тасаг, Сургалт, дадлагын төв, Мэдээлэл, технологийн төв, Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтэс/ телехяналтын камерын систем бий болгох, шинэчлэхэд шаардлагатай **102.9** сая орчим төгрөгийн зардлыг шийдвэрлүүлэх саналтай байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2015.12.08

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг шинээр боловсруулан батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтэс

Аудит хийгдсэн объект: Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг шинээр боловсруулан батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагаа

Аудитын төрөл: Нийцлийн аудит

Аудитын хугацаа: 2015.11.04- 2015.12.04

Дотоод аудитын нэгжийн дарга: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Н.Батзогсх

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх, С.Баасанжав

1. ТАНИЛЦУУЛГА

Хуулийн хэлтэс нь 2015 оны 11 дүгээр сарын байдлаар хэлтсийн дарга 1, ахлах мэргэжилтэн 6, нийт 7 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй цагдаагийн байгууллага, алба хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ тогтоосон баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах, хууль тогтоомж, эрхийн акт, тушаал шийдвэрийн төсөлд санал боловсруулах, төсөлд санал өгөх, эрх зүйн дүгнэлт гаргах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Аудитын хийгдэж буй үйл ажиллагаатай холбогдуулан тус хэлтсээс 2014 он, 2015 оны эхний хагас жилийн байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэжээ. Үүнд:

2014 онд нийт 25 журам /Код/-ыг шинэчлэх болон нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагааг зохион байгуулсан. 2015 оны эхний хагас жилийн байдлаар Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын дөрвөн /1, 2, 3 ба 7/ бүлэг болон 20 журмыг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах үйл ажиллагааг тус тус зохион байгуулжээ.

Өнөөдрийн байдлаар нийт 256 журам шинэчлэгдэн батлагдахаас 247 журам батлагдсан, ажлын биелэлт 96.4 хувьтай, энэ ондоо багтаан үлдсэн журмуудыг батлуулж, 4 дэх эмхтгэлээ хэвлүүлэн түгээхээр ажиллаж байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

“Цагдаагийн байгууллагын 2015 оны дотоод аудитын төлөвлөгөө”-нд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн давхардал, хийдлийг арилгаж, уялдаа холбоог сайжруулах чиглэлээр дотоод аудит хийгдэхээр тусгасан.

Нөгөө талаас Цагдаагийн албаны тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, 2014 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөгдөж эхэлснээр цагдаагийн байгууллага нь шинэ бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн шинэ орчинд үйл ажиллагаагаа явуулах болсон. Улмаар цагдаагийн байгууллага, алба хаагчийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулсан журмуудыг шинэчлэн боловсруулах үйл явц эрчимтэй өрнөж, одоо ч үргэлжилсээр байна.

Иймд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг шинээр боловсруулан батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагаанд дотоод аудит хийж, түүнийг боловсронгуй болгох чиглэлээр санал, зөвлөмж боловсруулах нь энэхүү ажлын зорилго юм.

2.2 Аудитын цар хүрээ

Дотоод аудитын цар хүрээг 2014, 2015 оны эхний хагас жилд Хуулийн хэлтсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг шинээр боловсруулан батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагаагаар хязгаарлана.

Аудитын хүрээнд тус хэлтсийн алба хаагчидтай уулзалт ярилцлага хийж, үйл ажиллагааны тайлан, ажлын байрны тодорхойлолттой танилцан, тохиолдлын байдлаар түүвэрлэн авсан 25 ширхэг журам /Код/-ын хувийн хэргийн бүрдүүлэлтийг шалгав.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг боловсруулах, хэрэгжүүлэх /Код 103/ журмын 103.14.5-д “хувийн хэрэгт тухайн кодтой журмыг боловсруулах, батлах, тараах, шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой бүхий л санал, албан бичиг, хэлэлцсэн тэмдэглэл зэрэг материалыг багтаан баяжуулах ажлыг Хуулийн хэлтэс, түүний алба хаагч хариуцах”-аар зохицуулжээ.

Үүний дагуу түүвэрлэн авсан 25 ширхэг журмын хувийн хэргийн бүрдүүлэлтийг үзэж танилцахад дараах нөхцөл байдалтай байлаа. Үүнд:

1. Хувийн хэргийг хадгалах сейф шүүгээ нь багтаамж муутайгаас шалтгаалан хувийн хэрэгт байвал зохих тухайн журмыг шинэчлэн

боловсруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар цагдаагийн нэгж, алба хаагчдаас ирүүлсэн саналууд нь өөр газар хадгалагдаж байна. Ингэхдээ санал, холбогдох баримт бичгүүдийг журам тус бүрээр ангилаагүй, тус хэлтэст ирсэн, явсан бусад албан бичгүүдтэй нэгтгэн архивын нэгж болгосон нь журамд заасан шаардлагыг зөрчсөн, цаашид тухайн журмын намтар буюу төслийн шатанд цугларсан санал, холбогдох баримт материалыг дахин ашиглахад хүндрэл учрахаар болжээ.

2. Тус хэлтсийн зүгээс цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг шинээр батлах болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагаанд тулгамдаж буй хүндрэл бэрхшээл байхгүй, гагцхүү журмыг алба хаагчдад сурталчлан таниулах, хэрэглээ болгох ажил үр дүн багатай гэх байр суурьтай байна. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын эмхтгэл нь 2011 онд 400 хувь, 2012 онд 400 хувь, 2013 онд 400 хувь тус тус хэвлэгджээ. Эмхтгэлийг 2013 онд нэг бүрийг нь 6000 төгрөгөөр хэвлүүлсэн бөгөөд хэвлэгдсэн тоо хэмжээ нь цагдаагийн байгууллагын нийт алба хаагчдын тоотой харьцуулахад хангалтгүй байна.

4. ДҮГНЭЛТ

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий Бодлогын зөвлөлийн үйл ажиллагаа нь Хуулийн хэлтэс, алба хаагчийн дэмжлэг, оролцоотойгоор зохих журмын дагуу хэрэгжиж, тус хэлтэс, алба хаагчид нь энэ талаар мэргэшсэн, үйл ажиллагаа нь жигдэрсэн гэж үзэж болохоор байна.

Харин журмын хувийн хэргийн бүрдүүлэлт, холбогдох баримт материалыг архивын нэгж болгон хадгалахад сейф шүүгээний багтаамж, хүрэлцээ, тус хэлтсийн үйл ажиллагааны өмнөх зохион байгуулалтаас хамааран нийтлэг бус ч анхаарвал зохих зарим асуудал байна. Тухайлбал, журмын төсөлд нэгж, алба хаагчдаас ирүүлж байсан саналууд журам тус бүрээр ангилан архивлагдаагүй, журмын код өөрчлөгдөх, эсхүл журмуудыг нэгтгэх, салгах зэргээс хамаарч түүнд холбогдох зарим материал нь өөр журмын хувийн хэрэгт үлдэн хадгалагдаж байна.

Нөгөө талаас журмыг хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээлтэй байгаа талаар нэгж, алба хаагчдын дунд үг яриа цөөнгүй гардаг ч, түүнийг сайжруулж боловсронгуй болгох чиглэлээр идэвхи санаачлага гаргах, журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглээ болгох хандлага дутмаг байна. Энэ байдалд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын эмхтгэлийн хангалт, хүрэлцээ муу, тасгийн даргаас доошхи алба хаагчдад хүрэлцэхээргүй байдал нь тодорхой хэмжээнд нөлөөлдөг байх магадлалтай.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын хэрэгжилтэд мониторинг хийж, түүнийг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, санал, зөвлөмж боловсруулах зорилгоор “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, түүний хэрэгжилтэд мониторинг

хийх” судалгааны ажлыг Цагдаагийн ерөнхий газар, Хууль сахиулахын их сургуультай хамтран хэрэгжүүлэхээр удирдамж батлагдаж, уг ажлыг эхлүүлээд байна.

5. ЗӨВЛӨМЖ

Дотоод аудитын хүрээнд илэрсэн асуудлуудыг шийдвэрлэх талаар Хуулийн хэлтэст дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгосон. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын хувийн хэргийн иж бүрдлийг журамд заасан шаардлагад нийцүүлэн бүрдүүлэх, цаашид баяжилт, ашиглалтыг хялбаршуулах зорилгоор зохион байгуулалтын арга хэмжээ авч, өмнөх уулзалтуудад өгсөн техникийн шинжтэй зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх.

2. Шаардлагатай төсөв зардал шийдвэрлэгдсэн тохиолдолд ухаалаг гар утсанд зориулсан программ /аппликейшн/ хөгжүүлж нэвтрүүлэх үйл ажиллагааг холбогдох нэгжтэй хамтарч хэрэгжүүлэх.

6. САНАЛ

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын хүртээмж, ашиглалтыг дээшлүүлэх зорилгоор ухаалаг гар утсанд зориулсан программ /аппликейшн/-ыг захиалгаар хийлгүүлж нэвтрүүлэхэд шаардлагатай 6 сая, нэг бүрийг нь 8000 төгрөгөөр 1000 ширхэг эмхтгэл хэвлүүлэхэд шаардлагатай 8 сая, нийт 14 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх саналтай байгааг илтгэн танилцуулж байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ДОТООД
АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХИЙСЭН ЭРСДЭЛИЙН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2015.06.22

Улаанбаатар хот

Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх би, Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 2015 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 06 дугаар тушаалын дагуу цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийн үнэлгээ хийж, дүнг танилцуулж байна.

Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлийг бүртгэх маягтыг боловсруулах зорилгоор Аюулгүй байдлын хэлтсийн алба хаагчид болон Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн санхүүгийн хяналт шалгалт хариуцсан ахлах байцаагч нараас саналуудыг авч нэгтгэн боловсруулалт хийж, аюулгүй байдлын 7 чиглэл, 33 эрсдэлийн бүлэг, 240 эрсдэлийн зүйл бүхий маягт /Хавсралт 1/-ыг боловсруулсан.

Түүнчлэн уг маягтын дагуу эрсдэлийг хэрхэн бүртгэх, цагдаагийн байгууллагын аюулгүй байдлын хувийн хэрэг үүсгэж хөтлөх талаар Аюулгүй байдлын хэлтсийн алба хаагчдад зааварчлага өгч ажиллалаа.

Аюулгүй байдлын хэлтсийн алба хаагчдаас хуваарь гарган Улаанбаатар хотын цагдаагийн хүрээний 37 байгууллагад хүрэлцэн очиж ажиллан, дээрх маягтын дагуу бүртгэсэн эрсдэлд суурилан эрсдэлийн үнэлгээг дараах аргачлалаар хийлээ.

Эрсдэлийн давтамжийг тодорхойлохдоо тухайн эрсдэл хичнээн нэгжид давтагдсан хувийг харгалзан 1-5 хүртэлх оноогоор үнэллээ. Нийт 37 нэгж хамрагдсанаас 0-20 хувь буюу 1-8 нэгж бол 1 оноо, 20-40 хувь буюу 9-15 нэгж бол 2 оноо, 40-60 хувь буюу 16-22 нэгж бол 3 оноо, 60-80 хувь буюу 23-29 нэгж бол 4 оноо, 80-100 хувь буюу 30-37 нэгж бол 5 оноо тус тус өгсөн.

Эрсдэлийн нөлөөллийг тодорхойлохдоо тухайн эрсдэл нь байгууллагын дотоод аюулгүй байдлын харгалзах чиглэлээр учруулсан, эсхүл учруулж болзошгүй хохирлын хэмжээг харгалзан 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн.

Дээрх аргачлалаар эрсдэлийн үнэлгээг гаргахад эрсдэлийн түвшин өндөр-8, эрсдэлийн түвшин дундаас дээш-20, эрсдэлийн түвшин дунд-27 эрсдэл үнэлэгдэж, бусад нь эрсдэлийн түвшин дундаас доош буюу эрсдэлийн матрицад тусгах шаардлагагүй эрсдэлүүд байв.

Эрсдэлийн матриц

Давтамж	5				
	4			5.3.8, 7.2.2	3.1.1, 3.2.3, 3.3.1
	3			3.5.7, 3.5.14, 5.1.3, 7.1.7	2.2.2 3.4.1, 3.4.3, 4.3.5, 5.3.4, 6.4.1
	2				2.1.12, 2.1.13, 3.1.5, 3.2.1, 3.5.11, 4.3.1, 4.3.2, 4.3.3, 5.2.1, 5.3.5, 5.3.6, 5.4.2, 5.5.2, 6.2.2, 6.2.3, 6.2.5, 6.4.2, 6.5.1, 7.2.4, 7.2.5, 7.2.7, 7.2.9, 7.3.2 1.1.8, 3.1.2, 3.4.2, 3.5.6, 4.1.2, 4.1.3, 4.1.5, 4.2.1, 5.1.8, 5.3.2, 5.3.3, 5.6.7, 6.1.1, 6.2.1, 7.1.4, 7.2.8, 7.3.1
	1				
		1	2	3	4
Нөлөөлөл					

Эрсдэлийн матрицад туссан дундаас дээш түвшний эрсдэлүүдийг цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлын чиглэл бүрээр ангилан тодорхойлоход дараах байдалтай байна. Үүнд:

Нэг. Байгууллагын дотоод аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалт

Байгууллагын аюулгүй байдлыг хангах чиглэлээр төсөв, хөрөнгө шийдүүлж зарцуулаагүй (1.1.8) гэх эрсдэл нийт 14 цагдаагийн байгууллагад давтагдсан нь хамгийн өндөр хувьтай байна. Цагдаагийн байгууллагын аюулгүй байдлыг хангахад шаардлагатай төсөв, хөрөнгийг шийдвэрлэн зарцуулах нь энэхүү танилцуулгад дурьдагдсан аливаа эрсдэлийг бууруулахад тэргүүлэх ач холбогдолтой.

Хоёр. Төсөв, санхүүгийн аюулгүй байдал

Цагдаагийн албанаас халагдсан, чөлөөлөгдсөн алба хаагчдын дүрэмт хувцасны тооцоог дутуу хийх (2.2.2), санхүүгийн баримтад гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан түр эзгүйд орон ажиллах хүнийг тушаалаар баталгаажуулж эрх олгодоггүй (2.1.12), кассын ерөөний аюулгүй байдал хангалтгүй (2.3.13) гэх эрсдэлүүд харьцангуй өндөр түвшинтэй байлаа. Иймд эдгээр эрсдэлийг бууруулах талаар зохицуулалтын арга хэмжээ авч, ажлын чиглэл хүргүүлэх нь зүйтэй.

Гурав. Хүний нөөцийн аюулгүй байдал

Орон тоо дутуу ажиллах (3.1.1), алба хаагч өвчний учир чөлөө авах (3.2.3), алба хаагч сахилга, ёс зүйн зөрчилд холбогдох (3.3.1), алба хаагч гэмт хэрэгт холбогдож шалгуулах (3.4.1), захиргааны зөрчил гаргах (3.4.3)

зэрэг нь хүний нөөцийн аюулгүй байдалд учирч болзошгүй хамгийн өндөр түвшинтэй эрсдэлүүд байна. Мөн алба хаагчид тогтвор суурьшилгүй ажиллах (3.1.2), алба хаагч гэмт хэрэг үйлдсэн тухай шүүхийн шийдвэр гарах (3.4.2), алба хаагч албан үүргээ гүйцэтгэхэд хөндлөнгөөс нөлөөлөх (3.5.6) зэрэг эрсдэл нь дундаас дээш түвшний эрсдэлд тооцогдсон байна.

Цаашид цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүй, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, алба хаагчийн баталгааг хангах үйл ажиллагаанд эдгээр эрсдэлүүдийг анхаарч ажиллах нь зохистой.

Дөрөв.Алба хаагчийн аюулгүй байдал

Эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын хамгаалах тусгай хэрэгслийн хангалт дутуу байх (4.3.5), алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа, эсхүл гүйцэтгэсэнтэй холбогдуулан эрүүл мэнд (4.1.2), эд хөрөнгөөр (4.1.3) хохирох, гүтгүүлж доромжлуулах (4.1.5) нь алба хаагчийн аюулгүй байдалд учирч болзошгүй гол эрсдэлүүд юм.

Эрсдэлийн үнэлгээнээс үзвэл гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон алба хаагчдын судалгааг гарган, түүнд дүн шинжилгээ хийж урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, хохирсон алба хаагчдад эрх зүйн болон бусад дэмжлэг, туслалцаа үзүүлэх, эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын аюулгүй байдлыг хангахад анхаарч ажиллах шаардлага байна.

Тав.Мэдээллийн аюулгүй байдал

Вирусны эсрэг програмгүйгээс мэдээлэл алдагдах, компьютер хэрэгсэл гэмтэх (5.4.3), нууцын ажилтныг төрийн нууцын тухай хууль тогтоомжид заасан шаардлагыг хангахуйц өрөө, бусад хэрэгслээр хангаагүй (5.6.7) зэрэг эрсдэл нь мэдээллийн аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй байна.

Түүнчлэн мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр тодорхой ажлууд төлөвлөж хэрэгжүүлэх, эрсдэл бүхий нэгж, алба хаагчийн компьютерыг вирусны эсрэг програмаар хангах, давтамж багатай ч, нөлөөлөл өндөр тул төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах шаардлагатайг эрсдэлийн үнэлгээ анхаарууллаа.

Зургаа.Галт зэвсэг, тусгай хэрэгслийн аюулгүй байдал

Галт зэвсэг (6.1.1), тусгай хэрэгслийн (6.4.1) хангалт, хүрэлцээ муу, стандартын шаардлага хангахгүй өрөөнд хадгалах (6.2.1, 6.5.1) нь галт зэвсэг, тусгай хэрэгслийн аюулгүй байдалд гол эрсдэлийг учруулж байна. Иймд галт зэвсэг, тусгай хэрэгслийн хангалт хүрэлцээг нэмэгдүүлэх, хадгалах орчин нөхцлийг сайжруулах нь зүйтэй.

Долоо.Барилга, байгууламжийн аюулгүй байдал

Тухайн барилга, байгууламжийн ашиглалтын хугацаа дууссан (7.1.3), аюулгүй байдлын хувьд ашиглах боломжгүй тухай мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан (7.1.4), цагдаагийн байгууллага нь телехяналтын камерын системгүй (7.2.8), ийм системтэй ч хуучирсан, хэрэгцээ шаардлага хангахгүй (7.2.9) байх, цахилгааны шугам, сүлжээний найдвартай байдал, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх зэрэг нь барилга, байгууламжийн аюулгүй байдалтай холбон анхаарах асуудлууд юм.

Энэ чиглэлийн эрсдэлүүд нь их хэмжээний хохирол учруулж болзошгүй тул эрсдэлийг бууруулах арга хэмжээг хойшлуулалгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Дүгнэлт, санал

Энэхүү танилцуулгад “шаардлагатай” гэдэг үгийг цөөнгүй удаа ашигласан нь тохиолдлын зүйл биш юм. Учир нь цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах нь дур зорго, хүсэл сонирхол, хэрэгцээ бус зайлшгүй “шаардлага” юм. Тиймээс ч цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох гэсэн энэхүү анхны оролдлого нь дараах гол ач холбогдолтой байлаа. Үүнд:

- Цагдаагийн байгууллагын аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, бүртгэх, үнэлгээ хийх маягт, аргачлалыг боловсруулсан,
- Улаанбаатар цагдаагийн хүрээний байгууллагуудын хэмжээнд аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг гаргаж, хаана, ямар эрсдэл байгааг илрүүлж, тэдгээрийг нэгтгэн харах боломжтой болсон,
- Эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан нэгжүүдээс аюулгүй байдлаа хангахад анхаарч ажиллах шаардлагатай чиглэлээ тодорхойлж, эрсдэлээ олж харах боломжийг олгосон.

Эрсдэлийн үнэлгээг хийх явцад эрсдэлээ тодорхойлж ирүүлэхдээ бүтээлч, ажил хэрэгч хандсан нэгжүүдийн зэрэгцээ энэхүү ажлын ач холбогдлыг сулруулж хайнга хандсан нэгжүүд ч байсан нь ажиглагдлаа.

Цаг хугацаа, хүний нөөцийн хязгаарлагдмал боломжоос шалтгаалан эрсдэл бүрийн бодитой эсэхийг нягтлах боломж энэ удаа байгаагүй ч, цаашид эрсдэлийн үнэлгээний зорилго, ач холбогдлыг цагдаагийн нэгж, тэдгээрийн удирдлагуудад зөвөөр ойлгуулж, эрсдэлийг бодитойгоор бүртгэж тайлагнадаг болгох нь чухал юм.

Цаашид цагдаагийн байгууллагын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг эрсдэлийн үнэлгээнд суурилан хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор дараах саналуудыг танилцуулж байна.

Үүнд:

1. Цагдаагийн байгууллагын аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийсэн ажлын дүнг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж, эрсдэлийн түвшин өндөр, их хэмжээний хохирол учруулж болзошгүй эрсдэлүүдийг бууруулахад шаардлагатай төсөв, зардлыг үе шаттайгаар шийдвэрлүүлэх,
2. Цаашид аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээнд суурилан эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх ажлыг байгууллагын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллахыг Аюулгүй байдал, төрийн нууц, шифр харилцааны хэлтэст даалгах,
3. Эрсдэлийн үнэлгээний маягтыг боловсронгуй болгон, цаашид хагас жил тутамд цагдаагийн байгууллагын аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээг хийж ажиллахыг мөн хэлтэст зөвлөх,
4. Эрсдэлийн үнэлгээний тайланд үндэслэн төсөв, хөрөнгө шаардагдахгүй, бусад арга, хэлбэрээр бууруулах боломжтой эрсдэлийн хүрээнд төв, орон нутгийн цагдаагийн байгууллагад ажлын чиглэл боловсруулж хүргүүлэх зэрэг болно.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

Хавсралт 1
ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЮУЛГҮЙ БАЙДАЛД УЧИРЧ БОЛЗОШГУЙ ЭРСЭДЛИЙН ҮНЭЛЭЭ

Д/д	Аюулгүй байдлын чиглэл	Д/д	Эрсдэлийн бүлэг	Д/д	Эрсдэлийн зүйл	Дагтамж				Эрсдэлийн үнэлгээ		
						Газар, төвүүд	Дүүргийн болон ТЭЦХ, МАТЦХ	Нийт нэгж	Оноо			
1	Аюуллагын дотоод аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтад учирч болзошгүй эрсдэл	1.1.1	Байгууллагын дотоод аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтад учирч болзошгүй эрсдэл	1.1.1	Аюулгүй байдлыг хангах орон тооны бус аяллын хэсгийг шинэчлэн байгуулсан эсэх			2	1	4	4	
		1.1.2		Орон тооны бус аяллын хэсгийн гишүүдийн хариуцах чиг үүргийг тодорхойлсон эсэх			6	1	4	4		
		1.1.3		Орон тооны бус аяллын хэсэг хуралдаж, шийдвэр гаргадаг эсэх			4	1	4	4		
		1.1.4		Цагдаагийн байгууллагын аюулгүй байдлыг хангах салбар төлөвлөгөө гаргасан эсэх			2	1	4	4		
		1.1.5		Уг төлөвлөгөөний биелэлт, үр дүнг тооцсон эсэх			3	1	4	4		
		1.1.6		Байгууллагын аюулгүй байдлыг хангах чиглэлээр удирдлагаас анба хаагчдад үүрэг, даалгавар өгсөн эсэх			1	1	4	4		
		1.1.7		Өгсөн үүрэг, даалгаврын биелэлт, үр дүнг тооцсон эсэх			4	1	4	4		
		1.1.8		Байгууллагын аюулгүй байдлыг хангах чиглэлээр төсөв, хөрөнгө шийдүүлж зарцуулсан эсэх			14	2	5	10		
		1.1.9		Гэнэтийн осол, гамшгийн үед ажиллах төлөвлөгөөтэй эсэх			1	1	5	5		
		1.1.10		Алба хаагчдад гэнэтийн осол, гамшгийн үед хэрхэн ажиллах талаар сургалт зохион байгуулсан эсэх			1	1	5	5		
		2.1.1		Анхан шатны барилгын бүрдэл дутуу баримтаар зарлага гаргах					0	4	0	
		2.1.2		Кассаас бэлэн мөнгө дутах					0	4	0	
		2.1.3		Мөнгөн хөрөнгийн дансаар хийгдэж буй гүйлгээг тооцооны дансаар дамжуулдаг эсэх					7	1	2	2
		2.1.4		Харилцагч байгууллагуудтай тайлант хугацаа бүрээр тооцоо нийлж баталгаажуулалт хийдэг эсэх					4	1	2	2
2.1.5	Хувь хүнээс бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа хуулийн дагуу татварын тооцоо хийгдэж байх					1	1	4	4			
2.1.6	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа зах зээлийн үнийн харьцуулсан судалгаа хийжгүй байх						0	4	0			
2.1.7	Үнэлгээний жорсо байуулж, сонгон шалгаруулалт хийхгүй байх						0	4	0			
2.1.8	Хөрөнгийн орлого, зарлагыг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлцэлцэж, төсөв, төлөвлөгөө боловсруулж хянуулаагүй байх						0	4	0			
2.1.9	Гүйцэтгэлийн тайлан гаргахгүй, түүнд хяналт тавихгүй байх						0	4	0			
2.1.10	Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах						0	5	0			
2.1.11	Төсвийн хөрөнгийг зарцуулсан дарга, ерөнхий нягтлан бодогч, мөнгөн кассын няраа зэрэг албан тушаалтнууд нэг гэр бүлийн гишүүн, хамаатан садан байх						0	5	0			
2.1.12	Санхүүгийн баримтад гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан түр эзгүйд орлон ажиллах хүнийг тушаалаар баталгаажуулж эрх олгодог эсэх					13	2	4	8			
2.1.13	Кассын өрөө бусдаас тусгаарлагдсан, цонх, хаалтыг гөмөр сараалжаар бэхлсэн эсэх					13	2	4	8			
2.1.14	Бэлэн мөнгө, үнэт цаасыг шатахааргүй гөмөр сейфэнд хадгалах					1	1	5	5			

2015.06.22

Улаанбаатар хот

3.5	Алба хаагч авчлгч, ашиг сонирхлын зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх	3.5.7	Албан үүргээ гүйцэтгэсэнтэй нь холбогдуулан алба хаагчид нөлөөлөх гэсэн оролдлогыг бүртгэдэг эсэх			17	3	3	9					
		3.5.8	Алба хаагчид авчлгч өгөхөөр оролдсон тухай удирдах албан тушаалтандаа мэдэгдсэн эсэх			0	1	0						
		3.5.9	Авчлгчаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, үр дүнг тооцсон эсэх			1	1	3	3					
		3.5.10	Авчлгчн эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр алба хаагчдын дунд сургалт зохион байгуулсан эсэх			4	1	3	3					
		3.5.11	Цагдаагийн алба хаагч хүнд суртал гаргасан талаар өргөдөл, гомдол мэдээлэл иргэдээс ирүүлсэн эсэх			12	2	4	8					
		3.5.12	Эрх мэдлээ урвуулсан, цагдаагийн алба хаагч нь ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэсэн талаар өргөдөл, гомдол мэдээлэл иргэдээс ирүүлсэн эсэх			3	1	4	4					
		3.5.13	Цагдаагийн алба хаагчидтай холбоотой иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын бүртгэлтэй эсэх			1	1	3	3					
		3.5.14	Цагдаагийн алба хаагчдын авчлгч, хүнд суртал, ёс зүйн зөрчлийн талаар мэдээлэл авах тусгай утас гаргасан эсэх			16	3	3	9					
		3.5.15	Лээрх утсаар ирсэн мэдээлэлд байгууллагын удирдлагын зүгээс хяналт тавьсан эсэх			7	1	3	3					
		3.5.16	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр мэдээллийн самбар байршуулсан эсэх			4	1	1	1					
		3.5.17	Мэдээллийн ил тод байдлын хүрээнд холбогдох мэдээллүүдийг цахим хуудсанд бүрэн байршуулсан эсэх			3	1	1	1					
		3.5.18	Авчлгчаас урьдчилан сэргийлэх орон тооны бус салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан эсэх			10	2	3	6					
		3.6	Цагдаагийн албаны нэр хүнд	3.6.1	Тухайн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх гомдол, мэдээлэл өсөх			3	1	4	4			
				3.6.2	Тухайн нэгжийн алба хаагчдын үйл ажиллагааны талаарх гомдол, мэдээлэл өсөх			4	1	4	4			
3.6.3	Тухайн нэгж, алба хаагчдын талаарх сөрөг мэдээлэл хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тархах					2	1	4	4					
4	Алба хаагчийн аюулгүй байдалд учирч болозошгүй эрсдэл	4.1	Алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа, эсхүл гүйцэтгэсэнтэй холбогдуулан гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирах	4.1.1	Амь насва алдах			3	1	5	5			
				4.1.2	Эрүүл мэндээр хохирах			14	2	5	10			
				4.1.3	Эд хөрөнгөөр хохирах			14	2	5	10			
				4.1.4	Заналхийлэл, дарамт шахалтад өртөх			6	1	5	5			
				4.1.5	Гүтгүүлж, доромжлуулах			15	2	5	10			
				4.1.6	Ойр дотны хүмүүс нь гэмт халдлагад өртөх			5	1	5	5			
		4.2	Алба хаагч албан үүргээс үл	Алба хаагч албан үүргээс үл хамаарах шалтгаанаар гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирах	4.2.1	Алба хаагч албан үүргээс үл хамаарах шалтгаанаар гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирах			9	2	5	10		
					4.3	Алба хаагч гэмт үзэгдэлд өртөж хохирсон алба хаагчдын судалгаатай эсэх	4.3.1	Гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон алба хаагчдын судалгаатай эсэх			10	2	4	8
							4.3.2	Гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон алба хаагчид эрх зүйн болон бусад дэмжлэг туслалцаа үзүүлдэг эсэх			12	2	4	8

Албан хэрэгцээнд

	4.3	Мэдээллийн өргтөхөөс урьдчилан сэргийлэх	4.3.3	Дээрх судалгаанд дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулсан эсэх				10	2	4	8				
			4.3.4	Алба хаагчид хувийн аюулгүй байдлаа хангаж ажиллах талаар удирдлагаас зөвлөмж, зааварчлалгаар хангадаг эсэх				0	4	0					
			4.3.5	Эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын хамгаалах тусгай хэрэгслийн хангалт дутуу байх				16	3	5	15				
	5.1	Мэдээллийн сүлжээний аюулгүй байдал	5.1.1	Сүлжээний төхөөрөмжүүдийг (converter, router, switch) зориулалтын шкафанд(Rack) байрлуулсан эсэх			3	1	5	5					
			5.1.2	Байрлуулсан боловч түгжээ, лацгүй байх				9	2	3	6				
			5.1.3	Сүлжээний болон цахилгааны утас кабелийг далдлаагүй байх				16	3	3	9				
			5.1.4	Сүлжээний топологи схем гаргасан эсэх				18	3	2	6				
			5.1.5	Сүлжээний хяналт хийгдсэн эсэх				14	2	2	4				
			5.1.6	Сүлжээний тохиргоо, нууцлалын бүртгэлтэй эсэх				12	2	3	6				
			5.1.7	Сүлжээний доголдол, засвар үйлчилгээний бүртгэл хөтөлдөг эсэх				17	3	1	3				
			5.1.8	Байгууллагын дотоод орчинд утасгүй сүлжээ ашиглах				10	2	5	10				
			5.1.9	Алба хаагчид зөвшөөрөлгүйгээр олон нийтийн портал сайт руу хандах				9	2	3	6				
			5.1.10	Домэйны нэгдсэн удирдлагад холбогдсон эсэх				16	3	1	3				
			5.1.11	ГА-ын эрх бүхий алба хаагчдын компьютер интернэтэд холбогдсон байх				7	1	5	5				
				5.2	Техник хангамжийн аюулгүй байдал	5.2.1	Албаны компьютер нь хэвийн бус ажиллагаатай байх (нууц, бичиг хэргийн ажилтан, хууль, дотоод ажил, санхүү, хүний нөөцийн ажилтан, эрүүгийн төлөөлөгч нарын мэдээлэл устах эрсдэлтэй)			11	2	4	8		
						5.2.2	Техник хэрэгслийн засвар үйлчилгээ, салбаз хэрэгсэл солиход бүртгэл (техникийн карт) хөтөлдөг эсэх				18	3	2	6	
						5.2.3	Серверийн өрөөний стандарт хангагдаагүй байх				15	2	3	6	
5.2.4	Сервер компьютерт ямар хугацаанд ямар үйлчилгээ хийдэг тухай бүртгэлтэй эсэх							18	3	2	6				
5.2.5	Тог баригч, хөргөлтийн системтэй эсэх (МТТ, МШУТ, Лицензийн төв, Замын цагдаагийн газар, Төв архив, Лавлагааны сан)							0	4	0					
	5.3	Програм хангамжийн аюулгүй байдал	5.3.1	Албаны компьютерийн нууц үг алдагдах/тайлагдах			4	1	5	5					
			5.3.2	Вирусын эсрэг програм хангамжтай эсэх				11	2	5	10				
			5.3.3	Вирусын эсрэг програмтай бол шинэчлэл (update) хийгддэг эсэх				13	2	5	10				
			5.3.4	Вирусын эсрэг программгүйгээс мэдээлэл алдагдах, компьютер хэрэгсэл гэмтэх				16	3	5	15				
			5.3.5	Сүлжээ, шуудан, холбооны саатлаас болж албаны шуурхай байдал алдагдах				11	2	4	8				
			5.3.6	Үйлдлийн системийн аюулгүй байдал хангагдсан эсэх (нууц код нь нууц үгийн стандарт хангахгүй, системийг сэргээх боломжоор хангагдаагүй)				14	2	4	8				
			5.3.7	Нууцлал бүхий файлыг ашиглах, хуулбарлахад нууц кодоор хамгаалдаг эсэх				5	1	4	4				
			5.3.8	Флэш дискийг холдолдог эсэх				24	4	3	12				
			5.3.9	Цагдаагийн байгууллагад ашиглагдаж байгаа тусгай програм хангамжийн нэвтрэх нууц код нь стандарт хангасан эсэх				4	1	3	3				
			5.3.10	Сар тугам нууц кодоо сольдог эсэх				13	2	3	6				
		Мэдээллийн аюулгүй байдал													

5	5.4	Мэдээллийн сангийн аюулгүй байдлыг эрсдэл	Мэдээллийн сангийн аюулгүй байдал	5.4.1	Мэдээллийн сангийн нөөцлөлт хийгддэг эсэх				12	2	2	4
				5.4.2	Санд нэвтрэх эрх бүхий алба хаагчдын бүртгэлтэй эсэх				9	2	4	8
				5.4.3	Мэдээллийн сангийн багтаамж, нууцлалд хяналт тавьдаг эсэх				6	1	4	4
				5.5.1	Цагдаагийн байгууллагын мэдээллийн технологийн бодлого, журамтай гяналдаж, мөрдлөг болгон ажилладаг эсэх				6	1	1	1
				5.5.2	Мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр тодорхой аюулд төлөвлөж хэрэгжүүлдэг эсэх				12	2	4	8
				5.5.3	Сүлжээ хариуцсан алба хаагчдын мэргэжлийн ур чадвар шаардлага хангасан эсэх				8	1	3	3
				5.5.4	Сүлжээ хариуцсан алба хаагчдын ажлын ачаалал их байх				20	3	1	3
				5.5.5	Нийт алба хаагчдыг мэдээллийн технологийн чиглэлээр сургалтад хамруулдаг эсэх				18	3	2	6
				5.6.1	Шүүвэн, холбооны үйл ажиллагаанаас болж албаны баримт бичиг үүрдэх				1	1	5	5
				5.6.2	Төрийн болон байгууллагын нууцд, хамаарах мэдээлэл алдагдах				1	1	5	5
				5.6.3	Төрийн болон байгууллагын нууцд, хамаарах баримт бичиг үүрдэх				2	1	5	5
				5.6.4	Төрийн нууц задрах				1	1	5	5
				5.6.5	Байгууллагын нууц задрах				1	1	5	5
				5.6.6	Байгууллагын дарга тухайн байгууллагад төвлөрсөн нууц мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хамгаалах талаар тодорхой ажил зохион байгуулсан эсэх				7	1	5	5
	5.6.7	Нууц ажилтан төрийн нууцын аюулгүй байдлын шаардлагыг хангахууд өрөө, зориулалтын сейф, төрийн нууцын компьютер болон төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагаанд ашиглагдах бусад эд зүйл /сейф, дардас, лац гэм-сэр хангасан эсэх				14	2	5	10			
	5.6.8	ЦЕУАЖ /Код Т14-ийн Т14.4.7-д заасны дагуу төрийн нууцтай танилцах албан хаагч бүрээс нууцын багалгаа авсан эсэх				2	1	5	5			
	5.6.9	Байгууллагын даргын Тушаалаар нууцын ажилтан болон бичээчийг томилж, тэднээс нууц задруулажгүй байх баталгаа /Маягт ЦЕУАЖ №Т14.53а/-г авсан эсэх				4	1	5	5			
	5.6.10	Нууцын ажилтан, нууцын бичээчийг томилохдоо тагнуулын байгууллагаас зөвшөөрөл авсан эсэх				7	1	5	5			
	5.6.11	Нууцын ажилтан эзлгийн амралттай, өвчтэй, чөлөөтэй тохиолдолд нууцтай танилцах эрх бүхий алба хаагчид уг ажлыг түр хүлээлтэнд өгч орлон гүйцэтгүүлдээ удирдлагаас шийдвэр гаргадаг эсэх				7	1	5	5			
	5.6.12	Нууцын ажилтан нууцын зэрэглэлтэй албан бичгийг хариуцсан алба хаагчаар шийдвэрлүүлсний дараа эх хувийг буцаан авч, ирсэн бичгийн санц хадгалдаг эсэх				5	1	5	5			
5.6.13	Төрийн нууцд, хамаарах мэдээ, баримт бичиг боловсруулж буй нууцын компьютерийг гадаад сүлжээнд холбох				3	1	5	5				
6.1	Хангалт, болон байдал, хяналт	6.1.1	Галт зэвсгийн хангалт нь ...-д заасан хувь хэмжээнд хүрэхгүй байх					13	2	5	10	
		6.1.2	Алба хаагчдад зэвсэг хэрэглэлтэй хадгалах, арчлах, ашиглах дадлага, чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулсан эсэх					5	1	3	3	

Албан хэрэгцээнд

Угч ажил	6	1	3	3
6.1.3 Дээрх чиглэлээр зөвлөмж, зааварчилгаа өгч ажилладаг эсэх	14	2	5	10
6.2.1 Стандартлаг хаангагүй өрөөнд галт зэвсгийг хадгалах	12	2	4	8
6.2.2 Галт зэвсэг, хэрэглэлийг хадгалах өрөө нь телехяналтын камергүй байх	14	2	4	8
6.2.3 Галт зэвсэг, хэрэглэл хадгалах өрөө нь дохиоллын системгүй байх	8	1	4	4
6.2.4 Галт зэвсэг, хэрэглэлийг хадгалах өрөөнийг телехяналтын камер нь жижүүрийн байнгын хяналтад байдаг эсэх	12	2	4	8
6.2.5 Сууны зориулалтын саванд хадгалахгүй байх	6	1	4	4
6.2.6 Галт зэвсгийн хадгалалт, арчилгаа хангалтгүйгээс ашиглах боломжгүй болох	3	1	5	5
6.2.7 Галт зэвсэг алдагдах	2	1	5	5
6.2.8 Галт зэвсгийн эд анги алдагдах/солгогдох	1	1	5	5
6.2.9 Галт хэрэглэл алдагдах	5	1	4	4
6.2.10 Байгууллагын даргын тушаалаар галт зэвсэг, хэрэглэлийг харуулах албан тушаалтныг томилсон эсэх	3	1	4	4
6.2.11 Зэвсгийн агуулах өрөө /сейф/-д нэвтрэх, гамшиг ослын үед ажиллах болон зэвсэг хэрэглэлд үзлэг хийх хуваарь, горимыг баталж мөрдүүлсэн эсэх	2	1	3	3
6.3.1 Зэвсгийн өрөө /сейф/-ний түлхүүр, лацыг хүлээн авсан тухай бүртгэл хөтөлдөг эсэх	11	2	3	6
6.3.2 Галт зэвсэг, хэрэглэл харуусан алба хаач агуу үед /эзлэгийн амралттай өнгөтэй, чөлөөтэй г.м ажил хүргээлцүүлэх ажлыг хэсэг томилдог эсэх	12	2	3	6
6.3.3 Дээрх тохиолдолд нотломж тэмдэглэл үйлддэг эсэх	6	1	3	3
6.3.4 Алба хаач албааас халагдсан, чөлөөлөгдсөн, түр чөлөө авсан тохиолдолд энэ тухай байгууллагын даргад танилцуулж, тойрох хуудсанд зэвсэг, хэрэглэлийн тооцоотой эсэх талаар тэмдэглэл хийдэг эсэх	2	1	5	5
6.3.5 Галт зэвсэг, хэрэглэлийн тооллыг тогтоосон хугацаа /хагас, бүтэн жил/-нд хийсэн эсэх	3	1	5	5
6.3.6 "Зэвсэг, галт хэрэглэлийн тооллын дэлгэрэнгүй бүртгэл"-ийн маягт /№4.5а/, "Зэвсэг, галт хэрэглэлийн тооллын нэгдсэн товчоо" маягт /4.5б/-ын дагуу бүртгэл хөтөлж, тооллыг дүнг хоолбодох албанд ирүүлдэг эсэх	0	3	0	0
6.3.7 Тооллын явдал илэрсэн эдэлгээний улмаас засварлах боломжгүй болсон зэвсгийн дагагдах хэрэгсэл /оосор, дайз, бууны гэр, сумны цүнх гэх мэт/-ийг актилах, устгах талаар саналаа хөтөлдөх албанд ирүүлж шийдвэрлүүлсэн эсэх	0	3	0	0
6.3.8 Ашиглах боломжгүй болсон галт хэрэглэл /сум-ийг шумурын шинжилгээний байгууллагын дүнгэлтийг үндэслэж, бууны жад, дуран-гэрлэлт, хараа хэрэгсэлийг Цэгдлагийн ерөнхий газрын өмч хамгаалах комиссын шийдвэрээр актилах, данс бүртгэлээс хассан эсэх	2	1	3	3
6.3.9 Зэвсэг, хэрэглэлийг алба хаачид хүлээлгэн өгөхдөө маягт /№5.3а/-ын дагуу зэвсгийн карт олгодог эсэх	2	1	3	3
6.3.10 "Зэвсэг, галт хэрэглэл тавьж олгосон, буцаан авсан тухай бүртгэл"-ийн маягт / №5.3б/-ыг хөтөлдөг эсэх	2	1	3	3

эрсдэл	7.2	Догоод хүчин зүйл	7.2.6	Аюулгүйн гарц, аврах зураглалыг давхар бүхэнд байршуулсан эсэх			2	1	3	3
			7.2.7	Барилгын эрсдэл бүхий цонхнуудыг төмөр хаалтаар бүрэн тоногдосон эсэх			14	2	4	8
			7.2.8	Тухайн цагдаагийн байгууллага төлөхяналтын камерын системгүй байх			14	2	5	10
			7.2.9	Тухайн цагдаагийн байгууллага төлөхяналтын камерын систем нь хуучирсан, хэрэгцээ шаардлага хангахгүй байх			12	2	4	8
			7.2.10	Алба хаачийн буруутай үйл ажиллагааны улмаас төлөхяналтын камерын үйл ажиллагаа доголдох, саатах			4	1	4	4
			7.2.11	Авто гараашийг камерын хяналтад авсан эсэх			6	1	4	4
			7.2.12	Авто гараашид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг байрлуулсан эсэх			3	1	4	4
			7.3.1	Байгалийн гамшиг, осол, хүн, малын гоц халдварт өвчин гарснаас байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах			10	2	5	10
			7.3.2	Өндөр дээд хэмжээний зочин, төлөөлөгчдийн айлчлалаас шалтгаалан байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах			11	2	4	8
			7.3.3	Дээрх шалтгаанаар алба хаагч, байгууллагын барилга байгууламж, эд хөрөнгөд хохирол учрах			8	1	5	5
	7.3	Давалцагчийн хүчин зүйл								

Товчлол: ХГ-Хамгаалалтын газар, ТГ-Техникийн газар, АСТ-Албадан саатуулах төв, ТАГ-Тусгай ажиллагааны газар, ТА-Төв архив, ЛТ-Лицензийн төв, АБ-Авгобааз, БН-Багануур, БХ-Багахангай, НАЛ-Налайх
Давтамж: Нийт 37 нэгж хамрагдсанаас 0-20 хувь буюу 1-8 нэгж бол 1 оноо, 20-40 хувь буюу 9-15 нэгж бол 2 оноо, 40-60 хувь буюу 16-22 нэгж бол 3 оноо, 60-80 хувь буюу 23-29 нэгж бол 4 оноо, 80-100 хувь буюу 30-37 нэгж бол 5 оноо

Өндөр
Дундаас дээш
Дунд
Дундаас доош

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ